- Бага насны хүүхдийг аюулгүйн бүсээр тоглуулахыг хориглоно. Хүүхдийн хүзүүнд аюулгүйн бүс орооцолдсон үед амьсгал боогдуулах, амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай. Дээрх нөхцөл байдал үүсч хэрэв бүсний түгжээ тайлагдахгүй байвал хайчаар бүсийг тайрна.

⚠ АЮУЛТАЙ

- Хүүхдийн суудал (суудал өндөрсгөгч) ашиглах үед аюулгүйн бүсний мөрний хэсэг хүүхдийн мөрний төв дээр таарч байгааг нягтлана.
- Хүүхдийн суудал үйлдвэрлэгчийн зааварчилгааг баримталж суурилуулна.
- Бүсний хэл ба гархи гүйцэд түгжигдсэн байгааг нягтлана.
- Бүс хуниралдаагүй эсэхийг нягтлана.
- Хүүхдийн суудал үйлдвэрлэгчийн зааварчилгааг баримталж хөдөлгөөнгүй суурилуулна.
- Хүүхдийн суудал хөдөлгөөнгүй бэхлэгдсэн эсэхийг урагш хойш, баруун зүүн тийш татаж шалгана.

1 **Аюулгүйн бүсийг хүүхдийн суудал дундуур гаргана.**

Хүүхдийн суудал үйлдвэрлэгчийн зааварчилгааг баримталж суурилуулна.

2 **Дуу гарах хүртэл бүсний хэлийг гархинд хийнэ.**

Бүс мушгираагүйг нягтлана.

3 **Аюулгүйн бүс бүрэн бэхлэгдсэнийг нягтлана.**



Хүүхдийн суудал угсрах үед бүс гүйхээс сэргийлсэн хавчаар шаардагдана. Хүүхдийн суудлын үйлдвэрлэгчийн гарын авлагад заасны дагуу суудал угсрах ба хэрэв таны суудалд бүс гүйхээс сэргийлсэн хавчаар дагалдаж ирээгүй тохиолдолд та өөрийн Lexus дилерт хандан дараах кодоор захиалан авах боломжтой: Locking clip for child restraint system (Part No. 73119-22010)

4 **Хүүхдийн суудал угсарсны дараа нааш цааш хөдөлгөн бэхэлгээг шалгана.**

Хүүхдийн суудал хөдөлгөөнгүй бэхлэгдсэнийг нягтлана.

Аюулгүйн бүс ашиглан угсарсан хүүхдийн суудал салгах

Аюулгүйн бүс ашиглан угсарсан хүүхдийн суудал салгах үед аюулгүйн бүсийг тайлна.

1 **Бүс тайлах товч дарна.**

Бүс тайлагдсан үед хүүхдийн суудал дээш хүчтэй түлхэгдэж болох тул хүүхдийн суудлыг сайтар дарангаа бүс тайлна.

2 **Хүүхдийн суудлаас аюулгүйн бүс салгана.**

Аюулгүйн бүс автоматаар хураагдана.

Урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал угсрах (Тайваниас бусад)

Зайлшгүй шалтгаанаас бусад нөхцөлд урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал угсрахыг хориглоно. Ослын үед SRS аюулгүйн дэрний дэлгэгдэх хүч хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

Зайлшгүй шалтгаанаар урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал угсрах үед суудлыг дараах байдлаар тохируулна:

- Суудлыг хамгийн арагш хойшлуулна
- Суудлыг хамгийн өндөр тохиргоонд тохируулна
- Түшлэгийг эгц босоо байрлалд тохируулна.

  Хүүхдийн суудал болон суудлын түшлэгний хооронд зай байгаа үед түшлэгийг тохируулж зайгүй болгоно.
- Толгойн түшлэгийг авна

  Толгойн түшлэг авах боломжгүй үед хамгийн өндөр байрлалд тохируулна.



⚠ АЮУЛТАЙ

- Арагш харсан хүүхдийн суудлыг урд зорчигчийн суудалд угсрах хориотойг анхааруулсан тэмдэг урд зорчигчийн суудлын нарны хаалт дээр байдаг.

- Зайлшгүй шаардлагаар урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал угсрах үед суудлыг хамгийн арагш хойшлуулна. Ослын үед SRS

⚠ АЮУЛТАЙ

аюулгүйн дэрний дэлгэгдэх хүч хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

- Хүүхэд хаалга, тулгуур багана, дээврийн хөндлөн тулгуурт хүүхдийн бие хүрэхгүй байдлаар хүүхэд суулгана. Ослын үед SRS аюулгүйн дэрний дэлгэгдэх хүч хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.
- Хүүхдийн суудал (суудал өндөрсгөгч) ашиглах үед аюулгүйн бүс зөв зүүнэ.
- Хүүхдийн биеийн хэмжээ, насны ангилалд тохирсон хүүхдийн суудал сонгоно.

Урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал угсрах

- **Хүүхдийн суудал угсрахаас өмнө урд зорчигчийн суудлыг тохиромжтой байрлалд тохируулна.**

  Хүүхдийн суудлыг суудлын гарын авлагын дагуу угсарна.

Аюулгүйн дэр гар аргаар асааж унтраах систем*

Систем дараах аюулгүйн дэрний ажиллагааг цуцлана.

● SRS урд зорчигчийн аюулгүйн дэр

Зөвхөн урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал угсрах үед системийг цуцлана.



A "PASSENGER AIR BAG" индикатор

"PASSENGER AIR BAG" болон "ON" индикаторууд аюулгүйн дэрний систем идэвхжих үед асаад 60 секундын дараа унтарна. (зөвхөн асаах товчны ON горимд).

B Аюулгүйн дэр гар аргаар асааж унтраах товч

МЭДЭЭЛЭЛ

■ "PASSENGER AIR BAG" индикаторын мэдээлэл

Дараах аль нэг асуудал үүссэн үед системд доголдол үүссэн байж болзошгүй.

Та автомашинаа өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

● Аюулгүйн дэр гар аргаар асааж унтраах товчийг "OFF"-д шилжүүлэх үед "OFF" индикатор асахгүй байх.

● Аюулгүйн дэр гар аргаар асааж унтраах товчийг "ON", эсвэл "OFF" горимд шилжүүлэх үед индикатор өөрчлөгдөхгүй байх.

⚠ АЮУЛТАЙ

■ Хүүхдийн суудал угсрах үед

Аюулгүйн үүднээс хүүхдийн суудлыг арын суудалд угсарна. Арын суудал ашиглах боломжгүй нөхцөлд аюулгүйн дэр гар аргаар унтраах системийг "OFF"-д шилжүүлсэн нөхцөлд урд суудал ашиглах боломжтой. Аюулгүйн дэр гар аргаар унтраах систем идэвхтэй үед аюулгүйн дэрний дэлгэгдэх үеийн хүч амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

*:Тоноглогдсон автомашинд

⚠ АЮУЛТАЙ

■ Урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал угсраагүй үед

Аюулгүйн дэр гар аргаар унтраах системийг "ON" горимд буцаана. Off горимд үлдээсэн нөхцөлд ослын үед дэлгэгдэхгүй ба амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

Урд зорчигчийн аюулгүйн дэрний ажиллагааг цуцлах

● **Цилиндрт механик түлхүүрийг хийж "OFF" байрлалд эргүүлнэ.**

"OFF" индикатор асна (зөвхөн асаах товчны ON горимд).



Түлхүүрийн төрлүүд

Автомашинд дараах түлхүүрүүд дагалдаж ирнэ.



A Электрон түлхүүр
- Smart entry & start системийн ажиллагаа
- Түлхүүрийн алсын удирдлаганы ажиллагаа

B Механик түлхүүр

C Түлхүүрийн дугаар бүхий пайз

D Түлхүүр карт (электрон түлхүүр)*

Smart entry & start системийн ажиллагаа

⚠ АНХААР

■ Түлхүүрийг гэмтлээс сэргийлэх

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Түлхүүрийг унагах, хүчтэй доргиох, мушгихыг хориглоно.
- Удаан хугацаанд хэт өндөр хэмд байлгахыг хориглоно.
- Норгох, хэт авианы угаалгын машинаар угаах зэргийг хориглоно.
- Түлхүүрт металл, соронзон материалтай эд зүйлс зүүх, ойр орчимд тавихыг хориглоно.
- Түлхүүрийг задлахыг хориглоно.
- Электрон түлхүүрийн гадаргуу дээр наалт, аливаа зүйл нааж болохгүй.
- Түлхүүрийг зурагт, аудио хөгжим, индукцийн плитка, бага давтамжтай цахилгаан эмчилгээний төхөөрөмж зэрэг соронзон орон үүсгэдэг эд зүйлсийн ойр орчимд тавихыг хориглоно.

■ Биедээ электрон түлхүүр авч явах

Электрон түлхүүрийг асаалттай цахилгаан хэрэгслээс 10 см (3.9 инч) ба түүнээс хол зайд байлгана. Электрон түлхүүрнээс 10 см (3.9 инч) хүртэлх зайд байгаа цахилгаан хэрэгслээс ялгарсан радио долгион түлхүүрийн хэвийн ажиллагааг алдагдуулах магадлалтай.

■ Түлхүүр карт ашиглах үед

- Түлхүүр картны зай, эсвэл картны терминал норсон үед зай зэвэрч түлхүүр карт ажиллахгүй болно. Түлхүүрийг ус, шингэн зүйлд унагасан, түлхүүр дээр асгарсан үед нэн даруй зайн тагийг авч зай болон терминалыг арчина. (Тагийг зөөлөн атгаад татна). Зай зэвэрсэн үед та өөрийн Lexus дилерт хандаж солиулна уу.
- Зайны таг авах үүднээс халив ашиглах, эсвэл тагийг эвдлэж болохгүй. Тагийг хүчээр салгах нь түлхүүрийг гэмтээх, хэлбэр алдагдахад хүргэнэ.

*:Тоноглогдсон автомашинд

⚠ АНХААР

- Тагийг олон дахин салгасан үед таг суларна.
- Зайг угсрах үед зайг зөв харуулж угсрахад анхаарна. Буруу харуулж угсарсан үед зайны цэнэг хурдан сууна.
- Дараах нөхцлүүдэд түлхүүр карт гэмтэх, эсвэл хамгаалалтын хуулга нь хууларч болно:
  - Зоос, түлхүүр зэрэг хатуу эд зүйлтэй хамт түлхүүр картыг авч явах үед.
  - Балны хошуу зэрэг хурц эд зүйлээр хуссан үед.
  - Түлхүүр картын гадаргууг шингэлэгч, эсвэл бензенээр арчсан үед.

МЭДЭЭЛЭЛ

■ Түлхүүр карт ашиглах үед

- Түлхүүр карт хэвийн ажиллахгүй зэрэг зөвхөн онцгой нөхцөлд түлхүүр карт доторх мехник түлхүүр ашиглана.
- Зайны тагийг угсраагүйгээс зай унасан, эсвэл зай норсноос шалтгаалан зайг салгасан үед зайны нэмэх тэмдэгтэй талыг Lexus эмблем рүү харуулан угсарна.



- Түлхүүр карт нь усны хамгаалалтгүй болно.

■ Нисэх онгоцоор зорчих үед

Онгоцоор зорчихдоо биедээ автомашины электрон түлхүүр авч явах үед түлхүүрийн аливаа товчийг дарж болохгүй. Түлхүүрийг цүнх болон бусад саванд хийх бол түлхүүрийн товч санамсаргүй дарагдахаас сэргийлнэ. Товч дарагдах үед түлхүүрнээс онгоцны жолоодлогод саад учруулах радио долгион цацагддаг.

■ Электрон түлхүүрийн зайны цэнэг дуусах

- Хэвийн нөхцөлд зайны ашиглалтын хугацаа 1 - 2 жил байна. (Түлхүүр картны зайны ашиглалтын хугацаа 1 жил орчим байдаг).
- Зайны цэнэг муудсан нөхцөлд хөдөлгүүр унтраахад автомашины бүхээг дотор дуут дохио дуугарна.
- Электрон түлхүүр нь байнга радио долгион хүлээн авдаг тул түлхүүр ашиглагдаагүй үед ч зай цэнэгээ алддаг. Дараах шинж тэмдгүүд нь электрон түлхүүрийн зай цэнэг алдсаныг илтгэнэ. Шаардлагатай үед зайг шинээр солино.

- Smart entry & start систем, эсвэл түлхүүрийн алсын удирдлага ажиллахгүй байх.
- Түлхүүр таних хүрээ багасах.
- Түлхүүр дэх LED индикатор гэрэл асахгүй байх.

● Зайны цэнэг буурахаас сэргийлж электрон түлхүүрийг соронзон орон үүсгэдэг цахилгаан хэрэгслээс 1м (3 фут) зайнд орхиж болохгүй:

- Зурагт
- Компьютер
- Цэнэглэгдэж буй гар утас болон утасгүй суурин утас, зай цэнэглэгч
- Ширээний чийдэн
- Индукцийн плитка
- Ширээний чийдэн

■ **Аккумулятор, түлхүүрийн зайны цэнэг хэмнэх функц**

Зайны цэнэг хэмнэх функц нь автомашин урт хугацаанд ашиглагдаагүй үед электрон түлхүүрийн зай болон аккумуляторын цэнэг хэмнэх зорилгоор идэвхиждэг.

● Дараах нөхцөлд Smart entry & start системийн хаалганы түгжээ тайлах хугацаа удаан байж болно.

- Электрон түлхүүрийг автомашинаас 3.5м (11 фут) хүртэлх зайнд 10-с дээш минут орхисон үед.
- Smart entry & start систем 5-с дээш хоног ашиглагдаагүй үед.

● Smart entry & start систем 14-с дээш хоног ашиглагдаагүй үед зөвхөн жолоочийн хаалгаар түгжээ тайлж болно. Энэ тохиолдолд жолоочийн хаалганы бариулнаас барих, алсын удирдлага ашиглах эсвэл механик түлхүүрээр хаалга тайлна.

■ **Электрон түлхүүрийн зайны цэнэг хэмнэх функц**

Зайны цэнэг хэмнэх горим сонгогдсон үед электрон түлхүүрийг радио долгион авдаггүй болгох замаар зайны цэнэг алдалтыг бууруулдаг.

Электрон түлхүүрний товчийг дарангаа товчийг 2 удаа дарна. Электрон түлхүүрийн индикатор 4 удаа анивчиж зайны цэнэг хэмнэх горимд шилжинэ.

Электрон түлхүүр зайны цэнэг хэмнэх горимд байгаа үед Smart entry & start систем ашиглах боломжгүй. Горимын цуцлах үед электрон түлхүүрийн аль нэг товчийг дарна.



Бүртгэлтэй түлхүүрийн тоог шалгах

Бүртгэлтэй түлхүүрийн тоог Lexus дилерт хандаж шалгуулах боломжтой.

Авто зогсоолын ажилтанд автомашины түлхүүр үлдээх үед

Шаардлагатай тохиолдолд урд хайрцгийг түгжинэ. Механик түлхүүрийг өөртөө үлдээх ба зөвхөн электрон түлхүүрийг зогсоолын ажилтанд өгнө.

Smart entry & start систем

⚠ АЮУЛТАЙ

■ **Радио долгионоос үүсэх нөлөөлөл (Smart entry & start системийн антенны нөлөөлөл)**

- Дотуур суулгасан дефибриллятор, кардиостимулятор /зохиомлоор зүрхний хэмнэл удирдагч/-тай хүн Smart entry & start системийн хүлээн авагч антеннаас зохих зай барих шаардлагатай. Радио долгион нь эдгээр төхөөрөмжийн ажиллагаанд нөлөөлж болзошгүй. Шаардлагатай үед Entry функцийг идэвхгүй болгох боломжтой. Та өөрийн Lexus дилерээс радио долгионы давтамж, цацагдах мөчлөг зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг авсны үндсэн дээр өөрийн эмчээс автомашины тус системийг идэвхгүй болгох шаардлагатай эсэх талаар зөвлөгөө авах нь зүйтэй.
- Дотуур суулгасан дефибриллятор, кардиостимулятор /зохиомлоор зүрхний хэмнэл удирдагч/-с бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн тухайн төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс радио долгионы төхөөрөмжийн ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн тухай мэдээлэл авна. Радио долгион эмчилгээний зарим электрон төхөөрөмжинд ихээхэн нөлөө үзүүлдэг.

Та өөрийн Lexus дилерт хандаж Entry функцийг хэрхэн идэвхгүй болгох тухай мэдээлэл авна уу.

МЭДЭЭЛЭЛ

■ **Антенны байрлал**



A Гадна антенн
B Дотор антенн
C Тээшний хэсгийн гадна антенн

■ **Мэдрэх хүрээ (электрон түлхүүр мэдрэх хүрээ)**



A Хаалга түгжих, тайлах үед

Хаалганы гадна бариулнаас электрон түлхүүр 0.7 м (2.3 ft.) зайнд байгаа үед систем ажиллана. (Зөвхөн түлхүүр мэдэрсэн хаалга ажиллана.)

B Хөдөлгүүр асаах, асаах товчны горим солих үед

Электрон түлхүүр автомашин дотор байх үед систем ажиллана.

■ **Дохиолол дуугарах, эсвэл дэлгэц дээр анхааруулга гарсан үед**

Автомашины гадна талын болон салоны анхааруулах дуут дохио, анхааруулах гэрэл болон мэдээллийн дэлгэц дээрх анхааруулах мэдээлэл нь хүний буруутай үйлдлээс шалтгаалан автомашин хулгайд өртөх, мөн таамаглашгүй алдаа гарахаас сэргийлдэг. Тухайн анхааруулах мэдээллийн дагуу тохирох арга хэмжээг авна.

Дараах хүснэгтэнд зөвхөн анхааруулах дуут дохио дуугарсан үеийн нөхцөл байдал, авах арга хэмжээг харуулав.

- Гадна талын анхааруулах дуут дохио нэг удаа 5 секунд дуугарах

  Нөхцөл байдал: Хаалга нээлттэй автомашин түгжих оролдлого хийсэн үед.

  Авах арга хэмжээ: Бүх хаалга бүрэн хаасны дараа дахин түгжинэ.

- Салоны анхааруулах дуут дохио үргэлжлэн дуугарах

  Нөхцөл байдал: Асаах товчийг жолоочийн хаалга нээлттэй ACC горимд шилжүүлсэн (эсвэл асаах товч ACC горимд байх үед жолоочийн хаалга нээсэн) үед

  Авах арга хэмжээ: Асаах товчийг OFF унтраагаад жолоочийн хаалга хаана.

■ **Ажиллагаанд нөлөөлөх нөхцөл**

Smart entry & start систем, түлхүүрийн алсын удирдлага, иммобилайзер систем нь хүчин чадал багатай радио долгион ашигладаг. Дараах тохиолдлуудад электрон түлхүүр болон автомашины хооронд долгион тасалдаж Smart entry & start систем, түлхүүрийн алсын удирдлага, иммобилайзер системийн ажиллагаа алдагдаж болно.

- Электрон түлхүүрийн зай суусан үед
- Телевизийн цамхаг, цахилгаан станц, ШТС, радио станц, том оврын дэлгэц, нисэх буудал, бусад хүчтэй радио долгион болон цахилгаан долгион ялгаруулдаг газрын ойр орчимд
- Электрон түлхүүр дараах металл эд зүйлстэй нийлсэн эсвэл бүрхэгдсэн үед
  - Хөнгөн цагаан ялтастай карт

- Дотроо хөнгөн цагаан материалаар бүрэгдсэн тамхины хайрцаг
- Металл түрийвч, цүнх
- Зоос
- Металлийн агаартай исэлдэх үед дулаан ялгаруулах чанарыг нь ашигласан гар дулаацуулагч элс (металл элс)
- CD, DVD зэргийн медиа дамжуулагч

● Ойр орчимд алсын удирдлагатай түлхүүр (радио долгион цацдаг) ашиглагдаж байгаа үед

● Электрон түлхүүрийг дараах радио долгион цацдаг төхөөрөмжүүдтэй хамт авч явах үед

- Зөөврийн радио, гар утас, бусад холбоо харилцааны утасгүй төхөөрөмж
- Радио долгион цацдаг өөр автомашины электрон түлхүүр, алсын удирдлагатай түлхүүр
- Персонал компьютер эсвэл халаасны компьютер
- Дижитал аудио тоглуулагч
- Зөөврийн тоглоомын консоль

● Ард талын шилэнд металлын агуулгатай шилний наалт эсвэл металл эд зүйлс наасан үед

● Электрон түлхүүрийг зай хураагуур цэнэглэгч эсвэл цахилгаан төхөөрөмжийн хажууд тависан үед

● Радио долгионоор ажилладаг төлбөртэй автозогсоолд байрлуулах үед

Дараах нөхцлүүдэд электрон түлхүүр үйлчлэх хүрээ (электрон түлхүүрийг таних хүрээ)-нд байсан ч систем ажиллахгүй байж болно:

● Хаалга түгжих, тайлах үед электрон түлхүүр цонх эсвэл хаалганы бариулд хэт ойр, автомашинаас хэт өндөр эсвэл хэт нам дор байх.

● Тээшний хаалга нээх үед электрон түлхүүр арын гуперны гол хэсэгт хэт ойр, автомашинаас хэт өндөр эсвэл хэт нам дор байх.

● Хөдөлгүүр асаах, хөдөлгүүр асаах товчны горим солих үед электрон түлхүүр хянах самбар, тээшний хэсгийг тусгаарлах гүйдэг хучлага болон шалан дээр, хаалганы халаас эсвэл урд хайрцагт байх.

■ **Entry функцийн анхааруулга**

● Автомашинаас гарах үедээ электрон түлхүүрийг хянах самбарын дээд тал, хаалганы халаасны ойр орчимд үлдээж болохгүй. Радио долгион хүлээн авч байгаа нөхцөл байдлаас хамаарч хүлээн авагч антенн түлхүүрийг автомашины гадна байна гэж таних, улмаар түлхүүрээ кабинд үлдээн түгжих нөхцөл бүрддэг.

● Электрон түлхүүр үйлчлэх хүрээнд байгаа үед бусад хүн хаалга түгжих, түгжээ тайлах боломжтой.

- Электрон түлхүүр автомашины гадна байгаа боловч цонхонд ойр үед хайбрид систем асч болно.
- Электрон түлхүүр системийн үйлчлэх хүрээнд байгаа үед бороо орох, автомашин угаах зэргээр хаалганы бариул дээр их хэмжээний ус цацагдсан тохиолдолд хаалганы түгжээ тайлагдаж болно. (Хэрвээ хаалга нээж хаагаагүй бол 30 орчим секундын дараа автоматаар түгжигдэнэ.)
- Электрон түлхүүр автомашины ойр орчимд байх үед алсын удирдлага ашиглан автомашин түгжсэн үед entry функцаар хаалганы түгжээ тайлагдахгүй байж болно. (Түгжээг алсын удирдлага ашиглан тайлна.)
- Бээлийтэй гараар хаалганы бариул барих үед хаалганы түгжээ тайлагдах, түгжигдэхгүй байж болно. Бээлийгээ тайлна.
- Хаалга түгжих мэдрэгч ашиглан түгжих үйлдэл хийсэн үед тухайн үйлдлийг танисныг илтгэх дохио 2 удаа дуугарна. Үүний дараа үйлдлийг танисан дохио дахиж дуугарахгүй.
- Автомашин угаах зэргээр хаалганы бариул норсон үед электрон түлхүүр үйлчлэх хүрээнд орсон тохиолдолд хаалганы түгжээ тайлагдах, түгжигдэх үйлдэл олон удаа давтагдаж болно. Энэ тохиолдолд дараах арга хэмжээг авна:
  - Электрон түлхүүрийг 2м (6 фут) ба түүнээс хол зайд тавина. (Түлхүүр хулгайд алдагдахаас сэргийлнэ.)
  - Электрон түлхүүрийг зайны цэнэг хэмнэх горимд тохируулж Smart entry & start системийг идэвхгүй болгоно.
- Электрон түлхүүр бүхээгт байгаа үед автомашин угаах зэргээр хаалганы бариул норсон үед мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарах ба дуут дохио автомашины гадна талд дуугарна. Анхааруулах дохиог унтраах үед бүх хаалгыг түгжинэ.
- Хаалга түгжих мэдрэгчид мөс, цас, шавар зэрэг тогтсон үед хэвийн ажиллахгүй. Энэ тохиолдолд мэдрэгчийг цэвэрлээд үйлдлийг давтах эсвэл бариулны доод талын түгжих мэдрэгч ашиглана.
- Үйлчлэх хүрээнд огцом орох эсвэл хаалганы бариулнаас огцом татах үед систем хаалганы түгжээ тайлагдахаас сэргийлж хаалга тайлагдахгүй байж болно. Энэ тохиолдолд хаалганы бариулыг анхны байрлалд буцаах ба түгжээ тайлагдсаны дараа дахин татна.
- Үйлчлэх хүрээнд өөр электрон түлхүүр байгаа үед хаалганы бариул атгаж тайлах үед систем бага зэрэг удаан ажиллаж болно.

■ **Автомашиныг удаан хугацаанд ашиглахгүй үед**

- Автомашин хулгайд алдахаас сэргийлж электрон түлхүүрийг автомашинаас 2м (6 фут) хүртэлх зайд хадгалахгүй.
- Smart entry & start системийг идэвхгүй болгох боломжтой.
- Электрон түлхүүрийн зайны цэнэг хэмнэх функц нь зайны цэнэг зарцуулалтыг бууруулна.

■ **Системийн хэвийн ажиллагааг хангах**

Системтэй ажиллах үед электрон түлхүүртэй байна. Гадна системтэй ажиллах үед электрон түлхүүрийг автомашинд хэт ойртуулахгүй.

Электрон түлхүүрийн байршил, хэрхэн бариж байгаагаас хамаарч түлхүүр зөв танигдахгүй байх, мөн систем зөв ажиллахгүй байж болно. (Автомашины дохиоллын систем гэнэт ажиллах, хаалга түгжигдэхээс сэргийлэх функц ажиллахгүй байх тохиолдол гарч болно.)

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Хаалга нээх/хаах

⚠ АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үеийн анхааруулга

Жолоодлогын үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Бүх хаалга бүрэн хаагдаж түгжигдсэн байгааг нягтлана.
- Хөдөлгөөний үед дотор талын хаалга нээх товч дарж болохгүй.

  Хаалга түгжээтэй байсан үед онгойх боломжтой тул ялангуяа жолоочийн хаалгыг анхаарна.
- Хүүхэд арын суудалд зорчих үед хойд хаалганы хүүхэд хамгаалах түгжээг түгжиж дотор талаас хаалга нээх боломжгүй болгоно.

■ Хаалга нээх, хаах үеийн анхааруулга

Хаалга нээх, хаах үед ойр орчмоо нягтлах ба бариулнаас чанга барина.

- Налуу зам дээр
- Хаалга болон хана зэрэг объект хүртэлх зай ойр
- Хүчтэй салхитай үед

МЭДЭЭЛЭЛ

■ Хаалганы түгжээний дохио

Хаалга бүрэн хаагдаагүй үед түгжих оролдлого хийсэн нөхцөлд дохио 5 секунд дуугарна. Хаалга бүрэн хааж дохиог зогсоох ба дахин түгжинэ.

■ Нээлттэй хаалга анхааруулах дохио

Автомашины хурд 5 км/ц (3 mph) хүрэх үед ерөнхий анхааруулах гэрэл анивчиж дохио дуугаран хаалга, эсвэл капот дутуу хаагдсаныг анхааруулна. Мэдээллийн дэлгэц дээр дутуу хаагдсан хаалга, капотыг харуулна.

■ Арын суудлын анхааруулах функц

Асаах товчийг OFF горимд унтраасан ба дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед эд зүйлсээ арын суудал дээр мартахаас сэргийлэх зорилгоор дуут дохио дуугарах ба мэдээллийн дэлгэц дээр анхааруулга 6 секунд гарна.

- Арын хаалга нээгээд хаасnаас хойш 10 минутын дотор хөдөлгүүр асаасан.
- Хөдөлгүүр ассаны дараа арын хаалга нээгдээд хаагдсан.

  Нөгөөтэйгүүр арын хаалга нээгээд 2 секундын дотор хаасан үед арын суудлын анхааруулах функц ажиллахгүй.

  Арын суудлын анхааруулах функц нь зөвхөн арын хаалга нээгээд хаах үйлдэл дээр үндэслэн арын суудалд эд зүйл тависан байж болохыг тооцдог тул тус функц нь эд зүйлээ арын суудалд мартаж үлдээсэн ч ажиллахгүй байх, эсвэл шаардлагагүй тохиолдолд ажиллаж болно.
- Арын суудлын анхааруулах функцийг идэвхжүүлэх/цуцлах боломжтой.

Холбоотой холбоосууд

Түлхүүрийн төрлүүд(Х. 70)

Хаалга түгжих/тайлах(Х. 82)

Механик түлхүүр ашиглах(Х. 605)

Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед(Х. 612)

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

Хаалга нээх

▶ Автомашины гадна талаас нээх



Хаалга түгжээтэй үед:

Электрон түлхүүрийг биедээ авч хаалганы бариулны хаалга нээх товч A дарж хаалга нээнэ.

Электрон түлхүүрийн таних хүрээнд хаалганы бариулны дотор талд байрлах хаалга нээх товчийг A дарна.

Хаалга түгжээтэй үед:

Хаалганы бариулны хаалга нээх товч A дарж хаалга нээнэ.

хаалганы бариулны дотор талд байрлах хаалга нээх товчийг A дарна.

▶ Автомашины дотор талаас нээх



Жолоочийн хаалга:

Хаалга түгжээтэй байсан ч хаалга нээх товчны A урд талыг дарж хаалга нээнэ.

Хаалганы түгжээ тайлагдах ба хаалганы түгжээний индикатор унтарна.

Зорчигчийн хаалга:

Хаалга түгжих товч дарж түгжээ тайлаад хаалга нээх товчны A урд талыг дарж хаалга нээнэ.

Хаалганы түгжээ тайлагдах ба хаалганы түгжээний индикатор унтарна.

МЭДЭЭЛЭЛ

Хаалганы дотор хаалга нээх товч ажиллах нөхцөл

Дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед:

- Автомашины хурд 4 км/ц (2 mph)-с бага ба зогсоолын тоормос залгагдсан
- Автомашины хурд 4 км/ц (2 mph)-с бага ба тоормосны дөрөө гишгэсэн
- Араа P байрлалд байгаа

Автомашины дотор талаас хаалга нээх үед

Хаалга нээх товч даран хаалга нээнэ.

Хаалганы түгжээ бүрэн тайлагдаагүй үед хаалга нээх товчийг 2 удаа дарж хаалга нээнэ.

Автомашины дотор талын гар аргаар нээх бариул

Автомашины дотор талын хаалга нээх товчийг гар аргаар хаалга нээхэд ашиглах боломжтой.

Хаалга нээх товчны цахилгаан удирдлагаар, эсвэл гар аргаар нээх бариулыг 2 удаа татан хаалга нээх боломжтой.



Хаалга түгжих/тайлах

МЭДЭЭЛЭЛ

■ Хүчтэй доргилтын үед түгжээ тайлах систем

Автомашин хүчтэй урд болон хойд мөргөлтөнд өртсөн үед бүх хаалганы гараар нээх бариулын ажиллагаа идэвхжинэ.

■ Ажиллагааны дохио

Дохио дуугарч ослын дохионы гэрэл анивчиж (2 удаа) түгжээ тайлагдсаныг илтгэнэ.

Дохио дуугарч ослын дохионы гэрэл анивчиж (1 удаа) түгжээ түгжигдсэнийг илтгэнэ.

■ Аюулгүй байдлын функц

Хаалганы түгжээ тайлагдсанаас 30 секундын дотор хаалга нээгээгүй үед аюулгүй байдлын функц автоматаар хаалга түгжинэ.

Smart entry & start систем ашиглах

Smart entry & start системээр хаалга түгжих, тайлах

Жолооч электрон түлхүүр (эсвэл түлхүүр карт)-г халаасандаа зэргээр цаг ямагт биедээ авч явна.



1 Хаалганы бариулаас атгаж түгжээ тайлна.*1

Бариулны ард талын мэдрэгчид хүрнэ.

Хаалга түгжигдсэнээс хойш 3 секундын дотор түгжээ тайлагдахгүй.

2 Түгжих мэдрэгчид (хаалганы бариулын хонхор хэсэг) хүрч хаалга түгжинэ.

Хаалга бүрэн түгжигдсэн байгааг нягтлана.

Хаалга түгжигдэх үед дохиолол идэвхжинэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Түгжих мэдрэгчид хуруугаар хүрсэн ч хаалга түгжигдэхгүй үед

Түгжих мэдрэгчид гарын алгаар хүрнэ.

Бээлий өмссөн үед тайлна.

*1 : Хаалганы түгжээ тайлах тохиргоог өөрчлөх боломжтой.



Түгжээ тайлах хаалгыг өөрчлөх

Entry функцийн аль хаалгаар түлхүүрийн алсын удирдлага ашиглан түгжээ тайлах тохиргоо хийж болно.

1 **Асаах товч унтраана.**

2 **Тохиргоо хийх үед дохиоллын систем санамсаргүйгээр идэвхжихээс сэргийлж гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч* болон хазайлтын мэдрэгчийг* унтраана.**

3 **Түлхүүрийн индикатор асаагүй үед , , эсвэл * товчийг товчийг дарангаа 5 секунд дарна.**

Дараах үйлдэл хийх бүрт тохиргоо өөрчлөгдөнө. (Тохиргоог үргэлжлүүлэн өөрчлөх үед товчийг суллан 5-с дээш секунд хүлээгээд 3-р үйлдлийг давтана.)

Мэдээллийн дэлгэц/Богино дуу	Түгжээ тайлах функц
 Гадна тал: 3 удаа дуугарах Дотор тал: Нэг удаа дуугарах	Жолоочийн хаалганы бариулнаас атгах үед зөвхөн жолоочийн хаалганы түгжээ тайлагдана.
	Аль нэг зорчигчийн хаалганы бариулнаас атгах үед бүх хаалганы түгжээ тайлагдана.
 Гадна тал: 2 удаа дуугарах Дотор тал: Нэг удаа дуугарах	Аль нэг хаалганы бариулнаас атгах үед бүх хаалганы түгжээ тайлагдана.

Тохиргоо хийж дууссаны дараа автомашины дохиолол санамсаргүй ажиллахаас сэргийлж алсын удирдлагатай түлхүүрээр түгжээ тайлж хаалга нээгээд хаана. (Хэрэв товч дарснаас хойш 30 секундын дотор хаалга онгойлгоогүй үед хаалга дахин түгжигдэх ба дохиоллын

*:Тоноглогдсон автомашинд

систем идэвхжинэ.) Дохиоллын систем ажилласан үед нэн даруй салгана.

Түлхүүрийн алсын удирдлага ашиглан ажиллуулах

Түлхүүрийн алсын удирдлагаар хаалга түгжих, тайлах



1 Бүх хаалга түгжинэ

Хаалга бүрэн түгжигдсэнийг нягтлана.

2 Бүх хаалга тайлна

МЭДЭЭЛЭЛ

Хулгайгаас сэргийлэх паник горим*

-г 1 секундээс удаан дарах үед дохиолол тасалдан дуугарч гэрэл анивчин автомашинд нэвтрэх, эвдрэл гэмтэл учруулах гэж буй хүнээс автомашиныг хамгаална.

Дохиоллыг унтраах үед электрон түлхүүрийн аль нэг товчийг дарна.



Хаалга түгжих товч ашиглах

Хаалга түгжих товчоор хаалга түгжих/тайлах



1 товч дарна.

Бүх хаалга түгжигдэнэ.

A индикатор асна.

2 товч дарна.

Бүх хаалганы түгжээ тайлагдана.

A унтарна.

Хаагаад түгжих (холдох) *функц

Тээшний автомат хаалга нээлттэй байгаа үед тээшний хаалга хаагдах үед бүх хаалга түгжигдэнэ.

*: Тоноглогдсон автомашинд

МЭДЭЭЛЭЛ

■ Хаагаад түгжих (холдох) функцийн ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед тус функц ажиллана:

- Автомашин дотор электрон түлхүүр мэдрэгдээгүй.
- Тээшний автомат хаалганаас бусад бүх хаалга хаалттай.
- Тоормосны дөрөө гишгээгүй.
- Асаах товч унтраастай.

■ Гарны оролцоогүй хаагаад түгжих (холдох) функцийн* ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед тус функц ажиллана:

- Гарны оролцоогүй хаагаад түгжих (холдох) функцийн тохиргоо идэвхтэй.
- Гарны оролцоогүй тээшний автомат хаалга ажиллах нөхцөл бүрдсэн.
- Автомашин дотор электрон түлхүүр мэдрэгдээгүй.
- Тээшний автомат хаалганаас бусад бүх хаалга хаалттай.
- Тоормосны дөрөө гишгээгүй.
- Асаах товч унтраастай.

■ Хаагаад түгжих (холдох) функц хэвийн ажиллахгүй нөхцлүүд

Дараах нөхцөлд хаагаад түгжих (холдох) функц хэвийн ажиллахгүй:

- Электрон түлхүүртэй гараараа тээшний хаалганы доод талын товч дарсан
- Электрон түлхүүрийг цүнх зэрэгт хийж газарт тавиад тээшний хаалганы доод талын товч дарсан
- Электрон түлхүүр ойр байхгүй үед тээшний хаалганы доод талын товч дарсан

Тээшний хаалга хаагаад бүх хаалга түгжих



1 Дараах үйлдлийг автомашин дотор электрон түлхүүр байхгүй үед хийнэ. Тээшний автомат хаалга хаагдах үед бүх хаалга түгжигдэнэ.

Товч ашиглах:

2 Электрон түлхүүрийг биедээ аван тээшний автомат хаалганы доод талын товч дарна.

Тээшний автомат хаалганаас холдох үед хаалга автоматаар хаагдана.

Электрон түлхүүртэй хүн дахин ойртох үед тээшний автомат хаалганы хаагдах ажиллагаа зогсоно.

Хэвийн үеэс өөр дуут дохио дуугарна. Тээшний автомат хаалга хаагдах үед бүх хаалга түгжигдсэнийг илтгэн хаалга түгжих ажиллагааны дохио дуугарна.

Гарны оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин:*2

3 Электрон түлхүүртэй хүн гарны оролцоогүй тээшний автомат хаалга хаах үйлдэл хийсэн үед бүх хаалга зэрэг түгжигдэнэ.

Тээшний автомат хаалганаас холдох үед хаалга автоматаар хаагдана.

Электрон түлхүүртэй хүн дахин ойртох үед тээшний автомат хаалганы хаагдах ажиллагаа зогсоно.

Хэвийн үеэс өөр дуут дохио дуугарна. Тээшний автомат хаалга хаагдах үед бүх хаалга түгжигдсэнийг илтгэн хаалга түгжих ажиллагааны дохио дуугарна.

⚠ АЮУЛТАЙ

Тээшний автомат хаалгыг хаагаад холдох функцаар хаах үед хаах үйлдэл эхлэхээс өмнө хэвийн үеэс өөр дохио дуугарна.

Үйлдэл зөв эхлэснийг дохио хэвийн үеэс өөрөөр 1 удаа дуугарснаар нягтлана.

Мөн тээшний автомат хаалга бүрэн хаагдаад түгжигдсэн үед бүх хаалга түгжигдсэнийг илтгэн хаалга түгжих ажиллагааны дохио дуугарна.

Автомашин орхин явахаас өмнө ажиллагааны дохио дуугарч бүх хаалга түгжигдсэнийг нягтлана.

*2 : Тус тохиргоог та Lexus дилер дээрээ өөрчлүүлэх боломжтой.

Хулгайгаас сэргийлэх систем

Тус автомашин нь автомашины хулгайгаас сэргийлэхэд туслах хөдөлгүүрийн иммобилайзер систем болон дохиоллын системтэй болно. Хөдөлгүүрийн иммобилайзер систем нь тус автомашинд бүртгэснээс бусад түлхүүрээр автомашинд нэвтрэх, хөдөлгүүр асаахаас сэргийлдэг. Түлхүүрт суурилагдсан транспондер чипээр дамжуулан бүртгэгдсэн түлхүүрийг зөвшөөрөлгүйгээр хуулбарласан хуулбар түлхүүрээс ялгадаг. Дохиоллын систем нь автомашинд халдлага үйлдэж буйг мэдэрсэн нөхцөлд гэрэл болон дохиогоор анхааруулга өгдөг.

МЭДЭЭЛЭЛ

■ Entry функцийн анхааруулга

Хөдөлгүүрийн иммобилайзер систем нь автомашины хулгайгаас сэргийлэх зорилготой. Нөгөөтэйгүүр систем нь автомашины хулгайн эсрэг үнэмлэхүй хамгаалалт биш болно.

■ Системийн засвар үйлчилгээ

Автомашинд засвар үйлчилгээ шаарддаггүй хөдөлгүүрийн иммобилайзер систем болон дохиоллын систем суурилагдсан байдаг.

■ Дохиолол ажиллах

Дараах нөхцлүүдэд дохиолол ажиллана:

- Механик түлхүүрээр хаалганы түгжээ тайлсан.

  Малайз, ӨАБНУ-с бусад: Дохиоллын систем идэвхтэй үед механик түлхүүрээр хаалганы түгжээ тайлсан нөхцөлд анхааруулах дохио 10 секунд дуугарна. Дохиоллыг энэ хугацаанд цуцлаагүй, эсвэл зогсоогоогүй үед дохиоллын анхааруулга өгөх хэлбэр өөрчлөгдөх ба дохио тодорхой хугацаанд үргэлжлэн дуугарна.
- Автомашин дотор байгаа хүн хаалга, капот нээх, эсвэл тээшний дотор бариулны түгжээний хөшүүргээр хаалганы түгжээ тайлсан.
- Автомашин түгжээтэй үед аккумуляторыг цэнэглэсэн, эсвэл солисон.
- Entry функц, түлхүүрийн алсын удирдлага, механик түлхүүрээс бусад аргаар түгжээтэй хаалга тайлсан, эсвэл нээсэн. (Хаалга буцаж автоматаар түгжигдэнэ.)
- Капотыг автомашины гадна талаас нээсэн.
- Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч* автомашин дотор хөдөлгөөн мэдэрсэн. (Жишээ: халдагч цонх хагалан дотогш нэвтэрсэн.)
- Хазайлтын мэдрэгч* автомашин хазайсныг мэдэрсэн.

*: Тоноглогдсон автомашинд

■ **Дохиоллын ажиллагаатай холбоотой хаалга түгжих функцийн ажиллах нөхцөл**

Дараах тохиолдлуудад тухайн нөхцөл байдлаас хамаарч автомашинд буруу нэвтрэхээс сэргийлж тус функц хаалга түгжиж болно:

- Автомашинд үлдсэн хүн хаалганы түгжээ тайлсан ба дохиолол идэвхжсэн.
- Дохиолол идэвхжсэн ба автомашинд үлдсэн хүн хаалганы түгжээ тайлсан.
- Аккумулятор цэнэглэсэн, эсвэл солисон.

Хөдөлгүүрийн иммобилайзер систем идэвхжүүлэх

⚠ АНХААР

Системийг өөрчлөх, эсвэл салгаж болохгүй. Өөрчилсөн, салгасан нөхцөлд систем хэвийн ажиллах баталгаагүй болно.

Асаах товчийг унтраана.

Хөдөлгүүрийн иммобилайзер системийг идэвхжүүлсэн үед систем ажиллаж байгааг илтгэн дохиоллын системийн индикатор анивчина.

Автомашинаас холдох үед салонд түлхүүр үлдээж болохгүй.



МЭДЭЭЛЭЛ

■ **Хөдөлгүүрийн иммобилайзер системийг цуцлах**

Автомашинд бүртгэгдсэн түлхүүрийг биедээ авч асаах товчийг ACC, эсвэл ON горимд шилжүүлнэ. Хөдөлгүүрийн иммобилайзер систем цуцлагдаж дохиоллын системийн индикатор унтарна.

Давхар түгжих систем ба системийн ажиллагаа*

Давхар түгжих систем нь автомашины дотор болон гадна талаас хаалганы түгжээ тайлах боломжгүй болгож гадны биет нэвтрэхээс сэргийлдэг.

⚠ АЮУЛТАЙ

Дотор талаас хаалга нээх боломжгүй болох тул автомашинд хүн байгаа үед ямар ч нөхцөлд давхар түгжих системийг идэвхжүүлж болохгүй.

*:Тоноглогдсон автомашинд

Тус системтэй автомашины урд 2 хаалганы цонхонд дээр тэмдэг байдаг.



Давхар түгжих системийг идэвхжүүлэх

Асаах товчийг унтрааж бүх зорчигчийг буулгаад бүх хаалга хаана.

Entry функц ашиглах: Хаалганы гадна бариулын мэдрэгчид 5 секундын дотор 2 удаа хүрнэ.

Түлхүүрийн алсын удирдлага ашиглах: -г 5 секундын дотор 2 удаа дарна.

Давхар түгжих систем идэвхжинэ.

Давхар түгжих системийг цуцлах

Entry функц ашиглах: Хаалганы гадна бариулаас бариад тээшний хаалганы товч дарах, эсвэл гарын гуперны төв хэсгийн доогуур хөлөө хөдөлгөнө (гарны оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин).

Түлхүүрийн алсын удирдлага ашиглах: товч дарна.

Дохиоллын систем идэвхжүүлэх

Дохиоллын систем идэвхжүүлэхийн өмнө дараах зүйлсийг нягтлана:

- Автомашинд хүн байхгүй байгааг нягтлана.
- Дохиоллын систем идэвхжүүлэхийн өмнө бүх цонх, дээврийн нээлхий хаана.
- Үнэ цэнэтэй эд зүйл, бусад хувийн эд зүйл автомашинд үлдээгүйг нягтлана.

⚠ АНХААР

Системийг өөрчлөх, эсвэл салгахыг хориглоно. Системийг өөрчилсөн, салгасан үед системийн найдвартай ажиллагааны баталгаа алдагдана.



Малайз, ӨАБНУ-с бусад: Хаалга ба капот хаагаад автомашиныг түгжинэ. Систем автоматаар 30 секундын дараа идэвхжинэ.

Малайз, ӨАБНУ: Хаалга ба капот хаагаад entry функц, эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар автомашиныг түгжинэ. Систем автоматаар 30 секундын дараа идэвхжинэ.

Индикатор гэрэл үргэлжлэн асах горимоос анивчин асч систем идэвхжсэнийг илтгэнэ.

Капот нээлттэй хэвээр бүх хаалга хаасан үед дохиоллын системийг идэвхжүүлэх боломжтой.

Дохиоллын системийг цуцлах/зогсоох

Дохиоллын системийг цуцлах, эсвэл зогсоох үед дараах аль нэг үйлдлийг хийнэ:

- **Малайз, Өмнөд Африкаас бусад: Хаалганы түгжээ тайлна.**
- **Малайз, Өмнөд Африк: Entry функц, эсвэл түлхүүрийн алсын удирдлага ашиглан хаалганы түгжээ тайлна.**
- **Малайз, Өмнөд Африкаас бусад: Асаах товчийг ACC, эсвэл ON горимд шилжүүлэх, эсвэл хөдөлгүүр асаана.**
- **Малайз, Өмнөд Африк: Хөдөлгүүр асаана.**

Хэдэн секундын дараа дохиолол цуцлагдах, эсвэл ажиллагаа зогсоно.

Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч, хазайлт мэдрэгч*

Автомашинд гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч нь автомашин халдлагад өртөх, эсвэл автомашин дотор хөдөлгөөн үүссэн үед мэдэрнэ. Хазайлт мэдрэгч нь автомашин ачигдах зэргээр хазайлт үүссэн үед мэдэрнэ. Энэ нь гадны халдлагад өртөхөөс хамгаалах зориулалттай систем ба нөгөөтэйгүүр автомашины халдлагын эсрэг үнэмлэхүй хамгаалалт биш юм.

⚠ АНХААР

Автомашинд гадны биет нэвтэрснийг таних мэдрэгчийн хэвийн ажиллагааг хангах.

* : Тоноглогдсон автомашинд

⚠ АНХААР

- Мэдрэгчийн нүх рүү агаар цэвэршүүлэгч болон бусад зүйл шууд цацахыг хориглоно.



- Мэдрэгчинд хүрэх, таглахыг хориглоно.



- Lexus-н оригинал биш тоноглол суурилуулах, жолооч болон урд зорчигчийн суудлын хооронд аливаа эд зүйлс тавих нь мэдрэгчийн чадварыг бууруулна.
- Электрон түлхүүр автомашины ойр орчимд байх үед гадны биет нэвтэрснийг таних мэдрэгчийн ажиллагааг цуцлаж болно.

МЭДЭЭЛЭЛ

■ Хазайлтын мэдрэгчтэй холбоотой анхаарах зүйлс

Мэдрэгч дараах тохиолдлуудад дохиоллын системийг идэвхижүүлнэ:

- Автомашины дотор хүн, эсвэл гэрийн тэжээвэр амьтан үлдсэн.
- Цонх, дээврийн нээлхий нээлттэй үед. Энэ тохиолдолд мэдрэгч дараах зүйлсийг мэдрэх боломжтой:
  - Салхи, эсвэл автомашины бүхээг дахь навч, хорхой шавьж зэргийн хөдөлгөөн
  - Бусад автомашины автомашинд гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч зэргийн цацаж буй хэт авианы давтамж
  - Автомашины гадна талд байгаа хүний хөдөлгөөн
- Автомашин дотор дэнгийн эрвээхэй, ялаа зэрэг жижиг хорхой шавьж байгаа
- Бүхээгт өлгөдөг тоглоом, эсвэл хувцасны өлгүүрт өлгөөстэй хувцас зэрэг хялбар хөдөлдөг эд зүйлс байгаа үед.
- Авто зогсоол, гарааж зэрэг дуу чимээ, чичиргээ ихтэй газар автомашин байрлуулсан үед.

- Автомашинд үргэлжилсэн чичиргээ, доргилт учруулах байдлаар тогтсон цас, мөсийг арилгах үед.
- Автомашин өндөр даралттай авто угаалга эсвэл автомат авто угаалгын газарт байгаа үед.
- Автомашин мөндөр, аянга цахилгаан, мөн бусад үргэлжилсэн чичиргээ, доргилтонд өртсөн үед.

■ **Хазайлтын мэдрэгчтэй холбоотой анхаарах зүйлс**

Мэдрэгч дараах тохиолдлуудад дохиоллын системийг идэвхижүүлнэ:

- Усан онгоц, чиргүүл, галт тэрэг зэргээр автомашин тээвэрлэж байгаа үед.
- Автомашиныг авто зогсоолд байрлуулсан үед.
- Автомашиныг автоматаар хөдөлгөх зарчмаар ажилладаг авто угаалгад.
- Аль нэг дугуйны хийн даралт буурсан үед.
- Домкратаар өргөх үед.
- Газар хөдлөлт үүсэх, эсвэл зам цөмрөх үед.
- Дээврийн ачаанд ачаа тээш ачсан, буулгасан үед.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Гадны биет халдсан, хазайлтыг мэдрэх мэдрэгчийг идэвхжүүлэх

Дохиоллын систем идэвхжих үед гадны биет халдсан, хазайлтыг мэдрэх мэдрэгч автоматаар идэвхжинэ.

Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч, хазайлтын мэдрэгчийн ажиллагааг цуцлах

Автомашин дотор гэрийн тэжээвэр амьтан болон бусад хөдөлдөг зүйл үлдээх үед эдгээр нь дохиолол ажиллуулж болох тул дохиоллын систем идэвхжүүлэхийн өмнө мэдрэгчүүдийг цуцлана.

Эдгээр мэдрэгчийн ажиллагаа цуцласан ч дохиолол ажиллана.

1 **Товчлол дэлгэцийн товч дарна.**

2 **-г дарна.**

Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч, хазайлтын мэдрэгчийн ажиллагаа цуцлагдах ба мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

Мэдрэгчүүдийг идэвхжүүлэх үед дахин дарна.

Мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

МЭДЭЭЛЭЛ

■ Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч, хазайлтын мэдрэгч автоматаар идэвхжих

- Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч, хазайлтын мэдрэгчийг цуцласны дараа entry функц, эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар хаалганы түгжээ тайлах үед мэдрэгчүүд автоматаар идэвхжинэ.
- Дохиоллын системийг дахин идэвхжүүлэх үед гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч, хазайлтын мэдрэгч дахин идэвхжинэ.

Автомашинд ачаа тээш ачих

Тээшний хэсэгт ачаа тээш ачих үеийн анхааруулга

⚠ АЮУЛТАЙ

■ **Ачаа тээшний анхааруулга**

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд дөрөөний зөв ажиллагаанд саад учруулах, жолоочид харагдах байдлыг хязгаарлах, эсвэл эд зүйлс жолооч, зорчигчийг цохих, улмаар осол аваар үүсэхэд хүргэх аюултай.

- Тээшний хэсэгт ачсан үед дараах зүйлс нь галын аюул үүсгэх аюултай:
  - Бензин хийсэн сав
  - Лааз тай шүршдэг аэрозолын бүтээгдэхүүн
- Тээшний хэсэгт ачаа тээшийг боломжтой нөхцөлд бэхлэнэ.
- Тээшний хэсэгт суудлын түшлэгээс өндөрлөн ачаа тээшийг давхарлан ачиж болохгүй.
- Арын суудлыг доош эвхэх үед урд суудлын ард талд урт эд зүйл хийж болохгүй.
- Тээшний хэсэгт зорчигч суулган хөдөлгөөн оролцохыг хориглоно.

  Энэ нь зорчигч тээвэрлэхэд зориулагдаагүй болно.

  Зорчигч суудал дээр сууж аюулгүйн бүс зөв бүслэх шаардлагатай.
- Дараах байрлалуудад ачаа тээш байрлуулахыг хориглоно.
  - Жолоочийн хөлний хажууд
  - Урд зорчигчийн, эсвэл арын суудал дээр (эд зүйл давхарлаж тавих үед)
  - Тээшний хэсгийн эвхэгддэг хаалт дээр
  - Салоны урд хэсэгт
  - Хянах самбар дээр
- Зорчигчийн хэсэгт байгаа бүх ачаа тээшийг хөдөлгөөнгүй бэхлэнэ.

■ **Ачааны жин болон хуваарилалтын талаарх анхааруулга**

- Автомашины даацыг хэтрүүлж болохгүй.
- Ачаа тээшийг жигд хуваарилж ачина.

  Ачаа тээшийг жигд бус ачсан нөхцөлд дугуй бүр дээр ирэх ачаалал өөр байна. Энэ нь автомашины жолоодлого, тоормосны гүйцэтгэлийг бууруулах, улмаар осол аваарт хүргэх аюултай.

■ **Дээврийн ачаа ашиглах үед (дээврийн ачаатай автомашин)**

Дараах анхааруулгыг мөрдөнө:

- Ачаа тээшийг урд болон хойд тэнхлэг дээр жигд хуваарилагдахаар ачина.

⚠ АЮУЛТАЙ

- Урт, эсвэл өргөн ачаа тээш ачих үед автомашины урт болон өргөнөөс хэтэрч болохгүй.
- Жолоодлогын өмнө дээврийн ачаанд ачаа тээш сайтар бэхлэгдсэн байгааг нягтлана.
- Дээврийн ачаа дээр ачаа тээш ачих нь автомашины хүндийн төвийг дээшлүүлдэг.

  Өндөр хурд, огцом хөдөлгөөн, эргэлт, маневр хийхээс зайлсхийнэ. Автомашины хэвийн жолоодлого алдагдах, хөмрөх аюултай.
- Хол зам, энхэл донхолтой, эсвэл өндөр хурдаар явах үед автомашиныг ойр ойрхон зогсоож ачаа хөдөлгөөнгүй байгааг нягтлана.
- Дээврийн ачаан дээр 80 кг (176.3 lb.)-с их ачаа тээш ачиж болохгүй.

⚠ АНХААР

Дээврийн нээлхий болон панорамик дээврийн нээлхий дээр ачаа тээш тавиж болохгүй. Эсрэг тохиолдолд нээлхийг гэмтээх аюултай.

Тээшний хаалганы функц ба ажиллагаа

Тээшний хаалгыг дараах дарааллаар түгжих/тайлах болон нээх/хаах боломжтой.

⚠ АЮУЛТАЙ

■ Хөдөлгөөн эхлэхийн өмнө

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Хөдөлгөөн эхлэхийн өмнө тээшний хаалга гүйцэд хаана. Хаалга дутуу хаагдсан үед хөдөлгөөний явцад гэнэт онгойх, улмаар осол аваар үүсгэх аюултай.

■ Жолоодлогын үеийн анхааруулга

- Хөдөлгөөний үед тээшний хаалга хаалттай байлгана.

  Тээшний хаалга нээлттэй үед хаалга ойр орчмын эд зүйлийг цохих, эсвэл ачаа тээш унаж осол үүсэх шалтгаан болно.

  Үүнээс гадна хаягдал утаа бүхээгт орж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай. Хөдөлгөөн эхлэхийн өмнө тээшний хаалга хаана.
- Ямарч нөхцөлд тээшний хэсэгт хүн суулгаж болохгүй.

  Огцом тоормос, эргэлт, эсвэл мөргөлтийн үед тээшний хэсэгт суусан зорчигчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

■ Автомашинд хүүхэд байгаа үед

Дараах анхааруулгыг мөрдөнө.

⚠ АЮУЛТАЙ

- Тээшний хэсэгт хүүхэд тоглуулж болохгүй.

  Тээшний хэсэгт хүүхэд санамсаргүйгээр түгжигдсэн үед хэт халуун болон бусад бэртэл гэмтэл авах аюултай.
- Бага насны хүүхдээр тээшний хаалга нээлгэж хаалгаж болохгүй.

  Тээшний хаалга гэнэт хөдлөх, эсвэл хүүхэд гар хуруу, толгой, хүзүүгээ тээшний хаалганд хавчуулах аюултай.

■ Тээшний хаалга ажиллуулах

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Тээшний хаалга ажиллуулахаас өмнө цас мөс зэрэг хүнд зүйлсийг хаалганаас авна. Эсрэг тохиолдолд тээшний хаалга нээгдсэнийхээ дараа гэнэт хаагдах аюултай.
- Тээшний хаалга нээх хаах үед ойр орчмын аюулгүй байдлыг сайтар нягтална.
- Ойр орчимд бусад хүн байгаа үед тэдний аюулгүй байдлыг нягтлах ба тээшний хаалга нээх хаах гэж буйг мэдэгдэнэ.
- Хүчтэй салхинд цохигдон хаалга огцом савах аюултай тул салхитай үед тээшний хаалга нээх хаах үед анхаарал болгоомжтой хандана.
- Тээшний автомат хаалгагүй автомашин: Тээшний хаалга бүрэн нээгдээгүй үед гэнэт хаагдах аюултай. Тэгш газартай харьцуулахад налуу газар дээр тээшний хаалга нээж хаах нь хүндрэлтэй тул хаалга гэнэт нээгдэх, хаагдахаас сэргийлнэ. Тээшний хэсгийг ашиглахаас өмнө тээшний хаалга бүрэн нээгдэж хөдөлгөөнгүй байгааг нягтлана.
- Тээшний автомат хаалгатай автомашин: Тээшний хаалга бүрэн нээгдээгүй үед гэнэт хаагдах аюултай. Тэгш газартай харьцуулахад налуу газар дээр тээшний хаалга нээж хаах нь хүндрэлтэй тул хаалга гэнэт нээгдэх, хаагдахаас сэргийлнэ. Тээшний хэсгийг ашиглахаас өмнө тээшний хаалга бүрэн нээгдэж хөдөлгөөнгүй байгааг нягтлана.
- Тээшний хаалга хаах үед гар хуруу зэргээ хавчуулахаас сэргийлнэ.
- Тээшний хаалга хаах үед хаалганы гадна талыг зөөлөн дарна. Тээшний хаалганы бариул ашиглан хаах үед гар хуруугаа хаалганд хавчуулах аюултай.
- Тээшний хаалга өргөгч (тээшний автомат хаалгагүй автомашин), эсвэл тээшний хаалганы өргөгч цилиндрээс (тээшний автомат хаалгатай автомашин) татаж хаалга хаах, эсвэл тээшний хаалга өргөгч (тээшний автомат хаалгагүй автомашин) тээшний хаалганы өргөгч цилиндрээс (тээшний автомат хаалгатай автомашин) зүүгдэхийг хориглоно. Энэ нь гар хуруугаа хавчуулах, эсвэл тээшний хаалга өргөгч (тээшний автомат хаалгагүй автомашин), тээшний хаалганы өргөгч цилиндрийг (тээшний автомат хаалгатай автомашин) гэмтээх, улмаар осолд хүргэх аюултай.

⚠ АЮУЛТАЙ

- Тээшний хаалганд унадаг дугуйн суурь, түүнтэй төстэй хүнд зүйл угсарсан үед нээгдсэн хаалга гэнэт хаагдах, хүний гар хуур, толгой, хүзүү хавчиж гэмтээх аюултай. Тээшний хаалганд тоноглол угсрах үед Lexus-н оригинал бүтээгдэхүүн ашиглахыг зөвлөж байна.

■ Тээшний сордог хаалга (тээшний автомат хаалгатай автомашин)

- Тээшний хаалга дутуу хаагдсан үед тээшний сордог хаалга автоматаар гүйцэд хаана. Тээшний сордог хаалга ажиллах хүртэл хэдэн секундын хугацаа шаардагдана. гар хурууны яс бяцрах, бусад ноцтой бэртэл гэмтэл үүсгэх тул гар хуруу болон бусад зүйлсийг тээшний хаалганд хавчуулахаас сэргийлнэ.
- Тээшний автомат хаалганы ажиллагааг цуцласан ч тээшний сордог хаалга ажиллах тул сордог хаалга ашиглах үед гар хуруугаа болон бусад эд зүйл хавчуулахаас сэргийлнэ.

■ Тээшний автомат хаалга

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Хаалганд саад болох зүйл байгаа эсэх, эсвэл бусад эд зүйл хавчуулагдахаас сэргийлж ойр орчны аюулгүй байдлыг нягтлана.
- Ойр орчимд бусад хүн байгаа үед тэдний аюулгүй байдлыг нягтлах ба тээшний автомат хаалга нээх хаах гэж буйг мэдэгдэнэ.
- Тээшний автомат хаалга ажиллах явцах тус хаалганы системийн ажиллагааг цуцласан нөхцөлд тээшний автомат хаалганы ажиллагаа зогсоно. Энэ нөхцөлд тээшний автомат хаалгыг гараар ажиллуулах шаардлагатай. Тээшний автомат хаалга гэнэт нээгдэх, хаагдах аюултай тул өндөр болгоомжтой хандана.
- Тээшний автомат хаалганы ажиллагааны нөхцөл алдагдсан үед дуут дохио дуугарч тээшний автомат хаалганы ажиллагаа зогсоно. Энэ нөхцөлд тээшний автомат хаалгыг гараар ажиллуулах шаардлагатай. Тээшний автомат хаалга гэнэт нээгдэх, хаагдах аюултай тул өндөр болгоомжтой хандана.
- Налуу газарт тээшний автомат хаалга нээгдсэнийхээ дараа гэнэт хаагдах аюултай. Тээшний автомат хаалгыг бүрэн нээж хөдөлгөөнгүй бэхлэнэ.
- Дараах нөхцлүүдэд тээшний автомат хаалга хэвийн бус байдал мэдэрч автомат ажиллагаа цуцлагдаж болно. Энэ нөхцөлд тээшний автомат хаалгыг гараар ажиллуулах шаардлагатай. Зогссон тээшний хаалга огцом нээгдэх, эсвэл хаагдах, улмаар осолд хүргэх аюултай тул энэ нөхцөлд анхаарал болгоомжтой хандана.
  - Тээшний автомат хаалга сааданд тулсан үед
  - Асаах товчийг ON горимд шилжүүлсэн, эсвэл хөдөлгүүр автомат ажиллагаагаар ассан зэргээр аккумуляторын хүчдэл гэнэт буурсан үед

⚠ АЮУЛТАЙ

- Тээшний автомат хаалганд унадаг дугуйн суурь, түүнтэй төстэй хүнд зүйл угсарсан үед хаалга ажиллахгүй байх, доголдол үүсэх, эсвэл нээгдсэн хаалга гэнэт хаагдах, хүний гар хуур, толгой, хүзүү хавчиж гэмтээх аюултай. Тээшний автомат хаалганд тоноглол угсрах үед Lexus-н оригинал бүтээгдэхүүн ашиглахыг зөвлөж байна.

■ Хавчихаас хамгаалах функц (тээшний автомат хаалгатай автомашин)

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Хавчихаас хамгаалах функцийг албаар идэвхжүүлэхийн тулд биеийн аль нэг хэсгээ ашиглаж болохгүй.
- Хавчихаас хамгаалах функц нь тээшний автомат хаалга бүрэн хаагдахын өмнө аливаа зүйл хавчуулагдсан ч ажиллахгүй байж болно. Гар хуруу, эд зүйл хавчуулахаас сэргийлнэ.
- Хавчихаас хамгаалах функц нь хавчуулагдсан зүйлийн хэлбэрээс хамаарч ажиллахгүй байж болно. Гар хуруу, эд зүйл хавчуулахаас сэргийлнэ.

⚠ АНХААР

■ Тээшний хаалганы өргөгч цилиндрийн анхааруулга (тээшний автомат хаалгатай автомашин)

Тээшний хаалга нь хаалгыг өргөсөн байрлалд баридаг өргөгч цилиндртэй A болно.

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд тээшний хаалганы өргөгч цилиндрийг гэмтээх A, улмаар осол аваарт хүргэх аюултай.



- Хуулга, наалддаг цаас болон бусад эд зүйлсийг цилиндрийн голд наахгүй байх.
- Цилиндрийн голд бээлий, бусад даавуун материал хүргэхгүй байх.
- Тээшний хаалганд хүнд зүйл угсрахгүй байх.

  Угсрах үед та өөрийн Lexus дилерээс зөвлөгөө авна уу.
- Цилиндрт гараар хүрэх, эсвэл хөндлөн чиглэлд татаж түлхэж болохгүй.

⚠ АНХААР

■ Тээшний хаалга өргөгчийн анхааруулга (тээшний автомат хаалгагүй автомашин)

Тээшний хаалга нь хаалгыг өргөсөн байрлалд баридаг A тээшний хаалга өргөгчтэй. Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд тээшний хаалга өргөгч гэмтэх A, улмаар доголдол үүсгэнэ.



- Хуулга, наалддаг цаас болон бусад эд зүйлсийг өргөгчийн голд наахгүй байх.
- Өргөгчийн голд бээлий, мөн бусад даавуун материалтай эд зүйлс хүргэхгүй байх.
- Тээшний хаалганд Lexus-н оригинал биш нэмэлт тоноглол угсарч болохгүй.
- Өргөгчийн голд бээлий, мөн бусад даавуун материалтай эд зүйлс хүргэхгүй байх.

■ Тээшний автомат хаалга, тээшний сордог хаалганы доголдлоос сэргийлэх (тээшний автомат хаалгатай автомашин)

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд тээшний автомат хаалга, тээшний сордог хаалганд доголдол үүсгэх аюултай.

- Тээшний сордог хаалга ажиллах үед тээшний хаалганд хэт хүчээр нөлөөлж болохгүй.
- Тээшний хаалганы ажиллагаанд нөлөөлөх мөс хаалга болон араамны завсар байхгүйг нягтлана.
- Хутга, эсвэл бусад хурц зүйлээр мэдрэгч (тээшний автомат хаалганы баруун зүүн үзүүрт байрлах) гэмтээхээс сэргийлнэ.

  Мэдрэгч салгагдсан үед тээшний автомат хаалга автоматаар хаагдахгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ Тээшний хэсгийн гэрэл

- Тээшний хаалга онгойх үед тус гэрэл асна.
- Асаах товч унтраастай үед тээшний хэсгийн гэрлийг асаалттай орхисон нөхцөлд гэрэл автоматаар 20 минутын дараа унтарна.

■ Тээшний автомат хаалга ажиллах нөхцөл

Малайзаас бусад: Тээшний автомат хаалганы ажиллагааг ON-д тохируулсан үед хаалга дараах нөхцөлд автоматаар нээгдэж хаагдана:

- Тээшний хаалганы түгжээ тайлсан.

Нөгөөтэйгүүр тээшний хаалга түгжээтэй үед дараах нөхцөлд тээшний автомат хаалга ажиллах боломжтой:

- Электрон түлхүүртэй хүн тээшний автомат хаалганы товч дарсан
- Өөрчлөх боломжтой тохиргоо функцаар хаалга түгжээтэй үед ч түлхүүрийн алсын удирдлагаар ажиллах боломжтой тохиргоо хийсэн

● Асаах товчны ON горимд дээрх нөхцлүүдээс гадна дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед тээшний хаалга ажиллана:

- Зогсоолын тоормос идэвхжсэн
- Тоормосны дөрөө гишгэсэн
- Араа P байрлалд байгаа

Малайз:

● Тээшний автомат хаалганы ажиллагаа ON-д тохируулсан.

● Тээшний хаалганы түгжээ тайлагдсан.

● Асаах товчны ON горимд тээшний хаалганы түгжээ тайлагдах ба дараах аль нэг нөхцөлд хаалга ажиллана:

- Зогсоолын тоормос идэвхжсэн
- Тоормосны дөрөө гишгэсэн
- Араа P байрлалд байгаа

■ **Тээшний автомат хаалганы ажиллагаа (тээшний автомат хаалгатай автомашин)**

Тээшний хаалга дутуу хаагдсан үед тээшний сордог хаалга автоматаар ажиллаж бүрэн хаана.

Асаах товчны горимоос үл хамааран тээшний сордог хаалга ажиллана.

■ **Тээшний автомат хаалганы ажиллагаа (тээшний автомат хаалгатай автомашин)**

● Тээшний хаалга нээгдэж/хаагдаж буйг илтгэж дохио дуугарах ба ослын дохионы гэрэл 2 удаа (Малайзаас бусад) анивчина.

● Тээшний автомат хаалганы ажиллагааг OFF-д тохируулсан үед тээшний автомат хаалга ажиллахгүй ба гараар нээж хаах боломжтой.

● Тээшний автомат хаалга автоматаар нээгдэх үед хүн, эсвэл эд зүйл мэдрэгдсэн зэрэг хэвийн бус нөхцөл үүссэн үед ажиллагаа зогсоно.

■ **Аккумулятор дахин холбох үед (тээшний автомат хаалгатай автомашин)**

Тээшний автомат хаалганы зөв ажиллагааг идэвхжүүлэх үүднээс тус хаалгыг гараар хаана.

■ **Хавчихаас хамгаалах функц (тээшний автомат хаалгатай автомашин)**

Тээшний автомат хаалганы баруун зүүн өнцөг суурилсан мэдрэгчүүд.

Хаалга автоматаар хаагдах үед эд зүйл хавчуулагдах зэргээр мэдрэгч дарагдсан үед хавчихаас хамгаалах функц ажиллана. Хаалга тухайн байрлалаас автоматаар эсрэг чиглэлд бага зэрэг хөдлөөд функцийн ажиллагаа зогсоно.



Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Smart entry & start системээр тээшний хаалга нээх

Электрон түлхүүр, эсвэл түлхүүр карт биедээ авч явах үедаа тээшний хаалга түгжих/тайлах боломжтой. Жолооч электрон түлхүүр, эсвэл түлхүүр картыг цаг ямагт биедээ авч явна.

Smart entry & start системээр тээшний хаалга түгжих/тайлах

Электрон түлхүүр биедээ аван дараах үйлдлийг хийнэ.



1 1-г дарна.

Бүх хаалганы түгжээ тайлагдана. Нөгөөтэйгүүр хаалга түгжсэн үед 3 секундын дотор тайлагдахгүй.

2 2-г дарна.

Бүх хаалга түгжигдэнэ. Хаалга бүрэн түгжигдсэн эсэхийг нягтлана.

Хаалга түгжих товчоор тээшний хаалга түгжих/тайлах

Хаалга түгжих товчоор тээшний хаалга түгжих/тайлах



1 товч дарна.

Тээшний болон бүх хаалга түгжигдэнэ.

2 товч дарна.

Тээшний болон бүх хаалганы түгжээ тайлагдана.

Түлхүүрийн алсын удирдлагаар тээшний автомат хаалга ажиллуулах

Түлхүүрийн алсын удирдлагаар тээшний хаалга нээх/хаах (тээшний автомат хаалгатай автомашин)



● -г 1 секунд дарна.

Түгжээ тайлагдсан үед тээшний хаалга нээгдэх боломжтой*1.

Тээшний хаалга нээгдэнэ.

Түлхүүрийн алсын удирдлагаар тээшний хаалга түгжих/тайлах



1 -г дарна.

Тээшний хаалга болон бүх хаалга түгжигдэнэ.

Бүх хаалга бүрэн түгжигдсэн байгааг нягтлана.

2 -г дарна.

TAZA25L-AWZLTV, TAZA25L-AWZLTV загваруудад*2: Товч дарж жолоочийн хаалга тайлна. Товчийг 3 секундын дотор дахин дарж тээшний болон бусад бүх хаалга тайлна.

Тээшний болон бусад бүх хаалга тайлагдана.

*1 : Өөрчлөх боломжтой тохиргоогоор хаалга түгжигдсэн үед тээшний хаалга нээх боломжтойгоор тохируулах боломжтой (Малайзаас бусад).

*2 : Модель кодийг бүртгэлийн дугаарын хавтангаас харна уу.

Салон дахь тээшний автомат хаалганы товчоор тээшний автомат хаалга ажиллуулах*

Тээшний хаалга дотор талаас нээх/хаах



-г 1 секунд дарна.

Дохио дуугарч тээшний хаалга автоматаар нээгдэх буюу хаагдана.

Тээшний хаалга нээгдэх/хаагдах явцад товч дарж хаалга зогсооно.

Хаалга зогссон үед товч дарахад тээшний хаалга эсрэг чиглэлд хөдлөнө.

Тээшний хаалганы товч ашиглан тээшний хаалга ажиллуулах*

Тээшний хаалганы товчоор тээшний хаалга нээх/хаах



-г дарна.

Дохио дуугарч тээшний хаалга автоматаар хаагдана.

Тээшний хаалга хаагдах явцад -г дарж зогсооно.

Дахин товч дарах үед хаалга эсрэг чиглэлд ажиллана.

Тээшний хаалга нээх товчоор тээшний хаалга ажиллуулах

Тээшний хаалга нээх товчоор тээшний хаалга автоматаар нээх (тээшний автомат хаалгатай автомашин)



Хаалганы түгжээ тайлагдсан үед тээшний хаалга нээх товч дарна.

Дохио дуугарч тээшний хаалга автоматаар нээгдэнэ.

Тээшний хаалга ажиллах үед товч дахин дарахад үйлдэл зогсоно.

* : Тоноглогдсон автомашинд

МЭДЭЭЛЭЛ

■ Хаалга түгжээтэй үед тээшний хаалга нээх товчоор тээшний хаалга нээх

Малайзаас бусад: Электрон түлхүүрийг биедээ аван тээшний хаалга нээх товч дарна.

Малайз: Тээшний хаалганы түгжээ тайлаад тээшний хаалга нээх товч дарна.

Дохио дуугарч тээшний хаалга автоматаар нээгдэнэ.

Тээшний хаалга нээх товч ашиглан тээшний хаалга гараар нээх (тээшний автомат хаалгагүй автомашин)



Тээшний хаалга нээх товч дарангаа тээшний хаалга өргөнө.

Тээшний хаалганы бариулаар тээшний хаалга ажиллуулах

Тээшний хаалганы бариул ашиглан тээшний хаалга автоматаар хаах*3

⚠ АЮУЛТАЙ

Тээшний хаалга хаах үед дараах зүйлсийг мөрдөнө.

- Тээшний хаалга хаах үед хуруу гар зэргээ хавчуулахаас сэргийлнэ.
- Тээшний хаалга хаах үед хаалганы гадна талд зөөлөн дарж өгнө.

  Тээшний хаалганы бариулыг хаалга гүйцэд хаагдах хүртэл ашиглах нь гар хуруугаа хавчуулахад хүргэнэ.
- Хаалга хаахын тулд тээшний хаалга өргөгчөөс татах, зүүгдэх хориотой.

  Гар хуруугаа хавчуулах, эсвэл хаалга өргөгчийн цилиндр эвдэрч осол аваарт хүргэх аюултай.

*3 : Тээшний автомат хаалгатай автомашин

Тээшний хаалганы бариул ашиглан доош татна.

Дуут дохио дуугарах ба тээшний хаалга автоматаар хаагдана.



Тээшний хаалганы бариул ашиглан тээшний хаалга гараар хаах*4

⚠ АЮУЛТАЙ

Тээшний хаалга хаах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Гар хуруу зэргээ хавчуулахаас сэргийлж тээшний хаалга болгоомжтой хаана.
- Бариул ашиглан тээшний хаалга гүйцэд хаах нь гараа хавчуулахад хүргэх аюултай.
- Тээшний хаалга хаах зорилгоор хаалга өргөгчөөс татах, зүүгдэхийг хориглоно.

  Эсрэг тохиолдолд гараа хавчуулах, эсвэл хаалга өргөгчийг эвдлэх, улмаар осол үүсгэх аюултай.



Бариулаас татан тээшний хаалга доошлуулаад хаалганы гадна талаас дарж хаана.

Kick сенсор ашиглан тээшний хаалга ажиллуулах*5

⚠ АНХААР

Kick сенсор арын гуперны гол хэсгийн доод талд байрладаг.

*4 : Тээшний автомат хаалгагүй автомашин

*5 : Гарны оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин

⚠ АНХААР

Тээшний автомат хаалганы хэвийн ажиллагааг хангах үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө:

- Арын гуперны гол хэсгийн доод талыг цаг ямагт цэвэр байлгана.

  Арын гуперны гол хэсгийн доод тал бохирдсон, эсвэл цас тогтсон үед kick сенсор ажиллахгүй байж болно.

  Энэ нөхцөлд тухайн бохирдол, эсвэл цасыг цэвэрлэн автомашиныг одоогийн байрлалаас хөдөлгөөд kick сенсорын ажиллагааг шалгана.

  Сенсор ажиллахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.
- Арын гуперны гол хэсгийн доод талд ус тогтохоос сэргийлдэг өнгөлгөө болон бусад өнгөлгөө хийж болохгүй.
- Өвс, мод зэрэг хөдлөөд арын гуперны гол хэсгийн доод талд хүрч болох эд зүйлийн ойр орчимд зогсоож болохгүй.

  Өвс, мод зэрэг хөдлөөд арын гуперны гол хэсгийн доод талд хүрч болох эд зүйлийн ойр орчимд автомашин удаан зогссон үед kick сенсор ажиллахгүй болж болно.

  Энэ нөхцөлд автомашиныг одоогийн байрлалаас шилжүүлээд kick сенсорын ажиллагааг дахин шалгана.

  Сенсор ажиллахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.
- Kick сенсор болон ойр орчмыг хүчтэй цохилтонд өртөхөөс сэргийлнэ.

  Kick сенсор болон ойр орчим хүчтэй цохилтонд өртсөн үед kick сенсорын хэвийн ажиллагаа алдагдана.

  Kick сенсор дараах нөхцлүүдэд ажиллахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

  - Kick сенсор болон ойр орчим хүчтэй цохилтонд өртсөн.
  - Арын гуперны голын доод хэсэг зурагдсан, эсвэл гэмтсэн.
- Арын гуперыг задлаж болохгүй.
- Арын гуперт наалт нааж болохгүй.
- Арын гуперыг будаж болохгүй.
- Унадаг дугуйн суурь, эсвэл бусад төстэй хүнд зүйл тээшний автомат хаалганд угсарсан үед kick сенсорыг цуцлана.

МЭДЭЭЛЭЛ

Kick сенсор ажиллах нөхцөл

- Kick сенсорын ажиллагааг идэвхжүүлсэн
- Электрон түлхүүр ажиллах хүрээнд байгаа

Kick сенсор хэвийн ажиллахгүй нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд kick сенсор хэвийн ажиллахгүй байж болно:

- Арын гупер доороос хөлөө гаргаагүй

- Арын гуперыг хөлөөрөө хүчтэй өшиглөсөн, эсвэл хүрээд удсан

  Арын гуперт хүрээд удсан үед тээшний хаалгыг дахин ажиллуулах хүртэл бага зэрэг хүлээнэ.
- Арын гуперт өөр хүн хэт ойр байгаа үед ажиллуулсан
- Автомашин болон электрон түлхүүр хоорондын долгион дамжуулалтанд гадны радио долгионы эх үүсвэр саад учруулсан
- Автомашин төлбөртэй зогсоол, ШТС, цахилгаан халаалттай зам, өдрийн гэрэл зэрэг гарны оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагаанд нөлөөлөх цахилгаан долгионы шуугиан үүсгэдэг төхөөрөмжийн ойр орчимд байгааг үед
- Телевизийн цамхаг, радио станц, цахилгаан станц, том дэлгэц, нисэх буудал, бусад хүчтэй радио долгион ялгаруулдаг газрын ойр орчимд
- Автомашин угаах, эсвэл хүчтэй бороотой зэргээр арын гупер дээр их хэмжээний ус цацагдсан
- Арын гуперт шавар, цас, мөс тогтсон үед
- Өвс зэрэг хөдлөөд арын гуперны гол хэсгийн доод талд хүрэх эд зүйлийн ойр удаан зогссон үед
- Арын гуперт нэмэлт тоноглол суурилуулсан үед

  Нэмэлт тоноглол угсарсан үед kick сенсорын ажиллагааг цуцлана.

■ **Kick сенсор санамсаргүйгээр ажиллуулахаас сэргийлэх**

Электрон түлхүүр ажиллах хүрээнд байгаад үед kick сенсор ажиллаж болзошгүй тул дараах нөхцөлд анхаарал болгоомжтой байна.

- Автомашин угаах, эсвэл хүчтэй бороотой зэргээр арын гупер дээр их хэмжээний ус цацагдсан
- Арын гуперт тогтсон тоос шороог арчиж цэвэрлэх үед
- Жижиг биетэй амьтан, эсвэл бөмбөг зэрэг жижиг эд зүйл арын гуперны доогуур хөдөлсөн үед
- Арын гуперны дооройс аливаа эд зүйл хөдөлж холдсон үед
- Арын тээшний хаалга дээр суусан хүн хөлөө савчуулан хөдлөх үед
- Автомашины араар өнгөрч буй хүн арын гуперт хөл, биеээрээ хүрсэн
- Автомашин төлбөртэй зогсоол, ШТС, цахилгаан халаалттай зам, өдрийн гэрэл зэрэг гарны оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагаанд нөлөөлөх цахилгаан долгионы шуугиан үүсгэдэг төхөөрөмжийн ойр орчимд байгааг үед
- Телевизийн цамхаг, радио станц, цахилгаан станц, том дэлгэц, нисэх буудал, бусад хүчтэй радио долгион ялгаруулдаг газрын ойр орчимд
- Өвс ургамал зэрэг хөдөлгөөнтэй эд зүйл арын гуперт хүрсэн байдалтайгаар удаан зогсолт хийсэн
- Арын гуперт ачаа тээш ойр байгаа
- Арын гуперт нэмэлт тоноглол, бүтээлэг суурилуулсан, эсвэл салгаж авсан

● Автомашин чирүүлж буй үед

Санамсаргүй ажиллахаас сэргийлж kick сенсорын ажиллагааг салгана.

Kick сенсор ашиглан тээшний хаалга нээх/хаах (Гарны оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин)

⚠ АЮУЛТАЙ

Тээшний автомат хаалга ажиллуулах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Ойр орчимд хаалганы ажиллагаанд саад учруулах, эсвэл таны эд зүйлийг татаж хавчуулах эд зүйл байхгүйг нягтлана.
- Арын гуперны доогуур хөлөө хийх үед түлэгдэж гэмтэх аюултай тул бүрэн хөрөх хүртэл янданд хөлөөр хүрч болохгүй.

  Яндан халуун үед түлэгдэх аюултай.
- Арын гупер доор хангалттай зай байхгүй үед гарны оролцоогүй тээшний автомат хаалга ажиллуулж болохгүй.



A Kick сенсор

B Kick сенсорын ажиллах хүрээ

C Smart entry & start системийн мэдрэх хүрээ

1 **Биедээ электрон түлхүүртэй үед арын гуперны Smart entry & start системийн ажиллах хүрээ болох 50-с 70 см (19.7-с 27.6 in.) зайд зогсоно.**

2 **Арын гупернээс 10 см (3.9 in.) зайд хөлөө оруулаад гаргана.**

Гарны оролцоогүй тээшний автомат хаалга ажиллуулах үед арын гуперт хөлөөр хүрэхгүй.

3 **Дохио дуугарах үед хөлөө гаргана. Дохио дуугарах ба тээшний хаалга автоматаар нээгдэж хаагдана.**

- Бүх үйлдлийг 1 секундын дотор хийж гүйцэтгэнэ.
- Арын гуперны доор хөл байгаа нь мэдрэгдсэн үед тээшний хаалга ажиллахгүй.
- Бүхээг, эсвэл тээшний хэсэгт өөр электрон түлхүүр байгаа үед хаалга ажиллаж эхлэхэд бага зэрэг удаан байж болно.
- Дуут дохио 2 удаа дуугарсан үед үйлдлийг давтана.

Тээшний хаалга нээгдэх буюу хаагдах явцад арын гупер доогуур хөлөө дахин оруулвал тээшний хаалганы ажиллагаа зогсоно.

МЭДЭЭЛЭЛ

Бүх хаалга цоожлогдсон үед kick сенсор хөл мэдэрсэн нөхцөлд хаалганы түгжээ тайлагдана.

Тээшний хаалганы нээгдэх өнцгийг тохируулах (тээшний автомат хаалгатай автомашин)

Тээшний хаалганы нээгдэх өнцгийг тохируулах боломжтой.

1 **Тээшний хаалгыг тохируулах байрлалд зогсооно.**

2 **Тээшний хаалганы доод талд байрлах товчийг 2 секунд дарна.**

Тохиргоо дууссан үед дохио дуугарна.

Тохируулсан байрлалд тээшний хаалга дараагийн удаа онгойлгох үед зогсоно.

Тээшний хаалганы нээгдэх өнцөгний тохиргоог цуцлах

● **Тээшний хаалганы доод талын товчийг 7 секунд орчим удаан дарна.**

Дуут дохио 4 удаа дуугараад дахин 2 удаа дуугарна.

Тээшний автомат хаалга дараагийн удаа нээгдэх үед анхны тохиргооны байрлалд нээгдэнэ.

Арын суудлын түшлэг

Суудлын түшлэгийг бариул, эсвэл товч ашиглан эвхэх боломжтой.

⚠ АЮУЛТАЙ

■ **Арын суудлын түшлэг ажиллуулах үед**

Дараах анхааруулгыг мөрдөнө.

● Зорчигч суусан үед арын суудлыг ажиллуулж болохгүй.

● Суудлыг тохируулсны дараа суудал тухайн байрлалд түгжигдсэн байгааг нягтлана. Суудал түгжигдээгүй үед улаан тэмдэг харагдана. Улаан тэмдэг харагдахгүй байгааг нягтлана уу.



⚠ АЮУЛТАЙ

■ Арын суудлын түшлэг эвхэгдсэн үед

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Жолоодлогын үед суудлын түшлэгийг эвхэж болохгүй.
- Тэгш газар зогсож зогсоолын тоормос залгаад араар Р-д шилжүүлнэ.
- Жолоодлогын үед эвхсэн суудлын түшлэг, эсвэл тээшний хэсэгт хүн суулгахыг хориглоно.
- Тээшний хэсэгт хүүхэд оруулж болохгүй.

■ Арын суудлыг тохируулсны дараа

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Арын суудлын түшлэгийг урагш хойш хөдөлгөн бүрэн түгжигдсэн эсэхийг нягтлана.

  Суудлыг тохируулсны дараа суудал тухайн байрлалд түгжигдсэн байгааг нягтлана. Суудал түгжигдээгүй үед улаан тэмдэг харагдана. Улаан тэмдэг харагдахгүй байгааг нягтлана уу.



- Аюулгүйн бүс хуниралдаагүй, мөн суудлын түшлэгний завсар хавчуулагдаагүй байгааг нягтлана.

■ Хавчихаас хамгаалах функц (автомат суудал)

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Хавчихаас хамгаалах функцийн ажиллагааг шалгахын тулд биеээ хавчуулж турших нь аюултай.
- Суудлын түшлэг бүрэн дэлгэгдэхийн дөнгөж өмнө хавчуулагдсан эд зүйлийг хавчихаас хамгаалах функц мэдрэхгүй байх магадлалтай. Гар хуруу болон бусад эд зүйл хавчуулахгүй байхад анхаарна.
- Функц хавчуулагдсан эд зүйлийн хэлбэрээс хамаарч ажиллахгүй байж болно. Гар хуруу болон бусад эд зүйл хавчуулахгүй байхад анхаарна.

⚠ АНХААР

Арын суудлын түшлэг эвхэхээс өмнө голын суудлын аюулгүйн бүс, бүсний хэл болон гарын түшлэгийг хураана.

Тээшний хэсгийн товчоор арын суудлын түшлэг автоматаар эвхэх (автомат суудалтай автомашин)

МЭДЭЭЛЭЛ

■ Түшлэг эвхэх үйлдлийн ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед арын суудлын ажиллагааны товчоор арын суудлын түшлэг эвхэх боломжтой:

- Тээшний хаалга нээлттэй.
- Суудлын тохиргооны бусад товч ажиллуулаагүй, дараагүй.

Дээрхээс гадна асаах товч ON горимд байгаа дараах аль нэг нөхцлүүдэд автомат суудал ажиллаж байгаа:

- Зогсоолын тоормос залгагдсан
- Тоормосны дөрөө гишгэсэн
- Араа P байрлалд байгаа

1 Арын голын суудлын аюулгүйн бүс, бүсний гархи, тохойн түшлэгийг хураана.

2 Арын суудлын толгойн түшлэгийг доош буулгана.

3 Товчийг удаан дарж тухайн суудлын түшлэг эвхэнээ.



Дуут дохио дуугарч түшлэг эвхэгдэж эхэлнэ. Үйлдэл дуусах үед дуут дохио дахин дуугарна.

Түшлэг эвхэх үйлдлийг зогсоох үед арын суудлын товчны аль нэг талыг дарах, эсвэл тээшний хэсэг дэх тухайн суудлын товч дарна. Үйлдэл зогсох үед дуут дохио дуугарна.



Хэрэв суудлын түшлэг A зурагт үзүүлсэн хэсгээс гарсан үед зогсоох боломжгүй.

Голын дэлгэцийн товчоор арын суудлын түшлэг автоматаар эвхэх (автомат суудалтай автомашин)

МЭДЭЭЛЭЛ

■ Суудлын түшлэг эвхэх ажиллагааны нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед арын суудлын ажиллагааны товчоор арын түшлэг эвхэх боломжтой:

Суудлын өөр ажиллагааны товч ажиллуулаагүй, эсвэл дараагүй.

Дээрхээс гадна асаах товч ON горимд байгаа ба автомат суудал дараах аль нэг нөхцөлд ажиллаж байгаа үед:

- Зогсоолын тоормос залгагдсан
- Тоормосны дөрөө гишгэсэн
- Араа P-д байгаа

1 **Арын голын суудлын аюулгүйн бүс, бүсний гархи, тохойн түшлэгийг эвхэнэ.**

2 **Арын суудлын толгойн түшлэгийг буулгана.**

3 **Үндсэн меню дэх -г дарна.**

4 **[Seats]-г дарна.**

5 **Бүх суудлын түшлэг эвхэх үед: [Fold all]-г дарна. Аль нэг суудлын түшлэг эвхэх үед: Тохиргоо хийх суудлаа сонгоод [Fold]-г дарна.**

Дуут дохио дуугарах ба түшлэг эвхэх үйлдэл эхэлнэ. Үйлдэл дууссан үед дуут дохио дахин дуугарна.

Арын суудлын түшлэгийг гараар эвхэх

1 **Арын голын суудлын аюулгүйн бүс, бүсний гархи, тохойн түшлэгийг хураана.**

2 **Арын суудлын толгойн түшлэгийг доошлуулна.**

3 **Түшлэгний өнцөг тохируулах хөшүүргийг татаад доош эвхэнэ.**



Арын суудлын товч/тээшний хэсгийн товч даран арын суудлын түшлэг автоматаар дэлгэх (автомат суудалтай автомашин)

МЭДЭЭЛЭЛ

■ Суудлын түшлэг эвхэх үйлдлийн ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцлүүд бүрдсэн үед арын суудлын ажиллагааны товчоор арын суудлын түшлэг эвхэх боломжтой:

- Арын суудлын товч ажиллуулах үед: Тухайн ажиллуулах талын хойд хаалгыг нээнэ.
- Тээшний хэсгийн товч ажиллуулах үед: тээшний хаалга нээлттэй.
- Суудлын бусад товчийг ажиллуулаагүй.

Дээрхээс гадна асаах товч ON горимд байгаа ба автомат суудлыг дараах нөхцөлд ажиллуулсан:

- Зогсоолын тоормос залгагдсан
- Тоормосны дөрөө гишгэсэн
- Араа P байрлалд байгаа

■ Суудлын түшлэгний хавчихаас сэргийлэх функц

Суудлын түшлэгийг буцаах үед суудлын түшлэг болон суудлын зөөлөвчний завсар аливаа эд зүйл мэдрэгдсэн нөхцөлд суудлын түшлэг эсрэг чиглэлд хөдлөөд зогсоно. Суудлын түшлэг эсрэг чиглэлд хөдлөх үед дохио тасалдаж дуугарна. Дохио зогссоны дараа суудлын түшлэгийг дахин ажиллуулах боломжтой.

1 Арын суудлын товч/тээшний хэсгийн товч ашиглах: Аль нэг товчийг дарж суудлын түшлэгийг буцаана.

▶ Арын суудлын товч



▶ Тээшний хэсгийн товч



Суудлын түшлэг буцах үйлдэл эхлэх үед дохио дуугарна. Үйлдэл дуусах үед дохио дахин дуугарна.

Түшлэгний ажиллагааг зогсоох үед арын суудлын товч, эсвэл тээшний хэсгийн товчны аль нэгийг дарна. Ажиллагаа зогсох дохио дуугарна.

2 Аюулгүйн бүс тус бүрийн гархи суудлын урд талд байгааг нягтлана.



Голын дэлгэцний товч дарах арын суудлын түшлэг автоматаар дэлгэх (автомат суудалтай автомашин)

МЭДЭЭЛЭЛ

■ Суудлын түшлэг эвхэх үйлдэл ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед арын суудлын ажиллагааны товчоор арын суудлыг түшлэгийг эвхэх боломжтой:

Суудлын тохиргооны бусад товч дараагүй.

Дээрхээс гадна асаах товчны ON горимд автомат суудал дараах аль нэг нөхцөлд ажиллана:

- Зогсоолын тоормос залгагдсан
- Тоормосны дөрөө гишгэсэн
- Араа P байрлалд байгаа

■ Суудлын түшлэгний хавчихаас хамгаалах функц

Суудлын түшлэг буцаах үед суудлын түшлэг болон зөөлөвчний завсар аливаа зүйл мэдрэгдсэн үед түшлэг эсрэг чиглэлд бага зэрэг хөдлөөд зогсоно. Суудлын түшлэг эсрэг чиглэлд хөдлөх үед дохио тасалдан дуугарна. Түшлэг зогссоны дараа дахин ажиллуулах боломжтой.

1 **Үндсэн цэсний -г дарна.**

2 **[Seats]-г дарна.**

3 **Тухайн сонгосон суудлын түшлэг буцаах үед: Тохиргоо хийх суудлыг сонгоод [Raise]-г дарна. Бүх суудал буцаах үед: [Raise all]-г дарна.**

Дохио дуугарах ба суудлын түшлэг буцах үйлдэл эхлэнэ. Үйлдэл дуусах үед дохио дахин дуугарна.

Хөдөлж буй түшлэгийг зогсоох үед голын дэлгэцний [**Cancel**]-г дарна.

4 **Бүх суудлын аюулгүйн бүс суудлын урд талд байгааг нягтлана.**



Арын суудлын түшлэгийг гараар буцааж дэлгэх

1 **Арын суудлын түшлэгийг түгжигдэх хүртэл өргөнө.**



2 **Бүх суудлын аюулгүйн бүс суудлын урд талд байгааг нягтлана.**



Чиргүүл чирэх (чирэх багцгүй автомашин)

Lexus нь тус автомашин чиргүүл чирэхийг зөвлөдөггүй. Мөн Lexus нь чирэх дэгээ, эсвэл тэргэнцэр, скүүтер, унадаг дугуй зэргийн чирэх дэгээгээр бэхлэгддэг бэхэлгээ ашиглахыг зөвлөдөггүй. Тус автомашин нь чиргүүл чирэх, эсвэл чирэх дэгээ суурилуулахад зориулагдаагүй болно.



Цонх нээх ба хаах

⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Бүх цонхны нээх хаах үйлдэл, тэр дундаа зорчигчийн хийж буй үйлдлийн хариуцлага жолоочид ноогддог.

- Бага насны хүүхдээр цонх ажиллуулахыг хориглоно. Бага насны хүүхэд, мөн бусад зорчигчид биеийн аль нэг хэсгээ цонхонд хавчуулж болзошгүй. Мөн автомашинд бага насны хүүхэд зорчиж буй үед цонх түгжих товчоор түгжинэ.
- Цонхтой харьцах үед бусад бүх зорчигчдын биеийн аль нэг хэсэг цонхонд хавчуулагдахаас сэргийлж шалгана.
- Автомашинаас гарах үед асаах товчийг off горимд буцаах ба биедээ түлхүүрээ аван бага насны хүүхдийн хамт автомашинаас гарна. Хүүхэд цонх буруу ажиллуулах, санамсаргүй үйлдэл зэргээс үүдэн осол гарч болзошгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ Автомат цонхны ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Хөдөлгүүр унтраасны дараа автомат цонх ажиллуулах

Асаах товч ACC эсвэл OFF горимд шилжүүлснээс 45 секундын дотор автомат цонхыг ажиллуулах боломжтой.

Нөгөөтэйгүүр аль нэг урд хаалга нээсэн үед ажиллахгүй.

Цонх аюулгүйгээр нээж хаахад туслах функцууд

Дараах функц нь цонх аюулгүйгээр нээж хаахад туслана.

- Хавчихаас хамгаалах функц

  Цонх хаах үед цонх ба цонхны хүрээний завсар аливаа зүйл хавчуулагдсан үед цонхны хаагдах хөдөлгөөн зогсох ба бага зэрэг нээгдэнэ.

- Хавчуулагдахаас сэргийлэх функц

  Цонх нээх үед цонх ба хаалганы завсар аливаа зүйл хавчуулагдсан үед цонхны нээгдэх хөдөлгөөн зогсоно.

- Автомат цонх нээлттэйг анхааруулах дуут дохио

  Автомат цонх нээлттэй хэвээр асаах товч унтрааж жолоочийн хаалга нээсэн үед дуут дохио дуугарч хянах самбарын мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна.

⚠ АЮУЛТАЙ

■ **Хавчихаас хамгаалах функц**

- Хавчихаас хамгаалах функцийг албаар идэвхжүүлэхийн тулд биеийн аль нэг хэсгээ санаатай хавчуулахыг хориглоно.
- Хавчихаас хамгаалах функц нь цонх бүрэн хаагдахын өмнө аливаа эд зүйл хавчуулагдвал ажиллахгүй байж болно.

  Биеийн аль нэг хэсэг болон хувцасаа цонхонд хавчуулахаас сэргийлнэ.

■ **Хавчуулагдахаас сэргийлэх функц**

- Хавчуулагдахаас сэргийлэх функцийг албаар идэвхжүүлэхийн тулд биеийн аль нэг хэсэг, хувцасаа албаар хавчуулахыг хориглоно.
- Биеийн аль нэг хэсэг, хувцасаа цонхонд хавчуулахаас сэргийлнэ. Хавчуулагдахаас сэргийлэх функц нь цонх бүрэн нээгдэхийн өмнө аливаа зүйл хавчуулагдвал ажиллахгүй байж болно.

Автомат цонхны товчоор ажиллуулах

Автомат цонхны товчоор цонх нээх/хаах



1 Автомат цонхны товчийг хагас өргөнө.

Товч өргөх хугацаанд цонх хаагдана.

2 Автомат цонхны товчийг гүйцэд өргөнө.

Цонх автоматаар гүйцэд хаагдана.

Үйлдэл дунд цонхыг зогсоох үед товчийг эсрэг чиглэлд ажиллуулна.

3 Автомат цонхны товчийг хагас дарна.

Товч дарах хугацаанд цонх нээгдэнэ.

4 Автомат цонхны товчийг гүйцэд дарна.

Цонх автоматаар гүйцэд нээгдэнэ.

Үйлдэл дунд цонхыг зогсоох үед товчийг эсрэг чиглэлд ажиллуулна.

Түлхүүрийн алсын удирдлага ашиглан ажиллуулах

Түлхүүрийн алсын удирдлагаар автомат цонх нээх, хаах боломжтой.*1

*1 : Тус тохиргоог та өөрийн Lexus дилер дээр хийлгэх шаардлагатай.

⚠ АЮУЛТАЙ

Түлхүүрийн алсын удирдлага ашиглан автомат цонх ажиллуулахын өмнө бусад зорчигчдын биеийн аль нэг хэсэг цонхонд хавчуулагдахаас сэргийлж шалгана. Мөн бага насны хүүхдийг түлхүүрийн алсын удирдлага ашиглан автомат цонх ажиллуулахыг хориглоно. Бага насны хүүхэд, мөн бусад зорчигчид биеийн аль нэг хэсгээ цонхонд хавчуулж болзошгүй.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

Түлхүүрийн алсын удирдлагаар цонх нээх

Түлхүүрийн алсын удирдлагаар хаалганы түгжээ тайлангаа нэгэн зэрэг цонхнууд нээх боломжтой.*2



● **Түлхүүрийн алсын удирдлаганы түгжээ тайлах товчийг удаан дарна.**

Хаалганы түгжээ тайлагдах ба дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий* нээгдэнэ.

Дуут дохио дуугарч цонх болон дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий* нээгдэж байгааг анхааруулна.

Түлхүүрийн алсын удирдлага ашиглан цонх хаах

Түлхүүрийн алсын удирдлага ашиглан бүх хаалга түгжэнгээ цонх хаах боломжтой.*3

*2 : Тус тохиргоог Lexus дилер дээр хийнэ.

* : Тоноглогдсон автомашинд

*3 : Тус тохиргоог Lexus дилер дээр хийнэ.



● **Түлхүүрийн алсын удирдлаганы хаах товчийг удаан дарна.**

Бүх хаалга түгжигдэх ба цонх ба дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий * хаагдана.

Дуут дохио дуугарч цонх болон дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий* нээгдэж/хаагдаж байгааг илтгэнэ.

Хаалга бүрэн түгжигдэж цонх хаагдсаныг нягтлана.

Цонх санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх

Цонх түгжих товч нь бага насны хүүхэд санамсаргүйгээр цонх нээх, хаахаас сэргийлэх зориулалттай.

Цонх түгжих товч дарна.

Индикатор A асах ба зорчигчийн цонхнууд түгжигдэнэ.



* : Тоноглогдсон автомашинд

Суудал тохируулах

Урд суудал тохируулах

Жолоодлогын зөв байрлалыг бүрдүүлэн суудлыг урагш хойш, дээш доош тохируулна.

▶ Гар тохиргоотой суудал



A Суудлын байрлал тохируулах хөшүүрэг
B Суудлын өнцөг тохируулах хөшүүрэг
C Суудлын өндөр тохируулах хөшүүрэг

▶ Автомат тохируулгатай суудал



A Суудлын байрлал тохируулах товч
B Суудлын зөөлөвчний (урд) өнцөг тохируулах товч
C Суудлын түшлэгний өнцөг тохируулах товч
D Өндөр тохируулах товч
E Түшлэгний хатууг тохируулах товч (жолоочийн суудлын)
F Түшлэгний өндөр тохируулах товч (жолоочийн суудлын)*

МЭДЭЭЛЭЛ

■ Суудлын тохиргоо хийх үед

Толгойн түшлэг тааз, нарны хаалтад хүрэхгүй байхад анхаарна.

⚠ АЮУЛТАЙ

Суудлын тохиргоо хийх үед дараах зүйлсийг мөрдөнө.

- Жолоодлого хийх үед жолоочийн суудлын тохиргоо хийж болохгүй.
  Жолооч автомашины жолоодлого алдахад хүргэх аюултай.
- Суудлын байрлал тохируулах үед бусад зорчигчдод гэмтэл учруулахаас сэргийлнэ.
- Урд суудал доор аливаа зүйл хийж болохгүй.

*:Тоноглогдсон автомашинд

⚠ АЮУЛТАЙ

Суудал доор хийсэн зүйл нь суудлын ховилд тээглэн суудлыг тухайн байрлалд түгжигдэхгүй болгох аюултай. Энэ нь осол аваар үүсгэх, эсвэл суудлын тохиргооны механизмыг гэмтээнэ.

- Бэртэл гэмтлээс сэргийлж гараа суудлын доогуур оруулах, эсвэл хөдөлж буй эд анги руу ойртуулахаас зайлсхийнэ.

  Суудлын механизмад гар хуруугаа хавчуулах аюултай.
- Ослын үед аюулгүйн бүсний завсар гулсах эрсдэлийг бууруулах зорилгоор суудлыг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн налуулахгүй.

  Хэрэв суудал хэт налуулвал ослын үед аюулгүйн бүсний бүсэлхийн хэсэг ташаанаас сугарч бэлхүүсийг шахах, мөн бүсний мөрний хэсэг нь хүзүү дарах аюултай.
- Гар тохиргоотой суудал: Суудлын тохиргоо хийсний дараа суудал тухайн байрлалд түгжигдсэн эсэхийг нягтлана.
- Жолооч, зорчигч болон суудлын түшлэгний завсар зөөлөвч хийж болохгүй.

  Зөөлөвч нь суудалд зөв байрлалд суухад саад болохоос гадна аюулгүйн бүс болон толгойн түшлэгний ажиллагааг бууруулна.

Толгойн түшлэг тохируулах

Толгойн түшлэг нь бүх суудалд суурилагдсан байдаг.

⚠ АЮУЛТАЙ

Толгойн түшлэгтэй холбоотой дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

- Толгойн түшлэгийг зөвхөн тухайн суудалд ашиглана.
- Толгойн түшлэгийг цаг ямагт зөв байрлалд тохируулна.
- Толгойн түшлэг тохируулсны дараа доош дарж түгжигдсэнийг нягтлана.
- Толгойн түшлэггүйгээр хөдөлгөөнд оролцож болохгүй.

■ Урд толгойн түшлэгийн өндрийг тохируулах



1 Дээш

Толгойн түшлэгийг дээш өргөнө.

2 Доош

Түгжээ суллах A товч дарангаа толгойн түшлэгийг дарна.

■ Арын толгойн түшлэгийн өндрийг тохируулах



1 Дээш

Толгойн түшлэгийг дээш өргөнө.

2 Доош

Түгжээ суллах [A] товч дарангаа толгойн түшлэгийг дарна.

МЭДЭЭЛЭЛ

■ Толгойн түшлэгний өндрийг тохируулах (урд суудал)

Толгойн түшлэгний төв хэсэг жолоочийн чихний орчимд байхаар толгойн түшлэгийг тохируулж түгжинэ.



■ Толгойн түшлэгний өндрийг тохируулах

Арын суудал ашиглах үед толгойн түшлэг хураах байрлалаас багадаа 1 шатаар дээш тохируулна.

■ Урд суудлын толгойн түшлэгийг урагш хойш тохируулах (F SPORT)

Түшлэгийг 4 шатлалаар тохируулах боломжтой.

Толгойн түшлэгийг хамгийн урд байрлалаас урагш татах үед түшлэг хамгийн арын байрлалд буцна.



Толгойн түшлэг салгах

▶ Урд суудал



Түгжээ тайлах товчийг дарангаа толгойн түшлэгийг дээш өргөнө A.

Толгойн түшлэг таазанд хүрч авахад хүндрэлтэй үед суудлын өндөр, эсвэл өнцгийг тохируулна.

▶ Арын суудал



Түгжээ тайлах товчийг дарангаа толгойн түшлэгийг дээш өргөнө A.

Толгойн түшлэг угсрах

▶ Урд суудал



Толгойн түшлэгийг угсрах нүхтэй тааруулаад түгжих байрлал хүртэл дарна.

Толгойн түшлэг доош буулгах үед A товчийг үргэлжлүүлэн дарна.

▶ Арын суудал



Толгойн түшлэгийг угсрах нүхтэй тааруулаад түгжих байрлал хүртэл дарна.

Толгойн түшлэг доош буулгах үед A товчийг үргэлжлүүлэн дарна.

Арын суудал тохируулах

Хөшүүргээр суудлын түшлэг доош буулгах, эвхэх үйлдлийг хийх боломжтой.



A Түшлэг доош буулгах

⚠ АЮУЛТАЙ

Түшлэгний тохиргоо хийх үед дараах зүйлсийг анхаарна.

- Бусад зорчигчдыг суудлын түшлэгээр цохихоос сэргийлнэ.
- Хөдөлж буй эд анги, эсвэл суудалны завсар гараа оруулах, биеийн аль нэг хэсгээ хавчуулахаас сэргийлнэ.
- Автомат суудалтай автомашин: Бусад зорчигчид суудалд хавчуулагдах аюултай тул бага насны хүүхдээр суудал ажиллуулуулж болохгүй.
- Автомат суудалтай автомашин: Суудал эвхэхээс өмнө тухайн суудалд зорчигч суугаагүйг нягтлана. Мөн суудал урагш эвхэгдэх үед суудал дээр хүн суулгаж болохгүй.
- Ослын үед аюулгүйн бүсний завсар гулсах эрсдэлийг бууруулах зорилгоор суудлыг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн налуулахгүй.

  Хэрэв суудал хэт налуулвал ослын үед аюулгүйн бүсний бүсэлхийн хэсэг ташаанаас сугарч бэлхүүсийг шахах, мөн бүсний мөрний хэсэг нь хүзүү дарах аюултай.

Аюулгүйн бүс ашиглах



- Аюулгүйн бүсний мөрний хэсгийг мөрний дээгүүр татна. Энэ үед аюулгүйн бүс хүзүүнд хүрэх, эсвэл мөрнөөс унахгүй байхаар тохируулна.
- Ташааны хэсгийг ташаандаа аль болох доор татна.
- Суудлын түшлэг тохируулна. Нуруу цэх, арагш шахаж сууна.
- Бүсийг мушгиралдуулж болохгүй.

⚠ АЮУЛТАЙ

Огцом тоормос, эргэлт, ослын үед үүсч болох бэртэл гэмтлийн эрсдэлийг бууруулахын тулд дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Бүх зорчигч аюулгүйн бүсээ зүүсэн эсэхийг нягтлана.
- Аюулгүйн бүсийг цаг ямагт зөв зүүж хэрэглэнэ.
- Аюулгүйн бүс тус бүрийг зөвхөн нэг хүн ашиглана.

  Бага насны хүүхэдтэй хамт зэрэг нэгээс илүү хүн ашиглахыг хориглоно.
- Lexus нь бага насны хүүхдийг зөвхөн арын суудалд суулгаж аюулгүй бүс, эсвэл тохирох хүүхдийн суудал ашиглахыг зөвлөдөг.
- Өөрт тохиромжтой байрлалд суухын тулд суудлын түшлэгийг хэт налуулж болохгүй. Жолооч болон зорчигч нуруу цэх, арагш шахаж суух үед аюулгүйн бүс хамгийн үр дүнтэй байдаг.
- Аюулгүйн бүсний мөрний хэсгийг суган доогууруа хийхгүй.
- Бүсийг ташааны хэсгээр аль болох доор, биед шахаж зүүнэ.

⚠ АЮУЛТАЙ

- Жирэмсэн хүн өөрийн эмчээс аюулгүйн бүс хэрхэн зөв зүүх талаар зөвлөгөө авна.

  Жирэмсэн эмэгтэй бусад зорчигчийн адил аюулгүйн бүсний ташааны хэсгийг ташаагаараа дайруулан аль болох доор зүүнэ. Бүсний мөрний хэсгийг цээжээрээ дайруулан хангалттай татна. Аюулгүйн бүс хэвлий гэдсэнд хүрэхээс зайлсхийнэ.

  Аюулгүйн бүс зөв зүүж хэрэглээгүй тохиолдолд огцом тоормос, огцом эргэлт, эсвэл ослын үед жирэмсэн эхээс гадна ургийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.



- Бие өвдсөн хүн өөрийн эмчээс аюулгүйн бүс хэрхэн зөв зүүх талаар зөвлөгөө авна.
- Бүс зүсэгдсэн, сэмэрсэн, эд ангиуд суларсан эсэхийг тогтмол шалгана. Жолооч зорчигчийг амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтлээс бүс хамгаалах чадваргүй болох тул гэмтсэн үед шинээр солих хүртэл ашиглахыг хориглоно.
- Хэрэв таны автомашин ноцтой осолд орсон бол аюулгүйн бүс болон суудлыг нүдэнд ил харагдах гэмтэлтэй эсэхээс үл хамааран цогцоор нь солино.
- Аюулгүйн бүсийг угсрах, салгах, задлах, өөрчлөх, хаях зорилгоор оролдохыг хориглох ба шаардлагатай бүх засвар үйлчилгээг Lexus дилерээр хийлгэнэ. Буруу засвар үйлчилгээ нь хэвийн ажиллагаа алдагдуулна.
- Бага насны хүүхдийг аюулгүйн бүсээр тоглуулахыг хориглоно.

  Хүүхдийн хүзүүнд аюулгүйн бүс орооцолдсон үед амьсгал боогдуулах, амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

  Дээрх нөхцөл байдал үүчсч хэрэв бүсний түгжээ тайлагдахгүй байвал хайчаар бүсийг тайрна.

МЭДЭЭЛЭЛ

■ Бага насны хүүхэд бүс зүүх

Аюулгүйн бүс нь насанд хүрсэн хүний биеийн хэмжээнд тохируулан хийгдсэн байдаг.

- Бага насны хүүхэд аюулгүйн бүсийг зөв зүүх хэмжээнд хүрэх хүртэл хүүхдийн аюулгүйн бүс, зориулалтын хүүхдийн суудал ашиглана.

- Бага насны хүүхэд бүсийг зөв зүүх хэмжээнд хүрсэн үед аюулгүйн бүсний зөв хэрэглээ хэсэгт заасан зааврыг дагаж мөрдөнө.

■ **Аюулгүйн бүсний дүрэм журам**

Тухайн улс орны аюулгүйн бүсний дүрэм журмийг баримтлах үүднээс та өөрийн Lexus дилерт хандаж бүсээ солиулах, эсвэл суурилуулна уу.

Аюулгүйн бүс зүүх ба тайлах



1. Бүс зүүх үед түгжих хэлийг гархинд хийж дуугарах хүртэл түлхэж оруулна.
2. Аюулгүйн бүсийг тайлах үед гархины товч A дээр дарна.

МЭДЭЭЛЭЛ

■ **Аюулгүйн бүс цоожлогч (ELR)**

Автомашин огцом тоормос хийх, доргилт авсан үед цоожлогч функц аюулгүйн бүсийг цоожилдог. Бүсийг зөөлөн татах үед энэ функц идэвхжихгүй бөгөөд бүсийг бүрэн сунгах боломжтой болно.

⚠ АЮУЛТАЙ

- Бүс, түгжих хэл, гархийг хаалганд хавчуулан гэмтээж болохгүй.
- Бүс зөв түгжигдсэн, мөн бүс хуниралдаагүй эсэхийг шалгана.

  Аюулгүйн бүс хэвийн ажиллахгүй үед та өөрийн Lexus дилерт нэн даруй хандана уу.

Урд суудлын аюулгүйн бүсний өндөр тохируулах



1. Суллах A товчийг дарангаа бүсний суурийг доош дарна.
2. Суллах A товчийг дарангаа бүсний суурийг дээш түлхэнэ.

   Дуугарах хүртэл шаардагдах хэмжээгээр дээш, доош шилжүүлнэ.

⚠ АЮУЛТАЙ

■ Аюулгүйн бүсний өндөр тохируулагч

Аюулгүйн бүсний мөрний хэсэг жолооч ба зорчигчийн мөрний төв хэсгээр дайрч байгаа эсэхийг цаг ямагт нягтлана. Бүс жолооч ба зорчигчийн хүзүүнээс зайтай, мөн мөрнөөс доош унахгүй байрлалд байна. Эсрэг тохиолдолд огцом тоормос, огцом эргэх, ослын үед бүсний хамгаалах чадвар буурах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэлд хүргэж болзошгүй.

Жолооны хүрд болон толины байрлал тохируулах

Жолооны хүрдийг дээш доош, урагш хойш тохируулах (гар тохиргоотой)

⚠ АЮУЛТАЙ

Жолоодлогын үед хүрдний тохиргоо хийж болохгүй

1 **Жолооны хүрдийг гараар сайтар бариад хөшүүргийг доош дарна.**



2 **Жолооны хүрдийг дээш доош, урагш хойш хөдөлгөн тохиромжтой байрлалд тохируулна.**

Тохиргоо хийсний дараа хөшүүргийг дээш татаж хүрдийг түгжинэ.



МЭДЭЭЛЭЛ

■ Жолооны хүрд тохируулсны дараа

Жолооны хүрд бүрэн түгжигдсэнийг нягтлана.

Жолооны хүрд бүрэн түгжигдээгүй үед дуут дохио дуугарахгүй байж болно.

⚠ АЮУЛТАЙ

Жолооны хүрд тохируулсны дараа хүрд бүрэн түгжигдсэнийг нягтлана.

Эсрэг тохиолдолд жолооны хүрд гэнэт хөдлөх аюултай.

Жолооны хүрдийг баруун зүүн/дээш доош тохируулах (автомат тохируулгатай)

МЭДЭЭЛЭЛ

■ Жолооны хүрд тохируулах боломжтой нөхцлүүд

Асаах товчны ACC, эсвэл ON горимд.*1

⚠ АЮУЛТАЙ

Жолоодлогын үед жолооны хүрд тохируулж болохгүй.



Товч ашиглан жолооны хүрдийг дараах байдлаар хөдөлгөх боломжтой:

1 Дээш
2 Доош
3 Нааш
4 Цааш

МЭДЭЭЛЭЛ

■ Жолооны хүрдний байрлал автоматаар тохируулагдах

Хүссэн жолооны хүрдний байрлалаа санах ойд сануулж жолоодлогын байрлал санах системээр дуудах боломжтой.

■ Хялбараар бууж суухад туслах систем

Асаах товчны горим болон жолоочийн аюулгүйн бүсний байдлаас хамаарч жолооны хүрд болон жолоочийн суудал хөдөлнө.

Голын толины байрлал тохируулах

⚠ АЮУЛТАЙ

Жолоодлогын үед толины байрлал тохируулж болохгүй.

Жолоодлогын зөв байрлал хангах байдлаар голын толь тохируулна.

*1 : Жолоочийн аюулгүйн бүс бүслэгдсэн үед асаах товчны горимоос үл хамааран тохируулах боломжтой.

Голын толийг гараар хөдөлгөн дээш доош тохируулна.



Дижитал арыг харах толины нөлөө ба анхааруулга*

Дижитал голын толь нь автомашины арын камерны дүрсийг дижитал голын толь дээр гаргах систем юм.

Хөшүүрэг ашиглан дижитал голын толийг оптик толь болон дижитал тольны горимд солих боломжтой.

Дижитал голын толь нь толгойн түшлэг, тээш зэрэг саадаас үл хамааран ар талыг харах боломж бүрдүүлдэг. Мөн арын суудлыг харуулдаггүй зорчигчдын хувийн орон зайг бүрдүүлдэг.

⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.

■ **Дижитал толь ашиглахын өмнө**

● Жолоодлогын өмнө толийг тохируулна.

- Оптик толины горимд шилжүүлээд хойд тал сайн харагдах байдлаар дижитал толины байрлалыг тохируулна.
- Дижитал толины горимд шилжүүлээд дэлгэцийг тохируулна.

● Дижитал болон оптик толины горимуудад харагдах байдал, талбай өөр байдаг тул хөдөлгөөн эхлэхийн өмнө ялгааг нягтлана.

Дижитал голын толины системийн эд анги



A Камерын индикатор

Камер хэвийн ажиллаж байгааг илтгэнэ.

B Тэмдгүүдийн хэсэг

Дэлгэцийн тэмдгүүд, хэмжүүрийн тохиргоог харуулна.

C Сонгох/тохируулах товч

Тухайн өөрчлөх тохиргоог сонгох үед дарна.

* : Тоноглогдсон автомашинд

D Меню товч

Тэмдэг, эсвэл цэсний сонголт хийнэ.

E Хөшүүрэг

Дижитал болон оптик тольны горимд солино.

Холбоотой холбоосууд

Дижитал толь тохируулах(X. 134)

Дижитал арыг харах толины горим солих

Хөшүүргийг ажиллуулж дижитал толины болон оптик толины горимд солино.



1 Дижитал толины горим

Автомашины талын дүрсийг харуулна.

[ ] тус горимд асна.

2 Оптик толины горим

Дижитал голын толийг унтраан толийг оптик толь болгон ашиглаж болно.

Дижитал голын толины ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

Асаах товчийг ON-с OFF, эсвэл ACC горимд шилжүүлсэн үед дүрс хэдэн секундын дараа унтарна.

Дижитал толины горимын анхааруулга

Дижитал голын толь дээр гэрэл ойсон, камер дээр усны дусал, тоос зэрэг тогтсоноос бохирдсон, эсвэл арын автомашины гэрэл нүд гялбуулах, эсвэл дэлгэцээр дүрс гарах нь таньд төвөгтэй санагдаж байгаа үед оптик толины горимд шилжүүлнэ.

Бороо орж байгаа үед хэрэв арын цонхон дээрх уснаас шалтгаалж дүрс тод харагдахгүй үед арын шил арчигч ажиллуулна.

- Тээшний хаалга нээлттэй үед дижитал голын толины дүрс зөв гарахгүй байж болно. Хөдөлгөөн эхлэхийн өмнө тээшний хаалга хаана.
- Ойсон гэрлээс шалтгаалж дэлгэц муу харагдаж байгаа үед нарны хаалт хаана.
- Шөнийн цагаар зэргээр харанхуй орчинд жолоодох үед дараах нөхцлүүд үүсч болно. Эдгээр нь доголдлыг илэрхийлэхгүй.

- Дэлгэцээр харагдах объектын өнгө бодит өнгөнөөс өөр байж болно.
- Автомашины ард талын гэрлийн өндрөөс хамаарч ард тал цайрах, эсвэл гялбаж харагдаж болно.
- Тод гэрэлтэй дүрсний автомат тохируулгын улмаас дүрсний ойр орчим гялбаж харагдаж болно.

  Тольны дүрсийг үзэх хүндрэлтэй, эсвэл дижитал тольны дүрс жолоодлогод тань саад болж байгаа үед оптик толины горимд шилжүүлнэ.

● Дижитал толины горимд дижитал голын толь халж болно. Энэ нь аливаа доголдлыг илэрхийлэхгүй.

● Таны биеийн байдал, эсвэл наснаас хамаарч дижитал голын тольны дүрс дээр хараа төвлөрөх хүртэл удаж болно. Энэ нөхцөлд оптик толины горимд шилжүүлнэ.

● Хөдөлгөөний үед зорчигчдыг толины дүрс рүү удаан харуулж болохгүй. Дотор муухайрахад хүргэнэ.

■ Систем доголдсон үед



Дижитал голын толийг дижитал толины горимд ашиглах үед зурагт үзүүлсэн тэмдэг дэлгэц дээр гарвал системд доголдол үүссэн байж болзошгүй. Тэмдэг хэдэн секундын дараа унтарна.

Хөшүүргийг ажиллуулж оптик толины горимд шилжүүлээд өөрийн Lexus дилер дээрээ оношлуулна уу.

Дижитал толь тохируулах

Дижитал голын толины тохиргоо, нүд гялбахаас сэргийлэх автомат функц идэвхжүүлэх, цуцлах зэргийг өөрчлөх боломжтой.

1 Меню товч дарна.

Дэлгэц дээр тэмдэг гарна.



2 Меню товчийг дарж тохиргоо хийх системээ сонгоно.

3 [ ], эсвэл [ ]-г дарж тохиргоо өөрчилнө.

Товчийг 5-с дээш секунд ажиллуулаагүй үед тэмдэг унтарна.

Тэмдэг	Тохиргоо
	Дэлгэцийн гэрлийн түвшинг тохируулна.
	Дэлгэцээр гарах хэсгийг дээш/доош тохируулна.
	Дэлгэцээр гарах хэсгийг баруун/зүүн тохируулна.
	Дэлгэцээр гарах дүрсний өнцгийг тохируулна.
	Дэлгэцийн дүрсийг томруулна/жижигрүүлнэ.
	Автомат нүд гялбахаас сэргийлэх функцийг идэвхжүүлнэ/цуцлана.*2 Арын автомашины их гэрлийн тод, бүдэгт нийцүүлэн толины ойлгох гэрлийн хэмжээг автоматаар тохируулна. Асаах товчийг ON горимд шилжүүлэх бүрт автомат нүд гялбахаас сэргийлэх функц идэвхжинэ.
	Хэрэглэгч гаражны хаалга нээгч систем сургахад ашиглах HomeLink® сургалтын тайлбар харуулна.
	HomeLink® сургалтын тайлбарын хэл сонгоно.

Дижитал голын толь тохируулах үеийн анхааруулга

■ Дэлгэцийн тохиргоо (дижитал толины горим)

- Товчийг 5-с дээш секунд ажиллуулаагүй үед тэмдэг дэлгэц дээр унтарна.
- Дэлгэцээр гарах дүрсийг тохируулсан үед дүрсний хэлбэр алдагдаж болно. Энэ нь доголдлыг илтгэхгүй.
- Дижитал голын толины гэрлийг хэт тод тохируулсан үед энэ нь нүд ядрахад хүргэж болно. Дижитал голын толины гэрлийг

*2 : Тус функц нь оптик толинд зориулагдсан боловч дижитал толины горим ашиглах үед тохиргоог өөрчлөх боломжтой.

тохирох түвшинд тохируулна. Хэрэв таны нүд ядарсан нөхцөлд оптик толины горимд шилжүүлнэ.

- Дижитал голын толины гэрлийн түвшин автомашины урд талын гэрлийн хэмжээнд тохируулан автоматаар гэрлийн түвшин тохируулагдана.

■ Гэрэл мэдрэгчийг доголдлоос сэргийлэх

Гэрлийн мэдрэгчийг доголдлоос сэргийлж мэдрэгчинд гараар хүрэх, халхлаж болохгүй.



⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.

■ Жолоодлогын үед

- Дижитал толины байрлал болон дэлгэцийн тохиргоог жолоодлогын үед хийж болохгүй.

  Автомашиныг зогсоогоод дижитал толины товч ажиллуулна. Эсрэг тохиолдолд жолоодлого алдах, улмаар осол аваар үүсгэх аюултай.
- Цаг ямагт ойр орчмын бусад автомашинд анхаарал хандуулна.

  Дижитал болон оптик толины горимуудад бусад автомашин болон объектын хэмжээ өөр харагдана. Ухрах үйлдэл хийх үед ойр орчмоо, ялангуяа хойд талаа шууд харж аюулгүй байдлыг нягтлана. Мөн шөнийн цагаар зэргээр харанхуй орчинд хойд талаас бусад автомашин ойртох үед толинд сайн харагдахгүй байж болно.

Дижитал голын толийг цэвэрлэх

■ Толины гадаргууг цэвэрлэх

Толины гадаргуу бохирдсон үед дэлгэц дээрх дүрс муу харагдаж болно. Зөөлөн хуурай даавуугаар толины гадаргууг арчиж цэвэрлэнэ.

МЭДЭЭЛЭЛ

Камер

Дижитал голын толины камерын байрлалыг харуулав.



АНХААР

Камерт доголдол үүсэхээс сэргийлэх

- Дижитал голын толь зөв ажиллагаа алдагдах тул дараах анхааруулгыг мөрдөнө.
  - Камерны байрлал, өнцөг өөрчлөгдөж болзошгүй тул камерыг хүчтэй цохилт, доргилтонд өртөхөөс сэргийлнэ.
  - Камерыг салгах, задлах болон өөрчилж болохгүй.
  - Камерны таг дээр органик нэгдэл, вакс, цонх цэвэрлэгч бодис, эсвэл шил өнгөлөгч хүргэж болохгүй. Хүргэсэн даруй арчина.
  - Арын шилэн дээр өнгөтэй хальс (тунгалаг хальс хамаарна) наах үед камерны урд хэсэгт нааж болохгүй. Камерны дүрс дэлгэц дээр зөв гарахгүй байх магадлалтай.
- Доголдол үүсгэх аюултай тул камерыг цохилтод өртөхөөс сэргийлнэ. Камер хүчтэй цохилтод өртсөн тохиолдолд та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.
- Толины агааржуулалтын нүхийг бөглөж болохгүй. Толь халж доголдох, эсвэл галын аюул үүсгэх аюултай.



Дижитал голын тольтой холбоотой дараах шинж тэмдэг мэдэрсэн үед

Дараах аль нэг шинж тэмдэг мэдрэгдсэн үед дараах хүснэгтэд заасан шалтгааны дагуу арга хэмжээ авна.

Хэрэв авах арга хэмжээгээр шинж тэмдэг арилахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

Шинж тэмдэг	Шалтгаан	Авах арга хэмжээ
Дүрс муу харагдаж байгаа.	Толины гадаргуу бохирдсон.	Хуурай зөөлөн алчуураар толины гадаргууг цэвэрлэнэ.
	Дижитал голын толь дээр нар эсвэл автомашины их гэрэл шууд тусч байгаа.	Оптик толины горимд шилжүүлнэ. (гэрэл дээврийн нээлхий, эсвэл панорамик дээврийн нээлхийгээр тусч байгаа үед нарны хаалт, эсвэл электрон нарны хаалт хаана.)
	● Автомашин харанхуй газарт байгаа. ● Телевизийн цамхаг, радио станц цахилгаан станц, бусад хүчтэй цахилгааны шум үүсгэдэг газрын ойр орчимд байгаа. ● Камер орчмын хэм хэт халуун/хүйтэн. ● Гадна орчны хэм хэт хүйтэн. ● Бороо орж байгаа, эсвэл хэт чийгшилттэй. ● Линз дээр нар эсвэл автомашины их гэрэл шууд тусч байгаа. ● Флуоресцент гэрэл (өдрийн гэрэл), натрийн ламп мөнгөн усны орцтой гэрлийн дор байгаа үед. ● Хаягдал утаа камер халхлаж байгаа үед.	Оптик толины горимд шилжүүлнэ. (Дүрс муу харагдах шалтгааны нөлөө буурсан үед дижитал толины горимд буцаана.)
	Усны дусал, тоос зэрэг гадны биет камерны линз дээр тогтсон.	Та өөрийн Lexus дилер дээрээ оношилгоо хийлгэнэ үү

Шинж тэмдэг	Шалтгаан	Авах арга хэмжээ
Дүрс муу харагдаж байгаа.	Тээшний хэсгийн ачаа тээш арын цонхны шилэнд ойж камерт саад учруул байгаа.	Оптик толины горимд шилжүүлнэ. Тээшийг камерт саад болохгүй байрлалд шилжүүлэх, эсвэл хар даавуугаар хучиж арын шилэнд ойх тусгалыг бууруулна.
	Арын шил цантсан.	Арын шилний цан арилгагчаар цан арилгаад дахин дижитал голын толь ашиглана.
	Арын шилний гадна тал бохирдсон.	Арын шил арчигчаар цэвэрлэнэ.
	Арын шилний гадна тал бохирдсон.	Та өөрийн Lexus дилер дээрээ оношилгоо хийлгэнэ үү
Дүрсний өнцөг алдагдсан.	Тээшний хаалга дутуу хаагдсан.	Тээшний хаалга гүйцэд хаана.
	Камер, камерны ойр орчим хүчтэй цохилтод өртсөн.	Оптик толины горимд шилжүүлээд Lexus дилер дээрээ оношлуулна уу.
Дэлгэц бүдэг бөгөөд [ ] гарч байгаа.	Системд доголдол үүссэн байж болно.	Оптик толины горимд шилжүүлээд Lexus дилер дээрээ оношлуулна уу.
[ ] тэмдэг унтарсан.		
[ ] тэмдэг дэлгэц дээр гарсан.	Дижитал голын толь хэт халсан. (Дэлгэц аажмаар бүдэг болно. Дэлгэцийн хэм өссөн хэвээр байгаа үед дижитал голын толь унтарна.)	Дэлгэцийн хэм буулгах үед бүхээгний хэмийг буулгах нь тохиромжтой арга болно. ([ ] тэмдэг дэлгэц хөрөх үед унтарна.) тэмдэг [ ] дэлгэц хөрсөн ч унтрахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

Шинж тэмдэг	Шалтгаан	Авах арга хэмжээ
Хөшүүрэг хэвийн ажиллахгүй байгаа.	Хөшүүрэгт доголдол үүссэн байж болно.	Оптик толины горимд шилжүүлээд Lexus дилер дээрээ оношлуулна уу. Оптик толины горимд шилжүүлээд меню товчийг 10 орчим секунд дарна.

Хажуугийн толь тохируулах

⚠ АЮУЛТАЙ

Толийг жолоодлогын үед тохируулж болохгүй.

1 Товч дарж тохируулах толио сонгоно.



A Зүүн толь сонгох
B Баруун толь сонгох

2 Товч даран толь тохируулна.



A Дээш
B Баруун
C Доош
D Зүүн

МЭДЭЭЛЭЛ

■ **Толийг дараах нөхцөлд тохируулах боломжтой**

Асаах товч ACC, эсвэл ON горимд байгаа.

■ **Толины байрлалын автомат тохиргоо (жолоодлогын байрлал санах ойтой автомашин)**

Толины байрлалыг санах ойд сануулан жолоодлогын байрлал санах ойгоор дахин дуудах боломжтой.

■ **Ухрах араатай холбоотой толины ажиллагаа (жолоодлогын байрлал санах ойтой автомашин)**

Толины тохиргооны товч “L”, эсвэл “R” байрлалд байгаа нөхцөлд ухрах араанд сэлгэсэн үед хажуугийн толь автоматаар доош хэлбийж ухрах үеийн толины харагдацийг сайжруулна.

Тус функцийг цуцлах үед толины тохиргооны товчийг голын байрлалд шилжүүлнэ (“L” болон “R” байрлалын дунд)

Арааг R байрлалд шилжүүлээд хажуугийн толины байрлалыг тохируулна.

Тус байрлалыг систем ухрах үеийн толины байрлал гэж санах ба дараагийн удаагаас арааг R байрлалд шилжүүлэх үед тухайн байрлалд хажуугийн толь шилжинэ.

Тухайн санасан ухрах арааны байрлал нь хажуугийн толины энгийн байрлалтай (R-с бусад араатай үед тохируулсан толины тохиргоо) уялдаатай байдаг. Хажуугийн толины энгийн үеийн байрлалыг өөрчлөн тохируулсан үед ухрах арааны байрлал мөн өөрчлөгдөнө.

Хажуугийн толины энгийн үеийн байрлалыг өөрчлөн тохируулсан үед ухрах арааны байрлалыг дахин тохируулна.

■ **Ухрах араатай холбоотой толины ажиллагааг хүйтэн улиралд ашиглах**

Ухрах араатай холбоотой толины ажиллагааг хүйтэн улиралд ашиглах үед толь хөлдсөн байх, улмаар автоматаар ухрах арааны байрлалд тохируулагдахгүй байж болно. Энэ нөхцөлд толиноос мөс, цасийг цэвэрлэнэ.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Хажуугийн толь эвхэх, дэлгэх

▶ Товч ашиглах



Товч дарж толь эвхэнэ.

Дахин дарж анхны байрлалд дэлгэнэ.

▶ Автомат горимд тохируулах



Автомат горим нь хаалга түгжих, тайлах үйлдэлтэй уялдаатайгаар толь эвхэх буюу дэлгэнэ.

Товч дарж автомат горимыг тохируулна.

A индикатор асна.

Товч дахин дарах үед гар ажиллагааны горимд буцна.

МЭДЭЭЛЭЛ

■ Цаг агаар хүйтэн үед автомат горим ашиглах

Цаг агаар хүйтэн үед автомат горим ашигласан нөхцөлд толь хөлдөж автоматаар эвхэгдэх, дэлгэгдэхгүй байж болно. Энэ нөхцөлд толинд тогтсон цас мөсийг аваад гар ажиллагааны горимоор ажиллуулах, эсвэл гараар хөдөлгөнө.

⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Толь эвхсэн хэвээр жолоодож болохгүй.
- Толь хөдлөх үед толинд хүрч болохгүй. Эсрэг тохиолдолд гар хуруугаа хавчуулах, эсвэл толь гэмтээнэ.
- Толины гадаргуу халах тул толины цан арилгагч ажиллах үед толинд хүрч болохгүй.
- Жолоодлогын өмнө жолооч болон зорчигчийн талын толийг дэлгэж зөв тохируулна.

2 Автомашин жолоодох

2-1. Хөдөлгүүр асаах, унтраах

Хөдөлгүүр асаах 144

Хөдөлгүүр унтраах 148

Stop & Start систем 149

2-2. Жолоодох дараалал

Автомашин жолоодох 157

Шинэ Lexus автомашинтай хэрхэн харьцах тухай 160

Эко жолоодлого 161

Арааны байрлалын ашиглалтын зориулалт (Автомат хурдны хайрцаг) 163

Арааны байрлал бүрийн зориулалт (CVT хурдны хайрцаг) 165

Арааны байрлал солих (автомат хурдны хайрцаг) 166

Арааны байрлал солих (CVT хурдны хайрцаг) 172

Хөдөлгөөн эхлэх 174

Баруун зүүн эргэх, эгнээгээ солих үеийн ажиллагаа 175

Араа солих (Автомат хурдны хайрцаг) 176

Араа солих (CVT хурдны хайрцаг) 178

Араа солих (Автомат хурдны хайрцаг) 179

Араа солих (CVT хурдны хайрцаг) 181

2-3. Автомашиныг зогсоолд байрлуулах

Автомашиныг зогсоолд байрлуулах үед 183

Зогсоох 185

Автомашин зогсоолд байрлуулах 187

2-4. Шатахуун цэнэглэх

Шатахуун цэнэглэх 200

Хөдөлгүүр асаах

Хөдөлгүүр асаах

⚠ АЮУЛТАЙ

Жолоочийн суудалд суугаад хөдөлгүүр асаана. Хөдөлгүүр асаах үед ямар ч нөхцөлд хааз гишгэж болохгүй.

⚠ АНХААР

■ **Хөдөлгүүр асаах үед**

- Хөдөлгүүр хүйтэн үед өндөр хааз өгч болохгүй.
- Хөдөлгүүр асахад хүндрэлтэй, эсвэл байнга хүч алдаж унтарч байгаа үед та өөрийн Lexus дилер дээрээ автомашинаа даруй оношлуулна уу.

■ **Асаах товчны ажиллагаа**

Товч бага зэрэг наалдах зэргээр асаах товч хэвийн үеэс өөрөөр ажиллаж байгаа нөхцөлд доголдол үүссэн байж болно. Та даруй өөрийн Lexus дилерт хандана уу.

1 **Зогсоолын тоормос залгагдсан байгааг нягтлана.**

Зогсоолын тоормосны индикатор асна.

2 **Тоормосны дөрөө сайтар гишгэнэ.**

болон мэдээлэл нь мэдээллийн дэлгэц дээр гарна. Дэлгэц дээр гараагүй үед хөдөлгүүр асах боломжгүй.

3 **Асаах товчийг богино, чанга дарна.**



Асаах товч ажиллуулах үед нэг удаа богино, чанга дарахад хангалттай. Товчийг удаан дарах шаардлагагүй.

Стартер мотор хөдөлгүүр асах хүртэл ажиллах, асаагүй нөхцөлд 30 секунд ажиллана.

Хөдөлгүүр бүрэн асах хүртэл тоормосны дөрөөг үргэлжлүүлэн асна.

Хөдөлгүүрийг асаах товчны аль ч горимоос асааж болно.

МЭДЭЭЛЭЛ

■ **Асаах товчны гэрэл**

Тухайн нөхцлөөс хамаарч асаах товчны гэрэл дараах байдлаар асна.

- Хаалга нээж асаах товчийг ACC, эсвэл ON горимоос унтраасан үед асаах товч удаан анивчина.
- Электрон түлхүүртэй үед тоормосны дөрөө гишгэхэд асаах товчны гэрэл хурдан анивчина.
- Асаах товчийг ACC, эсвэл ON горимд шилжүүлэх үед асаах товчны гэрэл асна.

■ **Хөдөлгүүр асахгүй үед**

- Хөдөлгүүрийн иммобилайзер системийг цуцлаагүй байж болно. Та өөрийн Lexus дилерт хандана уу.
- Мэдээллийн дэлгэц дээр асалттай холбоотой мэдээлэл гарсан үед мэдээллийн зааварчилгааг дагана.

■ **Жолооны хүрд түгжих функц**

Асаах товч унтрааж хаалга нээгээд хаасны дараа жолооны хүрд түгжих функцаар жолооны хүрд түгжигдэнэ. Асаах товчийг дахин ажиллуулах үед тус функцийн ажиллагаа автоматаар цуцлагдана.

■ **Асаах товчны ажиллагаа**

- Товчийг богино, чанга дараагүй үед асаах товчны горим солигдохгүй байх, эсвэл хөдөлгүүр асахгүй байж болно.
- Хөдөлгүүр унтраасан даруйд дахин асаах оролдлого хийсэн ч зарим нөхцөлд асахгүй байж болно. Хөдөлгүүр унтрааснаас хойш хэдэн секундын дараа дахин асаана.

Холбоотой холбоосууд

Зогсоолын тоормос гар аргаар залгах/салгах (гар ажиллагааны горим)(X. 190)

Арааны байрлалын дэлгэц болон араа сэлгэх (X. 167)

Асаах товчны горим солих

Тоормосны дөрөө гишгэн асаах товч дарж горим солих боломжтой. (Товч дарах бүрт горим солигдоно.)



1 OFF

Ослын дохионы гэрэл ашиглах боломжтой.

2 ACC *1

Аудио хөгжим зэрэг зарим электрон төхөөрөмж ашиглах боломжтой. **"ACCESSORY"** мэдээллийн дэлгэц дээр гарна.

3 ON

Бүх электрон төхөөрөмж ашиглах боломжтой.

"IGNITION ON" мэдээллийн дэлгэц дээр гарна.

МЭДЭЭЛЭЛ

Автоматаар унтраах функц

- ACC горим, эсвэл ON (хөдөлгүүр унтраастай) горимд P араатай 20-с дээш минут болсон үед асаах товч OFF горимд шилжинэ.
- ACC горим, эсвэл ON (хөдөлгүүр унтраастай) горимд аккумуляторын цэнэг багасах үед асаах товч OFF горимд шилжинэ.

Нөгөөтэйгүүр энэ нь аккумуляторын цэнэг суухаас бүрэн сэргийлэх боломжгүй тул хөдөлгүүр асаагүй үед ACC, ON горимд удаан орхиж болохгүй.

Арааны удирдлагын системд доголдол үүссэн үед

Арааны удирдлагын системд доголдол үүссэн үед асаах товчийг унтраах оролдлого хийсэн ч унтрахгүй байж болно. Энэ нөхцөлд зогсоолын тоормос залгасны дараа асаах товч ажиллуулан унтраах боломжтой.

Системд доголдол үүссэн үед та өөрийн Lexus дилер дээр автомашинаа оношлуулна уу.

АНХААР

Хөдөлгүүр унтраастай үед асаах товчны ACC, эсвэл ON горимд автомашиныг удаан орхиж болохгүй.

Хөдөлгүүр асаагүй үед хянах самбар дээр **"ACCESSORY"**, эсвэл **"IGNITION ON"** гарах нь асаах товч унтраагүйг илтгэнэ. Асаах товч унтраагаад автомашинаас гарна.

*1 : Өөрчлөх боломжтой тохиргоогоор идэвхжүүлэн/цуцлах боломжтой.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

Хөдөлгүүр унтраах

Хөдөлгүүр унтраах

⚠ АЮУЛТАЙ

Жолоодлогын үед онцгой, аваарын нөхцөл үүсч хөдөлгүүр унтраах шаардлагатай үед асаах товчийг 2-с дээш секунд эсвэл 3-с олон удаа хурдан дарна.

Зөвхөн онцгой нөхцөл үүссэн үед асаах товч дарна. Хөдөлгүүр унтраах нь жолоо болон тоормосны удирдлага алдагдахад хүргэхгүй боловч аккумуляторын цэнэгийн хэмжээ, эсвэл ашиглалтын нөхцөл байдлаас хамаарч эдгээр системүүдийн ажиллагааг дэмжих цахилгаан хүчлүүр ажиллагаагүй болсноор жолоо, тоормос хатуу болох тул боломжтой үед нэн даруй замаас гарч аюулгүй газарт зогсоно.

1 **Автомашиныг бүрэн зогсооно.**

2 **Арааны P байрлалын товч дарна.**

Арааны байрлалын P болон зогсоолын тоормосны индикаторууд ассаныг нягтлана.

3 **Асаах товч дарна.**

Хөдөлгүүр болон хянах самбарын дэлгэц унтарна (хянах самбарын дэлгэцийн дараа арааны байрлалын индикатор хэдэн секунд асна).

4 **Тоормосны дөрөөг суллаж хянах самбарын дэлгэц унтарсан байгааг нягтлана.**

Холбоотой холбоосууд

Зогсоолын тоормос гар аргаар залгах/салгах (гар ажиллагааны горим)(X. 190)

Арааны байрлалын дэлгэц болон араа сэлгэх (X. 167)

Арааны хөшүүрэг шилжүүлэх(X. 172)

Хөдөлгүүр унтраахаас өмнө нормал хаазаар ажиллуулах нөхцлүүд (NX350)

Турбо гэмтэхээс сэргийлж өгсүүр замаар удаан явах, уралдааны замаар жолоодох, чиргүүл болон өөр автомашин чирэх (чирэх багцтай автомашин) зэргээр хөдөлгүүрийн өндөр ачаалалтай явсны дараа хөдөлгүүрийг 1 минут сул хаазаар ажиллуулна.

Хэвийн хотын жолоодлого, эсвэл өндөр хурдны жолоодлогын (хурдны замын хурдны хязгаар, эсвэл тохирох хурдаар) дараа сул хаазаар ажиллуулах шаардлагагүй.

Stop & Start систем*

Stop & Start системийн ажиллагаа ба анхаарах зүйлс

Stop & Start систем нь шатахууны хэмнэлт сайжруулж хөдөлгүүрийн сул ажиллагаанаас үүдэх дуу чимээний бохирдлыг бууруулах үүднээс гэрлэн дохио, уулзвар зэрэг дээр автомашин зогсох үед хаазны дөрөө, эсвэл арааны хөшүүргийн ажиллагаанд нийцүүлэн хөдөлгүүр асааж унтраана.

■ **Ашиглах үед анхаарах зүйлс**

- Stop & Start систем ажиллаж хөдөлгүүр унтарсан нөхцөлд хэрэв асаах товч дарсан тохиолдолд хөдөлгүүр автоматаар хөдөлгүүр асаах функцаар асахгүй. Энэ үед хөдөлгүүрийг хэвийн асаах дарааллаар асаана.
- Хөдөлгүүр Stop & Start системээр асах үед цахилгааны залгуур түр хугацаанд ашиглах боломжгүй болох ба энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.
- Электрон төхөөрөмж болон утасгүй антенн суурилуулах, салгах нь Stop & Start системийн ажиллагаанд нөлөөлж болно.

  Та өөрийн Lexus дилертээ хандана уу.
- Удаан хугацаанд зогсолт хийх үед асаах товчийг дарж хөдөлгүүр бүрэн унтраана.
- Stop & Start систем ажиллаж хөдөлгүүр ассан даруйд жолооны хүрд богино хугацаанд хүнд мэдрэгдэж болно.

■ **Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах систем**

Өгсүүр зам дээр хөдөлгүүр Stop & Start системээр унтарсан үед хаазны дөрөөг суллахад автомашиныг арагш өнхрөхөөс сэргийлж хөдөлгүүр асан зүтгэх хүч үүсэх хүртэл тоормосны хүч автомашиныг түр хугацаанд баридаг. Зүтгэх хүч үүссэн үед тоормосны хүч автоматаар цуцлагддаг.

- Тус функц нь өгсүүр зам болон тэгш зам дээр мөн ажиллана.
- Тоормосны системээс дуу гарч болох ба энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.
- Гишгэх үеийн тоормосны дөрөөний мэдрэмж өөрчлөгдөж чичиргээ мэдрэгдэж болох ба энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.

* : Тоноглогдсон автомашинд

⚠ АЮУЛТАЙ

■ **Stop & Start систем ажиллах үед**

- Автомашин агааржуулалт муутай орчинд байгаа үед Stop & Start системийн ажиллагааг цуцлана. Цуцлаагүй нөхцөлд хөдөлгүүр автоматаар дахин асах, улмаар хаягдал утаа хуримтлагдаж бүхээгт нэвтэрч улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.
- Автомашин агааржуулалт муутай орчинд байгаа үед Stop & Start системийг (Stop & Start индикатор асаалттай үед) цуцлана. Хөдөлгүүр автоматаар асах функцаас шалтгаалж осол үүсэх аюултай.
- Хөдөлгүүр Stop & Start системээр унтарсан (Stop & Start индикатор асаалттай үед) үед шаардлагатай нөхцөлд тоормосны дөрөө гишгэх, зогсоолын тоормос залган аюулгүй байдлыг хангана.

⚠ АНХААР

■ **Системийн хэвийн ажиллагааг хангах**

Дараах аль нэг нөхцөл үүссэн үед Stop & Start систем хэвийн ажиллахгүй байж болно.

Та автомашинаа өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

- Жолоочийн аюулгүйн бүс бүслэгдсэн үед жолооч болон урд зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл анивчих.
- Жолоочийн аюулгүйн бүс бүслэгдээгүй үед ч жолооч болон урд зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл асахгүй байх.
- Жолоочийн хаалга хаалттай үед ч нээлттэй хаалга анхааруулах гэрэл асах, эсвэл салоны гэрлийн товч хаалганы байрлал горимд байгаа үед салоны гэрэл асах.
- Жолоочийн хаалга нээлттэй үед ч нээлттэй хаалга анхааруулах гэрэл асахгүй байх, эсвэл салоны гэрлийн товч хаалганы байрлал горимд байгаа үед салоны гэрэл асахгүй байх.

Холбоотой холбоосууд

Хөдөлгүүр асаах(Х. 144)

Stop & Start системийн ажиллагаа

■ Хөдөлгүүр унтраах

Арааны D байрлал сонгон жолоодох үедээ тоормос гишгэн автомашин зогсооно. Хөдөлгүүр автоматаар унтарна. Хөдөлгүүр унтрах үед Stop & Start индикатор асна.



■ Хөдөлгүүр дахин асаах

Тоормосны дөрөө салгана. Хөдөлгүүр автоматаар асна. Хөдөлгүүр асах үед Stop & Start индикатор унтарна.

■ Тоормос баригч систем ажиллах үед

- Stop & Start системээр хөдөлгүүр унтарсан үед хэрэв тоормосны дөрөө гишгээгүй нөхцөлд хөдөлгүүр унтарсан хэвээр байна.
- Stop & Start системээр хөдөлгүүр унтарсан үед хэрэв тоормосны дөрөө гишгэсэн нөхцөлд хөдөлгүүр дахин асна.
- Stop & Start системээр унтарсан хөдөлгүүр дахин ассан ч тоормос баригч системийн ажиллах нөхцөл цуцлагдсахаас бусад нөхцөлд тоормос баригч үргэлжлүүлэн тоормос барина.

■ Бүх хурдны динамик радарын хурд баригч ажиллах үед

- Бүх хурдны динамик радарын хурд баригчаар автомашин зогссон үед тоормосны дөрөө гишгээгүй байсан ч хөдөлгүүр автоматаар унтарна.
- Урд талын дагаж буй автомашин хөдөлгөөнөө эхлэх үед хөдөлгүүр автоматаар асна.
- Бүх хурдны динамик радарын хурд баригчийн ажиллагаагаар зогссон автомашины хөдөлгүүр Stop & Start системээр ассан үед хурд баригчийн удирдлагаар автомашин үргэлжлэн зогсоно.

МЭДЭЭЛЭЛ

■ Ажиллах нөхцөл

- Дараах бүх нөхцөл бүрдсэн үед Stop & Start систем ажиллана:
  - Автомашиныг тодорхой хугацаанд жолоодсон.
  - Тоормосны дөрөөг бүрэн гишгэсэн. (Бүх хурдны динамик радарын хурд баригч автомашин хоорондын зай барих горимоор ажиллах үе хамаарахгүй)
  - Арааны D байрлал сонгогдсон.

- Жолооч аюулгүйн бүс бүслэсэн.
- Жолоочийн хаалга хаалттай.
- Салхины шил арчигчийн цан арилгагч унтраастай.
- Хаазны дөрөө гишгээгүй.
- Хөдөлгүүр хангалттай халсан.
- Гадна агаарын хэм -5°C (23°F)-с их.
- Капот хаалттай.

● Дараах нөхцлүүдэд Stop & Start системийн ажиллагаагаар хөдөлгүүр унтрахгүй байж болно. Энэ нь Stop & Start системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.

- Агааржуулалтын систем ашиглаж байгаа үед.
- Аккумулятор цэнэглэгдэж байгаа үед.
- Автомашин удаан зогсолт хийснээс аккумуляторын цэнэг буурсан, цахилгааны ачаалал өндөр, аккумуляторын шингэний хэм хэт бага, эсвэл аккумуляторын цэнэг барилт муудсан зэрэг аккумулятор бүрэн цэнэглэгдээгүй үед.
- Тоормосны хүчлүүрийн вакум багассан үед.
- Хөдөлгүүр дахин ассанаас хойших хугацаа богино үед.
- Замын түгжрэл зэргээр автомашин олон дахин зогсолт хийсэн үед.
- Хөдөлгүүрийн хөргөлтийн, эсвэл хурдны хайрцагны шингэний хэм хэт бага, хэт өндөр үед.
- Огцом налуу зам дээр зогссон үед.
- Жолооны хүрдтэй харьцаж байгаа үед.
- Автомашин өндөрлөг газраар явж байгаа үед.
- Аккумуляторын шингэний хэм хэт бага, хэт өндөр үед.
- Аккумуляторын шон салгаад залгаснаас хойш тодорхой хугацаанд.

● Дараах аль нэг нөхцөл бүрдэх үед Stop & Start системээр унтарсан хөдөлгүүр автоматаар дахин асна: (Stop & Start системээр хөдөлгүүр дахин унтрах тохируулгыг идэвхжүүлэхийн тулд үргэлжлүүлэн жолоодно.)

- Агааржуулалтын систем ассан.
- Салхины шил арчигчийн цан арилгагч ассан.
- Арааны хөшүүргийг D, эсвэл P-с өөр араанд шилжүүлсэн.
- Арааны хөшүүргийг P-д шилжүүлсэн. (Арааны хөшүүрэг P-д байх үед хөдөлгүүр Stop & Start системээр унтарсан.)
- Жолооч аюулгүйн бүс тайлсан.
- Жолоочийн хаалга нээгдсэн.

- Stop & Start cancel товч дарсан.
- Жолооны хүрд эргүүлсэн.
- Хаазны дөрөө гишгэсэн.
- Налуу зам дээр автомашин өнхөрч эхэлсэн.

● Stop & Start системээр унтарсан хөдөлгүүр дараах нөхцлүүдэд автоматаар асна: (Stop & Start системээр хөдөлгүүр дахин унтраах үед автомашиныг хэсэг жолоодно.)

- Тоормосны дөрөөг олон дахин, эсвэл хүчтэй гишгэсэн.
- Агааржуулалтын систем асаалттай байгаа.
- Агааржуулалтын системийн товч дарсан (салхины шилний цан арилгагчийн товч зэрэг).
- Аккумуляторын цэнэг буурсан.

■ **Капот нээсэн**

● Stop & Start системээр хөдөлгүүр унтарсан үед капот нээхэд автоматаар хөдөлгүүр асаах функцаар хөдөлгүүр дахин асахгүй. Энэ нөхцөлд хэвийн үед хөдөлгүүр асаах үйлдлээр асаана.

● Капот нээлттэй үед хөдөлгүүр асаасны дараа капот хаасан ч Stop & Start систем ажиллахгүй. Капот хааж хөдөлгүүр унтраан 30 секунд хүлээгээд дахин асаана.

Холбоотой холбоосууд

Тоормос баригч систем(X. 250)

Капот нээх(X. 509)

Хөдөлгүүр асаах(X. 144)

Салхины шилний цан арилгах(X. 227)

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Stop & Start системийг цуцлах

Агааржуулалтын систем автомат горимд байгаа ба хөдөлгүүр Stop & Start системээр унтарсан үед бүхээгний хэм нэмэгдэх, эсвэл буурахаас сэргийлж сэнс бага хурдаар ажиллах, эсвэл унтарч болно.

Дараах нөхцлүүдэд Stop & Start системийг цуцлана.

● Агааржуулалтын системийн ажиллагааг чухалчлах үед

● Салхины шил цантсан

● Агааржуулалтын системээс үнэр гарах үед

Stop & Start cancel товчийг дарж Stop & Start системийн ажиллагааг цуцлана.

Stop & Start cancel индикатор асна. Товч дахин дарах үед Stop & Start систем идэвхжиж Stop & Start cancel индикатор унтарна.

▶ Уруу замд туслах удирдлагын системгүй автомашин



▶ Уруу замд туслах удирдлагын системтэй автомашин



МЭДЭЭЛЭЛ

■ **Stop & Start систем автоматаар идэвхжих**

Stop & Start cancel товчоор системийн ажиллагааг цуцласан үед систем асаах товчоор хөдөлгүүр унтрааж дахин асаах үед идэвхжинэ.

Мэдээллийн дэлгэц дээр гарах мэдээлэл

Дараах нөхцлүүдэд мэдээллийн дэлгэц дээр гарч болно.

▶ Stop & Start системээр хөдөлгүүр унтрахгүй үед

Мэдээлэл	Дэлгэрэнгүй/Авах үйлдэл
"Stop & Start System Malfunction Visit Your Dealer"	Stop & Start системд доголдол үүссэн байж болзошгүй. **Та автомашинаа өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.**
"Press Brake More to Activate"	Тоормосны дөрөөг хангалттай чанга гишгээгүй. Тоормосны дөрөө нэмж гишгэх үед хөдөлгүүр унтарна.

Мэдээлэл	Дэлгэрэнгүй/Авах үйлдэл
"Non-Dedicated Battery "	Stop & Start системд ашиглах зориулалтгүй аккумулятор ашигласан байж болно. Stop & Start систем ажиллахгүй байгаа үед. Та автомашинаа өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.
"Battery Charging"	● Аккумуляторын цэнэг бага байгаа. Аккумулятор цэнэглэх үүднээс хөдөлгүүр түр хугацаанд унтрахгүй. Хөдөлгүүр хэсэг хугацаанд ажилласны дараа систем автоматаар идэвхжинэ. ● Аккумуляторын цэнэг сэргээх үед Нэг цаг хүртэлх хугацаанд цэнэг сэргээх ба дууссаны дараа системийн ажиллагаа сэргэнэ. ● Дэлгэц дээр удаан үргэлжлэн гарсан (1 цагаас удаан) үед Аккумулятор муудсан байж болно. Дэлгэрэнгүйг та өөрийн Lexus дилэрээс авна уу.
"Stop & Start system unavailable"	● Stop & Start системийн ажиллагаа цуцлагдсан. Хөдөлгүүрийг хэсэг хугацаанд ажиллуулна. ● Капот нээлттэй үед хөдөлгүүр ассан байж болно. Капот хаан асаах товч унтраагаад 30-с дээш секунд хүлээгээд дахин асаана.
"Preparing to Operate"	● Автомашин өндөрлөг газар ашиглагдсан. ● Тоормосны хүчлүүрийн вакум сул. Тоормосны хүчлүүрийн вакум зохих түвшинд хүрсэн үед систем дахин идэвхжинэ.
"For Climate Control"	● Агааржуулалтын систем гадна агаарын хэм хэт өндөр, эсвэл нам үед ашигласан. Тохируулсан хэм болон салоны хэмийн зөрүү багассан үед систем дахин идэвхжинэ. ● Салхиний шилний цан арилгагч асаалттай.

▶ Stop & Start системээр унтарсан хөдөлгүүр автоматаар ассан үед

Мэдээлэл	Дэлгэрэнгүй/Авах үйлдэл
"Preparing to Operate"	Тоормосны дөрөөг нэмж гишгэсэн, эсвэл олон удаа гишгэсэн. Хөдөлгүүр ажиллаж тоормосны хүчлүүрийн вакум зохих түвшинд хүрсэн үед систем автоматаар идэвхжинэ.

Мэдээлэл	Дэлгэрэнгүй/Авах үйлдэл
"For Climate Control"	● Агааржуулалтын систем систем асаасан, эсвэл ашиглагдаж байгаа. ● Салхиний шилний цан арилгагч асаалттай.
"Battery Charging"	Аккумуляторын цэнэг бага байгаа. Хөдөлгүүр ажиллаж аккумуляторыг хангалттай цэнэглэсний дараа систем автоматаар идэвхжинэ.

Аудио систем гэнэт унтарсан

Аудио системийн дууны түвшин хэт өндөр үед аккумуляторын цэнэгийн хэрэглээг бууруулах үүднээс аудио системийн дууны гаралт гэнэт хаагдаж болно.

Аудио системийн дууг дахин гаргах үед асаах товчийг унтраагаад 3 секунд хүлээгээд ACC, эсвэл ON горимд шилжүүлнэ.

Аккумуляторын шонг салгаад дахин холбосон үед аудио систем идэвхжихгүй байж болно.

Асаах товчийг унтраагаад дараах үйлдлийг 2 удаа давтан аудио системийг хэвийн ажиллагаанд шилжүүлнэ.

● Асаах товчийг ON болгоод OFF-д буцаах.

Автомашин жолоодох

⚠ АЮУЛТАЙ

■ Автомашин жолоодох үед

- Хөдөлгүүр унтарсан зэргээр автомашин сул өнхрөх үед автомашин аюулгүй бүрэн зогсох хүртэл хаалга нээх товч ажиллуулах, эсвэл хаалга нээж болохгүй. Энэ нь жолооны хүрд түгжих функц ажиллуулж осол аваар үүсгэх аюултай.
- Ухрах үйлдэл хийх үед биеэрээ эргэж харах нь дөрөөний ажиллагааг хүндрэлтэй болгодог.

  Дөрөөтэй зөв ажиллана.
- Автомашиныг богино зайнд хөдөлгөх үед ч жолоо барих зөв биеийн байрлалтай сууна. Энэ нь таньд дөрөөтэй зөв ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- Тоормосны дөрөөг зөвхөн баруун хөлөөрөө гишгэнэ.

  Зүүн хөлөөрөө гишгэх нь яаралтай үед самбаачлах хурдыг багасгаж улмаар осол аваар үүсгэх аюултай.
- Шатамхай бодис дээгүүр гарах, шатамхай бодисын ойр орчимд автомашинаа зогсоож болохгүй. Яндангийн систем болон яндангаас ялгарч буй утаа нь өндөр хэмтэй байх ба шатамхай материалд гал авалцах аюултай.
- Хэвийн жолоодлогын үед хөдөлгүүр унтраахыг хориглоно. Хөдөлгөөний үед хөдөлгүүр унтраасан ч жолооны механизм, тоормос үргэлжлүүлэн ашиглах боломжтой боловч хүчлүүр ажиллахгүй тул жолоо, тоормос хүнд болно. Ойр орчмын аюулгүй байдлыг нягтлан замын хажууд зогсооно. Автомашиныг хэвийн аргаар зогсоох боломжгүй болсон үед онцгой аргаар автомашин зогсоох арга хэрэглэнэ.
- Эгц налуу замаар уруудах үед аюулгүй тогтмол хурд барихын тулд хөдөлгүүрийн тоормос (хүнд араанд шилжүүлэх) ашиглана. Тоормос удаан ашиглах нь хэт халж ажиллагаагүй болоход хүргэх аюултай.
- Жолоодлогын үед жолооны хүрд, суудал, голын болон хажуугийн толины тохиргоо хийж болохгүй. Энэ нь автомашины жолоодлого алдахад хүргэх аюултай.
- Хөдөлгөөний үед зорчигч гар, толгой болон биеийн бусад хэсгээ гадагш гаргахаас сэргийлж цаг ямагт шалгана.
- AWD загвар: Тус автомашин нь хэт бартаат замаар явахад зориулагдаагүй болно.
  - Зайлшгүй шаардлагаар элс, шавартай замаар явах үед болгоомжтой жолоодох ба элс шавраар урт хугацаанд үргэлжлүүлэн явахаас зайлсхийнэ.
  - Хэт хадархаг, эсвэл энхэл донхолтой замаар явж болохгүй.

⚠ АЮУЛТАЙ

- Гол ус туулж болохгүй. Энэ нь цахилгааны эд ангиудад богино холболт үүсгэх, хөдөлгүүр гэмтээх, эсвэл автомашинд бусад ноцтой гэмтэл учруулах аюултай.
- Огцом тоормослох, хаазлах, мөн жолооны хүрд огцом эргүүлэх нь дугуйг халтирах, улмаар жолоодлого алдахад хүргэх аюултай.
- Огцом хурдлах, араа солиж хөдөлгүүрийн тоормос хийх, хөдөлгүүрийн эргэлт өөрчлөх нь автомашин халтирахад хүргэнэ.
- Тогтоол устай газраар явсны дараа тоормосны дөрөөг зөөлөн гишгэж хэвийн ажиллагааг шалгана. Норсон наклад тоормосны хэвийн ажиллагааг алдагдуулах магадлалтай. Автомашины нэг талын наклад норж тоормос муу барих нь жолоодлогод нөлөөлнө.
- AWD загвар:

  Зайлшгүй шаардлагаар элс, шавартай замаар явах үед болгоомжтой жолоодох ба элс шавраар урт хугацаанд үргэлжлүүлэн явахаас зайлсхийнэ.

  Хэт хадархаг, эсвэл энхэл донхолтой замаар явж болохгүй.

■ Зурагдах, хавирах дуу гарсан үед (накладны элэгдэл заагч)

Нэн даруй өөрийн Lexus дилерт хандаж тоормосны накладаа шалгуулж солиулна уу.

Даруй солиогүй наклад тоормосны планз гэмтээх магадлалтай.

Тоормосны наклад, планз зөвшөөрөгдөх хэмжээнээс элэгдсэн үед автомашин жолоодох нь аюултай.

⚠ АНХААР

■ Автомашины эд ангиудыг эвдрэл гэмтлээс хамгаалах

- Жолооны хүрдийг аль нэг тийш тултал нь эргүүлэх, мөн эргүүлсэн хэвээр удаан бариж болохгүй. Жолооны механизмын хүчлүүр эвдрэх аюултай.
- Энхэл доголтой замаар явах үед дугуй, автомашины доод тал зэргийг гэмтэхээс сэргийлж боломжит бага хурдаар явна.

■ Хөдөлгөөний үед дугуй хагарах

Дугуй хагарсан, гэмтсэн байж болох тул дараах нөхцлүүдэд жолооны хүрдийг чанга бариж тоормос зөөлөн гишгэн хурд хасна:

- Жолооны хүрд аль нэг тал руу татагдаж байгаа
- Автомашинаас хэвийн бус дуу чимээ, чичиргээ гарах
- Автомашин хэвийн бус хазайх

■ Зам үерлэсэн үед

Үертэй замаар гарах нь эрсдэлтэй. Энэ нь автомашинд дараах ноцтой гэмтэл учруулах аюултай:

⚠ АНХААР

- Хөдөлгүүр хүч алдаж унтрах
- Цахилгаан эд ангид богино холболт үүсэх
- Ус орсноос шалтгаалсан хөдөлгүүрийн гэмтэл үүсэх

Хэрэв та үертэй замаар гарсан, автомашин үерт автсан үед та өөрийн Lexus дилерт хандаж дараах зүйлсийг шалгуулна:

- Тоормосны ажиллагаа
- Хөдөлгүүр, хурдны хайрцаг, туслах хурдны хайрцаг, хүч дамжуулах анги (AWD загвар), хойд дифференциал (AWD загвар) зэргийн тос, шингэний хэмжээ, чанарын өөрчлөлт зэрэг
- Кардан гол (AWD загвар), холхивч болон гүүшингийн холбоосууд (шалгах боломжтой холбоосууд) болон бусад татуурга, хөндлөвч, холбоос зэргийн тосолгооны байдал

Үер уснаас шалтгаалан арааны удирдлагын систем гэмтсэн үед арааг P байрлалд, эсвэл P-с бусад байрлалд шилжүүлэх боломжгүй болно.

Энэ нөхцөлд та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ Хөдөлгүүрийн турбог гэмтлээс сэргийлэх (NX350)

Хөдөлгүүрийг өндөр ачаалалтай ажиллуулсны дараа сул ажиллуулна. Турбо хангалттай хөрсний дараа хөдөлгүүр унтраана. Эсрэг тохиолдолд турбо гэмтээх аюултай.

■ Гадаад улсад автомашинаа ашиглах үед

Автомашин бүртгэлийн холбогдох хууль дүрмийг мөрдөх ба тохирох чанартай шатахуун байгаа эсэхийг нягтлана.

Шинэ Lexus автомашинтай хэрхэн харьцах тухай

Ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх үүднээс шинэ автомашинд дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:

● Эхний 300 км (200 миль)-д:

Огцом тоормослохоос зайлсхийх.

● Эхний 2000 км (1200 миль)-д:

- Хэт өндөр хурдтай явахгүй байх.
- Огцом хаазнаас зайлсхийх.
- Хүнд араатай удаан хугацаанд явахгүй байх.
- Тогтмол хурдаар удаан хугацаанд явахгүй байх.

Эко жолоодлого

Шатахуун зарцуулалтыг сайжруулах, автомашины ялгаруулах нүүрсхүчлийн хийг бууруулах үүднээс дараах зүйлсийг анхаарна:

■ Эко горим ашиглах

Хэвийн жолоодлоготой харьцуулахад тус горимд хаазны дөрөө гишгэх үед хөдөлгүүрийн хүч аажмаар нэмэгддэг. Мөн энэ горимд шатахуун зарцуулалтыг сайжруулах зорилгоор автомашины агааржуулалтын систем (халуун/хүйтнээр үлээх) боломжит хамгийн бага хүчин чадлаар ажилладаг.

■ Эко жолоодлогын индикатор ашиглан жолоодох

Мэдээллийн дэлгэцийн эко жолоодлогын индикаторын саваа дэлгэцийг эко жолоодлогын бүсэд байлгах байдлаар жолоодон эко жолоодлого хийх боломжтой.

■ Хааз/тоормосны дөрөөний ажиллагаа

Огцом хурд нэмэх, хасахаас зайлсхийж автомашиныг зөөлөн жолоодно. Хурд аажим нэмэх, хасах нь шатахууны хэт зарцуулалтыг бууруулна.

■ Тоормослох үед

Автомашины урд тал болон ойр орчмын нөхцөл байдлыг нягтлах ба автомашин зогсоох цэгийг урьдчилан тооцоолно. Хаазны дөрөөг эрт суллаж автомашиныг өөрийн инерцээр нь гүйлгэнэ. Тухайн зогсох байрлалдаа тохируулан тоормосны дөрөөг гишгэх ба дөрөөтэй зөөлөн харьцах шаардлагатай.

■ Хоцрохоос зайлсхийх

Олон удаа хурд нэмэх ба хасах, мөн гэрлэн дохио хүлээх нь шатахуун зарцуулалтад сөргөөр нөлөөлнө. Замд гарахаас өмнө замын хөдөлгөөний мэдээллийг урьдчилж шалгах зэргээр товлосон цагаас хоцрохоос сэргийлнэ.

■ Хурдны замаар явах

Автомашины хурдийг тогтмол хурдад барина. Төлбөр хураах цэг зэрэг дээр зогсохын өмнө хангалттай зайнаас хаазны дөрөөг чөлөөлөх ба тоормосны дөрөөг зөөлөн гишгэнэ.

■ Агааржуулалтын систем ашиглах үеийн шатахуун зарцуулалт бууруулах

Агааржуулалтын системийг зөвхөн шаардлагатай үед ашиглах ба энэ нь шатахууны хэт зарцуулалтаас сэргийлнэ.

Зуны улирал: Гадна агаарын хэм өндөр үед дотор агаарын горим сонгоно. Энэ нь агааржуулалтын системийн ачааллыг бууруулах ба шатахуун зарцуулалтад эерэг нөлөөтэй.

Өвлийн улирал: Халуунаар үлээлгэхийн зэрэгцээ цан арилгах шаардлагатай үед A/C товч дарж асаах ба хэрэв зөвхөн халуунаар үлээлгэх үед A/C товчийг унтрааж шатахууны хэт зарцуулалтаас сэргийлнэ.

■ **Хөдөлгүүрийн сул ажиллагаа буюу нормал хааз**

- Шаардлагагүй үед хөдөлгүүр сул ажиллуулахаас зайлсхийнэ. Богино хугацаанд зогсолт хийх үед хөдөлгүүр унтраана.
- Гадна агаарын хэм хэт хүйтэн зэрэг цаг агаарын онцгой нөхцлөөс бусад үед хөдөлгөөний өмнө хөдөлгүүр халаах шаардлагагүй. Хөдөлгүүр халаах үед нормал хаазтай зогсохоос огцом хурд нэмэх, хасах, мөн хөдөлгүүрийн хурдийг огцом нэмэхгүйгээр эд ангиудыг жигд халаангаа зөөлөн явуулах нь илүү үр дүнтэй.
- NX250/NX350: Stop & Start систем ашиглах нь шатахуун зарцуулалт сайжруулна.
- NX200: Хөдөлгүүр унтраахаас өмнөх нормал хааз нь ажиллагааг хангах зориулалттай бөгөөд шаардлагагүй ажиллагаа биш болно.

■ **Ачаа тээшний шатахуун зарцуулалтад үзүүлэх нөлөө**

Хүнд ачаа нь шатахуун зарцуулалт нэмэгдүүлэх тул шаардлагагүй зүйлс тээхээс зайлсхийнэ. Мөн дээврийн том ачаа угсрах нь шатахуун зарцуулалтад сөрөг нөлөөтэй.

■ **Тогтмол засвар үйлчилгээ хийх**

- Дугуйн хийн даралтыг тогтмол шалгах ба дугуйн даралт тохироогүй үед автомашины шатахуун зарцуулалтад сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна өвлийн дугуй нь барьцалдах чадвар өндөртэй тул хуурай, цасгүй зам дээр ашиглах үед шатахуун зарцуулалт мууддаг. Улирал болон замын нөхцөлд тохирсон дугуй ашиглана.
- Тос болон шингэн нь шатахуун зарцуулалт болон автомашины эдэлгээний хугацаанд нөлөөлдөг тул тохирох хэмжээний тос болон шингэн ашиглах ба хэмжээг тогтмол шалгана.

Арааны байрлалын ашиглалтын зориулалт (Автомат хурдны хайрцаг)

Өөрийн зорилго, тухайн нөхцөл байдалд нийцүүлэн арааны байрлал сонгоно.

Арааны байрлал	Зориулалт ба функц
P	Зогсоолд байрлуулах/хөдөлгүүр асаах
R	Ухрах
N	Сул араа
D	Хэвийн жолоодлого(1)
M	M горимын жолоодлого(2)

(1) Шатахуун зарцуулалтын сайжруулах, дуу чимээг бууруулах үүднээс хэвийн жолоодлогын үед D араах сонгоно. Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргээр жолоодлогын нөхцөл байдалдаа нийцүүлэн араа солих боломжтой.

(2) Жолоодлогын M горим сонгосон үед араах хязгаарлах боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

■ Хөдөлгүүрийн тоормос ажиллахгүй нөхцлүүд

Динамик радарын хурд баригчаар автомашин явах үед дараах үйлдлийг хийсэн хөдөлгүүрийн тоормос ажиллахгүй.

- D араагаар явах үед 7/6/5, эсвэл 4-р араанд хүндрүүлэх.
- D арааны байрлалд жолоодлогын Sport горим сонгосон.

■ Араа солих үйлдлийн талаар мэдээлэл дэлгэцээр гарсан үед

Буруу араа сонгох, эсвэл автомашин гэнэт ухасхийн хөдлөхөөс сэргийлж арааны байрлал автоматаар солигдох, эсвэл арааны хөшүүрэг шилжүүлэхийг шаардаж болно. Энэ нөхцөлд мэдээллийн дэлгэцийн мэдээллийн зааврын дагуу араа шилжүүлнэ.

■ AI-SHIFT

AI-SHIFT нь жолоочийн жолоодлого болон хөдөлгөөний нөхцөлд тааруулан тохирох арааг сонгодог. AI-SHIFT нь арааны хөшүүрэг D байрлалд автоматаар ажилладаг. (Арааны хөшүүргийг M байрлалд шилжүүлэх үед функц салгагдана.)

⚠ АЮУЛТАЙ

Хальтиргаатай зам дээр огцом хааз нэмэх, араа шилжүүлж болохгүй. Хөдөлгүүрийн тоормос, эсвэл хөдөлгүүрийн хурд өөрчлөгдөх нь автомашин хөндлөн шарвахад хүргэнэ.

⚠ АНХААР

■ Арааны удирдлагын системд доголдол үүсч болзошгүй нөхцлүүд

Дараах аль нэг нөхцөлд арааны удирдлагын системд доголдол үүсч болзошгүй.

Автомашиныг даруй аюулгүй, тэгш газар зогсоож зогсоолын тоормос залгаад өөрийн Lexus дилерт хандана уу.

- Мэдээллийн дэлгэц дээр арааны удирдлагын системийг илтгэх анхааруулга гарсан үед.
- Тодорхой секундээс удаан хугацаанд арааны байрлал сонгогдоогүйг дэлгэцээр харуулна.

Арааны байрлал бүрийн зориулалт (CVT хурдны хайрцаг)

Арааны байрлалыг эдгээрийн зориулалт болон нөхцөл байдалд нийцүүлэн сонгоно.

■ Арааны байрлалын зориулалт болон функц

Арааны байрлал	Зориулалт, функц
P	Автомашиныг зогсоолд байрлуулах/хөдөлгүүр асаах
R	Ухрах
N	Сул араа
D	Хэвийн жолоодлого(1)
M	10 шатлалт спорт горимоор жолоодох(2)

(1) Шатахуун зарцуулалт сайжруулах, дуу чимээг буурулах үүднээс хэвийн жолоодлогод арааны D байрлал сонгоно. Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргээр жолоодлогын нөхцөлд нийцүүлэн араа сонгох боломжтой.

(2) Арааны M байрлалд араа сонгосноор хурд нэмэх болон хөдөлгүүрийн торможны хүчийг удирдах боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

■ Хөдөлгүүрийн торможхийгдэхгүй үед

Автомашин хурд баригч, эсвэл динамик радарын хурд баригчаар удирдагдах үед дараах үйлдлийг хийсэн ч хөдөлгүүрийн торможхийгдэхгүй.

- Арааны D байрлалаар жолоодох.
- Арааны D байрлалд Спорт горимоор жолоодох.

■ G AI-SHIFT

G AI-SHIFT нь жолоочийн үйлдэл болон жолоодлогын нөхцөлд нийцүүлэн спорт жолоодогод тохиромжтой арааг автоматаар сонгодог. G AI-SHIFT нь арааны D байрлалд жолоодлогын горим сонгох товчийг Спорт горимд тохируулсан үед автоматаар идэвхжинэ. (Жолоодлогын горимыг хэвийн горимд шилжүүлсэн, эсвэл арааг M байрлалд шилжүүлсэн үед тус функц автоматаар идэвхжинэ.)

⚠ АЮУЛТАЙ

Хальтиргаатай замаар явах үед хаазны дөрөө болон арааг огцом ажиллуулахаас зайлсхийнэ. Хөдөлгүүрийн торможс, эсвэл хөдөлгүүрийн хурд өөрчлөгдсөнөөр автомашин хажуу тийш шарвах аюултай.

Арааны байрлал солих (автомат хурдны хайрцаг)

⚠ АЮУЛТАЙ

- Урагш араа сонгосон үед автомашин арагш өнхрөх, R арааны байрлал сонгосон үед урагш өнхрөхөөс сэргийлнэ.

  Энэ нь хөдөлгүүр хүч алдаж унтрах, эсвэл тоормос, жолоодлогоны гүйцэтгэлийг бууруулах, улмаар осол аваар, автомашины эвдрэл гэмтэлд хүргэх аюултай.
- Автомашин явж байх үед арааг P-д шилжүүлж болохгүй. Хурдны хайрцаг гэмтэх, автомашины удирдлага алдахад хүргэнэ.
- Автомашин урагш явж байх үед арааг R-д шилжүүлж болохгүй. Хурдны хайрцаг гэмтэх, автомашины удирдлага алдахад хүргэнэ.
- Автомашин ухрах үед арааг урагш шилжүүлж болохгүй. Хурдны хайрцаг гэмтэх, автомашины удирдлага алдахад хүргэнэ.
- Автомашин явж байх үед арааг N-д шилжүүлснээр хөдөлгүүрийн хүч хурдны хайрцагт дамжихгүй. N байрлал сонгосон үед хөдөлгүүрийн тоормос хийгдэхгүй.
- Хааз гишгэсэн үедээ араа солихоос сэргийлнэ. Арааг P, эсвэл N-с бусад байрлалд шилжүүлэх үед автомашин огцом ухасхийх, хурд нэмэхэд хүргэх ба осол аваар үүсгэх, амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай. Арааны байрлал сольсны дараа хянах самбарын дэлгэц дээр тухайн сонгосон арааны индикатор ассан байгааг нягтлана.

Холбоотой холбоосууд

Анхааруулга гарах үед(X. 575)

Арааны байрлалын дэлгэц болон араа сэлгэх



A Арааны хөшүүрэг

Арааны хөшүүргийг арааны байрлалын индикаторын сумны дагуу зөөлөн шилжүүлнэ.

N араанд шилжүүлэх үед арааг сумны дагуу шилжүүлээд барина.

Арааг тухайн байрлалд шилжүүлсний дараа хөшүүрэг анхны байрлалд буцна (●).

M байрлалд зөвхөн арааны D байрлалаас шилжих боломжтой.

P-с N, D эсвэл R, N, D, M, эсвэл R-с P, D, эсвэл M-с R, R-с D-д шилжүүлэх үед тоормос гишгэн хөдөлгөөнгүй зогсоно.

B Арааны байрлалын индикатор

Хянах самбарын дэлгэц:

Одоогийн арааны байрлал асна.

Арааны хөшүүргийн байрлал:

Одоогийн арааны байрлалыг харуулна.

Арааны байрлал сонгох үед тухайн араанд бүрэн шилжсэн байгааг хянах самбар дээр гарч буй арааны байрлалаар нягтлана.

C P байрлалын товч

Автомашиныг бүрэн зогсоож зогсоолын тоормос залгаад P байрлалын товч дарна.

Араа P байрлалд шилжих үед индикатор асна.

Арааны байрлалын индикатор P болсныг нягтлана.

МЭДЭЭЛЭЛ

■ Асаах товчны горимуудад арааны байрлал солих

- Асаах товчны ACC, эсвэл off горимд арааны байрлал солих боломжгүй.
- Асаах товчны ON горимд арааг зөвхөн N байрлалд шилжүүлэх боломжтой.

- Хөдөлгүүр асаалттай үед арааг P-с D, N, эсвэл R байрлалд шилжүүлэх боломжтой.

■ **Арааг P-с бусад байрлалд шилжүүлэх**

- Тоормосны дөрөөг сайтар гишгэнгээ арааны хөшүүргийг хөдөлгөнө. Тоормосны дөрөө гишгэлгүйгээр арааны хөшүүрэг хөдөлгөсөн үед дохио дуугарч арааны байрлал солих ажиллагаа цуцлагдана.
- Арааны байрлал сонгох үед хянах самбар дээр тухайн байрлалын индикатор ассан байгааг харан араа солих үйлдэл бүрэн хийгдсэнийг нягтлана.
- Арааг P-с M байрлал руу шууд шилжүүлэх боломжгүй.

■ **Арааны байрлал солигдохгүй нөхцлүүд**

Дараах нөхцлүүдэд дохио дуугарч араа солих боломжгүйг мэдээлнэ. Араа солих үйлдлийг зөв дарааллаар дахин хийнэ.

- Хаазны дөрөө гишгэлгүйгээр P-с өөр байрлалд шилжүүлэхээр оролдсон
- Хаазны дөрөө гишгэсэн үедээ P-с өөр байрлалд шилжүүлэхээр оролдсон
- Зогссон, эсвэл хэт бага хурдаар явах үедээ тоормосны дөрөө гишгэлгүйгээр N байрлалаас өөр байрлалд шилжүүлэхээр оролдсон
- Зогссон, эсвэл хэт бага хурдаар явах үедээ хаазны дөрөө гишгэн N байрлалаас өөр байрлалд шилжүүлэхээр оролдсон
- Арааг P, эсвэл N байрлалаас M-д шилжүүлэхээр оролдсон
- Жолоодлогын үед P арааны байрлалын товч дарсан

  Хэт бага хурдаар явах үед араа P байрлалд шилжиж болно.

■ **Араа автоматаар N байрлалд шилжих нөхцөл**

Дараах нөхцлүүдэд дохио дуугарч араа N байрлалд шилжсэнийг мэдээлнэ. Зохих үйлдлийн дагуу арааны байрлалыг дахин солино.

- Автомашин урагш явж байх үед арааг R-д шилжүүлэхээр оролдох

  Бага хурдаар явах үед араа R-д шилжиж болно.
- Автомашин ухрах үед арааг D-д шилжүүлэхээр оролдох

  Бага хурдаар явах үед араа D-д шилжиж болно.
- Арааг R-с M-д шилжүүлэхээр оролдох үед

■ **Жолоодлогын үед арааны N байрлал сонгогдсон нөхцөлд**

Тодорхой хурдаас дээш хурдтай үед арааны хөшүүргийг N байрлалд шилжүүлсэн нөхцөлд хөшүүргийг N байрлалд удаан барилгүйгээр араа N байрлалд шилжинэ. Энэ нөхцөлд дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарч араа N байрлалд шилжсэнийг мэдээлнэ.

■ **Автоматаар P байрлал сонгох функц**

Дараах нөхцлүүдэд араа автоматаар P байрлалд шилжинэ.

- Автомашин зогссон ба асаах товч ON горимд байгаа үед арааны P-с бусад байрлалд асаах товч дарсан (араа P байрлалд шилжсэний дараа асаах товч унтарна) *1
- Араа P-с бусад байрлалд байгаа үед жолоочийн хаалга нээгдсэн ба дараах бүх нөхцөл бүрдсэн нөхцөлд
  - Асаах товч ON горимд байгаа.
  - Жолооч аюулгүйн бүсээ бүслээгүй.
  - Тоормосны дөрөө гишгээгүй.

  Араа P байрлалд шилжсэний дараа автомашин дахин хөдөлгөх.
- Жолоодлогын үед онцгой нөхцөл шаардлагаар хөдөлгүүр унтраасны дараа автомашин зогссон нөхцөлд.
- Араа P-с бусад байрлалд байгаа үед аккумуляторын хүчдэл унасан нөхцөлд.

■ **Араа P байрлалаас өөр байрлалд шилжихгүй байгаа үед**

Аккумуляторын цэнэг суусан байж болно. Энэ нөхцөлд аккумулятороо шалгана уу.(→X. 591)

⚠ АЮУЛТАЙ

■ **Арааны хөшүүргийн тухай**

- Арааны хөшүүргийн толгой салгах, эсвэл Lexus-н оригиналаас өөр толгой ашиглаж болохгүй. Мөн арааны хөшүүрэг дээр аливаа зүйл тогтоож болохгүй. Арааны хөшүүргийг байрлалд буцаахад саад болох, улмаар автомашины хөдөлгөөний үед осол аваар үүсгэх аюултай.
- Арааны байрлалыг санамсаргүйгээр солихоос сэргийлж ашиглаагүй үед арааны хөшүүрэгт хүрч болохгүй.

■ **P байрлалын товч**

- Автомашин явах үед P байрлалын товч дарж болохгүй.

  Автомашин бага хурдаар явах (жишээлбэл автомашин зогсохын өмнө) үед P байрлалын товч дарсан нөхцөлд автомашин огцом зогсох, улмаар осолд хүргэх аюултай.
- Арааны байрлалыг санамсаргүйгээр солихоос сэргийлж ашиглаагүй үед арааны хөшүүрэгт хүрч болохгүй.

*1 : Автомашин бүрэн зогсохоос дөнгөж өмнөхөн зэрэг хэт бага хурдаар явах үед асаах товч дарсан нөхцөлд араа P байрлалд автоматаар шилжиж болно. Асаах товч дарахын өмнө автомашин бүрэн зогссоныг нягтлана.

⚠ АНХААР

■ **Арааны хөшүүрэг болон P байрлалын товчны ажиллагааны анхааруулга**

Арааны хөшүүрэг болон P байрлалын товчийг ээлжлэн олон ажиллуулж болохгүй. Системийн хамгаалах функц идэвхжиж арааг P-с өөр байрлалд түр хугацаанд шилжүүлэх боломжгүй болно. Энэ нөхцөлд арааны хөшүүргийг дахин ажиллуулах хүртэл хэсэг хүлээнэ.

■ **Автомашинаас гарах үед(зөвхөн жолоочийн суудал)**

Хаалга онгойлгож автомашинаас гарахаас өмнө арааны индикатор P байрлалыг зааж зогсоолын тоормосны индикатор ассан байгааг нягтлана.

Арааны хөшүүргийг N байрлалд барингаа асаах товчийг ACC горимд шилжүүлсэн үед

Дараах үйлдлээр арааны N байрлалд асаах товчийг ACC горимд шилжүүлэх боломжтой.

1 **Хөдөлгүүр асаалттай үед арааг N байрлалд шилжүүлнэ.**

2 **Арааны хөшүүргийг (●) байрлалд буцаана.**

3 **Дохио дуугарах хүртэл арааны хөшүүргийг N байрлалд барина.**

4 **Дохио дуугарснаас хойш 5 секундын дотор асаах товч дарна.**

Арааны N байрлалд асаах товч ACC горимд шилжинэ.*2

Дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр **"Holding N Push P Switch When Done"** гарсныг нягтлана.

- Арааг N-с өөр байрлалд шилжүүлэх үед P байрлалын товч дарна. Араа P байрлалд шилжинэ.
- Хөдөлгүүр асаагүй үед ч арааны хөшүүрэг болон асаах товч ашиглан арааны N байрлалд асаах товчийг ACC горимд шилжүүлэх боломжтой. Үйлдэл хийхээс өмнө хөдөлгүүр асаалттай байгааг нягтлана.

⚠ АНХААР

■ **Арааны хөшүүргийн N байрлалыг өөрчлөлгүйгээр асаах товчийг ACC горимд шилжүүлэх**

Арааны хөшүүргийн N байрлалыг өөрчлөлгүйгээр асаах товчийг ACC горимд шилжүүлэх үед тус горимд шилжүүлэхээс өмнө хөдөлгүүр

*2 : Энэ хэвээр байлгах үед асаах товчийг ажиллуулж болохгүй. Асаах товч ажиллуулсан үед асаах товч унтарч араа автоматаар P байрлалд шилжинэ.

⚠ АНХААР
асаалттай байх шаардлагатай. Хөдөлгүүр асаагүй үед асаах товчны горимд солисон нөхцөлд араа Р байрлалд шилжинэ.

Арааны байрлал солих (CVT хурдны хайрцаг)

⚠ АЮУЛТАЙ

- Автомашиныг урагш араатай үед арагш, R араатай үед урагш өнхрөхөөс сэргийлнэ. Эсрэг тохиолдолд хөдөлгүүр хүч алдаж унтрах, эсвэл тоормос, жолоодлого муудаж улмаар осол аваар, эвдрэл гэмтэлд хүргэж болно.
- Автомашин явж байх үед араг P байрлалд шилжүүлж болохгүй. Хурдны хайрцаг гэмтээх, улмаар автомашины удирдлага алдагдахад хүргэж болно.
- Автомашин явж байх үед араг R байрлалд шилжүүлж болохгүй. Хурдны хайрцаг гэмтээх, улмаар автомашины удирдлага алдагдахад хүргэж болно.
- Автомашин ухрах үед араг урагш араанд шилжүүлж болохгүй. Хурдны хайрцаг гэмтээх, улмаар автомашины удирдлага алдагдахад хүргэж болно.
- Автомашин явж байх үед араг N-д шилжүүлэх нь хөдөлгүүрийн хүчийг салгана. N байрлалд хөдөлгүүрийн тоормос ажиллахгүй.
- Хаазны дөрөө гишгэнгээ араа солихоос сэргийлнэ. P, эсвэл N-с бусад араанд шилжүүлсэн үед автомашин огцом ухасхийн хөдөлж улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

Арааны хөшүүрэг шилжүүлэх



Асаах товчны ON горимд тоормосны дөрөө гишгээд*1 араа суллах товч дарангаа арааны хөшүүргийг шилжүүлнэ.

Араа суллах товчийг дарангаа арааны хөшүүргийг шилжүүлнэ.

Арааны хөшүүргийг хэвийн байдлаар шилжүүлнэ.

Араг P болон D хооронд сэлгэх үед автомашин бүрэн зогссон байх шаардлагатай.

*1 : Араа суллах товч дарахаас өмнө эхлээд тоормос гишгэхэд араг P байрлалаас шилжүүлэх боломжтой. Араа суллах товчийг эхлээд дарсан үед араа шилжихгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ Араа түгжих системийн функц, ажиллагаа

Араа түгжих систем нь хөдөлгөөн эхлэх үед арааны хөшүүргийн буруу ажиллагаанаас сэргийлэх систем болно. Зөвхөн асаах товчны ON горимд тоормосны дөрөө гишгэсэн нөхцөлд арааг P-г шилжүүлэх боломжтой.

Араа түгжих түгжээг тайлах

⚠ АЮУЛТАЙ

Арааны түгжээ тайлах товч дарахаас өмнө зогсоолын тоормос залгаж тоормос гишгэнэ. Арааны түгжээ тайлах товч дарах үед санамсаргүй хаазны дөрөө гишгэн арааг P-с шилжүүлсэн нөхцөлд автомашин огцом ухасхийн хөдлөх аюултай.

Эхлээд тоормосны дөрөө гишгэнэ. Тоормос гишгэсэн арааны хөшүүрэг шилжихгүй үед араа түгжих системд гэмтэл үүссэн байж болзошгүй. Даруй өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

Дараах үйлдлээр арааны хөшүүргийг онцгой нөхцөлд шилжүүлэх боломжтой.

1 **Зогсоолын тоормос залгана.**

2 **Асаах товч унтраана.**

3 **Тоормосны дөрөө гишгэнэ.**

4 **Тагийг хасах халив, эсвэл төстэй багажаар хөшнө.**

Тагийг гэмтлээс сэргийлж халивны үзүүрийг даавуугаар жийрэглэнэ.



5 **Араа түгжих товчийг дарангаа арааны хөшүүрэг дэх товчийг дарна.**

Товч дарах үед арааны хөшүүргийг шилжүүлэх боломжтой.



Хөдөлгөөн эхлэх

1 **Хаазны дөрөө гишгэн арааг D-д шилжүүлнэ.**

Арааны байрлалын D индикатор ассаныг нягтлана.

⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгүүр асаалттай зогсох үед цаг ямагт тоормосны дөрөө гишгэнэ. Энэ нь автомашин урагш өнхрөхөөс сэргийлнэ.

2 **Зогсоолын тоормос залгагдсан байгаа үед салгана.**

3 **Тоормосны дөрөөг зөөлөн суллан хааз аажмаар гишгэн хөдөлгөөн эхлэнэ.**

Холбоотой холбоосууд

Зогсоолын тоормос гар аргаар залгах/салгах (гар ажиллагааны горим)(X. 190)

Өгсүүр зам өөд хөдөлгөөн эхлэх

1 **Тоормосны дөрөөг гүйцэд гишгээд арааг D-д шилжүүлнэ.**

Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах функц идэвхжинэ.

⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгүүр асаалттай зогсох үед цаг ямагт тоормосны дөрөө гишгэнэ. Энэ нь автомашин урагш өнхрөхөөс сэргийлнэ.

2 **Зогсоолын тоормос залгана.**

3 **Тоормосны дөрөөг суллан хаазны дөрөөг зөөлөн гишгэнэ.**

4 **Зогсоолын тоормос салгана.**

Холбоотой холбоосууд

Зогсоолын тоормос гар аргаар залгах/салгах (гар ажиллагааны горим)(X. 190)

Баруун зүүн эргэх, эгнээгээ солих үеийн ажиллагаа

Эргэх дохионы хөшүүрэг ашиглан жолооч дараах утгыг илэрхийлэх боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

- Асаах товчны ON горимд эргэх дохионы хөшүүрэг ажиллана.
- Индикатор хэвийн үеэс хурдан анивчих үед урд болон хойд эргэх дохионы гэрэл шатсан эсэхийг нягтлана уу.



1 Хөшүүргийг 1 байрлалд шилжүүлнэ.

Баруун эргэх дохионы гэрэл анивчина.

2 Хөшүүргийг 2 байрлалд түлхээд суллана.

Баруун эргэх дохионы гэрэл 3 анивчина.

3 Хөшүүргийг 3 байрлалд түлхээд суллана.

Зүүн эргэх дохионы гэрэл 3 анивчина.

4 Хөшүүргийг 4 байрлалд шилжүүлнэ.

Зүүн эргэх дохионы гэрэл анивчина.

Араа солих (Автомат хурдны хайрцаг)

Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүрэг ашиглан араа солих боломжтой. Араа солих нь шаардлагагүй хөнгөн араанд шилжихээс сэргийлж хөнгөн арааг хязгаарлаж хөдөлгүүрийн тоормос гаргадаг.

Арааны D байрлалд арааны шатлал сонгох

D араатай үед арааг түр өөрчлөн [-] жолоодох үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулна.

Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [-] болон [+] талыг дарж арааны шатлал сонгоно.



1 Хөнгөн араанд шилжүүлэх
2 Хүнд араанд шилжүүлэх

Мэдээллийн дэлгэц дээр D1-с D8 хүртэлх арааны шатлалыг харуулна.

D байрлалд буцах үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [+] товчийг доош удаан дарна.

- Мэдээллийн дэлгэц дээр D2-с D8 хүртэлх арааны шатлал гарсан үед автомашины хурд болон жолоодлогын байдалд нийцүүлэн 1-р араанаас тухайн араа хүртэлх арааны хооронд хурдны хайрцаг автоматаар шилжинэ.
- Мэдээллийн дэлгэц дээр D1 гарсан үед зөвхөн 1-р араа сонгогдоно.

  Хөнгөн араатай харьцуулахад хүнд араа нь илүү хүчтэй хөдөлгүүрийн тоормосны хүч үүсгэнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ D арааны байрлалд арааны шатлалт автоматаар цуцлагдах

Дараах нөхцөлд цуцлагдана:

- Автомашин зогссон
- Хаазны дөрөөг тодорхой хугацаанаас удаан гишгэсэн үед
- Арааг D-с өөр байрлалд сэлгэсэн

■ Хүнд арааnd шилжихийг хязгаарлах анхааруулах дуут дохио

Аюулгүй байдал, жолоодлогын гүйцэтгэлийг хангах үүднээс зарим нөхцөлд хүнд арааnd шилжих нь хязгаарлагдаж болно. Зарим нөхцөлд жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг сэлгэсэн ч хүнд арааnd шилжихгүй байж болно. (Дуут дохио 2 удаа дуугарна.)

Араа солих (CVT хурдны хайрцаг)

Арааны хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүрэг ашиглан арааг солих боломжтой. Араа солих нь хөдөлгүүрийн торможны хүчийг удирдах боломж олгоно.

Арааны D байрлалд араа солих

D араатай үед арааг түр өөрчлөн жолоодох үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн аль нэг талыг дарна.

Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [-] болон [+] талыг дарж араа солино.



1 Хөнгөн араанд шилжүүлэх
2 Хүнд араанд шилжүүлэх

Мэдээллийн дэлгэц дээр D1-с D10 хүртэлх арааны шатлалыг харуулна.

D байрлалд буцах үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [+] товчийг удаан дарна.

● Арааны шатлалууд ба тэдгээрийн функц

- Хурд нэмэх, хөдөлгүүрийн торможс хийх 10 шатлалт араа сонгоно.
- Доод араанууд нь дээд араануудаас илүү хүчтэй хурд нэмэх, хөдөлгүүрийн торможс хийх хүчтэй ба хөдөлгүүрийн эргэлт мөн нэмэгдэнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ D арааны байрлалд арааны шатлал автоматаар цуцлагдах

Дараах нөхцөлд цуцлагдана:

● Автомашин зогссон
● Хаазны дөрөөг тодорхой хугацаанаас удаан гишгэсэн үед
● Арааг D-с өөр байрлалд сэлгэсэн
● Хөдөлгүүрийн хурд тухайн сонгосон араанд хэт өндөр болсон

■ Хүнд араанд шилжихийг хязгаарлах анхааруулах дуут дохио

Аюулгүй байдал, жолоодлогын гүйцэтгэлийг хангах үүднээс зарим нөхцөлд хүнд араанд шилжих нь хязгаарлагдаж болно. Зарим нөхцөлд жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг сэлгэсэн ч хүнд араанд шилжихгүй байж болно. (Дуут дохио 2 удаа дуугарна.)

Араа солих (Автомат хурдны хайрцаг)

Арааны хөшүүргийг M байрлалд шилжүүлж M горим сонгоно. Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүрэг ашиглан шаардлагатай арааг сонгох боломжтой.

M горимд араа солих

Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [-] болон [+] товчоор араа солих боломжтой.



1 Хөнгөн араанд шилжүүлэх
2 Хүнд араанд шилжүүлэх

Хөшүүргийг ажиллуулах бүр араа нэг байрлалаар өөрчлөгдөнө.

Тухайн сонгосон M1-с M8 араа мэдээллийн дэлгэц дээр гарна.

Тус горим сонгогдсон үед арааны хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулаагүй үед араа солигдохгүй.

Нөгөөтэйгүүр M байрлал сонгогдсон ч дараах нөхцлүүдэд араа автоматаар шилжинэ:

- Автомашины хурд буурах үед (зөвхөн хүнд араанд).
- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм бага, эсвэл автомат хурдны хайрцагны шингэний хэм хэт бага үед.
- Автомат хурдны хайрцагны шингэний хэм хэт өндөр үед (зөвхөн хөнгөн араанд).
- Тахометрын зүү улаан бүсэд орсон (зөвшөөрөгдөх хөдөлгүүрийн хурдаас давсан).

Дараах нөхцлүүдэд жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулсан ч араа шилжихгүй.

- Автомашины хурд бага (зөвхөн хөнгөн араанд).

МЭДЭЭЛЭЛ

■ Хүнд араанд шилжихийг хязгаарлах анхааруулах дуут дохио

Аюулгүй байдал, жолоодлогын гүйцэтгэлийг хангах үүднээс зарим нөхцөлд хүнд араанд шилжих нь хязгаарлагдаж болно. Зарим нөхцөлд хөшүүргийг сэлгэсэн ч хүнд араанд шилжихгүй байж болно. (Дуут дохио 2 удаа дуугарна.)

■ **Хөшүүргийг M байрлалд сэлгэсэн ч "M" индикатор асахгүй байх, эсвэл "D" индикатор ассан хэвээр байх үед**

Автомат хурдны хайрцагны системд доголдол үүссэн байж болзошгүй. Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу. (Энэ нөхцөлд хурдны хайрцаг D арааны горимтой адил байдлаар ажиллана.)

Араа солих (CVT хурдны хайрцаг)

10 араатай спорт араа солих горимд шилжүүлэх үед арааг М байрлалд шилжүүлнэ. Арааны хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргээр араа солих боломжтой.

М горимд араа сонгох

Арааны хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн [-] болон [+] товчоор араа солих боломжтой.



1 Хөнгөн арааңд шилжүүлэх
2 Хүнд арааңд шилжүүлэх

Хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулах бүр араа нэг байрлалаар өөрчлөгдөнө.

Тухайн сонгосон М1-с М10 араа мэдээллийн дэлгэц дээр гарна.

Арааны хөшүүрэг М горимд байгаа ч арааны хөшүүрэг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулаагүй үед араа солигдохгүй.

Нөгөөтэйгүүр М байрлал сонгогдсон ч хөдөлгүүрийн хурдаас хамаарч араа автоматаар солигдож болно.

МЭДЭЭЛЭЛ

■ Арааны хөшүүргийн М байрлалд автомашин хурд хасч зогсох үед

- Автомашин зогссон үед хурдны хайрцаг автоматаар М1 арааңд шилжинэ.
- Зогссоны дараа автомашин М1 араагаар хөдөлгөөн эхлэнэ.
- Автомашин зогссон үед хурдны хайрцаг М1-д тохируулагдана.

■ **Хүнд арааnd шилжихийг хязгаарлах дуут дохио**

Аюулгүй байдал, жолоодлогын гүйцэтгэлийг хангах үүднээс зарим нөхцөлд хүнд арааnd шилжих нь хязгаарлагдаж болно. Зарим нөхцөлд хөшүүргийг, эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүрэг сэлгэсэн ч хүнд арааnd шилжихгүй байж болно. (Дуут дохио 2 дуугарна.)

■ **Арааг M-д шилжүүлсэн ч "M" индикатор асахгүй байх, эсвэл "D" индикатор ассан хэвээр байгаа нөхцөлд**

Автомат хурдны хайрцагны системд доголдол үүссэн байж болзошгүй. Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу. (Энэ нөхцөлд хурдны хайрцаг арааны D байрлалын горимоор ажиллана.)

Автомашиныг зогсоолд байрлуулах үед

Автомашиныг зогсоосон, зогсоолд байрлуулсан үеийн анхааруулга

⚠ АЮУЛТАЙ

■ **Зогсоолд байрлуулсан үед**

- Байнга зогсоолын тоормос татаж арааг P байрлалд шилжүүлэн хөдөлгүүр унтрааж автомашиныг түгжинэ. Хөдөлгүүр асаалттай үед автомашиныг хүнгүй орхиж болохгүй.

  Зогсоолын тоормос залгалгүйгээр арааны P байрлалд автомашин зогсоосон автомашин хөдлөх, улмаар осол аваар үүсгэх аюултай.
- Бага насны хүүхдийг хараа хяналтгүй автомашинд үлдээж болохгүй. Хүүхэд санамсаргүй зогсоолын тоормос салгаж автомашин өнхрөх, улмаар осол аваар үүсгэх аюултай.
- Нартай үед нүдний шил, тамхины асаагуур, лаазтай шүршдэг бодис, лаазтай ундаа автомашинд үлдээхийг хориглоно. Дараах эрсдлүүд үүснэ:
  - Тамхины асаагуур, лаазтай шүршдэг бодисноос хий алдагдаж улмаар гал гарч болзошгүй.
  - Автомашины бүхээгний өндөр хэмд нүдний шилний хуванцар линз болон бусад хэсгийн хэлбэр алдагдах, цуурч гэмтэх аюултай.
  - Ундааны лааз хагарах, ундаа автомашины бүхээгт цацагдах, цахилгааны эд ангиудад богино холболт үүсгэх аюултай.
- Автомашинд тамхины асаагуур үлдээж болохгүй.

  Урд хайрцагт хийсэн, эсвэл шалан дээр тамхины асаагуур орхисон үед суудлын тохиргоо хийх, эд зүйл хийх үед санамсаргүй дарагдаж асах, улмаар гал гарч болзошгүй.
- Сорж наалддаг наалт шилэнд наах, мөн агаар цэвэршүүлэгч зэргийн сав хянах самбар, урд хэсэгт тавиж болохгүй. Эдгээр нь линз шиг гэрэл цуглуулж гал гаргах аюултай.
- Хүнхэр шил зэргийг гэрэл ойлгодог мөнгөлөг өнгөтэй металл хуулгаар бүрсэн нөхцөлд автомашины цонх, хаалгыг онгорхой орхиж болохгүй.

  Шил хүнхэр линз шиг ойсон гэрлийг цуглуулж гал гаргах аюултай.
- Хөдөлгүүр ажиллаж байгаа, эсвэл унтарсан даруйд халуун янданд хүрч болохгүй. Халуун янданд хүрсэн үед түлэгдэх аюултай.

■ **Автомашинд унтах үед**

Автомашинд унтах үед хөдөлгүүр заавал унтраана. Эсрэг тохиолдолд санамсаргүйгээр арааг солих, эсвэл хаазны дөрөөг гишгэвэл энэ нь осол гаргах, мөн хөдөлгүүр хэт халснаас үүдэн гал гарахад хүргэх аюултай. Үүнээс гадна автомашин агааржуулалт муутай орчинд байгаа үед яндангийн утаа хуримтлагдах, улмаар бүхээгт орох аюултай.

Хаягдал утааны анхааруулга

Утаа нь амьсгалсан тохиолдолд аюултай бодис агуулах тул амьсгалах нь аюултай.

⚠ АЮУЛТАЙ

Автомашины хаягдал утаанд өнгө болон үнэргүй нүүрстөрөгчийн исэл (CO) агуулагддаг тул дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд хаягдал утаа автомашины бүхээгт орж хүний мэдрэлийн тогтолцоонд нөлөөлөх замаар осолд хүргэх, эсвэл амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй.

- Тээшний хаалга хаалттай байна.

  Тээшний хаалга хаалттай үед бүхээгт хаягдал утааны үнэр үнэртвэл цонхоо нээх, мөн даруй өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа оношлуулна.
- Автомашин гарааш зэрэг битүү, эсвэл агааржуулалт муутай орчинд байгаа үед хөдөлгүүрийг унтраана.
- Удаан хугацаанд хөдөлгүүр асаалттай байлгахыг хориглоно. Зайлшгүй шаардлагаар удаан хугацаанд хөдөлгүүр асаалттай байлгах тохиолдолд автомашиныг задгай талбайд байрлуулах ба бүхээгт яндангаас гарч буй утаа орохгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.
- Цас хунгарласан, эсвэл цас орж буй газар хөдөлгүүр асаалттай орхихыг хориглоно. Асаалттай автомашины ойр орчимд цас хунгарласан үед хаягдал утаа хуримтлагдаж бүхээг рүү орж болзошгүй.
- Автомашины яндангийн систем, эд ангиудыг тогтмол шалгана. Дараах аль нэг шинж тэмдэг илэрсэн үед та өөрийн Lexus дилерт хандаж оношилгоо, засвар хийлгэнэ үү.
  - Янданд зэврэлтээс үүдсэн нүх болон цууралт үүссэн
  - Яндан залгаас хэсгээрээ гэмтсэн
  - Яндангаас хэвийн бус дуу чимээ гарч байгаа

Зогсоох

1 Тоормосны дөрөө гишгэнэ.

⚠ АЮУЛТАЙ

- Тоормос норсон үед хэвийн үеэс илүү анхааралтай жолоодно. Тоормос норсон үед тоормосны зам уртасна. Мөн тоормос барилт муудах ба нөхцөл байдлаас хамаарч баруун болон зүүн талын тоормос өөрөөр барина. Үүнээс гадна зогсоолын тоормос сайн барихгүй байж болно.
- Тоормосны хүчлүүр ажиллахгүй үед бусад автомашинд ойр явж болохгүй ба тоормос шаардах уруу, эсвэл огцом эргэлттэй замаас зайлсхийнэ. Энэ нөхцөлд тоормос ажиллах боловч тоормосны дөрөөг хэвийн үеэс илүү хүчээр гишгэх шаардлагатай. Мөн тоормосны зай уртасна. Тоормосоо даруй засуулна уу.
- Хөдөлгүүр хүч алдаж унтарсан үед тоормосыг олон гишгэж болохгүй. Тоормос гишгэх бүрт цахилгаан дэмжлэгэтэй тоормосны нөөц зарцуулагдана.
- Тоормосны гидравлик систем доголдсон үед даруй засуулна уу. Систем нь 2 тусдаа системээс бүрдэх ба аль нэг систем доголдох үед нөгөө систем нь ажиллана. Энэ нөхцөлд тоормосны дөрөөг илүү хүчтэй гишгэх шаардлагатай болох ба тоормосны зам уртасна.

⚠ АНХААР

Өгсүүр замд автомашиныг зогсоох үүднээс хаазны дөрөө гишгэх, эсвэл хааз болон тоормосны дөрөөг зэрэг гишгэхийг хориглоно.

2 Шаардлагатай үед зогсоолын тоормос татна.

Автомашиныг удаан зогсоох шаардлагатай үед арааг P байрлалд шилжүүлнэ.

⚠ АЮУЛТАЙ

■ Автомашин зогссон үед

- Хөдөлгүүр ээрүүлж болохгүй.

  Араа P, эсвэл N-с бусад байрлалд байгаа үед автомашин гэнэт ухасхийн хөдөлж осолд хүргэх аюултай.
- Автомашин өнхөрч осол үүсгэхээс сэргийлж хөдөлгүүр асаалттай үед байнга тоормос гишгэж шаардлагатай үед зогсоолын тоормос залгана.
- Автомашин налуу зам дээр зогссон үед автомашин урагш хойш өнхрөхөөс сэргийлж тоормос гишгэх ба шаардлагатай үед зогсоолын тоормос залгана.

⚠ АЮУЛТАЙ

- Хэт өндөр хааз өгөх, хөдөлгүүр ээрүүлэхийг хориглоно. Автомашин зогссон үед хөдөлгүүрийг өндөр хурдаар ажиллуулах нь хаягдал утааны системийг халаах, улмаар ойр орчмын шатамхай материалыг шатаах аюултай.

Холбоотой холбоосууд

Арааны байрлалын дэлгэц болон араа сэлгэх (X. 167)

Арааны хөшүүрэг шилжүүлэх(X. 172)

Автомашин зогсоолд байрлуулах

1 **Тоормос гишгэж автомашиныг бүрэн зогсооно.**

2 **Зогсоолын тоормос залгагдаагүй үед залгана.**

3 **Арааг P-д шилжүүлнэ.**

Арааны хөшүүргийн P байрлалын индикатор болон зогсоолын тоормосны индикатор ассаныг нягтлана.

⚠ АЮУЛТАЙ

Байнга зогсоолын тоормос залган арааг P-д шилжүүлнэ. Эсрэг тохиолдолд автомашин хөдлөх, эсвэл санамсаргүйгээр хаазны дөрөө гишгэсэн үед автомашин огцом ухасхийх аюултай.

4 **Асаах товч дарж хөдөлгүүр унтраана.**

5 **Тоормосны дөрөөг аажмаар суллана.**

6 **Хаалга түгжиж электрон түлхүүрийг биедээ авснаа нягтлана.**

Налуу талбай дээр зогсоолд байрлуулсан үед ивээс ашиглана.

Холбоотой холбоосууд

Зогсоолын тоормос гар аргаар залгах/салгах (гар ажиллагааны горим)(X. 190)

Арааны байрлал солих (автомат хурдны хайрцаг)(X. 166)

Арааны байрлал солих (CVT хурдны хайрцаг)(X. 172)

Зогсоолын тоормосны ажиллагаа

Зогсоолын тоормосыг автоматаар (автомат горим), эсвэл гар аргаар (гар ажиллагааны горим), татах, салгах боломжтой. Автомат горимд арааны хөшүүргийн ажиллагаанаас хамаарч зогсоолын тоормос автоматаар идэвхжих буюу салгагдана. Мөн автомат горимд гар аргаар ажиллуулах боломжтой.

⚠ АЮУЛТАЙ

■ Автомашиныг зогсоолд байрлуулах үед

Бага насны хүүхдийг автомашинд ганцаар үлдээхийг хориглоно. Хүүхэд зогсоолын тоормосыг санамсаргүйгээр салгах, улмаар автомашин хөдөлж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осол үүсгэх аюултай.

⚠ АЮУЛТАЙ

■ Зогсоолын тоормосны товч

Зогсоолын тоормосны товчны ойр орчимд аливаа эд зүйл байрлуулах, суурилуулахыг хориглоно. Тоормосны товчтой санамсаргүй харьцах, улмаар зогсоолын тоормос ажиллахад хүргэж болно.

⚠ АНХААР

■ Автомашиныг зогсоолд байрлуулсан үед

- Байнга зогсоолын тоормос татаж арааг P байрлалд шилжүүлэн хөдөлгүүр унтрааж автомашиныг түгжинэ. Хөдөлгүүр асаалттай үед автомашиныг хүнгүй орхиж болохгүй.

  Зогсоолын тоормос залгалгүйгээр арааны P байрлалд автомашин зогсоосон автомашин хөдлөх, улмаар осол аваар үүсгэх аюултай.

■ Системд доголдол үүссэн үед

Автомашиныг аюулгүй газарт зогсоож анхааруулах мэдээллийг шалгана.

■ Аккумуляторын цэнэг суусан үед

Зогсоолын тоормосны систем идэвхжихгүй.

■ Доголдлоос шалтгаалан зогсоолын тоормос салгагдахгүй үед

Зогсоолын тоормос залгаатай хэвээр автомашиныг жолоодох нь тоормосны эд ангийг халаах ба энэ нь тоормосны ажиллагааг бууруулах, эд ангийн элэгдэл хүргэнэ. Энэ нөхцөлд даруй өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

МЭДЭЭЛЭЛ

■ Зогсоолын тоормос автоматаар салгах функц

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед хаазны дөрөө гишгэн зогсоолын тоормос салгах боломжтой.

- Жолоочийн хаалга хаалттай
- Жолооч аюулгүйн бүсээ бүсэлсэн
- Арааны хөшүүрэг урагш, эсвэл ухрах арааанд байгаа
- Доголдлын индикатор, эсвэл тоормосны системийн анхааруулах гэрэл асаагүй

Хаазны дөрөөг зөөлөн гишгэнэ. Хаазны дөрөө гишгэх үед зогсоолын тоормос салаагүй нөхцөлд зогсоолын тоормосыг гар аргаар салгана.

Автомат горим: Арааг P байрлалаас шилжүүлэх үед зогсоолын тоормос автоматаар салгагдана.

■ Зогсоолын тоормосны ажиллагааны дуу

Зогсоолын тоормос ажиллах үед мотор ажиллах дуу (хүнгэнэсэн) сонсогдож болно. Энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.

■ **Зогсоолын тоормосны индикатор**

● Хөдөлгүүрийн асаах товчны горимоос хамаарч зогсоолын тоормосны индикатор дараах байдлаар асна:

ON: Зогсоолын тоормос салгагдах хүртэл асна.

ON-с бусад горим: 15 секунд орчим асна.

● Зогсоолын тоормос залгаатай үед асаах товч унтраасан нөхцөлд зогсоолын тоормосны индикатор 15 секунд үргэлжлэн асна. Энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.

■ **Зогсоолын тоормосны товч доголдсон үед**

Автомат горим (автоматаар тоормос залгах, салгах) автоматаар асна.

■ **Зогсоолын тоормосны анхааруулах дуу**

Зогсоолын тоормос залгаатай үед автомашин жолоодсон нөхцөлд дохио дуугарна. **"Parking Brake ON"** анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гарна (хурд 5 км/ц [3 миль/ц] хүрэх үед).

Зогсоолын тоормос автоматаар залгагдах/салгагдах (авто горим)

Автомашин зогссон үед зогсоолын тоормосны товчийг **"EPB Shift Interlock Function Activated"** мэдээлэл мэдээллийн дэлгэц дээр гарах хүртэл татна.

Автомат горим асах үед зогсоолын тоормос дараах байдлаар ажиллана.

● Араар P-с шилжүүлэх үед: Зогсоолын тоормос салгагдах ба зогсоолын тоормосны индикатор унтарна.

● Араар P-д шилжүүлэх үед: Зогсоолын тоормос залгагдах ба зогсоолын тоормосны индикатор асна.

Тоормосны дөрөө гишгэн арааны хөшүүргийг сэлгэнэ.

Арааны хөшүүргийг хэт хурдан хөдөлгөсөн үед автомат функц ажиллахгүй байж болно. Энэ нөхцөлд зогсоолын тоормосыг гар аргаар залгана.

Автомашин зогссон үед зогсоолын тоормосны товчийг дуут дохио дуугарч дэлгэц дээр **"EPB Shift Interlock Function Deactivated"** гарах хүртэл дарна. Автомат горим унтарна.

МЭДЭЭЛЭЛ

■ **Зогсоолын тоормосны ажиллагаа**

● Асаах товч ON горимд байхгүй үед зогсоолын тоормосны товчоор зогсоолын тоормос салгах боломжгүй.

● Асаах товч ON горимд байхгүй үед автомат горим (автоматаар тоормос залгах, салгах) ажиллахгүй.

Зогсоолын тоормос гар аргаар залгах/салгах (гар ажиллагааны горим)

Зогсоолын тоормосыг гар аргаар залгах, мөн салгах боломжтой.



1 Товчийг татаж зогсоолын тоормос залгана.

Зогсоолын тоормосны индикатор асна.

Жолоодлогын үед онцгой нөхцөл үүссэн ба зогсоолын тоормос ажиллуулах шаардлагатай үед товчийг удаан татна.

2 Товчийг дарж зогсоолын тоормос салгана.

● Тоормосны дөрөө гишгэнгээ зогсоолын тоормосны товч ажиллуулна.

● Зогсоолын тоормос автоматаар салгах функцаар хаазны дөрөө гишгэн зогсоолын тоормос салгах боломжтой.

Зогсоолын тоормос автоматаар салгах функц

Зогсоолын тоормосны индикатор болон зогсоолын тоормосны товчны индикатор унтарсан байгааг нягтлана.

Зогсоолын тоормосны индикатор анивчсан үед товчийг дахин ажиллуулна.

Гаражны хаалга нээгч, нээгчийн ажиллагаа*

HomeLink ашиглан гаражны хаалга нээгчийг®гаражны хаалга, зогсоол, хаалганы түгжээ, гэрийн гэрэлтүүлэг, дохиоллын систем болон бусад төхөөрөмжийг програмчлах боломжтой.

*:Тоноглогдсон автомашинд

Системийн эд анги

Таны автомашинд тоноглогдсон HomeLink® утасгүй удирдлагын систем нь 3 товчтой ба 3 өөр төхөөрөмж ажиллуулахаар програмчилж болно.

▶ Нүд гялбахаас сэргийлэх автомат голын тольтой автомашин



A HomeLink® индикатор
B Гаражны хаалганы ажиллагааны индикатор
C HomeLink® дүрст тэмдэг
HomeLink® ажиллах үед асна.
D Товч

▶ Дижитал голын тольтой автомашин



A HomeLink® лого
HomeLink® ажиллах үед гарна. Меню товч дарах үед HomeLink® ажиллаж байсан ч лого унтарна.
B Гаражны хаалганы ажиллагааны индикатор
C HomeLink® индикатор
Дээрх товчнуудыг сонгох үед асна.
D Товч

⚠ АЮУЛТАЙ

HomeLink®-г тухайн улсын аюулгүй байдлын стандартын шаардлага хангахгүй аливаа гаражны хаалга, төхөөрөмжтэй холбож ашиглахыг хориглоно. Ажиллагааны үед аливаа эд зүйл, объектыг мэдрэх функцгүй гаражын хаалга, төхөөрөмж нь дээрх ашиглахыг хориглосонд хамаарна. Тус функцгүй хаалга, төхөөрөмж нь амь нас, эрүүл мэндэд учруулах эрсдэлийг нэмэгдүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ **HomeLink®-н санах ойд хадгалагдсан кодууд**

- Санах ойд хадгалагдсан код нь автомашины аккумуляторыг салгасан үед ч хадгалагдан үлдэнэ.
- Өмнө нь код сануулсан HomeLink® товчинд шинэ код сануулахаар програмчлах үед алдаа гарвал өмнөх код устахгүй.

HomeLink®-г програмчлах (А төрлийн гаражны хаалга)

HomeLink®-г програмчлахын өмнө дараах үйлдлийг хийнэ:

- Програмчлах явцад гаражны хаалга, хаалт, эсвэл бусад төхөөрөмж ажиллаж магадгүй тул бэртэл гэмтэл, бусад болзошгүй хохирлоос сэргийлэх үүднээс эдгээр гаражны хаалга, хаалт, төхөөрөмжөөс аливаа хүн болон эд зүйл хол байгааг нягтлана.
- Програмчлалын илүү нарийвчлалтай хийхийн тулд системийн алсын удирдлаганы зайг шинээр солих нь зүйтэй.

  Дамжуулагчийн зайтай талыг HomeLink® товчны эсрэг харуулна.
- 1995 оноос хойш үйлдвэрлэгдсэн гаражны хаалга нээх зарим цахилгаан мотор нь алсын удирдлаганы дохионы давтамж хуулахаас сэргийлсэн дохиог кодчилох хамгаалалттай байдаг. Энэ нөхцөлд шат зэргийг ашиглан цахилгаан моторны “Learn” эсвэл “Smart” товчийг дарна.

⚠ АЮУЛТАЙ

- Гаражны хаалга, эсвэл бусад төхөөрөмж гэнэт ажиллах аюултай тул ойр орчимд байгаа хүн, аливаа эд зүйлийг аливаа бэртэл гэмтэл, эвдрэлээс сэргийлнэ.
- Бага насны хүүхдээр HomeLink® товч ажиллуулах, тоглуулахыг хориглоно.

1-р үйлдлээс 60 секундын дотор **3**-р үйлдлийг хийж дуусгана. Эсрэг тохиолдолд индикатор анивчих нь зогсох ба програмчлах үйлдэл цуцлагдана.

1 **Програмчлах гэж буй HomeLink® товчийг нэг дарж HomeLink® индикатор гэрэл шаргал өнгөөр анивчиж байгааг нягтлана.**

2 **Төхөөрөмжийн алсын удирдлагыг голын толины HomeLink® товч руу 25-75 мм (1-3 инч) зайнаас чиглүүлнэ .**

Програмчлах үедээ HomeLink® индикатор гэрэл харагдаж байгаа эсэхийг нягтлана.

▶ Автоматаар нүд гялбахаас сэргийлэх голын тольтой автомашин



▶ Дижитал голын тольтой автомашин



3 HomeLink® индикатор гэрэл шаргал өнгөөр удаан анивчих горимоос ногоон өнгөөр хурдан асах (нууцлалтай кодтой), эсвэл үргэлжилсэн ногоон (тогтмол кодтой) болох хүртэл алсын удирдлаганы товч дарна.

▶ Автоматаар нүд гялбахаас сэргийлэх голын тольтой автомашин



▶ Дижитал голын тольтой автомашин



4 HomeLink®-н ажиллагааг шинээр програмчилсан товчийг даран индикатор гэрлийн өнгөөр шалгана:

- HomeLink® индикатор асч байгаа: Төхөөрөмжийг тогтмол кодоор програмчилсныг илтгэнэ. HomeLink® товч дарах үед таны гаражны хаалга, хаалт ажиллана.
- HomeLink® индикатор хурдан анивчиж байгаа: Таны гараж-ны хаалганы цахилгаан мотор (эсвэл бусад төхөөрөмж) нууцлалтай кодтойг илтгэнэ. Энэ тохиолдолд тухайн програмчилсан HomeLink® товчийг 2 секунд удаан дарж суллахад програмчлал дуусна.
- Хэрэв гаражны хаалга, эсвэл бусад төхөөрөмж ажиллахгүй байвал Нууцлалтай кодтой системийг програмчлах(→X. 195)-г харна уу.

5 Дээрх үйлдлүүдийг үлдсэн HomeLink® товчуудад хийж болно.

HomeLink-г програмчлах® (B төрлийн гаражны хаалга*1)

HomeLink®-г програмчлахын өмнө дараах үйлдлийг хийнэ:

- Програмчлах явцад гаражны хаалга, хаалт, эсвэл бусад төхөөрөмж ажиллаж магадгүй тул бэртэл гэмтэл, бусад болзошгүй хохирлоос сэргийлэх үүднээс эдгээр гаражны хаалга, хаалт, төхөөрөмжөөс аливаа хүн болон эд зүйл хол байгааг нягтлана.
- Програмчлалын илүү нарийвчлалтай хийхийн тулд системийн алсын удирдлаганы зайг шинээр солих нь зүйтэй.

  Алсын удирдлаганы зайтай талыг HomeLink® товчны эсрэг тийш харуулна.
- 1995 оноос хойш үйлдвэрлэгдсэн гаражны хаалга нээх зарим цахилгаан мотор нь алсын удирдлаганы дохионы давтамж хуулахаас сэргийлсэн дохиог кодчилох хамгаалалттай байдаг. Энэ нөхцөлд шат зэргийг ашиглан цахилгаан моторны “Learn” эсвэл “Smart” товчийг дарна.

⚠ АЮУЛТАЙ

- Гаражны хаалга болон бусад төхөөрөмж ажиллаж болзошгүй тул санамсаргүй гэмтэл, эвдрэлээс сэргийлж ажилах хүрээнээс хүн, эд зүйлсийг гаргана.
- HomeLink® товчоор бага насны хүүхэд тоглуулж болохгүй.

1-р үйлдлээс **3**-р үйлдлийг 60 секундын дотор хийж дуусгана. Эсрэг тохиолдолд анивчиж буй индикатор унтарч програмчлах үйлдэл дуусна.

1 Програмчлах гэж буй HomeLink® товчийг нэг дарж HomeLink® индикатор гэрэл шаргал өнгөөр анивчиж байгааг нягтлана.

*1 : Хаалга програмчлах/HomeLink-г програмчлах®

2 Төхөөрөмжийн алсын удирдлагыг голын толины HomeLink® товч руу 25-75 мм (1-3 in.) зайнаас чиглүүлнэ.

Програмчлах үедээ HomeLink® индикатор гэрэл харагдаж байгаа эсэхийг нягтлана.

▶ Автоматаар нүд гялбахаас сэргийлсэн голын тольтой автомашин



▶ Дижитал голын тольтой автомашин



3 HomeLink® индикатор гэрэл шаргал өнгөөр удаан анивчих горимоос ногоон өнгөөр хурдан асах (нууцлалтай кодтой), эсвэл үргэлжилсэн ногоон (тогтмол кодтой) болох хүртэл алсын удирдлаганы товчийг 2 секундын зайтай үргэлжлүүлэн дарна.

4 HomeLink® ажиллагааг шинээр програмчилсан товчийг даран индикатор гэрлийн өнгөөр шалгана:

- HomeLink® индикатор асч байгаа: Төхөөрөмжийг тогтмол кодоор програмчилсныг илтгэнэ. HomeLink® товч дарах үед таны гаражны хаалга, хаалт ажиллана.
- HomeLink® индикатор хурдан анивчиж байгаа: Таны гаражны хаалганы цахилгаан мотор (эсвэл бусад төхөө-рөмж) нууцлалтай кодтойг илтгэнэ. Энэ тохиолдолд тухайн програмчилсан HomeLink® товчийг 2 секунд удаан дарж суллахад програмчлал дуусна.
- Хэрэв гаражны хаалга, эсвэл бусад төхөөрөмж ажиллахгүй байвал Нууцлалтай кодтой системийг програмчлах(→Х. 195)-г харна уу.

5 Дээрх үйлдлүүдийг үлдсэн HomeLink® товчуудад хийж болно.

Нууцлалтай кодтой системийг програмчлах

Тус системийг програмчлахад 2-с олон хүн шаардлагатай.

1 Гаражны хаалганы цахилгаан моторны “Learn”, эсвэл “Smart” товчийг олно.

Энэ товч нь төхөөрөмжний хүлээн авагч антенны ойр орчимд ихэвчлэн байдаг ба товчны байрлал, өнгө, нэршил нь үйлдвэрлэгчээс хамаарч өөр байж болно. Дэлгэрэнгүйг хаалганы цахилгаан моторны гарын авлаганаас харна уу.



2 “Learn”, эсвэл “Smart” товчийг нэг удаа дарна.

3-р үйлдлийг **2**-р үйлдлээс 30 секундын дотор хийнэ.



3 HomeLink® товчийг (автомашины бүхээгний) 2 секунд дарна. Энэ үйлдлийг (дарах/дараад барих/суллах) 3 удаа хийхэд програмчлал дуусна.

HomeLink® товч дарах үед хаалганы цахилгаан мотор ажиллаж байвал мотор HomeLink®-н сигналыг таниж байгаа гэж үзнэ.

▶ Автоматаар нүд гялбахаас сэргийлсэн голын тольтой автомашин



▶ Дижитал голын тольтой автомашин



Гаражны хаалга болон систем харилцан сигнал солилцох

Гаражны хаалга болон системийг харилцан сигнал солилцох тохиргоо хийснээр гаражны хаалга нээгдсэн, эсвэл хаалттай байгааг автомашины индикатороор мэдэх боломжтой болно.

Энэ тохиргоо нь зөвхөн тохирох төхөөрөмжтэй ажиллана.

Төхөөрөмжийн мэдээллийг www.HomeLink.com-с харна уу.

Гаражны хаалга болон систем харилцан сигнал солилцох

1 **Гаражны хаалганы цахилгаан мотор нь HomeLink® системтэй холбогддог бол гаражны хаалга нээгчийг програмчилж дууссанаас 5 секундын дотор гаражны хаалга нээгчийн индикатор ногоон өнгөөр хурдан анивчих, мөн индикатор 2 удаа анивчина.**

Хэрэв индикатор анивчихгүй байвал **2** ба **3**-р үйлдлийг давтаад HomeLink®товчийг програмчлал дууссанаас хойш 10 удаа дарна.

2 **Сонгосон HomeLink® товчийг дарж гаражны хаалгыг ажиллуулна.**

3 **Гаражны хаалганы ажиллагаа зогссоны дараа HomeLink® товч дарах ба 1 минутын дотор гаражын хаалганы цахилгаан моторны “Learn”, эсвэл “Smart” товч дарна.**

Гаражны хаалга болон систем харилцан сигнал солилцох тохиргоо хийгдсэнээс 5 секундын дотор гаражны хаалга нээгчийн индикатор ногоон өнгөөр хурдан анивчих, мөн гаражны хаалганы моторын индикатор 2 удаа анивчин харилцан мэдээлэл солилцох тохиргоо хийгдсэнийг илтгэнэ.

HomeLink ажиллуулах®

Тус функц нь зөвхөн тохирох төхөөрөмжтэй ажиллана.
Төхөөрөмжийн мэдээллийг www.HomeLink.com-с харна уу.

▶ **Автоматаар нүд гялбахаас сэргийлэх голын тольтой автомашин**



A Нээх
B Хаах

▶ Дижитал голын тольтой автомашин



A Нээх
B Хаах

Зохих HomeLink® товчийг ажиллуулна.

HomeLink® индикатор асна. Гаражны хаалганы нээгдэх, хаагдах явц индикатор дээр дараах байдлаар харагдана.

- Шаргал (анивчих): Нээж/хааж байгаа
- Ногоон: Нээж/хааж дууссан
- Улаан (анивчих): Хариу дохио ирээгүй

МЭДЭЭЛЭЛ

- Индикатор гаражнаас ойролцоогоор 250 м (820 фут) зайнд ажиллах боломжтой. Нөгөөтэйгүүр, автомашин болон гаражны хаалганы хооронд байшин, мод зэрэг саад байгаа тохиолдолд хариу дохиог хүлээн авч чадахгүй байж болно.
- Хаалганы өмнөх байдлын дохиог дахин дуудахын тулд аль нэг HomeLink® товчийг ба , эсвэл ба (автоматаар нүд гялбахаас сэргийлэх голын тольтой автомашин), ба , эсвэл ба (дижитал голын тольтой автомашин) товчтой нэг удаа зэрэг дарна.

  Энэ үед систем хамгийн сүүлд санасан хаалганы байдлыг 3 секундын хугацаанд харуулна.

HomeLink-г дахин програмчлах®

Дараах үйлдлийг хийж өмнө нь төхөөрөмж бүртгүүлсэн товчны тохиргоо дээр шинээр бүртгэх боломжтой:

1. **Тохиргоо хийх HomeLink® товч дээр дарна.**
2. **HomeLink® индикатор шаргал өнгөөр анивчих үед HomeLink® товчийг суллана.**
3. **Тохиргоо хийх HomeLink® товчийг удаан дарж HomeLink® индикатор шаргал өнгөөр анивчиж байгааг нягтлана.**

   HomeLink® анивчих хүртэл 20 секунд шаардагдана.

HomeLink®-н санах ойг бүрэн устгах

Автомашинаа зарах үед HomeLink®-д бүртгэсэн кодыг устгана.

HomeLink®-н 2 захын товчийг 10 секунд удаан дарна. HomeLink® индикатор шаргал өнгөөр үргэлжлэн асахаас ногоон өнгөөр хурдан анивчих горимд шилжсэнийг нягтлана.

Санах ойд бүртгэгдсэн бүх код устгагдана.

▶ **Нүд гялбахаас сэргийлэх автомат голын тольтой автомашин**



▶ **Дижитал голын тольтой автомашин**



Шатахуун цэнэглэх

Шатахууны савны тог онгойлгох

1 **Шатахууны сав нээгч товч дарна.**

Шатахууны савны таг нээгдэнэ.



2 **Тагийг зөөлөн эргүүлж аваад суурин дээр тогтооно.**



⚠ АЮУЛТАЙ

Таг тайлах бүрт тагны гараар барих хэсгээс сайн бариж зөөлөн эргүүлнэ. Шатахууны савны таг суллах үед исгэрэх дуу гарч болно. Тагийг бүрэн авахаас өмнө дуу зогсох хүртэл хүлээнэ. Цаг агаар халуун үед даралттай шатахуун цацагдаж бэртэл гэмтэл учруулах аюултай.

Шатахуун цэнэглэх үеийн анхааруулга

Тохирох төрлийн шатахуун сонгож аюулгүйгээр цэнэглэнэ.

⚠ АЮУЛТАЙ

Шатахуун цэнэглэх үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Автомашинаас бууж шатахууны савны таг нээхээс өмнө будаггүй металл гадаргууд хүрч статик гүйдлийг цэнэггүйжүүлнэ.

  Биенд хуримтлагдсан статик гүйдлээ цэнэггүйжүүлээгүй аливаа хүнийг нээлттэй шатахууны саванд ойртуулахыг хориглоно.

  Шатахууны ууранд статик цэнэгээс үүссэн оч гал авалцах аюултай.
- Ууршсан шатахуунаар амьсгалахыг хориглоно. Амьсгалсан тохиолдолд хүний биед хортой нэгдлүүдийг шатахуун агуулдаг.

⚠ АЮУЛТАЙ

- Шатахуун цэнэглэх үед тамхи татахыг хориглоно. Шатахуунд гал авалцаж гал түймэр үүсэх аюултай.
- Автомашинд буцаж суух, эсвэл бусад хүн болон статик гүйдэл хуримтлагдсан байж болзошгүй эд зүйлсэд хүрэхийг хориглоно. Эдгээр үйлдэл нь статик гүйдлийн цэнэг хуримтлагдах, улмаар оч үсэрч гал авалцах аюултай.
- Түгээгүүрийн хошууг шатахууны саванд гүйцэд шургуулна.
- Хошуу автоматаар буух үед шатахуун цэнэглэлтийг зогсооно.
- Шатахууны сав дүүрсэн үед нэмж хийхийг хориглоно.

⚠ АНХААР

Шатахуун цэнэглэх үед шатахуун асгахыг хориглоно. Хаягдал утааны системийн хэвийн ажиллагаа алдагдах, шатахууны системийн эд ангиудыг гэмтээх, мөн автомашины будагтай арьс гэмтээх зэргээр сөрөг нөлөө үзүүлэх аюултай.

МЭДЭЭЛЭЛ

■ Хар тугалгагүй бензинд зориулсан шатахууны савны амсар

Буруу шатахуунаар цэнэглэхээс сэргийлж Lexus автомашины шатахууны савны амсар нь зөвхөн хар тугалгагүй бензиний тусгай хошуу орох зориулалт бүхий хийцтэй байдаг.

Шатахууны савны таг хаах

Шатахуун цэнэглэж дууссаны дараа тагийг чаг хийж дуугарах хүртэл эргүүлнэ.

Тагнаас гараа авах үед таг эсрэг чиглэлд бага зэрэг буцна.



⚠ АЮУЛТАЙ

Зөвхөн тухайн загварын автомашинд зориулагдсан Lexus-н оригинал шатахууны савны таг ашиглана. Эсрэг тохиолдолд галын аюул үүсгэх аюултай.

3 Нөхцөл байдалд нийцүүлэн жолоодох

3-1. Харанхуй орчинд жолоодох

Их гэрэл ашиглах 204

Холын гэрэл болон ойрын гэрлийн хооронд автоматаар шилжүүлэх.. 209

3-2. Нар, бусад автомашины их гэрэл хүчтэй тусах үед жолоодох

Нарны хаалт ашиглах..... 217

Голын толины нүд гялбахаас сэргийлэх функц (автоматаар нүд гялбахаас сэргийлэх голын тольтой автомашин)..... 218

Дижитал голын толины нүд гялбалтаас сэргийлэх функц (оптик толины горим)..... 219

3-3. Бороотой үеийн жолоодлого

Бороотой үеийн жолоодлогын анхааруулга..... 220

Бороотой үеийн харагдах байдлыг хангах..... 221

3-4. Цонх, эсвэл толь цантсан үед жолоодлого хийх

Салхины шилний цан арилгах..... 227

Хойд цонхны цан арилгах229

Хажуугийн толины цан арилгах..... 230

3-5. Хүйтэн үед автомашин жолоодох

Хүйтний улиралд бэлдэх.. 231

Өвлийн жолоодлого 234

3-6. Манан дундуур, эсвэл үзэгдэх орчин муутай уулын замаар явах

Манангийн гэрэл ашиглах..... 236

Дуут дохио дуугаргах..... 238

3-7. Utility төрлийн автомашины анхааруулга

Utility төрлийн автомашины анхааруулга..... 239

3-8. Жолоодлогын онцлогыг өөрчлөх

Жолоодлогын горим..... 242

Жолоодлогын горим солих..... 244

Trail горим (AWD автомашин)..... 246

DAC уруу замд туслах удирдлагын систем..... 248

3-9. Тоормос баригч систем

Тоормос баригч систем.... 250

Их гэрэл ашиглах

Их гэрлийг гар аргаар болон автоматаар ажиллуулах боломжтой.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

Их гэрэл асаах, унтраах

Хөдөлгүүр унтраастай үед гэрэл шаардлагатай хэмжээнээс удаан асааж болохгүй. Аккумуляторын цэнэг сууна.

товч ажиллуулах үед гэрэл дараах байдлаар асна:

▶ **А төрөл**



1 Урд оврын, оврын, дугаарын болон хянах самбарын гэрэл асна.

2 Их гэрэл болон дээрх бүх гэрэл асна.

3 AUTO Их гэрэл, өдрийн хөдөлгөөний гэрэл болон дээрх бүх гэрэл автоматаар асч унтарна.

▶ B төрөл



1 Урд оврын, оврын, дугаарын болон хянах самбарын гэрэл асна.

2 Их гэрэл болон дээрх бүх гэрэл асна.

3 AUTO Их гэрэл, өдрийн хөдөлгөөний гэрэл болон дээрх бүх гэрэл автоматаар асч унтарна.

4 Өдрийн хөдөлгөөний гэрэл асна.

МЭДЭЭЛЭЛ

Auto горим ашиглах боломжтой нөхцлүүд

Power товч ON горимд байгаа.

Өдрийн хөдөлгөөний гэрэл

Өдрийн цагаар бусад жолоочид өөрийн автомашины харагдах байдлыг нэмэгдүүлэх үүднээс хөдөлгүүр асааж зогсоолын тоормос салгасан ба их гэрлийн асаагуурын (зөвхөн B төрөл), эсвэл AUTO байрлалд тус гэрэл автоматаар асна. (Урд оврын гэрлээс тод асна.) Өдрийн хөдөлгөөний гэрэл нь шөнийн цагаар ашиглах зориулалтгүй болно.

Их гэрлийн удирдлагын мэдрэгч

Мэдрэгч аливаа зүйл тависан, эсвэл мэдрэгчийг халхлах зүйл салхины шилэнд тогтсон үед мэдрэгчийн хэвийн ажиллагаа алдагдаж болно. Энэ нөхцөлд мэдрэгч орчны гэрлийн түвшинг мэдрэхэд саад учруулах ба автомат их гэрлийн системийг доголдуулна.



Автоматаар гэрэл унтраах систем

● A төрөл

Их гэрэл болон бүх гэрэл асаах товчийг унтраах үед унтарна. Гэрлүүдийг дахин асаах үед асаах товчийг ON-д буцаах, эсвэл гэрэл асаах товчийг AUTO байрлалд шилжүүлээд, эсвэл байрлалд буцаана.

● В төрөл

- Гэрлийн товч , эсвэл байрлалд байгаа үед:

  Их гэрэл болон урд манангийн гэрэл* автоматаар асаах товч унтраах үед унтарна.

- Гэрлийн товч AUTO байрлалд байгаа үед:

  Их гэрэл болон бүх гэрэл автоматаар асаах товч унтраах үед унтарна.

Гэрлүүдийг дахин асаах үе асаах товч ON-д буцаах, эсвэл гэрлийн товчийг AUTO байрлалд шилжүүлээд, эсвэл -д буцаана.

■ **Гэрэл сануулах дуут дохио**

Асаах товчийг OFF, эсвэл ACC горимд шилжүүлээд гэрэл асаалттай үед жолоочийн хаалга нээхэд дуут дохио дуугарна.

■ **Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх функц**

● А төрөл

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж асаах товчны OFF горимд гэрэл асаах товч , эсвэл AUTO байрлалд байгаа үед аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх функц 20 минутын дараа бүх гэрлийг унтраана. Асаах товчийг ON горимд шилжүүлэх үед тус функц цуцлагдана.

Дараах аль нэг үйлдлийг хийх үед аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх функцийн ажиллагаа цуцлагдаад дахин идэвхжинэ. Функц дахин идэвхижсэнээс 20 минутын дараа бүх гэрэл унтарна:

- Их гэрлийн асаагуур ажиллуулсан
- Хаалга, эсвэл тээшний хаалга нээсэн, эсвэл хаасан

● В төрөл

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж асаах товчны OFF горимд их гэрэл, оврын гэрэл асаалттай үед аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх функц 20 минутын дараа бүх гэрлийг унтраана. Асаах товчийг ON горимд шилжүүлэх үед тус функц цуцлагдана.

Дараах аль нэг үйлдлийг хийх үед аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх функцийн ажиллагаа цуцлагдаад дахин идэвхжинэ. Функц дахин идэвхижсэнээс 20 минутын дараа бүх гэрэл унтарна:

- Их гэрлийн асаагуур ажиллуулсан

*:Тоноглогдсон автомашинд

- Хаалга нээсэн, эсвэл хаасан

Холын гэрэл асаах



1 Их гэрэл асаалттай үед хөшүүргийг урагш түлхэнэ.

Холын гэрэл асна.

Хөшүүргийг анхны байрлалд буцааж холын гэрэл унтраана.

2 Хөшүүргийг нааш татаад суллана.

Холын гэрэл 1 удаа анивчина.

Их гэрэл унтраастай үед ч энэ аргаар холын гэрэл асаах боломжтой.

Их гэрэл үргэлжлэн асах*

Тус систем нь асаах товчийг OFF горимд шилжүүлсэн үед их гэрлийг 30 секунд үргэлжлүүлэн асаадаг.

Асаах товчийг OFF горимд унтраасны дараа их гэрлийн AUTO байрлалд хөшүүргийг нааш татаад суллана.

Хөшүүргийг дахин нааш татаад суллах үед тус системийн ажиллагаа цуцлагдана.



Эргэх дохионы нэмэлт гэрлийн ажиллагаа

Их гэрэл (ойрын гэрэл) асаалттай ба дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед эргэх дохионы нэмэлт гэрэл асч эргэх чиглэлийг заана. Тус гэрэл нь уулзвар, эсвэл шөнийн жолоодлогын үед автомашины харагдах байдлыг нэмэгдүүлнэ.

- Жолооны хүрд эргүүлсэн
- Эргэх дохионы хөшүүргийг түлхсэн
- Арааны хөшүүрэг R байрлалд байгаа

МЭДЭЭЛЭЛ

Эргэх дохионы нэмэлт гэрлийн удирдлага

- Эргэх дохионы нэмэлт гэрэл нь автомашины хурд 35 км/ц (22 миль/ц)-с их үед асахгүй.

*: Тоноглогдсон автомашинд

● Асаалттай хэвээр байгаа үед 30 минут гэрэл автоматаар унтарна.

Автомат их гэрлийн түвшин тохируулах системийн ажиллагаа

Зорчигчдын тоо, ачаа тээшинд тохируулан их гэрлийн түвшинг бусад жолоочид саад учруулахгүй байдлаар автоматаар тохируулна.

Холын гэрэл болон ойрын гэрлийн хооронд автоматаар шилжүүлэх

AHS холын гэрлийн систем

AHS холын гэрэл нь салхины шилний дээд хэсгийн дотор талд байрлах урд камераар замын гэрэлтүүлэг, орчны болон зөрж өнгөрч буй автомашин зэргийн гэрлийг мэдэрдэг ба шаардлагатай үед их гэрлийн тусгалыг автоматаар хуваарилдаг.

⚠ АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

AHS холын гэрлийн системд хэт найдаж болохгүй. Замын хөдөлгөөнд хөдөлгөөний аюулгүй байдлыг цаг ямагт хангаж оролцох ба ойр орчмын нөхцөл байдлаа сайтар анхаарч шаардлагатай тохиолдолд их гэрлийг гар аргаар асаах буюу унтраана.

■ AHS холын гэрлийг санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх

Систем цуцлах шаардлагатай нөхцлүүд: → X.350

Системийн удирдлага

- Автомашины хурдаас хамаарч холын гэрлийн хүч, тусах талбай тохируулална.
- Эргэлт дээр эргэж буй талын зам илүү тод байхаар холын гэрлийн тусгал, эргэлтийг тохируулна.
- Урд талын автомашин байгаа хэсэгт хэсэгчлэн их гэрэл тусахгүй, бусад хэсэгт их гэрэл тусах байдлаар тохируулна

  Тус гэрэл нь урд талын автомашины жолоочийн нүд гялбахаас сэргийлэн гэрэл жолоочид харагдах байдлыг нэмэгдүүлнэ.



A Холын гэрэл тусч буй талбай
B Ойрын гэрэл тусч буй талбай

- Урд талд явж буй автомашин хүртэлх зайнд тохируулан ойрын гэрэл тусах зайг тааруулна.

AHS холын гэрэл ашиглах

1 AHS холын гэрлийн товч дарна.



2 Их гэрлийг [AUTO], эсвэл [ ] байрлалд шилжүүлнэ.

Их гэрлийн хөшүүрэг ойрын гэрлийн байрлалд байгаа үед AHS систем идэвхжиж AHS индикатор асна.



МЭДЭЭЛЭЛ

Систем ажиллах нөхцөл

- Дараах бүх нөхцөл бүрдсэн үед холын гэрэл асч систем ажиллана:
  - Автомашины хурд 15 км/ц (9 миль/ц)-с их*.*1
  - Автомашины урд тал харанхуй.
- Дараах бүх нөхцөл бүрдсэн үед урд талд байгаа автомашины байрлалаас хамаарч их гэрэл хэсэгчлэн асна:
  - Автомашины хурд 15 км/ц (9 миль/ц)-с их.
  - Автомашины урд тал харанхуй.
  - Урд талд байгаа автомашин гэрлээ асаасан.
  - Замын гэрэлтүүлэг, эсвэл урд зам дээр бусад гэрэл багатай.
- Дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед систем ойрын гэрэлд шилжинэ:
  - Автомашины хурд 12 км/ц (7.5 миль/ц)-с бага.
  - Автомашины урд тал харанхуй биш.
  - Урд талд олон автомашин байгаа.
  - Урд тал замын гэрэлтүүлэг болон бусад гэрэл ихтэй.

*1 : Эргэлттэй замаар 30 км/ц (19 миль/ц)-с дээш хурдаар явах үед эргэж буй тал руу илүү тод тусна.

■ **Урд камерын ажиллагаа**

- Дараах нөхцөлд их гэрэл автоматаар AHS горимд шилжихгүй байх магадлалтай:
  - Урд талд өөр автомашин хажуу талаас огцом орж ирсэн үед
  - Өөр автомашин таны урдуур хөндлөн гарах үед
  - Замын эгнээ тусгаарлагч, зам дагуух мод, мөн замын дараалсан эргэлт зэргээс шалтгаалж урд талын автомашин олон удаа мэдрэгдээд болих үед
  - Өргөн зам дээр эсрэг чиглэлийн автомашин холуур зөрж өнгөрөх үед
  - Автомашин хол байгаа үед
  - Урд талын автомашин гэрлээ асаагаагүй үед
  - Урд талын автомашины гэрэл бүдэг үед
  - Таны автомашины их гэрэл зэрэг хүчтэй гэрлийг урд талын автомашин ойлгож байгаа үед
  - Мэдрэгч хэвийн ажиллахгүй байх нөхцлүүд: → X.354
- Урд талын автомашин их гэрлээ асаагаагүй ба манангийн гэрлээ асаасан үед холын гэрэл AHS горимоор асч болно.
- Айлын гэрэл, замын гэрэл, гэрлэн дохио, гэрэлтэй самбар болон бусад гэрэл ойлгох объектоос шалтгаалж холын гэрэл AHS горимд шилжих, эсвэл шилжихгүй байж болно.
- Дараах нь AHS горимд шилжих хурд, эсвэл ойрын гэрэлд шилжих хугацааг өөрчилж болно:
  - Урд талын автомашины их гэрлийн гэрлийн түвшин
  - Урд талын автомашины хөдөлгөөн ба чиглэл
  - Урд талын автомашин хүртэлх зай
  - Урд талд байгаа автомашин зөвхөн нэг талдаа гэрэлтэй
  - Урд талд 2 дугуйтай тээврийн хэрэгсэл байгаа
  - Замын нөхцөл байдал (хэвгий, эргэлт, замын гадаргуугын байдал зэрэг)
  - Зорчигчдын тоо, ачаа тээшний хэмжээ
- Холын гэрлийн тусгалын хуваарилалт нь жолоочийн тооцоолоогүй, урьдчилан таамаглаагүй үед асах буюу унтрах магадлалтай.
- Унадаг дугуй, мөн түүнтэй адил зүйлс мэдрэгчид танигдахгүй байх магадлалтай.
- Дараах нөхцлүүдэд орчны гэрлийн түвшинг систем нарийн тогтооход хүндрэлтэй байх магадлалтай. Энэ тохиолдолд холын гэрэл рүү шилжихгүй байх, эсвэл холын гэрэл явган зорчигч, бусад тээврийн

хэрэгсэл болон бусдад хүндрэл учруулж болзошгүй. Энэ нөхцөлд холын болон ойрын гэрлийн хооронд гар аргаар шилжүүлнэ.

- Ойр орчимд автомашины их гэрэл, арын гэрэл, манангийн гэрэлтэй төстэй гэрэл байгаа үед
- Урд талын автомашины их гэрэл, оврын гэрэл унтраастай, бохирдсон, өнгө нь өөрчлөгдсөн, тусгал алдагдсан үед
- Их гэрлийг ойр ойрхон холын болон ойрын гэрэл солиж байгаа үед.
- Холын гэрэл ашиглах нь тохиромжгүй, эсвэл холын гэрэл нь явган зорчигч, бусад жолоочийн нүд гялбуулах үед.
- Баруун гарын замын хөдөлгөөнтэй улс оронд зориулагдсан автомашиныг зүүн гарын замын хөдөлгөөнтэй улсад ашиглах зэргээр автомашиныг анх нийлүүлснээс эсрэг замын хөдөлгөөнтэй улс оронд ашигласан үед
- Системийг цуцлах шаардлагатай нөхцөл: → Х.350
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд: → Х.354

■ **Өөрчлөх боломжтой тохиргоо**

Зарим функцийн тохиргоог өөрчлөх боломжтой. → Х.685

Холын гэрэл гар аргаар асаах/унтраах

■ **Холын гэрэлд шилжүүлэх**

● **Хөшүүргийг урагш түлхэнэ.**



AHS индикатор унтарч их гэрлийн индикатор асна.

AHS холын гэрлийг дахин идэвхжүүлэх үед хөшүүргийг анхны байрлалд буцаана.

■ **Ойрын гэрэлд шилжүүлэх**

● **AHS системийн товч дарна.**



AHS индикатор унтарна.

Товч дахин дарж AHS системийг идэвхжүүлнэ.

Ойрын гэрэлд түр шилжүүлэх

Холын гэрэл ашиглах нь тохиромжгүй үед, эсвэл холын гэрэл нь бусад жолооч, ойр орчмын явган зорчигчид хүндрэл, төвөг учруулах үед ойрын гэрэл ашиглах нь тохиромжтой.

● **Хөшүүргийг арагш татсаны дараа анхны байрлалд буцаана.**



Хөшүүргийг нааш татах хугацаанд холын гэрэл асах ба хөшүүрэг анхны байрлалд буцах үед ойрын гэрэл тодорхой хугацаанд асна. Үүний дараа AHS (Adaptive High-beam System) систем ажиллана.

AHB автомат холын гэрэл

Автомат холын гэрэл нь салхины шилний дээд талд байрлах урд камер ашиглан урд талын автомашин, замын гэрэлтүүлэг зэргийн гэрлийн түвшинг мэдэрдэг ба их гэрлийг холын болон ойрын гэрэлд автоматаар шилжүүлдэг.

⚠ АЮУЛТАЙ

■ **Ашиглалтын аюулгүй байдал**

Автомат холын гэрэлд хэт найдаж болохгүй. Ойр орчмоо нягтлан холын гэрлийг шаардлагатай нөхцөлд гараар асааж унтраан цаг ямагт аюулгүй жолоодлого хийнэ.

■ **AHS их гэрлийг санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх**

Системийг цуцлах шаардлагатай нөхцлүүд: → X.350

Автомат холын гэрлийн систем ашиглах

1 **Автомат холын гэрлийн товч дарна.**



2 Их гэрлийн асаагуурыг [AUTO], эсвэл [] байрлалд шилжүүлнэ.

Их гэрлийн хөшүүрэг ойрын гэрлийн байрлалд байгаа үед AHS систем идэвхжих ба AHB индикатор асна.



МЭДЭЭЛЭЛ

■ Холын гэрэл автоматаар асах нөхцөл

● Дараах бүх нөхцөл бүрдсэн үед холын гэрэл автоматаар асна:
- Автомашины хурд 34 км/ц (21 миль/ц)-с их.
- Автомашины урд тал харанхуй байгаа.
- Гэрлээ асаасан автомашин урд талд байхгүй байгаа.
- Урд талын зам дээр замын гэрэлтүүлэг болон бусад гэрэл багатай.

● Дараах аль нэг нөхцөлд их гэрэл ойрын гэрэлд автоматаар шилжинэ:
- Автомашины хурд 25 км/ц (16 миль/ц)-с буурсан.
- Автомашины урд тал харанхуй биш.
- Гэрлээ асаасан автомашин урд талд байгаа.
- Урд зам нь замын гэрэлтүүлэг, бусад гэрэл ихтэй.

■ Урд камераар мэдрэх

● Дараах нөхцлүүдэд их гэрэл автоматаар ойрын гэрэлд шилжихгүй байж болно:
- Таны урдуур огцом автомашин орж ирэх үед
- Автомашины урдуур бусад автомашин хөндлөн гарсан үед
- Үргэлжилсэн эргэлттэй зам, замын урсгал тусгаарлах хаалт, замын хажуугийн мод зэргээс шалтгаалж урд талын автомашин олон дахин мэдрэгдээд алга болох үед
- Эсрэг чиглэлийн автомашин олон эгнээний зайтай үед
- Урд талын автомашин хол үед
- Урд талын автомашин гэрлээ асаагаагүй үед
- Урд талын автомашины гэрэл бүдэг үед
- Урд талын автомашинаас таны автомашины гэрэл зэрэг хүчтэй гэрэл буцаж ойж байгаа үед
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцлүүд: → X.354

● Урд талын автомашин их гэрлээ асаалгүйгээр манангийн гэрлээ асаасан үед их гэрэл ойрын гэрэлд шилжиж болно.

- Гэрийн гэрэл, гудамжны гэрэл, гэрлэн дохио, гэрэлтэй самбар зэргээс шалтгаалж холын гэрлээс ойрын гэрэлд шилжиж болно.
- Дараах зүйлс нь холын гэрлээс ойрын гэрэлд шилжих хугацааг өөрчилж болно:
  - Урд талын автомашины гэрлийн түвшин
  - Урд талын автомашины хөдөлгөөн болон чиглэл
  - Урд талын автомашин хүртэлх зай
  - Урд талын автомашины зөвхөн нэг талын гэрэл ассан үед
  - Урд талд 2 дугуйтай тээврийн хэрэгсэл байгаа үед
  - Замын нөхцөл байдал (хэвгий, эргэлт, замын гадаргуугийн байдал зэрэг)
  - Зорчигчдын тоо, ачаа тээш
- Их гэрэл нь гэнэт холын болон ойрын гэрлийн хооронд солигдож болно.
- Унадаг дугуй, мөн бусад жижиг тээврийн хэрэгсэл танигдахгүй байж болно.
- Дараах нөхцлүүдэд мэдрэгч орчны гэрлийн хэмжээг зөв мэдрэхгүй байж болно. Ингэснээр ойрын гэрэл үргэлжлэн асах, эсвэл холын гэрэл анивчих, явган зорчигч болон бусад жолоочийн нүд гялбуулахад хүргэж болно. Энэ нөхцөлд холын болон ойрын гэрлийн хооронд гараар шилжүүлнэ.
  - Автомашины их гэрэл, арын гэрэлтэй төстэй гэрэл ойр орчимд байгаа үед
  - Урд талын автомашины их гэрэл, арын гэрэл унтраастай, бохирдсон, өнгө өөрчлөгдсөн, эсвэл тусгал алдагдсан үед
  - Холын болон ойрын гэрлийн хооронд ойр ойрхон, хэвийн бус байдлаар шилжүүлсэн үед.
  - Холын гэрэл ашиглах нь тохиромжгүй нөхцөлд, эсвэл холын гэрэл явган зорчигч, бусад жолоочийн нүд гялбуулж байгаа үед.
  - Тухайн автомашиныг анх нийлүүлэгдсэн улсаас замын хөдөлгөөний эсрэг урсгалтай бусад улс оронд, жишээлбэл замын хөдөлгөөний баруун гарын дүрэмтэй улсад зориулагдсан автомашиныг зүүн гарын дүрэмтэй улсад, эсвэл эсрэгээр ашиглах үед
  - Системийн ажиллагааг цуцлах шаардлагатай нөхцлүүд: → Х.350
  - Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцлүүд: → Х.354

Холын гэрлийг гараар асаах, унтраах

■ Холын гэрэлд шилжүүлэх

● Хөшүүргийг урагш түлхэнэ.



Автомат холын гэрлийн индикатор унтарч холын гэрлийн индикатор асна.

Хөшүүргийг анхны байрлалд татаж автомат холын гэрлийн системийг дахин идэвхжүүлнэ.

■ Ойрын гэрэлд шилжүүлэх

● Автомат холын гэрлийн товч дарна.



Автомат холын гэрлийн индикатор унтарна.

Товч дахин дарж автомат холын гэрлийг идэвхжүүлнэ.

Ойрын гэрэлд түр шилжүүлэх

Холын гэрэл ашиглах нь тохиромжгүй, эсвэл холын гэрэл нь бусад жолооч, явган зорчигчид хүндрэл учруулж болзошгүй үед ойрын гэрэлд шилжүүлэхийг зөвлөж байна.

● Хөшүүргийг арагш татаад анхны байрлалд буцаана.



Хөшүүргийг татах хугацаанд холын гэрэл асах ба анхны байрлалд буцаах үед ойрын гэрэл тодорхой хугацаанд асна. Үргэлжлээд автомат холын гэрлийн систем ажиллана.

Нарны хаалт ашиглах



1 Нарны хаалтыг доош буулгана.
2 Нарны хаалтыг доош буулган дэгээнээс салгаад хажуу тийш эргүүлнэ.

Голын толины нүд гялбахаас сэргийлэх функц (автоматаар нүд гялбахаас сэргийлэх голын тольтой автомашин)

Хойд талын автомашины их гэрлийн хэмжээнд нийцүүлэн толинд ойсон гэрлийг автоматаар бууруулна.

Асаах товчийг ON горимд шилжүүлэх бүрт тус функц асна.

МЭДЭЭЛЭЛ

Голын толины автоматаар нүд гялбахаас сэргийлэх функцийг автомат горимд тохируулсан үед голын толины ажиллагаатай уялдан хажуугийн толь мөн ойсон гэрлийг бууруулна.

Товч дарж автоматаар нүд гялбахаас сэргийлэх функцийг асаана/унтраана

Автоматаар нүд гялбахаас сэргийлэх функц асаалттай үед A индикатор асна.

Товч дахин дарах үед функц унтарна. (A индикатор мөн унтарна.)



МЭДЭЭЛЭЛ

■ Мэдрэгчийн доголдлоос сэргийлэх

Мэдрэгчид хүрэх, халхлаж болохгүй. Мэдрэгчид доголдол учруулж болзошгүй.



Дижитал голын толины нүд гялбалтаас сэргийлэх функц (оптик толины горим)

Оптик толины горимын автомат нүд гялбалтаас сэргийлэх функцийг идэвхжүүлэх/цуцлах боломжтой.

Асаах товчийг ON горимд асаах үед автомат нүд гялбалтаас сэргийлэх функц автоматаар идэвхжинэ.

1 Меню товчийг дарна.

Тохиргооны дэлгэц гарна.

2 Меню товчийг давтан дарж -г сонгоно.

Тохиргооны дэлгэц гарна.



3 [ ], эсвэл [ ]-г дарж автомат нүд гялбахаас сэргийлэх функцийг идэвхжүүлэх (ON)/цуцлах (OFF) тохиргоо хийнэ.

Товчийг 5-с дээш секунд дараагүй үед тэмдэг дэлгэц дээр унтарна.

Бороотой үеийн жолоодлогын анхааруулга

Бороотой үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Бороотой үед үзэгдэх орчин буурах ба цонх цантах, зам хальтиргаатай болох тул өндөр анхааралтай жолоодно.
- Бороо орж эхлэх үед зам илүү хальтиргаатай байдаг тул өндөр анхааралтай жолоодно.
- Замын гадаргуу болон дугуйн завсар усан давхарга үүсч жолоодлого, тоормос гүйцэд ажиллахгүй байдалд хүрч болзошгүй тул бороотой үед өндөр хурдтай жолоодохоос зайлсхийнэ.

Бороотой үеийн харагдах байдлыг хангах

Шил арчигчийн хөшүүрэг ашиглан арчигчийн ажиллагааг автомат болон гар ажиллагаанд тохируулах, мөн шил угаагч ажиллуулна.

Урд шил арчигч ашиглах

⚠ АЮУЛТАЙ

Бороо мэдрэгчтэй шил арчигчтай автомашин:

Гар хуруу зэргээ шил арчигчинд хавчуулахаас сэргийлнэ.

AUTO горимд сонгогдсон үед мэдрэгчид хүрсэн, эсвэл салхины шил доргилтод өртөх үед шил арчигч гэнэт ажиллаж болзошгүй.

⚠ АНХААР

Урд шил арчигч ашиглах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Хөдөлгүүр унтраастай үед шил арчигчийг шаардлагатай хэмжээнээс удаан ашиглаж болохгүй. Аккумуляторын цэнэг суух аюултай.
- Салхины шилийг гэмтээх тул салхины шил хуурай үед шил арчигч ажиллуулж болохгүй.

хөшүүргийг ажиллуулах үед шил арчигч, угаагч дараах байдлаар ажиллана.

■ Ажиллах давтамжийг тохируулдаг тасалдсан горимтой шил арчигч*



1 ○ Off
2 Тасалдсан горим
3 ▼ Удаан
4 ▼▼ Хурдан
5 △ Нэг удаа арчих

* : Тоноглогдсон автомашинд

■ Бороо мэдрэгчтэй шил арчигч*



1 ○ Off

2 AUTO Бороо мэдрэгчийн ажиллагаа

Мэдрэгч бороо мэдрэх үед шил арчигч автоматаар ажиллана. Борооны хэмжээ болон автомашины хурдад нийцүүлэн систем автоматаар шил арчигчийн ажиллах хурдыг тохируулна

3 ▼ Удаан

4 ▼▼ Хурдан

5 △ Нэг удаа арчих

МЭДЭЭЛЭЛ

■ Урд шил арчигч, угаагч ажиллах нөхцөл

Асаах товчны ON горимд.

Шил арчигчийн хурд өөрчлөх

■ Ажиллах давтамжийн тохиргоотой тасалдсан горимтой шил арчигч

Тасалдсан горим сонгосон үед шил арчигчийн хурдыг тохируулах боломжтой.



1 Шил арчигчийн хурд нэмнэ

2 Шил арчигчийн хурд хасна

■ Бороо мэдрэгчтэй шил арчигч

AUTO сонгогдсон үед бороо мэдрэгч бороо мэдэрсэн нөхцөлд шил арчигч автоматаар ажиллана. Борооны хэмжээ болон автомашины хурдад тохируулан систем шил арчигчийн хурдыг автоматаар тохируулна.



1 Мэдрэх түвшинг нэмнэ
2 Мэдрэх түвшинг хасна

МЭДЭЭЛЭЛ

■ **Шил арчигчийн ажиллагаанд нөлөөлөх автомашины хурдны нөлөө (бороо мэдрэгчтэй шил арчигчтай автомашин)**

Тасалдсан горимтой шил арчигчийн ажиллагаанд автомашины хурд нөлөөө үзүүлнэ.

■ **Бороо мэдрэгч (бороо мэдрэгчтэй шил арчигчтай автомашин)**

● Бороо мэдрэгч нь салхины шилэн дээр тусах бороон дуслын хэмжээг мэдэрдэг.

Оптик мэдрэгч ашиглагддаг ба өглөө оройны нарны туяа салхины шилэн дээр шууд тусах, салхины шилэн дээр хорхой шавьж тогтсон зэрэг үед мэдрэгчийн хэвийн ажиллагаа алдагдаж болно.



● Бороо мэдрэгчийн хэм 90°C (194°F) ба түүнээс их, эсвэл -15°C (5°F)-с бага үед автомат ажиллагаа ажиллахгүй байж болно.

Энэ нөхцөлд AUTO горимоос өөр горим сонгоно.

Урд шил арчигч ашиглах

⚠ АЮУЛТАЙ

Хүйтэн үед салхины шил халах хүртэл шил арчигчийн шингэн ашиглаж болохгүй.

Шингэн салхины шилэн дээр хөлдөж үзэгдэх байдлыг бууруулах, улмаар осолд хүргэх аюултай.

⚠ АНХААР

Шил угаагчийн хошуу бөглөрсөн үед та өөрийн Lexus дилерт хандана уу. Зүү болон бусад зүйлээр сэтгэж болохгүй. Хошуу гэмтэх аюултай.

Хөшүүргийг татна.



Урд шил арчигч болон угаагч ажиллана.

Урд шил угаагч ажиллуулах үед урд шил арчигч автоматаар 2 удаа ажиллана.

Их гэрэл цэвэрлэгчтэй автомашин: Их гэрэл асаалттай үед хөшүүргийг татаад барихад их гэрэл цэвэрлэгч 1 удаа ажиллана. Үргэлжлүүлэн их гэрэл угаагч хөшүүргийг таван удаа татах тутамд нэг удаа ажиллана.

⚠ АНХААР

Шил угаагчийн хошуунаас шингэн цацагдахгүй үед шил арчигчийн шингэний насос гэмтээх тул хөшүүргийг нааш татан удаан ажиллуулж болохгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ **Шил арчигч, угаагчийн ажиллах нөхцөл**

Асаах товч ON горимд байгаа.

■ **Үлдсэн дусал урсахаас сэргийлсэн шил арчигчийн ажиллагаа (бороо мэдрэгчтэй шил арчигчтай автомашин)**

Шил арчигч хэд хэдэн удаа ажиллаад тодорхой хугацааны дараа үлдсэн дусал урсахаас сэргийлж дахин нэг ажиллана.

Нөгөөтэйгүүр тус функц нь автомашин явах үед ажиллахгүй.

■ **Шил арчигчийн шингэн цацагдахгүй үед**

Шил арчигчийн шингэний нөөцийн саванд шингэн байгаа тохиолдолд угаагчийн хошуу бөглөрсөн эсэхийг шалгана.

Арын шил арчигч ашиглах

⚠ АНХААР

Арын шил арчигч ашиглах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Хөдөлгүүр унтраастай үед арын шил арчигчийг шаардлагатай хэмжээнээс удаан ажиллуулж болохгүй. Аккумуляторын цэнэг сууна.

АНХААР

- Арын шил хуурай үед арын шилийг гэмтээх тул шил арчигч ашиглаж болохгүй.

МЭДЭЭЛЭЛ

Арын шил арчигч ба угаагчийн ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

товч дарах үед арын шил арчигч дараах байдлаар ажиллана:



1 Off
2 Тасалдсан горим
3 Хэвийн ажиллагаа

Арын шил угаагч ашиглах

АНХААР

Шил угаагчийн хошуу бөглөрсөн үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Зүү болон бусад зүйлээр сэтгэж болохгүй. Хошуу гэмтэх аюултай.

Хөшүүргийг татна.



Арын шил арчигч болон угаагч ажиллана.

Угаагч автоматаар ажиллаж Lexus зогсоолд байрлуулахад туслах дэлгэцийн камерыг цэвэрлэнэ.

Арын угаагч ажилласны дараа арын шил арчигч 2 удаа автоматаар ажиллана.

⚠ АНХААР

Шил арчигчийн шингэний насос хэт халах аюултай тул хойд шил угаагчийг удаан ажиллуулж болохгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ **Арын шил арчигч, угаагч ажиллах нөхцөл**

Power товч ON горимд байгаа.

■ **Салхины шил арчигчийн шингэн цацагдахгүй үед**

Шил арчигчийн шингэний нөөцийн саванд шингэн байгаа тохиолдолд угаагчийн хошуу бөглөрсөн эсэхийг шалгана.

Салхины шилний цан арилгах

Цан арилгагчийг салхины шил болон урд хажуугийн шилний цан арилгахад ашиглана.

⚠ АЮУЛТАЙ

- Салхины шилний цан арилгагчийг хэт чийгшилтэй орчинд агааржуулалтын системийг хүйтэн тохиргоонд тохируулан ашиглаж болохгүй.

  Гадны агаарын хэм болон салхины шилний температурын зөрүүнээс үүдэн салхины шилний гадна тал цантаж харагдах байдлыг хязгаарлаж болно.
- Агааржуулалтын хоолойг хаах аливаа эд зүйлийг хянах самбарын дээд талд байрлуулж болохгүй.

  Эсрэг тохиолдолд агаарын урсгал хаагдаж салхины шилний цан арилгагчийн ажиллагаанд саад учруулна.





Салхины шилний цан арилгагчийн товч дарна.

Чийгшил бууруулах функц ажиллаж агаарын урсгал нэмэгдэнэ.

Дотор агаарын горимд байгаа үед гадна/дотор агаарын горимын товчийг гадна агаарын горимд шилжүүлнэ. (Автоматаар шилжиж болно.)

Салхины шил болон хажуугийн шилний цанг хурдан арилгах үед агаарын урсгал болон температурын тохиргоог нэмнэ.

Салхины шилний цан арилсны дараа салхины шилний цан арилгагчийн товч дахин дарж өмнөх горимд буцна.

МЭДЭЭЛЭЛ

Цонх цантах

- Бүхээгний агаарын чийгшилт өндөр үед цонх амархан цантана.
  “A/C” товч дарах, эсвэл “A/C”-г сонгох үед агааржуулалтаас гарах агаарын чийгшилт бууруулах ба цонхны цанг үр дүнтэй арилгана.
- “A/C”-г унтраасан үед цонх хялбар цантаж болно.
- Дотор агаарын горим сонгосон үед цонх цантаж болно.

Хойд цонхны цан арилгах

▶ Хажуугийн толины цан арилгагчгүй автомашин



Хойд цонхны цан арилгагчийн товч дарж цан арилгана.

Цан арилгагч автоматаар тодорхой хугацааны дараа унтарна.

▶ Хажуугийн толины цан арилгагчтай автомашин



Хойд цонхны болон хажуугийн толины цан арилгагчийн товч дарж цан арилгана.

Хойд цонх болон хажуугийн толины цан арилгагч ажиллаж хойд цонх болон хажуугийн толины цан арилгана.

Цан арилгагч автоматаар тодорхой хугацааны дараа унтарна.

⚠ АЮУЛТАЙ

Хажуугийн толины цан арилгагчтай автомашин:

Хойд цонх болон хажуугийн толины цан арилгагч ажиллах явцад толины гадаргуу өндөр хэмд халж түлэгдэх аюултай тул толинд хүрэхийг хориглоно.

Хажуугийн толины цан арилгах*



Хойд шил болон хажуугийн толины цан арилгагчийн товч дарна.

Хойд шил болон хажуугийн толины цан арилгагч ажиллаж хойд цонх болон хажуугийн толины цан арилгана.

Тодорхой хугацааны дараа цан арилгагч автоматаар унтарна.

⚠ АЮУЛТАЙ

Хойд шил болон хажуугийн толины цан арилгагч ажиллах үед толины гадаргуу халж түлэх аюултай тул хажуугийн толинд хүрч болохгүй.

* : Тоноглогдсон автомашинд

Хүйтний улиралд бэлдэх

Хүйтний улиралд ашиглахын өмнө шаардлагатай бэлтгэл, үзлэг хийнэ. Цаг агаарын нөхцөлд нийцүүлэн зөв жолоодлого хийнэ.

Зайлшгүй үзэж шалгах зүйлс

- Гадна агаарын хэмд тохирсон шингэн ашиглана.
  - Хөдөлгүүрийн тос
  - Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэн
  - Шил арчигчийн шингэн
- Авто засварын мэргэжилтнээр аккумулятороо шалгуулна уу.

Өвлийн дугуй угсрах

Автомашинд өвлийн дөрвөн дугуй угсарна.

Өвлийн дугуйнууд бүгд ижил хэмжээ, брендийн дугуй.

⚠ АЮУЛТАЙ

Өвлийн дугуй угсрах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд автомашины удирдлага алдах магадлалтай.

- Зөвхөн заасан хэмжээтэй дугуй ашиглана.
- Дугуйн хийн даралтыг тохирох хэмжээнд барина.
- Тухайн угсарсан өвлийн дугуйнд заасан хурдны дээд хязгаараас давсан хурдаад явж болохгүй.
- Өвлийн дугуй ашиглах үед бүх дөрвөн дугуйнд угсарна.

⚠ АНХААР

Өвлийн дугуйгаа засах, солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилер, эсвэл бусад албан ёсны дугуйны борлуулалтын төвд хандана уу.

Өвлийн дугуй салгах, угсрах нь дугуйн хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийн ажиллагаанд нөлөөлж болзошгүй.

Дугуйн гинж ашиглах үед

Дугуйн гинжийг урд 2 дугуйнд угсарна.*1

Дугуйн хэмжээнд таарах дугуйн гинж ашиглана.

МЭДЭЭЛЭЛ

Дугуйн гинж угсрах, салгах болон ашиглах үед дараах анхааруулгыг мөрдөнө:

*1 : 235/50R20 дугуйнд дугуйн гинж ашиглаж болохгүй.

- Дугуйн гинжийг аюулгүй газар угсрах буюу салгана.
- Дугуйн гинжийг зөвхөн урд дугуйнд угсарна.
  Дугуйн гинжийг хойд дугуйнд угсарч болохгүй.
- Дугуйн гинжний гарын авлагад заасны дагуу угсарна.
- Гинжийг урд дугуйнд аль болох чанга угсрах ба 0.5-1.0 км (1/4-1/2 миль) яваад дахин чангална.

⚠ АЮУЛТАЙ

Автомашинд дугуйн гинж угсарсан үед дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд автомашиныг аюулгүйгээр жолоодох боломжгүй болно.

- 50 км/ц (30 миль/ц) хүртэлх хурдаар жолоодно. Хэрэв замын хурдны дээд хязгаар энэ хурдаас бага үед хурдны дээд хязгаарыг баримтлана.
- Энхэл донхолтой, нүхтэй замаар явахаас зайлсхийнэ.
- Огцом хурд нэмэх, жолоо эргүүлэх, тоормослох, эсвэл хөдөлгүүрийн тоормос үүсгэх араа хүндрүүлэхээс зайлсхийнэ.
- Замын эргэлт дээр урьдчилж хурд хасч тэнцвэрээ хадгална.
- LTA систем ашиглаж болохгүй.
- LDA систем ашиглаж болохгүй.

⚠ АНХААР

■ Дугуйн гинж угсрах

Дугуйн гинж угсарсан үед дугуйн хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч зөв ажиллахгүй байж болно.

■ Дугуйн гинж сонгох

Дугуйн хэмжээнд тохирсон дугуйн гинж ашиглана. Дугуйн гинжний хэмжээ нь дугуйн хэмжээнд тохируулан өөр байдаг.

● 235/60R18 дугуйтай автомашин



A Хажуугийн гинж (3 мм [0.12 инч] диаметртэй)

B Хажуугийн гинж (10 мм [0.39 инч] өргөнтэй)

C Хажуугийн гинж (25 мм [0.98 инч] урттай)

D Хөндлөн гинж (4 мм [0.16 инч] диаметртэй)

E Хөндлөн гинж (14 мм [0.55 инч] өргөнтэй)

F Хөндлөн гинж (25 мм [0.98 инч] урттай)

- 235/50R20 дугуйтай автомашин

  235/50R20 дугуйнд дугуйн гинж ашиглаж болохгүй.

  Дугуйн гинжний оронд цасны дугуй ашиглана.

Дугуйн гинж ашиглалттай холбоотой дүрэм журам

Гинж ашиглалтай холбоотой дүрэм журам нь тухайн бүс нутгийн онцлог, замын нөхцлөөс хамаарч өөр байдаг тул бүс дүрэм журмыг урьдчилж шалгана.

Өвлийн жолоодлого

Хүйтний улиралд жолоодлогын өмнө шалгах зүйлс

Жолоодлогын нөхцөлд нийцүүлэн дараах үйлдлийг хийнэ:

- Хөлдсөн цонхыг хүчээр нээх, шил арчигч ажиллуулахыг хориглоно. Хөлдсөн хэсэгт халуун ус асгаж мөсийг хайлуулна. Хөлдөхөөс сэргийлж усыг даруй арчиж цэвэрлэнэ.
- Агааржуулалтын системийн сэнсний хэвийн ажиллагааг хангаж салхины шилний урд байрлах агаар сорох хоолойнд тогтсон цас цэвэрлэнэ.
- Гадна гэрлүүд, дээвэр, араам, дугуй болон тоормосны механизмын ойр орчимд цас, мөс тогтсон эсэхийг шалгаж цэвэрлэнэ.
- Автомашинд суухын өмнө гутлын уланд тогтсон цас, шаврыг цэвэрлэнэ.

Цаг агаар хүйтэн үеийн жолоодлогын анхааруулга

Зөөлнөөр хурд нэмэх ба урд талын автомашинаас аюулгүй зай барин замын нөхцөлд нийцсэн байдлаар хурдаа хасч жолоодно.

Цаг агаар хүйтэн үед зогсоолд байрлуулах анхааруулга

- Зогсоолын тоормосны автомат горимыг унтраана. Зогсоолын тоормос хөлдөж автоматаар салгагдахгүйд хүрч болно.

  Автомат горим унтарсан үед ч зогсоолын тоормос автоматаар ажиллаж болох тул системүүдийг ашиглаж болохгүй.

  • Тоормос баригч систем
- Автомашиныг зогсоолд байрлуулаад зогсоолын тоормос залгалгүйгээр арааг P-д шилжүүлнэ. Зогсоолын тоормос хөлдөж салгагдахгүй байж болно. Зогсоолын тоормос залгаагүй үед дугуйнд ивээс хийнэ.

  Эсрэг тохиолдолд автомашин өнхөрч осол үүсгэх аюултай.
- Зогсоолын тоормос автомат горимд байгаа үед арааг P-д шилжүүлээд зогсоолын тоормос салгана.
- Зогсоолын тоормос залгалгүйгээр зогсоолд байрлуулсан үед араа P-с хөдлөх боломжгүйг нягтлана.
- Автомашиныг зогсоолд байрлуулаад зогсоолын тоормос залгалгүйгээр арааг P-д шилжүүлнэ.

  Зогсоолын тоормос залгаагүй үед дугуйнд ивээс хийнэ. Эсрэг тохиолдолд автомашин өнхөрч осол үүсгэх аюултай.

- Хүйтэн цаг агаартай үед нойтон тоормостой автомашин зогсоолд байрлуулсан үед тоормос хөлдөнө.

МЭДЭЭЛЭЛ

Ухрах араатай холбоотой толины функц

Хүйтэн цаг агаарт ухрах үйлдэл хийх үед хажуу толь хөлдөн толины нүүр ухрах арааны байрлалд шилжихгүй байж болно. Энэ нөхцөлд тогтсон цас мөсийг толиноос цэвэрлэнэ.

Хөлдсөн шил арчигчийг хөдөлгөх үүднээс салхины шил халаах*

Шил арчигчийн мөс арилгагч ашиглан шил арчигчийг салхины шилтэй хөлдөхөөс сэргийлнэ.

Сонголтын дэлгэц дээр [**Deicer**]-г сонгоно.

Шил арчигчийн мөс арилгагч тодорхой хугацааны дараа унтарна.

АЮУЛТАЙ

Шил арчигчийн мөс арилгагч ажиллах үед салхины шилний доод хэсэг, эсвэл урд багананы ойр орчим халж түлэгдэх аюултай тул хүрч болохгүй.

* :Тоноглогдсон автомашинд

Манангийн гэрэл ашиглах

Бороо болон манан зэрэг цаг агаарын муу нөхцөлд урд манангийн гэрэл асааж урд талын харагдах байдал, мөн арын манангийн гэрэл асааж арын автомашинд харагдах өөрийн автомашины харагдах байдлыг нэмэгдүүлнэ.

Манангийн гэрэл ашиглах

⚠ АНХААР

Хөдөлгүүр унтраастай үед аккумуляторын цэнэг суухаас сэргийлж гэрлийг шаардлагатай хэмжээнээс удаан асаахгүй.

▶ Арын манангийн гэрлийн товч



1 ○ Арын манангийн гэрэл унтраана

2 Арын манангийн гэрэл асаана

Товчны цагирагийг ○ -д буцаана.

Товчны цагирагийг дахин ажиллуулах үед арын манангийн гэрэл унтарна.

МЭДЭЭЛЭЛ

■ **Манангийн гэрэл асах нөхцөл**

Их гэрэл асаалттай.

▶ Урд ба арын манангийн гэрлийн товч



1 Урд болон арын манангийн гэрэл унтраана

2 Урд манангийн гэрэл асаана

3 Урд болон арын манангийн гэрэл зэрэг асаана

Товчны цагирагийг -д буцаана.

Товчны цагирагийг дахин ажиллуулах үед зөвхөн арын манангийн гэрэл унтарна.

МЭДЭЭЛЭЛ

■ Манангийн гэрэл асах нөхцөл

Урд манангийн гэрэл: Урд оврын гэрэл асаалттай үед.

Арын манангийн гэрэл: Урд манангийн гэрэл асаалттай үед.

Дуут дохио дуугаргах

тэмдэг, эсвэл түүний ойролцоо дарна.



Utility төрлийн автомашины анхааруулга

Тус автомашин нь хүндийн төвийн өндөртэй харьцуулахад газраас тэнхлэг хүртэлх зай харьцангуй өндөр, дугуйн мөрний зай харьцангуй нарийн онцлогтой utility автомашины төрөлд хамаардаг.

Utility төрлийн автомашины анхааруулга

- Автомашины загвар дизайн, онцлогоос хамаарч суудлын автомашинтай харьцуулахад хүндийн төв нь илүү өндөрт байрладаг ба энэ төрлийн автомашин унах, хөмрөх магадлал ихтэй байдаг.
- Газраас тэнхлэг хүртэлх зай өндөр учир замын нөхцөл байдлыг илүү сайн харах, эрсдэлийг урьдчилж мэдэх боломжтойгоороо давуу талтай.
- Энэ төрлийн автомашин нь суудлын автомашин, мөн бартаат замын зориулалттай спорт автомашинтай адил хурдаар эргэлт хийхэд зориулагдаагүй болно. Тиймээс өндөр хурдтай огцом эргэлт хийх үед автомашин хөмрөх аюултай.

⚠ АЮУЛТАЙ

■ Utility төрлийн автомашины анхааруулга

Амь нас, эрүүл мэндэд учирж болзошгүй ноцтой хохирол, автомашины эвдрэлийг боломжит бага хэмжээ хүртэл бууруулахын тулд дараах анхааруулгыг цаг ямагт дагаж мөрдөнө:

- Автомашин унасан, хөмөрсөн үед аюулгүйн бүс бүслээгүй хүний амь насанд эрсдэл учрах аюул бүсэлсэн хүнтэй харьцуулахад туйлын өндөр байдаг тул жолооч болон бүх зорчигч цаг ямагт аюулгүйн бүс зүүж ашиглана.
- Огцом эргэлт, огцом маневр хийхээс аль болох зайлсхийнэ. Автомашины жолоодлогыг буруу хийсэн тохиолдолд жолоодлого алдах, эсвэл автомашин унах, хөмрөхөд хүргэх ба улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.
- Дээврийн ачаа (тоноглогдсон автомашинд) дээр тээш ачих нь автомашины хүндийн төвийг илүү өндөр болгох тул өндөр хурд, огцом хөдөлгөөн эхлэх, огцом эргэлт хийх, огцом, тоормослох болон огцом маневр хийхээс зайлсхийнэ. Жолоодлого алдах, эсвэл автомашин унах, хөмрөхөд хүргэх ба улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.
- Хүчтэй хөндлөн салхитай үед цаг ямагт хурдаа хасна. Автомашины хэлбэр болон хүндийн төв өндөр байдгаас хамаарч хөндлөн салхинд суудлын автомашинаас илүү мэдрэмтгий байдаг. ба хурд хасах нь автомашины удирдлагыг сайжруулна.

⚠ АЮУЛТАЙ

- Хэт налуу зам дээр хөндлөн явахыг хориглох ба эгц дээш, эсвэл доош явах нь зүйтэй. Автомашин (мөн бусад ижил төстэй бартаат замын автомашин) урагш болон арагш талаасаа илүү хажуу тал руугаа хялбар унах магадлалтай байдаг.

Бартаат замын жолоодлого

Тус автомашин нь бартаат замаар жолоодохоор бүтээгдсэн автомашин биш болно. Нөгөөтэйгүүр бартаат замаар жолоодох зайлшгүй шаардлагатай үед зорчиход хориотой хэсгээс зайлсхийх үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө.

- Зөвхөн off-road автомашин явах боломжтой газраар явна.
- Бусдын хувийн өмч, эзэмшлийг хүндлэнэ. Бусдын эзэмшил газарт нэвтрэхээс өмнө тухайн хүний зөвшөөрөл авна.
- Автомашин нэвтрэхийг хориглосон газар луу нэвтрэхийг хориглоно. Хөдөлгөөн хориглосон хаалт, хаалга, замын тэмдгийн заалтыг баримтлана.
- Хатуу гадаргуутай замаас гарч болохгүй. Зам норсон, эсвэл ус тогтсон үед жолоодлогын арга техникээ өөрчлөх, мөн замын гадаргууг гэмтээхээс сэргийлж хөдөлгөөнөө зогсооно.

⚠ АЮУЛТАЙ

■ Бартаат замын жолоодлогын анхааруулга

Амь нас, эрүүл мэндэд учирж болзошгүй ноцтой хохирол, автомашины эвдрэлийг боломжит бага хэмжээ хүртэл бууруулахын тулд дараах анхааруулгыг цаг ямагт дагаж мөрдөнө:

- Замгүй газраар явах үед анхаарал болгоомжтой жолоодно. Аюултай газраар явахгүй байх зэргээр шаардлагагүй эрсдэлд орохоос зайлсхийнэ.
- Бартаат замын жолоодлогын үед жолооны хүрдний дотор талаас барихыг хориглоно. Замын энхэл донхолд дугуй цохигдох үед жолооны хүрд хүчтэй эргэж гар гэмтээх аюултай тул 2 гар, ялангуяа эрхий хуруугаа хүрдний гадна талд байрлуулна.
- Элс, шавар, ус болон цастай замаар явсны дараа тухай бүр тоормосны ажиллагааг шалгана.
- Өндөр өвс, шавар, чулуу, элстэй замаар явсан, гол туулсны дараа автомашины доод талд өвс, бут сөөг, цаас, даавуу, чулуу болон элс зэрэг наалдаагүй эсэхийг нягтлах ба эдгээр зүйлс наалдсан, тогтсон үед цэвэрлэнэ. Жолоодлого хийх нь эвдрэл гэмтэл үүсэх, гал түймэр гаргах аюултай.

⚠ АЮУЛТАЙ

- Бартаат зам, шороон зам дээр хэт өндөр хурд авах, харайлгах, огцом эргэлт хийх, аливаа зүйл мөргөх зэргээс зайлсхийнэ. Энэ нь жолоодлого алдах, автомашин унах, хөмрөхөд хүргэх, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай. Мөн амортизатор, араам, их биенд өндөр үнийн дүн бүхий гэмтэл учруулах магадлалтай.

⚠ АНХААР

■ Уснаас үүдэх гэмтлээс сэргийлэх

Хөдөлгүүр болон бусад хэсгүүдэд ус гэмтэл учруулахаас сэргийлж зохих бүх арга хэмжээг авна.

- Хөдөлгүүрийн агаар сорох хоолойд нэвтэрсэн ус хөдөлгүүрт ноцтой гэмтэл учруулна.
- Автомат хурдны хайрцагт ус орсон тохиолдолд араа шилжилт муудах, хурдны хайрцагт чичиргээ үүсч түгжигдэх болон бусад ноцтой гэмтэл учруулна.
- Ус нь дугуйн холхивчийг тосолгоогүй болгох, зэврэлт үүсгэх, эдэлгээг богиносгох аюултай ба мөн дифференциал, хурдны хайрцаг, туслах хурдны хайрцагт нэвтрэх магадлалтай ба хүч дамжуулах ангийн тосны чанарт сөргөөр нөлөөлнө.

■ Ус туулсны дараа

Жижиг гол гатлах зэргээр ус туулах үед эхлээд усны гүн болон голын ёроол хэр хатуу болохыг шалгана. Гүнзгий уснаас зайлсхийж бага хурдаар жолоодно.

■ Бартаат замаар явсны дараах үзлэг

- Тоормосны наклад, планзны завсар тогтсон элс, шавар нь тоормосны хүчийг бууруулах, механизмыг гэмтээх аюултай.
- Шороон зам, элс, шавар, ус зэрэг бартаат замаар явсан өдөр тутам засвар үйлчилгээний үзлэг хийх шаардлагатай.

Жолоодлогын горим

Жолоодлого, ашиглалтын нөхцөлд нийцүүлэн дараах жолоодлогын горим ашиглах боломжтой.

Жолоодлогын горим тус бүрийн онцлог

AVS (Adaptive Variable Suspension System) системгүй автомашин:

■ **Хэвийн горим**

Шатахуун бага зарцуулалт, дуу чимээ бага, жолоодлогын чадвар өндөртэй ба хотын жолоодлогод тохиромжтой.

■ **Эко горим**

Хэвийн горимтой харьцуулахад хааз гишгэх үеийн зүтгэх хүч бага, агааржуулалтын системийн ажиллагаа хязгаарлагдсан, мөн шатахуун зарцуулалт сайжруулахад тохиромжтой жолоодлогод шилжинэ.

■ **Спорт горим**

Хөдөлгүүр болон хурдны хайрцаг удирдан жолоодлого болон хаазны хариу үйлдлийг бүрдүүлнэ. Уулын замаар явах зэрэг спорт жолоодлогод тохиромжтой.

AVS (Adaptive Variable Suspension System) системтэй автомашин:

■ **Хэвийн/Custom горим**

● Хэвийн горим

Шатахуун бага зарцуулалт, дуу чимээ бага, жолоодлогын чадвар өндөртэй ба хотын жолоодлогод тохиромжтой.

● Custom горим

Хүч дамжуулах анги, явах эд ангийн функцийг өөрийн хүссэн байдлаар тохируулах, агааржуулалтын системийн ажиллагааг тохируулах замаар хүссэн тохиргоондоо тохируулан жолоодох боломжтой. Тус горимыг зөвхөн голын дэлгэцний жолоодлогын горим өөрчлөх тохиргоогоор тохируулна.

■ **Эко горим**

Хэвийн горимтой харьцуулахад хааз гишгэх үеийн зүтгэх хүч бага, агааржуулалтын системийн ажиллагаа хязгаарлагдсан, мөн шатахуун зарцуулалт сайжруулахад тохиромжтой жолоодлогод шилжинэ.

■ **Спорт горим**

● Sport S горим

Хурдны хайрцаг, хөдөлгүүр удирдах замаар хаазны дөрөө гишгэх үеийн зүтгэх хүчийг нэмэгдүүлнэ. Хүчтэй хурд авалт шаардлагатай үеийн жолоодлогод тохиромжтой.

- Sport S+ горим

  Хурдны хайрцаг, хөдөлгүүр удирдах замаар хаазны дөрөө гишгэх үеийн зүтгэх хүч өндөр нэмэгдэх ба жолооны механизм болон явах эд ангийг цогцоор удирдах замаар тэнцвэртэй байдал дээд зэргээр нэмэгдэнэ. Спорт жолоодлогод тохиромжтой.

МЭДЭЭЛЭЛ

Эко горим дахь агааржуулалтын системийн ажиллагаа

- Эко горимд шатахуун зарцуулалтыг сайжруулах үүднээс агааржуулалтын систем дараах байдлаар ажиллана.
  - Агааржуулалтын системийн халаах, хөргөх ажиллагааг хязгаарлах үүднээс хөдөлгүүр, компрессорын ажиллагаа удирдагдана
  - Автомат горим сонгогдох үед сэнсний хурд хязгаарлагдана
- Агааржуулалтын системийн ажиллагааг нэмэх үед дараах үйлдлийг хийнэ.
  - Сэнсний хурдыг тохируулна
  - Температурын тохиргоог өөрчилнө
  - Эко горим унтраана
- Жолоодлогын горимыг эко горимд шилжүүлсэн үед агааржуулалтын систем автоматаар эко горимд шилжинэ. Эко горим цуцлах үед [**Eco heat/cool**] товч дарна.

Жолоодлогын горим солих

▶ AVS (Adaptive Variable Suspension) системгүй автомашин



1 Эко горим

Эко горим сонгогдоогүй үед жолоодлогын горим сонгох товчийг зүүн эргүүлж эко горимд шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр эко жолоодлогын горимын индикатор гарна.

2 Спорт горим

Спорт горим сонгогдоогүй үед жолоодлогын горим сонгох товчийг баруун эргүүлж спорт горимд шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр спорт жолоодлогын горимын индикатор гарна.

3 Хэвийн горим

Эко, эсвэл спорт горим сонгогдсон үед жолоодлогын горим сонгох товчийг дарж хэвийн горимд шилжүүлнэ.

▶ AVS (Adaptive Variable Suspension) системтэй автомашин



1 Эко горим

Эко горим сонгогдоогүй үед жолоодлогын горим сонгох товчийг зүүн эргүүлж эко горимд шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр эко жолоодлогын горимын индикатор гарна.

2 Спорт горим

- Спорт S горим

  Спорт S горим сонгогдоогүй үед жолоодлогын горим сонгох товчийг баруун эргүүлж спорт S горимд шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр спорт S жолоодлогын горимын индикатор гарна.

- Спорт S+ горим

  Спорт S горимд жолоодлогын горим сонгох товчийг баруун эргүүлж спорт S+ горимд

шилжүүлнэ. Мэдээллийн дэлгэц дээр спорт S+ жолоодлогын горимын индикатор гарна.

3 Хэвийн/Custom горим

Товч дарж хэвийн горим, эсвэл Custom сонгоно. Товч дарах бүрт систем хэвийн горим болон Custom горимын хооронд шилжинэ.

Custom сонгогдсон үед мэдээллийн дэлгэц дээр тус горимын индикатор асна.

Эко горим, спорт горимд байгаа үед товч дарахад систем хэвийн горимд буцна.

МЭДЭЭЛЭЛ

Спорт/Custom горим цуцлах

- Өөр жолоодлогын горим сонгоно. Мөн асаах товчийг унтраах үед спорт болон Custom горимууд нь автоматаар цуцлагдана.
- Хэвийн горим болон эко горим нь өөр жолоодлогын горим сонгох хүртэл асаах товч унтраасан ч цуцлагдахгүй.

Тухайн сонгосон жолоодлогын горимын мэдээллийн дэлгэц

Тухайн сонгосон жолоодлогын горимоос хамаарч мэдээллийн дэлгэц дээр гарах хэмжих хэрэгслүүд солигдоно.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Trail горим (AWD автомашин)

Trail горим нь дөрвөн дугуйн тоормос болон хүчний удирдлагын системийг нэгдсэн байдлаар удирдах замаар хий эргэлтээс сэргийлдэг. Trail горимыг энхэл донхолтой зам зэрэг дээр ашиглана.

● **Trail Mode товч дарна.**

Trail Mode товч дарж Trail горим асаана. Trail горимын индикатор мэдээллийн дэлгэц дээр асна. Тус систем унтраах үед Trail Mode товч дээр дахин дарна.

Дугуй хий эргэх үед шарвалтын индикатор анивчиж Trail горим дугуйн хий эргэлтийг удирдаж байгааг илтгэнэ.





МЭДЭЭЛЭЛ

■ **Trail горим**

● Trail горим нь замын муу нөхцөлд автомашины зүтгэх хүчийг хамгийн өндөр байлгахаар автомашиныг удирддаг. Үүний үр дүнд тус горим асаагүй үетэй харьцуулахад шатахууны зарцуулалт нэмэгдэж болно.

● Замын нөхцлөөс хамаарч Trail горимыг удаан ашигласан нөхцөлд холбоотой эд ангиудад ирэх ачаалал нэмэгдэж системийн хэвийн ажиллагаа алдагдаж болно. Энэ үед **"Traction Control Turned OFF"** мэдээллийн дэлгэц дээр гарах ба нөгөөтэйгүүр автомашиныг үргэлжлүүлэн хэвийн жолоодохо боломжтой. Мэдээллийн дэлгэц дээрх **"Traction Control Turned OFF"** анхааруулг тодорхой хугацааны дараа унтрах ба систем хэвийн ажиллана.

■ **Trail горим цуцлагдсан үед**

Тус горимыг сонгосон ч дараах нөхцлүүдэд Trail горим автоматаар цуцлагдаж болно:

● Жолоодлогын горим өөрчлөгдсөн үед.

● Хөдөлгүүр дахин асаасан үед.

■ Trail горимоор жолоодох үеийн дуу болон чичиргээ

Trail горим ажиллах үед дараах нөхцлүүд үүсч болно. Эдгээр нь системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй:

- Автомашины их бие, жолооны хүрднээс чичиргээ мэдрэгдэх
- Хөдөлгүүрийн хэсгээс дуу сонсогдож болно

■ Trail горимын индикатор асахгүй үед

Trail Mode товч дарсан ч Trail горимын индикатор асахгүй үед системд доголдол үүссэн байж болзошгүй.

Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

⚠ АЮУЛТАЙ

■ Trail горим ашиглахын өмнө

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд санамсаргүй осол аваарт хүргэх аюултай.

- Trail горим нь бартаа ихтэй замаар явах үед ашиглах зориулалттай.
- Хөдөлгөөн эхлэхийн өмнөTrail горимын индикатор ассан байгааг нягтлана уу.
- Trail горим нь автомашины хүчин чадлыг нэмэгдүүлэх функц биш болно. Замын байдлыг сайн ажиглан анхааралтай жолоодно.

⚠ АНХААР

■ Trail горимын хэвийн ажиллагааг хангах

Trail горимыг удаан ашиглаж болохгүй. Жолоодлогын нөхцлөөс хамаарч холбогдох эд ангиудад ирэх ачаалал нэмэгдэж функцийн хэвийн ажиллагаа алдагдана.

Холбоотой холбоосууд

Жолоодлогын горим солих(Х. 244)

DAC уруу замд туслах удирдлагын систем

Уруу замд туслах удирдлагын систем нь уруу зам дээр хурд хэт нэмэгдэхээс сэргийлэхэд тусладаг. Систем нь туслах хурдны хайрцагны L4 горимд, хурд 30 км/ц (18 миль/ц)-с бага үед тоормосны дөрөө сулласан үед ажилладаг.

“DAC” товч дарна.



Уруу замд туслах удирдлагын системийн индикатор асч систем ажиллана. Систем ажиллах үед шарвалтын индикатор анивчиж тоормосны гэрэл/тоормосны нэмэлт гэрэл асна. Систем ажиллах үед дуу гарч болно. Энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.

Систем ажиллах үед “DAC” товч дарна.

Уруу замд туслах удирдлагын системийн индикатор унтарч системийн ажиллагаа аажмаар зогсох ба систем бүрэн унтрах үед индикатор унтарна. Индикатор анивчих үед “DAC” товч дарж системийг дахин идэвхжүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Ажиллуулах зарчим

Арааны хөшүүргийн S горимын 1-р араа, эсвэл R байрлалд систем ажиллана.

■ Уруу замд туслах удирдлагын индикатор анивчсан үед

● Дараах нөхцлүүдэд индикатор анивчиж систем ажиллахгүй:

- Арааны хөшүүрэг S горимын 1-р араа, эсвэл R-с бусад байрлалд байгаа.
- Автомашины хурд 25 км/ц (15 mph)-с давсан.
- Тоормосны систем хэт халсан.

● Дараах нөхцөлд индикатор анивчиж жолоочид анхааруулга өгөх боловч систем ажиллана:

- Систем ажиллах явцад “DAC” товчийг унтраасан.

  Системийн ажиллагаа аажмаар зогсоно. Систем ажиллах үед индикатор анивчих ба систем бүрэн унтрах үед унтарна.

■ Уруу замд туслах удирдлагын системийг удаан ашигласан нөхцөлд

Энэ нь тоормос идэвхжүүлэгчийг хэт халааж болно. Энэ нөхцөлд уруу замд туслах удирдлагын системийн ажиллагаа зогсож дуут дохио дуугарах ба системийн индикатор анивчиж эхлээд **"Traction Control Turned OFF"** мэдээллийн дэлгэц дээр гарна. Уруу замд туслах удирдлагын

системийн индикатор үргэлжлэн асч **"Traction Control Turned OFF"** анхааруулга унтрах хүртэл системийг ашиглахаас татгалзана. (Энэ үед автомашиныг хэвийн жолоодох боломжтой.)

■ **Уруу замд туслах удирдлагын системийн ажиллагаатай холбоотой дуу, чичиргээ**

- Хөдөлгүүр ассан, эсвэл хөдөлгөөн эхэлсэн даруйд хөдөлгүүрийн хэсгээс дуу гарч болно. Энэ дуу нь уруу замд туслах удирдлагын системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.
- Уруу замд туслах систем ажиллах үед дараах аль нэг нөхцөл үүсч болно. Эдгээр нь системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.
  - Автомашины их бие болон жолооны хүрднээс чичиргээ мэдрэгдэж болно.
  - Автомашин зогссоны дараа моторын дуу сонсогдож болно.

■ **Системийн доголдол**

Дараах нөхцөлд та өөрийн Lexus дилерт хандана уу.

- Асаах товчийг ON горимд шилжүүлэх үед уруу замд туслах удирдлагын системийн индикатор асахгүй байх.
- “DAC” товч дарсан ч уруу замд туслах удирдлагын системийн индикатор асахгүй байх.
- Шарвалтын индикатор асах.

⚠ АЮУЛТАЙ

■ **Уруу замд туслах удирдлагын систем ашиглах үед**

Системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй. Тус функц нь автомашины хүчин чадлын хязгаарыг нэмэгдүүлдэггүй. Цаг ямагт замын нөхцлийг шалгаж аюулгүй жолоодно.

■ **Систем хэвийн ажиллахгүй нөхцлүүд**

Систем дараах замын нөхцлүүдэд хэвийн ажиллахгүй бөгөөд улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- Норсон, эсвэл шавартай зэрэг хальтиргаатай зам
- Мөстсөн зам
- Шороон зам

Тоормос баригч систем

⚠ АЮУЛТАЙ

■ **Огцом өгсүүр, уруу зам дээр зогссон үед**

Огцом өгсүүр, уруу зам дээр тоормос баригч ашиглах үед өндөр анхааралтай байна. Тоормос баригч автомашиныг бариж чадахгүй байж болно.

■ **Хальтиргаатай зам дээр зогссон үед**

Дугуйны барьцалдах чадвараас давсан үед систем автомашиныг бариж чадахгүй. Хальтиргаатай зам дээр зогссон үед системийг ашиглаж болохгүй.

⚠ АНХААР

■ **Автомашиныг зогсоолд байрлуулах үед**

Тоормос баригч систем нь автомашиныг удаан хугацаанд зогсооход зориулагдсан систем биш болно. Систем автомашиныг бариж байгаа үед асаах товчийг off горимд унтраах нь систем автомашины тоормосыг салгах, улмаар автомашин өнхрөхөд хүргэнэ. Асаах товчтой харьцах үед тоормосны дөрөөг гишгээд арааны хөшүүргийг P байрлалд шилжүүлээд зогсоолын тоормос татна.

Холбоотой холбоосууд

Зогсоолын тоормосны ажиллагаа(X. 187)

Тоормос баригчийн ажиллагааны индикатор (дуут дохио)(X. 574)

Тоормос баригч асаах

Арааны хөшүүрэг D, M, эсвэл N арааны байрлалд байгаа ба тоормосны дөрөөгөөр автомашин зогсоосон үед тоормос баригч систем тоормосыг үргэлжлүүлэн баридаг. Систем нь арааны хөшүүрэг D, M араанд хаазны дөрөө гишгэх үед хөдөлгөөний зөөлөн эхлэх боломж бүрдүүлж тоормос сулладаг.

Арааны хөшүүрэг D, M, эсвэл N арааны байрлалд байгаа ба тоормосны дөрөөгөөр автомашин зогсоосон үед тоормос баригч систем тоормосыг үргэлжлүүлэн баридаг. Систем нь арааны хөшүүрэг D, M араанд хаазны дөрөө гишгэх үед хөдөлгөөний зөөлөн эхлэх боломж бүрдүүлж тоормос сулладаг.

Тоормос баригчийг асаах

Тоормос баригчийн индикатор (ногоон) асна. Систем тоормос барих үед тоормос баригчийн ажиллагааны индикатор (шар) асна.



МЭДЭЭЛЭЛ

Тоормос баригчийн ажиллах нөхцөл

Дараах нөхцлүүдэд тоормос баригчийг асаах боломжгүй:

- Жолоочийн хаалга хаагдаагүй.
- Жолооч аюулгүйн бүсээ бүслээгүй.
- Зогсоолын тоормос залгагдсан.

Тоормос баригчийн систем идэвхжсэн үед дээрх аль нэг нөхцөл илэрсэн нөхцөлд систем унтарч тоормос баригчийн индикатор унтарна. Мөн систем тоормос барих үед дээрх аль нэг нөхцөл илэрсэн нөхцөлд дуут дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна. Энэ үед зогсоолын тоормос автоматаар залгагдана.

Тоормос баригчийн функц

- Систем тоормос бариж байгаа үед 3 минутын турш тоормосны дөрөө гишгээгүй бол зогсоолын тоормос автоматаар идэвхжинэ. Энэ тохиолдолд анхааруулах дуут дохио дуугарах ба мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна.
- Налуу зам дээр тоормос баригч функц автомашиныг хөдөлгөөнгүй зогсоож чадахгүй байж болно. Энэ нөхцөлд анхааруулах дуут дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах ба энэ үед жолооч тоормос ашиглах шаардлагатай. Мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарсан үед анхааруулгын зааварчилгааг мөрдөнө.
- Систем тоормос бариж байгаа үед системийг унтраах тохиолдолд тоормосны дөрөөг сайтар гишгээд товчийг дахин дарна.
- Тоормос баригчийг автоматаар ажиллуулах шаардлагагүй үед тоормос баригчийн товчийг систем ажиллахад бэлэн байгааг илтгэх индикатор (ногоон) унтрах хүртэл удаан дараад асаах товч унтраана.

Систем тоормос барих үед зогсоолын тоормос автоматаар залгагдсан нөхцөлд

Дараах аль нэг үйлдлээр зогсоолын тоормос салгана.

- Хаазны дөрөө гишгэнэ. (Аюулгүйн бүс бүслэгдээгүй үед зогсоолын тоормос автоматаар салгагдахгүй.)
- Тоормос гишгэнгээ зогсоолын тоормосны товч дарна.

Зогсоолын тоормосны индикатор унтарсныг нягтлана.

■ **Lexus дилер дээрээ үзлэг хийлгэх шаардлагатай нөхцлүүд**

Тоормос баригчийн ажиллах нөхцөл бүрдсэн нөхцөлд тоормос баригчийн товч дарсан ч индикатор (ногоон) асахгүй үед системд доголдол үүссэн байж болно.

Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

■ **"Brake Hold Malfunction" анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гарсан үед**

Системд доголдол үүссэн байж болно.

Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

■ **Анхааруулах мэдээлэл ба дохио**

Анхааруулах мэдээлэл ба дохио нь системийн доголдол, эсвэл жолоочийн анхаарах шаардлагатай зүйлсийг илтгэдэг. Мэдээллийн дэлгэц дээр анхааруулах мэдээлэл гарсан үед зааварчилгааг баримтлана.

4 Салон дахь функц, тоноглолууд

4-1. Хувийн тохиргоо

Миний тохиргоо 254

4-2. Жолоодлогын байрлал тохируулах

Жолооч хялбараар суух, буух (Жолооч буух, суухад туслах систем) 256

Жолоодлогын байрлал сануулах/дахин дуудах/устгах 257

4-3. Бүхээгний хэм/орчныг тохируулах

Систем бүрийн ажиллагааг тохируулалгүйгээр тав тухтай орчинг бүрдүүлэх (Агааржуулалтын автомат горим) 261

Агааржуулалтын системийн удирдлагын самбар 263

Жолооны хүрд халаагч..... 272

Суудал халаагч..... 273

Суудлын агааржуулагч 275

Дээврийн нээлхий ашиглах..... 276

Панорамик дээврийн нээлхий ашиглах..... 279

Электрон нарны хаалт нээх хаах 282

4-4. Салоны гэрэл асаах

Салоны гэрэл ашиглах 284

4-5. Салоны функц, системүүдийг ашиглах

Хайрцаг тавиурны байрлал..... 288

Салоны хэрэгцээтэй функцууд 294

4-6. Тээшний хэсгийг ашиглах

Тээш бэхлэх дэгээ ашиглах..... 305

Ачааны торны дэгээ ашиглах..... 306

Тор, уутны дэгээ ашиглах. 307

Тээшний хэсгийн шалны хавтан..... 308

Тээшний хаалт эвхэх..... 310

Миний тохиргоо

Электрон түлхүүр зэрэг төхөөрөмжөөр жолооч өөрийгөө системд таниулж болох ба энэ нөхцөлд жолоочийн жолоодлогын байрлал болон бусад тохиргоо жолооч автомашинд суух үед автоматаар дуудагдана. Жолооч таних төхөөрөмжийг урьдчилан сануулснаар автомашинд суух үед жолоочийн сануулсан тохиргоо дуудагдана.Миний тохиргоо системд 3 хүртэлх жолоочийн тохиргоог бүртгүүлэх боломжтой. Таних төхөөрөмжийн бүртгэл, бүртгэл устгах, жолоочийн нэр өөрчлөх, жолоочийн бүртгэлийн тохиргоог тэглэх, гар аргаар өөр жолоочийн тохиргоонд шилжүүлэх, жолоочийн бүртгэл устгах тухай дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

■ Жолоочийг таних төхөөрөмжийн төрлүүд

Дараах төхөөрөмжүүдээр жолоочийг таних боломжтой.

● Электрон түлхүүр

Smart entry & start систем тухайн жолооч дээр бүртгэгдсэн электрон түлхүүрээр танина.

● Bluetooth төхөөрөмж

Аудио системд өмнөх удаа холбогдсон Bluetooth төхөөрөмжөөр жолоочийг таних боломжтой.

■ Дахин дуудагдах функцууд

Төхөөрөмж жолоочийг таних үед дараах функцийн тохиргоо дуудагдана.

● Жолоодлогын байрлал (санах ой буцаан дуудах функц)*

Жолоочийг танисан ба дараах аль нэг үйлдлийг хийх үед өмнөх жолоодлого дууссан үеийн жолоодлогын байрлал автоматаар дуудагдана.

Smart entry & start систем, эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар хаалга тайлж нээсэн.

● Хэмжүүр, HUD дэлгэц* болон мултимедиа мэдээлэл*1

Жолоочийг танисан үед асаах товчийг өмнө нь унтраасан үеийн автомашины тохиргоо дахин дуудагдана.

● Голын дэлгэц ашиглан хийх боломжтой автомашины тохиргоо*1

Жолоочийг танисан үед асаах товчийг өмнө нь унтраасан үеийн автомашины тохиргоо дахин дуудагдана.

● Аюулгүй жолоодлогод туслах функц*1

* : Тоноглогдсон автомашинд

*1 : Зарим тохиргоо хамаарахгүй.

Жолоочийг танисан үед асаах товчийг өмнө нь унтраасан үеийн автомашины тохиргоо дахин дуудагдана.

Жолооч хялбараар суух, буух (Жолооч буух, суухад туслах систем)*

⚠ АЮУЛТАЙ

Хавчихаас хамгаалах функцийг албаар идэвхжүүлэх үүднээс биеээ санаатай хавчуулж болохгүй.

Дараах бүх үйлдлийг хийсэн үед жолоочийн суудал болон жолооны хүрд автоматаар жолооч хялбараар бууж суух байрлалд шилжинэ.



- Арааг P байрлалд шилжүүлсэн.
- Асаах товчийг ACC, эсвэл ON горимд шилжүүлсэн.
- Жолоочийн суудлын бүс тайлагдсан.

Дараах аль нэг үйлдлийг хийх үед жолоочийн суудал болон жолооны хүрд автоматаар анхны байрлалд буцна.

- Асаах товчийг ACC, эсвэл ON горимд шилжүүлсэн.
- Жолоочийн суудлын бүс бүслэгдсэн.

МЭДЭЭЛЭЛ

■ Жолооч буух, суухад туслах системийн ажиллагаа

Автомашинаас буух үед суудал хамгийн арагш байрлалд ойр байгаа нөхцөлд жолооч буух, суухад туслах систем ажиллахгүй байж болно.

■ Хавчихаас хамгаалах функц

Жолооч буух, суухад туслах систем ажиллах үед урд суудлын ард аливаа эд зүйл хавчуулагдсан нөхцөлд урд суудлын хөдөлгөөн зогсох ба бага зэрэг буцаж урагшлана. Хавчихаас хамгаалах функц ажиллах үед суудал тохируулснаас өөр байрлалд зогсоно. Суудлын байрлалыг нягтлана уу.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

* : Тоноглогдсон автомашинд

Жолоодлогын байрлал сануулах/дахин дуудах/устгах*

Тус функц нь автомашинд хялбараар бууж суух, эсвэл таны сонголтод нийцүүлэн жолоочийн суудал, жолооны хүрд, хажуугийн толь болон HUD дэлгэцийн*байрлалыг автоматаар тохируулдаг.

Миний тохиргоо функц бүртгэгдсэн жолооч, зочин нэг бүрт 3 хүртэлх өөр байрлал сануулах боломжтой. Миний тохиргоогоор жолоочид электрон түлхүүр (түлхүүр карт мөн хамаарна) бүртгэгдсэн үед тухайн жолоочийн суудлын байрлал дуудагдана (санах ой дахин дуудах функц).

Санах ойд жолоодлогын байрлал бүртгэх (байрлал санах функц)

1 **Арааг P-д байгааг нягтлана.**

2 **Асаах товчийг ON горимд шилжүүлнэ.**

3 **Жолоочийн суудал, жолооны хүрд, хажуугийн толь болон HUD дэлгэцийг * сануулах байрлалд тохируулна.**

4 **“SET” товч дарангаа тус товчийг дарснаас 3 секундын дотор “1”, “2”, эсвэл “3” товчийг дохио дуугарах хүртэл дарна.**

Тус байрлалд жолоодлогын байрлал бүртгэгдсэн үед өмнөх бүртгэл устгагдана.



МЭДЭЭЛЭЛ

■ **Санах боломжтой суудлын байрлалууд**

Түшлэгний гүн тохируулах товчоор тохируулснаас бусад суудлын байрлалыг санана.

■ **Жолоодлогын байрлал санах ойн функцийн зөв ашиглалт**

Хэрэв суудлын байрлалын тохиргоо нь аль нэг чиглэлд тулсан ба тухайн чиглэлд суудлын тохиргоог хийж байгаа үед сануулсан суудлын байрлал дахин дуудах үед бага зэрэг өөр байж болно.

⚠ АЮУЛТАЙ

Суудлын тохиргоо хийх үед суудал арын зорчигчийг цохих, эсвэл таныг жолооны хүрдэнд шахахаас сэргийлнэ.

* : Тоноглогдсон автомашинд

Жолоодлогын байрлал дахин дуудах (байрлал санах ойн функц)

⚠ АЮУЛТАЙ

Хавчихаас хамгаалах функцийн ажиллагааг шалгахын тулд биеээ хавчуулж турших нь аюултай.

1 **Араа Р байрлалд байгааг нягтлана.**

2 **Асаах товч ON горимд шилжүүлнэ.**

3 **Дохио дуугарах хүртэл тухайн дуудах гэж жолоодлогын байрлалын товчийг дарна.**



МЭДЭЭЛЭЛ

■ **Жолоодлогын байрлал дуудагдах үед зогсоох**

Дараах аль нэг үйлдлийг хийнэ:

- “SET” товч дарна.
- “1”, “2”, эсвэл “3” товч дарна.
- Суудлын тохиргооны аль нэг товч дарна (зөвхөн суудлын байрлал дахин дуудах үйлдлийг зогсооно).
- Жолооны хүрд тохируулах товч дарна (зөвхөн жолооны хүрдний байрлал дахин дуудах үйлдлийг зогсооно).

■ **Асаах товч унтраасны дараа жолоодлогын байрлал санах ойг ажиллуулах**

Бүртгэгдсэн суудлын байрлалыг жолоочийн хаалга нээснээс 180 секунд, хааснаас 61 секундын дотор дуудах боломжтой.

■ **Бүртгэгдсэн суудлын байрлалыг дахин дуудах боломжгүй нөхцлүүд**

Суудлын заримд байрлалд сануулсан байрлалыг систем дахин дуудах боломжгүй.

Дэлгэрэнгүйг та өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

■ **Хавчихаас хамгаалах функц**

Жолоодлогын байрлал дуудагдах, эсвэл хялбараар бууж суухад туслах систем ажиллах явцад урд суудлын ард талд аливаа эд зүйл гацсан нөхцөлд суудал зогсож бага зэрэг урагш хөдлөнө. Хавчихаас

хамгаалах функц ажилласан үед суудал жолоодлогын санасан байрлалаас өөр байрлалд зогсоно. Суудлын байрлалыг шалгана уу.

■ **Жолоодлогын байрлал дуудах**

Толгойн түшлэг таазанд, эсвэл нарны хаалтад хүрэхээс сэргийлнэ.

Электрон түлхүүрт жолоодлогын байрлал бүртгэх (санах ой дахин дуудах функц)

Миний тохиргоо функц ашиглан электрон түлхүүрийг жолооч дээр бүртгэснээр тухайн байрлал нэг бүрийг автоматаар дуудах боломжтой.

Явж байсан автомашиныг зогсоогоод арааг P байрлалд шилжүүлэх үед тухайн жолоодлогын байрлал бүртгэгдэнэ.

Электрон түлхүүрээс бүртгэсэн жолоочийн байрлал устгах (санах ой дахин дуудах функц)

Миний тохиргоогоор электрон түлхүүрт бүртгэсэн жолооч тус бүрийн жолоодлогын байрлал автоматаар дуудагдах боломжтой.

Миний тохиргоо дахь жолоочийн бүртгэлийн тохиргоог устгана.

Электрон түлхүүрээр бүртгэгдсэн жолоодлогын байрлал дуудах (санах ойн эргэн дуудах функц)

Электрон түлхүүрийн миний тохиргоо функцаар жолооч бүрт бүртгэн жолоодлогын байрлалыг автоматаар дуудах боломжтой.

⚠ АЮУЛТАЙ

Хавчихаас хамгаалах функцийг албаар идэвхжүүлэх зорилгоор гар хуруугаа санаатайгаар хавчуулж болохгүй.

1 **Зөвхөн тухайн хэрэглэгч дээр миний тохиргоо функцаар бүртгэсэн түлхүүр биедээ аван жолоочийн хаалгыг Smart entry & start систем, эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар тайлна.**

Жолооны хүрднээс бусад жолоодлогын байрлал бүртгэгдсэн байрлалд шилжинэ. Нөгөөтэйгүүр автомашинд хялбараар суухад туслах үүднээс жолоочийн суудал бүртгэгдсэн байрлалаас бага зэрэг арагш шилжинэ.

Жолоодлогын байрлал өмнө бүртгэгдсэн байрлалд байгаа үед байрлал шилжихгүй.

2 **Асаах товчийг ACC, эсвэл ON-д шилжүүлнэ.**

Суудал болон жолооны хүрд (зөвхөн асаах товчны ON горимд) бүртгэгдсэн байрлалд шилжинэ.

МЭДЭЭЛЭЛ

Хавчихаас хамгаалах функц

Жолоодлогын байрлал дуудагдаж байгаа, эсвэл хялбараар бууж суухад туслах систем ажиллаж байгаа үед аливаа эд зүйл урд суудлын хойно тээглэсэн нөхцөлд суудлын хөдөлгөөн зогсоод бага зэрэг урагш шилжинэ. Хавчихаас сэргийлэх функц ажиллах үед жолоодлогын байрлал санах системд сануулснаас өөр байрлалд суудал зогсоно. Суудлын байрлалыг нягтлана уу.

Жолоодлогын байрлал дахин дуудах

Толгойн түшлэг тааз, эсвэл нарны хаалтад хүрэхээс сэргийлнэ.

Систем бүрийн ажиллагааг тохируулалгүйгээр тав тухтай орчинг бүрдүүлэх (Агааржуулалтын автомат горим)

Агааржуулалтын системийн температурын тохиргоо, гадна агаарын хэм, бүхээгний хэм зэрэгт нийцүүлэн суудал халаагч, урд суудлын агааржуулагч, жолооны хүрд халаагчийн ажиллагаа автоматаар удирдагдана.*

Агааржуулалтын автомат горим

Агааржуулалтын автомат горим нь агааржуулалтын системийн[**AUTO**] тохиргоонд нийцүүлэн ажиллана.

1. **Сонголтын дэлгэцийн товч дарна.→ X.264**
2. **[Climate concierge] товч сонгоно.**
3. **[AUTO] товчийг асаана.**

Автоматаар удирдах боломжтой функцууд

- Автомат агааржуулалтын систем→ X.263

  Жолооч, урд зорчигчийн талын температурын тохиргоотой уялдан агааржуулалтын системийн ажиллагаа автоматаар удирдагдана.

- Суудал халаагч→ X.273

  Жолооч, урд зорчигчийн талын температурын тохиргоотой уялдан суудал халаагчийн ажиллагаа автоматаар удирдагдана.

  Агааржуулалтын системийн температурын тохиргоо, гадна агаарын хэм зэрэгтэй уялдан суудал халаагч олон суудлын агааржуулагчийн хооронд автоматаар солигдоно.

- Суудлын агааржуулагч→ X.275

  Жолооч, урд зорчигчийн талын температурын тохиргоотой уялдан суудлын агааржуулагчийн ажиллагаа автоматаар удирдагдана.

  Агааржуулалтын системийн температурын тохиргоо, гадна агаарын хэм зэрэгтэй уялдан суудал халаагч олон суудлын агааржуулагчийн хооронд автоматаар солигдоно.

- Жолооны хүрд халаагч→ X.272

  Агааржуулалтын системийн температурын тохиргоо, гадна агаарын хэм зэрэгтэй уялдан жолооны хүрд халаагчийн ажиллагаа автоматаар удирдагдана.

* : Тоноглогдсон автомашинд

МЭДЭЭЛЭЛ

■ **Зорчигч мэдрэх функц**

● Урд зорчигчийн суудал дээр зорчигч мэдрэгдсэн үед суудал халаагч болон суудлын агааржуулагч автоматаар ажиллана.

● Суудал халаагч/суудлын агааржуулагчийн товч AUTO горимд тохируулагдсан үед зорчигч мэдрэх функц ажиллахгүй.

■ **Арын суудал халаагчийн ажиллагаа (арын суудал халаагчтай автомашин)**

Арын суудал халаагч нь агааржуулалтын автомат горимаар удирдагддаггүй.

Агааржуулалтын системийн удирдлагын самбар

[**AUTO**] товч асаалттай үед тохируулсан температурт нийцүүлэн агааржуулалтын хоолой болон сэнсний хурд автоматаар өөрчлөгдөнө. Баруун жолооны хүрдтэй автомашины товчны байрлал болон хэлбэр өөр байж болно. Мөн системийн төрлөөс хамаарч товчны байрлал болон дэлгэц өөр байж болно.

⚠ АНХААР

Хөдөлгүүр унтраастай үед агааржуулалтын системийг шаардлагатай хэмжээнээс удаан ашиглаж болохгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ **Шороо тоостой замаар явах үед**

Бүх цонх хаана. Цонх хаасны дараа бүхээг дотор орсон тоос үлдсэн нөхцөлд гадна агаарын горим сонгож сэнсний хурдыг унтраах горимоос бусад горимд тохируулна.

■ **Гадна агаарын хэм буурсан үед**

[**A/C**] товч дарсан ч чийгшил бууруулах функц ажиллахгүй байж болно.

■ **Агааржуулагч, эйр кондишны үнэр**

- Цэвэр агаар оруулах үед гадна агаарын горимд шилжүүлнэ.
- Агааржуулагч ажиллах үед автомашины гадна болон дотор талаас олон төрлийн үнэр агааржуулагчийн системд орох, хуримтлагдаж болно. Үүнээс шалтгаалж агааржуулагчаас үнэр мэдрэгдэж болно.
- Үнэр үүсэхээс сэргийлэх:
  - Автомашин унтраахаас өмнө гадна агаарын горимд шилжүүлэх нь зүйтэй.
  - Агааржуулалтын систем автомат горимоор ажиллаж эхлэх үед хэсэг хугацаанд үлээхгүй байж болно.
- Автомашиныг зогсоолд байрлуулах үед агаарын солилцоог сайжруулах, автомашин асаах үед үнэр үүсэхээс сэргийлж систем гадна агаарын горимд автоматаар шилжинэ.*

■ **Дуу хоолойн систем ашиглах**

Дуу хоолойн систем ашиглан агааржуулалтын систем удирдах боломжтой. Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

■ **Өөрчлөх боломжтой тохиргоо**

Автомат горимтой холбоотой функцийг ([**AUTO**] товч асаалттай үед) голын дэлгэцний [**Vehicle customise**]-р өөрчлөх боломжтой.

* : Тоноглогдсон автомашинд

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Option дэлгэцийн товч

▶ 14 инчийн голын дэлгэцтэй загвар



A Зүүн талын температурын удирдлагын товч
B Агаарын урсгалын горимын товч
C Option дэлгэцийн товч
D Товчлол дэлгэцийн товч
Функцуудын товчлол тэмдэг гаргах үед сонгоно.
E [**SYNC**] товч
F Баруун талын температурын удирдлагын товч
G [**A/C**] товч
H Гадна агаар/дотор агаарын горимд солих товч
I Сэнсний хурдны удирдлагын товч
J [**OFF**] товч
K [**AUTO**] товч

▶ 9.8 инчийн голын дэлгэцтэй загвар



A Зүүн талын температурын удирдлагын товч
B Агаарын урсгалын горимын товч
C Option дэлгэцийн товч

D Товчлол дэлгэцийн товч

Функцуудын товчлол тэмдэг гаргах үед сонгоно.

E Баруун талын температурын удирдлагын товч

F [**SYNC**] товч

G [**A/C**] товч

H Гадна агаар/дотор агаарын горимд солих товч

I Сэнсний хурдны удирдлагын товч

J [**OFF**] товч

K [**AUTO**] товч

Температур тохируулах

Температур тохируулах хүрдийг цагийн зүүний дагуу эргүүлж температур нэмэх, эсрэг эргүүлж хасна.

[**SYNC**] товчны индикатор ассан үед урд зорчигчийн суудлын температурын тохиргоо жолоочийн суудлын тохиргоотой адил байна.

[**SYNC**] товчны индикатор унтарсан үед [**SYNC**] товч асаавал [**SYNC**] товчны индикатор асч урд зорчигчийн суудлын температур жолоочийн суудлын температурт шилжинэ.

Урд зорчигчийн суудлын температурын тохиргооны товч ажиллах үед [**SYNC**] товчны индикатор унтрах ба урд зорчигчийн суудлын температурын тохиргоог хийх боломжтой болно.

[**A/C**] товчны индикатор унтарсан үед сэнс болон халаагуур ашиглах боломжтой.

Сэнсний хурд тохируулах

Сэнсний хурд нэмэх үед сэнсний хурд тохируулах [**+**] товч, эсвэл дэлгэцний сэнсний хурд тохируулах тэмдгийг баруун тийш хөдөлгөнө. Сэнсний хурд хасах үед сэнсний хурд тохируулах [**-**] товч, эсвэл дэлгэцний сэнсний хурд тохируулах тэмдгийг зүүн тийш хөдөлгөнө.

[**OFF**] товч сонгож сэнс унтраана.

Агаарын урсгалын горим солих

Агаарын урсгалын горимын товч дарна

Товч дарах бүрт агаарын урсгалын горим солигдоно.

Сонгосон агаарын урсгалын горимоос хамаарч үлээх агааржуулагч болон агаарын хэмжээ өөрчлөгдөнө.

: Цээж рүү үлээх

: Цээж болон хөл рүү үлээх

: Хөл рүү үлээх

: Хөл рүү үлээж салхины шилний цан арилгагч ажиллах

МЭДЭЭЛЭЛ

Агааржуулагчийн байрлал



Гадна болон дотор агаарын горимд солих

Хонгил, эсвэл замын ачаалал ихтэй зэргээр бохир агаар салонд нэвтрэхээс сэргийлэх, мөн гадна агаарын хэм өндөр үед салоныг хөргөх үед агаарын горимыг дотор агаарын горимд шилжүүлэх нь тохиромжтой.

Гадна/дотор агаарын горимын товч сонгоно.

Товч дарах бүрт агаарын горим гадна болон дотор агаарын горимд солигдоно. Дотор агаарын горим сонгогдсон үед индикатор асна.

Температурын тохиргоо, бүхээгний хэм зэргээс хамаарч агаарын горим автоматаар солигдож болно.

Урд суудалд төвлөрсөн агаарын урсгалын горим (S-Flow)

Тус функц нь урд суудлууд руу агаарын урсгалыг урд суудалд төвлөрүүлэх байдлаар агааржуулалтын системийг автоматаар удирддаг. Агааржуулалтын системийн шаардлагагүй ажиллагааг бууруулснаар шатахуун зарцуулалт сайжруулна.

Урд суудалд төвлөрсөн агаарын урсгалын горим дараах нөхцөлд ажиллана.

- Арын суудал дээр зорчигч мэдрэгдээгүй
- Салхины шилний цан арилгагч ажиллаагүй

Урд суудалд төвлөрсөн агаарын урсгалын горимд тов даран агаарын урсгалыг зөвхөн урд суудалд төвлөрүүлэх болон бүх суудал руу чиглүүлэх горимд шилжүүлж болно. Тус горимыг гар аргаар идэвхжүүлсэн үед агаарын урсгалын автомат удирдлагын ажиллагаа зогсоно.

1 **Сонголтын дэлгэцийн товч дарна.**

2 **[S-Flow] товч сонгоно.**

- Индикатор ассан: Агаарын урсгал зөвхөн урд суудалд төвлөрнө
- Индикатор асаагүй: Бүх суудал руу агаар үлээнэ

МЭДЭЭЛЭЛ

■ Агаарын урсгалын автомат удирдлагын ажиллагаа

- Салон дахь тав тухтай байдлыг хангах үүднээс зорчигчгүй суудал руу хөдөлгүүр ассан даруйд, мөн гадна агаарын хэмээс шалтгаалж бусад үеүүдэд мөн агаар үлээж болно.
- Хөдөлгүүр ассаны дараа хэрэв зорчигч автомашин дотор шилжиж суусан, эсвэл автомашинд суусан, автомашинаас буусан үед систем зорчигч байгаа эсэхийг нарийн тодорхойлж чадахгүй байх, улмаар агаарын урсгалын автомат удирдлага ажиллахгүй байж болно.

■ Агаарын урсгалын гар удирдлага

Функцийн ажиллагааг гараар зөвхөн урд суудалд төвлөрүүлэхээр тохируулсан ч арын суудалд зорчигч суусан үед агаарын урсгал бүх суудал руу автоматаар чиглэж болно.

Эко агааржуулалтын горимын индикатор

Сэнсний хурд бууруулах зэргээр шатахуун зарцуулалт бууруулах байдлаар агааржуулалтын систем ажиллана.

1 **Сонголтын дэлгэцийн товч дарна.**

2 **[Eco Heat/Cool]-г дарна.**

- Эко жолоодлогын горимд шатахуун зарцуулалтыг бууруулах байдлаар агааржуулалтын систем дараах байдлаар удирдагдана. Агааржуулалтын системийн ажиллагааг нэмэгдүүлэх үед эко агааржуулалтын горимыг унтраана.
  - Халаах/хөргөх хүчин чадлыг хязгаарлах байдлаар хөдөлгүүрийн хурд, компрессорын ажиллагаа удирдагдана.
  - Автомат горим сонгогдсон үед сэнсний хурд хязгаарлагдана.
- Жолоодлогын горимыг эко жолоодлогын горимд тохируулсан үед эко агааржуулалтын горим автоматаар асна. Энэ үед [**Eco Heat/Cool**] товчоор эко агааржуулалтын горимыг унтраах боломжтой.

Салоныг хурдан халаах (Халаагчийн дээд ажиллагаа)

Салоныг хурдан халаах үүднээс [**халаагчийн дээд ажиллагааг**] асаасан даруйд агааржуулалтын системийн ажиллагааны тохиргоо өөрчлөгдөнө.

1 **Товчлох дэлгэц сонгоно.**

2 **[Max heat] товч сонгоно.**

- Агааржуулалтын системийн температур [**Hi**]-д тохиргоонд шилжих ба [**AUTO**] асна.
- Суудал халаагч Hi тохиргоонд тохируулагдана. (суудал халаагчтай автомашин)
- Суудал халаагч Hi тохиргоонд тохируулагдана. (суудал халаагчтай автомашин)
- Дараах нөхцлүүдэд урд зорчигчийн суудал халаагч [**AUTO**] тохиргоонд тохируулагдана. (суудал халаагчтай автомашин)
  - [**Climate concierge**] асаалттай үед
  - Систем урд зорчигчийн суудалд зорчигч байгаа гэж мэдэрсэн үед
- [**SYNC**] товчны индикатор ассан үед урд зорчигчийн талын температурын тохиргоо мөн [**Hi**] тохиргоонд тохируулагдана.

МЭДЭЭЛЭЛ

[Халаагчийн дээд ажиллагаа]

- [**Max heat**] товчоор тус тохиргоог унтраах боломжгүй.
- [**Max heat**] товч ажиллуулсны дараа температурын тохиргоог агааржуулалтын системийн температурын удирдлагын товчоор өөрчлөх боломжтой.
- [**Climate concierge**] асаалттай үед [**AUTO**] товч асаавал температурын тохиргоонд нийцүүлэн урд суудлын суудал халаагч болон суудлын агааржуулагч, жолооны хүрд халаагч автоматаар ажиллана.*
- Функц бүрийг өөрийн хүссэн тохиргоонд тохируулах боломжтой.

Салоныг хурдан хөргөх (Max cool)

[**Max cool**] асаалттай үед салоныг хурдан хөргөх үүднээс агааржуулалтын системийн тохиргоо даруй өөрчлөгдөнө.

1 **Товчлох дэлгэцийн товч дарна.**

2 **[Max cool] товч сонгоно.**

- Агааржуулалтын системийн температурын тохиргоо [**Lo**]-д шилжих ба [**AUTO**] товч асна.

* : Тоноглогдсон автомашинд

- Суудлын агааржуулагч Hi-д тохируулагдана. (суудлын агааржуулагчтай автомашин)
- Дараах нөхцлүүдэд суудал халаагч [**AUTO**]-д тохируулагдана. (суудал халаагчтай автомашин)
  - [**Climate concierge**] асаалттай үед
- Дараах нөхцлүүдэд урд зорчигчийн суудлын суудал халаагч [**AUTO**]-д тохируулагдана. (суудал халаагчтай автомашин)
  - [**Climate concierge**] асаалттай үед
  - Урд зорчигчийн суудал дээр зорчигч байгаа гэж систем мэдэрсэн үед
- [**SYNC**] товчны индикатор асч урд зорчигчийн суудлын температурын тохиргоо [**Lo**]-д тохируулагдана.

МЭДЭЭЛЭЛ

[Max cool]

- Тус тохиргоог [**Max cool**] товчоор унтраах боломжгүй.
- [**Max cool**] товч ажиллуулсны дараа агааржуулалтын системийн температурын удирдлагын товчоор салоны хэмийг тохируулах боломжтой.
- [**Climate concierge**] идэвхтэй үед [**AUTO**] товч дарсан нөхцөлд температурын тохиргоонд нийцүүлэн урд суудлын суудал халаагч, агааржуулагч, мөн жолооны хүрд халаагч автоматаар ажиллана.*
- Функц тус бүрийг мөн хүссэн тохиргоондоо тохируулах боломжтой.

nanoe™ X систем*1*

Агааржуулалтын систем нь nanoe™ үүсгэгчтэй болно. Үүсгэгч нь жолоочийн суудлын захын агааржуулалтын хоолойноос усан тоосонцроор бүрхэгдсэн үл ялиг хүчиллэг nanoe™ ялгаруулж салоныг цэвэр агаараар дүүргэдэг*2.

1 Сонголтын дэлгэцний товч дарна.

2 [nanoe™X] товч сонгоно.

- Сэнс ассан ба сонголтын удирдлагын дэлгэц дээр [**nanoe™X**] сонгогдсон үед nanoe™ X систем идэвхжинэ.

* : Тоноглогдсон автомашинд

*1 : nanoe™ болон nanoe™ нь Панасоник корпорацийн барааны тэмдэгт болно.

*2 : Температур болон чийгшилт, сэнсний хурд болон агаар үлээх чиглэлээс хамаарч nanoe™ X систем бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байж болно.

- Сэнс дараах нөхцөлд ажиллах үед системийн ажиллагаа хамгийн өндөр байна. Дараах нөхцлүүд бүрдээгүй үед системийн ажиллагаа хязгаарлагдана.
  - Цээж рүү үлээх, цээж хөл рүү, эсвэл хөл рүү үлээх хоолой ажиллаж байгаа үед.
  - Жолоочийн суудлын цонхны талын агааржуулалтын хоолой нээлттэй.
- nanoe™ X ялгарч байгаа үед озоны хий бага хэмжээгээр ялгарч болох ба зарим нөхцөлд сулхан үнэртэж болно. Нөгөөтэйгүүр энэ нь ойн агаарт агуулагдах хэмжээний буюу байгальд байх хэвийн хэмжээ бөгөөд хүний биед аливаа нөлөө үзүүлэхгүй.
- Систем ажиллах үед бага хэмжээний дуу гарч болно. Энэ доголдлыг илэрхийлэхгүй.

⚠ АЮУЛТАЙ

■ nanoe™ X үүсгэгч

Өндөр хүчдлийн эд ангитай тул үүсгэгчийг задлах, засварлахыг хориглоно. Үүсгэгчид засвар хийх шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

⚠ АНХААР

■ nanoe™ X-н эвдрэл гэмтлээс сэргийлэх

Жолоочийн хажуу талын агааржуулалтын хоолойд аливаа эд зүйл хийх, ойр орчимд шүршигч ашиглахыг хориглоно. Эдгээр нь үүсгэгчийн хэвийн ажиллагааг алдагдуулж болно.

Агааржуулалтын хоолойн чиглэл өөрчлөх, нээх ба хаах

Дараах үйлдлээр агааржуулалтын хоолойн чиглэл өөрчлөх ба нээж хаана:

▶ Урд гол



1 Агаарын урсгалыг баруун зүүн, дээш доош чиглүүлэх
2 Хүрдийг эргүүлж нээж хаана

▶ Урд хажуу



1 Агаарын урсгалыг баруун зүүн, дээш доош чиглүүлэх
2 Хүрдийг эргүүлж нээж хаана

▶ Хойд



1 Агаарын урсгалыг баруун зүүн, дээш доош чиглүүлэх
2 Хүрдийг эргүүлж нээж хаана

Жолооны хүрд халаагч*

Жолооны хүрдний хажуу талын барих хэсгийг халаана.

⚠ АЮУЛТАЙ

Дараах хүмүүс халаагч асаалттай үед жолооны хүрдтэй харьцаж байхдаа анхаарал болгоомжтой байна:

- Нялх, бага насны хүүхэд, настай хүн, өвчтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүн
- Мэдрэмтгий арьстай хүн
- Ядарч сульдсан хүн
- Согтууруулах ундаа, нойр хүргэдэг эм (нойрны эм, ханиадны эм г.м.) хэрэглэсэн хүн

⚠ АНХААР

Хөдөлгүүр унтраастай үед тус функцийг ашиглаж болохгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ **Ажиллах нөхцөл**

Асаах товчны ON горимд.

Жолооны хүрд халаагч асаах/унтраах

Голын дэлгэц дээр -г сонгоно.

Товч сонгох үед ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдөнө.

AUTO→Hi (2 сегмент асах)→Lo (1 сегмент асах)→Off

Халаагч ажиллах явцад түвшний индикатор (улаан) асна. [**AUTO**] индикатор халаагч автоматаар ажиллах үед асна.

МЭДЭЭЛЭЛ

■ **Өөрчлөх боломжтой тохиргоо**

Жолооны хүрд халаагчийн тохиргоог голын дэлгэцний [**Vehicle customise**]-р тохируулах боломжтой.

*:Тоноглогдсон автомашинд

Суудал халаагч*

Суудлын гадаргууг халаана.

⚠ АЮУЛТАЙ

■ Түлэгдэж гэмтэхээс сэргийлэх

Дараах хүмүүс халаагч асаалттай үед жолооны хүрдтэй харьцаж байхдаа, эсвэл суудал дээр сууж байгаа тохиолдолд анхаарал болгоомжтой байна:

- Нялх, бага насны хүүхэд, настай хүн, өвчтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүн
- Мэдрэмтгий арьстай хүн
- Ядарч сульдсан хүн
- Согтууруулах ундаа, нойр хүргэдэг эм (нойрны эм, ханиадны эм г.м.) хэрэглэсэн хүн

■ Түлэгдэж гэмтэхээс сэргийлэх

Суудал халаагчтай холбоотой дараах анхааруулгыг мөрдөнө:

- Суудал халаагч ашиглах үед суудлын зөөлөвч, бүтээлэг зэргийг суудал дээр тавиж болохгүй.
- Шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэж болохгүй.

⚠ АНХААР

■ Суудал халаагчийг гэмтлээс сэргийлэх

Тэгш бус гадаргатай хүнд зүйл суудал дээр тавихгүй байх, мөн хурц үзүүртэй зүйл (зүү, хадаас г.м.) суудалд хатгахыг хориглоно.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед энэ функцийг ашиглаж болохгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ Ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

Урд суудал халаагч асаах/унтраах

Голын дэлгэц дээр , эсвэл -г сонгоно.

Товч дарах бүрт ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдөнө.

AUTO → Hi (3 сегмент асах) → Mid (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

Суудлын агааржуулагчтай автомашин: Ажиллагааны үед түвшний индикатор (шар) асна.

*: Тоноглогдсон автомашинд

Ажиллагааны үед түвшний индикатор (улаан) асна. [**AUTO**] индикатор автомат ажиллагааны үед асна.

МЭДЭЭЛЭЛ

■ Тохиргоог өөрчлөх

Урд суудал халаагчийн хэмийн тохиргоог голын дэлгэцний [**Vehicle customise**]-р хийх боломжтой.

Арын суудал халаагч асаах/унтраах*

Товч дарна.

Товч дарах бүрт ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдөнө.

Hi (3 сегмент асах) → Mid (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

Суудал халаагч ажиллах үед түвшний индикатор (шар) асна.



* : Тоноглогдсон автомашинд

Суудлын агааржуулагч*

Суудал дотор байрласан сэнс ашиглан суудлын гадаргууг агааржуулна.

⚠ АНХААР

■ Суудал агааржуулагчийг эвдрэл гэмтлээс сэргийлэх

Тэгш бус гадаргуутай аливаа эд зүйл суудал дээр байрлуулах, эсвэл суудал руу хурц үзүүртэй зүйл (зүү, хадаас зэрэг) хатгаж болохгүй.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед тус функцийг ашиглаж болохгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ Ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

Суудлын агааржуулагч (урд) асаах/унтраах

Голын дэлгэц дээр , эсвэл -г сонгоно.

Товч дарах бүрт ажиллагаа дараах байдлаар солигдоно.

Hi (3 сегмент асах) → Mid (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

Ажиллах үед түвшний индикатор (цэнхэр) асна. [**AUTO**] индикатор автомат ажиллагааны үед асна.

МЭДЭЭЛЭЛ

■ Агааржуулалтын системтэй холбоотой удирдлагын горим

Суудлын агааржуулагч Hi горимд сонгогдсон үед агааржуулалтын системийн сэнсний хурдад тохируулан суудал агааржуулагчийн сэнсний хурд нэмэгдэж болно.

■ Тохиргоог өөрчлөх

Суудлын агааржуулагчийн сэнсний хурдыг голын дэлгэцний [**Vehicle customise**]-р тохируулах боломжтой.

4 Салон дахь функц, тоноглолууд

* : Тоноглогдсон автомашинд

Дээврийн нээлхий ашиглах*

Бүхээг дэх тав тухтай мэдрэмжийг бүрдүүлж дээврийн нээлхийг нээх, дээш өргөх боломжтой.

⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Хөдөлгөөний үед аливаа зорчигчийг гар, толгойгоо автомашинаас гадагш гаргуулж болохгүй.
- Дээврийн нээлхийн дээр сууж болохгүй.
- Дээврийн нээлхий нээх, хаах үйлдлийн хариуцлага жолоочид ногддог. Санамсаргүй аюултай үйлдэл, ялангуяа бага насны хүүхдийн үйлдлээс сэргийлэхийн тулд бага насны хүүхдээр нээлхий ажиллуулахыг хориглоно. Хүүхэд, бусад зорчигчид биеийн аль нэг хэсгээ хавчуулж болзошгүй.
- Дээврийн нээлхийг ажиллуулах үед зорчигчдын биеийн аль нэг хэсэг нээлхийд хавчуулагдахаас сэргийлж шалгана.
- Алсын удирдлага, механик түлхүүр ашиглан дээврийн нээлхий ажиллуулахын өмнө бусад зорчигчдын биеийн аль нэг хэсэг нээлхийд хавчуулагдахаас сэргийлж шалгана.

  Мөн бага насны хүүхдээр алсын удирдлага, механик түлхүүр ашиглан дээврийн нээлхий ажиллуулахыг хориглоно. Хүүхэд болон бусад зорчигчид биеийн аль нэг хэсгээ нээлхийд хавчуулж болзошгүй.
- Автомашинд хүүхэд байгаа үед автомашинаас гарахдаа асаах товчийг OFF горимд буцаах ба биедээ түлхүүрээ аван бага насны хүүхдийн хамт автомашинаас гарна. Хүүхэд цонх буруу ажиллуулах, тоглох зэргээс үүдэн осол гарч болзошгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ Дээврийн нээлхий ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Хөдөлгүүр унтраасны дараа дээврийн нээлхий ажиллуулах

Асаах товч ACC эсвэл OFF горимд шилжүүлэн хөдөлгүүр унтрааснаас хойш 45 секундын дотор дээврийн нээлхийг ажиллуулах боломжтой.

Урд талын аль нэг хаалга онгойлгосон бол дээврийн нээлхий ажиллахгүй.

■ Нарны хаалт

Нарны хаалтыг гар аргаар нээж хааж болно. Нөгөөтэйгүүр дээврийн нээлхий нээгдэх үед хаалт автоматаар нээгдэнэ.

*:Тоноглогдсон автомашинд

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Дээврийн нээлхий аюулгүйгээр нээж хаахад туслах функц

Дараах функцууд нь дээврийн нээлхий аюулгүйгээр нээж хаахад туслана.

- Хавчихаас хамгаалах функц

  Дээврийн нээлхий хаагдах, эсвэл өргөсөн нээлхий доош буух үед нээлхий болон араамны завсар эд зүйл мэдрэгдсэн үед нээлхийн хөдөлгөөн зогсож буцаж бага зэрэг нээгдэнэ.

- Дээврийн нээлхий нээлттэй байгааг анхааруулах дохио

  Дээврийн нээлхий нээлттэй үед асаах товч унтрааж жолоочийн хаалга нээхэд дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

⚠ АЮУЛТАЙ

■ Хавчихаас хамгаалах функц

- Хавчихаас хамгаалах функцийн ажиллагааг шалгахын тулд биеэ хавчуулж турших нь аюултай.
- Дээврийн нээлхий бүрэн хаагдахын дөнгөж өмнө хавчуулагдсан эд зүйлийг хавчихаас хамгаалах функц мэдрэхгүй байх магадлалтай.

  Мөн дээврийн нээлхийн товч дарж ажиллуулах явцад хавчихаас хамгаалах функц нь ажиллахгүй.

  Гар хуруу болон бусад эд зүйл хавчуулахгүй байхад анхаарна.

Дээврийн нээлхий нээх

товч дарна.*1

Салхины чимээг багасгах зорилгоор дээврийн нээлхий бүрэн онгойх байрлалаас бага зэрэг дутуу зогсоно.



*1 : Ажиллаж буй дээврийн нээлхийг зогсоох үед товчны аль нэг талыг зөөлөн дарна.

Дээврийн нээлхий хаах

товч дарна.*2



Дээврийн нээлхийг дээш өргөх

товч дарна.*3



Дээврийн нээлхий доош буулгах

товч дарна.*4



*2 : Ажиллаж буй дээврийн нээлхийг зогсоох үед дээврийн нээлхийн товчны аль нэг талыг дарна.

*3 : Дээврийн нээлхийн товчны аль нэг талыг дарж дээврийн нээлхийг зогсооно.

*4 : Дээврийн нээлхийн товчны аль нэг талыг дарж ажиллаж буй дээврийн нээлхийг зогсооно.

Панорамик дээврийн нээлхий ашиглах*

Бүхээг доторх тав тухтай мэдрэмжийг бүрдүүлж панорамик дээврийн нээлхий нээх, дээш өргөх боломжтой.

⚠ АЮУЛТАЙ

Панорамик дээврийн нээлхий нээж хаах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Панорамик дээврийн нээлхий нээх, хаах үйлдлийн хариуцлага жолоочид ногддог. Санамсаргүй аюултай үйлдэл, ялангуяа бага насны хүүхдийн үйлдлээс сэргийлэхийн тулд бага насны хүүхдээр нээлхий ажиллуулахыг хориглоно. Хүүхэд, бусад зорчигчид биеийн аль нэг хэсгээ хавчуулж болзошгүй.
- Панорамик дээврийн нээлхийг ажиллуулах үед зорчигчдын биеийн аль нэг хэсэг нээлхийд хавчуулагдахаас сэргийлж шалгана.
- Алсын удирдлага, механик түлхүүр ашиглан панорамик дээврийн нээлхий ажиллуулахын өмнө бусад зорчигчдын биеийн аль нэг хэсэг нээлхийд хавчуулагдахаас сэргийлж шалгана.

  Мөн бага насны хүүхдээр алсын удирдлага, механик түлхүүр ашиглан дээврийн нээлхий ажиллуулахыг хориглоно. Хүүхэд болон бусад зорчигчид биеийн аль нэг хэсгээ нээлхийд хавчуулж болзошгүй.
- Автомашинаас гарах үед асаах товчийг OFF горимд буцаах ба биедээ түлхүүрээ аван бага насны хүүхдийн хамт автомашинаас гарна. Хүүхэд панорамик дээврийн нээлхий буруу ажиллуулах, тоглох зэргээс үүдэн осол гарч болзошгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ Панорамик дээврийн нээлхийн ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Хөдөлгүүр унтраасны дараа панорамик дээврийн нээлхий ажиллуулах

Асаах товчийг ACC, эсвэл OFF горимд шилжүүлснээс хойш 45 секундын дотор панорамик дээврийн нээлхий ажиллуулах боломжтой.

Урд аль нэг хаалга нээсэн үед панорамик дээврийн нээлхий ажиллахгүй

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

* :Тоноглогдсон автомашинд

Панорамик дээврийн нээлхий аюулгүйгээр нээж хаахад туслах функц

Дараах функцууд нь панорамик дээврийн нээлхий аюулгүйгээр нээж хаахад туслана.

- Хавчихаас хамгаалах функц

  Панорамик дээврийн нээлхий хаагдах, эсвэл бууж байгаа үед нээлхий болон араамны завсар аливаа зүйл хавчуулагдвал нээлхийний хөдөлгөөн зогсох ба бага зэрэг нээгдэнэ.

- Панорамик дээврийн нээлхий нээлттэй байгааг анхааруулах дохио

  Панорамик дээврийн нээлхий нээлттэй үед асаах товч унтрааж жолоочийн хаалга нээсэн нөхцөлд дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

⚠ АЮУЛТАЙ

■ Хавчихаас хамгаалах функц

- Хавчихаас хамгаалах функцийг албаар идэвхжүүлэхийн тулд биеийн аль нэг хэсгээ санаатай хавчуулахыг хориглоно.
- Панорамик дээврийн нээлхий бүрэн хаагдахын дөнгөж өмнө аливаа эд зүйл хавчуулагдвал хавчихаас хамгаалах функц ажиллахгүй байж болно.

  Мөн хавчихаас хамгаалах функц нь дээврийн нээлхийн товч даран ажиллуулж байгаа үед ажиллахгүй.

  Гар хуруу зэргээ хавчуулахаас сэргийлнэ.

Панорамик дээврийн нээлхий нээх

товч дарна.*1

Панорамик дээврийн нээлхийн товчны аль нэг талыг зөөлөн дарж нээгдэж буй нээлхийг зогсооно.



*1 : товч дарах үед панорамик дээврийн нээлхий болон электрон нарны хаалт автоматаар нээгдэнэ.

Панорамик дээврийн нээлхий хаах

Хаах үед товч дарна.*2

Панорамик дээврийн нээлхийг дээш өргөсөн байрлалаас хаах боломжтой.

товчийг урагш дарна. Панорамик дээврийн нээлхий автоматаар бүрэн хаагдана.



Панорамик дээврийн нээлхийг дээш өргөх

товч дарна.*3

Дээврийн нээлхий дээш өргөгдсөн үед электрон нарны хаалт хагас нээгдэнэ.



Панорамик дээврийн нээлхийг доош буулгах

товчийг удаан дарна.

Панорамик дээврийн нээлхийг зөвхөн дээш өргөсөн үед доош буулгах боломжтой.



*2 : Хөдөлж буй панорамик дээврийн нээлхийг зогсоох үед панорамик дээврийн нээлхийн товчны аль нэг талыг хөнгөн дарна.

*3 : Панорамик дээврийн нээлхийн товчны аль нэг талыг дээврийн нээлхий ажиллах үед хөнгөн дарна.

Электрон нарны хаалт нээх хаах*

Бүхээг дэх тав тухтай мэдрэмжийг бүрдүүлэх үүднээс электрон нарны хаалтыг нээх боломжтой.

⚠ АЮУЛТАЙ

Электрон нарны хаалт нээх болон хаах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Нарны хаалт ажиллуулах үед бүх зорчигчид хаалтанд биеээ хавчуулахгүй байрлалд байгааг нягтлана.
- Бага насны хүүхдээр электрон нарны хаалт ажиллуулуулж болохгүй. Хүүхэд өөртөө болон бусад амь нас, эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах аюултай.
- Дээвэр болон электрон нарны хаалтны завсар гар хуруугаа хийж болохгүй.

  Гараа хавчуулж гэмтэх аюултай. Мөн нарны шууд тусгалт автомашиныг удаан хугацаанд орхисон үед дээвэр өндөр хэмд халж түлэгдэх аюултай.

МЭДЭЭЛЭЛ

■ Электрон нарны хаалтын ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Хөдөлгүүр унтарсны дараа электрон нарны хаалт ажиллуулах

Асаах товчийг ACC, эсвэл OFF горимд шилжүүлснээс 45 секундын дотор электрон нарны хаалтыг ажиллуулах боломжтой.

Нөгөөтэйгүүр аль нэг урд хаалга нээсэн үед хаалт ажиллахгүй.

Электрон нарны хаалт аюулгүйгээр нээх, хаахад туслах функц

Дараах функц нь электрон нарны хаалт аюулгүйгээр нээх, хаахад туслана.

Хавчихаас хамгаалах функц

Электрон нарны хаалт хаагдах үед нарны хаалт болон араамны завсар аливаа зүйл хавчуулагдвал электрон нарны хаалтын хөдөлгөөн зогсох ба бага зэрэг буцаж нээгдэнэ.

Хавчихаас хамгаалах функц ажилласан үед товчны талыг дахин дарсан ч буцаж нээгдэх үйлдэл дуусах хүртэл электрон нарны хаалт хаах чиглэлд хөдлөхгүй.

Жолоодлогын болон орчны нөхцөл байдлаас хамаар электрон нарны хаалт аливаа эд зүйлтэй тулах, улмаар эсрэг чиглэлд ажиллаж болно.

*: Тоноглогдсон автомашинд

⚠ АЮУЛТАЙ

- Хавчихаас хамгаалах функцийг албаар идэвхжүүлэх үүднээс гар, биеээ хавчуулж болохгүй.
- Хавчихаас хамгаалах функц нь электрон нарны хаалт бүрэн хаагдахын дөнгөж өмнө аливаа зүйл хавчуулагдвал ажиллахгүй байж болно.

  Мөн хавчихаас хамгаалах функц нь дээврийн нээлхийн товч дарж байгаа үед ажиллахаар хийгдээгүй.

  Гар хуруу зэргээ хавчуулахаас сэргийлнэ.

Электрон нарны хаалт нээх

товч дарна.

Электрон нарны хаалт нээгдэнэ.

товчийг удаан дарсан үед электрон нарны хаалт автоматаар бүрэн нээгдэнэ.*1



Электрон нарны хаалтыг хаах

товч дарна.

Электрон нарны хаалт хаагдана.

товчийг үргэлжлүүлэн дарсан үед электрон нарны хаалт автоматаар бүрэн хаагдана.*2



*1 : Ажиллаж буй нарны хаалтыг зогсоох үед товчны аль нэг талыг хөнгөн дарна.

*2 : Электрон нарны хаалт ажиллах үед товчны аль нэг талыг дарж хаалтыг зогсооно.

Салоны гэрэл ашиглах

Салоны гэрлийн байрлал



A Арын салоны гэрэл
B Урд салоны гэрэл
C Хувийн гэрэл
D Хаалганы дотор хавтасны гэрэл*
E Хаалганы дотор бариулын гэрэл*1
F Хаалганы гэрэл*
G Урд голын жижиг хайрцагны гэрэл**1
H Гадна хөлийн гэрэл
I Хөлийн гэрэл*1

- Асаах товчны ON горимд хаалганы дотор хавтасны гэрэл, хаалганы дотор бариулын гэрэл, урд голын жижиг хайрцагны гэрэл, хөлийн гэрэл асна. Нөгөөтэйгүүр хянах самбарын гэрлийн удирдлагын товчийг хамгийн багад тохируулсан үед хөлийн гэрэл унтарна.
- Арааны хөшүүрэг P-с өөр байрлалд байгаа үед хаалганы дотор хавтасны гэрэл, хаалганы дотор бариулын гэрэл, урд голын жижиг хайрцагны гэрэл, хөлийн гэрэл бүдэгрэнэ.

* : Тоноглогдсон автомашинд

1 : Гэрлийн өнгийг мөн солих боломжтой. Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

МЭДЭЭЛЭЛ

■ Гэрэл тус бүр автоматаар асах/унтрах

- Entry системийн гэрэл: Асаах товчны горим, электрон түлхүүр байгаа эсэх, хаалга түгжигдсэн эсэх, хаалга хаалттай эсэхээс хамаарч гэрэл автоматаар асч унтарна.
- Асаах товчийг OFF горимд шилжүүлсэн ба салоны гэрлүүд асах горимд асч байгаа үед гэрэл автоматаар 20 орчим минутын дараа унтарна.

■ Салоны гэрлүүд автоматаар асах

Аль нэг SRS аюулгүйн дэр дэлгэгдсэн, эсвэл хойд талаараа хүчтэй мөргөлтөнд өртсөн үед салоны гэрлүүд автоматаар асна. Салоны гэрлүүд 20 минутын дараа автоматаар унтарна.

Салоны гэрлийг гараар унтраах боломжтой. Нөгөөтэйгүүр дахин мөргөлт үүсэхээс сэргийлж аюулгүй байдлыг баталгаажуулах хүртэл гэрлийг асаалттай байлгах нь зүйтэй. (Мөргөлтийн хүч, нөхцөл байдлаас хамаарч салоны гэрлүүд автоматаар асахгүй байж болно.)

⚠ АНХААР

■ Гэрлийн линз салгах

Линз гэмтэх тул урд салоны гэрэл болон хувийн гэрлийн линзийг салгаж болохгүй. Линз салгах шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед аккумуляторын цэнэг суухаас сэргийлж салоны гэрлийг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн асааж болохгүй

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

Салоны гэрлүүд

МЭДЭЭЛЭЛ

■ Урд салоны гэрлүүд хэвийн ажиллахгүй нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд урд салоны гэрлүүд хэвийн ажиллахгүй байж болно:

- Ус, шавар зэрэг линзны гадаргуу дээр тогтсон
- Нойтон гараар ажиллуулсан
- Бээлий зэргийг өмссөн

Салоны гэрлийг асаах/унтраах



Гэрэл дээр гараар хүрнэ.

Салоны урд гэрэл гараар хүрэх бүрт асч унтарна.

Салоны арын гэрэл мөн асч унтарна.

Нөгөөтэйгүүр салоны арын гэрэл асаалттай үед тус гэрэл салоны урд гэрлийн ажиллагаагаар ажиллахгүй.

Урд салоны гэрлийн ажиллагааг хаалга нээх/хаахтай холбох



DOOR товч дарна.

DOOR товч дарах бүрт урд салоны гэрлийн хаалгатай холбоотой ажиллаагаа ON/OFF горимд шилжинэ.

Арын салоны гэрлийн ажиллагаа мөн хаалга нээх/хаахтай холбогдоно.

Тохиргоо On горимд шилжих үед A индикатор асна.

Арын салоны гэрлийг асаах/унтраах



товч дарна.

товч дарах бүрт арын салоны гэрэл асч унтарна.

Урд салоны гэрэл асч унтрах ажиллагаатай холбоотой арын салоны гэрлийн асч унтрах ажиллагаа.

Арын салоны гэрлийг урд салоны гэрлийн асч унтрах ажиллагаагаар асаасан үед товч дарсан ч арын гэрэл унтрахгүй.

Хувийн гэрэл

МЭДЭЭЛЭЛ

■ Хувийн гэрэл хэвийн ажиллахгүй нөхцлүүд

Дараах нөхцөлд хувийн гэрэл хэвийн ажиллахгүй:

- Линзний гадаргуу дээр ус, шороо тоос зэрэг тогтсон үед
- Нойтон гараар ажиллуулсан үед
- Бээлий зэргийг өмссөн үед

Хувийн гэрэл ашиглах

Гэрэл дээр гараар хүрнэ.

Хүрэх бүрт хувийн гэрэл асна/унтарна.



Хайрцаг тавиурны байрлал

⚠ АЮУЛТАЙ

Хайрцагт нүдний шил, асаагуур, шүршдэг лааз зэргийг үлдээвэл бүхээг хэт халуун болох үед дараах нөхцөл байдал үүсгэж болох тул үлдээж болохгүй:

- Хайрцаг дахь өөр эд зүйлтэй нийлсэн үед нүдний шил хагарах, эсвэл халуунаас шалтгаалан хэлбэр алдаж болно.
- Асаагуур, шүршдэг лааз дэлбэрч болно. Асаагуур бусад зүйлтэй нийлсэн үед асах, хий ялгаруулах зэргээр галын аюул үүсгэнэ.



A Урд хайрцаг
B Туслах хайрцаг
C Карт хадгалагч
D Ундааны тавиур
E Голын хайрцаг
F Аяганы тавиур
G Зоосны хайрцаг

МЭДЭЭЛЭЛ

■ Урд хайрцаг болон голын хайрцагны гэрэл

Урд хайрцаг болон голын хайрцагны гэрэл нь оврын гэрэл асаах үед асна.

Туслах хайрцаг ашиглах

Таг дээр дарна.

▶ A төрөл



⚠ АЮУЛТАЙ

- 200г (0.44 lb.)-с хүнд эд зүйл хадгалж болохгүй. Эсрэг тохиолдолд туслах хайрцаг онгойж доторх эд зүйл унаж осолд хүргэх аюултай.
- Хөдөлгөөний үед, эсвэл туслах хайрцаг ашиглаагүй үед хаалттай байлгана. Огцом тоормос, эргэлт, ослын үед хайрцаг доторх эд зүйлсэд жолооч, зорчигчид цохигдох аюултай.

Тагийг дарна.

Тагийг дараад суллан хаана.

▶ B төрөл



⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгөөний үед, эсвэл туслах хайрцаг ашиглаагүй үед хаалттай байлгана. Огцом тоормос, эргэлт, ослын үед хайрцаг доторх эд зүйлсэд жолооч, зорчигчид цохигдох аюултай.

Карт тогтоогчийн байрлал



Урд хайрцаг ашиглах

⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгөөний үед, эсвэл урд хайрцаг ашиглаагүй үед хаалттай байлгана.

Нээлттэй орхисон үед огцом тоормос, эргэлтийн үед урд зорчигч урд хайрцагны таганд цохигдох, эсвэл доторх эд зүйл шидэгдэж осолд хүргэх аюултай.

Бариулнаас татаж урд хайрцаг нээнэ. Урд хайрцгийг механик түлхүүрээр түгжих, тайлах боломжтой.



1 Бариулнаас татаж урд хайрцаг нээнэ.
2 Механик түлхүүрээр түгжинэ.
3 Механик түлхүүрээр түгжээ тайлна.

МЭДЭЭЛЭЛ

■ Урд хайрцагны гэрэл

Оврын гэрэл асаалттай үед урд хайрцагны гэрэл асна.

Аяганы тавиур ашиглах

⚠ АЮУЛТАЙ

Аяганы тавиурт аяга, эсвэл хөнгөн цагаан лаазнаас бусад зүйл хийж болохгүй.

Бусад зүйл нь осол, огцом тоормосны үед аяганы тавиураас шидэгдэж бэртэл гэмтэлд хүргэх аюултай.

Боломжтой үед түлэгдэхээс сэргийлж халуун уух зүйлийг таглана.

▶ Урд



▶ Хойд



Тохойн түшлэгийг доош буулгана.

Ундааны савны тавиурын байрлал

⚠ АНХААР

Ундааны савны тавиур ашиглах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Дотроо шингэнтэй нээсэн лонх, шилэн аяга, цаасан аягыг ундааны савны тавиур дээр тавиж болохгүй.

  Шингэн асгарах, мөн шилэн аяга хагарах аюултай.
- Лонх байрлуулах үед таглана.

▶ Урд



▶ Хойд



МЭДЭЭЛЭЛ

■ **Ундааны савны тавиур**

Ундааны савны хэлбэр хэмжээнээс хамаарч тавиурт багтахгүй байж болно.

Голын хайрцаг ашиглах

⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгөөний үед, эсвэл ашиглаагүй үед голын хайрцаг хаана.

Хайрцаг онгорхой үед огцом тоормос, эргэлтийн үед жолооч, зорчигч голын хайрцагны таганд цохигдох, эсвэл доторх эд зүйл шидэгдэж осолд хүргэх аюултай.

Товчийг дарангаа тагийг өргөж голын хайрцаг нээнэ.

Голын хайрцгийг 2 талаас онгойлгох боломжтой.



МЭДЭЭЛЭЛ

■ **Голын хайрцагны гэрэл**

Оврын гэрэл асаах үед голын хайрцагны гэрэл асна.

Зоосны хайрцаг ашиглах



Товчийг дарж хайрцагны таг нээнэ.

⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгөөний үед, эсвэл зоосны хайрцаг ашиглаагүй үед хаана.

Таг нээлттэй үед огцом тоормос, эргэлтийн үед жолооч хайрцагны таганд цохигдох, эсвэл доторх эд зүйл шидэгдэж осол аваар үүсгэх аюултай.

Салоны хэрэгцээтэй функцууд

USB цэнэглэх портын функц болон ажиллагаа

⚠ АНХААР

■ **USB цэнэглэх портыг гэмтлээс сэргийлэх**

- Портод гадны биет хийж болохгүй.
- Порт руу ус, бусад шингэн асгаж болохгүй.
- Арын голын хайрцаг: USB цэнэглэх порт ашиглаагүй үед тагийг таглана. Гадны биет, эсвэл шингэн порт руу орсон үед богино холболт үүсч болзошгүй.
- USB цэнэглэх портод их хүчээр нөлөөлөх, хүчтэй цохилтоос сэргийлнэ.
- USB цэнэглэх портыг задлах, өөрчлөхийг хориглоно.

■ **Зөөврийн төхөөрөмжийг гэмтлээс сэргийлэх**

- Зөөврийн төхөөрөмжийг автомашинд үлдээж болохгүй. Бүхээг доторх хэм нэмэгдэж зөөврийн төхөөрөмжийг гэмтээж болно.
- Зөөврийн төхөөрөмж, холбоотой кабель дээр хэт хүчээр дарах, татахыг хориглоно.

■ **Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх**

Хөдөлгүүр унтраастай үед USB цэнэглэх порт шаардлагагүй хэмжээнээс удаан ашиглаж болохгүй.

USB цэнэглэх порт нь 3.0 ампер, 5 вольтийн цахилгаанаар зөөврийн төхөөрөмжийг цэнэглэдэг.

USB цэнэглэх порт нь зөвхөн цэнэглэх зориулалттай. Порт нь дата өгөгдөл дамжуулах, бусад зорилгоор ашиглагдах боломжгүй.

Зөөврийн төхөөрөмжөөс хамаарч хэвийн цэнэглэхгүй байж болно. USB цэнэглэх порт ашиглахаас өмнө зөөврийн төхөөрөмжийн гарын авлагыг уншина уу.

МЭДЭЭЛЭЛ

■ **USB цэнэглэх порт ашиглах боломжтой нөхцлүүд**

Асаах товч ACC, эсвэл ON горимд байгаа.

■ **USB цэнэглэх порт хэвийн ажиллахгүй нөхцлүүд**

- Зөөврийн төхөөрөмж 3.0 ампер, 5 вольтоос илүү цахилгаан хэрэглээтэй.
- USB санах ой зэрэг компьютертой холбох төхөөрөмж холбосон
- Холбосон зөөврийн төхөөрөмж унтраастай байгаа (төхөөрөмжөөс хамаарна)
- Наранд удаан зогссон зэргээр бүхээгний хэм хэт өндөр үед

■ **Холбосон зөөврийн төхөөрөмжийн тухай**

Зөөврийн төхөөрөмжөөс хамаарч цэнэглэлт түр зогсоод дахин цэнэглэгдэж болно. Энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.

USB цэнэглэх порт ашиглах

▶ Хянах самбар



▶ Хойд голын хайрцаг дээр



Таг нээнэ.

Цахилгааны залгуурын функц болон ажиллагаа (12 VDC)

⚠ **АНХААР**

■ **Цахилгааны залгуурыг гэмтлээс сэргийлэх (12 VDC)**

- Залгуурт гадны биет хийж болохгүй.
- Ус болон бусад шингэн асгаж болохгүй.
- Цахилгааны залгуурыг (12 VDC) ашиглаагүй үед таглана. Залгуурт гадны эд зүйл, шингэн орсон үед богино холболт үүсгэх аюултай.
- Цахилгааны залгуурт их хүчээр нөлөөлөх цохилтонд өртөхөөс сэргийлнэ.

■ **Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх**

Хөдөлгүүр унтраастай үед цахилгааны залгуурыг (12 VDC) удаан ашиглаж болохгүй.

Цахилгаан залгуурт 12 VDC/10 A (120 W чадалтай) хүртэл цахилгаан хэрэгсэл залгаж ашиглана.

Олон цахилгаан хэрэгсэл ашиглах үед бүх хэрэгслийн нийт чадал 120 W-с бага байна.

МЭДЭЭЛЭЛ

■ Цахилгааны залгуур ашиглах боломжтой нөхцөл

Асаах товч ACC, ON горимд байгаа.

■ Хөдөлгүүр унтраах үед

Зөөврийн зай хураагуур зэрэг цэнэглэх функцтай электрон төхөөрөмжийг салгана.

Холбоотой орхисон тохиолдолд асаах товч дарсан ч хөдөлгүүр хэвийн унтрахгүй байж болно.

Цахилгааны залгуур ашиглах (12 VDC)

▶ Голын хайрцагны ар талд



Тагийг нээнэ.

▶ Тээшний хэсэгт



Тагийг нээнэ.

Утасгүй цэнэглэгчийн функц болон ажиллагаа

Wireless Power Consortium-н Qi стандартад нийцсэн утасгүй цэнэглэх технологитой ухаалаг утас, зөөврийн зай хураагуур зэргийг цэнэглэх хэсэгт байрлуулан цэнэглэх боломжтой.

⚠ АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үеийн анхааруулга

Зөөврийн төхөөрөмжийг жолоодлогын үед цэнэглэх нөхцөлд аюулгүйн үүднээс жолооч зөөврийн төхөөрөмжийг ажиллуулж болохгүй.

■ Хөдөлгөөний үед

Утасгүй чихэвч зэрэг жижиг, хөнгөн зөөврийн төхөөрөмжийг жолоодлогын үед цэнэглэж болохгүй. Эдгээр нь цэнэглэх тавиурнаас шидэгдэх аюултай.

■ Электрон төхөөрөмжинд учруулах долгионы нөлөөллийн тухай анхааруулга

Дотуур суулгасан дефибриллятор, кардиостимулятор /зохиомлоор зүрхний хэмнэл удирдагч/, мөн бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн өөрийн эмчид хандаж утасгүй цэнэглэгч ашиглалттай холбоотой зөвлөгөө авна.

Утасгүй цэнэглэгчийн ажиллагаа эмчилгээний төхөөрөмжинд нөлөөлж болно.

■ Бэртэл гэмтэл, түлэгдлээс сэргийлэх

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- Цэнэглэх хэсэг болон зөөврийн төхөөрөмжийн завсар аливаа металл эд зүйл хийж болохгүй.
- Цэнэглэх хэсэгт хөнгөн цагаан наалт, эсвэл бусад металл эд зүйл нааж болохгүй.
- Зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх тавиуртай харьцах гадаргууд (эсвэл хамгаалалтын гэрт) хөнгөн цагаан наалт, эсвэл металл эд зүйл нааж болохгүй.
- Цэнэглэх тавиурыг жижиг эд зүйл тавих тавиур болгон ашиглахгүй.
- Утасгүй цэнэглэгчийг хүчтэй цохилтоос сэргийлнэ.
- Утасгүй цэнэглэгчийг задлах, салгах, өөрчлөхийг хориглоно.
- Qi стандартыг дэмждэггүй зориулалтын биш зөөврийн төхөөрөмж цэнэглэж болохгүй.
- Утасгүй цэнэглэгчид соронзтой эд зүйл ойртуулж болохгүй
- Цэнэглэх хэсэг бохирдсон үед цэнэглэж болохгүй
- Зөөврийн төхөөрөмж ашиглаагүй үед гадны биет, эсвэл шингэн хүрэхээс сэргийлж таглана.
- Цэнэглэх үед утасгүй цэнэглэгчийг даавуу, бусад зүйлээр хучиж болохгүй.

⚠ АНХААР

■ Дата өгөгдөл гэмтээх, ажиллаагүй болгохоос сэргийлэх

- Утасгүй цэнэглэгч ашиглах үед соронзон орны нөлөөгөөр дата устах тул кредит карт зэргийн соронзон карт, соронзон бичлэгтэй төхөөрөмжийг цэнэглэгчид ойртуулж болохгүй.

  Мөн бугуйн цаг зэргийн нарийн хийцтэй механизм нь эвдэрч болох тул ойртуулж болохгүй.
- Замын IC карт зэрэг зайнаас ажилладаг IC картыг цэнэглэх хэсэг болон зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх талын завсар хийж болохгүй. IC чип хэт халж зөөврийн төхөөрөмж, эсвэл IC карт гэмтээж болзошгүй. Зөөврийн төхөөрөмжийг хамгаалалтын гэрээс гаргалгүй цэнэглэх, эсвэл төхөөрөмжид зайнаас ажилладаг IC тогтоосон үед цэнэглэхээс сэргийлнэ.

  Зайнаас унших боломжтой ухаалаг карт хийх боломжтой хамгаалалтын гэртэй зөөврийн төхөөрөмж цэнэглэж огт болохгүй.
- Зөөврийн төхөөрөмжийг автомашин дотор үлдээж болохгүй. Нартай үед автомашины бүхээг дотор хэт халж төхөөрөмжинд гэмтэл учруулах магадлалтай.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед утасгүй цэнэглэгчийг шаардлагатай хэмжээнээс удаан ашиглахгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ Утасгүй цэнэглэгч ашиглах боломжтой нөхцөл

Асаах товч ACC, эсвэл ON горимд байгаа.

■ Холбосон зөөврийн төхөөрөмжийн тухай

- Qi стандартад нийцсэн утасгүй цэнэглэх технологитой зөөврийн төхөөрөмжийг цэнэглэж болно. Нөгөөтэйгүүр Qi стандартад нийцсэн зарим төхөөрөмжийг цэнэглэх боломжгүй байж болно.
- Утасгүй цэнэглэгч нь гар утас, ухаалаг утас зэрэг 5W хүртэлх бага чадалтай төхөөрөмжид зориулагдсан болно.
- Эсрэг тохиолдолд галын аюултай. Нөгөөтэйгүүр 5W-с илүү чадалтай дараах зөөврийн төхөөрөмжийг цэнэглэх боломжтой.
  - 7.5 W-р цэнэглэдэг iPhone-г 7.5 хүртэлх ваттаар цэнэглэх.
  - WPC стандартын Ver1.2.4 хувилбарыг дэмждэг зөөврийн төхөөрөмжийг 10 хүртэлх ваттаар цэнэглэх.

■ Smart entry & start систем ашиглах

Цэнэглэх үед Smart entry & start систем элэктрон түлхүүр хайсан үед цэнэглэлт түр цуцлагдаж болно.

■ **Зөөврийн төхөөрөмжинд хамгаалалтын гэр, чимэглэл хийсэн үед**

Зөөврийн төхөөрөмжинд Qi технологи дэмжихгүй хамгаалалтын гэр, чимэглэл хийсэн үед цэнэглэж болохгүй.

Төхөөрөмж “Qi” технологи дэмждэг байсан ч цэнэглэгдэхгүй байж болно. (→ X.300)

■ **Цэнэглэх үеийн анхааруулга**

Цэнэглэх үед утасгүй цэнэглэгч, зөөврийн төхөөрөмж халж болно. Энэ нь доголдол биш болно.

Цэнэглэх үед зөөврийн төхөөрөмж халсан нөхцөлд зөөврийн төхөөрөмж хамгаалах функц цэнэглэлтийг зогсооно. Төхөөрөмж хөрөх хүртэл хүлээгээд дахин цэнэглэнэ.

Утасгүй цэнэглэгчийн дотор хэмийг бууруулах сэнс ажиллаж болно. Энэ нь доголдол биш болно.

■ **Ажиллагааны үеийн дуу**

Асаах товчийг ACC, эсвэл ON горимд шилжүүлэх, мөн зөөврийн төхөөрөмж таних үед ажиллагааны дуу гарч болно. Энэ нь доголдол биш болно.

■ **“Qi” тэмдэг**

“Qi” тэмдэг нь Wireless Power Consortium-н барааны тэмдэгт болно.

Утасгүй цэнэглэгчийн эд ангийн нэр



A Ажиллагааны индикатор
B Цэнэглэх хэсэг
C Цэнэглэх тавиур

Утасгүй цэнэглэгч ашиглах

● **Цэнэглэх тавиур дээр зөөврийн төхөөрөмжийг байрлуулна.**



Зөөврийн төхөөрөмжөөс хамаарч цэнэглэх ороомог төхөөрөмжийн голд байхгүй байж болно. Энэ нөхцөлд зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх ороомог цэнэглэх тавиурыг голлох байдлаар байрлуулна.

Цэнэглэх үед ажиллагааны индикатор (шаргал) асна.

Цэнэглэгдэхгүй үед зөөврийн төхөөрөмжийг цэнэглэх тавиурын төв рүү ойртуулж тавина.

Цэнэглэлт дууссан үед цэнэглэх тавиурын ажиллагааны индикатор (ногоон) асна.

МЭДЭЭЛЭЛ

■ **Цэнэглэх үеийн AM радио дамжуулах функц**

● Цэнэглэх үед AM радионд шуугиан үүсч болно. Энэ нөхцөлд цэнэглэх давтамж шуугиан бууруулах үүднээс автоматаар өөр давтамжинд шилжинэ.

● AM радио станц автоматаар хайх үед цэнэглэх үеийн шум радио станц гэж танигдахаас сэргийлж цэнэглэлтийг түр цуцлана. Радио станц хайх үйлдэл дуусах үед цэнэглэлт эхлэнэ.

■ **Дахин цэнэглэх функц**

● Цэнэглэлт дууссанаас хойш тодорхой хугацаа өнгөрсөн ба зөөврийн төхөөрөмжийг аваагүй үед утасгүй цэнэглэгч дахин цэнэглэж эхэлнэ.

● Цэнэглэх хэсэг дотор зөөврийн төхөөрөмжийг бага зэрэг хөдөлгөсөн үед ороомог салж цэнэглэлт түр зогсож болно. Нөгөөтэйгүүр цэнэглэх ороомог цэнэглэх хэсэг дотор танигдсан үед ороомог утасгүй цэнэглэгч дотор өөр ороомог руу хөдөлж цэнэглэлт дахин эхлэнэ.

■ **Хурдан цэнэглэх функц**

Дараах зөөврийн төхөөрөмжүүд хурдан цэнэглэх боломжтой.

● WPC Ver1.2.4 EPP (Extended Power profile)-г хангасан хурдан цэнэглэх боломжтой төхөөрөмж

● 7.5 W-р цэнэглэх боломжтой iPhone (iPhone 8-с хойших)

■ **Утасгүй цэнэглэгч зөв ажиллахгүй байх нөхцлүүд**

Дараах нөхцлүүдэд утасгүй цэнэглэгч зөв ажиллахгүй байж болно:

● Зөөврийн төхөөрөмж бүрэн цэнэглэгдсэн

● Зөөврийн төхөөрөмж утасгүй холболтоор цэнэглэгдэж байгаа.

- Цэнэглэх хэсэг болон зөөврийн төхөөрөмжийн завсар гадны биет орсон
- Цэнэглэх үед зөөврийн төхөөрөмж халсан
- Цэнэглэх тавиурын ойр орчмын хэм нар туссан зэргээр 35°C (95°F)-с давж халсан.
- Зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх талыг дээш харуулан тависан
- Цэнэглэх хэсэг дээр зөөврийн төхөөрөмж голлоогүй
- Зөөврийн төхөөрөмж цэнэглэх тавиураас том
- Зөөврийн төхөөрөмжийг цэнэглэх хэсгийн гадна байрлуулсан
- Телевизийн цамхаг, цахилгаан станц, ШТС, радио станц, том дэлгэц, нисэх буудал, эсвэл бусад хүчтэй радио долгион, цахилгааны шум үүсгэдэг байгууламжийн ойр орчимд байгаа үед
- Дараах аль нэг зүйл зөөврийн төхөөрөмжинд тогтоосон, эсвэл цэнэглэх хэсгээс 2 мм (0.08 in.)-с их зайтайгаар зөөврийн төхөөрөмжийг цэнэглэх хэсгээс тусгаарлах зүйл байгаа үед:
  - Зузаан гэр ,эсвэл хайрцаг
  - Зузаан чимэглэл
  - Цэнэглэх талдаа ховилтой, зузаан нь тэгш бус гэр, хамгаалалтын хайрцаг
  - Хурууний цагираг, утасны оосор зэрэг чимэглэл.
- Зөөврийн төхөөрөмж дараах аль нэг металл эд зүйлд хүрсэн, эсвэл дотор байгаа үед:
  - Хөнгөн цагаан ялтас зэргээр бүрээстэй карт
  - Хөнгөн цагаан ялтастай тамхины хайрцаг
  - Металл түрийвч, эсвэл цүнх
  - Зоос
  - Металл материалаар хийгдсэн өөрөө халдаг гар дулаацуулагч
  - CD, DVD зэрэг медиа
  - Металл чимэглэл, тоноглол
  - Металл хамгаалалтын гэр зэрэг
- Ойр орчимд электрон долгион ашигладаг алсын удирдлага ашиглагдсан үед
- Цэнэглэх тавиурт 2-с олон зөөврийн төхөөрөмж байрлуулсан үед

Цэнэглэлт хэвийн бус хийгдэх, бусад аливаа шалтгаанаар индикатор анивчиж байгаа үед утасгүй цэнэглэгч доголдсон байж болно. Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

Та өөрийн Lexus дилерт хандана уу.

Утасгүй цэнэглэгчийн ажиллагааны индикатор

Ажиллагааны индикатор нь утасгүй цэнэглэгчийн ажиллагааны горимыг дараах байдлаар илтгэнэ:

Ажиллагааны индикатор		Ажиллагааны горим
Цэнэглэх тавиур	Голын дэлгэц	
Off	Off	Утасгүй цэнэглэгч унтраастай
Ногоон (асах)	Саарал	Хүлээлгийн горим (цэнэглэх боломжтой)(1)
		Цэнэглэж дууссан(2)
Шаргал (асах)	Цэнхэр	Цэнэглэх хэсэг дээр төхөөрөмж тавих үед (зөөврийн төхөөрөмж таних)
		Дараах зөөврийн төхөөрөмж нь хурдан цэнэглэх функц дэмждэг ● WPC Ver1.2.4 дэмждэг ба хурдан цэнэглэх функцтай зөөврийн төхөөрөмж ● 7.5 W-р цэнэглэх iOS-той iPhone гар утас (iPhone 8-с хойших загвар)

(1) Хүлээлгийн горимд цэнэг шахахгүй. Тус горимд цэнэглэх тавиур дээр металл эд зүйл байрлуулсан ч халахгүй.

(2) Зөөврийн төхөөрөмжөөс хамаарч цэнэглэж дууссан ч индикатор шаргал өнгөөр асч болно.

Гарын түшлэг ашиглах

⚠ АНХААР

Гарын түшлэг дээр хэт их даралт учруулж болохгүй. Гарын түшлэгийг гэмтээх аюултай.



● **Гарын түшлэгийг доош буулгана.**

Туслах бариулын ашиглалт

⚠ АЮУЛТАЙ

Туслах бариулыг автомашинд суух, автомашинаас буух болон суудлаас босох үед ашиглаж болохгүй.

⚠ АНХААР

Эвдрэл гэмтлээс сэргийлж туслах бариуланд хүнд зүйл өлгөх болон байрлуулж болохгүй.

Таазанд байрлах туслах бариулыг суудал дээр суух үед биеийн тэнцвэрээ хадгалах зориулалтаар ашиглана.



Хувцасны дэгээний байрлалууд

⚠ АЮУЛТАЙ

Хувцасны өлгүүр, бусад хатуу, хурц өнцөгтэй зүйл дэгээнд өлгөхийг хориглоно. SRS хөшигөн аюулгүйн дэр дэлгэгдэх үед эдгээр нь шидэгдэж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

Хувцасны дэгээ нь арын суудлын туслах бариуланд байрладаг.



Гоо сайхны толь ашиглах

● Тагийг хажуу тийш хөдөлгөн нээнэ.

Таг нээх үед гоо сайхны толины гэрэл асна.



⚠ АНХААР

Хөдөлгүүр унтраастай үед гоо сайхны толины гэрлийг шаардлагатай хэмжээнээс удаан асааж болохгүй. Аккумуляторын цэнэг сууна.

МЭДЭЭЛЭЛ

■ Гэрэл автоматаар унтраах функц

Асаах товч унтраасан үед гоо сайхны толины гэрэл асаалттай байгаа нөхцөлд гэрэл 20 минутын дараа автоматаар унтарна.

Тээш бэхлэх дэгээ ашиглах

Тээш бэхлэх дэгээг ачаа тээшийг бэхлэх үед ашиглана.

● **Дэгээг ашиглах үед дээш өргөнө.**



⚠ АЮУЛТАЙ

Дэгээ ашиглаагүй үед бэртэл гэмтлээс сэргийлж дэгээг хураах байрлалд хураана.

Ачааны торны дэгээ ашиглах

Ачааны торны дэгээ ашиглан ачааны торийг тогтоох боломжтой.

● **Ашиглах үед дэгээг өргөнө.**



⚠ АЮУЛТАЙ

Бэртэл гэмтлээс сэргийлж ачааны торны дэгээ ашиглаагүй үед дэгээг анхны байрлалд буцаана.

Тор, уутны дэгээ ашиглах

● **Тор, уутны дэгээ дээр дарж ашиглана.**



⚠ АНХААР

Дэгээнд 4 кг (8.8 lb.)-с хүнд зүйл өлгөж болохгүй.
Дэгээг гэмтээх аюултай.

Тээшний хэсгийн шалны хавтан

Тээшний хэсгийн шал нээх

⚠ АЮУЛТАЙ

Тээшний хэсгийн шалыг нээсэн, эсвэл салгаж авсан үед хөдөлгөөн эхлэхээс өмнө буцааж угсрана. Эсрэг тохиолдолд огцом тоормос, ослын үед шалан доор байрлах эд зүйлс шидэгдэж жолооч, зорчигчийг цохих аюултай.

1 Тээшний хаалга нээнэ.



2 Тээшний хэсгийн шалыг нээнэ.

▶ A загвар



▶ B загвар



▶ С загвар



Тээшний шалны доод талын тавиурт эд зүйл хадгалах

Дараах зүйлсийг хадгалах боломжтой.

● Нэмэлт тоноглол



● Ослын гурвалжин тэмдэг*1



*1 : Ослын гурвалжин тэмдэг нь автомашины үндсэн тоноглолд хамаарахгүй.

Тээшний хаалт эвхэх

1 Хаалтны уяаг дэгээнээс салгана.



2 Бариулнаас дээш татаж шал эвхэнэ.



3 Тээшний хаалтыг салгаж авна.

Суудлын түшлэгийг арагш налуулсан үед түшлэгийг эгц байрлалд тохируулсны дараа тээшний хаалтыг авна.



4 Тээшний хаалтыг эвхэнэ.



5 Шалыг дээш өргөөд тээшний хаалтыг байрлуулна.



⚠ АЮУЛТАЙ

- Тээшний хаалт дээр эд зүйл тавиж болохгүй. Огцом тоормос, эргэлтийн үед шидэгдэж жолооч, зорчигчийг гэмтээх аюултай.
- Тээшний хаалт руу хүүхэд авируулж болохгүй. Тээшний хаалт эвдлэнэ.

5 Автомашины мэдээлэл болон индикаторууд

5-1. Хянах самбарын функц болон дэлгэц

Анхааруулах гэрэл ба индикатор 314

Хянах самбарын хэмжих хэрэгслүүд (F SPORT загвараас бусад) 320

Хянах самбарын хэмжих хэрэгслүүд (F SPORT загвар) 325

5-2. Дэлгэцийн функцууд

Мэдээллийн дэлгэц (HUD дэлгэцгүй автомашин) ... 329

Мэдээллийн дэлгэц (HUD дэлгэцтэй автомашин) ... 331

HUD дэлгэц 333

Дэлгэцээр харуулах агуулга 335

5-3. Дэлгэцний тохиргоог өөрчлөх

Хянах самбарын гэрлийн түвшин тохируулах 345

HUD дэлгэцийн тохиргоо өөрчлөх 346

Анхааруулах гэрэл ба индикатор

Хянах самбар болон хажуугийн толин дах анхааруулах гэрэл, индикаторууд нь жолоочид автомашины олон төрлийн системийн ажиллагааны байдлыг мэдээлнэ.

Тайлбарлах зорилгоор дараах зурагт бүх анхааруулах гэрэл, индикаторуудыг асаан харуулав.

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



Анхааруулах гэрлийн жагсаалт

Системд доголдол үүссэн үед тухайн системийн анхааруулах гэрэл анхааруулга өгч асна.

(улаан)	Тоормосны системийн анхааруулах гэрэл(1)
(шар)	Тоормосны системийн анхааруулах гэрэл(1)
	Хөргөлтийн шингэний хэм анхааруулах гэрэл(2)
	Аккумулятор цэнэглэх системийн анхааруулах гэрэл(2)
	Хөдөлгүүрийн тосны даралт багассаныг анхааруулах гэрэл(2)
	Доголдол анхааруулах гэрэл(1)
	SRS анхааруулах гэрэл(1)
	ABS анхааруулах гэрэл(1)
	Дөрөөний буруу ажиллагааг анхааруулах гэрэл(2)
(улаан)	Электрон жолооны механизмын анхааруулах гэрэл(1)
(шар)	Электрон жолооны механизмын анхааруулах гэрэл(1)
	Шатахуун багассаныг анхааруулах гэрэл
	Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл
	Арын зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл (HUD дэлгэцгүй автомашин)*

*:Тоноглогдсон автомашинд

	Арын зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл (HUD дэлгэцтэй автомашин)*
	Дугуйн даралт анхааруулах гэрэл(1)
(шаргал)	LDA индикатор
(шаргал)	LTA индикатор
(анивчих)	Stop & Start cancel индикатор(1)*
(анивчих)	Stop & Start индикатор*(1)
	Lexus parking assist-sensor OFF индикатор*(1)
(шаргал)	Хурд баригчийн индикатор
	Динамик радарын хурд баригчийн индикатор
	Жолоодлогод туслах мэдээллийн индикатор(1)
(анивчих эсвэл асах)	PCS анхааруулах гэрэл(1)
	Шарвалтын индикатор(1)
(анивчих)	Зогсоолын тоормосны индикатор

HOLD (анивчих)	Тоормос баригчийн ажиллагааны индикатор(1)

(1) Энэ гэрлүүд нь асаах товчийг ON горимд шилжүүлсэн үед системийн ажиллагааг шалгаж байгааг илтгэж асах ба хөдөлгүүр асах, эсвэл хэдэн секундын хугацаа өнгөрсний дараа унтарна. Гэрэл асахгүй, эсвэл унтрахгүй байх нь системийн хэвийн ажиллагаа алдагдсаныг илэрхийлнэ. Та өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа оношлуулна уу.

(2) Тус гэрэл нь мэдээллийн дэлгэц дээр асна.

⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгүүр асаах үед ABS болон SRS анхааруулах гэрэл зэрэг аюулгүйн системийн индикатор гэрэл асахгүй байх нь эдгээр аюулгүйн систем ослын үед ажиллах боломжгүйг илтгэх ба улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай. Энэ тохиолдолд та өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа оношлуулна уу.

Холбоотой холбоосууд

Анхааруулах гэрэл ассан/анивчсан үед(X. 563)

Индикаторын жагсаалт

Индикаторууд нь жолоочид автомашины олон төрлийн системийн ажиллагааг мэдээлнэ.

	Эргэх дохионы индикатор
	Оврын гэрлийн индикатор
	Холын гэрлийн индикатор
	AHS индикатор*(1) AHB индикатор*(1)
	Урд манангийн гэрлийн индикатор*
	Арын манангийн гэрлийн индикатор

*: Тоноглогдсон автомашинд

	PCS анхааруулах гэрэл[1][3]
	Хурд баригчийн индикатор
	Динамик радарын хурд баригчийн индикатор
	LDA индикатор
	LTA индикатор
	BSM хажуугийн толины индикатор*[2]
	Lexus parking assist-sensor OFF индикатор*[3][1]
	Жолоодлогод туслах мэдээллийн индикатор[1][3]
	Stop & Start индикатор*[1]
	Stop & Start cancel индикатор[1][3]*
(анивчих)	Шарвалтын индикатор[1]
	VSC OFF индикатор[1][3]
	Зогсоолын тоормосны индикатор[1]
	Тоормос баригч ажиллахад бэлэн байгааг илтгэх индикатор[1]
	Тоормос баригчийн ажиллагааны индикатор[1]
	Эко жолоодлогын индикатор[1]

	Гадна агаарын нам хэмийн индикатор(4)
	[**PASSENGER AIR BAG**] индикатор(5)*
	Уруу замд туслах удирдлагын системийн индикатор*
ECO	Эко жолоодлогын горимын индикатор
SPORT	Sport горимын индикатор(6)
SPORT S	Sport S горимын индикатор(7)
SPORT S+	Sport S+ горимын индикатор(7)
CUSTOM	Custom горимын индикатор(7)
	Trail Mode индикатор*

(1) Энэ гэрлүүд нь асаах товчийг ON горимд шилжүүлсэн үед системийн ажиллагааг шалгаж байгааг илтгэж асах ба хөдөлгүүр асах, эсвэл хэдэн секундын хугацаа өнгөрсний дараа унтарна. Гэрэл асахгүй, эсвэл унтрахгүй байх нь системийн хэвийн ажиллагаа алдагдсаныг илэрхийлнэ. Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

(2) Тус гэрэл хажуугийн толин дээр асна.

(3) Тус гэрэл систем унтрах үед асна.

(4) Гадна агаарын хэм 3°C (37°F)-с бага үед тус индикатор 10 секунд анивчаад асна.

(5) Тус гэрэл урд салоны/хувийн гэрэл дээр асна.

(6) F SPORT загвараас бусад

(7) F SPORT загвар

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

Хянах самбарын хэмжих хэрэгслүүд (F SPORT загвараас бусад)

▶ HUD дэлгэцгүй автомашин



A Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм

Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэмийг харуулна

B Цаг

GPS цагийн мэдээлэлд (GPS цаг) үндэслэн цагийг автоматаар тохируулна. Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

C Тахометр

Хөдөлгүүрийн 1 минутын эргэлтийн хурдыг харуулна

Спидометр

Тухайн тохиргооноос хамаарч дэлгэц өөрчлөгдөнө.

D Арааны байрлал/шилжих боломжтой арааны дээд хязгаар/одоогийн араа

E Гадна агаарын хэм

Гадна агаарын хэмийг -40°C (-40°F)-с 50°C (122°F) хооронд заана.

F Шатахууны хэмжээ

Шатахууны бакд байгаа шатахууны хэмжээг харуулна.

G Одометр ба гүйлтийн дэлгэц

H Мэдээллийн дэлгэц

Автомашины олон төрлийн мэдээлэл, мөн доголдол үүссэн үед анхааруулга жолоочид өгнө.

I Жолоодлогын горимын суурь өнгө

Жолоодлогын горимоос хамаарч суурь өнгө өөрчлөгдөнө.

▶ HUD дэлгэцтэй автомашин



A Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм

Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэмийг харуулна

B Цаг

GPS цагийн мэдээлэлд (GPS цаг) үндэслэн цагийг автоматаар тохируулна. Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

C Навигацийн системийн тооцоолсон очих газарт хүрэх цаг*

Навигацийн системийн тооцоолж буй очих газарт хүрэх цагийг харуулна.

D Тахометр

Хөдөлгүүрийн 1 минутын эргэлтийн хурдыг харуулна

Аналог спидометр

Тухайн тохиргооноос хамаарч дэлгэц өөрчлөгдөнө.

E Арааны байрлал/шилжих боломжтой арааны дээд хязгаар/одоогийн араа

F Дижитал спидометр

G Гадна агаарын хэм

Гадна агаарын хэмийг -40°C (-40°F)-с 50°C (122°F) хэмийн хооронд заана.

H Шатахууны хэмжээ

Шатахууны бакд байгаа шатахууны хэмжээг харуулна.

I Одометр ба гүйлтийн дэлгэц

J Мэдээллийн дэлгэц

*: Тоноглогдсон автомашинд

Автомашины олон төрлийн мэдээлэл, мөн доголдол үүссэн үед анхааруулга жолоочид өгнө.

K Жолоодлогын горимын суурь өнгө

Жолоодлогын горимоос хамаарч суурь өнгө өөрчлөгдөнө.

L Туулах боломжтой зай

Шатахууны нөөцөөр туулах боломжтой зайг харуулна.

МЭДЭЭЛЭЛ

Хянах самбар, хэмжих хэрэгслүүд асах нөхцөл

Асаах товчны ON горимд.

Гадна агаарын хэмийн дэлгэц

- Дараах нөхцлүүдэд гадна агаарын хэмийг зөв заахгүй байх, эсвэл хэвийн үеэс заалт удаан солигдож болно:
  - Автомашин зогссон, эсвэл бага хурдаар явж байгаа үед (20 км/ц [12 миль/ц]-с бага)
  - Гадна агаарын хэм огцом өөрчлөгдсөн (авто зогсоол, хонгилын орц гарц дээр зэрэг)
- **"--"**, эсвэл **"E"** тэмдэг гарсан үед системд доголдол үүссэн байж болзошгүй.

  Автомашинаа өөрийн Lexus дилерт үзүүлнэ үү.

Туулах боломжтой зай*

- Тус зайг таны дундаж шатахуун зарцуулалтад үндэслэн тооцож гаргадаг. Дэлгэцийн заалт болон бодит туулсан зай өөр байж болно.
- Бага хэмжээний шатахуун нэмсэн үед дэлгэцийн заалт өөрчлөгдөхгүй байж болно. Шатахуун цэнэглэх үед асаах товчийг унтрана. Асаах товчийг унтраалгүйгээр шатахуун цэнэглэсэн үед заалт өөрчлөгдөхгүй байж болно.

Шингэн кристал дэлгэц (LCD)

Дэлгэц дээр хар эсвэл цагаан жижиг цэг гарч болно.

Энэ нь шингэн кристал дэлгэцийн онцлог бөгөөд дэлгэцийн хэвийн ажиллагаа алдагдаагүй болно.

Free/Open Source Software-н мэдээлэл

Тус бүтээгдэхүүн нь Free/Open Source Software (FOSS)-тэй болно. FOSS-н лиценз, эх сурвалж зэрэг мэдээллийг дараах холбоосноос авах боломжтой.
https://www.denso.com/global/en/opensource/meter/toyota/

⚠ АЮУЛТАЙ

Шингэн кристал дэлгэц (LCD) ашиглахын өмнө автомашины салоныг хангалттай хэмжээнд халаана. Хэт нам температурт дэлгэц удаан болох, хоцролт үүсч болно.

Жишээлбэл жолооч арааны хөшүүргийг шилжүүлэх үед тухайн сонгосон арааны байрлалыг дэлгэц хоцорч харуулж болно. Үүнээс шалтгаалж жолооч арааг хүнд арааны шилжүүлэх, улмаар хүчтэй хөдөлгүүрийн тоормос үүсч амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

⚠ АНХААР

Хөдөлгүүр болон эд ангийг гэмтлээс сэргийлж дараах анхааруулгыг мөрдөнө.

- Тахометрийн зүүг хөдөлгүүрийн дээд эргэлтийг заах улаан бүсэд орох байдлаар хааз өгч болохгүй.
- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний заалт улаан бүсэд орсон (H); эсвэл мэдээллийн дэлгэц дээр **"Engine Coolant Temp High Stop in a Safe Place See Owner's Manual"** анхааруулга гарсан үед хөдөлгүүр хэт халсан байх магадлалтай. Энэ тохиолдолд автомашиныг аюулгүй газарт даруй зогсоох ба бүрэн хөрсний дараа хөдөлгүүрийг шалгана.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Тахометр/спидометрийн дэлгэцийн хооронд солих

Тухайн жолоодлогын горим, эсвэл тохиргооноос хамаарч дэлгэц дараах байдлаар солигдоно. Тохиргоог голын дэлгэцээр өөрчлөх боломжтой.

HUD дэлгэцгүй автомашин

- Тахометр

  Хянах самбарын дэлгэцийн тохиргоог дэлгэцийн төрөл 1, эсвэл дэлгэцийн төрөл 3-г сонгосон үед гарна.

- Спидометр

  Байнга гарна.

  Хянах самбарын дэлгэцийн төрлийн тохиргооноос хамаарч дэлгэц дижитал спидометр болон аналог спидометрийн тохиргоонд солигдоно.

HUD дэлгэцтэй автомашин

- Тахометр

  Хянах самбарын дэлгэцийн төрлийг төрөл 1-д тохируулсан үед гарна.

F SPORT загвар: Мөн дэлгэцийн төрөл 3-г сонгосон үед гарна.

● Спидометр

Дижитал спидометр байнга гарна.

Хянах самбарын дэлгэцийн төрлийг төрөл 2-т тохируулсан үед аналог спидометр гаргах боломжтой.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Туулсан зайн дэлгэцийг өөрчлөх/туулсан зайг тэглэх

Дэлгэцийг дараах байдлаар өөрчлөх боломжтой.

● Одометр

Автомашины нийт гүйлтийг заана.

● Гүйлт A/Гүйлт B

Автомашины гүйлтийг өмнөх удаа тэглэснээс хойших гүйлтийг заана. Гүйлт A болон B-г ашиглаж 2 өөр гүйлтийг нэгэн зэрэг хэмжих боломжтой.

● Дараагийн удаа хөдөлгүүрийн тос солих хүртэлх зайг заана (Хонгконг, Макаогоос бусад)

Дараагийн удаа хөдөлгүүрийн тос солих хүртэлх зайг заана.

Товч дарах бүрт дэлгэц өөрчлөгдөнө.

Гүйлтийн дэлгэц гарсан үед товчийг удаан дарж заалтыг тэглэнэ.



Хянах самбарын хэмжих хэрэгслүүд (F SPORT загвар)

Арааны байрлал, одоогийн жолоодлогын горим, дэлгэцээр гарах зүйлс болон зарим хэмжүүрийн байрлал өөрчлөгдөнө.

▶ Цагираг дэлгэц



A Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм

Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэмийг харуулна

B Цаг

GPS цагийн мэдээлэл ашиглан автоматаар цаг (GPS Цаг) тохируулна. Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

C Навигацийн системийн хүрэх газарт очих хугацааны дэлгэц*

Навигацийн системийн хүрэх газарт очих хугацааг харуулна.

D Тахометр

Хөдөлгүүрийн 1 минутын эргэлтийн хурдыг харуулна

- Эргэлтийн индикатор
- Дээд эргэлт

Аналог спидометр

Сонгосон жолоодлогын горим, эсвэл тодорхой тохиргооноос хамаарч дэлгэц өөрчлөгдөнө.

E Арааны байрлал/араа солигдох хүрээ/арааны дугаар

F Дижитал спидометр

G Гадна агаарын хэм

Гадна агаарын хэмийг -40°C (-40°F)-с 50°C (122°F) хэмийн хооронд харуулна.

H Шатахууны хэмжээ

Шатахууны саванд дахь шатахууны хэмжээг заана.

*: Тоноглогдсон автомашинд

I Одометр ба гүйлтийн дэлгэц

J Мэдээллийн дэлгэц

Жолоочид автомашины олон төрлийн мэдээлэл өгөх ба доголдол үүссэн үед анхааруулах мэдээлэл гаргана.

K Жолоодлогын горимын дэлгэцийн суурь өнгө

Жолоодлогын горимоос хамаарч дэлгэцийн суурь өнгө өөрчлөгдөнө.

L Туулах боломжтой зай

Байгаа шатахуунаар туулах боломжтой зайг харуулна.

▶ **Саваа дэлгэц**



A Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм

Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэмийг харуулна

B Цаг

GPS цагийн мэдээлэл ашиглан автоматаар цаг (GPS Цаг) тохируулна. Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

C Навигацийн системийн хүрэх газарт очих хугацааны дэлгэц*

Навигацийн системийн хүрэх газарт очих хугацааг харуулна.

D Тахометр

Хөдөлгүүрийн 1 минутын эргэлтийн хурдыг харуулна

- Эргэлтийн индикатор
- Дээд эргэлт

E Арааны байрлал/араа солигдох хүрээ/арааны дугаар/дижитал спидометр

F Гадна агаарын хэм

Гадна агаарын хэмийг -40°C (-40°F)-с 50°C (122°F) хэмийн хооронд харуулна.

G Шатахууны хэмжээ

Шатахууны саванд дахь шатахууны хэмжээг заана.

H Одометр ба гүйлтийн дэлгэц

I Мэдээллийн дэлгэц

Жолоочид автомашины олон төрлийн мэдээлэл өгөх ба доголдол үүссэн үед анхааруулах мэдээлэл гаргана .

J Жолоодлогын горимын дэлгэцийн суурь өнгө

Жолоодлогын горимоос хамаарч дэлгэцийн суурь өнгө өөрчлөгдөнө.

K Туулах боломжтой зай

Байгаа шатахуунаар туулах боломжтой зайг харуулна.

МЭДЭЭЛЭЛ

Хянах самбар болон дэлгэц асах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

Гадна агаарын хэмийн дэлгэц

- Дараах нөхцлүүдэд гадна агаарын хэм гарахгүй байх, эсвэл удаан солигдоно:
  - Зогсож байгаа, эсвэл бага хурдаар (20 км/ц [12 mph]-с бага) явж байгаа
  - Гадна агаарын хэм огцом өөрчлөгдсөн (гараж, хонгил зэрэгт орсон/гарсан.)
- **"--"**, эсвэл **"E"** гарсан үед системд доголдол үүссэн байж болзошгүй.

  Та өөрийн Lexus дилер дээрээ оношлуулна уу.

Туулах боломжтой зай

- Туулах боломжтой зайг дундаж шатахуун зарцуулалт дээр үндэслэн тооцож гаргадаг. Бодит туулсан зай дэлгэцээр гарч буй туулах боломжтой зайн хэмжээнээс өөр байж болно.
- Зөвхөн бага хэмжээний шатахуун нэмсэн үед дэлгэцийн заалт өөрчлөгдөхгүй байж болно. Шатахуун цэнэглэх үед хөдөлгүүр унтраана. Асаах товч унтраалгүйгээр шатахуун цэнэглэсэн үед заалт шинэчлэгдэхгүй байж болно.

Шингэн кристал дэлгэц (LCD)

Дэлгэц дээр хар эсвэл цагаан жижиг цэг гарч болно.

Энэ нь шингэн кристал дэлгэцийн онцлог бөгөөд дэлгэцийн хэвийн ажиллагаа алдагдаагүй болно.

Нээлттэй эх үүсвэртэй программ хангамжийн мэдээлэл

Нээлттэй эх үүсвэртэй программ хангамжтай (FOSS) бүтээгдэхүүн болно. FOSS-н мэдээлэл, эх кодыг дараах холбоосоос харах боломжтой.
https://www.denso.com/global/en/opensource/meter/toyota/

⚠ АЮУЛТАЙ

LCD дэлгэц ашиглахаас өмнө салоныг хангалттай халаана. Хэт хүйтэн хэмд дэлгэцийн хариу үйлдэл удаан, хоцорч солигдож болно.

Жишээлбэл жолооч араа солих үед арааны дугаар дэлгэц дээр хоцорч гарч болно. Энэ хоцрогдол нь жолоочийг дахин хүнд араанд шилжүүлэхэд хүргэх, улмаар хөдөлгүүрийн хүчтэй тоормосноос шалтгаалан амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэж болно.

⚠ АНХААР

Хөдөлгүүр болон эд ангиудыг гэмтлээс сэргийлж дараах анхааруулгыг мөрдөнө.

- Хөдөлгүүрийн дээд хурдыг илэрхийлэх улаан бүсэд тахометрын зүүг хүргэж болохгүй.
- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм улаан бүсэд байгаа (H); эсвэл **"Engine Coolant Temp High Stop in a Safe Place See Owner's Manual"** мэдээллийн дэлгэц дээр гарсан үед хөдөлгүүр халсан байж болзошгүй. Энэ нөхцөлд даруй аюулгүй газар зогсоод бүрэн хөрсний дараа хөдөлгүүр шалгана.

Холбоотой холбоосууд

Тахометр/спидометрийн дэлгэцийн хооронд солих(X. 323)

Туулсан зайн дэлгэцийг өөрчлөх/туулсан зайг тэглэх(X. 324)

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Эргэлтийн индикатор/Дээд эргэлтийн дэлгэц

■ Эргэлтийн индикатор

Хөдөлгүүрийн эргэлт тохируулсан хурдад хүрсэн, эсвэл улаан бүсэд орсон үед тахометрыг тодоор харуулна.

Хөдөлгүүрийн эргэлт тохируулсан хурдад хүрсэн үед индикатор шаргал, улаан бүсэд хүрсэн үед улаан өнгөөр асна.

Эргэлтийн индикатор дэлгэц дээр гарах хөдөлгүүрийн хурдыг голын дэлгэцээр өөрчлөх боломжтой.

■ Дээд эргэлт

Хөдөлгүүрийн хурд 5000 эрг/мин хурдад хүрсэн, эсвэл давсан үед тахометр дэлгэц дээр гарч ирэн хөдөлгүүрийн хамгийн өндөр хурдыг 1 секунд хугацаанд харуулна.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Мэдээллийн дэлгэц (HUD дэлгэцгүй автомашин)

Жолоодлоготой холбоотой олон төрлийн мэдээлэл гаргах боломжтой. Нөхцөл байдлаас хамаарч анхааруулга, эсвэл автоматаар гарч ирдэг дэлгэц мөн гарна.

■ Дэлгэцийн хэсэг



A Дэлгэцийн мэдээллийн хэсэг

B Жолоодлогод туслах системийн мэдээллийн хэсэг

-с бусад меню дэлгэцээр гарч байгаа ба жолоодлогод туслах систем ажиллаж байгаа үед ажиллагааны байдлыг дэлгэцээр харуулна.

■ Дэлгэцийн мэдээллийн хэсэг дээр гарах зүйлс

Мэдээллийн дэлгэц дээр меню тэмдэг сонгосон үед дараах зүйлсийг гаргах боломжтой.

-

  Жолоодлогын мэдээллийн дэлгэц

-

  Навигацийн системтэй холбоотой дэлгэц*

-

  Аудио системтэй холбоотой дэлгэц

-

  Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц

-

  Анхааруулах мэдээлэл

МЭДЭЭЛЭЛ

■ Шингэн кристал дэлгэц (LCD)

Дэлгэц дээр хар эсвэл цагаан жижиг цэг гарч болно. Энэ нь шингэн кристал дэлгэцийн онцлог бөгөөд дэлгэцийн хэвийн ажиллагаа алдагдаагүй болно.

*: Тоноглогдсон автомашинд

⚠ АЮУЛТАЙ

■ **Жолоодлогын үед ашиглах тохиолдолд анхаарах зүйлс**

- Жолоодлогын үед мэдээллийн дэлгэц удирдах нөхцөлд ойр орчмын аюулгүй байдалд өндөр анхаарал хандуулна.
- Явган зорчигч, зам дээрх эд зүйлс, урд автомашин зэргийг харж чадахгүй байж болох тул жолоодлогын үед мэдээллийн дэлгэц рүү удаан харж болохгүй.

■ **Мэдээллийн дэлгэц хүйтэн үед**

Шингэн кристал дэлгэц (LCD) ашиглахын өмнө автомашины салоныг хангалттай хэмжээнд халаана. Хэт нам температурт дэлгэц удаан болох, хоцролт үүсч болно.

Жишээлбэл жолооч арааны хөшүүргийг шилжүүлэх үед тухайн сонгосон арааны байрлалыг дэлгэц хоцорч харуулж болно. Үүнээс шалтгаалж жолооч арааг хүнд араанд шилжүүлэх, улмаар хүчтэй хөдөлгүүрийн тоормос үүсч амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ **Дэлгэцийн тохиргоо хийх үеийн анхааруулга**

Дэлгэцийн тохиргоо хийх үед хөдөлгүүр асаалттай байх шаардлагатай тул автомашиныг агааржуулалт сайтай газар зогсооно. Битүү орчинд нүүртөрөгчийн дутуу исэл (CO) зэрэг хорт хий агуулагддаг утаа хуримтлагдаж автомашины дотор орох, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

⚠ АНХААР

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж хөдөлгүүр асаалттай үед дэлгэцийн тохиргоо хийнэ.

Холбоотой холбоосууд

Дэлгэцээр харуулах агуулга(Х. 335)

Хянах самбарын гэрлийн түвшин тохируулах(Х. 345)

Мэдээллийн дэлгэц (HUD дэлгэцтэй автомашин)

Жолоодлоготой холбоотой олон төрлийн мэдээлэл гаргах боломжтой. Нөхцөл байдлаас хамаарч анхааруулга, эсвэл автоматаар гардаг дэлгэц мөн гарна.

■ Дэлгэцийн хэсэг



A Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэцийн хэсэг

Жолоодлогод туслах систем ажиллаж байгаа ч дэлгэцийн мэдээллийн хэсэг дээр жолоодлогод туслах системийн гараагүй үед системийн ажиллагааны байдал дэлгэцээр гарна.

B Навигацийн системтэй холбоотой дэлгэцийн хэсэг*

Дэлгэцийн мэдээллийн хэсэг дээр навигацийн системтэй холбоотой дэлгэц гараагүй үед маршрутын зааварчилгаа дэлгэцээр гарна.

C Дэлгэцийн мэдээллийн хэсэг

■ Дэлгэцийн мэдээллийн хэсэгт гарах зүйлс

Дараах мэдээлэл гаргах боломжтой.

- Жолоодлогын мэдээлэл 1
- Жолоодлогын мэдээлэл 2
- Эко жолоодлогын индикатор
- Аудио системтэй холбоотой дэлгэц
- Навигацийн системтэй холбоотой дэлгэц**1
- Хүчлүүрийн хэмжүүр/хөдөлгүүрийн тосны температур хэмжигч/хөдөлгүүр тосны даралт хэмжигч*
- G-хүч
- Арааны байрлал
- Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц*1
- Хоосон (дэлгэц дээр дүр гарахгүй)

* : Тоноглогдсон автомашинд

*1 : Дэлгэцийн горимыг хамгийн их тохиргоонд хийсэн үед HUD дэлгэц дээр гарна.

МЭДЭЭЛЭЛ

Шингэн кристал дэлгэц (LCD)

Дэлгэц дээр хар эсвэл цагаан жижиг цэг гарч болно. Энэ нь шингэн кристал дэлгэцийн онцлог бөгөөд дэлгэцийн хэвийн ажиллагаа алдагдаагүй болно.

⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгөөний үед ашиглах анхааруулга

- Хөдөлгөөний үед мэдээллийн дэлгэц ашиглах нөхцөлд ойр орчмын аюулгүй байдалд өндөр анхаарал хандуулна.
- Автомашины явах чиглэлд байгаа явган зорчигч, зам дээрх объект зэргийг харж чадахгүй байж болох тул жолоодлогын үед мэдээллийн дэлгэц рүү удаан харж болохгүй.

Мэдээллийн дэлгэц хүйтэн үед

Шингэн кристал дэлгэц (LCD) ашиглахын өмнө автомашины салоныг хангалттай хэмжээнд халаана. Хэт нам температурт дэлгэц удаан болох, хоцролт үүсч болно.

Жишээлбэл жолооч арааны хөшүүргийг шилжүүлэх үед тухайн сонгосон арааны байрлалыг дэлгэц хоцорч харуулж болно. Үүнээс шалтгаалж жолооч арааг хүнд арааnd шилжүүлэх, улмаар хүчтэй хөдөлгүүрийн тоормос үүсч амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

Дэлгэцийн тохиргоо хийх үеийн анхааруулга

Дэлгэцийн тохиргоо хийх үед хөдөлгүүр асаалттай байх шаардлагатай тул автомашиныг агааржуулалт сайтай газар зогсооно. Битүү орчинд нүүртөрөгчийн дутуу исэл (CO) зэрэг хорт хий агуулагддаг утаа хуримтлагдаж автомашины дотор орох, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

⚠ АНХААР

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж хөдөлгүүр асаалттай үед дэлгэцийн тохиргоо хийнэ.

Холбоотой холбоосууд

Дэлгэцээр харуулах агуулга(Х. 335)

Хянах самбарын гэрлийн түвшин тохируулах(Х. 345)

HUD дэлгэц*

HUD дэлгэц нь жолоодлоготой холбоотой олон төрлийн мэдээлэл болон жолоодлогод туслах системийн ажиллагааг салхины шилэн дээр тусгаж харуулдаг.

Жолоодлогын нөхцөл болон HUD дэлгэцийн горимоос хамаарч дэлгэцээр гарах мэдээлэл өөр байна. Нөхцөл байдлаас хамаарч автоматаар гарч ирдэг дэлгэц мөн гарна.



A Үндсэн дэлгэцийн хэсэг

Дараах зүйлсийг харуулна:

- Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц
- Тахометр/Эко жолоодлогын индикатор
- Луужин*

B Жолоодлогын мэдээллийн дэлгэцийн хэсэг

Дараах зүйлсийг харуулна:

- Спидометр
- Арааны хөшүүргийн байрлал/шилжих боломжтой дээд араа/арааны дугаар

C ⚠ : Ерөнхий анхааруулах тэмдэг

Анхааруулах мэдээллийн үед дэлгэцээр гарна.

МЭДЭЭЛЭЛ

■ HUD дэлгэцийн ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

* : Тоноглогдсон автомашинд

■ HUD дэлгэц ашиглах үед

HUD дэлгэц нь нарны гэрэл, ялангуяа туйлширсан нарны шилээр харах үед бүдэг, муу харагдаж болно. HUD дэлгэцийн гэрлийг тод болгон тохируулах, эсвэл нарын шилээ авна.

⚠ АЮУЛТАЙ

Явган зорчигч, зам дээрх эд зүйлс, урд талын автомашиныг харахгүй байх аюултай тул жолоодлогын үед HUD дэлгэц рүү удаан харж болохгүй.

⚠ АНХААР

Дараах анхааруулгыг мөрдөнө.

- HUD дэлгэцийн проектрын ойр орчимд аливаа уух зүйл тавиж болохгүй. Проектор норсон нөхцөлд цахилгааны гэмтэл үүсч болзошгүй.



- HUD дэлгэцийн проектор дээр эд зүйл тавих, наалт нааж болохгүй.
  Дэлгэцийн заалтыг алдагдуулна.
- HUD дэлгэцийн проектрын дотор талд хуруугаар хүрэх, хатуу зүйлээр хатгаж болохгүй.
  Механик гэмтлээс үүдсэн доголдолд хүргэнэ.

Холбоотой холбоосууд

Тахометр/спидометрийн дэлгэцийн хооронд солих(X. 323)

Дэлгэцээр харуулах агуулга(X. 335)

HUD дэлгэцийн тохиргоо өөрчлөх(X. 346)

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Дэлгэцээр харуулах агуулга

Хянах самбар/дэлгэц удирдах

▶ HUD дэлгэцгүй автомашин



A ˂ / ˃ : Меню тэмдэг сонгоно

˄ / ˅ : Дэлгэцээр харуулах зүйлийг солих, дэлгэцийг дээш/доош гүйлгэх, курсорыг дээш/доош хөдөлгөх

B Орох/Сонгох

C Өмнөх дэлгэцэнд буцна

D Дуудлага хийх/хүлээн авах

Гарны оролцоогүй дуудлага хийх, хүлээн авах систем дэлгэц дээр гарна. Гарны оролцоогүй системийн тухай дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

▶ HUD дэлгэцтэй автомашин



A Тухайн нөхцөл болон тохиргооноос хамаарч товч бүрийн функц өөр байна.

Товчинд хүрэх үед HUD дэлгэц дээр товч тус бүрийн функц гарна. HUD унтраасан үед мэдээллийн дэлгэц дээр товч тус бүрийн функц гарна.

Мөн голын дэлгэц дээр товч тус бүрийг өөрийн хүссэн функцаар тохируулах боломжтой.

B Товч дарах бүрт функц өөрчлөгдөнө.

C Тэмдгийн дэлгэцийн товч

Товч тус бүрийн тэмдэг дэлгэцээр гарна. Гараар хүрсэн товч тодорно. (E)

D Товчны функцийн зааварчилгааны дэлгэц

Гараар хүрсэн товчны функцийн зааварчилгаа дэлгэц дээр гарна.

МЭДЭЭЛЭЛ

■ **Жолооны хүрдний товч дарсан ч хариу үйлдэл үзүүлэхгүй үед**

- Жолооны хүрдний товчинд хүрэх үедээ хуруугаа хөдөлгөхөд товч илүү хялбараар хариу үйлдэл үзүүлнэ.
- Жолооны хүрдний товчны гадаргуу бохирдсон үед асаах товчийг унтраагаад бохирдсон товчийг цэвэрлэнэ.
- Өвлийн бээлийний горимыг идэвхжүүлснээр товчны мэдрэгчийн мэдрэх түвшин нэмэгдэнэ.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

Мэдээллийн дэлгэцийн горим солих (HUD дэлгэцгүй автомашин)

● **Жолооны хүрдний удирдлагын товчны < , эсвэл > талыг дарна.**

Жолоочийн мэдээлэл хооронд солих (HUD дэлгэцгүй автомашин)

● **Хянах самбарын удирдлагын товчны < , эсвэл > -г дарж ⓘ -г сонгоно. Үргэлжлүүлээд ^ , эсвэл ˅ -г дарна.**

Мэдээллийн дэлгэцийн дэлгэц солих (HUD дэлгэцтэй автомашин)

МЭДЭЭЛЭЛ

■ **Жолооны хүрдний товчоор солих**

Хэрэв ⟨DISP / DISP⟩ товчийг жолооны хүрдний байнга ашигладаг функцаар тохируулсан үед дэлгэцийг ⟨DISP , эсвэл DISP⟩ товч даран солих боломжтой.

1 **Голын дэлгэц дээр ⚙ -г сонгоно.**
2 **[Vehicle customise]-г сонгоно.**
3 **[Meter]-г сонгоно.**

4 < , эсвэл > -г "Display switching"-с сонгоно.

Товч дарах бүрт дэлгэц солигдоно.

Жолоодлогын мэдээллийн дэлгэц

Дараах дэлгэцүүд дээр жолоодлоготой холбоотой мэдээлэл гарна.

- Мэдээллийн дэлгэц
- HUD дэлгэц*
- Голын дэлгэц

Дэлгэцнээс хамаарч гарах зүйл өөр байна.

Жолоодлогын мэдээлэл 1

Мэдээллийн дэлгэцээр дараах зүйлсийг гаргах боломжтой.

Дэлгэцийн заалтыг мэдээллийн журмаар ашиглана.

- Одоогийн шатахуун зарцуулалт

  Тухайн мөчийн шатахуун зарцуулалтыг харуулна

- Дундаж шатахуун зарцуулалт

Жолоодлогын мэдээлэл 2

Мэдээллийн дэлгэц дээр дараах мэдээлэл гаргах боломжтой.

- Автомашины дундаж хурд
- Жолоодлогын нийт хугацаа

Жолоодлогын мэдээлэл 3 (HUD дэлгэцгүй автомашин)

Мэдээллийн дэлгэц дээр дараах мэдээлэл гаргах боломжтой.

- Туулах боломжтой зай

  Үлдэгдэл шатахуунаар туулах боломжтой зайг харуулна.

- Хөдөлгүүр асааснаас хойших шатахууны дундаж хэмнэлт

  Хөдөлгүүр асааснаас хойших дундаж шатахуун зарцуулалтыг харуулна.

МЭДЭЭЛЭЛ

■ Туулах боломжтой зай

- Тус зайг таны автомашины дундаж шатахуун зарцуулалтад суурилан тооцоолдог ба дэлгэцийн заалт болон бодит туулсан зай өөр байж болно.
- Бага хэмжээний шатахуун нэмж цэнэглэх үед дэлгэцийн заалт өөрчлөгдөхгүй байж болно. Шатахуун цэнэглэх үед асаах товчийг off болгож унтраана. Асаах товчийг унтраалгүй шатахуун цэнэглэсэн үед дэлгэцийн заалт өөрчлөгдөхгүй байж болно.

*: Тоноглогдсон автомашинд

Эко жолоодлогын индикатор

Эко жолоодлогын индикаторыг мэдээллийн дэлгэц болон HUD дэлгэц дээр гаргах боломжтой*.

Тус зураг нь зөвхөн тайлбарлах зорилготой бөгөөд автомашины техник үзүүлэлтээс хамаарч өөр байж болно.



A Эко жолоодлогын индикатор гэрэл

Эко хурд нэмэлт (эко жолоодлого)-н үед эко жолоодлогын индикатор гэрэл асна. Хурд нэмэлт эко жолоодлогын бүсээс давсан, эсвэл автомашин зогссон үед гэрэл унтарна.

B Эко жолоодлогын бүсийн дэлгэц

Хурд нэмэлтэд үндэслэсэн одоогийн эко жолоодлогын харьцаагаар жолоодох үеийн эко жолоодлогын бүсийг санал болгоно.

C Хурд нэмэлтэд үндэслэсэн эко жолоодлогын харьцаа

Хурд нэмэлт эко жолоодлогын бүсээс давсан үед эко жолоодлогын индикаторын бүсийн баруун тал асна.

Энэ нөхцөлд эко жолоодлогын индикатор гэрэл унтарна.

D Эко жолоодлогын бүс

МЭДЭЭЛЭЛ

Эко жолоодлогын индикатор гэрэл дараах нөхцөлд асахгүй:

- Араа D-с өөр байрлалд байгаа.
- Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулсан.
- Жолоодлогын горимыг спорт горимд тохируулсан.
- Жолоодлогын горимыг custom горимд тохируулсан ба* явах эд ангийн удирдлагыг power тохиргоонд тохируулсан.
- Автомашины хурд 130 км/ц (80 mph) ба түүнээс их.

Тоормосны хүчлүүрийн даралт хэмжигч/Хөдөлгүүрийн тосны хэм хэмжигч/Хөдөлгүүрийн тосны даралт хэмжигч*

Дараах зүйлсийг мэдээллийн дэлгэц дээр гаргах боломжтой.

- Тоормосны хүчлүүрийн даралт хэмжигч

*: Тоноглогдсон автомашинд

Тоормосны хүчлүүрийн даралтыг заана. Даралт зохих хэмжээнээс хэтэрсэн үед дэлгэцийн өнгө өөрчлөгдөнө

- Хөдөлгүүрийн тосны хэм хэмжигч

  Хөдөлгүүрийн тосны хэмийг заана. Тосны хэм 140 °C (284 °F)-с давсан үед дэлгэц анивчина.

- Хөдөлгүүрийн тосны даралт хэмжигч

  Хөдөлгүүрийн тосны даралтыг заана. Тосны даралт буурсан үед дохио дуугарч анхааруулах мэдээлэл дэлгэцээр гарна.

G-хүчний дэлгэц

Автомашинд ирж буй урагш хойш, баруун зүүн чиглэлийн инерцийн хүчийг мэдээллийн дэлгэцээр харуулна.

G-хүчний дэлгэцээр жолооны хүрдний баруун зүүн эргүүлсэн хэмжээ, хаазны дөрөөний хэмжээ, тоормосны шингэний даралт зэргийг харуулна.



- A Хурд авалтын G-хүч
- B Одоогийн G-хүчний хэмжээ (урд/хойд болон баруун/зүүн G-хүчний хэмжээг тооцоолон харуулна)
- C Хамгийн их G-хүч

  Хөдөлгүүр асаах бүрт дэлгэцийн заалт тэглэгдэнэ.
- D Хаазны дөрөөний хэмжээ
- E Тоормосны шингэний даралт
- F Жолооны хүрд зүүн эргүүлсэн хэмжээ
- G Жолооны хүрд баруун эргүүлсэн хэмжээ

Хөндлөн чиглэлийн 0.5 G-с илүү G-хүч үүссэн үед G-хүчний хэмжээний дэлгэц хув шаргал өнгөөр 2 секунд асна. (оргил үеийг барих функц)

Дэлгэцийн заалтыг мэдээллийн журмаар ашиглана. Замын гадаргуугын байдал, температур болон автомашины хурд зэрэг хүчин зүйлээс хамаарч дэлгэц автомашины бодит нөхцлийг харуулахгүй байж болно.

МЭДЭЭЛЭЛ

- Автомашиныг зогсоолд байрлуулсан үед налуу газар зогссон зэргээс шалтгаалж ч G-хүчний хэмжээ 0-г заахгүй байж болно.

- Автомашины ашиглалтын нөхцлөөс хамаарч тоормосны шингэний даралтын дэлгэц тоормосны дөрөөг бүрэн гишгэсэн ч дээд утгыг харуулахгүй байж болно.
- Аккумуляторын шон салгаад дахин залгасан үед жолооны хүрдний хэмжээний дэлгэц түр хугацаанд цуцлагдана. Автомашиныг хэсэг хугацаанд жолоодсоны дараа дэлгэц идэвхжинэ.

Арааны байрлал

Араа шилжих боломжтой дээд араа, эсвэл D, M арааны байрлалд одоогийн арааны дугаарыг харуулна.

Хоосон дэлгэц (дэлгэц дээр мэдээлэл гарахгүй)

Мэдээллийн дэлгэц дээр жолоодлогын мэдээлэл гарахгүй.

Одоогийн шатахуун зарцуулалт/түүхийн дэлгэц

Голын дэлгэц дээр шатахуун зарцуулалтын мэдээлэл гаргах боломжтой.

■ Одоогийн шатахуун зарцуулалтын дэлгэц



- A Түүхийн мэдээллийг тэглэх
- B Өмнөх 15 минутын шатахуун зарцуулалт
- C Одоогийн шатахуун зарцуулалт
- D Хөдөлгүүр асааснаас хойших автомашины дундаж хурд
- E Туулах боломжтой зай
- F Хөдөлгүүр асааснаас хойших хугацаа.

Дэлгэцээр гарч буй шатахууны дундаж зарцуулалтыг мэдээллийн журмаар ашиглана. Тус зураг нь зөвхөн жишээ бөгөөд бодит байдлаас бага зэрэг өөр байж болно.

■ Шатахуун зарцуулалтын түүхийн дэлгэц

- A Хамгийн сүүлийн шатахуун зарцуулалт
- B Хамгийн сайн шатахуун зарцуулалт
- C Өмнөх шатахуун зарцуулалт
- D Түүхийн мэдээллийг устгах
- E Хамгийн сүүлийн шатахуун зарцуулалтын мэдээллийг шинэчлэх

Дэлгэцээр гарч буй шатахууны дундаж зарцуулалтыг мэдээллийн журмаар ашиглана. Тус зураг нь зөвхөн жишээ бөгөөд бодит байдлаас бага зэрэг өөр байж болно.

МЭДЭЭЛЭЛ

■ Түүхийн мэдээллийн шинэчлэх

Хамгийн сүүлийн шатахуун зарцуулалтыг [**Update**] дарж шинэчлэн одоогийн шатахуун зарцуулалтыг дахин хэмжинэ.

■ Мэдээллийг тэглэх

Шатахуун зарцуулалтын мэдээллийг [**Clear data**]-г сонгож тэглэнэ.

■ Туулах боломжтой зай

Одоо байгаа шатахууны хэмжээгээр туулах боломжтой хамгийн их зайг тооцон харуулна. Туулах боломжтой зайг шатахууны дундаж зарцуулалт дээр тооцож харуулдаг. Үр дүнд нь дэлгэцийн заалт болон бодит туулсан зай өөр байж болно.

Голын дэлгэц дээр шатахуун зарцуулалт/түүхийн дэлгэц харуулах

1. **Үндсэн менюнээс -г сонгоно.**
2. **[Trip information]-г сонгоно.**
3. **[Current], эсвэл [History]-г сонгоно.**

AWD ажиллагааны статусын дэлгэц (AWD загвар)



AWD ажиллагааны статусын дэлгэцийг голын дэлгэц дээр гаргах боломжтой.

Зургийг жишээ болгон харуулсан ба голын дэлгэц дээрх бодит харагдац өөр байж болно.

Мушгих хүчний хуваарилалтын дэлгэц:

Дугуй тус бүрийн хүчний статусыг 0-с 5 хүртэлх нийт 6 шатлалаар харуулна.

AWD ажиллагааны байдлыг голын дэлгэц дээр гаргах

1. **Үндсэн цэснээс -г сонгоно.**
2. **[All wheel drive]-г сонгоно.**

Дугуйн даралт

Голын дэлгэц дээр дугуйн даралт анхааруулах системээр мэдэрсэн дугуйн даралтыг гаргах боломжтой.

Голын дэлгэц дээр дугуйн хийн даралт гаргах

1 **Үндсэн менюнээс** **-г сонгоно.**

2 **[Tyre pressure]-г сонгоно.**

Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц

Мэдээллийн дэлгэц, эсвэл HUD дэлгэц дээр дараах системүүдийн ажиллагааг гаргах боломжтой*.

- Динамик радарын хурд баригч
- LTA эгнээ дагахад туслах систем
- LDA эгнээнээс гарах гэж буйг анхааруулах систем
- RSA замын тэмдэг танихад туслах систем*
- Proactive жолоодлогын туслах систем*
- PCS систем

МЭДЭЭЛЭЛ

■ **Дэлгэцийн байрлал (HUD дэлгэцтэй автомашин)**

HUD дэлгэцийн горимыг бүх мэдээлэл харуулах горимд тохируулсан үед жолоодлогод туслах системийн мэдээлэл HUD дэлгэц дээр гарах ба мэдээллийн дэлгэц дээр гарахгүй.

Аудио системтэй холбоотой дэлгэц

Аудио системтэй холбоотой дэлгэц нь мэдээллийн дэлгэц дээр аудио системийн ажиллагааны байдлыг харуулна.

Аудио эх үүсвэр, эсвэл дуу сонгох зэрэг үйлдлийг хийх боломжтой.

Навигацийн системтэй холбоотой дэлгэц*

Мэдээллийн дэлгэц дээр дараах мэдээлэл гарна.

- Хүрэх газар хүртэлх маршрут заах
- Гудамжны нэр
- Луужин

МЭДЭЭЛЭЛ

■ **Дэлгэцийн байрлал (HUD дэлгэцийн байрлал)**

HUD дэлгэцийн тохиргооноос хамаарч зарим мэдээлэл мэдээллийн дэлгэц дээр гарахгүй боловч HUD дэлгэц дээр гарч болно.

*: Тоноглогдсон автомашинд

Автоматаар гарч ирдэг дэлгэцийн мэдээлэл

Автоматаар гарч ирдэг дэлгэц нь мэдээллийн болон HUD дэлгэц дээр* шаардлагатай үед гардаг.

Автоматаар гарч ирдэг дэлгэц гарсан үед тухайн гарч байсан дэлгэцийн гарахаа болих ба автоматаар гарч ирдэг дэлгэц унтах үед дахин гарна.

Жолоодлогод туслах системүүд

Анхааруулах/санал болгох/зөвлөх мэдээллийг дэлгэц дээр гаргах, эсвэл холбогдох системийн ажиллагааг харуулах.

- Динамик радарын хурд баригч
- LTA систем
- LDA систем
- Идэвхтэй жолоодлогод туслах систем*
- PCS систем
- RSA систем
- Аюулгүйгээр буухад туслах систем (хаалга нээх удирдлагатай)
- FCTA функц

Анхааруулах мэдээлэл

Зарим анхааруулах мэдээлэл нь тодорхой нөхцөлд шаардлагатай үед дэлгэц дээр гардаг.

Гарны оролцоогүй системийн ажиллагааны статус

Гарны оролцоогүй систем ажиллах үед дэлгэцээр гарна.

Зөвлөмж функц

Дараах нөхцөлд жолоочид зөвлөмж болгох мэдээлэл гарч ирнэ. Зөвлөмжийн дэлгэрэнгүйг жолооны хүрдний товч даран харна уу.

■ Тээшний автомат хаалга идэвхжүүлэх зөвлөмж*

Тээшний автомат хаалганы ажиллагаа цуцласан (голын толины тохиргоог унтраасан) нөхцөлд хянах самбар дахь тээшний автомат хаалганы товч дарсан үед тээшний автомат хаалга идэвхжүүлэх эсэх тухай зөвлөмж дэлгэцээр гарна.

Тээшний автомат хаалга идэвхжүүлэх үед [**Yes**]-г дарна.

Тээшний автомат хаалгыг идэвхжүүлсний дараа тээшний автомат хаалганы товч дарж хаалга нээх буюу хаана.

* : Тоноглогдсон автомашинд

■ Автомат цонх хаах зөвлөмж (шил арчигчийн ажиллагаатай холбоотой)

Цонх нээлттэй үед шил арчигч ажиллуулсан нөхцөлд цонх хаах эсэх тухай зөвлөмж дэлгэцээр гарна.

Бүх цонх хаах үед [**Yes**]-г дарна.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

Жолооны хүрдний товчны ажиллагааны дэлгэц

■ HUD дэлгэцгүй автомашин

Жолооны хүрдний аудио удирдлагын товч дарсан үед гарна.

■ HUD дэлгэцтэй автомашин

Жолооны хүрдний аудио удирдлагын товч дарсан үед фунцкийн тайлбарын хамт дэлгэц гарна.

Холбоотой холбоосууд

Хянах самбар/дэлгэц удирдах(Х. 335)

Навигацийн системтэй холбоотой мэдээлэл*

Тодорхой нөхцлүүдэд навигацийн системтэй холбоотой дараах зүйлс дэлгэц дээр гарнаа:

- Очих газар хүртэлх маршрут заагч
- Газрын зургийн дэлгэц (HUD дэлгэц * дээр гарна)

Асаах товч унтраах үед дэлгэцээр гарах зүйлс

Асаах товч унтраах үед дараах зүйлс мэдээллийн дэлгэц дээр гарна.

- Асааснаас хойших дундаж шатахуун зарцуулалт*1
- Асааснаас хойших туулсан зай*1
- Асааснаас хойших жолоодлогын хугацаа*1

* :Тоноглогдсон автомашинд

*1 :Хөдөлгүүр унтрах бүрт заалт тэглэгдэнэ.

Хянах самбарын гэрлийн түвшин тохируулах

Хянах самбарын гэрлийн түвшинг тохируулах боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

Оврын гэрэл асаалттай болон унтарсан үеийн хянах самбарын гэрлийн түвшинг тус бүр тохируулах боломжтой.

Нөгөөтэйгүүр орчны гэрэл хүчтэй (өдрийн цагаар зэрэг) үед оврын гэрэл асаасан ч хянах самбарын гэрлийн түвшин өөрчлөгдөхгүй.



1 Бүдэг
2 Тод

HUD дэлгэцийн тохиргоо өөрчлөх

⚠ АЮУЛТАЙ

- Аюулгүй жолоодлогод HUD дэлгэцийн байрлал, гэрлийн түвшин саад болохгүй байгааг нягтлана.

  Дүрсний байрлал, гэрлийн түвшинг буруу тохируулснаар жолоочид харагдах байдалд саад учруулж улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.
- Тохиргоо хийх үед хөдөлгүүр асаалттай байх шаардлагатай тул автомашиныг агааржуулалт сайтай газар зогсооно. Битүү орчинд нүүртөрөгчийн дутуу исэл (CO) зэрэг хорт хий агуулагддаг утаа хуримтлагдаж автомашины дотор орох, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

⚠ АНХААР

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж хөдөлгүүр асаалттай үед HUD дэлгэцийн тохиргоо хийнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Жолооны хүрдний товчоор тохиргоог өөрчлөх

Жолооны хүрдний товчны тогтмол ашигладаг функцад дараах зүйлсийг сануулсан үед HUD дэлгэцийн тохиргоог жолооны хүрдний товчоор хийх боломжтой.

-

: Дэлгэц асаах/унтраах
-

: Дэлгэцийн горим
-
/
: Өндөр
-
/
: Гэрлийн түвшин

■ HUD дэлгэц асаах/унтраах

HUD дэлгэцийг унтраасан үед асаах товч унтраагаад дахин ON горимд асаах хүртэл асахгүй.

■ Дэлгэцийн гэрлийн түвшин

Орчны гэрлийн хэмжээнд нийцүүлэн гэрлийн түвшний тохиргооноос гадна дэлгэцийн гэрлийн түвшин автоматаар өөрчлөгдөнө.

■ **HUD дэлгэцийн байрлалын автомат тохиргоо (жолоодлогын байрлал санах ойтой автомашин)**

Дэлгэцийн байрлалыг сануулсан үед HUD дэлгэцийн байрлал автоматаар тохируулагдана.

1 **Голын дэлгэц дээр ⚙ -г сонгоно.**

2 **[Vehicle customise]-г сонгоно.**

3 **[Head-up display]-г сонгоно.**

HUD дэлгэцийн дараах тохиргоог өөрчлөх боломжтой.

- Дэлгэц асаах/унтраах
- Дэлгэцийн горим
- Өндөр
- Гэрлийн түвшин
- Өнцөг

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(X. 675)

6 Жолоодлогод туслах систем

6-1. Аюулгүй жолоодлогыг дэмжих функцууд

Lexus Safety System + ... 350

Жолоодлогод туслах системүүд 358

6-2. Аюулгүй жолоодлогод туслах функц ашиглах

Мөргөлтийн өмнөх систем 367

LTA эгнээ дагахад туслах систем 383

LDA эгнээнээс гарах гэж буйг анхааруулах систем 388

Эгнээ солих үед арын автомашин мэдрэхэд дэмжих дэмжлэг 394

Автомашины хойд талын мэдрэх боломжтой объектыг мэдэрч дохио дуугаргах, дэлгэцээр анхааруулга гаргаж анхааруулах, эсвэл хаалга нээх ажиллагааг цуцлан аюулгүйгээр буухад туслах 400

Бага хурдаар объектод ойртох үеийн анхааруулах дохио анхааруулга 407

Бага хурдаар явж байгаа үед ард талд автомашин мэдрэгдсэн үеийн дуут дохио, дэлгэцийн анхааруулга 415

Бага хурдаар явах үед ард талд явган зорчигч мэдрэгдсэн үеийн дуут дохио ба дэлгэцийн мэдээлэл 422

Бага хурдаар ойртох үед объект мэдрэгдсэн үеийн тоормосны ажиллагаа 427

RSA замын тэмдэг танихад туслах систем ... 439

Динамик радарын хурд баригч 442

Хурд баригч 455

Хааз болон тоормосны дөрөөг зэрэг гишгэсэн үед хөдөлгүүрийн хүчийг хязгаарлах 460

Огцом хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах удирдлага 461

6-3. Мөргөлтийн үед жолооч, зорчигчид ирэх нөлөөг бууруулах

Зорчигчид ирэх мөргөлтийн хүчийг бууруулах 462

Lexus Safety System +

Lexus Safety System + нь жолоодлогод туслах системүүдээс бүрдэх ба аюулгүй, тав тухтай жолоодлогыг бүрдүүлдэг.

⚠ АЮУЛТАЙ

■ Lexus Safety System +

Lexus Safety System + нь жолооч аюулгүй жолоодох нөхцөлд ажиллах бөгөөд мөргөлт үүссэн үед жолооч зорчигчид ирэх нөлөөг бууруулах, жолоодлогын хэвийн нөхцөлд жолоочид тусладаг.

Системийн ажиллагааны нарийвчлал болон үйлчлэл нь хязгаартай тул ажиллагаанд хэт найдахыг хориглоно. Жолооч хөдөлгөөнд цаг ямагт аюулгүй оролцох, ойр орчимдоо анхаарал хандуулах үүрэгтэй.

■ Ашиглалтын аюулгүй байдал

- Системд хэт найдаж болохгүй. Жолооч орчны аюулгүй байдлыг нягтлан аюулгүй жолоодлого хийх үүрэгтэй. Систем тохиолдол бүрт ажиллахгүй байж болох ба үзүүлэх дэмжлэг хязгаартай. Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.
- Систем хэвийн ажиллахгүй байх, улмаар осол үүсгэж болзошгүй тул ажиллагааг турших, шалгахыг хориглоно.
- Жолооч анхаарал хандуулах шаардлагатай, эсвэл систем доголдсон үед анхааруулга, эсвэл дуут дохио дуугарч анхааруулна. Дэлгэц дээр анхааруулга гарсан үед анхааруулгын зааварчилгааг баримтлана.
- Гадаад дуу чимээ, аудио системийн дуу зэргээс хамаарч анхааруулах дохио муу сонсогдож болно. Мөн замын нөхцөл байдлаас хамаарч системийн ажиллагааг мэдрэхэд хүндрэлтэй байж болно.

■ Системийг цуцлах шаардлагатай нөхцлүүд

Дараах нөхцөлд системийг цуцлана.

Эсрэг тохиолдолд систем хэвийн ажиллахгүй байх, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- Даац хэтэрсэн, дугуй хагарснаас шалтгаалан автомашин хазайсан
- Хэт өндөр хурдаар явах үед
- Өөр автомашин чирэх үед
- Ачааны машин, усан онгоц, вагон зэргээр тээвэрлэх.
- Автомашиныг лифтээр өргөсөн ба дугуй чөлөөтэй эргэж байгаа
- Автомашиныг динамометр, спидометрийн тестер зэрэг дамар хийцтэй төхөөрөмж дээр оношилгоо хийх, тэнхлэг тохиргоо хийх
- Автоспорт, эсвэл бартаат зам дээр жолоодох
- Автомат авто угаалга ашиглах
- Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтонд өртсөнөөр мэдрэгчийн тусгал алдагдсан

⚠ АЮУЛТАЙ

- Мэдрэгчийг халхлах нэмэлт тоноглол, эсвэл гэрэл суурилуулсан үед
- Жижиг нөөц дугуй, эсвэл гинж угсарсан, эсвэл онцгой нөхцөлд ашиглах дугуйн нөхөөс ашигласан
- Дугуй хэт элэгдсэн, эсвэл дугуйн хий хэт сул
- Үйлдвэрлэгчийн зөвлөснөөс өөр хэмжээтэй дугуй ашигласан
- Мөргөлт, доголдлоос хамааран автомашиныг тогтвортойгоор жолоодох боломжгүй.

■ Жолоодлогод туслах системүүд

- AHS холын гэрэл
  → X.209
- AHB автомат холын гэрэл
  → X.213
- PCS мөргөлтийн өмнөх систем
  → X.367
- LTA систем
  → X.383
- LDA систем
  → X.388
- RSA систем*
  → X.439
- Динамик радарын хурд баригч
  → X.442

Lexus Safety System + системийн мэдрэгчүүд

Системийн ажиллагаанд шаардлагатай мэдээллийг олон төрлийн мэдрэгч ашиглан бүрдүүлдэг.

■ Урд



A Урд радарын мэдрэгч
B Урд камер

*: Тоноглогдсон автомашинд

■ Хойд



Хойд хажуу радарын мэдрэгч

⚠ АЮУЛТАЙ

■ Радарын доголдлоос урьдчилан сэргийлэх

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд радарын мэдрэгчийн хэвийн ажиллахгүй байх, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- Радарын мэдрэгч болон радарын мэдрэгчийн тагийг цаг ямагт цэвэр байлгана.

  Урд радарын мэдрэгч, эсвэл радарын мэдрэгчийн тагны урд хойд талыг усны дусал, цас зэрэг тогтсон үед цэвэрлэнэ.

  Радарын мэдрэгч болон радарын мэдрэгчийн тагийг гэмтээлгүйгээр зөөлөн даавуугаар цэвэрлэнэ.



A Радарын мэдрэгч
B Радарын мэдрэгчийн таг

- Радарын мэдрэгч, радарын мэдрэгчийн таг, эдгээрийн ойр орчимд нэмэлт тоноглол, наалт (тунгалаг мөн хамаарна), хөнгөн цагаан ялтас зэргийг наахыг хориглоно.
- Радарын мэдрэгч, түүний ойр орчмыг хүчтэй цохилтоос хамгаална.
- Радарын мэдрэгч, радиаторын тор, урд гупер хүчтэй цохилтод өртсөн бол та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.
- Радарын мэдрэгчийг задлаж болохгүй.
- Радарын мэдрэгч, радарын мэдрэгчийн тагийг будах, өөрчлөх, эсвэл Lexus-н оригинал бус тоноглолоор солихыг хориглоно.
- Дараах нөхцлүүдэд радарын мэдрэгчийг дахин тохируулах шаардлагатай.

  Дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу.

⚠ АЮУЛТАЙ

- Радарын мэдрэгчийг салгаад угсарсан, эсвэл солисон
- Урд гупер, эсвэл урд радиаторын торийг солисон

■ Урд камерыг доголдлоос сэргийлэх

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд урд камерын хэвийн ажиллагаа алдагдах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- Салхины шилийг цаг ямагт цэвэр байлгана.
  - Салхины шил бохирдсон эсвэл тосорхог давхарга, усны дусал, цас зэрэг тогтсон үед салхины шилийг цэвэрлэнэ.
  - Салхины шилэнд өнгөлгөөний бодис түрхсэн ч салхины шилний урд камерын урд талын ойр орчимд тогтсон усны дусал зэргийг шил арчигч ажиллуулан арчиж цэвэрлэх шаардлагатай.
  - Урд камер суурилагдсан салхины шилний дотор тал бохирдсон үед Lexus дилертээ хандана уу.
- Урд камерны урд талын салхины шилний хэсэгт (зурагт саарлаар үзүүлсэн хэсэг) наалт (тунгалаг наалт хамаарна), эсвэл бусад эд зүйлсийг нааж болохгүй).



A 4см (1.6 in.)
B 4см (1.6 in.)

- Урд камерны урд талын салхины шилний хэсэг цантсан, хөлөрсөн, мөстсөн үед салхины шилний цан арилгагч ашиглан шилэн дээр тогтсон, цан, хөлрөлт, мөс зэргийг цэвэрлэнэ.
- Урд камерны урд талын салхины шилний хэсэгт тогтсон усны дуслыг салхины шилний шил арчигч гүйцэд арчихгүй үед салхины шилний шил арчигч шинээр солино.
- Салхины шилэнд цонхны хуулга нааж болохгүй.
- Салхины шил гэмтсэн, цуурсан үед шинээр солино.

  Салхины шилийг шинээр солисон үед урд камерыг дахин тохируулах шаардлагатай.

  Дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу.
- Урд камерт шингэн хүргэж болохгүй.
- Урд камер луу хүчтэй гэрэл тусгаж болохгүй.
- Урд камерны линз гэмтэх, линз бохирдохоос сэргийлнэ.

⚠ АЮУЛТАЙ

Салхины шилний дотор талыг цэвэрлэх үед шил угаагч бодис урд камерны линзэнд хүрэхээс сэргийлнэ. Урд камерны линзэнд шууд хүрч болохгүй.

Урд камерны линз бохирдсон, эсвэл гэмтсэн үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

- Урд камерыг хүчтэй цохилтоос хамгаална.
- Урд камерын байрлал, эсвэл тусгалыг өөрчлөх, камер салгаж болохгүй.
- Урд камерыг задлаж болохгүй.
- Урд камерын ойролцоох голын толь, тааз зэрэг эд ангиудыг өөрчилж болохгүй.
- Капот, урд радиаторын тор, эсвэл урд гупер дээр урд камерыг халхлах аливаа нэмэлт тоноглол суурилуулахгүй.

  Дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу.
- Серфингийн хавтан, эсвэл бусад урт зүйл дээвэр дээр байрлуулсан үед эдгээр нь урд камерыг халхлахгүй байхаар байрлуулна.
- Их гэрэл болон бусад гэрлийг өөрчилж болохгүй.

Салхины шилэн дээр урд камер суурилуулсан хэсэг

Систем салхины шилийг цантсан гэж мэдэрсэн үед систем автоматаар халаагчийг ажиллуулж салхины шилний урд камерын орчмын цанг арилгахаар ажиллуулна. Түлэгдэх эрсдэлтэй тул систем цан цэвэрлэх үед салхины шил хангалттай хөрөх хүртэл салхины шилний урд камерын ойр орчимд хүрч болохгүй.

МЭДЭЭЛЭЛ

Мэдрэгч хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд

- Автомашин өөрчлөлт хийснээс шалтгаалж автомашины өндөр, их биеийн өнцөг өөрчлөгдсөн үед
- Салхины шил бохирдсон, цантсан, цуурсан, эсвэл гэмтсэн
- Мэдрэгч хэт халуун үед
- Шавар, ус, цас, хорхой шавьж, гадны биет зэрэг мэдрэгчийн урд талд тогтсон үед
- Аадар бороо, манан, цас, эсвэл шороон шуурга зэрэг цаг агаар муу үед
- Урд талын автомашинаас ус, цас, шороо зэрэг шидэгдэх, эсвэл манан болон утаан дундуур явах үед
- Шөнийн цагаар, эсвэл хонгилоор явах зэргээр харанхуй замаар их гэрэл асаалгүйгээр явах үед
- Их гэрлийн линз бохирдсон ба гэрэл бүдэг тусч байгаа
- Их гэрлийн тусгал алдагдсан
- Их гэрлийн хэвийн ажиллагаа алдагдсан

- Бусад автомашины их гэрэл, нарны туяа, эсвэл ойсон гэрэл урд камер луу шууд тусч байгаа үед
- Орчны гэрлийн хэмжээ огцом өөрчлөгдөх орчинд
- Телевизийн цамхаг, цахилгаан станц, дахин дамжуулах станц, радар тоноглогдсон автомашин зэрэг, эсвэл бусад хүчтэй радио долгион цахилгаан шум ялгаруулдаг газрын ойр орчимд
- Урд камерыг шил арчигч халхалж байгаа үед
- Дараах зэрэг радио долгионыг хүчтэй ойлгодог объектын хажуугаар, ойр орчимд явах үед:
  - Хонгил
  - Төмөр карказан гүүр
  - Хайрган зам
  - Дугуйны ховил үүссэн, цасаар хучигдсан зам
  - Хана
  - Том ачааны машин
  - Траншейны таг
  - Төмөр хавтан
  - Замын хашлага
- Шат, эсвэл товойсон хэсэг
- Бага оврын моторт тэрэг зэрэг таних боломжтой автомашин нарийн хэлбэртэй
- Ачаагүй ачааны автомашин зэрэг таних боломжтой автомашины урд болон хойд тал нь нарийн
- Намхан тэвштэй ачааны машин зэрэг таних боломжтой автомашины урд болон хойд тал нь намхан



- Хэт өндөрлөсөн зэрэг таних боломжтой автомашин газраас өндөр үед



- Тэвшний хэсгээс илүү гарсан ачаа тээш тээвэрлэж яваа автомашин

- Хэсэгчлэн даавуу зэргээр халхлагдсан зэрэг таних боломжтой автомашины металл гадаргуу бага үед.
- Трактор, мотоциклын шаахай зэрэг таних боломжтой тээврийн хэрэгсэл онцгой хэлбэртэй үед.
- Таны автомашин болон таних боломжтой автомашин хоорондын зай хэт ойртсон үед
- Таних боломжтой автомашин ташуу өнцөгтэй байгаа
- Таних боломжтой автомашин дээр цас, мөс, тоос зэрэг тогтсон үед
- Дараах төрлийн замаар явах үед:
  - Огцом эргэлттэй, эсвэл мушгиралдсан зам
  - Огцом өгсүүр, уруу зэрэг налуугийн хэмжээ их өөрчлөгддөг зам
  - Баруун, эсвэл зүүн тийш налуу зам
  - Гүнзгий ховилтой зам
  - Эвдэрсэн, зам засвар хийгдээгүй зам
  - Энхэл донхол ихтэй тэгш бус зам
- Жолооны хүрдийг байнга, эсвэл огцом эргүүлж байгаа үед
- Автомашин эгнээ дотроо тогтмол нэг байрлалд явахгүй үед
- Тоормос зэрэг системтэй холбоотой эд ангиуд хэт халсан, эсвэл хэт хөрсөн, норсон зэрэг.
- Тэнхлэг тохиргоо алдагдсан
- Цас, мөс, хайрга зэргээр хучигдсан хальтиргаатай гадаргуутай замаар явах үед.
- Замын эргэлтийн хэлбэрээс хамаарч автомашины чиглэл өөрчлөгдөх зам
- Эргэлттэй хэсэг рүү орох үеийн автомашины хурд хэт өндөр
- Авто зогсоол, гараж, авто лифт зэрэгт орох, гарах үед
- Авто зогсоол дотор явах үед
- Өндөр өвс, модны мөчир, хөшиг зэрэг таны автомашинд хүрч болох саадны дундуур явах үед

■ **Замын шугам танигдахгүй байж болох нөхцлүүд**

- Замын эгнээ хэт өргөн, эсвэл хэт нарийн
- Замын эгнээ солисон даруйд, эсвэл уулзвараар нэвтрэх үед
- Түр зуурын эгнээ, эсвэл зам засвараас шалтгаалан зохицуулагдаж буй зам
- Ойр орчимд замын шугамтай төстэй объект, хээ, сүүдэр зэрэг байгаа үед
- Эгнээний шугам тод харагдахгүй, эсвэл замын гадаргуу нойтон үед
- Замын эргэлттэй хэсгийн шугам
- Төмөр бетон зэрэг тод, гэрэл ойлгодог зам дээр явах үед

■ **Системийн аль нэг, эсвэл бүх функцууд хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд**

- Тус систем, эсвэл тоормос, жолооны механизм зэрэг холбоотой системүүдэд доголдол илэрсэн үед
- VSC, TRC, эсвэл бусад аюулгүй байдалтай холбоотой системүүд ажиллаж байгаа
- VSC, TRC, эсвэл бусад аюулгүй байдалтай холбоотой системүүд унтарсан

■ **Тоормосны ажиллагааны дуу болон дөрөөний гишгэлт өөрчлөгдөх**

- Тоормос гишгэх үед тоормосны ажиллагааны дуу сонсогдох, мөн тоормосны дөрөөний гишгэлт өөрчлөгдөж болох ба энэ нь аливаа доголдлыг илэрхийлэхгүй.
- Систем ажиллах үед тоормосны дөрөө илүү хатуу, эсвэл зөөлөн бөгөөд доош гишгэгдэж болно. Аль ч нөхцөлд тоормосны дөрөөг нэмж гишгэж болно. Шаардлагатай үед дөрөөг нэмж гишгэнэ.

Жолоодлогод туслах системүүд

Хөдөлгөөний аюулгүй байдал, жолоодлогыг сайжруулах үүднээс замын нөхцөл байдлаас хамаарч дараах системүүд автоматаар ажилладаг. Нөгөөтэйгүүр эдгээр систем нь зөвхөн туслах үүрэгтэй тул жолоодлогын үед системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй.

■ ABS үл түгжигдэх тоормосны систем

Тоормос огцом ажиллах үед дугуй түгжигдэхээс сэргийлэх, мөн хальтиргаатай зам дээр тоормос гишгэх үед туслана.

■ Тоормосонд туслах систем

Систем ослын зогсолт хийж байна гэж тооцоолсон үед тоормосны дөрөө гишгэх үед тоормосны хүчийг нэмнэ.

■ VSC систем

Шарвалт үүссэн, эсвэл хальтиргаатай зам дээр эргэлт хийх үед автомашины тэнцвэр хадгалахад туслана.

ABS, TRC, VSC болон EPS системүүдийн цогц дэмжлэг үзүүлнэ.

Хальтиргаатай зам дээр шарвалт үүссэн үед жолооны механизмыг удирдах замаар автомашины явах шулуун чиглэлийн тэнцвэрийг хадгална.

■ Чиргүүлийн савалгааг хянах систем*

Чиргүүл савлах үед дугуйнд тус бүр өөр хүчээр тоормос өгөх, мөн хөдөлгүүрийн мушгих хүчийг удирдах замаар чиргүүл савлалтыг зогсооход туслана.

■ TRC (Traction Control) систем

Хальтиргаатай зам дээр хөдөлгөөн эхлэх, хурд авах үед хөтлөх дугуйг хий эргэхээс сэргийлэх ба автомашины зүтгэх хүчийг тогтмол барихад туслах систем

■ Идэвхтэй эргэлтийн туслах функц (ACA)

Эргэлтийн үед хурд нэмэх үйлдэл хийх хийсэн нөхцөлд автомашин тойргийн гадагш даялхаас сэргийлж дотор талын дугуйны тоормосыг удирдана.

■ Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага

Өгсүүр замд хөдөлгөөн эхлэх үед тус автомашин арагш өнхрөхөөс сэргийлэхэд туслах систем.

* : Тоноглогдсон автомашинд

■ VGRS (Variable Gear Ratio Steering) систем

Жолооны хүрдний эргэлтэд нийцүүлэн урд дугуйн эргэлтийн өнцгийг тохируулна.

■ EPS цахилгаан жолооны хүчлүүр

Жолооны хүрд эргүүлэхэд шаардагдах хүчийг бууруулах үүднээс цахилгаан мотор ашигладаг.

■ Динамик мушгих хүчний удирдлагатай AWD систем (NX250: AWD загвар)

Хэвийн жолоодлого, эргэлт, өгсүүр, хөдөлгөөн эхлэх, хурд нэмэх, цас бороотой хальтиргаатай замаар явах зэрэг жолоодлогын нөхцөлд нийцүүлэн жолоодлогын системийг урд дугуй хөтлөх, эсвэл AWD (бүх дугуй хөтлөх) горимд автоматаар шилжүүлэх замаар жолоодлого, хөдөлгөөний тогтвортой байдлыг хангахад тусладаг.

■ AVS (Adaptive Variable Suspension) систем *

Замын нөхцөл байдал, жолоодлогоос хамаарч 4 дугуйн амортизаторын ажиллагааг тус бүр өөрөөр удирдаж жолоодлогын тав тух, тэнцвэр, мөн автомашины байрлалыг хадгалахад тусладаг.

Мөн сонгосон жолоодлогын горимд нийцүүлэн амортизаторын ажиллагаа өөрчлөгдөнө.

■ Ослын тоормосны сигнал

Огцом тоормос хийсэн үед ослын дохионы гэрэл автоматаар анивчин асч арын жолоочид анхааруулга өгнө.

■ Хоёр дахь мөргөлтийн тоормос

SRS аюулгүйн дэрний мэдрэгч мөргөлтийг мэдэрч систем ажиллах ба тоормос болон тоормосны гэрэл автомашины хурд бууруулах, хоёр дахь мөргөлтөөс үүсэх нэмэлт хохирлыг бууруулах үүднээс автоматаар ажиллана.

☐ МЭДЭЭЛЭЛ

■ TRC/VSC системүүд ажиллах үед (чирэх багцгүй автомашин)

TRC/VSC системүүд ажиллах үед шарвалтын индикатор анивчина.



■ TRC/VSC/Чиргүүлийн савалгааг хянах систем ажиллах үед (чирэх багцтай автомашин)

TRC/VSC/Чиргүүлийн савалгааг хянах систем ажиллах үед шарвалтын индикатор анивчина.



■ TRC системийг цуцлах

Автомашин цас, шаварт суусан үед TRC систем дугуйнд дамжуулах хөдөлгүүрийн хүчийг бууруулах магадлалтай. Автомашиныг чөлөөлөх үед [OFF]-г дарж салгаж автомашины зүтгэх хүчийг нэмэх шаардлагатай.

TRC системийг унтраах үед [OFF] товчийг хурдан дараад авна.

The **"Traction Control Turned OFF"** анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гарна. Системийг асаах үед [OFF] товчийг дахин дарна.



■ TRC болон VSC системийг зэрэг унтраах (чирэх багцгүй автомашин)

TRC болон VSC системийг зэрэг унтраах үед [OFF] товчийг автомашин зогссон үед 3-с дээш секунд дарна.

VSC OFF индикатор асч мэдээллийн дэлгэц дээр **"Traction Control Turned OFF"** анхааруулга гарна. Системийг асаах үед [OFF] товчийг дахин дарна.

■ **TRC, VSC болон чиргүүлийн савалгааг хянах систем зэрэг унтраах (чирэх багцтай автомашин)**

TRC, VSC болон чиргүүлийн савалгааг хянах систем зэрэг унтраах үед [OFF] товчийг автомашин зогссон үед 3-с дээш секунд дарна.

VSC OFF индикатор асч мэдээллийн дэлгэц дээр **"Traction Control Turned OFF"** анхааруулга гарна. Системийг асаах үед OFF товчийг дахин дарна.

■ **Мэдээллийн дэлгэц дээр TRC цуцлагдсан гэж [OFF]-г дараагүй нөхцөлд гарсан үед**

TRC түр цуцлагдсан.

Индикатор ассан хэвээр нөхцөлд та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ **Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын ажиллах нөхцөл**

Дараах 4 нөхцөл бүрдсэн үед өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага ажиллана:

- Араа P, эсвэл N-с бусад байрлалд байгаа (Өгсүүр зам өөд урагш/хойш чиглэлд хөдөлгөөн эхлэх)
- Автомашин зогссон
- Хаазны дөрөө гишгээгүй
- Зогсоолын тоормос залгагдаагүй
- Асаах товч ON-д байгаа

■ **Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага автоматаар цуцлагдах**

Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага дараах аль нэг нөхцөлд цуцлагдана:

- Араг P, эсвэл N-д шилжүүлсэн
- Хаазны дөрөө гишгэсэн
- Зогсоолын тоормос залгагдсан
- Тоормосны дөрөө сулласанаас хойш 2 секундээс илүү хугацаа өнгөрөөгүй
- Асаах товч унтраасан

■ **VGRS цуцлагдах нөхцлүүд**

VGRS-н ажиллагаа дараах нөхцлүүдэд цуцлагдаж болно. Энэ нөхцөлд жолооны хүрд эгц шулуун байрлалаасаа хөдөлж болох ба системийг дахин асаах үед хэвийн болно.

- Автомашин зогсож байгаа, эсвэл удаан хурдаар явах үед жолооны хүрдийг удаан хугацаанд ажиллуулсан
- Жолооны хүрдийг баруун зүүн тийш бүрэн эргүүлсэн хэвээр барисан

VGRS цуцлагдах үед жолооны хүрдний голын байрлал алдагдаж болно. VGRS дахин идэвхжих үед жолооны хүрд хэвийн байрлалд буцна.

■ **ABS, тоормосонд туслах систем, VSC, чиргүүлийн савалгааг хянах систем, TRC болон өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын системийн ажиллагааны дуу чичиргээ (чирэх багцтай автомашин)**

- Тоормосны дөрөө давтан гишгэсэн, хөдөлгүүр ассан болон эсвэл хөдөлж эхэлсэн даруйд хөдөлгүүрийн хэсгээс дуу гарч болно. Эдгээр нь системүүдэд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.
- Дээрх системүүд ажиллах үед дараах нөхцөл байдал үүсч болно. Эдгээр нөхцлүүд нь системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.
  - Автомашины их бие болон жолооны хүрднээс чичиргээ мэдрэгдэж болно.
  - Автомашин зогссоны дараа моторын дуу сонсогдож болно.
  - ABS ажилласны дараа тоормосны дөрөө чичирч болно.
  - ABS ажилласны дараа тоормосны дөрөө бага зэрэг доошоо бууж болно.

■ **ABS, тоормосонд туслах систем, VSC, TRC болон өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын системийн ажиллагааны дуу чичиргээ (чирэх багцгүй автомашин)**

- Тоормосны дөрөө давтан гишгэсэн, хөдөлгүүр ассан болон эсвэл хөдөлж эхэлсэн даруйд хөдөлгүүрийн хэсгээс дуу гарч болно. Эдгээр нь системүүдэд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.
- Дээрх системүүд ажиллах үед дараах нөхцөл байдал үүсч болно. Эдгээр нөхцлүүд нь системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.
  - Автомашины их бие болон жолооны хүрднээс чичиргээ мэдрэгдэж болно.
  - Автомашин зогссоны дараа моторын дуу сонсогдож болно.
  - ABS ажилласны дараа тоормосны дөрөө чичирч болно.
  - ABS ажилласны дараа тоормосны дөрөө бага зэрэг доошоо бууж болно.

■ **Идэвхтэй эргэлтийн туслах функцийн ажиллагааны дуу, чичиргээ**

Идэвхтэй эргэлтийн туслах функц ажиллах үед тоормосны системээс ажиллагааны дуу болон чичиргээ гарч болох ба энэ нь доголдол биш болно.

■ **EPS болон VGRS ажиллагааны дуу**

Жолооны хүрд эргүүлэх үед моторын дуу(хүнгэнэсэн) сонсогдож болно. Энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.

■ **TRC, чиргүүлийн савалгааг хянах систем, VSC систем автоматаар дахин идэвхжих (чирэх багцтай автомашин)**

TRC, чиргүүлийн савалгааг хянах систем, VSC системийг унтраасны дараа дараах нөхцлүүдэд автоматаар идэвхжинэ:

- Асаах товчийг унтраасан
- Зөвхөн TRC систем унтраасан үед автомашины хурд нэмэгдэхэд TRC идэвхжинэ.

  TRC болон VSC систем зэрэг унтраасан үед автомашины хурд нэмэгдэхэд автоматаар идэвхжихгүй.

■ **TRC, VSC систем автоматаар дахин идэвхжих (чирэх багцгүй автомашин)**

TRC болон VSC системийг унтраасны дараа дараах нөхцлүүдэд автоматаар идэвхжинэ:

- Асаах товчийг унтраасан
- Зөвхөн TRC систем унтраасан үед автомашины хурд нэмэгдэхэд TRC идэвхжинэ.

  TRC болон VSC систем зэрэг унтраасан үед автомашины хурд нэмэгдэхэд автоматаар идэвхжихгүй.

■ **Идэвхтэй эргэлтийн туслах функцийн ажиллах нөхцөл**

Дараах нөхцөл үүссэн үед функц ажиллана.

- TRC/VSC ажиллах боломжтой
- Жолооч эргэлт дээр хурд нэмэх үйлдэл хийсэн
- Автомашин тойргийн гадагш шарваж систем мэдэрсэн
- Тоормосны дөрөө гишгэгдээгүй

■ **Цахилгаан жолооны хүчлүүрийн системийн ажиллагаа буурах**

EPS системийн ажиллагаа жолооны хүрдийг удаан хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулсан үед системийн халалтаас сэргийлж буурна. Энэ үед жолооны хүрд хүнд мэдрэгдэнэ.

Энэ үед жолооны хүрдийг идэвхтэй ашиглахаас татгалзах, эсвэл аюулгүй газарт зогсоод хөдөлгүүр унтраана. Системийн хэвийн ажиллагаа 10 минутын дараа сэргэнэ.

■ **Ослын тоормосны сигнал ажиллах нөхцөл**

Дараах нөхцлүүд бүрдсэн үед ослын тоормосны сигнал ажиллана:

- Ослын дохионы гэрэл асаагүй.
- Автомашины бодит хурд 55 км/ц (35 mph)-с их.
- Систем автомашины хурд хасалтыг огцом тоормосны ажиллагаа гэж тооцсон.

■ **Ослын тоормосны сигналын ажиллагаа автоматаар цуцлагдах**

Ослын тоормосны сигнал дараах нөхцлүүдэд цуцлагдана:

- Ослын дохионы гэрэл асаасан.
- Систем автомашины хурд хасалтыг огцом тоормосны ажиллагаа биш гэж тооцсон.

■ **Хоёр дахь мөргөлтийн тоормос ажиллах нөхцөл**

Автомашины хөдөлгөөний явцад мөргөлт үүссэнийг SRS аюулгүйн дэрний систем мэдрэх үед тус систем ажиллана. Нөгөөтэйгүүр систем дараах нөхцөлд ажиллахгүй.

■ **Хоёр дахь мөргөлтийн тоормосны ажиллагаа автоматаар цуцлагдах нөхцөл**

Дараах аль нэг нөхцөлд системийн ажиллагаа автоматаар цуцлагдана.

- Автомашины хурд 0 км/ц (0 mph) хүртэл буурсан.
- Үйлдэл хийх явцад тодорхой хугацаа өнгөрсөн
- Хаазны дөрөөг их хэмжээгээр гишгэсэн

⚠ АЮУЛТАЙ

■ **ABS дараах нөхцөлд үр дүнтэй ажиллахгүй**

- Дугуйн барьцалдах чадвараас хэтэрсэн (цастай замд элэгдсэн дугуйтай зэрэг) үед.
- Нойтон, хальтиргаатай зам дээр өндөр хурдтай явах үед усан гулгаа үүссэн.

■ **ABS ажиллах үеийн тоормосны зам энгийн үеэс уртсах**

ABS нь тоормосны замыг богиносгоход зориулагдсан систем биш болно. Урд автомашинаас цаг ямагт, ялангуяа дараах нөхцлүүдэд аюулгүй зай барина:

- Шороон, хайрган, эсвэл цасанд хучигдсан зам
- Дугуйн гинж ашиглаж байгаа үед
- Замын товгор хэсгээр явах үед
- Нүхтэй, тэгш бус замаар явах үед

■ **TRC/VSC дараах нөхцөлд үр дүнтэй ажиллахгүй**

Хальтиргаатай замаар явах үед TRC/VSC систем идэвхтэй үед ч автомашины жолоодлого, зүтгэх хүч хүрэхгүй байж болно.

■ **Идэвхтэй эргэлтийн туслах функц үр дүнтэй ажиллахгүй нөхцлүүд**

- Идэвхтэй эргэлтийн туслах функцад хэт найдаж болохгүй. Уруу, эсвэл хальтиргаатай зам дээр хурд нэмэх үед функц үр дүнтэй ажиллахгүй байж болно.
- Идэвхтэй эргэлтийн туслах функцийг олон ашигласан нөхцөлд тоормос, TRC болон VSC системийн хэвийн ажиллагааг хангах үүднээс функцийн ажиллагаа түр цуцлагдаж болно.

⚠ АЮУЛТАЙ

■ **Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага идэвхитэй ажиллахгүй нөхцлүүд**

- Тус системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй. Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага эгц өгсүүр, эсвэл мөстсөн зам дээр идэвхитэй ажиллахгүй.
- Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага нь зогсоолын тоормос шиг автомашиныг удаан хугацаанд хөдөлгөөнгүй барихад зориулагдаагүй. Осолд хүргэх аюултай тул өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагыг өгсүүр замд автомашин зогсоох зорилгоор ашиглаж болохгүй.

■ **TRC/VSC/Чиргүүлийн савалгааг хянах систем идэвхжсэн үед (чирэх багцтай автомашин)**

Шарвалтын индикатор анивчина. Хайнга жолоодлого нь осолд хүргэх аюултай тул цаг ямагт анхааралтай жолоодно. Индикатор анивчих үед илүү өндөр анхаарал хандуулна.

■ **TRC/VSC систем идэвхжсэн үед (чирэх багцгүй автомашин)**

Шарвалтын индикатор анивчина. Хайнга жолоодлого нь осолд хүргэх аюултай тул цаг ямагт анхааралтай жолоодно. Индикатор анивчих үед илүү өндөр анхаарал хандуулна.

■ **TRC/VSC/Чиргүүлийн савалгааг хянах систем унтарсан үед (чирэх багцтай автомашин)**

Тухайн замын нөхцөлд тохирох хурдаар анхаарал болгоомжтой жолоодно.

Эдгээр нь автомашины тэнцвэр, жолоодлогыг сайжруулахад туслах систем тул зөвхөн унтраах зайлшгүй шаардлагатайгаас бусад үед унтрааж болохгүй.

Чиргүүлийн савалгааг хянах систем нь VSC системийн нэг бүрэлдэхүүн хэсэг ба VSC систем унтарсан үед ажиллахгүй, эсвэл доголдоно.

■ **TRC/VSC системүүд унтарсан үед (чирэх багцгүй автомашин)**

Тухайн замын нөхцөлд тохирох хурдаар анхаарал болгоомжтой жолоодно.

Эдгээр нь автомашины тэнцвэр, жолоодлогыг сайжруулахад туслах систем тул зөвхөн унтраах зайлшгүй шаардлагатайгаас бусад үед унтрааж болохгүй.

■ **Дугуй солих**

Бүх дугуйны хэмжээ, үйлдвэрлэгч, хээ болон даац нь ижил байна. Мөн бүх дугуйны хийн даралтын хэмжээ тохиромжтой түвшинд байна.

Чирэх багцтай автомашин:

ABS, TRC, VSC болон чиргүүлийн савалгааг хянах системүүд нь автомашинд өөр өөр дугуй угсарсан үед зөв ажиллахгүй.

Чирэх багцгүй автомашин:

⚠ АЮУЛТАЙ

ABS, TRC, VSC системүүд нь автомашинд өөр өөр дугуй угсарсан үед зөв ажиллахгүй.

Дугуй болон обуд солих үед та өөрийн Lexus дилерт хандаж дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

■ **Дугуй, амортизарын зөв ашиглалт**

Аливаа асуудалтай дугуй ашиглах, өөрчлөлт хийгдсэн амортизаторын системийн эд анги ашиглах нь жолоодлогод туслах системүүдийн ажиллагаанд нөлөөлөх, улмаар эвдрэл гэмтэл учруулах аюултай.

■ **Чиргүүлийн савалгааг хянах системийн анхааруулга (чирэх багцтай автомашин)**

Тус систем нь чиргүүлийн савлагаа үүссэн тохиолдол бүрт савлагааг бууруулах боломжгүй. Автомашин, чиргүүл, замын гадаргуу, жолоодлого хийж буй орчин зэрэг олон хүчин зүйлээс чиргүүлийн савалгааг хянах систем үр дүнтэй ажиллах боломжгүй байж болно. Чиргүүл хэрхэн зөв чирэх тухай мэдээллийг та чиргүүлийн ашиглалтын гарын авлагаас харна уу.

■ **Чиргүүл савласан үед (чирэх багцтай автомашин)**

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Жолооны хүрдийг шулуун чиглэлд хөдөлгөөнгүй чанга барина. Жолоо эргүүлж савлагаа зогсоох арга хэмжээ авч болохгүй.
- Чиргүүл савласан даруйд хурд хасах зорилгоор хаазны дөрөөг аажмаар суллана.

  Хурд нэмэхийг хориглоно. Тоормос гишгэхийг хориглоно.

  Чиргүүл савласан үед жолооны хүрд, тоормосыг зөвхөн шаардагдах хэмжээнд ашигласан тохиолдолд автомашин болон чиргүүлийн тэнцвэр даруй сэргэнэ.

■ **Хоёр дахь мөргөлтийн тоормос**

Системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй. Систем нь хоёр дахь удаагийн мөргөлтөөс үүсэх хохирлыг бууруулах зориулалттай систем ба нөгөөтэйгүүр олон төрлийн нөхцөл байдлаас хамаарч системийн ажиллагааны үр дүн өөр байж болно. Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

Холбоотой холбоосууд

Дугуй ба обуд(Х. 670)

Мөргөлтийн өмнөх систем

PCS (Pre-Collision System) систем

Pre-collision system буюу PCS нь (→X. 367) урд талын объектыг мэдэрдэг. Урд талын объекттой мөргөлдөх эрсдэл өндөр гэж систем тооцоолсон үед жолоочид мөргөлтөөс зайлсхийх алхам хийх анхааруулга өгөх, мөн боломжит тоормосны хүчийг нэмэгдүүлэх замаар мөргөлтөөс зайлсхийх боломжийг жолоочид олгодог. Систем мөргөлдөх магадлал туйлын өндөр гэж тооцоолсон үед мөргөлтөөс зайлсхийх, мөргөлтийн хүч багасгах үүднээс автоматаар тоормослоно.

PCS системийг идэвхжүүлэх/цуцлах боломжтой ба мөн анхааруулга өгөх хугацааг өөрчилж болно.(→X. 381)

Тухайн улс/бүсээс хамаарч ашиглах боломжтой функц өөр байж болно. Дэлгэрэнгүйг таних боломжтой объект болон функцийн жагсаалтаас харна уу.

⚠ АЮУЛТАЙ

■ **Ашиглалтын аюулгүй байдал**

- Жолооч аюулгүй жолоодлогыг бүрэн хангах үүрэгтэй. Замын хөдөлгөөнд ямагт орчин тойрондоо анхаарал хандуулж оролцоно. Ямар ч тохиолдолд тоормосны оронд PCS систем ашиглахыг хориглоно. Систем тохиолдол бүрт мөргөлтөөс сэргийлэх, мөргөлтийн нөлөө, түүнээс учирч болзошгүй гэмтлийг бууруулж чадахгүй. Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.
- Системийн үндсэн зориулалт нь мөргөлтөөс зайлсхийх, мөргөлтийн нөлөөг бууруулахад туслах, дэмжихэд чиглэгдсэн байдаг. Нөгөөтэйгүүр тухайн байдлаас хамаарч системийн ажиллагаа өөр өөр байж болох тул тохиолдол бүрт системийн ажиллагаа өөр байж болно. Дараах нөхцлийг анхааралтай уншина уу . Системд хэт найдалгүй, ямагт болгоомжтой жолоодно уу.
  - Ашиглалтын аюулгүй байдал: → X.350

■ **PCS системийг цуцлах үед**

- Системийг цуцлах шаардлагатай нөхцлүүд: → X.350

Мэдрэх боломжтой объект ба боломжит функцууд

Систем дараах зүйлсийг мэдрэх боломжтой объектоор мэдрэх боломжтой. (Мэдрэх боломжтой объект нь функцаас хамаарч өөр байна.)

PCS хувилбар	Мэдрэх боломжтой объект	Ажиллах боломжтой функц	Улс/бүс нутаг
1	● Автомашин ● Унадаг дугуй(1) ● Явган зорчигч ● Мотоцикл(1) (1) Зөвхөн хүн унасан үед мэдрэх боломжтой.	Мөргөлтийн өмнөх анхааруулга, мөргөлтийн өмнөх тоормосны дэмжлэг, мөргөлтийн өмнөх тоормос, онцгой үеийн жолооны дэмжлэг, уулзварт мөргөлдөхөөс зайлсхийх дэмжлэг, бага хурдтай үед огцом хурд хязгаарлах функц, амортизаторын удирдлага*	Сингапур, Тайвань, Бруней, Хонконг, Макао, Оман, Катар, Кувейт, Саудын Араб, Бахрейн, АНЭУ, Өмнөд Африк
2	● Автомашин ● Унадаг дугуй(1) ● Явган зорчигч ● Мотоцикл(1)	Мөргөлтийн өмнөх анхааруулга, мөргөлтийн өмнөх тоормосны дэмжлэг, мөргөлтийн өмнөх тоормос, амортизаторын удирдлага*	Индонез, Камбож, Филиппин, Вьетнам, Малайз, Монгол, Йемен, Ливан, Аргентин, Аруба, Гватемал, Коста Рика, Чили, Никарагуа, Панам, Перу, Болив, Гондурас
3	Автомашин	Мөргөлтийн өмнөх анхааруулга	

(1) Зөвхөн хүн унасан үед мэдрэх боломжтой.

Хүснэгтэнд дурдагдсан улс болон бүс нь 2021 оны 9 сарын байдлаарх мэдээлэл болно. Нөгөөтэйгүүр автомашин борлуулагдсан хугацаанаас улс болон бүсийн мэдээлэл өөр байж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

*:Тоноглогдсон автомашинд

Системийн функц

■ Мөргөлтийн өмнөх анхааруулга

Урд талаараа мөргөлдөх магадлалтай гэж систем тооцсон үед анхааруулах дохио дуугаран мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарч жолоочид мөргөлтөөс сэргийлэх арга хэмжээг сануулна.



Тухайн мэдэрсэн объект нь автомашин бол анхааруулгатай хамт тоормос ажиллуулна.

Хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн гэж систем тооцоолсон үед мэдээллийн дэлгэц дээр дараах тэмдэг гарна.



■ Мөргөлтийн өмнөх тоормосны дэмжлэг

Автомашин урд талаараа мөргөлдөх магадлал өндөр гэж систем тооцоолсон үед тоормосны дөрөөг гишгэсэн хүчнээс илүү хүчээр тоормослуулна.

■ Мөргөлтийн өмнөх тоормосны удирдлага

Хэрэв систем урд талаараа мөргөлдөх магадлал туйлын өндөр гэж тооцоолсон үед мөргөлтөөс зайлсхийх, эсвэл мөргөлтийн хурдыг багасгах зорилгоор систем автоматаар тоормос ажиллуулна.

Мөргөлтийн өмнөх тоормосны удирдлагаар автомашин зогссон үед тоормосны дөрөө гишгэх хүртэл систем автомашиныг үргэлжлүүлэн зогсооно.

■ Ослын жолоодлогын туслах

Систем дараах нөхцлүүд үүссэн гэж тооцоолсон үед тус функц нь автомашины тэнцвэрийг хангангаа эгнээнээс гарахаас сэргийлж жолооны хүрдний ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. Ажиллагааны үед мөргөлтийн үеийн анхааруулгаас гадна дараах тэмдэг мэдээллийн дэлгэц дээр гарна.



- Мөргөлдөх магадлал өндөр
- Зайлсхийх маневр хийх хангалттай зай тухайн эгнээнд байгаа

● Жолооч жолооны хүрдтэй харьцаж байгаа

Системийн дэмжлэгийн үед мөргөлтийн өмнөх анхааруулга ажиллах ба дэлгэц дээр мэдээлэл гарна.

■ Уулзварт мөргөлдөхөөс зайлсхийх функц (баруун/зүүн эргэх)

Дараах нөхцлүүдэд урд талаараа мөргөлдөх магадлал өндөр гэж систем тооцоолсон үед тус функц нь анхааруулга өгөх ба мөргөлтийн өмнөх тоормос хийнэ. Уулзвараас хамаарч функц зөв ажиллахгүй байж болно.

● Эсрэг чиглэлийн автомашины урдуур баруун/зүүн эргэх



● Явган зорчигч, унадаг дугуй мэдрэгдсэн үед баруун/зүүн эргэх



■ Уулзварт мөргөлдөхөөс зайлсхийх функц (баруун/зүүн эргэх)

Уулзвар дээр ойртож буй автомашин, мотоциклтой мөргөлдөх магадлал өндөр гэж систем тооцоолсон үед тус функц нь анхааруулга өгөх ба мөргөлтийн өмнөх тоормос хийнэ. Уулзвараас хамаарч функц зөв ажиллахгүй байж болно.



■ Бага хурдтай үед хурд авалт хязгаарлах функц

Бага хурдтай явж байгаа ба хаазны дөрөө хүчтэй гишгэхэд хэрэв мөргөлдөх магадлал өндөр гэж тооцоолсон нөхцөлд хөдөлгүүрийн хүч хязгаарлагдах, эсвэл тоормос ажиллаж хурд авалтаас сэргийлнэ. Ажиллагааны үед дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр анхааруулах индикатор асч мэдээлэл гарна.



■ Амортизаторын удирдлага

Систем мөргөлдөх эрсдэл өндөр гэж тооцоолсон үед AVS систем (→X. 359) автомашины зөв байрлалыг хадгалах үүднээс амортизаторын ажиллах хүчийг удирддаг.

⚠ АЮУЛТАЙ

■ Мөргөлтийн өмнөх тоормос

- Мөргөлтийн өмнөх тоормосны функц ажиллах үед тоормос их хүчээр ажиллана.
- Мөргөлтийн өмнөх тоормос ажиллаж автомашин зогссон үед шаардлагатай нөхцөлд тоормос гишгэнэ.
- Дараах нөхцлүүдэд мөргөлтийн өмнөх тоормос ажиллсаны дараа тоормос баригч ажиллахгүй. Нөхцөл байдалд нийцүүлэн жолооч даруй тоормосны дөрөө гишгэх шаардлагатай.
  - Хаазны дөрөө гишгэсэн
  - Уулзварт мөргөлдөхөөс зайлсхийх функцийн ажиллаж автомашин зогссон үед
  - Автомашин налуу зам дээр зогссон үед
- Мөргөлтийн өмнөх тоормосны функц нь жолооч зарим төрлийн үйлдэл хийсэн үед ажиллахгүй. Хааз хүчтэй гишгэсэн, эсвэл жолооны хүрд эргүүлсэн үед систем жолоочийг мөргөлтөөс зайлсхийх үйлдэл хийж байна гэж тооцоолох, улмаар мөргөлтийн өмнөх тоормосны функц ажиллахгүй байж болно.
- Тоормосны дөрөө гишгэсэн үед систем жолоочийг мөргөлтөөс зайлсхийх үйлдэл хийж байна гэж тооцоолон мөргөлтийн өмнөх тоормосны функцийн ажиллах хугацааг хойшлуулж болно.

■ Бага хурдтай үед хурд авалт хязгаарлах функц

Жолооны хүрд эргүүлсэн үед систем жолоочийг зайлсхийх үйлдэл хийж байна гэж тооцоолон бага хурдтай үед хурд авалт хязгаарлах функцийг ажиллуулахгүй байж болно.

⚠ АЮУЛТАЙ

■ Ослын жолоодлогын туслах

- Эгнээнээс гарахаас сэргийлэх удирдлагын ажиллагаа дууссан гэж систем тооцоолсон Ослын жолоодлогын туслах цуцлагдана.
- Жолоочийн хийсэн үйлдлээс хамаарч ослын жолоодлогын туслах ажиллах, эсвэл ажиллагагаа цуцлагдаж болно.
  - Хаазны дөрөө хүчтэй гишгэсэн, жолооны хүрд их хэмжээгээр эргүүлсэн, тоормосны дөрөө гишгэсэн, эргэх дохионы хөшүүрэг түлхсэн үед систем жолоочийг зайлсхийх үйлдэл хийж байна гэж тооцоолох ба ослын жолоодлогын туслах ажиллахгүй байж болно.
  - Ослын жолоодлогын туслах ажиллах үед хаазны дөрөө хүчтэй гишгэсэн, жолооны хүрд их хэмжээгээр эргүүлсэн, тоормосны дөрөө гишгэсэн, эргэх дохионы хөшүүрэг түлхсэн үед систем жолоочийг зайлсхийх үйлдэл хийж байна гэж тооцоолох ба ослын жолоодлогын туслахын ажиллагаа цуцлагдана.
  - Ослын жолоодлогын туслах ажиллах үед жолооны хүрдийг чанга барисан, эсвэл системийн ажиллагааны эсрэг чиглэлд эргүүлсэн нөхцөлд ослын жолоодлогын туслахын ажиллагаа цуцлагдана.

МЭДЭЭЛЭЛ

■ Мөргөлтийн өмнөх системийн функцуудын ажиллах нөхцөл

Мөргөлтийн өмнөх систем идэвхжсэн ба мэдрэгдсэн объекттой урд талаараа мөргөлдөх эрсдэл өндөр гэж систем тооцоолсон үед.

Нөгөөтэйгүүр систем дараах нөхцөлд ажиллахгүй:

- Аккумуляторын шон салгаад дахин залгаснаас хойш автомашин тодорхой хугацаанд яваагүй яваагүй үед
- Араа R байрлалд байгаа үед

  Араа R байрлалд байгаа үед
- VSC OFF индикатор ассан үед (зөвхөн мөргөлтийн өмнөх анхааруулга ажиллах боломжтой)

Функц тус бүрийн ажиллах хурд болон ажиллагаа цуцлагдах нөхцлүүд:

- Мөргөлтийн өмнөх анхааруулга

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1/2	Урд талын автомашин, зогсож буй автомашин	5-180 км/ц (3-110 миль/ц) орчим	5-180 км/ц (3-110 миль/ц) орчим

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
3	Урд талын автомашин, зогсож буй автомашин	15-180 км/ц (10-110 миль/ц) орчим	15-180 км/ц (10-110 миль/ц) орчим
1	Урдаас ирж буй автомашин	30-180 км/ц (20-110 миль/ц) орчим	80-220 км/ц (50-130 миль/ц) орчим
1/2	Унадаг дугуй	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим
1/2	Явган зорчигч	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим
1	Урд талын мотоцикл, зогсож буй мотоцикл	5-80 км/ц (3-110 миль/ц) орчим	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим
2	Урд талын мотоцикл, зогсож буй мотоцикл	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим
1	Урдаас ирж буй мотоцикл	30-180 км/ц (20-110 миль/ц) орчим	30-180 км/ц (20-110 миль/ц) орчим

Мөргөлтийн өмнөх анхааруулга ажиллах үед жолооны хүрдийг их, эсвэл огцом эргүүлсэн нөхцөлд мөргөлтийн өмнөх анхааруулгын ажиллагаа цуцлагдана.

● Мөргөлтийн өмнөх тоормосны дэмжлэг

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1/2	Урд талын автомашин, зогсож буй автомашин	30-180 км/ц (20-110 миль/ц) орчим	10-180 км/ц (7-110 миль/ц) орчим
1/2	Унадаг дугуй	30-180 км/ц (20-50 миль/ц) орчим	30-180 км/ц (20-50 миль/ц) орчим

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1/2	Явган зорчигч	30-180 км/ц (20-50 миль/ц) орчим	30-180 км/ц (20-50 миль/ц) орчим
1	Урд талын мотоцикл, зогсож буй мотоцикл	30-180 км/ц (20-110 миль/ц) орчим	10-80 км/ц (7-50 миль/ц) орчим
2	Урд талын мотоцикл, зогсож буй мотоцикл	30-180 км/ц (20-50 миль/ц) орчим	10-80 км/ц (7-50 миль/ц) орчим

● Мөргөлтийн өмнөх тоормос

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1/2	Урд талын автомашин, зогсож буй автомашин	5-180 км/ц (3-110 миль/ц) орчим	5-180 км/ц (3-110 миль/ц) орчим
1	Урдаас ирж буй автомашин	30-180 км/ц (20-110 миль/ц) орчим	80-220 км/ц (50-130 миль/ц) орчим
1/2	Унадаг дугуй	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим
1/2	Явган зорчигч	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим
1	Урд талын мотоцикл, зогсож буй мотоцикл	5-180 км/ц (3-110 миль/ц) орчим	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим
2	Урд талын мотоцикл, зогсож буй мотоцикл	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим	5-80 км/ц (3-50 миль/ц) орчим

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1	Урдаас ирж буй мотоцикл	30-180 км/ц (20-110 миль/ц) орчим	30-180 км/ц (20-110 миль/ц) орчим

Мөргөлтийн өмнөх тоормос ажиллах явцад дараах аль нэг нөхцөл үүссэн үед ажиллагаа цуцлагдана:

- Хаазны дөрөө хүчтэй гишгэсэн
- Жолооны хүрдийг их, эсвэл огцом эргүүлсэн

● Ослын жолоодлогын туслах

Эргэх дохионы гэрэл анивчиж байгаа үед ослын жолоодлогын туслах ажиллахгүй.

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1	Урд талын автомашин, зогссон автомашин, унадаг дугуй, явган зорчигч, мотоцикл	40-80 км/ц (25-50 миль/ц) орчим	40-80 км/ц (25-50 миль/ц) орчим

Ослын жолоодлогын туслах ажиллах үед дараах аль нэг үйлдэл хийсэн нөхцөлд ослын жолоодлогын туслахын ажиллагаа цуцлагдана:

- Хаазны дөрөө хүчтэй гишгэсэн
- Жолооны хүрдийг их, эсвэл огцом эргүүлсэн
- Тоормосны дөрөө гишгэсэн

● Уулзварт мөргөлдөхөөс зайлсхийх функц (баруун/зүүн эргэх)

Уулзварт мөргөлдөхөөс зайлсхийх функц (баруун/зүүн эргэх) эргэх дохионы гэрэл асаагүй үед ажиллахгүй.

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Урдаас ирж буй автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1	Урдаас ирж буй автомашин	5-40 км/ц (3-25 миль/ц) орчим	5-75 км/ц (3-45 миль/ц) орчим	25-50 км/ц (7-70 миль/ц) орчим
1	Явган зорчигч	5-30 км/ц (3-20 миль/ц) орчим	-	5-40 км/ц (3-25 миль/ц) орчим
1	Унадаг дугуй	5-30 км/ц (3-20 миль/ц) орчим	-	5-50 км/ц (3-30 миль/ц) орчим
1	Урдаас ирж буй мотоцикл	5-40 км/ц (3-25 миль/ц) орчим	5-75 км/ц (3-45 миль/ц) орчим	10-115 км/ц (7-70 миль/ц) орчим

● Уулзварт мөргөлдөхөөс зайлсхийх функц (баруун/зүүн эргэх)

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Хөндлөн чиглэлийн автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1	Автомашин (хажуу талын)	5-60 км/ц (3-38 миль/ц) орчим	● Таны автомашины хурд (-с бага) ● 40 км/ц (25 миль/ц) хүртэл	5-60 км/ц (3-38 миль/ц) орчим

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Хөндлөн чиглэлийн автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1	Мотоцикл (хажуу талын)	5-60 км/ц (3-38 миль/ц) орчим	● Таны автомашины хурд (-с бага) ● 40 км/ц (25 миль/ц) хүртэл	5-60 км/ц (3-38 миль/ц) орчим

● Бага хурдтай үед хурд авалт хязгаарлах функц

Бага хурдтай үед хурд авалт хязгаарлах функц эргэх дохионы гэрэл асч байгаа үед ажиллахгүй.

PCS системийн хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Таны автомашин болон объектын хоорондын харьцангуй хурд
1	Урд талын автомашин, зогсож буй автомашин	0-15 км/ц (0-9 миль/ц) орчим	0-15 км/ц (0-9 миль/ц) орчим
1	Унадаг дугуй	0-15 км/ц (0-9 миль/ц) орчим	0-15 км/ц (0-9 миль/ц) орчим
1	Явган зорчигч	0-15 км/ц (0-9 миль/ц) орчим орчим	0-15 км/ц (0-9 миль/ц) орчим орчим

PCS хувилбар 1: Бага хурдтай үед хурд авалт хязгаарлах функц ажиллах явцад дараах аль нэг үйлдлийг хийсэн нөхцөлд бага хурдтай үед хурд авалт хязгаарлах функцийн ажиллагаа цуцлагдана:

- Хаазны дөрөө сулласан
- Жолооны хүрдийг их, эсвэл огцом эргүүлсэн

■ **Мэдрэх боломжтой объектыг мэдрэх**

Систем объектыг хэлбэр, хэмжээ болон хөдөлгөөнд үндэслэн мэдэрдэг. Орчны гэрэл хөдөлгөөн, мэдрэх боломжтой объектын байрлал болон чиглэлээс хамаарч мэдрэгдэхгүй байх, улмаар систем зөв ажиллахгүй байж болно. Систем нь дараах хэлбэр дүрсийг мэдрэх боломжтой объект гэж мэдэрдэг.

● PCS хувилбар 1



● PCS хувилбар 2



■ **Мөргөлдөх эрсдэл өндөр биш байсан ч систем ажиллах нөхцлүүд**

● Дараах зэрэг тодорхой нөхцлүүдэд систем мөргөлдөх эрсдэл өндөр гэж тооцоолон ажиллах магадлалтай:

- Мэдрэх боломжтой объектын хажуугаар өнгөрөх үед
- Мэдрэх боломжтой объектыг гүйцэж түрүүлэнгээ эгнээ солисон
- Мэдрэх боломжтой объектод огцом ойртсон үед
- Замын хаалт, шон, мод, хана зэрэг мэдрэх боломжтой, эсвэл замын хажуу талын объектод ойртох үед
- Замын эргэлт, туслах замтай нийлэх хэсэгт мэдрэх боломжтой объект, бусад зүйл байгаа үед



- Автомашины зураг, дүрс, эсвэл самбар зэрэг зүйлсийг мэдрэх боломжтой объект гэж систем буруу танисан

- Эгнээгээ солиж байгаа, эсвэл баруун, зүүн эргэлт хийж буй мэдрэх боломжтой объектын хажуугаар өнгөрөх үед



- Баруун, зүүн эргэлт хийхээр зогссон мэдрэх боломжтой объектын хажуугаар өнгөрөх үед



- Мэдрэх боломжтой объект таны зорчиж буй зам руу орохын өмнө зогссон үед
- Замын дээгүүр байрлах эд зүйлийн (замын тэмдэг, самбар зэрэг) доогуур гарах үед



- Замын постын хаалт, авто зогсоолын хаалт болон бусад нээгдэж хаагддаг хаалтанд ойртох үед
- PCS хувилбар 1: ·Баруун, зүүн эргэлт хийх үед урдаас ирж буй автомашин, эсвэл явган зорчигч урдуур явах үед
- PCS хувилбар 1: Урдаас ирж буй автомашин, эсвэл явган зорчигчийн урдууд баруун, зүүн эргэлт хийх оролдлого хийх үед
- PCS хувилбар 1: Баруун, зүүн эргэлт хийх үед урдаас ирж буй автомашин, эсвэл явган зорчигч таны урдуур орохоос өмнө зогссон
- PCS хувилбар 1: Баруун, зүүн эргэлт хийх үед урдаас ирж буй автомашин таны урдуур баруун, зүүн эргэлт хийсэн



- PCS хувилбар 1: Урдаас ирж буй автомашины чиглэлд жолооны хүрдийг эргүүлсэн

■ **Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд**

● Дараах нөхцлүүдэд урд мэдрэгчээр объектыг мэдрэх боломжгүй байх, улмаар системийн хэвийн ажиллахгүй байж болно:

- Мэдрэх боломжтой объект таны автомашинд ойртон ирэх үед
- Таны автомашин, эсвэл мэдрэх боломжтой объект нааш цааш савлан явж байгаа үед
- Мэдрэх боломжтой объект огцом маневр хийж байгаа (огцом эргэх, хурд нэмэх, хасах зэрэг)
- Мэдрэх боломжтой объектод огцом ойртох үед
- Мэдрэх боломжтой объект хана, хашаа, замын хашлага, траншейны таг, зам дээрх хавтгай төмөр, эсвэл бусад автомашины ойр орчимд байгаа үед
- Мэдрэх боломжтой объектын дээр аливаа эд зүйл байгаа үед
- Мэдрэх боломжтой объект хэсэгчлэн бусад зүйлд халхлагдсан (том ачаа, шүхэр, замын хашлага зэрэг)
- Мэдрэх боломжтой олон объект давхацсан үед
- Нарны туяа зэрэг хүчтэй гэрэл мэдрэх боломжтой объектоос ойж байгаа үед
- Мэдрэх боломжтой объект нь цагаан өнгөтэй ба тод үед
- Мэдрэх боломжтой объектын өнгө, гэрлийн түвшин нь ойр орчимдоо уусч байгаа үед
- Мэдрэх боломжтой объект таны урдуур огцом орж ирсэн, эсвэл таны урд гарч ирсэн
- Ойртож буй автомашины чиглэл ташуу үед
- PCS хувилбар 2: Урд талд мотоцикл байгаа үед
- Урд талд хүүхдийн унадаг дугуй, эсвэл овортой зүйл ачсан, илүү зорчигч суулгасан, эсвэл хэвийн бус хэлбэртэй унадаг дугуй байгаа үед (хүүхдийн суудалтай, эсвэл 2 хүний унадаг дугуй зэрэг)
- Явган зорчигч, эсвэл унадаг дугуй 1 м (3.2 фут)-с нам, эсвэл 2 м (6.5 фут)-с өндөр үед.
- Явган зорчигч, эсвэл унадаг дугуйн дүрс тод бус (бороонд цув, урт юбка өмссөн зэрэг.)
- Явган зорчигч, эсвэл унадаг дугуй урагш тонгойсон, эсвэл явган суусан
- Явган зорчигч, эсвэл унадаг дугуй өндөр хурдтай үед
- Явган зорчигч хүүхдийн тэрэг, тэргэнцэр, унадаг дугуй, эсвэл өөр зүйл түрсэн үед

- Бүдэг (өглөө, үдэш), эсвэл харанхуй (шөнө, эсвэл хонгилд) зэргээр мэдрэх боломжтой объект ойр орчиндоо уусан харагдаж байгаа үед)
- Хөдөлгүүр асааснаас хойш тодорхой хугацааны турш автомашиныг жолоодоогүй үед
- Баруун, зүүн эргэснээс хэдэн секундын дотор дахин баруун, зүүн эргэсэн
- Эргэлтээр эргэснээс хэдэн секундын дотор дахин эргэлтээр эргэсэн
- PCS хувилбар 1: Нэгээс олон эгнээгээр тусгаарлагдсан замаар явах үед урдаас ирж буй автомашин баруун, зүүн эргэлт хийх үед
- PCS хувилбар 1: Баруун, зүүн эргэлт хийх үед таны автомашин болон урдаас ирж буй автомашины ихэнхи хэсэг зөрж байгаа үед



- PCS хувилбар 1: Баруун, зүүн эргэх үед явган зорчигч ардаас, эсвэл хажуу талаас ойртсон



● PCS хувилбар 1: Эдгээрээс гадна дараах зарим нөхцлүүдэд ослын жолоодлогын туслах ажиллахгүй байж болно:

- Мэдрэх боломжтой объект автомашинд хэт ойр байгаа
- Зайлсхийх маневр хийх хангалттай зай байхгүй, эсвэл зайлсхийн гарах чиглэлд саад байгаа үед
- Урдаас ирж байгаа автомашин байгаа үед

PCS системийн тохиргоог өөрчлөх

● PCS системийг өөрчлөх боломжтой тохиргоогоор идэвхжүүлэх, цуцлах боломжтой.→ X.686

Тус функц нь асаах товчийг ON горимд шилжүүлэх бүрт идэвхжинэ.

● Систем цуцлагдсан үед PCS анхааруулах гэрэл болон мэдээлэл мэдээллийн дэлгэц дээр гарна.

● Өөрчлөх боломжтой тохиргоогоор PCS тохиргоог өөрчлөх боломжтой.→ X.686

● PCS анхааруулга өгөх хугацааг өөрчилсөн үед онцгой үед жолооний хүрдний ажиллагаанд туслах функцийн (идэвхитэй жолооны функц үл хамаарна) хугацаа мөн өөрчлөгдөнө. [**Later**] сонгогдсон үед ихэнхи тохиолдолд онцгой үед жолооний хүрдний ажиллагаанд туслах функц(идэвхтэй жолооны функц үл хамаарна) ажиллахгүй.

Динамик радарын хурд баригч ажиллах үед хэрэглэгчийн тохиргооноос үл хамааран PCS анхааруулга [**Earlier**] хугацаанд ажиллана.

LTA эгнээ дагахад туслах систем

LTA (Lane Tracing Assist) буюу эгнээ дагахад туслах систем

LTA функц



● Замын эгнээ заах тод шугамтай замаар динамик радарын хурд баригч асаан жолоодох үед урд камер болон радарын мэдрэгт танисан эгнээний шугам, мөн урд талын болон ойр орчмын автомашин гарах ба эгнээн дэх байрлалаа хадгалахад туслаж жолооны хүрдний ажиллагааг дэмжинэ.

Тус функцийг зөвхөн хурдны зам, экспресс зам дээр ашиглана.

Динамик радарын хурд баригч ажиллаагүй үед тус функц ажиллахгүй.

Замын түгжрэл зэргээс шалтгаалан эгнээний шугам муу харагдах, харагдахгүй байх үед урд талын болон ойр орчмын автомашины явсан байрлал дээр үндэслэн функц жолоодлогын дэмжлэг үзүүлнэ.

Систем тодорхой хугацааны турш жолооны хүрдийг ажиллуулаагүй, эсвэл жолооны хүрдийг чанга бариагүй гэж тооцоолсон үед жолоочид дэлгэцээр анхааруулга өгөх ба функцийн ажиллагаа түр цуцлагдана.

Жолооны хүрдийг чанга барих үед функцийн ажиллагаа сэргэнэ.



● Тус функц ажиллаж байгаа ба автомашин явж буй эгнээнээсээ гарах гэж буй үед функц жолоочид дэлгэц болон дуут дохиогоор анхааруулга өгнө.

Дуут дохио дуугарсан үед автомашины ойр орчмыг нягтлаад жолооны хүрдийг болгоомжтой эргүүлж автомашиныг эгнээний гол руу буцаана.

⚠ АЮУЛТАЙ

■ LTA систем ашиглахаас өмнө

● LTA системд хэт найдахыг хориглоно. LTA систем нь жолоодлогод автоматаар дэмжлэг үзүүлдэг систем юм. Нөгөөтэйгүүр энэ нь аюулгүй жолоодлого хийхэд шаардагдах анхаарлыг бууруулах боломж бүрдүүлдэг систем биш юм. Хүрээлэн байгаа орчны нөхцөл байдалд өндөр анхаарал хандуулах, мөн замын чиглэл, байдалд тохируулан жолооны хүрдтэй харьцах замаар жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг цаг ямагт бүрэн хангах үүрэгтэй. Мөн жолооч урт хугацаанд жолоо барихдаа ядарсан үедээ хангалттай амралт авна.

Буруу жолоодлого хийх, анхаарал болгоомж алдах нь осолд хүргэх аюултай.

● LTA систем ашиглаагүй үед LTA товчоор системийг унтраана.

МЭДЭЭЛЭЛ

■ Функцийн ажиллах нөхцөл

● Дараах бүх нөхцлүүд бүрдсэн үед тус функц ажиллана:

- LTA систем эгнээний шугам, эсвэл урд талын болон ойр орчмын автомашины явсан замыг мэдэрсэн (урд талд мотоцикл зэрэг жижиг тээврийн хэрэгсэл байгаагаас бусад үед).
- Динамик радарын хурд баригч ажиллаж байгаа.
- Эгнээний өргөн 3-с 4 м (10-с 13 фут).
- Эргэх дохионы хөшүүрэг ажиллуулаагүй.
- Автомашин огцом эргэлттэй замаар яваагүй үед.
- Автомашин тодорхой хэмжээнээс илүүгээр хурд нэмээгүй, эсвэл хасаагүй.
- Жолооны хүчийг хүчтэйгээр эргүүлээгүй.
- Жолооны хүрднээс гараар бариагүйг анхааруулах анхааруулга (→Х. 385) ажиллаагүй.
- Автомашин эгнээний голоор явж байгаа.

■ Функцийн ажиллагаа түр цуцлагдах

● Ажиллах нөхцөл алдагдсан үед функцийн ажиллагаа түр цуцлагдана. Нөгөөтэйгүүр ажиллах нөхцөл дахин бүрдсэн үед функцийн ажиллагаа автоматаар дахин сэргэнэ. (→Х. 384)

● Функц ажиллаж байх үед хэрэв функцийн ажиллах нөхцөл алдагдвал дуут дохио дуугарч функцийн ажиллагаа түр цуцлагдсаныг илтгэнэ.

● Жолооч жолооны хүрд эргүүлэх үед функцийн жолооны механизмын удирдлага дарагдана.

■ LTA ажиллах үеийн эгнээнээс гарах гэж буйг анхааруулах функцийн ажиллагаа

- LDA функцийн анхааруулга өгөх хэлбэрийг жолооны хүрдний чичиргээ тохиргоонд хийсэн үед ч LTA ажиллах үед автомашин эгнээнээс хазайвал анхааруулах дуут дохио дуугарч жолоочид анхааруулга өгнө.
- Эгнээ солиход шаардагдахтай дүйцэх хэмжээнд жолооны хүрд ажиллуулсан нөхцөлд систем автомашиныг эгнээнээс хазайгаагүй гэж тооцоолох ба анхааруулга ажиллахгүй.

■ Жолооны хүрднээс гар салгасаныг анхааруулах анхааруулга

Дараах нөхцөлд жолоочид жолооны хүрднээс барихыг анхааруулсан анхааруулга болон дараах зурагт үзүүлсэн тэмдэг мэдээллийн дэлгэц дээр гарна. Систем жолоочийг жолооны хүрднээс барисныг танисан үед анхааруулга унтарна. Тус системийг ашиглах үед анхааруулга гарсан эсэхээс үл хамааран жолооны хүрднээс гараа салгаж болохгүй.



- Системийн ажиллагааны үед жолооч жолооны хүрднээс гараар барилгүйгээр жолоодож байгааг систем тогтоосон үед

  Жолооч жолооны хүрднээс гараа салгасан хэвээр байгаа үед анхааруулах дуут дохио дуугарч жолоочид анхааруулга өгөх ба функц түр цуцлагдана. Тус анхааруулга нь жолооч жолооны хүрдийг бага хэмжээгээр ажиллуулж байгаа үед мөн адил гарна.
- Автомашин, жолоодлогын болон замын нөхцөл байдлаас хамаарч анхааруулга ажиллахгүй байж болно.

Функцийг идэвхжүүлэх/цуцлах

LTA товч дарах бүрт функц идэвхжих/цуцлагдах горимд солигдоно.

LTA идэвхжсэн үед LTA индикатор асна.

▶ HUD дэлгэцгүй автомашин



⚠ АЮУЛТАЙ

■ Функц хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд функц хэвийн ажиллахгүй байх, улмаар автомашин эгнээнээс гарч болзошгүй. Функцийн ажиллагаанд хэт найдаж болохгүй.

▶ HUD дэлгэцтэй автомашин



⚠ АЮУЛТАЙ

Жолооч нь ойр орчиндоо анхаарал хандуулан шаардлагатай жолоо ашиглан аюулгүй байдлыг бүрдүүлнэ.

- Урд талын, эсвэл ойролцоох автомашин эгнээ солисон (таны автомашин тухайн автомашиныг дагаж эгнээгээ солиж болзошгүй)



- Урд талын, эсвэл ойролцоох автомашин даялж байгаа үед (таны машин мөн даялж эгнээнээс гарч болно)
- Урд талын, эсвэл ойролцоох автомашин эгнээнээс гарсан үед (таны автомашин мөн тухайн автомашиныг даган эгнээнээс гарч болно)
- Урд талын, эсвэл ойролцоох автомашин эгнээнийхээ баруун, эсвэл зүүн тал руу шахан явж байгаа (таны автомашин мөн тухайн автомашиныг даган эгнээнээс гарч болно)
- Ойр орчимд хөдөлж буй объект, байгууламж байгаа үед (тухайн объектын харьцангуй байрлалаас хамаарч таны автомашин your даялж болно)
- Автомашин хөндлөн салхи, эсвэл бусад автомашины салхинд цохигдсон үед
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцлүүд: → X.354
- Эгнээний шугам танигдахгүй нөхцлүүд: → X.356
- Системийг цуцлах шаардлагатай нөхцлүүд: → X.350

Жолооны хүрдний дэмлэгийн ажиллагааны дэлгэц

LTA системийн ажиллагааны байдлыг харуулна.

Индикатор	Эгнээний дэлгэц	Жолооны тэмдэг	Нөхцөл
Цагаан	Хар саарал	Саарал	LTA систем хүлээлгийн горимд
Ногоон	Ногоон	Ногоон	LTA ажиллаж байгаа
Шаргал Анивчих	Шаргал Анивчих	Ногоон	Эгнээний дэлгэц анивчиж буй тал руу автомашин эгнээнээс гарч байгаа

LDA эгнээнээс гарах гэж буйг анхааруулах систем

LDA (Lane Departure Alert) эгнээнээс гарах гэж буйг анхааруулах систем

Үндсэн функц

LDA систем нь автомашин тухайн эгнээ, эсвэл чиглэлээс[*1], гарах үед жолоочид анхааруулга өгөх ба эгнээ, , эсвэл чиглэлээс[*1] гарахаас зайлсхийхэд туслах үүднээс жолооны хүрдийг бага зэрэг ажиллуулдаг.

Урд камер ашиглан эгнээ, эсвэл чиглэлийг[*1] мэдэрдэг.

■ **Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах функц**



Систем автомашиныг тухайн зорчиж буй эгнээ, эсвэл чиглэлээс[*1] гарах магадлалтай гэж тооцоолсон үед дэлгэц дээр анхааруулга гаргах ба дохио дуугаргах, жолооны хүрд чичиргэж жолоочид мэдэгдэнэ.

Анхааруулах дохио дуугарсан үед орчны байдлыг нягтлаад жолооны хүрдийг болгоомжтой эргүүлэн автомашиныг эгнээнд нь буцаана[*1].

BSM-тэй автомашин: Автомашин эгнээнээсээ гарч хажуу эгнээний автомашинтай мөргөлдөх магадлал өндөр байна гэж систем тооцоолсон үед эргэх дохионы ажиллуулсан байсан ч эгнээнээс гарах гэж буйг анхааруулах анхааруулга ажиллана.

*1 : Өвс, шороо, эргэлт зэрэг замын хажуу тал болон асфалтан замын зааг хэсэг.

■ Эгнээнээс гарахаас сэргийлэх функц



Систем автомашиныг тухайн зорчиж буй эгнээ, эсвэл чиглэлээс[*1]гарах магадлалтай гэж тооцоолсон үед эгнээгээ барих үүднээс жолооны хүрд богино хугацаанд бага хэмжээгээр ажиллуулдаг.

Жолооны хүрдийг тодорхой хугацаанд эргүүлээгүй, эсвэл чанга бариагүй гэж систем тооцоолсон үед дэлгэц дээр анхааруулах мэдээлэл гарч дохио дуугаран жолоочид анхааруулга өгнө.

BSM-тэй автомашин: Систем автомашиныг хажуу эгнээний автомашинтай мөргөлдөх магадлалтай гэж тооцоолсон үед эргэх дохионы хөшүүрэг түлхсэн байсан ч тус функц ажиллана.

■ Амрахыг санал болгох функц



Автомашин олон дахин даялсан үед анхааруулах дохио дуугарч жолоочид түр амрахыг санал болгоно.

⚠ АЮУЛТАЙ

■ LDA систем ашиглахын өмнө

- LDA системд хэт найдаж болохгүй. LDA нь жолоодлогод тусламж үзүүлэх автомат систем ба нөгөөтэйгүүр хөдөлгөөний үед анхаарлаа багасгах боломж олгох систем биш болно. Жолооч нь ойр орчны аюулгүй байдлыг цаг ямагт нягтлан шаардлагатай тохиолдолд жолооны хүрд эргүүлэн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Мөн жолооч

⚠ АЮУЛТАЙ

нь холын замд явах зэргээр удаан хугацаанд автомаши жолоодон ядарсан үедээ түр амрах үүрэгтэй.

- Осолд аваар үүсгэх аюултай нөхцөлд байдалд нийцүүлэн анхааралтай, зөв жолоодлого хийнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Функц бүрийн ажиллах нөхцөл

● Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах/сэргийлэх функц

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Автомашины хурд 50 км/ц (30 миль/ц)-с их.

  Эгнээний ойролцоо бусад автомашин, мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч мэдрэгдсэн үед 40 км/ц (25 миль/ц)-с их хурдтай үед тус функц ажиллаж болно.
- Систем эгнээ, эсвэл шугам мэдэрсэн*2. (зөвхөн нэг талд мэдэрсэн үед*2 систем зөвхөн тухайн мэдэрсэн талд ажиллана.)
- Замын эгнээний өргөн 3 м (9.8 ft.)-с их.
- Эргэх дохионы хөшүүргийг ажиллуулаагүй.

  (BSM-тэй автомашин: Эргэх дохионы хөшүүргийг ажиллуулсан талд автомашин мэдэрснээс бусад нөхцөлд.)
- Автомашин огцом эргэлтэй замаар яваагүй үед.
- Автомашин тодорхой хэмжээнээс ихээр хурд нэмээгүй, хасаагүй үед.
- Жолооны хүрдийг эгнээгээ өөрчлөхөд хангалттай хэмжээгээр эргүүлээгүй.

● Амрахыг санал болгох функц

Тус функц дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Автомашины хурд 50 км/ц (30 миль/ц)-с их.
- Зорчих эгнээний өргөн 3 м (9.8 фут)-с өргөн.

■ Функцийн ажиллагаа түр цуцлагдах

Ажиллагааны нөхцөл алдагдсан үед функцийг ажиллагаа түр цуцлагдана. Нөгөөтэйгүүр ажиллах нөхцөл дахин бүрдсэн үед ажиллагаа автоматаар дахин сэргэнэ. (→X. 390)

*2 : Өвс, шороо, эргэлт зэрэг замын хажуу тал болон асфалтан замын зааг хэсэг.

■ Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах/ сэргийлэх функцийн ажиллах нөхцөл

- Автомашины хурд, замын нөхцөл, эгнээнээс гарах өнцөг зэргээс хамаарч эгнээнээс гарахаас сэргийлэх функцийн ажиллагаа мэдрэгдэхгүй байх, эсвэл ажиллахгүй байж болно.
- Нөхцөл байдлаас хамаарч өөрчлөх боломжтой тохиргоогоор чичиргээгээр анхааруулах тохиргоонд хийсэн дохио сонсогдохгүй байж болно.
- Эгнээ, чиглэлийн[*2] зах хэсэг тодорхой харагдахгүй, эсвэл шулуун биш үед эгнээнээс гарахаас сэргийлэх функц ажиллахгүй байж болно.
- Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах функц, сэргийлэх функц нь явган зорчигч, зогссон автомашиныг тойрч гарахаар жолооны хүрд эргүүлсэн гэж систем тооцоолсон үед.
- BSM-тэй автомашин: Хажуу эгнээний автомашинтай мөргөлдөх эрсдэл байгааг систем тооцоолох боломжгүй байж болно.
- Эгнээнээс гарахаас сэргийлэх функцийн жолооны хүрдний дэмжлэг нь жолоочийн жолооны хүрд эргүүлэх үйлдэлд дарагдана.

■ Жолооны хүрднээс гар салгасаныг анхааруулах анхааруулга

Дараах нөхцөлд жолоочид жолооны хүрд ажиллуулахыг шаардсан мэдээлэл дэлгэц дээр гарч дохио дуугаран жолоочид анхааруулга өгнө. Тус системийг ашиглах үед анхааруулга гарч байгаа эсэхээс үл хамааран жолооны хүрдийг чанга барих нь зүйтэй.

- Систем жолоочийг жолооны хүрднээс сайн бариагүй, эсвэл эгнээнээс гарахаас туслах функцийн жолооны дэмжлэг ажиллах үед жолооч жолооны механизмтай харьцахгүй байна гэж систем тооцоолсон үед

  Жолооны дэмжлэг ажиллах давтамж нэмэгдэх тусах анхааруулах дохионы дуугарах хугацаа уртасна. Жолооны хүрдийг жолооч эргүүлсэн гэж систем тооцоолсон ч анхааруулах дохио үргэлжлэн тодорхой хугацаанд дуугарна.

■ Амрахыг санал болгох функц

Автомашин олон удаа даялсан үед жолоочийг түр амрахыг сануулсан анхааруулга дэлгэцээр гарах ба дохио дуугарна.

Автомашин болон замын нөхцөл байдлаас хамаарч амрахыг санал болгох функц ажиллахгүй байж болно.

Дэлгэц болон системийн ажиллагаа

Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах функцийн ажиллагааны байдал блдлг эгнээнээс гарахаас сэргийлэх функцийн жолооны хүрдний ажиллагааг дэмжих ажиллагааг харуулна.

Индикатор	Эгнээний дэлгэц	Жолооны хүрдний тэмдэг	Нөхцөл байдал
Шаргал Ассан	Асахгүй байх	Асахгүй байх	Систем цуцлагдсан
Асахгүй байх	Саарал	Асахгүй байх	Систем эгнээний шугам танихгүй байх
Асахгүй байх	Цагаан	Асахгүй байх	Систем эгнээний шугам танисан
Шаргал Анивчих	Шаргал Анивчих	Асахгүй байх	Эгнээний шугамны дэлгэц анивчиж буй талд эгнээнээс гарах гэж буйг анхааруулах функц ажиллаж байгаа
Ногоон	Ногоон	Ногоон	Эгнээний шугамны дэлгэц ассан талын эгнээнээс гарах гэж буй анхааруулах функц ажиллаж байгаа
Шаргал Анивчих	Шаргал Анивчих	Ногоон	Эгнээний шугам анивчиж байгаа талын эгнээнээс гарах гэж буйг анхааруулах, эгнээнээс гарахаас сэргийлэх функц ажиллаж байгаа

LDA тохиргоог өөрчлөх

- LDA системийг өөрчлөх боломжтой тохиргоогоор идэвхжүүлэх, цуцлах боломжтой.→ X.686
- LDA системийн дараах тохиргоог өөрчлөх боломжтой тохиргоогоор өөрчлөх боломжтой.→ X.686

⚠ АЮУЛТАЙ

■ LDA систем ашиглаж болохгүй нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд LDA системийг цуцлана. Эсрэг тохиолдолд осолд хүргэнэ.

- Системийг цуцлах шаардлагатай нөхцлүүд: → X.350

■ Системийн хэвийн ажиллагаа алдагдах нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд систем хэвийн ажиллахгүй байх, улмаар эгнээнээс гарч болзошгүй. Системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй. Жолооч нь ойр орчны аюулгүй байдалд анхаарал хандуулан жолооны хүрд шаардлагатай хэмжээнд ашиглан аюулгүй жолоодох үүрэгтэй.

- Өвс, шороо, эргэлт, замын хашлага, тусгаарлах хаалт, бусад объект болон зам хоорондын зааг хэсэг сайн харагдахгүй, эсвэл шулуун биш
- Автомашин хөндлөн чиглэлийн салхи, эсвэл бусад автомашины салхинд цохигдсон үед
- Эгнээний шугам танигдахгүй байх нөхцлүүд :→ X.356
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй байх нөхцлүүд: → X.354
- Системийн зарим, эсвэл бүх функцууд ажиллах боломжгүй болох нөхцлүүд: → X.357

Эгнээ солих үед арын автомашин мэдрэхэд дэмжих дэмжлэг*

BSM нь арын гуперын баруун болон зүүн дотор талд байрлах хойд хажуугийн радарын мэдрэгч ашиглан эгнээ солих үед жолоочид туслах систем юм.

⚠ АЮУЛТАЙ

■ Систем ашиглах үеийн анхааруулга

Жолооч аюулгүй жолоодлогыг бүрэн хангах үүрэгтэй. Замын хөдөлгөөнд цаг ямагт аюулгүй оролцож ойр орчимдоо анхаарал хандуулна.

BSM нь жолоочид харагдахгүй хэсэгт автомашин зорчиж буйг анхааруулах нэмэлт функц юм. BSM системд хэт найдах, даатгахыг хориглоно. Эгнээ байраа өөрчлөх нь аюулгүй эсэхийг систем тооцоолох боломжгүй тул системд хэт найдах, даатгах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

Тухайн нөхцлөөс хамаарч систем зөв ажиллахгүй байж болно. Тиймээс жолооч өөрийн нүдээр замын аюулгүй байдлыг шалгах шаардлагатай.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

BSM системийн зорилго

МЭДЭЭЛЭЛ

■ Систем бусад автомашиныг мэдрэхгүй нөхцлүүд

Тус систем нь дараах төрлийн автомашин, эд зүйлийг мэдрэх боломжгүй:

- Жижиг мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч зэрэг *1
- Эсрэг чиглэлд явж буй автомашин
- Замын хашлага, хана, самбар, зогсоолд байрлуулсан автомашин, хөдөлгөөнгүй объект*1
- Нэг эгнээгээр явж буй арын автомашин*1
- Таны автомашинаас 2 эгнээний зайтай явж буй автомашин*1
- Таны автомашин хурдтай гүйцэж түрүүлж буй бусад автомашин*1

* : Тоноглогдсон автомашинд

*1 : Нөхцөл байдлаас хамаарч автомашин, объектыг мэдрэхгүй байж болно.

Системийн эд анги



A Голын дэлгэц

BSM системийг асаах/унтраах.

B Хажуугийн толины индикатор

BSM функц нь хажуу эгнээгээр хажуугийн толинд үл харагдах өнцөгт зорчиж буй автомашиныг, эсвэл үл харагдах өнцөгт бусад автомашин огцом ойртож ирсэн үед тухайн талын хажуугийн толины индикатор асдаг. Хэрэв тухайн тал руу эргэх дохионы хөшүүргийг түлхсэн үед хажуугийн толины индикатор анивчина.

МЭДЭЭЛЭЛ

Хажуугийн толины индикаторын харагдах байдал

Хүчтэй нартай үед хажуугийн толины индикатор сайн харагдахгүй байж болно.

⚠ АЮУЛТАЙ

Системийн хэвийн ажиллагааг хангах

Автомашины арын гуперны баруун ба зүүн дотор талд BSM мэдрэгч суурилагдсан байдаг. Blind Spot Monitor системийн хэвийн ажиллагааг хангахын тулд дараах анхааруулгыг дагаж мөрдөнө.

- Мэдрэгч болон гуперны тухайн хэсгийг цаг ямагт цэвэр байлгана.

  Мэдрэгч болон гуперны тухайн хэсэг бохирдсон, эсвэл цас мөс тогтсон үед BSM системийн ажиллагаа алдагдах ба анхааруулга дэлгэц дээр гарна. Энэ тохиолдолд бохирдол, цас мөсийг цэвэрлэх ба BSM функцийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн 10 минут орчим жолоодно. Анхааруулга унтрахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношилгоо хийлгэнэ үү.



- Мэдрэгч болон гуперны тухайн хэсэгт нэмэлт тоноглол, хуулга, наалт (тунгалаг наалт хамаарна), хөнгөн цагаан тууз наах, суурилуулахыг хориглоно.
- Мэдрэгч болон арын гуперны тухайн хэсгийг хүчтэй цохилтоос хамгаална.

⚠ АЮУЛТАЙ

Мэдрэгчийн байрлал бага зэрэг хөдөлсөн үед ч системийн хэвийн ажиллагаа алдагдах ба автомашиныг мэдрэхгүй байж болно. Дараах нөхцөлд та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

- Мэдрэгч, түүний ойр орчим хүчтэй цохилтод өртсөн.
- Мэдрэгчийн ойр орчим зурагдсан, хонхойсон, эсвэл зарим хэсэг нь салж унасан.

- Мэдрэгчийг задлахыг хориглоно.
- Мэдрэгч болон гуперны тухайн хэсгийг өөрчилж болохгүй.
- Мэдрэгч, эсвэл арын гуперыг салгах, угсрах, солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.
- Арын гуперыг Lexus-н албан ёсны өнгөөс өөр өнгөөр будахыг хориглоно.

BSM системийн мэдрэх боломжтой автомашин

BSM нь хойд хажуугийн радарын мэдрэгч ашиглан зэргэлдээ эгнээгээр явж буй арын автомашиныг мэдэрч хажуугийн толины индикатороор жолоочид мэдэгдэх систем юм.



A Хажуугийн толинд харагдахгүй хэсгээр (толинд үл харагдах хэсэг) явж байгаа автомашин

B Хажуугийн толинд харагдахгүй хэсгээр (толинд үл харагдах хэсэг) огцом ойртон ирж автомашин

BSM функцийн мэдрэх хүрээ

Функцийн мэдрэх хүрээг дараах байдлаар харуулав.



Мэдрэх хүрээ:

A Автомашины 2 талаас 0.5 м (1.6 ft.)-с 3.5 м (11.5 ft.) зай*2

B Арын гупернээс 1 м (3.3 ft.) урагш

C Арын гупернээс 3 м (9.8 ft.) зай

D Арын гупернээс 3 м (9.8 ft.)-с 60 м (197 ft.) зай*3

BSM системийг асаах/унтраах

BSM системийг голын дэлгэцнээс асаах болон унтраах боломжтой

1 -г сонгоно.

2 [Driving assist]-г сонгоно.

3 [Blind spot monitor]-г сонгоно.

BSM систем цуцлагдсан үед жолоодлогод туслах мэдээллийн индикатор асна.

Асаах товчийг унтраагаад буцааж ON болгох үед BSM систем автоматаар идэвхжинэ.

МЭДЭЭЛЭЛ

■ BSM системийн ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед BSM систем ажиллана:

- BSM систем асаалттай.
- Автомашины хурд 10 км/ц (7 mph)-с их.
- Араа R-с бусад байрлалд байгаа.

■ BSM системийн автомашин мэдрэх нөхцөл

Дараах нөхцөлд BSM систем мэдрэх хүрээнд байгаа :

- Хажуу эгнээний автомашин гүйцэж түрүүлэх үед.
- Хажуу эгнээний автомашиныг бага хурдаар гүйцэж түрүүлэх үед.

*2 : Автомашины хажуу талаас 0.5 м (1.6 ft.) хүртэлх зайг систем мэдрэхгүй.

*3 : Таны автомашин болон системийн мэдэрсэн автомашины хурдны зөрүү их тусам илүү хол байгаа автомашиныг систем таних ба хажуугийн индикатор асах буюу анивчина.

● Бусад тээврийн хэрэгсэл эгнээгээ солингоо системийн мэдрэх хүрээнд орж ирсэн.

■ **Систем хэвийн ажиллахгүй байх магадлалтай нөхцлүүд**

● BSM функц дараах нөхцөлд автомашин зөв мэдрэхгүй байж болно:

- Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтонд өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
- Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчимд шавар, цас, мөс, наалт наасан, тогтсон үед
- Аадар бороо, цас, манан зэрэг цаг агаарын нөхцөл байдлаас тогтоол ус үүссэн замаар явах үед
- Хоорондоо ойр зайтай хэд хэдэн автомашин ойртох үед
- Таны автомашинаас хойд талын автомашин хүртэлх зай ойр үед
- Таны автомашин болон функцийн мэдрэх хүрээнд орж ирсэн автомашин хоорондын хурдны зөрүү хэт их үед
- Таны автомашин болон бусад автомашин хоорондын харьцангуй хурд өөрчлөгдөж байгаа үед
- Функцийн мэдрэх хүрээнд орж ирсэн автомашин таны автомашинтай адил хурдтай үед
- Хөдөлгөөн эхлэх үед зогссон хэвээр байгаа автомашин
- Өгсүүр уруу замаар явах үед
- Огцом эргэлт ихтэй, эсвэл замын гадаргуу тэгш бус замаар явах үед
- Замын эгнээ өргөн үед, эсвэл эгнээний нэг тал руу шахаж явах зэргээр хажуу эгнээгээр зорчиж буй автомашин хүртэлх зай хол үед
- Автомашины хойд талд унадаг дугуйн суурь, бусад нэмэлт тоноглол суурилуулсан үед
- Функцийн мэдрэх хүрээнд орж ирсэн автомашин болон таны автомашины өндөр хэт зөрүүтэй үед
- BSM функц асаасан даруйд

● Дараах нөхцлүүдэд BSM функц автомашин, унадаг дугуй, обьектыг буруу таних магадлал нэмэгдэнэ:

- Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтонд өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
- Функцийн мэдрэх хүрээнд орж ирсэн замын хаалт, хана зэрэг хүртэлх зай ойр үед
- Өгсүүр уруу замаар явах үед
- Замын эгнээ нарийн үед, эсвэл эгнээний нэг тал руу шахаж явах зэргээр функцийн таних хүрээнд хажуу эгнээнээс өөр эгнээгээр зорчиж буй автомашин орж ирэх үед
- Огцом эргэлт ихтэй, эсвэл замын гадаргуу тэгш бус замаар явах үед

- Дугуй шарваж байгаа, хий эргэж байгаа үед
- Таны автомашинаас хойд талын автомашин хүртэлх зай ойр үед
- Автомашины хойд талд унадаг дугуйн суурь, бусад нэмэлт тоноглол суурилуулсан үед

Автомашины хойд талын мэдрэх боломжтой объектыг мэдэрч дохио дуугаргах, дэлгэцээр анхааруулга гаргаж анхааруулах, эсвэл хаалга нээх ажиллагааг цуцлан аюулгүйгээр буухад туслах*

Аюулгүйгээр буухад туслах систем (хаалга нээх удирдлагатай) нь хаалга нээх үед мөргөлдөж болзошгүй автомашин унадаг дугуй ойртож буйг арын гуперны дотор талд байрлах радарын мэдрэгчээр мэдэрч жолооч, зорчигчид анхааруулга өгөх, эсвэл мөргөлдөх эрсдлийг бууруулах үүднээс хаалга нээх ажиллагааг цуцлах систем болно.

⚠ АЮУЛТАЙ

■ Систем ашиглахтай холбоотой анхааруулга

- Жолооч нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Ойр орчны аюулгүй байдлыг нягтлан цаг ямагт замын хөдөлгөөн аюулгүйгээр оролцоно.
- Аюулгүйгээр буухад туслах систем нь автомашин зогссон үед ойртож буй автомашин, унадаг дугуй байгааг жолооч, зорчигчдод мэдээллэх зорилготой туслах систем болно. Тус систем нь дангаараа аюулгүй эсэхийг тодорхойлох боломжгүй тул системийн ажиллагаанд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

  Систем зарим нөхцөлд зөв ажиллахгүй байж болох тул жолооч аюулгүй байдлыг шууд харан нягтлах шаардлагатай.

Холбоотой холбоосууд

Өөрчлөх боломжтой функцууд(Х. 675)

Автомашинаас аюулгүйгээр гарахад туслах функцийн зорилго

МЭДЭЭЛЭЛ

■ Систем бусад автомашиныг танихгүй нөхцлүүд

- Тус функц дараах төрлийн объект, автомашин, унадаг дугуйг танихгүй:
  - Удаан хурдаар ойртож буй автомашин, унадаг дугуй
  - Хаалга нээхэд хаалгатай (тээшний хаалганаас бусад) мөргөлдөх магадлал бага гэж тооцсон автомашин, унадаг дугуй
  - Эгц хойноос ойртож буй автомашин, унадаг дугуй

*:Тоноглогдсон автомашинд

- Урд талаас ойртож буй автомашин, унадаг дугуй
- Замын хашлага, хана, замын тэмдэг, зогсоолд байрлуулсан автомашин, бусад хөдөлгөөнгүй объект
- Амьтан зэрэг.

● Дараах нөхцлүүдэд тус функц ажиллахгүй:

- Хөдөлгүүр унтрааснаас хойш 3 минут өнгөрсөн (хаалга нээгээд хаасан үед тус хугацаа уртсаж болно)
- Таны автомашин бүрэн зогсоогүй үед

Системийн эд анги



A Голын дэлгэц

Аюулгүйгээр гарахад туслах системийг асаах, унтраах. Хаалга нээх үйлдэл цуцлагдсан үед систем ажилласныг жолоочид дуу хоолойн зааварчилгаа мэдээлнэ.

B Мэдээллийн дэлгэц/HUD дэлгэц*/Анхааруулах дуут дохио

Бусад автомашины хаалга цохиж магадгүй үед хаалга нээх үйлдэл цуцлагдах ба мэдээллийн дэлгэц ба HUD дэлгэц анхааруулга гарна. Мөн хажуугийн толины индикатор ассан үед хаалга нээвэл дуут дохио анхааруулж дуугарна.

C Хажуугийн толины индикатор

Бусад автомашин, эсвэл унадаг дугуй нээсэн хаалга (тээшний хаалганаас бусад) мөргөж магадгүй үед тухайн мэдэрсэн талын хажуугийн толины индикатор анивчина. Мэдэрсэн талын хаалга нээлттэй, эсвэл хаалга нээх үйлдэл цуцлагдсан үед хажуугийн толины индикатор анивчина.

D Хаалга нээх товч (гар аргаар нээх хөшүүрэг)

Хажуугийн толины индикатор анивчих үед хаалга нээхээр хаалга нээх товч ажиллуулсан нөхцөлд хаалга нээх үйлдэл цуцлагдана.

*: Тоноглогдсон автомашинд

МЭДЭЭЛЭЛ

Хажуугийн толины индикаторын харагдах байдал

Нарны хүчтэй гэрэл туссан үед хажуугийн толины индикатор сайн харагдахгүй байж болно.

Дуут дохио

Аудио системийн дуу чанга, эсвэл орчны дуу чимээ ихтэй үед анхааруулах дуут дохио сонсогдохгүй байж болно.

Дуу хоолойн мэдээлэл

Дараах нөхцлүүдэд дуу хоолойн мэдээлэл систем өгнө:

- Хаалга нээж автомашинд суусан үед хөдөлгүүр асаах хүртэл
- Хөдөлгүүр унтрааснаас хойш 3-с дээш минут өнгөрсөн
- Голын дэлгэцний хэлний тохиргоог дуу хоолойн мэдээлэл дэмждэггүй хэлээр тохируулсан үед
- Автомашины гадна талаас бүх хаалга түгжсэн үед
- Хөдөлгүүр унтраасны дараа хаалга 1-с дээш минут нээсэн
- Голын толины өөрчлөх боломжтой тохиргоогоор ACC горимд идэвхжүүлсэн ба хөдөлгүүр унтраастай байгаа
- Голын дэлгэцний зогсоолд байрлуулахад туслах дууны тохиргоо унтраастай байгаа

⚠ АЮУЛТАЙ

Системийн хэвийн ажиллагааг хангах

Аюулгүйгээр гарахад туслах мэдрэгчүүд нь арын гуперны баруун зүүн талд байрладаг. Аюулгүйгээр гарахад туслах системийн хэвийн ажиллагааг хангаж дараах анхааруулгыг мөрдөнө.

- Арын гуперны мэдрэгчийн ойр орчмыг цаг ямагт цэвэр байлгана.

  Мэдрэгч, эсвэл арын гуперны мэдрэгчийн ойр орчимд шавар, цас тогтсон үед аюулгүйгээр гарахад туслах функц ажиллахгүй, анхааруулга гарахгүй байж болно. Энэ нөхцөлд шавар, цасыг цэвэрлээд тус функцийн ажиллах нөхцөл бүрдүүлэн 10 орчим минут жолоодно. Анхааруулга унтрахгүй үед та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.



⚠ АЮУЛТАЙ

- Нэмэлт тоноглол, наалт (мөн тунгалаг наалт), хөнгөн цагаан тууз зэргийг мэдрэгч болон мэдрэгчийн ойр орчимд нааж болохгүй.
- Мэдрэгч болон арын гуперны мэдрэгчийн ойр орчмыг хүчтэй цохилтоос хамгаална.

  Мэдрэгчийн байрлал бага зэрэг хөдөлсөн үед ч систем доголдож бусад автомашиныг зөв танихгүй байж болно. Дараах нөхцлүүдэд та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.
  - Мэдрэгч, эсвэл мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтонд өртсөн.
  - Мэдрэгчийн ойр орчим зурагдсан, хонхойсон, эсвэл эдгээрийн эд анги салгагдсан.
- Мэдрэгчийг задлаж болохгүй.
- Мэдрэгч, эсвэл арын гуперны мэдрэгчийн ойр орчимд өөрчлөлт хийж болохгүй.
- Мэдрэгч, эсвэл арын гупер салгах, угсрах, эсвэл солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.
- Арын гуперыг Lexus-н албан ёсны өнгөнөөс өөр өнгөөр будаж болохгүй.

Аюулгүй буухад туслах систем мэдрэх боломжтой автомашин

Аюулгүй буухад туслах систем нь дараах автомашин, унадаг дугуйг хойд хажуугийн радарын мэдрэгчээр мэдрэх ба зорчигчид хажуугийн толины индикатор, дуут дохио, хянах самбарын мэдээлэл болон дуу хоолойн мэдээллээр дамжуулан анхааруулдаг.



A Хаалга нээх үед нээсэн хаалгатай (тээшний хаалганаас бусад) мөргөлдөх эрсдэл өндөртэй автомашин, эсвэл унадаг дугуй

Аюулгүйгээр буухад туслах функцийн мэдрэх хүрээ

Бусад автомашиныг таних боломжтой хүрээг дараах байдлаар харуулав.



A Урд хаалганаас хойш 45м *1

Аюулгүйгээр буухад туслах функцийг асаах/унтраах

Аюулгүйгээр буухад туслах функцийг голын дэлгэц дээр асааж унтраах боломжтой

1 **-г сонгоно.**

2 **[Driving assist]-г сонгоно.**

3 **[Safe exit assist]-г сонгоно.**

Аюулгүйгээр буухад туслах функцийг цуцалсан үед жолоодлогод туслах мэдээллийн индикатор асна.

Асаах товчийг унтраагаад ON горимд дахин асаах үед функц автоматаар идэвхжинэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Аюулгүйгээр буухад туслах функцийн ажиллах нөхцөл

Аюулгүйгээр буухад туслах функц дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Асаах товч ON горимд байгаа, хайбрид систем унтрааснаас 3 минутын хугацаанд, эсвэл хаалга нээж автомашинд зорчигч сууснаас 3 минутын дотор (хаалга нээгээд хаасан үед ажиллах хугацаа уртасч болно)
- Аюулгүйгээр буухад туслах функц идэвхтэй
- Автомашин зогссон.
- Араа R-с бусад байрлалд.

■ Аюулгүйгээр буухад туслах функц автомашин мэдрэх нөхцөл

Аюулгүйгээр буухад туслах функц нь дараах нөхцлүүдэд мэдрэх хүрээнд байгаа автомашиныг мэдрэнэ:

Автомашин зогссон ба хажуу талаар явж буй бусад автомашин, унадаг дугуй хаалга (тээшний хаалганаас бусад) нээсэн талаар ойртох үед

*1 : Автомашин, унадаг дугуйн ойртох хурд хурдан байх тусам хажуугийн толины индикатор асах, эсвэл анивчих зай нэмэгдэнэ.

■ **Хаалга нээх үйлдэл системээр цуцлагдсан үед хаалга нээх**

Дараах үйлдлээр хаалга нээнэ.

Ойртож буй автомашин, унадаг дугуй хажуугаар өнгөрсөн, эсвэл чиглэлээ өөрчилсний дараа ойр орчмоо нягтлаад хаалга нээх товч дахин дарна.

- Дотор талын хаалга нээх товчийг 3 секундээс удаан дарна → Х.401
- Дотор талын хаалга нээх товчийг 3 удаа хурдан дарна
- Гар аргаар хаалганы түгжээ тайлах бариул татна

■ **Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд**

- Дараах нөхцлүүдэд функц бусад автомашиныг мэдрэхгүй байж болно:
  - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтонд өртсөнөөс шалтгаалан мэдрэгчийн байрлал алдагдсан
  - Мэдрэгч, арын гуперны мэдрэгчийн ойр орчимд шавар, цас, мөс, наалт зэрэг наасан, тогтсон үед
  - Аадар бороо, цас, манан зэрэг цаг агаарын муу нөхцөл байдлаас тогтоол ус үүссэн замаар явах үед
  - Ойролцоо зогссон автомашины цаанаас автомашин, унадаг дугуй ойртон ирэх үед
  - Ойртож буй автомашин, унадаг дугуй гэнэт чиглэлээ өөрчлөх үед
  - Бусад автомашин, унадаг дугуй хөдөлгөөн эхэлсэн даруйд
  - Тээшний хаалга нээлттэй үед
  - Автомашины хойд талд унадаг дугуйн суурь, бусад нэмэлт тоноглол суурилуулсан үед
  - Автомашины хойд талд зогссон автомашин, самбар, хана, хүн, бусад хөдөлгөөнгүй объект байгаа үед
  - Автомашинаа зам дээр ташуу зогсоосон үед
  - Ойртож буй автомашин, унадаг дугуйн ойр орчимд бусад автомашин явах үед
  - Ойртож буй автомашин, унадаг дугуй нь хана, самбар зэрэг хөдөлгөөнгүй объектын дагуу явж байгаа үед
  - Автомашин, унадаг дугуй хэт өндөр хурдаар ойртох үед
  - Автомашин чирэх үед
  - Автомашин налуу газар зогссон үед
  - Замын эргэлт, эргэлттэй хэсгийн төгсгөл дээр зогссон үед
- Дараах нөхцлүүдэд функц автомашин, унадаг дугуй, объектыг буруу таних магадлал нэмэгдэнэ:
  - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтонд өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед

- Автомашин, унадаг дугуй хойд талаас ташуу өнцгөөс ойртох үед
- Автомашинаа зам дээр ташуу зогсоосон үед
- Зогсоолд байрлуулсан автомашины хойноос автомашин, унадаг дугуй ташуу өнцгөөр ойртох үед
- Автомашины хойд талд зогссон автомашин, самбар, хана, хүн, бусад хөдөлгөөнгүй объект байгаа үед
- Ойртож буй автомашин, унадаг дугуй гэнэт чиглэлээ өөрчлөх үед
- Ойртож буй автомашин, унадаг дугуй нь хана, самбар зэрэг хөдөлгөөнгүй объектын дагуу явж байгаа үед
- Тээшний хаалга нээлттэй үед
- Автомашины хойд талд унадаг дугуйн суурь, бусад нэмэлт тоноглол суурилуулсан үед
- Автомашин, унадаг дугуй хэт өндөр хурдаар ойртох үед
- Автомашин чирэх үед
- Налуу зам дээр зогссон үед
- Замын эргэлт, эргэлттэй хэсгийн төгсгөл дээр зогссон үед

Бага хурдаар объектод ойртох үеийн анхааруулах дохио анхааруулга*

Lexus parking assist-мэдрэгчийн зорилго

Автомашиныг хажуугийн зогсоолд байрлуулах, эсвэл гараашд маневр хийн оруулах үед саад хүртэлх зайг мэдрэгч мэдэрч дэлгэцээр харуулах, мөн анхааруулах дохио дуугарч жолоочид анхааруулга өгнө. Энэ системийг ашиглах үед ойр орчмоо шууд харж шалгана.

⚠ АЮУЛТАЙ

■ Системийн ашиглалттай холбоотой анхааруулга

Системийн мэдрэх түвшин болон хариу үйлдлийн гүйцэтгэл хязгаартай тул системийн ажиллагаанд хэт найдахыг хориглоно. Жолооч нь орчны аюулгүй байдлыг нягтлан аюулгүй жолоодлого хийх үүрэг хариуцлагыг цаг ямагт хүлээдэг.

■ Хэвийн ажиллагааг хангах

Хэвийн ажиллагааг хангах дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд автомашиныг аюулгүй жолоодох боломжгүйд хүрэх, улмаар осолд хүргэх аюултай.

- Мэдрэгчийг гэмтлээс хамгаалах ба цаг ямагт цэвэр байлгана.
- Наалт, эсвэл дугаар нь гэрэлтдэг улсын дугаар (ялангуяа өдрийн гэрэл ашигласан) зэрэг электрон хэрэгсэл, манангийн гэрэл, гуперны төмөр хамгаалалт, утасгүй антенн зэргийг мэдрэгчийн ойр орчимд суурилуулж болохгүй.
- Радарын мэдрэгч болон ойр орчмыг хүчтэй цохилтоос хамгаална. Радарын мэдрэгч, радиаторын тор, урд гупер хүчтэй цохилтонд өртсөн бол Lexus дилерт хандаж оношлуулна уу. Мэдрэгч, арын гупер салгах/угсрах, эсвэл солих үед Lexus дилерт хандана уу.
- Мэдрэгчийг өөрчлөх, задлах, будахыг хориглоно.
- Улсын дугаарын таг ашиглаж болохгүй.
- Дугуйны хийг зөв хийлнэ.

■ Функц цуцлах шаардлагатай үе

Дараах нөхцөлд мөргөлдөх эрсдэл байхгүй үед ч функц ажиллаж болзошгүй тул цуцлана.

- Дээрх анхааруулгыг мөрдөх боломжгүй үед.
- Lexus-н оригинал биш явах эд анги (намсгасан амортизатор зэрэг) угсарсан үед.

* : Тоноглогдсон автомашинд

МЭДЭЭЛЭЛ

■ Lexus parking assist-мэдрэгчийн ажиллах нөхцөл

- Асаах товч ON горимд байгаа.
- Lexus parking assist-мэдрэгчийн функц идэвхжүүлсэн.
- Автомашины хурд 10км/ц (6 миль/ц)-с бага.
- Арааны хөшүүрэг P-с бусад араанд байгаа.

■ Систем зөв танихгүй байж болох объектууд

Автомашины болон орчны тодорхой нөхцөл байдлууд мэдрэгчийг саад зөв мэдрэхэд нөлөөлөх магадлалтай. Дараах объектуудыг анхаарна уу:

- Төмөр утас, хашаа, олс зэрэг
- Хөвөн, цас болон бусад дууны долгионыг шингээдэг материал
- Хурц өнцөгтэй объект
- Намхан объект
- Өндөр бөгөөд объектын дээд хэсэг нь таны автомашин руу илүү гарсан саад

  Зарим төрлийн хувцас өмссөн хүнийг мэдрэхгүй байж болно.

■ Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд

Автомашины болон орчны тодорхой нөхцөл байдлууд мэдрэгчийг саад зөв мэдрэхэд нөлөөлөх магадлалтай. Зарим бодит жишээг доор дурдав.

- Мэдрэгч бохирдсон, эсвэл цас мөс тогтсон. (Мэдрэгчийг цэвэрлэх үед ажиллагаа сэргэнэ.)
- Мэдрэгч хөлдсөн. (Мэдрэгчийн ойр орчмыг гэсгээх шаардлагатай)

  Цаг агаарын хэт хүйтэн нөхцөлд мэдрэгч хөлдсөн үед дэлгэц хэвийн бус ажиллах, эсвэл хана зэрэг объектыг мэдрэхгүй байж болно.
- Мэдрэгчийн ойр орчим хэт халуун, хэт хүйтэн байгаа.



- Хэт энхэл донхолтой, налуу эсвэл хайрга, өвстэй зам.
- Автомашины ойр орчимд дуут дохио, мотоциклийн хөдөлгүүр, том оврын автомашины хийн тоормос болон бусад хэт авиа ялгаруулдаг дуу чимээ ихтэй.
- Мэдрэгч рүү аливаа зүйл цацагдсан, эсвэл аадар бороо орж байгаа.
- Объект мэдрэгчинд хэт ойр байгаа.
- Явган зорчигч хэт авиаг ойлгодоггүй материалтай хувцас (жишээлбэл, урт юбка зэрэг) өмссөн үед.

- Объект газартай тэгш биш, эсвэл автомашины чиглэлээс хөндлөн байрлалд биш, тэгш бус гадаргуутай, эсвэл мэдрэх хүрээнд дэрвэж байгаа үед.
- Хүчтэй салхи салхилж байгаа.
- Манан, цас, шороон шуурга зэрэг цаг агаар муу үед.
- Мэдэрсэн объект болон автомашины хооронд систем мэдрэх боломжгүй объект байгаа үед.
- Автомашин, мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч урдуур огцом орсон, эсвэл хажуугаар хурдтай өнгөрсөн үед.
- Мөргөлт, эсвэл бусад цохилтоос шалтгаалан мэдрэгчийн чиглэл алдагдсан үед.
- Чирэх дэгээ, гуперны хамгаалалт (нэмэлт хүрээ зэрэг), унадаг дугуйн суурь, цас түрэх отвал зэрэг мэдрэгчийг халхалж болзошгүй саад автомашинд суурилуулсан үед.
- Ачсан ачаа тээшээс хамаарч урд тал өргөгдсөн, эсвэл доош дарагдсан.
- Автомашин осолд орсон, системд доголдол үүссэн зэргээр автомашиныг хэвийн жолоодох боломжгүй үед.
- Дугуйн гинж, жижиг нөөц дугуй, эсвэл ослын дугуй засах нөхөөс ашигласан үед.

■ Мөргөлт үүсэх магадлал байхгүй байсан ч систем ажиллаж болзошгүй нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд мөргөлт үүсэх магадлал байхгүй байсан ч систем ажиллаж болзошгүй.

- Нарийн замаар явах үед



- Самбар, туг, модны мөчир, замын хаалт (төмөр замын фрезер, төлбөртэй зам, автозогсоолын хаалт) зэрэгт ойртох үед
- Замын гадаргуу дээр энхэл донхол, нүх байгаа үед
- Борооны ус зайлуулах төмөр таг (торон) зэрэг зам дээрх металл гадаргаа дээгүүр явах үед
- Огцом өгсүүр, уруу замаар явах үед
- Зам дээр буусан үер зэрэг их хэмжээний ус мэдрэгчийг цохисон үед
- Мэдрэгч мөс, цас, шороо тоос зэрэг тогтож бохирдсон үед. (мэдрэгчийг арчиж цэвэрлэх үед системийн хэвийн ажиллагаа сэргэнэ)
- Хүчтэй бороо, ус мэдрэгч руу цацагдаж байгаа үед

- Манан, цас, элсэн шуурга зэрэг цаг агаарын тааламжгүй нөхцөлд жолоодох үед
- Хүчтэй салхитай үед



- Автомашины дуут дохио, автомашин мэдрэгч, мотоциклын хөдөлгүүр, том оврын автомашины хийн тоормос, бусад автомашины сонар мэдрэгч, эсвэл автомашины ойр орчимд хэт авианы долгион үүсгэгч төхөөрөмж байгаа үед
- Ачсан ачаа тээшээс хамаарч урд тал өргөгдсөн, эсвэл доош дарагдсан
- Мөргөлт болон бусад цохилтын нөлөөллөөс мэдрэгчийн чиглэл өөрчлөгдсөн
- Өндөр, эсвэл мурийсан замын хашлагад ойртсон
- Олон давхар авто зогсоол, баригдаж буй барилга доторх багануудад (Н хэлбэртэй төмөр багана зэрэг) ойртох үед
- Осолд орсон, эсвэл систем доголдсон зэрэг шалтгаанаар автомашиныг хэвийн жолоодох боломжгүй үед
- Хэт энхэл донхолтой, налуу, эсвэл өвстэй замаар явах үед



- Дугуйн гинж, жижиг нөөц дугуй, эсвэл онцгой үед ашиглах дугуйн нөхөөс ашигласан үед

Lexus parking assist-мэдрэгчийн дэлгэц

Мэдрэгч объект мэдэрсэн үед саад хүртэлх зайг болон байрлалыг дараах дэлгэцээр жолоочид мэдэгдэнэ.

▶ Lexus parking assist монитор *



▶ Панорама дэлгэц *



Lexus parking assist-sensor системийн мэдрэгчийн байрлал



A Урд булангийн мэдрэгч
B Урд голын мэдрэгч
C Хойд булангийн мэдрэгч
D Хойд голын мэдрэгч

⚠ АЮУЛТАЙ

■ Автомашин угаах үед анхаарах зүйлс

Мэдрэгчийн ойр орчмыг даралттай ус, ууранр угааж болохгүй.

Мэдрэгчийг гэмтээх аюултай.

- Өндөр даралтын автомашин угаагчаар угаах үед мэдрэгчийг гэмтээх аюултай тул мэдрэгч рүү шууд шүршиж болохгүй.
- Халуун ууранр автомашин угаах үед мэдрэгчийг гэмтээх аюултай тул мэдрэгч рүү хэт ойртуулж болохгүй.

* : Тоноглогдсон автомашинд

Lexus parking assist-функцийг асаах, унтраах

Lexus parking assist-мэдрэгчийг голын дэлгэц дээр дараах байдлаар асаах, унтраах боломжтой:

1 **-г сонгоно.**

2 **[Driving assist]-г сонгоно.**

3 **[Parking assist-sensor]-г сонгож ON (асаах)/OFF (унтраах) тохиргоо хийнэ.**

ON (асаах)-г сонгосон үед Lexus parking assist-мэдрэгчийн индикатор асна.

OFF (унтраах)-г сонгох үед Lexus parking assist-мэдрэгч цуцлагдах ба голын дэлгэц дээр дахин ON тохиргоог сонгох хүртэл функц дахин идэвхжихгүй.

(Асаах товчны ажиллагаагаар систем дахин идэвхжихгүй.)

Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх хүрээ

■ **Мэдрэгчийн мэдрэх хүрээ**



A 100 см (3.3 ft.) орчим
B 150 см (4.9 ft.) орчим
C 60 см (2.0 ft.) орчим

Мэдрэгчийн мэдрэх хүрээг диаграмаар харуулав.

Автомашинд хэт ойр байгаа объектыг мэдрэгч мэдрэх боломжгүйг анхаарна уу.

Объектын хэмжээ зэргээс хамаарч мэдрэгчийн мэдрэх хүрээ өөрчлөгдөж болно.

МЭДЭЭЛЭЛ

■ **Мэдрэгчийн ажиллагаатай холбоотой мэдээлэл**

- Мэдрэгчийн мэдрэх хүрээ нь автомашины гуперны ойр орчмоор хязгаарлагддаг.
- Автомашины болон орчны тодорхой нөхцөл байдлууд мэдрэгчийг саад зөв мэдрэхэд нөлөөлөх магадлалтай.

- Объект хэт ойр байгаа үед мэдрэгч мэдрэхгүй байж болно.
- Объектыг таних болон дэлгэц, дуут дохиогоор анхааруулга өгөх хооронд богино хугацааны хоцрогдол үүсч болно. Хурд бага үед ч анхааруулга гарч дохио дуугарах хүртэл объект мэдрэх хүрээнд орсон байх магадлалтай.
- Аудио системийн дууны түвшин, агааржуулалтын систем ажиллах дуунаас хамаарч дуут дохио сайн сонсогдохгүй байж болно.
- Бусад системийн дуут дохионоос хамаарч дуут дохио сайн сонсогдохгүй байж болно.

■ Зай болон дуут дохио

Саад хүртэлх ойролцоо зай	Дохио
Арын голын мэдрэгч: Ойролцоогоор 150 см (4.9 ft.)-с 60 см (2.0 ft.) (1) Урд голын мэдрэгч: Ойролцоогоор 100 см (3.3 ft.)-с 60 см (2.0 ft.) (1)	Удаан
Ойролцоогоор 60 см (2.0 ft.)-с 45 см (1.5 ft.) (1)	Дунд зэрэг
Ойролцоогоор 45 см (1.5 ft.)-с 30 см (1.0 ft.) (1)	Хурдан
30 см (1.0 ft.)-с бага, 15 см (0.5 ft.)-с бага (1)	Үргэлжлэн дуугарах

(1) Автоматаар дуут дохиог унтраах функц идэвжхсэн.

Lexus parking assist-мэдрэгчийн дохионы ажиллагаа ба ажиллах хүрээ

Объект мэдрэгдэх үед дохио дуугарна.

- Мэдрэгч ажиллах үед дохио дуугарна.
- Объектод ойртох тусам дуут дохио илүү хурдан дуугарна. Объектод 30 см (1.0 фут) хүртэлх зайд ойртох үед дуут дохио үргэлжлэн дуугарна.
- 2-с дээш мэдрэгч хөдөлгөөнгүй объектыг зэрэг мэдэрсэн үед илүү ойр байгаа мэдрэгчийн дуут дохио дуугарна.
- Мэдрэгч ажиллах үед зарим нөхцөлд дуут дохионы дуу хаагдана. (дуут дохионы дууг автоматаар хаах функц)

Lexus parking assist-мэдрэгчийн дохионы дууны түвшин тохируулах

Дохионы дууны түвшинг голын дэлгэц дээр тохируулах боломжтой.

1 **-г сонгоно.**
2 **[Driving assist]-г сонгоно.**
3 **[Collision mitigation]-г сонгоно.**
4 **[Parking assist volume]-г сонгоно.**

Lexus parking assist-sensor-н дохионы дууг хаах

Объект мэдрэгдэх үед голын дэлгэц дээр дуут дохионы дууг хаах товч гарч ирнэ. Дуут дохионы дууг хаах үед -г дарна.

Дохиог хаах үед -г дарна. Lexus parking assist-sensor, RCTA болон RCD функцийн дохионы дуу хаагдана.

Дууг хаах тохиргоо дараах нөхцөлд автоматаар цуцлагдана:

- Арааны хөшүүргийг сэлгэсэн.
- Автомашины хурд тодорхой хурдаас давсан.
- Мэдрэгчид доголдол үүссэн, эсвэл системийн ажиллагаа түр цуцлагдсан.
- Ажиллаж буй функцийг гар аргаар цуцласан.
- Хөдөлгүүрийн асаах товчийг унтраасан.

Бага хурдаар явж байгаа үед ард талд автомашин мэдрэгдсэн үеийн дуут дохио, дэлгэцийн анхааруулга*

RCTA (Rear crossing traffic alert) функцийн зориулалт

RCTA функц нь арын гуперны дотор байрлах BSM хойд хажуугийн радарын мэдрэгч ашигладаг. Тус функц нь ухрах үйлдэл хийх үед муу харагддаг хэсгийг нягтлахад жолоочид туслах зориулалттай.

⚠ АЮУЛТАЙ

■ Систем ашиглалттай холбоотой анхааруулга

Системийн мэдрэх түвшин болон хариу үйлдлийн гүйцэтгэл хязгаартай тул системийн ажиллагаанд хэт найдахыг хориглоно. Жолооч нь орчны аюулгүй байдлыг нягтлан аюулгүй жолоодлого хийх үүрэг хариуцлагыг цаг ямагт хүлээдэг.

МЭДЭЭЛЭЛ

■ RCTA функцийн ажиллах нөхцөл

RCTA нь дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Асаах товч ON горимд байгаа.
- Араа R байрлалд байгаа.
- Автомашины хурд 15 км/ц (9 mph)-с бага.
- Ойртож буй автомашины хурд 8 км/ц (5 mph) ба 56 км/ц (35 mph)-н хооронд байгаа.

■ Систем бусад автомашиныг мэдрэхгүй байх нөхцлүүд

RCTA функц нь дараах төрлийн автомашин, эсвэл объектыг таних боломжгүй:

- Чанх хойноос ирж байгаа автомашин
- Хажуу талын зогсоолоос ухарч буй автомашин
- Саад байгаагаас шалтгаалан мэдрэх боломжгүй автомашин



- Замын хашлага, хана, замын тэмдэг, зогсож буй автомашин, бусад төстэй объект*1

*: Тоноглогдсон автомашинд

- Жижиг мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч зэрэг.*1
- Таны автомашинаас холдон явж байгаа автомашин
- Хажуу талын зогсоолоос ойртож буй автомашин*1
- Мэдрэгч болон ойртож буй автомашин хоорондын зай хэт ойрхон үед

■ **Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд**

RCTA функц нь дараах нөхцлүүдэд автомашин мэдрэхгүй байж болно:

- Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтонд өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
- Арын гуперны мэдрэгч байрлах хэсэгт шавар, цас мөс тогтсон, наалт наасан үед
- Аадар бороо, цас, манан зэрэг цаг агаарын муу нөхцөл байдлаас хамаарч норсон замаар явах үед
- Хоорондоо ойр зайтай хэд хэдэн автомашин ойртох үед
- Автомашин өндөр хурдаар ойртох үед
- Чирэх дэгээ, гуперны хамгаалалт (нэмэлт хүрээ зэрэг), унадаг дугуйн суурь, цас түрэх отвал зэрэг мэдрэгчийг халхалж болзошгүй саад автомашинд суурилуулсан үед
- Налуугийн хэмжээ огцом өөрчлөгдөх зам дээр ухрах үед



- Зогсоолын талбайгаас бага өнцгөөр ухарч гарах үед



- Чиргүүл чирэх үед

*1 : Нөхцөл байдлаас хамаарч автомашин, эд зүйлийг мэдэрч болно.

- Таны автомашин болон мэдрэх бүсэд орж ирсэн автомашин хоорондын өндрийн зөрүү их үед
- Мэдрэгчийн ойр орчим хэт халуун, хэт хүйтэн үед
- Явах эд ангийг өөрчилсөн, тохирохгүй хэмжээтэй дугуйтай үед
- Ачсан ачаанаас хамаарч автомашины урд тал өргөгдсөн, доош дарагдсан үед
- Ухрангаа эргэх үед



- Мэдрэх хэсэгт өөр автомашин эргэлт хийж байгаа үед



■ Мөргөлт үүсэх магадлал байхгүй байсан ч систем ажиллаж болзошгүй нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд RCTA функц автомашин, обьектыг буруу таних магадлал нэмэгдэнэ:

- Авто замтай залгаа зогсоолын хажуугийн авто замаар автомашин явах үед



- Электрон долгионыг автомашины хойд тал руу буцаан ойлгож болзошгүй замын хашлага, хана, замын тэмдэг, эсвэл зогсож буй автомашин зэрэг металл хийцтэй эд зүйлс хүртэлх зай ойр үед



- Чирэх дэгээ, гуперны хамгаалалт (нэмэлт хүрээ зэрэг), унадаг дугуйн суурь, цас түрэх отвал зэрэг мэдрэгчийг халхалж болзошгүй саад автомашинд суурилуулсан үед
- Таны автомашины хажуугаар өөр автомашин явж өнгөрөх үед



- Системийн мэдэрсэн автомашин эргэлт хийнгээ ойртож байгаа үед



- Сэнс, барилгын эйр кондишн зэрэг эргэлддэг объект ойр орчимд байгаа үед
- Усалгааны ус шүршигч зэргээс арын гупер лүү ус шүршигдсэн, цацагдсан үед
- Хөдөлгөөнтэй объект (туг, автомашины утаа, борооны том дусал, цас, замын гадаргуу дээрх борооны ус зэрэг.)
- Замын хашлага, хана зэрэг системийн мэдрэх хүрээнд орж ирсэн объект хүртэлх зай хэт ойр үед
- Борооны ус зайлуулах системийн төмөр тор, таг
- Мэдрэгчийн ойр орчим хэт халуун, хэт хүйтэн үед.
- Явах эд ангийг өөрчилсөн, тохирохгүй хэмжээтэй дугуйтай үед
- Ачсан ачаанаас хамаарч автомашины урд тал өргөгдсөн, доош дарагдсан үед

Системийн эд анги



A Хянах самбар

Баруун, эсвэл зүүн хойд талаас автомашин ойртох үед дуут дохио дуугарна.

B Хажуугийн толины индикатор

Баруун, эсвэл зүүн хойд талаас автомашин ойртож буй нь мэдрэгдсэн үед хоёр хажуугийн толины индикатор анивчина.

C Голын дэлгэц

Баруун, эсвэл зүүн хойд талаас автомашин ойртож буй нь мэдрэгдсэн үед голын дэлгэц дээр мэдрэгдсэн талын RCTA тэмдэг гарна. Голын дэлгэц дээр RCTA функцийг асаана/унтраана.

Зурагт хоёр талаас автомашин ойртож буй жишээг харуулав.

МЭДЭЭЛЭЛ

■ Хажуугийн толины индикаторын харагдах байдал

Нар туссан үед хажуугийн толины индикатор сайн харагдахгүй байж болно.

■ RCTA дуут дохионы сонсогдох байдал

Аудио системийн дууны түвшин өндөр зэргээр дуу чимээтэй үед RCTA дуут дохио сайн сонсогдохгүй байж болно.

■ Хойд хажуугийн радарын мэдрэгч

→ X.395

RCTA функц

RCTA функцийн ажиллах нөхцөл

Тус функц нь автомашины баруун болон зүүн хойд талаас ойртож буй автомашиныг радарын мэдрэгч ашиглан мэдрэх ба хажуугийн толины индикатор болон анхааруулах дохио дуугаргаж жолоочид автомашин ойртож буйг анхааруулна.



A Ойртож буй автомашин

B Ойртож буй автомашиныг мэдрэх хүрээ

RCTA тэмдгийн дэлгэц

Автомашины баруун, эсвэл зүүн хойд талаас автомашин ойртож буй мэдрэгдсэн үед дараах байдлаар голын дэлгэц дээр гарна.

Жишээ: Автомашины 2 талаас автомашин зэрэг ойртож байгаа (Жишээ: Lexus parking assist монитортой автомашин)



RCTA функцийн мэдрэх хүрээ

Бусад автомашиныг мэдрэх боломжтой хүрээг дараах байдлаар тайлбарлав.

Автомашин хурдтай ойртож байгаа үед илүү холоос анхааруулга өгөх боломжтой.

Жишээ:



- Ойртож буй автомашины хурд: 56 км/ц (35 mph) (хурдан)

  A Анхааруулга өгөх зай: 25 м (82 ft.)
- Ойртож буй автомашины хурд: 8 км/ц (5 mph) (удаан)

  A Анхааруулга өгөх зай: 5.5 м (18 ft.)

RCTA тохиргоог өөрчлөх

RCTA функцийг асаах/унтраах

Голын дэлгэц дээр RCTA функцийг дараах байдлаар идэвхжүүлэх/цуцлах боломжтой:

1 **-г сонгоно.**
2 **[Driving assist]-г сонгоно.**
3 **[Rear cross traffic alert]-г сонгоно.**

RCTA функц цуцлагдсан үед мэдээллийн дэлгэц дээр жолоодлогод туслах мэдээллийн индикатор асна.

(Асаах товчийг унтраагаад дахин ON горимд асаах үед RCTA функц автоматаар идэвхжинэ.)

RCTA дохионы дууны түвшинг өөрчлөх

Дохионы дууны түвшинг голын дэлгэц дээр өөрчлөх боломжтой.

1 **-г сонгоно.**
2 **[Driving assist]-г сонгоно.**
3 **[Collision mitigation]-г сонгоно.**
4 **[Parking assist volume]-г сонгоно.**

RCTA дохионы дууг түр хаах

Объект мэдрэгдэх үед голын дэлгэц дээр дуу хаах товч гарна. Дуут дохиог хаах үед -г сонгоно.Дуут дохиог хаах үед -г сонгоно. Lexus parking assist-мэдрэгч, RCTA болон RCD функцийн дуу мөн хаагдана.

МЭДЭЭЛЭЛ

Дараах нөхцлүүдэд дууг түр хаах тохиргоо автоматаар цуцлагдана:

- Арааны байрлалыг солисон үед.
- Автомашины хурд тодорхой хурдаас давсан үед.
- Мэдрэгч доголдсон, эсвэл системийн ажиллагаа түр цуцлагдсан үед.
- Функцийн ажиллагааг гараар цуцласан үед.
- Асаах товч унтраасан.

Бага хурдаар явах үед ард талд явган зорчигч мэдрэгдсэн үеийн дуут дохио ба дэлгэцийн мэдээлэл*

RCD арын камераар мэдрэх системийн зорилго

Автомашин ухрах үед RCD функц нь автомашины ард талын мэдрэх хүрээнд явган зорчигчийг мэдрэнэ. Явган зорчигч мэдрэгдсэн үед анхааруулах дуут дохио дуугарах ба голын дэлгэц дээр тэмдэг гарч жолоочид явган зорчигч байгааг анхааруулна.

⚠ АЮУЛТАЙ

■ Системийн ашиглалттай холбоотой анхааруулга

Тус системийн явган зорчигч мэдрэх, мөн хариу үйлдэл үзүүлэх чадвар хязгаартай.

Жолооч нь системд хэт найдалгүй ойр орчны аюулгүй байдлыг нягтлан цаг ямагт аюулгүй жолоодлого хийх үүрэгтэй.

■ Системийн хэвийн ажиллагааг хангах

Осолд хүргэх аюултай тул дараах зүйлсэд анхаарал хандуулна.

- Камерыг гэмтээлгүйгээр байнга цэвэрлэнэ.
- Камерын ойролцоо электрон төхөөрөмж (гэрэлтдэг дугаарыг суурь, манангийн гэрэл зэрэг) суурилуулж болохгүй.
- Камерын ойр орчмыг хүчтэй цохилтоос хамгаална. Хэрэв камерын ойр орчим хүчтэй цохилтонд өртсөн тохиолдолд Lexus дилер дээр оношлуулна уу.
- Камерыг задлах, өөрчлөх, будахыг хориглоно.
- Камерт наалт, нэмэлт чимэглэл наахыг хориглоно.
- Арын гуперт оригинал бус хамгаалалтын хэрэгсэл (гуперны хүрээ зэрэг) суурилуулж болохгүй.
- Дугуйны хээг зөв тохируулна.
- Арын хаалга бүрэн хаагдсан эсэхийг нягтлана.

■ RCD функц унтрах

Дээрх нөхцлүүдийг мөрдөөгүй үед тус функц унтарч болно. RCD функц хэвийн ажиллахгүй байх, улмаар осолд хүргэх аюултай.

- Дээрх нөхцлүүдийг мөрдөөгүй.
- Lexus-н оригинал бус явах эд анги угсарч ашигласан.

МЭДЭЭЛЭЛ

■ RCD функц ажиллах нөхцөл

- Асаах товч ON горимд байгаа.

*: Тоноглогдсон автомашинд

- RCD функц асаалттай.
- Араа R байрлалд байгаа.

■ **Системийн хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд**

- Тус функц дараах зарим явган зорчигчийг таних боломжгүй байх, улмаар систем хэвийн ажиллахгүй байж болно:
  - Урагш тонгойсон, явган суусан хүн
  - Хэвтэж буй хүн
  - Гүйж буй хүн
  - Мэдрэх хүрээнд огцом орж ирсэн хүн
  - Унадаг дугуй, скэйтборд, бусад хөнгөн зорчих хэрэгсэл унасан хүн
  - Борооны цув, урт юбка зэрэг явган зорчигчийн харагдах байдлыг сарниулах том хувцастай хүн
  - Түрдэг тэрэг, шүхэр зэрэгт биеийн зарим хэсэг халхлагдсан хүн
  - Шөнийн цагаар зэрэг харанхуйд сайн харагдахгүй байгаа хүн
- Тус функц дараах нөхцлүүдэд зарим явган зорчигчийг таних боломжгүй байх, улмаар систем хэвийн ажиллахгүй байж болно:
  - Цаг агаар муу (бороо, цас, манан зэрэг) үед ухрах үед
  - Арын камер халхлагдсан (шороо, цас, мөс зэрэг наалдсан), эсвэл линз зурагдсан үед
  - Нар, автомашины их гэрэл зэрэг хүчтэй гэрэл арын камер луу шууд тусч байгаа үед
  - Гарааш, газар доорх авто зогсоолын хаалганы ойр орчимд зэргээр орчны гэрлийн хэмжээ өөрчлөгддөг газар ухрах үед
  - Үүр, үдшийн бүрий, газар доорх авто зогсоол зэрэг бүрэнхий орчинд ухрах үед
  - Камерын байрлал болон чиглэл алдагдсан үед
  - Чирэх дэгээ угсарсан үед
  - Камерын линз дээр усны дусал урсаж байгаа үед
  - Арын шил угаагч ажиллаж байгаа үед
  - Автомашины өндөр огцом өөрчлөгдсөн үед (хамар өргөгдөх, буух зэрэг)
  - Дугуйн гинж, эсвэл жижиг нөөц дугуй, онцгой үед дугуй нөхөх нөхөөс ашигласан үед
  - Явах эд ангид өөрчлөлт хийсэн, эсвэл тохирох хэмжээнд зааснаас өөр хэмжээтэй дугуй ашигласан
  - Нэмэлт тоноглол (дугаарын гэрэлтэй суурь манангийн гэрэл зэрэг) камерын ойр орчимд угсарсан

- Арын гуперт оригинал бус хамгаалалтын хэрэгсэл (гуперны хүрээ зэрэг) суурилуулж болохгүй

■ **Систем санамсаргүй ажиллаж болзошгүй нөхцлүүд**

● Мэдрэх хүрээнд явган зорчигч байхгүй байсан ч дараах объект мэдрэх хүрээнд орсон нөхцөлд тус функц ажиллаж болно.

- Шон, замын конусан тэмдэг, хашаа, эсвэл зогсож буй автомашин
- Автомашин мотоцикл зэрэг хөдөлж буй объект
- Ухрах үед туг дэрвэх, тогтоол ус цацагдах (эсвэл утаа, уур, бороо, цас зэрэг агаарт буй зүйл) зэргээр аливаа эд зүйл автомашинд ойртох
- Чулуун зам, хайрган хучилттай зам, трамвайн рельс, зам засвар, цагаан шугам, зам гарч явган зорчигч, эсвэл зам дээр унасан навч
- Борооны ус зайлуулах сувгийн төмөр торон таг зэрэг
- Тогтоол ус, зам дээр тогтсон усанд ойсон объект
- Зам дээр туссан сүүдэр

● Тус функц дараах нөхцлүүдэд явган зорчигч мэдрэх хүрээнд байхгүй байсан ч ажиллаж болзошгүй

- Замын хажуу, эсвэл зам дээр товгор хэсэг рүү чиглэн ухрах үед
- Өгсүүр, уруу зам руу чиглэн ухрах үед
- Ачсан ачаанаас хамаарч автомашины хойд тал өргөгдсөн, дарагдсан үед
- Арын гуперт нэмэлт хүрээ зэрэг гуперын хамгаалалт суурилуулсан үед
- Арын камерын чиглэл өөрчлөгдсөн үед
- Автомашины ард талд чирэх дэгээ угсарсан үед
- Арын камерын линз дээгүүр усны дусал урсах үед
- Арын камер халхлагдсан (шороо, цас, мөс зэрэг наалдсан), эсвэл линз зурагдсан үед
- Бусад автомашины ослын дохионы гэрэл зэрэг анивчсан гэрэл мэдрэх хүрээнд байгаа үед
- Дугуйн гинж, эсвэл жижиг нөөц дугуй, онцгой үед дугуй нөхөх нөхөөс ашигласан үед

● RCD функцийн анхааруулгыг сонсох, мэдэхэд хүндрэлтэй байх нөхцлүүд

- Аудио системийн дууны хэмжээ өндөр, агааржуулагчийн систем ажиллаж байгаа зэргээс шалтгаалж функцийн анхааруулах дуут дохио муу сонсогдож болно.
- Бүхээгний хэм хэт нам, хэт өндөр үед голын дэлгэц хэвийн ажиллахгүй байж болно.

RCD функц

Голын дэлгэц



A Явган зорчигч мэдрэх тэмдэг

Явган зорчигч мэдрэгдсэн үед автоматаар гарна.

(Асаах товч унтраагаад ON горимд асаах бүрт RCD функц автоматаар идэвхжинэ.)

Явган зорчигч мэдрэгдсэн үед

Мэдрэх хүрээнд явган зорчигч байгааг арын камераар таних систем мэдэрсэн үед дохио болон систем дараах байдлаар ажиллана:



A Явган зорчигч мэдрэх хэсэгт байгаа үед **A**

Дохио: Үргэлжлэн дуугарна

Явган зорчигч мэдрэх тэмдэг: Анивчина

B Явган зорчигч мэдрэх хэсэгт байгаа үед **B**

Дохио (автомашин зогсож байгаа үед): 3 удаа дуугарна

Дохио (автомашин ухарч байгаа үед, явган зорчигч автомашины ард талаас ойртож байгаа үед): Үргэлжлэн дуугарна

Явган зорчигч мэдрэх тэмдэг: Анивчина

C Мэдрэх хүрээнд автомашин болон явган зорчигч мөргөлдөх эрсдэлтэй гэж систем тооцоолсон үед **C**

Дохио: Үргэлжлэн дуугарна

Явган зорчигч мэдрэх тэмдэг: Анивчина

RCD тохиргоог өөрчлөх

RCD функцийг асаах/унтраах

Голын дэлгэцээр RCD функцийг дараах байдлаар асаах, унтраах боломжтой:

1 **-г сонгоно.**

2 **[Driving assist]-г сонгоно.**

3 **[Rear camera detection]-г сонгоно.**

RCD функцийг унтраасан үед мэдээллийн дэлгэц дээр жолоодлогод туслах мэдээллийн индикатор асна.

RCD дохионы дууны түвшин тохируулах

Голын дэлгэцээр дууны түвшин тохируулах боломжтой.

1 **-г сонгоно.**

2 **[Driving assist]-г сонгоно.**

3 **[Collision mitigation]-г сонгоно.**

4 **[Parking assist volume]-г сонгоно.**

RCD дуут дохиог түр унтраах

Объект мэдрэгдэх үед голын дэлгэц дээр дуут дохиог түр унтраах товч гарч ирнэ. -г дарж дуут дохиог түр унтраана. -г дарж дуут дохиог түр унтраана. Энэ үед Lexus parking assist-мэдрэгч, RCTA болон RCD функцуудын дуут дохио мөн унтарна.

МЭДЭЭЛЭЛ

Дараах нөхцлүүдэд дуут дохионы ажиллагаа автоматаар дахин идэвхжинэ:

- Арааны байрлал солигдсон үед.
- Автомашины хурд тодорхой хурдаас давсан.
- Мэдрэгчинд доголдол үүссэн, эсвэл систем түр ажиллагаагүй болсон.
- Ажиллагааны функцийг гар аргаар цуцласан үед.
- Асаах товчийг унтраасан.

Бага хурдаар ойртох үед объект мэдрэгдсэн үеийн тоормосны ажиллагаа *

PKSB зогсоолд байрлуулахад туслах системийн зорилго*

PKSB систем нь автомашиныг зогсоолд байрлуулах зэргээр бага хурдаар урагш явах, ухрах үед ажилладаг дараах функцуудаас бүрддэг. Мэдрэгдсэн объекттой мөргөлдөх магадлал өндөр гэж систем тооцоолсон үед анхааруулга гарч зайлсхийх арга хэмжээ авахыг шаарддаг.

■ Зогсоолд байрлуулахад туслах функц

Систем дараах объектуудыг мэдрэх боломжтой. (Функцаас хамаарч мэдрэх боломжтой объект өөр байна.)

- Урд болон хойд талын хөдөлгөөнгүй объект
- Автомашины араар явж буй автомашин
- Автомашины араар явж буй явган зорчигч

PKSB (Parking Support Brake) систем

⚠ АЮУЛТАЙ

■ Систем ашиглах үеийн анхааруулга

Осолд хүргэх аюултай тул системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй.

Автомашин, зам, цаг агаарын нөхцөл зэргээс хамаарч систем ажиллахгүй байж болно. Мэдрэгч болон радарын мэдрэх боломж хязгаартай. Замын хөдөлгөөнд оролцохдоо ямагт орчин тойрондоо анхаарал хандуулна.

- Жолооч хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй жолоодлогыг бүрэн хангах үүрэгтэй. Замын хөдөлгөөнд оролцохдоо ямагт орчин тойрондоо анхаарал хандуулж оролцоно. PKSB систем нь мөргөлтийн хүчийг бууруулахад зориулагдсан систем ба нөгөөтэйгүүр зарим нөхцөлд ажиллахгүй байж болно.
- PKSB нь автомашиныг бүрэн зогсооход зориулагдсан систем биш болно. Систем автомашиныг зогсоосон ч системийн тоормосны удирдлага 2 секундын дараа цуцлагдах тул тоормосны дөрөө гишгэж бүрэн зогсооно.
- Системийн ажиллагааг хана зэрэг объект руу санаатайгаар жолоодож шалгах нь туйлын аюултай. Ийм үйлдэл огт хийж болохгүй.

■ Зогсоолд байрлуулахад туслах тоормос салгах нөхцлүүд

Мөргөлт үүсэх аюул байхгүй үед ч дараах нөхцөлд систем ажиллаж болзошгүй тул зогсоолд байрлуулахад туслах тоормосыг салгана.

* : Тоноглогдсон автомашинд

⚠ АЮУЛТАЙ

- Автомашиныг динамометрын төхөөрөмж, дамарт хэмжилтийн төхөөрөмж ашиглан оношлох үед
- Автомашиныг усан онгоц, ачааны машин, бусад тээврийн хэрэгсэл дээр ачиж тээвэрлэх үед
- Амортизатор, явах эд ангийг өөрчилсөн, тохирохгүй хэмжээтэй дугуй суурилуулсан үед
- Ачсан ачаа тээшээс хамаарч урд тал өргөгдсөн, эсвэл доош дарагдсан
- Чирэх дэгээ, гуперны хамгаалалт (нэмэлт хүрээ зэрэг), унадаг дугуйн суурь, цас түрэх отвал зэрэг мэдрэгчийг халхалж болзошгүй зүйл суурилуулсан үед
- Автомат авто угаалга ашиглах үед
- Автомашин осолд орсон, систем доголдсон зэрэг хэвийн жолоодлого хийх боломжгүй үед
- Автомашиныг автоспорт, бартаат замын жолоодлогод ашиглах үед
- Дугуйны хий зөв хийлэгдээгүй үед
- Дугуй хэт элэгдсэн үед
- Дугуйн гинж, жижиг нөөц дугуй, онцгой нөхцөлд хэрэглэх дугуйн нөхөөс ашиглаж байгаа үед

■ Явах эд ангийн анхааруулга

Явах эд ангийг өөрчлөхийг хориглоно. Автомашины өндөр болон урагш хойш хазайлт өөрчлөгдсөн үед систем объектын зөв таниж чадахгүй байх, улмаар осолд хүргэх аюултай.

■ Системийн ерөнхий мэдээлэл

Зогсоолд байрлуулахад туслах тоормос аливаа объекттой мөргөлдөх эрсдэлтэй гэж үзсэн үед автомашины хурд нэмэгдэхээс сэргийлж хөдөлгүүрийн хүчийг хязгаарладаг. (Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага: Зураг 2-г харна уу.) Мөн хэрэв хаазны дөрөө гишгэсэн хэвээр байгаа үед автомашины хурдыг бууруулах үүднээс тоормос ажиллуулна. (Тоормосны удирдлага: Зураг 3-г харна уу.)

● Зураг 1: PKSB систем ажиллаагүй үед



A Хөдөлгүүрийн хүч
B Тоормослох хүч
C Хугацаа

● Зураг 2: Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллах үед



A Хөдөлгүүрийн хүч
B Тоормослох хүч
C Хугацаа
D Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж эхэлнэ (Объекттой мөргөлдөх эрсдэл өндөр гэж систем тооцоолсон үед)

● Зураг 3: Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага болон тоормосны удирдлага ажиллах үед



A Хөдөлгүүрийн хүч
B Тоормослох хүч
C Хугацаа
D Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж эхэлнэ (Объекттой мөргөлдөх эрсдэл өндөр гэж систем тооцоолсон үед)
E Тоормосны удирдлага ажиллаж эхэлнэ (Объекттой мөргөлдөх эрсдэл туйлын өндөр гэж систем тооцоолсон үед)

МЭДЭЭЛЭЛ

Зогсоолд байрлуулахад туслах тоормос ажилласан үед

Зогсоолд байрлуулахад туслах тоормосны ажиллагаагаар автомашин зогссон үед зогсоолд байрлуулахад туслах тоормос салгагдах ба PKSB OFF индикатор асна.

Хэрэв зогсоолд байрлуулахад туслах тоормос шаардлагагүй нөхцөлд ажилласан үед ажиллагааг тоормосны дөрөө гишгэх, эсвэл автоматаар цуцлагдах 2 секундын хугацаанд хүлээх үед ажиллагаа цуцлагдана. Системийн ажиллагаа цуцлагдсаны дараа хаазны дөрөө гишгэн хэвийн жолоодох боломжтой.

Зогсоолд байрлуулахад туслах тоормос дахин идэвхжүүлэх

Зогсоолд байрлуулахад туслах тоормос ажиллах үед цуцлагдсан системийн ажиллагааг дахин сэргээх үед системийг дахин идэвхжүүлэх, эсвэл хөдөлгүүр асаах товчийг унтраагаад дахин асаана.

Мөн дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед систем автоматаар идэвхжиж PKSB OFF индикатор унтарна:

- Арааны Р байрлал сонгогдсон
- Объект автомашины явах чиглэлээс гарсан

● Автомашины чиглэл өөрчлөгдсөн*1

PKSB зогсоолд байрлуулахад туслах тоормос асаах/унтраах

PKSB системийг голын дэлгэц дээр ON (асаах) болон OFF (унтраах) боломжтой.

1 **[Settings]-г сонгоно.**

2 **[Driving assist]-г сонгоно.**

3 **[Parking support brake]-г сонгож ON (асаах)/OFF (унтраах) тохиргоонд шилжүүлнэ.**

PKSB систем цуцлагдсан үед жолоодлогод туслах мэдээллийн индикатор асна.

OFF (унтраах) горимд шилжүүлсэн үед PKSB систем цуцлагдах ба голын дэлгэц дээр ON тохиргоонд шилжүүлэх хүртэл дахин идэвхжихгүй.

(Асаах товчны ажиллагаагаар тус функц дахин идэвхжихгүй.)

PKSB зогсоолд байрлуулахад туслах тоормосны дэлгэц ба дуут дохио

Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага, эсвэл тоормосны удирдлага ажиллах үед дохио дуугарч мэдээллийн дэлгэц, HUD дэлгэц* болон голын дэлгэц дээр мэдээлэл гарч жолоочид анхааруулга өгнө.

Нөхцөл байдлаас хамаарч хүч хязгаарлах удирдлага нь хааз хязгаарлах, эсвэл хөдөлгүүрийн хүчийг боломжит байдлаар хязгаарлах зарчмын аль нэгээр ажиллана.

■ **Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж байгаа (хааз хязгаарлах)**

● Тодорхой хэмжээнээс давсан хааз системээр хязгаарлагдана.

● Мэдээллийн дэлгэц:**"Object Detected Ahead Speed Reduced"**

● HUD дэлгэц*:**"Object Detected Acceleration Reduced"**

● Голын дэлгэц: Анхааруулга гарахгүй

● Жолоодлогод туслах мэдээллийн индикатор: Асахгүй

● Дуут дохио: Дуугарахгүй

*1 : PKSB функц (ар талын явган зорчигч) ажиллахаас бусад үед.

* : Тоноглогдсон автомашинд

■ **Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж байгаа (хааз хязгаарлах)**

- Хэвийн үеээс илүү хүчтэй тоормосын ажиллагаа шаардлагатай гэж систем тооцоолсон.
- Мэдээллийн дэлгэц ба HUD дэлгэц*: **"BRAKE!"**
- Голын дэлгэц: **"BRAKE!"**
- Жолоодлогод туслах мэдээллийн индикатор: Асахгүй
- Дуут дохио: Богино дуугарах

■ **Тоормосны удирдлага ажиллаж байгаа**

- Ослын тоормос шаардлагатай гэж систем тооцоолсон.
- Мэдээллийн дэлгэц болон HUD дэлгэц*: **"BRAKE!"**
- Голын дэлгэц: **"BRAKE!"**
- Жолоодлогод туслах мэдээллийн индикатор: Асахгүй
- Дуут дохио: Богино дуугарах

■ **Системийн ажиллагаагаар автомашин зогссон**

- Тоормосны удирдлагын ажиллагаагаар автомашин зогссон.
- Мэдээллийн дэлгэц: **"Accelerator Pedal is Pressed Press Brake Pedal"** (Хааз гишгээгүй үед, **"Press Brake Pedal"** гарна.)
- HUD дэлгэц*: **"Accelerator Pedal is Pressed Press Brake Pedal"** (Хааз гишгээгүй үед, **"Press Brake Pedal"** гарна.)
- Голын дэлгэц: **"Press Brake Pedal"**
- Жолоодлогод туслах мэдээллийн индикатор: Асна
- Дуут дохио: Давтан дуугарна

Урд болон хойд талын хөдөлгөөнгүй объект *

Хэрэв систем автомашины явж буй чиглэлд хана зэрэг хөдөлгөөнгүй объект байгааг мэдэрсэн ба хаазны дөрөөний буруу ажиллагаанаас автомашин урагш огцом ухасхийх, арааны байрлал буруу сонгосноос эсрэг чиглэлд хөдлөх, эсвэл зогсож байгаа болон бага хурдаар явах үедээ тухайн объекттой мөргөлдөх эрсдэлтэй гэж тооцоолсон үед мөргөлтийн хүчийг бууруулах, үр дүнд үүсэх хохирлын хэмжээг багасгах зорилгоор систем ажилладаг.

МЭДЭЭЛЭЛ

■ **Системийн ажиллах нөхцөл**

Тус функц нь жолоодлогод туслах мэдээллийн индикатор асаагүй, анивчаагүй ба дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

* :Тоноглогдсон автомашинд

● Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага

- Зогсоолд байрлуулахад туслах тоормос идэвхижсэн байгаа.
- Автомашины хурд 15км/ц (9 миль/ц)-с бага.
- Автомашины явж буй чиглэлд 2-с 4 м (6-с 13 фут) зайд хөдөлгөөнгүй объект байгаа.
- Мөргөлтөөс зайлсхийх үүднээс зогсоолд байрлуулахад туслах тоормосны систем энгийн үеэс илүү хүчтэй тоормос шаардлагатай гэж тооцоолсон үед.

● Тоормосны удирдлага

- Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж байгаа үед.
- Мөргөлтөөс зайлсхийх үүднээс зогсоолд байрлуулахад туслах тоормосны систем огцом тоормос шаардлагатай гэж тооцоолсон үед.

■ Системийн ажиллагаа зогсох нөхцөл

Дараах аль нэг нөхцөлд функцийн ажиллагаа зогсоно:

● Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага

- Зогсоолд байрлуулахад туслах тоормос салгагдсан үед.
- Хэвийн тоормосны ажиллагаагаар мөргөлтөөс сэргийлэх боломжтой болсон гэж систем тооцоолсон үед.
- Хөдөлгөөнгүй объект 2-с 4 м (6-с 13 фут) хол байгаа, эсвэл эвтомашины явж буй чиглэлд байхгүй үед.

● Тоормосны удирдлага

- Зогсоолд байрлуулахад туслах тоормос салгагдсан үед.
- Автомашин тоормосны удирдлагаар зогссоноос хойш 2 секунд өнгөрсөн.
- Автомашин тоормосны удирдлагаар зогссоны дараа тоормосны дөрөө гишгэсэн.
- Хөдөлгөөнгүй объект 2-с 4 м (6-с 13 фут) хол байгаа, эсвэл эвтомашины явж буй чиглэлд байхгүй үед.

■ Мэдрэх хүрээ

Системийн мэдрэх хүрээ нь Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх хүрээнээс өөр байдаг.

Тиймээс объектыг Lexus parking assist-мэдрэгч мэдэрч анхааруулга өгч байгаа үед ч PKSB функцийн ажиллагаа эхлэхгүй байж болно.

■ Lexus parking assist-мэдрэгчийн дохио

Lexus parking assist-мэдрэгчийн дохиог идэвхжүүлсэн эсэхээс үл хамааран PKSB систем идэвхтэй үед урд болон хойд талын хөдөлгөөнгүй объект мэдэрч тоормосны удирдлага ажилласан нөхцөлд объект хүртэлх

зайг жолоочид мэдэгдэх үүднээс Lexus parking assist-мэдрэгчийн дохио дуугарна.

■ **Систем ажиллахгүй нөхцлүүд**

→ X.408

■ **Мөргөлт үүсэх аюулгүй байсан ч систем ажиллаж болох нөхцлүүд**

→ X.407

⚠ АЮУЛТАЙ

■ **Төмөр замаар гарах үед зэргээр PKSB систем шаардлагагүй үед ажилласан нөхцөлд**

→ X.427

Автомашины урд болон хойд талын хөдөлгөөнгүй объектын мэдрэгч

→ X.411

⚠ АЮУЛТАЙ

■ **Системийн хэвийн ажиллагааг хангах**

→ X.407

■ **Автомашин угаах үед**

→ X.411

Автомашины урд болон хойд талын хөдөлгөөнгүй объект дээр ажиллах жишээ

Автомашины явж буй чиглэлд хөдөлгөөнгүй объект мэдрэгдсэн үед систем дараах нөхцөлд ажиллана.

● Автомашин бага хурдаар явж байгаа ба тоормосны дөрөө гишгээгүй, эсвэл оройтож гишгэсэн нөхцөлд



● Хаазны дөрөөг хэт гишгэсэн



● Араа буруу сонгосноос шалтгаалан автомашин урагш хөдөлсөн үед



Араар явж буй автомашин *

Хэрэв хойд радарын мэдрэгч баруун, зүүн хойд талаас автомашин ойртож байгааг мэдэрсэн ба тухайн объекттой мөргөлдөх өндөр эрсдэлтэй гэж тооцоолсон үед мөргөлтийн хүчийг бууруулах зорилгоор тус функц тоормосны удирдлага ажиллуулдаг.

МЭДЭЭЛЭЛ

Системийн ажиллах нөхцөл

Тус функц нь жолоодлогод туслах мэдээллийн индикатор асаагүй, мөн дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

● Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага

- PKSB систем идэвхжсэн.
- Автомашины хурд 15 км/ц (9 mph)-с бага.
- Баруун, зүүн хойд талаас ойртож буй автомашины хурд 8км/ц (5 mph)-с их үед.

* : Тоноглогдсон автомашинд

- Арааны хөшүүрэг R байрлалд.
- Ойртож буй автомашинтай мөргөлдөхөөс зайлсхийхийн тулд зогсоолд байрлуулахад туслах тоормос хэвийн үеээс илүү хүчтэй тоормос шаардлагатай гэж тооцсон үед.

● Тоормосны удирдлага

- Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж байгаа үед.
- Ойртож буй автомашинтай мөргөлдөхөөс зайлсхийхийн тулд зогсоолд байрлуулахад туслах тоормос ослын тоормос шаардлагатай гэж тооцсон үед.

■ **Системийн ажиллагаа зогсох нөхцөл**

Дараах аль нэг нөхцөлд функцийн ажиллагаа зогсоно:

● Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага

- PKSB систем цуцлагдсан.
- Хэвийн тоормосны ажиллагаагаар мөргөлтөөс зайлсхийх боломжтой үед.
- Баруун, зүүн хойд талд бусад автомашин байхгүй болсон үед.

● Тоормосны удирдлага

- PKSB систем цуцлагдсан.
- Тоормосны удирдлагаар автомашин зогссоноос хойш 2 секунд өнгөрсөн.
- Тоормосны удирдлагаар автомашин зогссоны дараа тоормосны дөрөө гишгэсэн.
- Баруун, зүүн хойд талд бусад автомашин байхгүй болсон үед.

■ **Мэдрэх хүрээ**

Тус системийн мэдрэх хүрээ нь RCTA функцийн мэдрэх хүрээнээс өөр байдаг. → X.420 Тиймээс RCTA функц автомашиныг мэдэрч анхааруулга өгсөн ч PKSB функцийн ажиллагаа эхлэхгүй байж болно.

■ **RCTA дуут дохио**

RCTA функц асаалттай, унтарсан эсэхээс үл хамааран PKSB систем цуцлагдахгүй ба тоормосны удирдлага ажиллах үед дохио дуугарч жолоочид анхааруулга өгнө.

■ **Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд**

→ X.415

■ **Мөргөлт үүсэх аюулгүй байсан ч систем ажиллаж болох нөхцлүүд**

→ X.415

Автомашины ард талаар явж байгаа автомашин функц ажиллах жишээ

Тус функц нь явж буй чиглэлд автомашин мэдрэгдсэн үед дараах нөхцөлд ажиллана.

■ Ухрах үед автомашин ойртож байгаа ба тоормос гишгээгүй, эсвэл оройтож гишгэсэн



Автомашины ард талаар явж байгаа автомашин мэдрэгч

→ X.394

⚠ АЮУЛТАЙ

■ **Системийн хэвийн ажиллагааг хангах**

→ X.394

Автомашины арын явган зорчигч*

Автомашин ухрах үед ар талд явган зорчигч байгааг арын камерны мэдрэгч мэдэрсэн ба явган зорчигчтой мөргөлдөх эрсдэл өндөр гэж систем тооцоолсон нөхцөлд анхааруулах дуут дохио дуугарна. Хэрэв систем явган зорчигчтой мөргөлдөх эрсдэл хэт өндөр гэж тооцоолсон үед мөргөлтийн нөлөөг бууруулах үүднээс систем автоматаар тоормос идэвхжүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ **Систем ажиллах нөхцөл**

● Жолоодлогод туслах мэдээллийн индикатор асаагүй, эсвэл анивчаагүй ба дараах бүх нөхцөл бүрдсэн үед функц ажиллана:

- Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага
- PKSB зогсоолд байрлуулахад туслах тоормосны систем идэвхжсэн.
- Автомашины хурд 15 км/ц (9 mph)-с бага.
- Араа R байрлалд байгаа.

*: Тоноглогдсон автомашинд

- Автомашин ухрах үед ар талд явган зорчигч байгааг арын камерны мэдрэгч мэдэрсэн ба явган зорчигчтой мөргөлдөх эрсдэл өндөр гэж систем тооцоолсон.
- Мөргөлтөөс сэргийлэхэд энгийн үеэс илүү хүчтэй тоормос шаардлагатай гэж PKSB систем тооцсон.

● Тоормосны удирдлага

- Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж байгаа.
- Явган зорчигч мөргөхөөс сэргийлэхэд энгийн үеэс илүү хүчтэй тоормос шаардлагатай гэж PKSB систем тооцсон.

■ **Системийн ажиллагаа зогсох нөхцлүүд**

Дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед функцийн ажиллагаа зогсоно:

● Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага

- PKSB функц цуцлагдсан.
- Энгийн тоормосны ажиллагаагаар мөргөлтөөс зайлсхийх боломжгүй болсон.
- Явган зорчигч автомашины араас гарсан.

● Тоормосны удирдлага

- PKSB функц цуцлагдсан.
- Тоормосны удирдлагаар автомашин зогссоноорс хойш 2 секунд өнгөрсөн.
- Тоормосны удирдлагаар автомашин зогссоны дараа тоормосны дөрөө гишгэсэн.

● Явган зорчигч автомашины араас гарсан.

■ **Мэдрэх хүрээ**

Тус системийн мэдрэх хүрээ RCD функцийн мэдрэх хүрээнээс өөр байдаг.
→ X.425 Тиймээс RCD функц явган зорчигч мэдэрч анхааруулга өгсөн ч PKSB функц ажиллахгүй байж болно.

■ **Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцлүүд**

→ X.422

■ **Систем санамсаргүй ажиллаж болзошгүй нөхцлүүд**

→ X.422

Автомашины ард талд автомашин мэдрэгдсэн үед

Ухрах үед автомашины ард талд явган зорчигч мэдрэгдсэн ба тоормосны дөрөө гишгээгүй, эсвэл оройтож гишгэсэн.



Ар талын явган зорчигчийн дэлгэц

Автомашины ар талын мэдрэх хүрээнд явган зорчигч мэдрэгдсэн үед жолоочид зайлсхийх арга хэмжээ авахыг анхааруулсан анхааруулга гарна. (Анхааруулга мөн голын дэлгэц дээр гарна.)



A Явган зорчигч мэдрэх тэмдэг
B Тоормос сануулах функц

RSA замын тэмдэг танихад туслах систем*

RSA замын тэмдэг танихад туслах систем

RSA систем нь замын тэмдгийг урд камераар танидаг ба дэлгэц болон дохиогоор жолоочид анхааруулга өгдөг.

⚠ АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

RSA системийн ажилагаанд хэт найдаж болохгүй. RSA систем нь замын тэмдгийн мэдээллийг жолоочид өгөх замаар жолоодлогод туслах систем ба нөгөөтэйгүүр жолоочийн хараа, анхаарлыг орлох систем биш болно. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь зөвхөн жолоочийн үүрэг болно. Ойр орчны байдалд анхаарал хандуулан аюулгүй жолоодно.

■ RSA системийг ашиглаж болохгүй нөхцлүүд

● Системийн ажиллагааг цуцлах шаардлагатай нөхцлүүд: → X.350

■ Систем хэвийн ажиллахгүй нөхцлүүд

● Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцлүүд: → X.354

Дэлгэцийн мэдээлэл

Урд камер замын тэмдэг танисан үед дэлгэц дээр замын тэмдэг гарна.

МЭДЭЭЛЭЛ

■ Дэлгэцийн ажиллах нөхцөл

Дараах нөхцлүүд бүрдсэн үед замын тэмдэг дэлгэц дээр гарна:

● Систем замын тэмдэг мэдэрсэн

Дараах нөхцлүүдэд дэлгэцээр гарч буй замын тэмдэг унтарна:

● Тодорхой зай туулах үед шинэ замын тэмдэг танигдаагүй

● Баруун, эсвэл зүүн эргэлт хийсэн зэргээр явж буй зам солигдсон гэж систем тооцсон үед

■ Дэлгэцийн функцийн хэвийн ажиллагаа алдагдаг нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд RSA замын тэмдэг таних функц зөв ажиллахгүйгээс замын тэмдэг зөв танихгүй байх, эсвэл дэлгэц дээр өөр замын тэмдэг гаргаж болно. Нөгөөтэйгүүр энэ нь доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.

● Замын тэмдэг бүдгэрсэн, хазайсан, нугарсан, эсвэл бохирдсон

● Замын электрон тэмдгийн харагдах байдал бүдэг

● Замын тэмдэг бүхэлдээ, эсвэл хэсэгчлэн мод, шон зэрэгт халхлагдсан

● Замын тэмдэг урд камерт богино цаг хугацаанд харагдсан

* : Тоноглогдсон автомашинд

- Жолоодлогын байдлыг (эргэх, эгнээ солих зэрэг) систем буруу танисан
- Уулзвар, эсвэл эгнээ нийлсэн даруйд байрлах замын тэмдэг
- Урд талын автомашины хойд талд наалт наагдсан
- Системийн таних боломжтой замын тэмдэгтэй төстэй өөр стандартын замын тэмдэг танигдсан үед
- Замын хурдны дээд хязгаар урд камерын таних боломжтой хүрээний дотор байгаа
- Тойрог замаар явах үед
- Ачааны машин зэрэгт зориулсан замын тэмдэг танигдсан үед
- Навигацийн системийн программ хангамж хуучирсан үед
- Навигацийн систем ашиглах боломжгүй үед

  Энэ нөхцөлд мэдээллийн дэлгэц болон навигацийн системийн дэлгэцээр гарах хурдны дээд хязгаарын заалт өөр байж болно.

■ **Өөрчлөх боломжтой тохиргоо**

RSA системийн тохиргоог өөрчлөх боломжтой тохиргоогоор өөрчлөх боломжтой.

Мэдээллэх функц

Дараах нөхцлүүдэд RSA систем жолоочид анхааруулах зорилгоор мэдээлэл өгнө.

- Мэдээллийн дэлгэц дээр гарч буй дээд хурд анхааруулах замын тэмдгийн заалтаас автомашины хурд давсан үед замын тэмдэг томоор гарч дохио дуугарна.

Систем таних боломжтой замын тэмдгийн төрлүүд

- Дараах төрлийн замын тэмдгийг дэлгэцээр гаргах боломжтой.

  Нөгөөтэйгүүр стандарт бус, эсвэл сүүлийн үед шинээр нэмэгдсэн замын тэмдгийг танихгүй байж болно.

	Хурдны дээд хязгаарлал

- Автомашины техник үзүүлэлтээс хамаарч замын тэмдэг дэлгэц дээр давхар гарч болно.

	Давхардсан дэлгэцийн жишээ

RSA тохиргоог өөрчлөх

Өөрчлөх боломжтой тохиргоогоор дараах RSA-н тохиргоог өөрчлөх боломжтой. → X.688

Динамик радарын хурд баригч

Динамик радарын хурд баригч

Динамик радарын хурд баригч нь радар ашиглан урд талын автомашиныг мэдэрдэг ба одоогийн автомашин хоорондын зайг тогтоох, мөн урд автомашинаас тохирох зайг баридаг. Автомашин хоорондын зайн товч ашиглан хоорондын зайг тохируулах боломжтой.

Динамик радарын хурд баригчийг зөвхөн хурдны зам, шулуун замд ашиглана.

⚠ АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь жолоочийн үүрэг болно. Системд хэт найдалгүй ойр орчны нөхцөл байдалд анхаарал хандуулан аюулгүй жолоодно.
- Бүх хурдны динамик радарын хурд баригч нь автомашины жолоодлогыг дэмжих замаар жолоочид ирэх ачааллыг бууруулахад систем юм. Нөгөөтэйгүүр системийн үзүүлэх дэмжлэг хязгаартай.

  Дараах нөхцлүүдийг сайтар уншина. Системд хэт найдалгүй цаг ямагт анхааралтай жолоодно.

  - Систем хэвийн ажиллахгүй нөхцлүүд: → Х.446
- Хурдны дээд хязгаар, замын хөдөлгөөний байдал, зам болон цаг агаарын нөхцөл зэрэгт нийцүүлэн хурдаа сонгоно. Жолооч нь тохируулсан хурдыг шалгах, нягтлах үүрэгтэй.
- Систем хэвийн ажилласан ч урд талын автомашины жолоочид харагдаж буй болон системээр мэдрэгдсэн байдал өөр байж болно. Тиймээс жолооч ньболзошгүй эрсдлийг дүгнэх, аюулгүй байдлыг хангах зэргээр анхаарал болгоомжтой байх шаардлагатай. Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ Жолоодлогод туслах системийн анхааруулга

Системийн үзүүлэх жолоодлогын дэмжлэг нь хязгаартай тул дараах анхааруулгыг мөрдөнө. Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- Жолоочид харагдах байдалд үзүүлэх дэмжлэгийн мэдээлэл

  Динамик радарын хурд баригч нь өөрийн болон өмнө яваа тээврийн хэрэгсэл хоорондын зайг тодорхойлоход зөвхөн туслах зориулалттай систем юм. Систем нь замын хөдөлгөөнд анхаарал болгоомжгүйгээр оролцох боломжийг бүрдүүлэх механизм биш бөгөөд мөн үзэгдэх орчин муу нөхцөлд жолоодлогод дэмжлэг үзүүлэх систем биш юм.

⚠ АЮУЛТАЙ

Жолооч нь ойр орчмын нөхцөлд байдалд анхаарал хандуулах шаардлагатай.

- Жолоочийн шийдвэр гаргалтанд үзүүлэх дэмжлэгийн мэдээлэл

  Динамик радарын хурд баригч нь урд талын автомашин хоорондын зайг тохируулсан зайнд байгаа эсэхийг тогтоодог ба бусад дүгнэлт гаргах боломжгүй. Тиймээс жолооч цаг ямагт өндөр сонор сэрэмжтэй байж, тухайн нөхцөлд болзошгүй аюул эрсдэл байгаа эсэхийг тогтоох нь туйлын чухал.

- Жолоочийн үйлдэлд үзүүлэх дэмжлэгийн мэдээлэл

  Динамик радарын хурд баригч системд урд талын автомашинтай мөргөлдөхөөс сэргийлэх, зайлсхийх функц байдаггүй. Тиймээс аливаа болзошгүй аюул эрсдэл үүссэн нөхцөлд аюулгүй байдлыг хангах үүднээс жолооч нэн даруй зохих арга хэмжээ авах шаардлагатай.

■ Динамик радарын хурд баригч ашиглахад тохиромжгүй нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд динамик радарын хурд баригч ашиглаж болохгүй. Эсрэг тохиолдолд автомашины хурдны удирдлага алдагдах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- Хурдны зам руу нэвтрэх хэсэг, гарц
- Ойртолтыг анхааруулах дуут дохио олон дуугарсан үед
- Систем хэвийн ажиллахгүй нөхцлүүд: → Х.354
- Замын шугам танигдахгүй нөхцлүүд: → Х.350

Үндсэн функц



A Тогтмол хурдаар хөдөлгөөнд оролцох:

Урд талд автомашин байхгүй үед

Жолоочийн тохируулсан тогтмол хурдаар автомашин явна.

Уруу замаар уруудах явцад тохируулсан хурдаас хурд давсан үед тохируулсан хурдны дэлгэц анивчиж дохио дуугарна.

B Хөдөлгөөний хурд хасах, урд талын автомашин дагах

Тохируулсан хурдаас урд талын автомашин бага хурдтай үед

Урд талд автомашин байгааг танисан үед систем автоматаар автомашины хурдыг бууруулна. Хурд их хэмжээгээр бууруулах шаардлагатай үед систем тоормос ажиллуулна (тоормосны гэрэл мөн асна). Жолоочийн тохируулсан хоорондын зайг барихын тулд систем урд талын автомашины хурдны өөрчлөлтийг дагана. Урд талын автомашинд ойртохоос сэргийлэх зорилгоор систем хөдөлгөөний хурд хангалттай бууруулж чадаагүй үед ойртолтыг анхааруулах дохио дуугаргаж анхааруулна.

C Хурд нэмэх

Тохируулснаас бага хурдтай автомашин урд талд байхгүй үед

Тохируулсан хурд хүртэл систем аажмаар хурд нэмнэ. Үүний дараа систем тогтмол хурдаар хөдөлгөөн үргэлжлүүлнэ.

D Хөдөлгөөн эхлэх:

HUD дэлгэцгүй автомашин: Урд талын автомашин зогсох үед таны автомашин мөн зогсоно (систем зогсооно). Урд талын автомашин хөдөлгөөн эхлэх үед [**+RES**] товч дарах, эсвэл хаазны дөрөө гишгэх

(хөдөлгөөн эхлэх үйлдэл) үед урд талын автомашиныг дахин дагаж эхэлнэ. Хөдөлгөөн эхлэх үйлдэл хийгээгүй үед систем автомашиныг зогсоосон хэвээр байна.

HUD дэлгэцтэй автомашин: Урд талын автомашин зогсох үед таны автомашин мөн зогсоно (систем зогсооно). Урд талын автомашин хөдөлгөөн эхлэх үед [**+**] товч дарах, эсвэл хаазны дөрөө гишгэх (хөдөлгөөн эхлэх үйлдэл) үед урд талын автомашиныг дахин дагаж эхэлнэ. Хөдөлгөөн эхлэх үйлдэл хийгээгүй үед систем автомашиныг зогсоосон хэвээр байна.

МЭДЭЭЛЭЛ

Ажиллах нөхцөл

- Арааны хөшүүрэг D-д байгаа.

  Арааны хөшүүрэг D-д байгаа.
- Автомашины хурд 30 км/ц (20 миль/ц)-с их үед хүссэн хурдаа тохируулах боломжтой.

  (Нөгөөтэйгүүр автомашины хурд30 км/ц [20 миль/ц]-с бага үед хурд тохируулсан нөхцөлд хурд баригч 30 км/ц [20 миль/ц] хурдад тохируулагдана.)

Хурдны тохиргоо хийсний дараа хааз нэмэх

Хаазны дөрөөг ашиглан хурд нэмэх боломжтой. Хааз өгсний дараа тохируулсан хурданд автоматаар буцна. Нөгөөтэйгүүр автомашин хоорондын зай барих горимд урд талын дагаж буй автомашин хоорондын зай барихын тулд автомашины хурд тохируулсан хурдаас буурч болно.

Автомашин дагах үед системийн удирдлагаар автомашин зогссон нөхцөлд

- HUD дэлгэцгүй автомашин: Системийн удирдлагаар автомашин зогссон үед [**+RES**] товч урд талын автомашин хөдөлгөөн эхэлснээс 3 секундын дотор дарах үед автомашин дагах үйлдэл дахин сэргэнэ.

  HUD дэлгэцтэй автомашин: Системийн удирдлагаар автомашин зогссон үед [**RES**] товч урд талын автомашин хөдөлгөөн эхэлснээс 3 секундын дотор дарах үед автомашин дагах үйлдэл дахин сэргэнэ.
- Системийн удирдлагаар автомашин зогссоноос 3 секундын дотор урд талын автомашин хөдөлгөөн эхэлсэн үед автомашин дагах үйлдэл дахин сэргэнэ.

Автомашин хоорондын зайн удирдлагын горим автоматаар цуцлагдах

Дараах нөхцлүүдэд автомашин хоорондын зайн удирдлагын горим автоматаар цуцлагдана:

- Тоормосны удирдлага, эсвэл жолоодлогод туслах системийн хүч хязгаарлах удирдлага ажилласан үед (Жишээ: Мөргөлтийн өмнөх систем, хөдөлгөөн эхлэх удирдлага)

- Зогсоолын тоормос ажиллуулсан
- Огцом өгсүүр зам дээр автомашин системийн удирдлагаар зогссон
- Системийн удирдлагаар автомашин зогссон үед дараах аль нэг нөхцөл үүссэн:
  - Жолоочийн аюулгүйн бүс тайлагдсан
  - Жолоочийн хаалга нээгдсэн
  - Автомашин зогссоноос хойш 3 минут өнгөрсөн
- Системийн зарим, эсвэл бүх функц ажиллахгүй нөхцлүүд: → X.357

■ **Динамик радарын хурд баригч системийн анхааруулах мэдээлэл болон дохио**

Ашиглалтын аюулгүй байдал: → X.350

■ **Мэдрэгч зөв танихгүй байж болох урд талын тээврийн хэрэгслүүд**

Дараах тохиолдлуудад тухайн нөхцлөөс хамаарч систем шаардлагатай хэмжээний хурд хасалт, хурд нэмэлт хийж чадахгүй үед тоормос, эсвэл хаазны дөрөө гишгэнэ.

Дараах автомашин, тээврийн хэрэгслүүдийг мэдрэгч зөв танихгүй байж болох тул ойртолтын анхааруулга (→X. 451) ажиллахгүй байж болно.

- Бусад автомашин урдуур огцом орж ирэх, эсвэл бусад автомашин хэт удаан, эсвэл хэт хурднаар бусад эгнээ рүү шилжих үед
- Эгнээ солих үед
- Урд талын автомашин хэт бага хурдаар явж байгаа үед
- Таны явж буй эгнээнд автомашин зогссон үед
- Таны явж буй эгнээгээр мотоцикл явж байгаа үед

■ **Систем хэвийн ажиллахгүй байж болохгүй нөхцлүүд**

Дараах нөхцлүүдэд шаардлагатай нөхцөлд тоормосны дөрөө (эсвэл нөхцөл байдлаас хамаарч хаазны дөрөө) гишгэнэ.

Систем автомашиныг зөв танихгүй байж болох тул систем хэвийн ажиллахгүй байж болно.

- Урд талын автомашин огцом тоормослосон үед
- Замын түгжрэлд зэргээр бага хурдаар эгнээгээ солих үед

Системийн эд анги

■ Хянах самбарын дэлгэц



A Мэдээллийн дэлгэц
B Автомашины тохируулсан хурд
C Индикатор

■ Товч

▶ HUD дэлгэцгүй автомашин



A Жолоодлогод туслах горим сонгох товч
B Жолоодлогод туслах товч
C [**+RES**] товч
D [**-**] товч
E Cancel товч
F Автомашин хоорондын зайн товч

▶ HUD дэлгэцтэй автомашин



A Тухайн нөхцөл болон тохиргооноос хамаарч товч бүрийн функц өөр байна.

Товч дарах үед товч бүрийн функц HUD дэлгэц дээр гарна. HUD дэлгэц унтраастай үед функцууд мэдээллийн дэлгэц дээр гарна.

B Жолоодлогод туслах горим сонгох товч
C Жолоодлогод туслах товч
D [**RES**] товч
E [**+**]товч
F [**-**]товч
G Автомашин хоорондын зайн товч
H Cancel товч

Динамик радарын хурд баригч ашиглах

Автомашины хурд тохируулах

1 Жолоодлогод туслах горимын товч дарж динамик радарын хурд баригч сонгоно.

Динамик радарын хурд баригчийн индикатор асна.

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



2 Хаазны дөрөөгөөр хурд нэмэх, эсвэл хасч тохируулах хурдад хүрээд (30 км/ц [20 миль/ц]-с дээш) жолоодлогод туслах товч дарж хурд тохируулна.

Мэдээллийн дэлгэц дээр тохируулсан хурд гарна.

Жолоодлогод туслах товчийг суллах үеийн хурд тохируулсан хурдаар тохируулагдана.

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



Тохируулсан хурдыг өөрчлөх

■ **Товч ашиглан тохируулсан хурд өөрчлөх**

● **HUD дэлгэцгүй автомашин: Тохируулах хурд дэлгэцээр гарах хүртэл [+RES], эсвэл [-] товчийг дарна.HUD дэлгэцтэй**

автомашин: Тохируулах хурд дэлгэцээр гарах хүртэл[+], эсвэл [-] товчийг дарна.

▶ HUD дэлгэцгүй автомашин:



▶ HUD дэлгэцтэй автомашин:



1 Тохируулсан хурд нэмнэ

2 Тохируулсан хурд хасна

Тохиргоо (бага) : Товчийг дарна

Тохиргоо (их): Тохиргоо хийх хурдад хүртэл товчийг дарна.

Автомашины тохируулсан хурд дараах байдлаар нэмэгдэж буурна:

Тохиргоо (бага) : Товч дарах бүрт 1 км/ц (0.6 mph), эсвэл 1миль/ц (1.6 km/h)-р нэмэгдэх буюу буурна

Тохиргоо (их): Товч дарах хугацаанд 5 км/ц (3.1 mph), эсвэл 5 миль/ц (8 km/h) шатлалтайгаар нэмэгдэх буюу буурна

Өөрчлөх боломжтой тохиргоогоор тохируулсан хурдны өөрчлөгдөх шатлалыг өөрчилж болно.

■ **Хаазны дөрөөгөөр тохируулсан хурдыг нэмэх**

1 Шинээр тохируулах хурдад хүртэл хааз гишгэнэ.

2 HUD дэлгэцгүй автомашин: [+RES] товч дарна.HUD дэлгэцтэй автомашин: [+] товч дарна.

Удирдлагыг цуцлах/сэргээх

1 Цуцлах товч, эсвэл жолоодлогод туслах товч дарж удирдлагыг цуцлана.

Хаазны дөрөө гишгэх үед удирдлага мөн цуцлагдана.

(Хэрэв автомашин системийн удирдлагаар зогссон үед тоормосны дөрөө гишгэх нь удирдлагыг цуцлахгүй.)

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



2 HUD дэлгэцтэй автомашин: [+RES] товч дарж удирдлагыг сэргээнэ.HUD дэлгэцтэй автомашин: [RES] товч дарж удирдлагыг сэргээнэ.

Автомашин хоорондын зайг өөрчлөх

● **Товчийг дарах үед автомашин хоорондын зай дараах байдлаар өөрчлөгдөнө:**

Урд талд автомашин байгаа үед автомашин дагах тэмдэг дэлгэц дээр гарна.

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



Зургийн дугаар	Автомашин хоорондын зай	Ойролцоо зай (Автомашины хурд: 100 км/ц [60миль/ц])
1	Хол	70 м (230 фут) орчим
2	Дунд зэрэг (Хол)	60 м (200 фут) орчим
3	Дунд зэрэг (Ойр)	45 м (145 фут) орчим
4	Ойр	30 м (100 фут) орчим

Автомашин хоорондын бодит зай нь автомашины хурдаас хамаарч өөр байна. Мөн системийн ажиллагаагаар автомашин зогссон үед тохиргооноос хамааралгүйгээр урд автомашинаас тодорхой зайд автомашин зогсоно.

Ойртолтын анхааруулга

Урдуур автомашин огцом орж ирсэн зэргээр таны автомашин урд автомашинд ойртож байгаа ба систем хангалттай хурд хасч чадахгүй үед анхааруулах дэлгэц асан дохио дуугарч жолоочид анхааруулга өгнө. Тохиромжтой автомашин хоорондын зайг хангах үүднээс тоормосны дөрөө гишгэнэ.

Анхааруулга өгөхгүй нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд автомашин хоорондын зай ойр байсан ч анхааруулга өгөхгүй байж болно.

- Урд талын автомашин таны автомашинтай адил хурд, эсвэл илүү хурдтай явж байгаа үед
- Урд талын автомашин хэт бага хурдтай явж байгаа үед
- Автомашины хурдыг тохируулсан даруйд
- Хаазны дөрөө гишгэсэн үед

Эргэлтийн үед хурд хасах функц

Замын эргэлт танигдсан үед автомашины хурд хасагдаж эхэлнэ. Эргэлт дуусах үед хурд хасалт дуусна.



Нөхцөл байдлаас хамаарч автомашины хурд тохируулсан хурдад буцна.

Урд талын автомашин огцом урдуур орж ирэх зэрэг автомашин хоорондын зайн удирдлагыг ажиллуулах шаардлагатай үед эргэлтийн үед хурд хасах функцийн ажиллагаа цуцлагдана.

МЭДЭЭЛЭЛ

■ Эргэлтийн үед хурд хасах функц ажиллахгүй нөхцлүүд

Дараах нөхцлүүдэд эргэлтийн үед хурд хасах функц ажиллахгүй байж болно:

- Автомашин алсуур эргэлттэй замаар явж байгаа
- Хаазны дөрөө гишгэсэн
- Автомашин хэт богино эргэлттэй хэсгээр явж байгаа

■ Эргэлтийн үед хурд хасах функцийн тохиргоог өөрчлөх

Өөрчлөх боломжтой тохиргоогоор эргэлтийн үед хурд хасах функцийн тохиргоог өөрчлөх боломжтой. (→X. 687)

Эгнээ солих үеийн дэмжлэг

80 км/ц (50 миль/ц)-с дээш хурдтайгаар гүйцэж түрүүлэх эгнээ рүү эгнээ солих нөхцөлд эргэх дохионы хөшүүргийг түлхэн эгнээ солих үед гүйцэж түрүүлэх үйлдэлд дэмжлэг үзүүлэх үүднээс тохируулсан хурд хүртэл автомашины хурд нэмэгдэнэ.

Гүйцэж түрүүлэх эгнээний байрлалыг зөвхөн автомашины жолооны хүрдний байршлаар систем тодорхойлдог (зүүн гарын замын хөдөлгөөн/баруун гарын замын хөдөлгөөн). Хэрэв автомашиныг гүйцэж түрүүлэх эгнээ нь анх нийлүүлэгдсэнээс эсрэг талын улс оронд ашигласан нөхцөлд автомашин гүйцэж түрүүлэх эгнээний эсрэг тал руу эргэх дохионы хөшүүрэг түлхэх үед хурд нэмж болзошгүй. (Жишээ: баруун гарын замын хөдөлгөөнтэй улсад нийлүүлэгдсэн автомашиныг зүүн гарын замын хөдөлгөөнтэй улс оронд ашиглах үед эргэх дохионы хөшүүргийг баруун түлхэх үед автомашин хурд нэмнэ.)

Таны автомашинаас бага хурдтай автомашин зорчиж буй эгнээ рүү 80 км/ц (50 миль/ц)-с дээш хурдтайгаар явах үедээ эгнээ солих нөхцөлд эргэх дохионы хөшүүргийг түлхэх үед гүйцэж түрүүлэх үйлдэлд дэмжлэг үзүүлэх үүднээс хурд буурна.

Замын тэмдэг таних динамик радарын хурд баригч*

HUD дэлгэцгүй автомашин: Замын тэмдэг таних RSA функц идэвхжсэн ба динамик радарын хурд баригч ажиллах үед хурдны дээд хязгаарын тэмдэг танигдсан нөхцөлд танигдсан хурд дэлгэцээр дээш доош сумтай хамт гарна. Тохируулсан хурдыг танигдсан хурдны хэмжээ хүртэл [**+RES**] товч , эсвэл [**-**] товч удаан даран нэмж хасна.

HUD дэлгэцтэй автомашин: Замын тэмдэг таних RSA функц идэвхжсэн ба динамик радарын хурд баригч ажиллах үед хурдны дээд хязгаарын тэмдэг танигдсан нөхцөлд танигдсан хурд дэлгэцээр дээш доош сумтай хамт гарна. Тохируулсан хурдыг

* : Тоноглогдсон автомашинд

танигдсан хурдны хэмжээ хүртэл [**+**] товч , эсвэл [**-**] товч удаан даран нэмж хасна.

■ Тохируулсан хурд танигдсан хурдаас бага үед

▶ HUD дэлгэцгүй автомашин

[**+RES**] товч удаан дарна.

▶ HUD дэлгэцтэй автомашин:

[**+**] товч удаан дарна.





■ Тохируулсан хурд танигдсан хурдаас их үед

[**-**] товч удаан дарна.

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



■ Замын тэмдэг таних динамик радарын хурд баригч идэвхжүүлэх, цуцлах

Замын тэмдэг таних динамик радарын хурд баригчийг customize тохиргоогоор идэвхжүүлэх, цуцлах боломжтой.(→X. 687)

МЭДЭЭЛЭЛ

Замын тэмдэг таних динамик радарын хурд баригч дараах нөхцөлд хэвийн ажиллахгүй байж болно

Замын тэмдэг таних динамик радарын хурд баригч нь замын тэмдэг таних RSA функц хэвийн ажиллахгүй байх, эсвэл замын тэмдэг зөв танихгүй нөхцөлд хэвийн ажиллахгүй (→Х. 439), тус функцийг ашиглах үед автомашины бодит хурдыг нягтлана уу.

HUD дэлгэцгүй автомашин: Дараах нөхцлүүдэд [**+RES**] товч, эсвэл [**-**] товч дарсан ч тохируулсан хурд танигдсан хурдад шилжихгүй байж болно:

HUD дэлгэцтэй автомашин: дараах нөхцлүүдэд [**+**] товч, эсвэл [**-**] товч дарсан ч тохируулсан хурд танигдсан хурдад шилжихгүй байж болно:

- Хурдны мэдээлэл байхгүй үед
- Танигдсан хурд болон тохируулсан хурд адил үед
- Танигдсан хурд динамик радарын хурд баригчийн ажиллах боломжтой хэмжээнээс гадна үед

Хурд баригч

Хурд баригч

Хаазны дөрөө гишгээгүй байсан ч автомашиныг тогтоосон хурдаар жолоодох боломжтой.

Хурд баригчийг зөвхөн хурдны зам, шулуун зам дээр ашиглана

⚠ АЮУЛТАЙ

■ **Ашиглалтын аюулгүй байдал**

- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь жолоочийн үүрэг болно. Системд хэт найдалгүй ойр орчны нөхцөл байдалд анхаарал хандуулан аюулгүй жолоодно.
- Хурдны хязгаар, хөдөлгөөний урсгал, замын нөхцөл, цаг агаар зэрэгт нийцүүлэн тохиромжтой хурд сонгож тохируулна. Жолооч нь тохируулсан хурдыг шалгах үүрэгтэй.

■ **Хурд баригч ашиглах болохгүй нөхцлүүд**

Дараах нөхцлүүдэд хурд баригч ашиглаж болохгүй. Систем автомашиныг зөв удирдах боломжгүй болох тул хурд баригч ашиглах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- Огцом эргэлттэй зам дээр
- Хүчтэй салхитай зам дээр
- Бороо, цас мөстэй зэрэг хальтиргаатай зам дээр
- Эгц уруу зам, эсвэл огцом өгсүүр уруу замтай хэсэгт

  Уруу замаар явах үед автомашины хурд тогтоосон хурдаас давж болно.
- Системийг цуцлах шаардлагатай нөхцлүүд: → X.350

Системийн эд анги

■ **Хянах самбар**



A Автомашины тохируулсан хурд
B Хурд баригчийн индикатор

■ Товч

▶ HUD дэлгэцгүй автомашин:



A Жолоодлогод туслах горим сонгох товч
B Жолоодлогод туслах товч
C [**+RES**]товч
D [**-**]товч
E Cancel товч

▶ HUD дэлгэцтэй автомашин:



A Тухайн нөхцөл болон тохиргооноос хамаарч товч бүрийн функц өөр байна.

Товчинд хүрэх үед товч тус бүрийн функцийг HUD дэлгэц дээр гаргана. HUD дэлгэц унтраастай үед мэдээллийн дэлгэц дээр функцийг гаргана.

B Жолоодлогод туслах горим сонгох товч
C Жолоодлогод туслах товч
D [**RES**]товч
E [**+**]товч
F [**-**]товч
G Cancel товч

Хурд баригч ашиглах

Автомашины хурд тохируулах

1 Жолоодлогод туслах горимын товч дарж хурд баригч сонгоно.

Хурд баригчийн индикатор асна.

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



2 Хаазны дөрөөгөөр автомашины шаардлагатай хурд (30 км/ц [20 миль/ц]-с дээш) хүртэл хурдаа нэмэх буюу хасах ба жолоодлогод туслах товч дарж хурдны тохиргоог хийнэ.

Товчийг суллах үеийн автомашины хурдаар тохируулсан хурд сонгогдоно.

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



Автомашины тохируулсан хурд өөрчлөх

■ Автомашины тохируулсан хурдыг товчоор өөрчлөх

● **HUD дэлгэцгүй автомашин: Тохируулах хурд гарах хүртэл [+RES], эсвэл [-] товч дарна.HUD дэлгэцтэй автомашин: Тохируулах хурд гарах хүртэл [+], эсвэл [-] товч дарна.**

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



1 Тохируулсан хурд нэмнэ

2 Тохируулсан хурд хасна

Тохируулсан хурд дараах байдлаар нэмэгдэх буюу буурна:

Бага тохиргоо: Товч дарах бүрт 1 км/ц (0.6 mph), эсвэл 1 миль/ц (1.6 km/h)-р өөрчлөгдөнө

Их тохиргоо: Товч дарах хугацаанд хурд өөрчлөгдөнө

■ **Хаазны дөрөөгөөр тохируулсан хурд нэмэх**

1 Тохируулах хурд хүртэл хаазны дөрөө гишгэн хурд нэмнэ.

2 HUD дэлгэцгүй автомашин: [+RES] товч дарна. HUD дэлгэцтэй автомашин: [+] товч дарна

Удирдлагыг цуцлах/дахин сэргээх

1 Cancel товч, эсвэл жолоодлогод туслах товчийг дарж удирдлагыг цуцлана.

Мөн тоормосны дөрөө гишгэн удирдлагыг цуцлах боломжтой.

▶ HUD дэлгэцгүй автомашин



▶ HUD дэлгэцтэй автомашин



2 HUD дэлгэцгүй автомашин: [+RES] товч дарж удирдлагыг сэргээнэ.HUD дэлгэцтэй автомашин: [RES] товч дарж удирдлагыг сэргээнэ.

Хурд баригч автоматаар цуцлагдах

Дараах нөхцлүүдэд хурд баригчийн ажиллагаа автоматаар цуцлагдана:

- Тохируулсан хурдаас автомашины хурдаас 16 км/ц (10 mph) ба түүнээс доош буурсан
- Автомашины хурд 30 км/ц (20 mph)-с доош буурсан
- Тоормосны удирдлага, эсвэл жолоодлогод туслах системийн хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажилласан үед (Жишээ: PCS, хөдөлгөөн эхлэх удирдлага)
- Зогсоолын тоормос ажилласан
- Системийн зарим, эсвэл бүх функцууд ажиллахгүй нөхцлүүд: → X.357

Хааз болон тоормосны дөрөөг зэрэг гишгэсэн үед хөдөлгүүрийн хүчийг хязгаарлах

Brake Override системийн зориулалт

Хааз болон тоормосны дөрөөг зэрэг гишгэх үед систем хөдөлгүүрийн хүчийг хязгаарладаг. Систем ажиллах үед мэдээллийн дэлгэц дээр анхааруулах мэдэээлэл гарна.

⚠ АЮУЛТАЙ

Буруу дөрөө гишгэхээс сэргийлж жолоодлогын өмнө тоормос болон хаазны дөрөөний байрлалыг сайтар мэддэг болох шаардлагатай.

Тоормосны дөрөөний оронд андуурч хааз гишгэсэн үед автомашин огцом ухасхийн хөдлөх аюултай.

⚠ АНХААР

Хөдөлгүүрийн хүчийг хязгаарлах тул хөдөлгөөний үед тоормос болон хаазны дөрөөг зэрэг гишгэж болохгүй.

Огцом хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах удирдлага

Огцом хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах (Хөдөлгөөн эхлэх удирдлага [DSC])

Хаазны дөрөө гишгэсэн үед дараах хэвийн бус үйлдэл хийгдсэн нөхцөлд систем хөдөлгүүрийн хүчийг хязгаарладаг.

- Арааг R-д шилжүүлсэн[1]
- Урагш жолоодлогын D зэрэг араанаас P, эсвэл R араанд шилжүүлсэн [1]

Систем ажилласан үед анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гарна. Анхааруулгын зааварчилгааг мөрдөнө.

Систем ажилласан үед анхааруулах гэрэл асна.

МЭДЭЭЛЭЛ

■ Хөдөлгөөн эхлэх удирдлага (DSC)

TRC идэвхгүй үед огцом хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах удирдлага мөн цуцлагдана. Огцом хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах систем идэвхжсэн үед автомашиныг шавар, цаснаас гаргахад хүндрэлтэй болж болно. Энэ тохиолдолд TRC системийг идэвхгүй болгож шавар цаснаас автомашин гаргах боломжтой.

Мөн огцон хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах удирдлага дараах нөхцлүүдэд ажиллахгүй:

- Trail горим ассан үед

Холбоотой холбоосууд

Жолоодлогод туслах системүүд(Х. 358)

*1 : Тухайн нөхцлөөс хамаарч арааны байрлал өөрчлөгдөхгүй байж болно

Зорчигчид ирэх мөргөлтийн хүчийг бууруулах

Аюулгүйн бүс буцаан чангалагч

● Тайвань, Вьетнам, Чили, Хонг Конг, Макао, Бруней, Сингапур, Индонези, Малайз, ӨАБНУ-с бусад:

Автомашин урд талаараа тодорхой төрлийн хүчтэй мөргөлтөнд өртсөн үед урд суудлын аюулгүйн бүс огцом хураагдаж жолооч болон зорчигчийг суудалтай чанга барина.

Энэ функц автомашин урд, хажуу, ард талаараа хүч багатай мөргөлтөд өртсөн, хөмөрсөн үед ажиллахгүй.

● Тайвань, Вьетнам, Чили, Хонг Конг, Макао, Бруней, Сингапур, Индонези, Малайз, ӨАБНУ:

Автомашин урд талаараа тодорхой төрлийн хүчтэй мөргөлтөнд өртөх үед урд суудал болон арын захын суудлын аюулгүйн бүс огцом хураагдаж жолооч болон зорчигчийг суудалтай чанга барина.

Энэ функц автомашин урд, хажуу, ард талаараа хүч багатай мөргөлтөд өртсөн, хөмөрсөн үед ажиллахгүй.



МЭДЭЭЛЭЛ

■ **Аюулгүйн бүс чангалагч ажилласан үед аюулгүйн бүсийг шинээр солино**

Хэрэв автомашин хэд хэдэн мөргөлтөнд өртсөн тохиолдолд бүс буцаан чангалагч зөвхөн эхний мөргөлтийн үед ажиллах ба 2 ба түүнээс хойших мөргөлтийн үед идэвхжихгүй.

■ **PCS-тэй холбоотой удирдлага**

Мөргөлтийн өмнөх тоормосны PCS систем мөргөлт үүсэх магадлал өндөр гэж тооцоолсон үед аюулгүйн бүс буцаан чангалагч ажиллахад бэлэн байдалд орно.

⚠ АЮУЛТАЙ

■ Аюулгүйн бүс буцаан чангалагч

Буцаан чангалагч ажилласан үед SRS анхааруулах гэрэл асна.

Энэ нөхцөлд аюулгүйн бүс ашиглах боломжгүй болох тул та өөрийн Lexus дилер дээр солиулна уу.

Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

SRS аюулгүйн дэр

Жолооч, зорчигчдод ноцтой гэмтэл учруулж болзошгүй цохилтонд автомашин өртсөн үед SRS аюулгүйн дэр дэлгэгддэг. Дэр нь амь нас, эрүүл мэндэд учирч болох ноцтой эрсдэлийг аюулгүйн бүстэй цогцоор ажиллаж бууруулдаг.



A SRS жолоочийн аюулгүйн дэр/урд зорчигчийн аюулгүйн дэр

Жолооч, урд зорчигчийн толгой, цээжин биеийг автомашины салоны эд ангиас ирэх цохилтоос хамгаална.

B SRS өвдөгний аюулгүйн дэр

Жолооч болон урд зорчигчийг хамгаална

C SRS хажуугийн аюулгүйн дэр

● Жолооч болон урд зорчигчийн биеийг хамгаална

D SRS хөшигөн аюулгүйн дэр

Жолооч, урд зорчигч, арын захын суудлын зорчигчийн толгойг хамгаална

E SRS урд голын аюулгүйн дэр*

Жолооч, урд зорчигчийн толгой, хүзүүг хамгаална

Үндсэн SRS аюулгүйн дэрний системийн бүрдлийг дээрх зурганд харуулав. SRS аюулгүйн дэр нь аюулгүйн дэрний мэдрэгчийн иж бүрдлээр удирдагддаг. Аюулгүйн дэр дэлгэгдэх үед дэлгэгч доторх химийн урвал аюулгүйн дэрийг хоргүй хийгээр хормын дотор дүүргэж зорчигчийн хөдөлгөөнийг хязгаарладаг.

МЭДЭЭЛЭЛ

SRS аюулгүйн дэр дэлгэгдсэн үед

- SRS аюулгүйн дэр нь өндөр хэмтэй хий ашиглан өндөр хурдаар дэлгэгддэг тул дэр дэлгэгдэх үед бага зэргийн шалбархай, түлэгдэл, хөхрөлт зэрэг үүсч болзошгүй.
- Чанга дуу гарах ба цагаан нунтаг цацагдана.
- Аюулгүйн дэрний модулийн эд ангиуд (жолооны хүрдний гол, аюулгүйн дэрний таг, аюулгүйн дэр дэлгэгч) болон ойролцоох эд ангиуд хэдэн минутын хугацаанд өндөр хэмтэй байж болно. Аюулгүйн дэр мөн адил өндөр хэмтэй байж болно.
- Салхины шил хагарч болзошгүй.
- Бүх хаалганы түгжээ тайлагдана.
- Тоормос, тоормосны гэрэл автоматаар удирдагдана.
- Салоны гэрлүүд асна.
- Ослын дохионы гэрэл автоматаар асна.
- Хөдөлгүүрт очих шатахуун таслагдана.
- eCall-тай автомашин: Дараах нөхцлүүд үүссэн үед тус систем нь eCall удирдлагын төв рүү ослын дуудлага хийж автомашины байрлалыг мэдэгддэг ([**SOS**] товч дарах шаардлагагүй) ба мэдээлэх ба оператор энэ үед ослын байдлын түвшин болон тусламж шаардлагатай эсэхийг тодруулна. Хэрэв жолооч болон зорчигч харилцах боломжгүй үед оператор ослын нөхцөл үүссэн гэж үзэн түргэн, онцгой албыг дуудлагад гаргана.
  - SRS аюулгүйн дэр ажилласан
  - Аюулгүйн бүс буцаан чангалагч ажилласан
  - Ноцтой хойд мөргөлтөнд өртсөн

Урд талын мөргөлтөнд SRS аюулгүйн дэр ажиллах нөхцлүүд

- Дараах SRS аюулгүйн дэр нь тогтоосон хэмжээ (20 - 30км/ц [12 - 18 миль/ц] орчим хурдаар хөдлөхгүй, хэлбэр алдахгүй хатуу хана урд талаараа мөргөхтэй дүйцэх)-с давсан мөргөлт үүсэх үед дэлгэгдэнэ:

*:Тоноглогдсон автомашинд

- SRS урд аюулгүйн дэр
- SRS өвдөгний аюулгүйн дэр

● Нөгөөтэйгүүр дараах тохиолдлуудад энэхүү хурдны тогтоосон хэмжээ харьцангуй өндөр байж болно:

- Мөргөлт үүсэх үед хөдөлгөөнд орох, хэлбэр алдах объект буюу зогсож буй автомашин, эсвэл замын тэмдгийг автомашин мөргөсөн үед

  Автомашины урд хэсэг ачааны машины тэвшинд доогуур орох, бусад машины доогуур шургах байдлаар мөргөлдсөн үед

● Мөргөлтийн төрлөөс хамаарч зөвхөн аюулгүйн дэр идэвхжиж болно:

- Аюулгүйн бүс бүцаан чангалагч

● Урд зорчигчийн суудалд зорчигч суугаагүй үед SRS урд зорчигчийн аюулгүйн дэрнүүд дэлгэгдэхгүй. Нөгөөтэйгүүр хэрэв урд суудал дээр эд зүйл тависан үед зорчигч суугаагүй байсан ч урд зорчигчийн суудлын SRS аюулгүйн дэр дэлгэгдэж болно.

● Урд талаараа ноцтой мөргөлтөнд өртсөн үед баруун болон зүүн талын SRS хөшигөн аюулгүйн дэр мөн дэлгэгдэж болно.

■ **Хажуугийн мөргөлтөнд SRS аюулгүйн дэр дэлгэгдэх нөхцлүүд**

● Дараах SRS аюулгүйн дэр нь тогтоосон хэмжээ (1500кг (3300 фунт) орчим жинтэй автомашин 20 - 30км/ц [12 - 18 миль/ц] хурдаар автомашины кабиныг хөндлөн чиглэлээс мөргөхтэй дүйцэх)-с давсан мөргөлт үүсэх үед дэлгэгдэнэ:

- SRS хажуугийн аюулгүйн дэр
- SRS хөшигөн аюулгүйн дэр
- SRS урд голын аюулгүйн дэр

● Аль талаараа мөргөлтөнд орсноос үл хамааран хоёр талын SRS хөшигөн аюулгүйн дэр зэрэг дэлгэгдэнэ.

■ **Доод талаараа мөргөлтөнд өртөх үед SRS аюулгүйн дэр дэлгэгдэх нөхцлүүд**

● Автомашины доод тал хатуу зүйл цохих үед дараах аюулгүйн дэр дэлгэгдэж болно:

- SRS урд аюулгүйн дэр
- SRS өвдөгний аюулгүйн дэр
- SRS хажуугийн аюулгүйн дэр
- SRS хөшигөн аюулгүйн дэр



■ **SRS хажуугийн аюулгүйн дэр дэлгэгдэхгүй нөхцлүүд**

● Дараах SRS аюулгүйн дэр нь автомашин хажуу болон хойд талаараа мөргөлтөнд өртсөн, хөмөрсөн, эсвэл бага хурдтай урд талын мөргөлтөнд өртсөн үед ерөнхийдөө дэлгэгддэггүй. Нөгөөтэйгүүр автомашины урагш чиглэлийн хурдыг тодорхой хэмжээнээс давуулан бууруулах аливаа мөргөлтийн үед эдгээр дэр дэлгэгдэж болно.



- SRS урд аюулгүйн дэр
- SRS өвдөгний аюулгүйн дэр

● Дараах SRS аюулгүйн дэр нь автомашин тодорхой өнцөгтэй хажуугийн мөргөлт, эсвэл зорчигчийн хэсгээс өөр хэсгээрээ хажуугийн мөргөлтөнд өртсөн үед дэлгэгдэхгүй байж болно:



- SRS хажуугийн аюулгүйн дэр
- SRS хөшигөн аюулгүйн дэр
- SRS урд голын аюулгүйн дэр

● Дараах SRS аюулгүйн дэр нь автомашин хөмөрсөн, урд, хойд талын, эсвэл бага хурдтай хажуугийн мөргөлтөнд өртсөн үед дэлгэгддэггүй:



- SRS хажуугийн аюулгүйн дэр
- SRS урд голын аюулгүйн дэр

● Дараах SRS аюулгүйн дэр нь автомашин хөмөрсөн, хойд талын, эсвэл бага хурдтай урд, хажуу талын мөргөлтөнд ерөнхийдөө дэлгэгддэггүй:



- SRS хөшигөн аюулгүйн дэр

■ **Lexus дилерт хандах нөхцөл**

Дараах нөхцлүүдэд автомашинд оношилгоо, засвар үйлчилгээ хийх шаардлагатай. Та даруй өөрийн Lexus дилерт хандана уу.

● Дараах аль нэг SRS аюулгүйн дэр дэлгэгдсэн үед

- Автомашины урд тал гэмтсэн, хэлбэр алдсан, эсвэл дараах SRS аюулгүйн дэр дэлгэгдэхээргүй хэмжээний хүчтэй мөргөлтөд өртсөн үед:
  - SRS урд аюулгүйн дэр
  - SRS өвдөгний аюулгүйн дэр



- Хаалга, хаалганы ойр орчим гэмтсэн, хэлбэр алдсан, хаалганд нүх үүссэн, эсвэл дараах SRS аюулгүйн дэр дэлгэгдэхээргүй хэмжээний хүчтэй мөргөлтөд өртсөн үед:
  - SRS хажуугийн аюулгүйн дэр
  - SRS хөшигөн аюулгүйн дэр
  - SRS урд голын аюулгүйн дэр



- Жолооны хүрдний төв хэсэг, эсвэл урд зорчигчийн аюулгүйн дэрний ойр орчим, эсвэл хянах самбарын доод тал зурагдсан, хагарсан, эсвэл бусад гэмтэл авсан үед.
- SRS хажуугийн аюулгүйн дэр, SRS урд голын аюулгүйн дэртэй суудлын гадаргуу зурагдсан, хагарсан, эсвэл бусад гэмтэл авсан үед.
- Урд болон хажуу, хойд талын тулгуур багана, эсвэл SRS хөшигөн дэр бүхий дээврийн зах хэсэг хагарсан, зурагдсан, эсвэл гэмтсэн үед.

⚠ АЮУЛТАЙ

■ SRS аюулгүйн дэрний анхааруулга

SRS аюулгүйн дэртэй холбоотой дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Жолооч болон бүх зорчигч тус бүрийн аюулгүйн бүс зүүж хэрэглэнэ.

  SRS аюулгүйн дэр нь аюулгүйн бүстэй хамт ашиглагддаг нэмэлт төхөөрөмж юм.
- Жолоочийн SRS аюулгүйн дэр нь их хүчтэй дэлгэгддэг ба ялангуяа жолооч аюулгүйн дэрэнд хэт ойр үед амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй.

  Жолоочийн дэр дэлгэгдэх үед дэрнээс 50 - 75 мм (2 - 3 инч.) зай нь эрсдэлтэй бүсэд тооцогддог тул тус дэрнээс 250 мм (10 инч.)-с зайтай суух нь аюулгүй орчинг бүрдүүлнэ. Тус зай нь жолооны хүрдний төвөөс жолоочийн цээж хүртэлх зай юм. Хэрэв та хүрднээс 250 мм (10 инч.) хүртэлх зайд суудаг бол жолоо барих байрлалаа дараах аргаар өөрчилж болно:
  - Дөрөөнд чөлөөтэй хүрэх байдлаар өөрийн суудлаа боломжит хэмжээнд арагш гүйлгэнэ.

⚠ АЮУЛТАЙ

- Суудлыг бага зэрэг арагш налуулна. Жолоочийн суудал урагш тулсан үед ч ихэнхи жолооч суудлаа бага зэрэг арагш налуулах төдийд дэрнээс 250 мм (11 инч.) зай барих боломжтой. Суудлыг арагш налуулах нь замын харагдах байдалд сөргөөр нөлөөлж байвал хатуу, гулгадаггүй зөөлөвч ашиглан суудлаа өндөрлөх, суудлын өндрийн тохиргоотой автомашины суудлыг өндөр болгоно.
- Жолооны хүрдийг доош буулгана. Аюулгүйн дэр толгой, хүзүү рүү биш цээж рүү чиглэх болно. Суудлыг дээрх зөвлөмжийн дагуу дөрөө, жолооны хүрд, хянах самбарын удирдлагуудтай зөв харьцах боломжийг бүрдүүлэн тохируулна.

- Урд зорчигчийн SRS аюулгүйн дэр нь мөн адил их хүчтэй дэлгэгддэг ба ялангуяа зорчигч дэрэнд хэт ойр байгаа үед амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна. Тус суудлыг нь аюулгүйн дэрнээс боломжит хэмжээнд хол байх, зорчигч цэх суух байдлаар тохируулна.
- Дэлгэгдсэн аюулгүйн дэр суудалд, эсвэл хүүхдийн суудалд буруу суусан балчир, бага насны хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна. Бүх хүүхэд арын суудалд суулгах, суудлын болон хүүхдийн суудлын бүс зүүхийг Lexus хатуу санууулж байна. Арын суудал бага насны хүүхдэд урд суудлаас илүү аюулгүй.
- Суудлаа өнцөгдөж суух, эсвэл автомашины урд тал руу хэт шахаж сууж болохгүй.



- Бага насны хүүхдийг SRS урд зорчигчийн аюулгүйн дэрний урд зогсоох, урд зорчигчийн өвөр дээр суулгаж болохгүй.
- Жолооч, урд зорчигч өвөр дээрээ эд зүйл тавиж болохгүй.



⚠ АЮУЛТАЙ

- Хаалга, урд болон дээд хүрээ, хажуугийн болон хойд талын тулгуур багана налж болохгүй.



- Суудал дээр хаалга руу харан өвдөглөн суух, толгой ба гараа автомашинаас гаргаж болохгүй.



- Хянах самбар, хянах самбарын доод тал, урд хайрцаг, жолооны хүрдний төв хэсэгт эд зүйл байрлуулж, налуулж болохгүй.



- Хаалга, салхины шил, хаалганы шил, хажуу ба хойд тулгуур багана, хаалганы дээд хүрээ, бариуланд эд зүйл байрлуулж болохгүй.



- Хувцас өлгөх дэгээнд хувцасны өлгүүр болон бусад хатуу эд зүйл өлгөж болохгүй. Хөшигөн SRS аюулгүйн дэр дэлгэгдэх үед эдгээр нь шидэгдэж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй.
- Өвдөгний SRS аюулгүйн дэрний дэлгэгдэх хэсэгт пластик наалт байвал хуулж авна.
- Хажуугийн SRS аюулгүйн дэр, суудлын зөөлөвчний аюулгүйн дэр дэлгэгдэх хэсгийг хаах суудлын нэмэлт хэрэгсэл нь дэр дэлгэгдэхэд саад учруулах тул ашиглахыг хориглоно. Ийм нэмэлт хэрэгсэл нь аюулгүйн дэр зөв ажиллахад саад учруулах, системийг ажиллагаагүй болгох,

⚠ АЮУЛТАЙ

эсвэл аюулгүйн дэр гэнэт дэлгэгдэхэд хүргэж болзошгүй ба улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй.

- SRS аюулгүйн дэрний эд ангиудын ойр орчим, эсвэл урд хаалгыг цохих, эсвэл их хэмжээний хүчний нөлөөнд оруулж болохгүй. Энэ нь SRS аюулгүйн дэрний ажиллагаанд доголдол үүсгэж болзошгүй.
- SRS аюулгүйн дэр дэлгэгдсэн даруйд халсан байж болзошгүй тул дэрний аливаа эд ангид хүрч болохгүй.
- SRS аюулгүйн дэр дэлгэгдсэний дараа амьсгалахад хүндрэлтэй үед цонх, эсвэл хаалга онгойлгож цэвэр агаар оруулах, аюулгүй тохиолдолд автомашиныг орхин гарна. Дэр дэлгэгдэх үед цацагдсан тоосонцор арьсны харшил үүсгэхээс сэргийлж даруй угаана.
- SRS аюулгүйн дэр байрлах хэсгүүд гэмтсэн, эсвэл хагарсан үед Lexus-н албан ёсны дилерт хандаж солиулна.

■ SRS аюулгүйн дэрэнд өөрчлөлт хийх, устгалд оруулах

Lexus-н албан ёсны дилерт хандалгүйгээр автомашинаа устгалд оруулах, эсвэл дараах өөрчлөлтүүдийг хийж болохгүй.

SRS аюулгүйн дэрний ажиллагаанд доголдол үүсгэх, эсвэл гэнэт ажиллах (дэлгэгдэх) ба ноцтой гэмтэл, мөн үхэлд хүргэж болзошгүй.

- SRS аюулгүйн дэр суурилуулах, салгах, задлах болох засварлах
- Дараах эд анги болон ойр орчимд засвар хийх, солих, өөрчлөлт хийх
  - Жолооны хүрд
  - Хянах самбар
  - Удирдлагын самбар
  - Суудал
  - Суудлын бүрээс
  - Урд багана
  - Хажуу багана
  - Хойд багана
  - Дээд араам
  - Урд хаалганы хавтас
  - Урд хаалганы дотор хавтас
  - Урд хаалганы спикер
- Урд хаалганы хавтаст өөрчлөлт (нүх гаргах зэрэг) хийх
- Дараах эд анги болон ойр орчимд засвар хийх, солих, өөрчлөлт хийх
  - Урд крыло
  - Урд гупер

⚠ АЮУЛТАЙ

- Автомашины зорчигчийн хэсгийн хажуу тал

● Дараах эд анги, нэмэлт тоноглол угсрах
- Урд хамгаалалт (төмөр гупер г.м.)
- Цас түрэх хусуур
- Лебёдка

● Автомашины амортизаторын системийг өөрчлөх

● Радио станц болон CD тоглуулагч зэргийн электрон тоног төхөөрөмж суурилуулах

Холбоотой холбоосууд

Бензин насос таслах системийн ажиллагаа(X. 561)

Smart entry & start системээр хаалга түгжих, тайлах(X. 82)

Жолоодлогод туслах системүүд(X. 358)

Салоны гэрлийн байрлал(X. 284)

Ослын дохионы гэрэл ашиглан бусад жолооч нарт анхааруулга өгөх(X. 559)

Онцгой нөхцлийн үед туслах систем(X. 474)

Хүүхэд зорчих үед(X. 32)

7 Утасгүй холбоо харилцаа

7-1. Онцгой нөхцлийн үед туслах систем

eCall 474

eCall*,*1

eCall нь Global Navigation Satellite System (GNSS) ашигласан технологи бөгөөд дараах ослын дуудлага хийх боломж бүрдүүлдэг: Ослын автомат дуудлага (Automatic Collision Notification) болон Ослын дуудлага ([**SOS**] товч дарах). Тус үйлчилгээ нь АНЭУ-н техникийн шаардлагын дагуу суурилагддаг.

eCall системийн эд анги



A Микрофон/Спикер
B [**SOS**] товч*2
C Индикатор гэрэл

eCall ослын дуудлагын үйлчилгээ

■ Автомат ослын дуудлага

Аль нэг аюулгүйн дэр дэлгэгдсэн үед систем eCall удирдлагын төв рүү автоматаар дуудлага хийдэг. *3 Хүлээн авсан операторт автомашины байршил, осол үүссэн цаг хугацаа, автомашины арлын дугаар илгээгдэх ба оператор үүссэн нөхцөл байдлыг тодруулахаар холбогдоно. Хэрэв жолооч, зорчигч хариу өгөхгүй үед оператор автоматаар ослын дуудлага гэж үзэж хамгийн ойрын алба (112 дугаар зэрэг) руу нөхцөл байдлын мэдээллэж тусламж илгээх хүсэлт тавина.

■ Ослын дуудлага

Онцгой нөхцөл байдалд [**SOS**] товч дарж eCall удирдлагын төв рүү дуудлага хийнэ. *3 Хүлээн авсан оператор автомашины байрлал тодорхойлж нөхцөл байдлын үнэлгээ хийх ба шаардлагатай тусламж илгээнэ. [**SOS**] товч дарахын өмнө тагийг нээнэ.



* : Тоноглогдсон автомашинд

*1 : eCall-н хамрах хүрээнд ажиллана. Нийлүүлэгдсэн улсаас хамаарч системийн нэр өөр байна.

*2 : eCall системийн оператортой холбох товч. Өөр системийн бусад төрлийн SOS товч нь энэ төхөөрөмжинд хамаарахгүй ба eCall системийн оператортой холбогдох зориулалтгүй.

[**SOS**] товч санамсаргүй дарсан үед операторт тусламж шаардлагагүйг хэлнэ.

DCM LED гэрлэн индикатор

(Зөвхөн АНЭУ, Кувейт, Катар) Асаах товчийг ON-д шилжүүлэх үед улаан индикатор асаад унтарна. Үргэлжлээд ногоон индикатор асч DCM(Data Communication Module) сервис идэвхсэнийг илтгэнэ. Дараах индикаторууд нь системийн ажиллагааг заана:

- Дараах ногоон индикатор *4 : DCM үйлчилгээний идэвхтэй горим
- Ногоон индикатор анивчих *4 : Ослын дуудлага хийж байгаа
- Улаан индикатор асах: Системийн доголдол
- Индикатор асахгүй (off)*4 : DCM үйлчилгээний идэвхигүй горим

МЭДЭЭЛЭЛ

Нээлттэй эх үүсвэртэй программ хангамжийн мэдээлэл

Тус бүтээгдэхүүн нь DCM-д зориулсан нээлттэй эх үүсвэртэй программ хангамжтай.

Нээлттэй эх үүсвэртэй программ хангамжийн мэдээллийг дараах холбоосоос авах боломжтой.

https://opensource.lge.com/osSch/list?types=ALL&search=TL21BNU

⚠ АЮУЛТАЙ

Ослын дуудлага хийгдэхгүй нөхцлүүд

- Дараах нөхцлүүдэд ослын дуудлага хийх боломжгүй. Энэ нөхцөлд ойр байрлах нийтийн утас ашиглах зэрэг бусад аргаар онцгой үйлчилгээний албанд (999 дугаар зэрэг) мэдээлнэ.
  - Үүрэн холбооны сүлжээтэй газарт байсан ч шугам завгүй зэргээр eCall удирдлагын төв рүү холбогдоход хүндрэлтэй байж болно. Энэ нөхцөлд систем eCall удирдлагын төв рүү холбогдох оролдлого хийсэн ч та удирдлагын төв рүү ослын дуудлага хийх боомжгүй байж болно.
  - Үүрэн холбооны сүлжээгүй газарт ослын дуудлага хийх боломжгүй.
  - Аль нэг холбоотой төхөөрөмж ([**SOS**] товчны самбар, индикатор, микрофон, спикер, DCM, антенн, эсвэл төхөөрөмжийг холбох цахилгаан утаснууд зэрэг) доголдсон, гэмтсэн, эвдэрсэн үед ослын дуудлага хийх боломжгүй.
  - Ослын дуудлагын үед систем eCall удирдлагын төв рүү холбогдох оролдлого олон удаа хийдэг. Нөгөөтэйгүүр радио долгион, үүрэн

*3 : Зарим нөхцлүүдэд дуудлага хийх боломжгүй байж болно.

*4 : АНЭУ, Кувейт, Катар

⚠ АЮУЛТАЙ

холбооны сүлжээ сул үед систем eCall удирдлагын төвд холбогдож чадахгүй байж болно. Улаан индикатор 30 секунд асч холбогдож чадаагүйг илтгэнэ.

- Аккумуляторын хүчдэл буурсан, эсвэл салсан үед систем eCall удирдлагын төвд холбогдож чадахгүй.

■ Ослын дуудлагын системийг шинээр солисон үед

Ослын дуудлагын системийг бүртгүүлэх шаардлагатай. Та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ Таны аюулгүй байдлын төлөө

- Аюулгүй жолоодлого хийнэ. Тус системийн функц нь зам тээврийн осол, эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай үед ослын дуудлага хийхэд туслах зориулалттай ба жолооч, зорчигчийг аливаа хэлбэрээр хамгаалах боломжгүй. Цаг ямагт аюулгүйн бүс зүүж аюулгүй жолоодлого хийнэ.
- Онцгой нөхцөл байдлын үед өөрийн болон бусдын амь насыг нэгдүгээрт тавина.
- Шатаж буй зүйл, бусад хэвийн бус үнэр үнэртсэн үед автомашиныг орхиж аюулгүй газарт очино.
- Системийн хэвийн ажиллагааны үед аюулгүйн дэр дэлгэгдсэн нөхцөлд систем ослын дуудлага хийнэ. Систем аюулгүйн дэр дэлгэгдээгүй ч ард талаасаа мөргүүлэх, эсвэл хөмрөх үед систем ослын дуудлага хийнэ.
- Аюулгүй байдлын үүднээс жолоодлого хийнгээ ослын дуудлага хийж болохгүй. Жолоодлогын үед дуудлага хийх нь санамсар болгоомжгүй осолд хүргэх аюултай жолоогоо алдахад хүргэж болзошгүй. Ослын дуудлага хийхээс өмнө аюулгүй газарт зогсолт хийгээд орчны аюулгүй байдлыг нягтлаад дуудлага хийнэ.
- Гал хамгаалагч солих үед зөвхөн тохирох гал хамгаалагч ашиглана. Тохирохгүй гал хамгаалагч ашигласнаар хэлхээнд оч үсрэх, утаа гарч болзошгүй ба улмаар галын аюул хүргэнэ.
- Утаа, эсвэл хэвийн бус үнэр үнэртэж байгаа үед системийг ашиглах нь галын аюул үүсгэж болзошгүй. Нэн даруй системийг ашиглахаа зогсоож Lexus дилерт хандана уу.

⚠ АНХААР

■ Эвдрэл гэмтлээс сэргийлэх

[**SOS**] товчны самбар, спикер зэрэгт шингэн зүйл цацах, цохих гэмтээхээс сэргийлнэ.

⚠ АНХААР

■ **Ослын дуудлага, засварын үед [SOS] товчны самбар, спикер, микрофонд доголдол үүссэн үед**

Ослын дуудлага хийж болохгүй байж болзошгүй тул системийн статусыг шалгах, эсвэл eCall удирдлагын төвийн оператортой холбогдоно. Дээрх аль нэг эд анги гэмтсэн нөхцөлд Lexus дилерт хандаж шалгуулна уу.

8 Засвар үйлчилгээ, арчилгаа

8-1. Автомашины гадна талыг цэвэрлэх, хамгаалах

Автомашин угаах 480

8-2. Автомашины салоныг цэвэрлэх, хамгаалах

Автомашины дотор талыг цэвэрлэх 486

Никель, металл гадаргууг цэвэрлэх 488

Арьсан гадаргууг цэвэрлэх 489

Нийлэг арьсан бүрээс, доторлогоог цэвэрлэх 490

8-3. Засвар үйлчилгээ

Засвар үйлчилгээнд тавигдах шаардлага 491

Хуваарьт засвар үйлчилгээ 492

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээ..... 494

Хуваарьт засвар үйлчилгээ 495

8-4. Хэрэглээний материалыг үзэж шалгах

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээний анхааруулга 506

Капот нээх 509

Хөдөлгүүрийн хэсэг..... 510

Шил арчигчийн шингэн нэмэх..... 523

Салоны агаар шүүгчийн засвар үйлчилгээ..... 524

8-5. Дугуй засах

Дугуйн засвар үйлчилгээ . 526

Дугуйнд үзлэг хийхэд шаардагдах зүйлс 527

Ослын гүйлттэй дугуй..... 529

Дугуйн даралт анхааруулах системийн ажиллагаа 530

Дугуйны хийн даралт шалгах 542

Автомашиныг домкратаар өргөх 544

Дугуйны байрлал солих... 545

Обуд 546

Дугуй солих..... 548

Автомашин угаах

⚠ АЮУЛТАЙ

- Автомашин угаах үед хөдөлгүүрийн хэсэгт ус оруулж болохгүй.
  Ус цахилгаан эд ангиуд, төхөөрөмжинд хүрсэн үед галын аюултай.
- Хаягдал утаа янданг өндөр хэмд халаадаг.

⚠ АНХААР

■ **Их бие, эд ангиудын (обуд зэрэг) будагны чанар муудах, зэврэлтээс сэргийлэх.**

- Дараан нөхцөлд даруй автомашиныг угаана уу:
  - Далай тэнгисийн эргээр явсан
  - Давс цацсан замаар явсан
  - Будганд тортог, модны шүүс, давирхай зэрэг наалдсан үед
  - Будган дээр хорхой шавьж наалдсан, шувуу, хорхой шавьжны баас унасан үед
  - Уурхайн тоос, нунтаг төмөр, химийн бодис, хөө тортогтой болон тосорхог утааны бохирдолтой газраар явсны дараа
  - Тоос, шавар ихээр наалдсан үед
  - Бензин, бензол зэргийн шингэн бодис будган дээр асгарсан үед
- Хэрэв будаг зурагдсан, хортон суусан бол даруй засуулна.
- Дугуйн обудыг хадгалах үед обудны зэврэлтээс сэргийлж бүх шавар тоосыг цэвэрлэж чийгшилт багатай орчинд хадгална.

■ **Шил арчигчийг гэмтлээс сэргийлэх**

Салхины шилнээс шил арчигчийг өргөх үед эхлээд жолоочийн талын шил арчигчийг өргөнө. Буулгах үед эхлээд зорчигчийн талын шил арчигчийг буулгана.

Эд анги бүрт тохирсон арга болон материалаар цэвэрлэнэ.

- Дээрээс доош нь угаах ба автомашины их бие, шаврын хаалт болон доод талыг их хэмжээний усаар угааж тоос шаварнаас цэвэрлэнэ.
- Автомашины их биеийг зөөлөн пролон, эсвэл илгэн алчуур зэрэг зөөлөн алчууpаар угаана.
- Цэвэрлэхэд хүндрэлтэй толбо, бохирдлыг авто угаалгын саван ашиглан цэвэрлэх ба усаар сайтар зайлна.
- Үлдсэн усыг арчиж авна.

МЭДЭЭЛЭЛ

■ Өөрөө дахин сэргэдэг өнгөлгөө

Автомашины их бие нь автомашин угаалга зэргийн үед үүсч болох жижиг зураасыг өөрөө дахин сэргээдэг өнгөлгөөтэй.

- Өнгөлгөө нь үйлдвэрээс нийлүүлэгдсэнээс хойш 5-8 жил үргэлжилдэг.
- Зураасны гүн, гадна агаарын хэмээс хамаарч өнгөлгөөний өөрөө сэргэх хугацаа өөр байна.

  Халуун ус хүргэсэн үед өнгөлгөөний өөрөө сэргэх хугацаа богиносч болно.
- Түлхүүр, зоос зэргээр зурагдсан зураас буцаж сэргэхгүй байж болно.
- Үрэгчтэй вакс ашиглаж болохгүй.

■ Авто угаалга ашиглах үед

Электрон түлхүүр таних хүрээнд байгаа ба хаалганы бариул норсон үед хаалга түгжигдэх болон тайлагдаж болно. Энэ тохиолдолд автомашин угаах үед дараах арга хэмжээ авна:

- Электрон түлхүүрийг 2м (6 фут) зайд байрлуулах эсвэл автомашин угаалгын үед түлхүүрийг тусад нь байлгах зүйтэй.

  Түлхүүр хулгайд алдахаас сэргийлнэ.
- Электрон түлхүүрийг зайын цэнэг хэмнэх горимд тохируулж smart entry & start системийг цуцлана.

■ Тоормосны наклад ба хавчигч аппарат

Тоормосны наклад болон диск нойтон байдалтай автомашиныг зогсоолд байрлуулсан үед зэв үүсч наклад ба диск наалдаж болно. Автомашин угаасны дараа зогсоолд байрлуулахаас өмнө тодорхой зайнд жолоодож тоормос хэд хэдэн удаа ажиллуулна.

Автомат авто угаалга ашиглах үед

⚠ АНХААР

Бороо мэдрэгчтэй шил арчигчтай автомашин:

Автомат авто угаалга ашиглах үед шил арчигчийн хөшүүргийг off байрлалд унтраана.

Хөшүүрэг AUTO байрлалд байгаа үед шил арчигч ажиллаж эвдрэх аюултай.

- Автомашиныг угаалгахын өмнө:
  - Толь эвхэнэ.
  - Тээшний автомат хаалгатай автомашин:

    Тээшний автомат хаалгыг унтраана.

  Урд талаас нь эхэлж угаана.

Хөдөлгөөн эхлэхийн өмнө хураасан толийг дэлгэнэ.

- Автомат авто угаалгын сойз автомашины арьс, эд ангид (обуд г.м.) хортон суулгах, будганд гэмтэл учруулж болзошгүй.
- Арын спойлерыг зарим автомат угаалгын газарт угаах боломжгүй байдаг. Үүнээс гадна автомашинд гэмтэл учруулах эрсдэл нэмэгддэг.
- Арааны N байрлалд асаах товчийг ACC горимд шилжүүлэх үед X.170-г харна уу.

Өндөр даралтын авто угаалга ашиглах үед

⚠ АНХААР

- Автомашин угаах үед бүх камер, мөн тэдгээрийн ойр орчим руу шууд шүршиж болохгүй. Өндөр даралттай усны нөлөөгөөр камер доголдох аюултай.
- Даралтын хошууг жийрэг (резин, каучук материалаар хийгдсэн таг), холбох эд ангиуд болон дараах эд ангиудад ойртуулж болохгүй.

  Өндөр даралттай усны нөлөөгөөр эд ангиудад гэмтэл үүсч болно.

  - Хүч дамжуулах ангийн эд анги
  - Жолооны механизмын эд анги
  - Амортизатортой холбоотой эд анги
  - Тоормозны эд анги
- Шүршигч хошууг автомашины их биеэс 30 см (11.9 инч)-с зайтай барина. Эсрэг тохиолдолд резин эд анги, гупер гэмтэх, хэлбэр өөрчлөгдөх аюултай. Мөн хошууг нэг байрлалд удаан шүршихгүй.
- Салхины шилний доод тал руу удаан шүршиж болохгүй. Агааржуулалтын системийн сорох хоолой салхины шилний доод талд байрлах ба агааржуулалтын системийн хэвийн ажиллагаа алдагдах аюултай.
- Өндөр даралтын автомашин угаагчаар автомашины доод талыг угааж болохгүй.

Ус бүхээгт орж болох тул авто угаалгын шүршигч хошууг цонх, хаалганд хэт ойртуулах, эдгээр хэсгүүд рүү удаан шүршиж болохгүй.

Обуд болон обудны таг цэвэрлэх

Дараах үйлдлийг хийнэ:

- **Шавар, бохирдлыг саармаг цэвэрлэгээний бодисоор даруй цэвэрлэнэ.**
- **Цэвэрлэгээний бодис ашигласны дараа нэн даруй угааж арилгана.**

- **Будгийг гэмтлээс хамгаалах үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө.**
  - Хүчиллэг, шүлтлэг, эсвэл үрэгч бодис ашиглаж болохгүй
  - Хатуу сойз, зүлгүүр ашиглаж болохгүй
  - Цаг агаар халуун үед, эсвэл хол замд халсан зэрэг шалтгаанаар дугуй халсан үед цэвэрлэгээний бодис ашиглахыг хориглоно

Гупер цэвэрлэх

⚠ АЮУЛТАЙ

Хэрэв арын гуперны будаг зурагдсан, холцорсон үед дараах системүүдийн хэвийн ажиллагаа алдагдаж болно. Энэ нөхцөлд та өөрийн Lexus дилерт хандана уу.

- Lexus Safety System +
- BSM функц*
- ARFHL автомат арын ослын дохионы гэрэл
- Аюулгүйгээр буухад туслах систем (хаалга нээх удирдлагатай)*
- RCTA функц*
- PKSB систем*

Зүлгүүртэй, эсвэл үрэгч цэвэрлэгээний бодис ашиглаж болохгүй.

Завсар ховилуудыг цэвэрлэх, хамгаалах

Бохирдол арилахгүй үед дараах байдлаар цэвэрлэнэ:

- **5% хувийн агууламжтай саармаг цэвэрлэгээний бодисыг зөөлөн даавуунд уусган цэвэрлэх ба усаар бодисыг угаана.**
- **Үлдсэн чийгийг хуурай, зөөлөн даавуугаар арчина.**
- **Тосорхог давхарга тогтсон үед спиртийн агууламжтай нойтон салфетка, эсвэл ижил төрлийн бүтээгдэхүүн ашиглаж цэвэрлэнэ.**

МЭДЭЭЛЭЛ

■ Цонхны хар өнгийн зэвэрдэггүй ган хүрээ*

Цонхны хүрээ нь хар оксидоор бүрсэн зэвэрдэггүй гангаар хийгдсэн байдаг.

Автомашин цэвэрлэх үед цонхны хүрээ гэмтэх, өнгө өөрчлөгдөх тул үрэгч материал агуулсан цэвэрлэгчээр хүрээг үрж болохгүй.

*: Тоноглогдсон автомашинд



Гадна гэрлүүдийг цэвэрлэх

⚠ АНХААР

- Болгоомжтой угаана. Органик нэгдэл ашиглах, хатуу сойзоор зүлгэхийг хориглоно.

  Энэ нь гэрлийн гадаргууг гэмтээнэ.
- Гэрэл дээр вакс түрхэж болохгүй.

  Вакс нь гэрлийн линз гэмтээнэ.

Салхины шил цэвэрлэх

⚠ АЮУЛТАЙ

Бороо мэдрэгчтэй шил арчигчтай автомашин:

Шил арчигчийн хөшүүргийг унтраах байрлалд шилжүүлнэ.

Шил арчигчийн хөшүүрэг AUTO байрлалд байгаа үед дараах нөхцлүүдэд шил арчигч автоматаар ажиллаж шил арчигч гэмтэх, ажилласан шил арчигчид гараа хавчуулж бэртэж гэмтэх аюултай.



A Off
B AUTO

- Бороо мэдрэгч байрлах салхины шилний дээд хэсэгт гараар хүрсэн
- Бороо мэдрэгчийн ойролцоо нойтон алчуур, эсвэл төстэй зүйл ойртуулсан
- Салхины шилэн дээр аливаа зүйл унасан
- Бороо мэдрэгчинд шууд гар биеэрээ хүрсэн, эсвэл мэдрэгч рүү аливаа зүйл унасан

МЭДЭЭЛЭЛ

■ Урд хажуугийн цонхны ус тогтоодоггүй өнгөлгөө (ус тогтоодоггүй өнгөлгөөтэй автомашин)

● Ус тогтоодоггүй өнгөлгөөний эдэлгээний хугацааг дараах аргаар уртасгах боломжтой.

- Урд хажуугийн цонхноос аливаа тоос бохирдлыг байнга цэвэрлэнэ.
- Цонхон дээр тоос шороо хуримтлагдахаас сэргийлнэ.

  Цонх бохирдсон үед даруй зөөлөн, нойтон даавуугаар даруй арчина.
- Цонх цэвэрлэх үед үрэгчтэй вакс, эсвэл шил цэвэрлэгч ашиглаж болохгүй.
- Шилэнд тогтсон цанг арилгах үед металл эд зүйл ашиглаж болохгүй.

● Өнгөлгөөний ус тогтоохгүй чадвар буурсан үед өнгөлгөөг дахин хийлгэх боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу.

Автомашиныг ваксдах

Автомашины ус үл тогтоох гадаргуу муудсан үед ваксдана.

Автомашины цэвэрлэсэн гадаргуу дээр ус бөнжигөнөж тогтохгүй үед хөрсний дараа ваксдана.

Автомашины дотор талыг цэвэрлэх

⚠ АЮУЛТАЙ

■ **Бүхээгт ус ашиглах**

- Автомашины бүхээгт шингэн зүйл асгах, цацахыг хориглоно. Энэ нь цахилгааны эд ангиуд зэрэгт доголдол гарах, эсвэл гал түймэрт хүргэх аюултай.
- Бүхээг дэх SRS аюулгүйн дэрний аливаа эд анги, цахилгааны утсыг норгохыг хориглоно.

  Үүссэн цахилгааны доголдлоос аюулгүйн дэр дэлгэгдэх, эсвэл хэвийн ажиллагаа алдагдах, эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулах аюултай.

■ **Автомашины дотор талыг цэвэрлэх (ялангуяа хянах самбар)**

Хянах самбар дээр ваксан өнгөлгөө, эсвэл өнгөлөгч цэвэрлэгээний бодис ашиглаж болохгүй. Хянах самбар, автомашины бүхээгний урд хэсгээс гэрэл салхины шилэнд ойж жолоочид харагдах байдлыг алдагдуулах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

⚠ АНХААР

■ **Цэвэрлэгээний бодисууд**

- Дараах цэвэрлэгээний бодис нь салоны эд ангийн өнгийг алдагдуулах, будагтай гадаргууд хортон суулгах, гэмтэл учруулах аюултай тул ашиглаж болохгүй:
  - Суудлаас бусад хэсэгт: Бензол болон бензин зэргийн органик нэгдэл, хүчиллэг, шүлтлэг уусмал, цайруулагч болон өнгө оруулагч
  - Суудал: Шингэлэгч, бензол болон спиртийн төрлийн гэх мэт хүчиллэг, шүлтлэг уусмал
- Өнгөлгөөний вакс, бодис ашиглахыг хориглоно. Хянах самбар, салоны бусад хэсгийн будагтай гадаргууг гэмтээх аюултай.

■ **Шал усаар угаах**

Автомашины шалыг усаар угаахыг хориглоно.

Шалны дээд болон доод талд байрлах аудио системийн электрон төхөөрөмж зэрэгт ус хүрсэн үед электрон системд гэмтэл үүсэх аюултай. Мөн ус автомашины их биед зэврэлт үүсгэж болзошгүй.

■ **Салхины шилний дотор талыг цэвэрлэх үед**

Урд камерны линзэнд шил цэвэрлэгч хүргэж болохгүй. Мөн линзэнд гараар хүрэхийг хориглоно.

■ **Салхины шил болон хойд цонхны дотор талыг цэвэрлэх**

- Хойд шилний цан арилгагчийн халаагч болон антенн гэмтээх аюултай тул хойд цонхны шилийг шил цэвэрлэгч ашиглан цэвэрлэж болохгүй.

⚠ АНХААР

Бүлээн усаар норгосон даавуугаар зөөлөн арчиж цэвэрлэнэ. Шилийг халаагч, антенны дагуу арчиж цэвэрлэнэ.

- Халаагч, антенныг гэмтээх, зурахаас сэргийлнэ.

Салоныг цэвэрлэх үед тухайн эд анги, материал бүрт тохирсон цэвэрлээ хийнэ.

- **Тоос сорогчоор шороо тоосыг цэвэрлэнэ. Бүлээн усанд дүрж мушгисан алчууураар бохирдсон гадаргууг арчина.**
- **Алчууураар арчиж цэвэрлэх боломжгүй бохирдлыг саармаг цэвэрлэгээний бодисны 1 хувийн уусмал шингээсэн алчууураар арчина.**

  Алчууураа сайтар мушгиж салон дахь цэвэрлэгээний бодис, усны үлдэгдлийг гүйцэд арчиж авна.

МЭДЭЭЛЭЛ

■ Хивс угаалгын шингэнээр хивсэнцэр цэвэрлэх

Хивсэнцэр цэвэрлэх үед ус ашиглахгүй бөгөөд хивсэнцрийг аль болох хуурай байлгаснаар илүү өндөр үр дүнд хүрэх боломжтой.

Хивс угаалгын хөөсөрдөг шингэн байдаг бөгөөд пролон, сойз ашиглан тойрог хэлбэрээр зүлгэж угаана.

■ Аюулгүйн бүс цэвэрлэх

Даавуу, пролон ашиглан зөөлөн савантай бүлээн усаар цэвэрлэнэ. Мөн аюулгүйн бүс хэт элэгдсэн, үрэгдэж сэтэрсэн эсэхийг тогтмол шалгана.

Никель, металл гадаргууг цэвэрлэх

- **Бохирдлыг нойтон даавуу, эсвэл нийлэг илгэн алчууpаар арчиж цэвэрлэнэ.**
- **Гадаргууг хуурай зөөлөн даавуугаар арчиж үлдэгдэл чийгийг авна.**

МЭДЭЭЛЭЛ

Никель, металл гадаргууг цэвэрлэх

Никель, металл гадаргуу нь бодит металл ашигласан тул тогтмол цэвэрлэж байх шаардлагатай. Хэрэв бохирдсон гадаргууг удаан хугацаанд цэвэрлээгүй үед бүрэн цэвэрлэгдэхгүй болно.

Арьсан гадаргууг цэвэрлэх

⚠ АНХААР

Арьсан гадаргуу гэмтэх, муудахаас сэргийлж дараах анхааруулгыг мөрдөнө:

- Арьсан гадаргуугаас аливаа бохирдлыг даруй цэвэрлэнэ.
- Нарны гэрэл шууд тусах газарт удаан хугацаанд зогсоож болохгүй.

  Ялангуяа зуны улиралд сүүдэр газар зогсооно.
- Бүхээг халах үед арьсан гадаргууд наалдаж болох тул суудал дээр винил, хуванцар, эсвэл вакс агуулсан эд зүйл орхиж болохгүй.

- **Тоос сорогч ашиглан тоос, бохирдлыг цэвэрлэнэ.**
- **Үлдсэн тоос шороог цэвэрлэгээний бодисны уусмал шингээсэн алчуураар арчиж цэвэрлэнэ.**

  Бөс даавуунд зориулагдсан саармаг цэвэрлэгээний бодисны 5 орчим хувийн уусмал ашиглана.
- **Алчууraa сайтар мушгиж салон дахь цэвэрлэгээний бодис, усны үлдэгдлийг гүйцэд арчиж авна.**
- **Үлдсэн чийгийг хуурай, зөөлөн алчууraар арчиж авна. Арьсан гадаргууг нарны гэрлийн шууд тусгалгүй, агааржуулалттай газар хатаана.**

МЭДЭЭЛЭЛ

■ Арьсан бүрээс, доторлогоог арчлах талаар

Автомашины салоны чанарыг хэвээр хадгалахын тулд Lexus-н зүгээс салоныг жилд 2 ба түүнээс олон удаа цэвэрлэхийг зөвлөж байна.

Нийлэг арьсан бүрээс, доторлогоог цэвэрлэх

- **Тоос сорогч ашиглан тоос, бохирдлыг цэвэрлэнэ.**
- **Нийлэг арьстай хэсгийг саармаг цэвэрлэгээний бодисны 1 хувийн уусмал шингээсэн алчууraар арчина.**
- **Алчууraа сайтар мушгиж цэвэрлэгээний бодис, усны үлдэгдлийг гүйцэд арчиж авна.**

Засвар үйлчилгээнд тавигдах шаардлага

Аюулгүй бөгөөд эдийн засагт хэмнэлттэй байдлаар автомашиныг ашиглахын тулд өдөр тутмын арчилгаа болон засвар үйлчилгээ зайлшгүй шаардлагатай. Lexus нь дараах засвар үйлчилгээ хийхийг зөвлөж байна:

⚠ АЮУЛТАЙ

■ Автомашины засвар үйлчилгээг зөв хийгээгүй үед

Автомашины засвар үйлчилгээг зөв хийгээгүй тохиолдолд автомашиныг эвдрэл гэмтэлд хүргэх, мөн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

■ Аккумулятортой харьцах үед

Аккумуляторын шон, зажим болон бусад эд ангиуд нь хүний тархи гэмтээдэг хар тугалга болон хар тугалгын орцтой эд ангиудаас бүрддэг. Тиймээс аккумулятортой харьцсаны дараа гараа сайтар угаана.

Хуваарьт засвар үйлчилгээ

● Хуваарьт засвар үйлчилгээг хуваарийн дагуу тодорхой давтамжаар хийж гүйцэтгэх шаардлагатай.

Засвар үйлчилгээг хуваарьт заасан гүйлт, эсвэл заасан хугацаа аль түрүүлж болсноор тооцон хийж гүйцэтгэнэ.

Засвар үйлчилгээг хуваариас хойно хийсэн нөхцөлд дараагийн засвар үйлчилгээг өмнөх хуваарийн давтамжаар хийнэ.

● Хаана засвар үйлчилгээ хийлгэх боломжтой вэ?

Та тухайн орон нутгийн Lexus дилерт засвар үйлчилгээ, бусад оношилгоо хийлгэх нь зүйтэй.

Lexus-н засвар үйлчилгээний ажилтнууд нь засвар үйлчилгээний тогтмол мэдээлэл, засвар үйлчилгээний аргууд болон дилерийн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан сүүлийн үеийн засвар үйлчилгээний мэдээлэл хүлээн авдаг, сайтар бэлтгэгдсэн мэргэжилтнүүд юм. Lexus-н мэргэжилтнүүд нь автомашин дээр ажилланган сурах биш Lexus-н бүх загварууд дээр хэрхэн ажиллах талаар сурсныхаа дараа таны автомашин дээр ажилладаг. Таньд энэ нь зөв арга хэлбэр гэж бодогдохгүй байна уу?

Таны Lexus дилер нь их хэмжээний хөрөнгө оруулалт Lexus-н засварын багаж, тоног төхөөрөмжинд хийсэн болно. Энэ нь засвар үйлчилгээний ажлыг бага зардлаар үр дүнтэй хийх боломж олгодог.

Таны Lexus дилерийн засвар үйлчилгээний алба нь таны автомашины бүх хуваарьт засвар үйлчилгээг бага зардлаар найдвартай хийж гүйцэтгэнэ.

Хөргөлтийн болон халаагуурын систем, тоормос, шатахууны системийн резин хоолойг мэргэжлийн засвар үйлчилгээний ажилтан Lexus-н засвар үйлчилгээний хуваарийн дагуу шалгах шаардлагатай.

Резин хоолой нь засвар үйлчилгээ хийх чухал эд ангиуд болно. Резин хоолой муудсан, гэмтсэн үед даруй шинээр солиулна уу. Резин хоолой нь ашиглалтын хугацаанаас шалтгаалан муудах ба үүний үр дүнд хоолой хавагнах, элэгдэх, цууралт үүсдэг.

Хөдөлгүүрийн тос солих анхааруулгыг тэглэх (Хонгконг, Макаогоос бусад)

Хөдөлгүүрийн тос сольсны дараа хөдөлгүүрийн тосны мэдээллийг дахин тохируулах шаардлагатай. Дараах үйлдлийг хийж гүйцэтгэнэ:

1 **-г голын дэлгэц дээр сонгоно.**
2 **[Vehicle customise]-г сонгоно.**
3 **[Utility]-г сонгоно.**
4 **[Oil maintenance]-г сонгоно.**
5 **[Reset]-г сонгоно.**

"The data has been reset." мэдээлэл голын дэлгэц дээр үйлдэл дуусах үед гарна.

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээ

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээ гэж юу вэ?

Олон засвар үйлчилгээ нь авто засварын үндсэн багаж хэрэгсэл болон авто механикийн бага зэргийн мэдлэгтэй үед өөрөө хийх боломжтой байдаг.

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээг номын энэ хэсэгт ойлгомжтой тайлбарлаж байна. Нөгөөтэйгүүр зарим засвар үйлчилгээ нь тусгай багаж хэрэгсэл болон ур чадвар шаарддаг тул мэргэжлийн засварчнаар хийлгэх нь зүйтэй. Та өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээг хийж сурсан, дадсан байсан ч засварын түүхийг хадгалж үлддэг Lexus дилерт хандаж автомашины засвар үйлчилгээг хийлгэхийг таньд зөвлөж байна. Энэ засварын түүх нь үйлдвэрлэгчийн баталгаат хугацааны засвар үйлчилгээ хийлгэх үед таньд тустай мэдээлэл юм.

МЭДЭЭЛЭЛ

■ Таны автомашинд засвар үйлчилгээ шаардлагатай байна уу?

Засвар үйлчилгээ хийх шаардлагатай болсныг илтгэх хөдөлгүүрийн хэвийн бус дуу, бусад нүдэнд харагдах өөрчлөлтүүдийг анхаарч мэднэ. Зарим чухал шинж тэмдгүүд:

- Хөдөлгүүрийн галын тохиргоо алдагдах, цохио үүсэх
- Хөдөлгүүр хүчгүй болох
- Хөдөлгүүрийн хэвийн бус дуу чимээ
- Автомашин доор шингэн асгарсан байх

  Нөгөөтэйгүүр эйр кондишноос гоожиж байгаа нөхцөлд хэвийн.
- Яндангийн дуу өөрчлөгдөх

  Энэ нь хортой нүүрсхүчлийн хий алдагдаж байгааг илэрхийлэх тохиолдолд байдаг. Цонхоо нээсэн байдалтай хөдөлгөөнөө үргэлжлүүлж яндангаа нэн даруй үзүүлэх шаардлагатай.
- Дугуйны хий гарсан юм шиг харагдах, эргэлт хийх үед дугуй хэт их чяхарч дуугарах, дугуй тэгш бус элэгдэх
- Тэгш зам дээр шулуун явах үед автомашин нэг тал руугаа даялах
- Амортизатор ажиллах үеийн хэвийн бус дуу
- Тоормосны хүч алдагдах, тоормос болон консны дөрөө зөөлөн болох, дөрөө шаланд тултал гишгэгдэх, тоормослох үед автомашин нэг тал руугаа чирэх
- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм байнга халах

Хэрэв таны автомашинд дээрх шинж тэмдгүүд илэрч байгаа тохиолдолд нэн даруй өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа үзүүлнэ үү. Таны автомашинд тохиргоо, эсвэл засвар хийх шаардлагатай болсон байж болзошгүй.

Хуваарьт засвар үйлчилгээ

Хуваарьт засвар үйлчилгээ хийх хэрэгцээ шаардлага

Хуваарьт засвар үйлчилгээг дараах байдлаар хийнэ:

Автомашины засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. (→ Х.495-г харна уу.)

Таны автомашины ашиглалтын нөхцөл дараах аль нэг, эсвэл хэд хэдэн нөхцөлд хамаарах үед автомашины зарим нэг засвар үйлчилгээг илүү богино давтамжтай хийх шаардлагатай. (→ Х.501-г харна уу.)

А. Замын нөхцөл

1. Бартаатай, шавартай, эсвэл хайлсан цастай зам.
2. Тоос шороотой зам (Зам хатуу хучлагагүй, эсвэл хуурай үед шороо тоос их босдог).
3. Давс цацсан зам.

В. Жолоодлогын нөхцөл

1. Хүнд ачаатай (Жишээ нь: дээвэр дээрээ ачаа ачих г.м.).
2. Хасах агаарын хэмд 8 км (5 миль) хүртэлх богино зайд тогтмол явдаг. (хөдөлгүүрийн хэм хэвийн хэмд хүрэхгүй.)
3. Удаан нормалдах, эсвэл цагдаа, такси, хүргэлтийн үйлчилгээний гэх мэт байнгын ажиллагаатай автомашин.
4. Өндөр хурдаар (автомашины дээд хурдны 80% ба түүнээс дээш хувьтай дүйцэх хурд) 2-с дээш цаг явах.

Засвар үйлчилгээний хуваарь

Засварын агуулга:

I = Шалгах, засах, шаардлагатай үед солих

R = Солих эсвэл тослох

T = Зохих хүчээр чангалах

▶ ӨАБНУ-с бусад

ЗАСВАР ХИЙХ ДАВТАМЖ:	ОДОМЕТРИЙН ЗААЛТ									САР
(Одометрийн заалт эсвэл сарын аль нэг түрүүлж хүрсэн үед)	x1000 км	10	20	30	40	50	60	70	80	
	x1000 миль	6	12	18	24	30	36	42	48	
ХӨДӨЛГҮҮРИЙН ҮНДСЭН ЭД АНГИ										

ЗАСВАР ХИЙХ ДАВТАМЖ:			ОДОМЕТРИЙН ЗААЛТ								САР
(Одометрийн заалт эсвэл сарын аль нэг түрүүлж хүрсэн үед)			x1000 км	10	20	30	40	50	60	70	80	
			x1000 миль	6	12	18	24	30	36	42	48	
1	Духны ремень				I		I		I		I	24
2	Хөдөлгүүрийн тос	Хонгконг, Макаогоос бусад		Засвар үйлчилгээний сануулга гарч ирэх үед солино.(1)								
		Хонгконг, Макао		R	R	R	R	R	R	R	R	12
3	Хөдөлгүүрийн тосны шүүр	Хонгконг, Макаогоос бусад		Засвар үйлчилгээний сануулга гарч ирэх үед солино.(1)								
		Хонгконг, Макао		R	R	R	R	R	R	R	R	12
4	Хүйтэн, халуунаар үлээх систем(2)						I				I	24
5	Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэн (зөвхөн NX350: intercooler-н хөргөлтийн шингэн хамаарна)(3)						I				I	-
6	Яндангийн хоолой, бэхэлгээ				I		I		I		I	12
АСААХ СИСТЕМ												
7	Очлуур (свеча)	NX200/ NX250		100000 км (60000 миль) тутам солих								
		NX350							R			-
8	Аккумулятор			I	I	I	I	I	I	I	I	12
ШАТАХУУН БОЛОН ХАЯГДАЛ УТААНЫ ХЯНАЛТЫН СИСТЕМ												
9	Шатахууны шүүр(4)										R	96
10	Хавхлаганы механизм(5)(6)			Шатахууны саванд 10000 км (6000 миль) тутам инжектор цэвэрлэгч хийх								-
11	Шатахуун цацах систем(5)(7)			Шатахууны саванд 10000 км (6000 миль) тутам инжектор цэвэрлэгч хийх								-

ЗАСВАР ХИЙХ ДАВТАМЖ:		ОДОМЕТРИЙН ЗААЛТ									САР
(Одометрийн заалт эсвэл сарын аль нэг түрүүлж хүрсэн үед)		x1000 км	10	20	30	40	50	60	70	80	
		x1000 миль	6	12	18	24	30	36	42	48	
12	Агаар шүүгч			I		R		I		R	I: 24 R:48
13	Бакны таг, хоолой, холбоос, ууршилт хянах хавхлаг(2)					I				I	24
14	Нүүрсэн шүүр					I				I	24
ЯВАХ ЭД АНГИ БОЛОН ИХ БИЕ											
15	Тоормосны дөрөө, зогсоолын тоормос(8)		I	I	I	I	I	I	I	I	6
16	Тоормосны наклад, диск		I	I	I	I	I	I	I	I	6
17	Тоормосны шингэн		I	I	I	R	I	I	I	R	I: 6 R:24
18	Тоормосны трубка, шланг			I		I		I		I	12
19	Тоормосны хүчлүүрийн вакум насос(9)		200000 км (120000 миль) тутам шалгах								-
20	Жолооны хүрд, холбоос, аппарат			I		I		I		I	12
21	Хөтлөх голын гармошка резин			I		I		I		I	24
22	Өндгөн тулгуур, гармошка резин			I		I		I		I	12
23	Автомат хурдны хайрцагны шингэн (мөн урд дифференциал)					I				I	24
24	Хүч дамжуулах ангийн тос (зөвхөн AWD загвар)			I		R		I		R	I: 12 R: 48
25	Хойд дифференциалын тос (зөвхөн AWD загвар)			I		R		I		R	I: 12 R: 48
26	Кардан гол (зөвхөн AWD загвар)			T		T		T		T	12

ЗАСВАР ХИЙХ ДАВТАМЖ:		ОДОМЕТРИЙН ЗААЛТ								САР
(Одометрийн заалт эсвэл сарын аль нэг түрүүлж хүрсэн үед)		x1000 км	10	20	30	40	50	60	70	80	
		x1000 миль	6	12	18	24	30	36	42	48	
27	Урд ба хойд амортизатор			I		I		I		I	12
28	Дугуй ба хийн даралт		I	I	I	I	I	I	I	I	6
29	Гэрэл, дуут дохио, шил арчигч болон шингэн		I	I	I	I	I	I	I	I	6
30	Салоны агаар шүүгч		R	R	R	R	R	R	R	R	12

(1) Хөдөлгүүрийн тос болон тосны шүүрийг засварын сануулга гарахгүй байсан ч 12 сарын дараа, эсвэл 10000 км (6000 миль)-т солих. Энэ нь 10000 км (6000 миль) хүрээгүй байхад засвар үйлчилгээний анхааруулга гарахад хүргэж болно.

Шороо тоостой орчинд ашиглагддаг автомашины хөдөлгүүрийн тос болон тосны шүүрийг 5000 км (3000 миль) эсвэл 6 сар тутам засварын сануулга гарахаас өмнө солих.

(2) Эхний удаа 80000 км (48000 миль) эсвэл 48 сар, дараа нь 20000 км (12000 миль) эсвэл 12 сар тутамд шалгах.

(3) Эхний удаа 160000 км (100000 миль), дараа нь 80000 км (50000 миль) тутам солих.

(4) Шатахууны савны шүүр мөн хамаарна.

(5) Тоёотагийн оригинал, эсвэл дүйцэх чанартай инжектор цэвэрлэгч.

(6) NX250/NX350: Зөвхөн Филиппин, Малайз улс.

(7) NX250: Зөвхөн Коста Рика, Гватемал, Гондурас, Никарагуа, Панам, Боливи, Аруба, Перу, Монгол, Бруней, Макаод.

NX350: Зөвхөн Коста Рика, Гватемал, Никарагуа, Панам, Болив, Аруба, Перу, Ирак, Бахрейн, Катар, Кувейт, Арабын Нэгдсэн Эмират, Йемен, Саудын Араб, Оман, Монгол болон Бруней улсад.

(8) Зогсоолын тоормосны үзлэг шаардлагагүй.

(9) Вакум насосны ир, вакум насосны ирний тагийг шинээр солих ба хуучин насосны ир болон ирний тагийг дахин ашиглаж огт болохгүй.

▶ ӨАБНУ-д

ЗАСВАР ХИЙХ ДАВТАМЖ:	ОДОМЕТРИЙН ЗААЛТ							САР
(Одометрийн заалт эсвэл сарын аль нэг түрүүлж хүрсэн үед)	x1000 км	15	30	45	60	75	90	
	x1000 миль	9	18	27	36	45	54	
ХӨДӨЛГҮҮРИЙН ҮНДСЭН ЭД АНГИ								

ЗАСВАР ХИЙХ ДАВТАМЖ:		ОДОМЕТРИЙН ЗААЛТ							САР
(Одометрийн заалт эсвэл сарын аль нэг түрүүлж хүрсэн үед)		x1000 км	15	30	45	60	75	90	
		x1000 миль	9	18	27	36	45	54	
1	Духны ремень		I	I	I	I	I	I	12
2	Хөдөлгүүрийн тос		Засвар үйлчилгээний сануулга гарч ирэх үед солино.(1)						
3	Хөдөлгүүрийн тосны шүүр		Засвар үйлчилгээний сануулга гарч ирэх үед солино.(1)						
4	Хүйтэн, халуунаар үлээх систем			I		I		I	24
5	Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэн (зөвхөн NX350: intercooler-н хөргөлтийн шингэн хамаарна)(2)			I		I		I	-
6	Яндангийн хоолой, бэхэлгээ		I	I	I	I	I	I	12
АСААХ СИСТЕМ									
7	Очлуур (свеча)	NX250(3)						R	-
		NX350				R			-
8	Аккумулятор		I	I	I	I	I	I	12
ШАТАХУУН БОЛОН ХАЯГДАЛ УТААНЫ ХЯНАЛТЫН СИСТЕМ									
9	Шатахууны шүүр(4)						R		96
10	Агаар шүүгч		I	I	I	R	I	I	I: 24 R:48
11	Бакны таг, хоолой, холбоос, ууршилт хянах хавхлаг			I		I		I	24
12	Нүүрсэн шүүр				I			I	24
ЯВАХ ЭД АНГИ БОЛОН ИХ БИЕ									
13	Тоормосны дөрөө, зогсоолын тоормос(5)			I		I		I	24
14	Тоормосны наклад, диск		I	I	I	I	I	I	12
15	Тоормосны шингэн		I	R	I	R	I	R	I: 12 R:24

ЗАСВАР ХИЙХ ДАВТАМЖ:		ОДОМЕТРИЙН ЗААЛТ							САР
(Одометрийн заалт эсвэл сарын аль нэг түрүүлж хүрсэн үед)		x1000 км	15	30	45	60	75	90	
		x1000 миль	9	18	27	36	45	54	
16	Тоормосны трубка, шланг		I	I	I	I	I	I	12
17	Тоормосны хүчлүүрийн вакум насос(6)		200000 км (120000 миль) тутам шалгах						-
18	Жолооны хүрд, холбоос, аппарат		I	I	I	I	I	I	12
19	Кардан гол		T	T	T	T	T	T	6
20	Хөтлөх голын гармошка резин		I	I	I	I	I	I	24
21	Өндгөн тулгуур, гармошка резин		I	I	I	I	I	I	12
22	Автомат хурдны хайрцагны шингэн (мөн урд дифференциал)				I			I	36
23	Хүч дамжуулах ангийн тос		I	R	I	R	I	R	I: 12 R: 48
24	Хойд дифференциалын тос		I	R	I	R	I	R	I: 12 R: 48
25	Урд ба хойд амортизатор		I	I	I	I	I	I	12
26	Дугуй ба хийн даралт		I	I	I	I	I	I	12
27	Гэрэл, дуут дохио, шил арчигч болон шингэн		I	I	I	I	I	I	12
28	Салоны агаар шүүгч		R	R	R	R	R	R	12

(1) Хөдөлгүүрийн тос болон тосны шүүрийг засварын сануулга гарахгүй байсан ч өмнөх удаа тос солисноос 12 сарын дараа, эсвэл 15000 км (9000 миль)-т солих. Энэ нь 15000 км (9000 миль) яваагүй байсан ч засвар үйлчилгээний сануулга гаргахад хүргэж болно.

Шороо тоостой орчинд ашиглагддаг автомашины хөдөлгүүрийн тос болон тосны шүүрийг 7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам засварын сануулга гарахаас өмнө солих.

(2) Эхний удаа 160000 км (100000 миль), дараа нь 80000 км (50000 миль) тутам солих.

(3) 100000 км (60000 миль) тутам солих боломжтой.

(4) Шатахууны савны шүүр мөн хамаарна.

(5) Зогсоолын тоормосны үзлэг шаардлагагүй.

(6) Вакум насосны ир, вакум насосны ирний тагийг шинээр солих ба хуучин насосны ир болон ирний тагийг дахин ашиглаж огт болохгүй.

Засвар үйлчилгээний нэмэлт хуваарь

Ашиглалтын хүнд нөхцөлд илүү олон давтамжтай засвар үйлчилгээ хийх шаардлагатай засварын хуваарийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав. (Дэлгэрэнгүйг → Х.495-с харна уу.)

ӨАБНУ-с бусад:

А-1: Бартаатай, шавартай, хайлмаг цастай зам.	
Тоормосны наклад, диск шалгах(1)	5000 км (3000 миль), эсвэл 3 сар тутам
Тоормосны хоолой, шланг шалгах(1)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам
Өндгөн тулгуур, гармошка резин шалгах(1)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам
Хөтлөх голын гармошка резин шалгах(1)	10000 км (6000 миль), эсвэл 12 сар тутам
Кардан голын боолт чангалах (зөвхөн AWD загвар)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам
Жолооны хүрд, холбоос, аппарат шалгах(1)	5000 км (3000 миль), эсвэл 3 сар тутам
Урд хойд амортизатор шалгах(1)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам
Араам, их биеийн боолт гайк чангалах(2)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

(2) Суудлын бэхэлгээний боолт, урд хойд амортизаторын бэхэлгээний боолт.

Тоос шороо ихтэй зам (Хатуу хучилт багатай, эсвэл тоос их босдог зам)	
Хөдөлгүүрийн тос солих (Зөвхөн Хонгконг Макаод)	5000 км (3000 миль), эсвэл 6 сар тутам
Хөдөлгүүрийн тосны шүүр солих (Зөвхөн Хонгконг Макаод)	5000 км (3000 миль), эсвэл 6 сар тутам

Тоос шороо ихтэй зам (Хатуу хучилт багатай, эсвэл тоос их босдог зам)	
Агаар шүүгч шалгах(1) эсвэл солих	I: 2500 км (1500 миль), эсвэл 3 сар тутам R: 40000 км (24000 миль), эсвэл 48 сар тутам
Тоормосны наклад, диск шалгах(1)	5000 км (3000 миль), эсвэл 3 сар тутам
Кардан голын боолт чангалах (зөвхөн AWD загвар)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

A-3. Давс цацсан зам дээр ашиглах үед.	
Кардан голын боолт чангалах (зөвхөн AWD загвар)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам

B-1: Хүнд ачаатай (Жишээ нь: дээвэр дээрээ ачаа ачих г.м.)	
Хөдөлгүүрийн тос солих (Зөвхөн Хонгконг Макаод)	5000 км (3000 миль), эсвэл 6 сар тутам
Хөдөлгүүрийн тосны шүүр солих (Зөвхөн Хонгконг Макаод)	5000 км (3000 миль), эсвэл 6 сар тутам
Тоормосны наклад, диск шалгах(1)	5000 км (3000 миль), эсвэл 3 сар тутам
Автомат хурдны хайрцагны шингэн (мөн урд дифференциал) шалгах(1) эсвэл солих	I: 40000 км (24000 миль), эсвэл 24 сар тутам R: 80000 км (48000 миль), эсвэл 48 сар тутам
Хүч дамжуулах ангийн тос солих (AWD загвар)	20000 км (12000 миль), эсвэл 6 сар тутам
Хойд дифференциалын тос солих (зөвхөн AWD загвар)	20000 км (12000 миль), эсвэл 6 сар тутам
Кардан голын боолт чангалах (зөвхөн AWD загвар)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам
Урд хойд амортизатор шалгах(1)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам
Араам, их биеийн боолт гайк чангалах(2)	10000 км (6000 миль), эсвэл 6 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

(2) Суудлын бэхэлгээний боолт, урд хойд амортизаторын бэхэлгээний боолт.

B-2: 8 км (5 миль) хүртэлх богино зайд агаарын хасах хэмд олон дахин явдаг автомашин. (Хөдөлгүүрийн хэм хэвийн ажиллах хэмд хүрэхгүй.)	
Хөдөлгүүрийн тос солих (Зөвхөн Хонгконг Макаод)	5000 км (3000 миль), эсвэл 6 сар тутам
Хөдөлгүүрийн тосны шүүр солих (Зөвхөн Хонгконг Макаод)	5000 км (3000 миль), эсвэл 6 сар тутам

B-3: Удаан нормал хаазаар ажилладаг, эсвэл цагдаа, такси зэрэг мэргэжлийн/хувийн хэрэглээ, хүргэлтийн үйлчилгээний гэх мэт байнгын ажиллагаатай автомашин.	
Хөдөлгүүрийн тос солих (Зөвхөн Хонгконг Макаод)	5000 км (3000 миль), эсвэл 6 сар тутам
Хөдөлгүүрийн тосны шүүр солих (Зөвхөн Хонгконг Макаод)	5000 км (3000 миль), эсвэл 6 сар тутам
Тоормосны наклад, диск шалгах(1)	5000 км (3000 миль), эсвэл 3 сар тутам
Автомат хурдны хайрцагны шингэн (мөн урд дифференциал) шалгах(1) эсвэл солих	I: 40000 км (24000 миль), эсвэл 24 сар тутам R: 80000 км (48000 миль), эсвэл 48 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

B-4: Өндөр хурдаар (автомашины дээд хурдны 80% ба түүнээс дээш хувьтай дүйцэх хурд) 2-с дээш цаг явах.	
Автомат хурдны хайрцагны шингэн (мөн урд дифференциал) шалгах(1) эсвэл солих	I: 40000 км (24000 миль), эсвэл 24 сар тутам R: 80000 км (48000 миль), эсвэл 48 сар тутам
Хүч дамжуулах ангийн тос солих (AWD загвар)	20000 км (12000 миль), эсвэл 6 сар тутам
Хойд дифференциалын тос солих (зөвхөн AWD загвар)	20000 км (12000 миль), эсвэл 6 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

ӨАБНУ-д:

A-1: Бартаатай, шавартай, хайлмаг цастай зам.	
Тоормосны наклад, диск шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам
Тоормосны наклад, диск шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам
Өндгөн тулгуур, гармошка резин шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам
Хөтлөх голын гармошка резин шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 12 сар тутам
Кардан голын боолт чангалах	7500 км (4500 миль), эсвэл 3 сар тутам
Жолооны хүрд, холбоос, аппарат шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам
Урд хойд амортизатор шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам
Араам, их биеийн боолт гайк чангалах(2)	15000 км (9000 миль), эсвэл 12 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

(2) Суудлын бэхэлгээний боолт, урд хойд амортизаторын бэхэлгээний боолт.

A-2: Тоос шороо ихтэй зам (Хатуу хучилт багатай, эсвэл тоос их босдог зам)	
Агаар шүүгч шалгах(1) эсвэл солих	I: 7500 км (4500 миль), эсвэл 12 сар тутам R: 60000 км (36000 миль), эсвэл 48 сар тутам
Тоормосны наклад, диск шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам
Кардан голын боолт чангалах	7500 км (4500 миль), эсвэл 3 сар тутам
Салоны агаар шүүгч солих	7500 км (4500 миль), эсвэл 12 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

A-3. Давс цацсан зам дээр ашиглах үед.	
Кардан голын боолт чангалах	7500 км (4500 миль), эсвэл 3 сар тутам

B-1: Хүнд ачаатай (дээвэр дээрээ ачаа ачих г.м.)	
Тоормосны наклад, диск шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам
Автомат хурдны хайрцагны шингэн (мөн урд дифференциал) шалгах(1) эсвэл солих	I: 45000 км (27000 миль), эсвэл 36 сар тутам R: 90000 км (54000 миль), эсвэл 72 сар тутам
Кардан голын боолт чангалах	7500 км (4500 миль), эсвэл 3 сар тутам
Урд хойд амортизатор шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам
Араам, их биеийн боолт гайк чангалах(2)	15000 км (9000 миль), эсвэл 12 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

(2) Суудлын бэхэлгээний боолт, урд хойд амортизаторын бэхэлгээний боолт.

B-3: Удаан нормал хаазаар ажилладаг цагдаа, такси зэрэг мэргэжлийн/ хувийн хэрэглээ, хүргэлтийн гэх мэт байнгын ажиллагаатай автомашин.	
Тоормосны наклад, диск шалгах(1)	7500 км (4500 миль), эсвэл 6 сар тутам
Автомат хурдны хайрцагны шингэн (мөн урд дифференциал) шалгах(1) эсвэл солих	I: 45000 км (27000 миль), эсвэл 36 сар тутам R: 90000 км (54000 миль), эсвэл 72 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

B-4: Өндөр хурдаар (автомашины дээд хурдны 80% ба түүнээс дээш хувьтай дүйцэх хурд) 2-с дээш цаг явах.	
Автомат хурдны хайрцагны шингэн (мөн урд дифференциал) шалгах(1) эсвэл солих	I: 45000 км (27000 миль), эсвэл 36 сар тутам R: 90000 км (54000 миль), эсвэл 72 сар тутам

(1) Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээний анхааруулга

Та засвар үйлчилгээгээ бие даан хийх үед номын энэ хэсэгт заасан зааварчилгааны дарааллыг баримтлана.

⚠ АЮУЛТАЙ

Автомашины хөдөлгүүрийн хэсэгт гэнэт ажиллаж эхэлдэг, халдаг, мөн хүчдэл авч асдаг олон төрлийн механизм болон шингэнүүд байдаг. Дараах анхааруулгыг мөрдөнө.

■ Хөдөлгүүрийн хэсэгт засвар үйлчилгээ хийх үед

- Эргэж буй духны ремень, сэнсэнд гар, хувцас, түлхүүр багажаа ойртуулж болохгүй.
- Хөдөлгүүрийг унтраасны дараа хөдөлгүүр, радиатор, ажилласан хийн коллектор зэрэг нь халуун байдаг тул хүрч болохгүй. Мөн тос болон бусад шингэн халуун байх магадлалтай.
- Хөдөлгүүрийн хэсэгт цаас, даавуу зэргийн шатамхай материал орхиж болохгүй.
- Шатахуун болон аккумуляторын ойр орчимд тамхи татах, оч үсрүүлэх болон ил задгай гал гаргахыг хориглоно. Шатахуун болон аккумуляторын уур нь галын аюултай.
- Аккумулятортой харьцах үед туйлын анхаарал болгоомжтой байна. Аккумуляторт хортой, идэмхий хүхрийн хүчил агуулагддаг.
- Тоормосны шингэн нь таны гар, нүд, мөн автомашины будагтай хэсгийг гэмтээх аюултай тул анхаарал болгоомжтой харьцана. Тоормосны шингэн таны гарт хүрсэн, нүдэнд орсон үед тухайн хэсгийг цэвэр усаар даруй угаана. Эвгүй мэдрэмж төрсөн үед даруй эмчид хандана уу.

■ Хөргөлтийн сэнс, эсвэл радиаторын торны ойр орчимд ажиллах үед

Асаах товчийг унтраана.

Асаах товч ON горимд байгаа ба хэрэв агааржуулалтын систем асаалттай, эсвэл хөргөлтийн шингэний хэм өндөр үед сэнс автоматаар ажиллаж болно.

■ Аюулгүйн нүдний шил

Шингэн цацагдах, аливаа зүйл унах, үсрэх зэргээр нүдэнд орохоос сэргийлж аюулгүйн нүдний шил зүүнэ.

⚠ АНХААР

■ Агаар шүүгчийг салгаж авсан тохиолдолд

Агаар шүүгчгүй үед агаар дахь тоосноос шалтгаалж хөдөлгүүрийн хэт элэгдэл үүсэх магадлалтай.

⚠ АНХААР

■ Шингэний түвшин бага эсвэл их үед

Тоормосны наклад элэгдэх, эсвэл нөөцийн савны түвшин их үед тоормосны шингэний түвшин бага зэрэг доошлох нь хэвийн үзэгдэл юм.

Нөөцийн савны шингэн дундарч байнга дүүргэх шаардлагатай болох нь ноцтой эвдрэл гэмтэл үүссэнийг илэрхийлнэ.

Засвар үйлчилгээ

Засвар үйлчилгээ шаардагддаг эд анги болон шаардлагатай сэлбэг, багаж хэрэгсэл:

■ **Аккумуляторын нөхцөл байдал**

- Бүлээн ус
- Хүнсний сода
- Товуд
- Түлхүүр (шонгийн боолт тайлах, боох)
- Нэрмэл ус

■ **Хөдөлгүүр/intercooler-н хөргөлтийн шингэний түвшин**

- "Toyota Super Long Life Coolant", эсвэл түүнтэй дүйцэх өндөр чанарын, этилен гликол суурьтай, силикатгүй, амингүй, нитритгүй, борын хүчлийн давсгүй, удаан эдэлгээтэй холимог органик хүчлийн технологитой шингэн

  "Toyota Super Long Life Coolant" нь 50% хөргөлтийн шингэн болон 50% ионгүйжүүлсэн уснаас бүрддэг.
- Юүлүүр (зөвхөн хөргөлтийн шингэнд ашиглагдах)

■ **Хөдөлгүүрийн тосны түвшин**

- "Toyota Genuine Motor Oil", эсвэл түүнтэй дүйцэх
- Даавуу, эсвэл цаасан алчуур
- Юүлүүр (зөвхөн хөдөлгүүрийн тос нэмэхэд ашиглагдах)

■ **Гал хамгаалагч**

Хуучин гал хамгаалагчтай адил ампертай

■ **Гэрлийн ламп**

Хуучин ламптай адил дугаар, ваттай ламп

■ **NX350: Радиатор, эйр кондишн болон intercooler-н радиатор**

-

■ **NX200/NX250: Радиатор, эйр кондишны радиатор**

-

■ **Дугуйн хийн даралт**

- Дугуйн хийн даралт хэмжигч манометр
- Насос, компрессор

■ **Шил арчигчийн шингэн**

- Антифризийн (өвөл ашиглах үед) орцтой ус болон шил арчигчийн шингэн
- Юүлүүр (зөвхөн ус, шил арчигчийн шингэнд ашиглагдах)

Капот нээх

1 **Капот нээх хөшүүрэг татна.**

Капот бага зэрэг нээгдэнэ.



2 **Туслах хөшүүргийг дээш татаад капот өргөнө.**



МЭДЭЭЛЭЛ

Капот хаах

Бага зэрэг өндөр байрлалаас (20 см орчим) капот орхих үед хаагдана.

Капот гараар дарж хаах үед 2 талын түгжээ түгжигдэхгүй байж болно.

⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгөөн эхлэхийн өмнө

Капот гүйцэд хаагдаж түгжигдсэн эсэхийг шалгана.

Хэрэв капот бүрэн түгжигдээгүй тохиолдолд хөдөлгөөний үед капот онгойх аюултай.

Хөдөлгүүрийн хэсэг

Хөдөлгүүрийн хэсэг

▶ NX200/NX250



A Гал хамгаалагчийн хайрцаг→ X.648
B Хөдөлгүүрийн тос нэмэх таг→ X.514
C Хөдөлгүүрийн тосны шүүп→ X.512
D Аккумулятор → X.518
E Агаар шүүгч→ X.517
F Радиатор → X.517
G Цахилгаан хөргөлтийн сэнс
H Кондишны радиатор → X.517
I Шил арчигчийн шингэний сав→ X.523
J Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний нөөцийн сав→ X.515

▶ NX350



A Гал хамгаалагчийн хайрцаг→ X.648
B Хөдөлгүүрийн тос нэмэх таг→ X.514
C Аккумулятор → X.518
D Агаар шүүгч→ X.517
E Радиатор → X.517
F Цахилгаан хөргөлтийн сэнс
G Кондишны радиатор → X.517
H Хөдөлгүүрийн тосны шүүп→ X.512
I Intercooler-н радиатор → X.517
J Шил арчигчийн шингэний сав→ X.523
K Intercooler-н хөргөлтийн шингэний нөөцийн сав → X.515
L Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний нөөцийн сав→ X.515

Хөдөлгүүрийн тос шалгах, нэмэх

МЭДЭЭЛЭЛ

■ Хөдөлгүүрийн тосны хэрэглээ

Автомашины ашиглалтын үед тодорхой хэмжээний хөдөлгүүрийн тос хэрэглэгддэг. Дараах нөхцлүүдэд хөдөлгүүрийн тосны хэрэглээ нэмэгддэг тул илүү богино хугацаанд тос нэмэх шаардлагатай.

- Шинэ автомашин, эсвэл хөдөлгүүр шинээр солиж тависан зэргээр автомашины хөдөлгүүр шинэ үед
- Чанар муутай тос, эсвэл тухайн нөхцөлд үл тохирох зууралданги чанартай тос ашигласан үед
- Өндөр хурдтай, эсвэл ачаа ихтэй, эсвэл хурд тогтмол нэмж хасдаг нөхцөлд автомашин ашиглагдаж байгаа үед
- Автомашиныг удаан хугацаанд нормал хаастай орхидог, эсвэл байнга замын түгжрэлтэй замаар явдаг үед

⚠ АЮУЛТАЙ

- Арьсны гэмтэлд хүргэх аюултай тул хуучин тостой удаан хугацаанд, эсвэл тогтмол харьцахаас зайлсхийнэ. Бие, арьсанд наалдсан хөдөлгүүрийн тосыг саван, усаар сайтар угааж арилгана.
- Хуучин хөдөлгүүрийн тос, тосны шүүрийг зөвхөн зориулалтын газар, зохих журмын дагуу хаяна. Ахуйн хэрэглээний хогтой хамт хаях, бохир усны шугамд хийх, газарт асгахыг хатуу хориглоно. Хог хаягдлын дахин ашиглалт, устгалтай холбоотой мэдээллийг та өөрийн Lexus дилер, эсвэл засварын төвүүдээс тодруулна уу.
- Хуучин тосыг бага насны хүүхдийн гар хүрэхгүй газар тавина.

⚠ АНХААР

■ Хөдөлгүүрийн тос солих үед

Хөдөлгүүрийн тос солих үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Хөдөлгүүрийн тосыг автомашины эд анги дээр асгахаас сэргийлнэ.
- Хөдөлгүүр гэмтэх магадлалтай тул шаардлагатай хэмжээнээс илүү тос хийхийг хориглоно.
- Тос нэмэх тухай бүрт тосны шүүпийг шалгана.
- Хөдөлгүүрийн тос нэмэх таг гүйцэд таглагдсаныг нягтлана.

■ Хөдөлгүүрийн таган дээр тос асгарсан үед

Хөдөлгүүрийн таг гэмтэхээс сэргийлж саармаг цэвэрлэгээний бодисоор даруй тосыг цэвэрлэнэ. Тоормос цэвэрлэгч зэрэг органик уусгагч ашиглаж болохгүй.

Хөдөлгүүрийн тос солих

Хөдөлгүүрийн ажлын температурт хөдөлгүүр унтраасны дараа шүүп ашиглан тосны түвшинг шалгана.

⚠ АНХААР

Хөдөлгүүрийн ноцтой гэмтлээс сэргийлэн тосны түвшинг тогтмол шалгана.

1 **Автомашиныг тэгш газарт байрлуулна. Хөдөлгүүр халаасны дараа унтраах ба тос бүрэн доош буух хүртэл 5 орчим минут хүлээнэ.**

2 **Шүүпний үзүүрт алчуур баринга татаж гаргана.**

▶ NX200/NX250



▶ NX350



3 **Шүүпийг арчиж цэвэрлэнэ.**

4 **Шүүпийг гүйцэд буцааж хийнэ.**

5 **Шүүпний үзүүрт алчуур баринга татан гаргаж тосны түвшинг шалгана.**



A Бага
B Хэвийн
C Илүү

Автомашин болон хөдөлгүүрийн төрлөөс хамаарч шүүпний хэлбэр өөр байдаг.

6 **Шүүпийг арчаад буцааж хийнэ.**

Тосны төрөл шалгах болон шаардлагатай зүйлс бэлдэх

Тосны төрлийг шалгах ба тос нэмэхэд шаардлагатай зүйлсийг урьдчилан бэлдэнэ.

- Хөдөлгүүрийн тос солих
- Тосны хэмжээ (Бага → Дүүрэн)
  1.5 л (1.6 qt., 1.3 Imp.qt.)

● Бэлдэх зүйлс

Цэвэр юүлүүр

Холбоотой холбоосууд

Тосолгооны систем (NX350)(X. 660)

Тосолгооны систем (NX250)(X. 662)

Тосолгооны систем (NX200)(X. 664)

Хөдөлгүүрийн тос нэмэх

Хөдөлгүүрийн тосны түвшин бага түвшний ойролцоо, эсвэл түүнээс багассан үед адил маркийн хөдөлгүүрийн тос нэмнэ.

▶ NX250



▶ NX200



▶ NX350



1 **Хөдөлгүүрийн тос нэмэх тагийг цагийн зүүний эсрэг эргүүлж авна.**

2 **Шүүпийг шалгангаа тос бага багаар нэмнэ.**

3 **Хөдөлгүүрийн тос нэмэх тагийг цагийн зүүний дагуу эргүүлж таглана.**

Хөргөлтийн шингэн шалгах

Хөргөлтийн шингэний түвшин нь хөдөлгүүр хүйтэн үед шингэний нөөцийн савны [**FULL**] болон [**LOW**] шугамны хооронд байна.

■ **Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний нөөцийн сав**

▶ NX200/NX250



A Нөөцийн савны таг
B [**FULL**] шугам
C [**LOW**] шугам

▶ NX350



A Нөөцийн савны таг
B [**FULL**] шугам
C [**LOW**] шугам

Хэрэв шингэний түвшин [**LOW**] шугамаас бага үед [**FULL**] шугам хүртэл шингэн нэмнэ.

■ Intercooler-н хөргөлтийн шингэний нөөцийн сав (зөвхөн NX350)



A Нөөцийн савны таг

B [**FULL**] шугам

C [**LOW**] шугам

Хэрэв шингэний түвшин [**LOW**] шугамаас бага үед [**FULL**] шугам хүртэл шингэн нэмнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Хөргөлтийн шингэн сонгох

Зөвхөн "Toyota Super Long Life Coolant", эсвэл дүйцэх өндөр чанарын этилен гликол суурьтай, силикат, амины хүчил, нитрит, борын хүчил агуулаагүй хосолмол органик хөргөлтийн шингэн ашиглана.

"Toyota Super Long Life Coolant" нь 50% хөргөлтийн шингэн болон 50% ионгүйжүүлсэн уснаас бүрддэг. (Зөвшөөрөгдөх доод хэм: -35°C [-31°F])

Хөргөлтийн шингэний талаар дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу.

■ Богино хугацааны дараа хөргөлтийн шингэн багасаад байгаа үед

Радиатор, шланг, хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний нөөцийн савны таг, дренажийн хаалт, усны насосыг нүдээр харж шалгана.

Шингэн хаанаас гоожиж байгаа нь олдохгүй үед та өөрийн Lexus дилерт хандаж таг болон хөргөлтийн шингэний системийг шалгуулна уу.

⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгүүр халуун үед хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний нөөцийн савны таг, эсвэл intercooler-н хөргөлтийн шингэний нөөцийн савны таг (зөвхөн NX350) нээж болохгүй.

Хөргөлтийн системд даралт үүссэн байж болох ба энэ үед тагийг авахад хэт халуун хөргөлтийн шингэн цацагдаж түлэгдэл үүсгэх аюултай.

⚠ АНХААР

■ Хөргөлтийн шингэн нэмэх үед

Хөргөлтийн шингэн нь цэвэр ус эсвэл найруулаагүй цэвэр антифриз байж болохгүй. Ус болон антифризны зөв хувь хэмжээгээр найруулсан шингэн нь зэврэлтээс хамгаалахын зэрэгцээ зөв тосолгоог үзүүлэх, хөдөлгүүр хөргөх үйлчилгээтэй байна. Антифриз, хөргөлтийн шингэний үйлдвэрлэгчийн шошго, мэдээллийг уншина уу.

■ Хөргөлтийн шингэн асгасан үед

Будаг болон эд ангид учруулах гэмтлээс сэргийлж усаар угаана.

Радиатор, кондишны болон Intercooler-н радиатор шалгах*

Радиатор, кондишны болон Intercooler-н радиаторыг шалгаж аливаа гадны биетээс цэвэрлэнэ.

Эдгээрийн аль нэг нь хэт бохирдсон, эсвэл тухайн эд ангийг биечлэн шалгах боломжгүй үед та өөрийн Lexus дилерт хандаж шалгуулна уу.

⚠ АЮУЛТАЙ

■ **Хөдөлгүүр халуун үед**

Хөдөлгүүрийн радиатор, кондишны радиатор, эсвэл Intercooler-н радиатор халуун ба, хүрсэн тохиолдолд түлэгдэх зэрэг ноцтой гэмтэл учрах тул хүрч болохгүй.

■ **Хөргөлтийн цахилгаан сэнс ажиллаж байгаа үед**

Хөдөлгүүрийн хэсэгт хүрч болохгүй. Асаах товчны ON горимд хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм өндөр үед хөргөлтийн цахилгаан сэнс автоматаар ажиллаж болзошгүй. Хөргөлтийн цахилгаан сэнс, радиаторын торны ойр орчимд ажиллах үед асаах товч унтраана.

Агаар шүүгч шалгах(зөвхөн NX350)

Агаар шүүгчийг дараах дарааллаар шалгана:

1 **Агаар шүүгчийн гэрнээс хумсыг мултална.**



2 **Хавчаарыг салгана.**



* :Тоноглогдсон автомашинд

3 **Тагийг дээш өргөөд агаар шүүгчийг салгаж авна.**

Шүүрний гадна талыг шалгах ба хэт бохирдсон тохиолдолд солино. Зөвхөн шүүр дээр тоос тогтсон үед даралттай хийгээр үлээлгэж цэвэрлэнэ.



⚠ АЮУЛТАЙ

Агаар шүүгчийг даралттай хийгээр цэвэрлэх үед тоос амьсгалахаас сэргийлж амны хаалт зүүнэ.

4 **Шалгаж дууссаны дараа шүүр зөв угсрагдсан байгааг нягтлана. Хавчаарыг хийж агаар шүүгчийн гэрийн дээд талыг тагийг таглана.**



Аккумулятор

⚠ АЮУЛТАЙ

■ **Аккумуляторт агуулагддаг бодисууд**

Аккумуляторт хортой, идэмхий хүхрийн хүчил агуулагддаг ба шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай устөрөгч мөн ялгардаг. Амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй ноцтой хохирлоос сэргийлэхийн тулд аккумулятортой, эсвэл ойр орчимд ажиллах үед дараах анхааруулгыг мөрдөнө:

- Багаж түлхүүрээр аккумуляторын шонд хүрч оч гаргаж болохгүй.
- Аккумуляторын хажууд тамхи татах, ил гал гаргахыг хориглоно.
- Нүд, арьс болон хувцсанд хүргэхээс зайлсхийнэ.
- Электролитээр амьсгалах, уухыг хатуу хориглоно.
- Аккумуляторын ойр орчимд ажиллах үед хамгаалалтын нүдний шүл зүүж ашиглана.
- Аккумуляторт бага насны хүүхэд ойртуулж болохгүй.

■ **Аккумулятор цэнэглэхэд аюулгүй газар**

Аккумуляторыг ил задгай газар цэнэглэнэ. Гарааш, битүү өрөө тасалгаа зэргийн агааржуулалт муутай газар цэнэглэхийг хориглоно.

⚠ АЮУЛТАЙ

■ **Электролиттэй холбоотой арга хэмжээ**

- Электролит нүдэнд орсон үед цэвэр усаар нүдээ 15-с дээш минут угаах ба эмнэлгийн тусламж авна. Хамгийн ойрын эмнэлэг хүрэх замдаа боломжтой тохиолдолд даавуу, пролон норгож тавина.
- Электролит арьсанд хүрсэн үед хүрсэн хэсгийг сайтар угаана. Таньд өвдөлт, арьс түлэгдсэн мэдрэмж төрсөн үед даруй эмнэлгийн тусламж авна.
- Электролит хувцсанд хүрсэн үед хувцсанд нэвчиж таны арьсанд хүрэх аюултай. Даруй хувцсаа тайлах ба шаардлагатай үед дээр дурдсан арга хэмжээг авна.
- Электролит санамсар болгоомжгүй уусан үед их хэмжээний ус, эсвэл сүү ууна. Эмнэлгийн яаралтай тусламж даруй авна.

■ **Аккумуляторын шингэн багассан үед**

Аккумуляторын шингэн багассан үед ашиглаж болохгүй. Аккумулятор дэлбэрэх магадлалтай.

Аккумулятор шалгах

■ **Анхааруулах тэмдэг**

Аккумуляторын дээд талд байрлах тэмдгүүдийн утга:

-

  Тамхи татах, ил гал, оч гаргахыг хориглоно
-

  Нүдээ хамгаалах шаардлагатай
-

  Бага насны хүүхдийг ойртуулахыг хориглоно
-

  Аккумуляторын хүчил
-

  Ашиглалтын гарын авлага унших
-

  Тэсрэх аюултай хий

■ Аккумуляторын гадна тал

Шон зэврээгүй, холболт сулраагүй, зажимд цууралт, сулралт үүсээгүйг нягтлана.

▶ NX200/NX250



A Шон
B Аккумуляторын бэхэлгээ

▶ NX350



A Шон
B Аккумуляторын бэхэлгээ

Цэнэглэхийн өмнө

Аккумулятор цэнэглэгдэх үед шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай устөрөгч ялгардаг. Тиймээс цэнэглэх үед дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:

- Аккумуляторыг автомашинаас салгалгүй цэнэглэх үед газардуулгын утсыг салгана.
- Аккумулятор цэнэглэгчийн утсыг аккумулятортой холбох, салгах үед цэнэглэгчийг унтраах товчоор унтраасан байна.

⚠ АНХААР

Аккумулятор цэнэглэх үед хөдөлгүүр унтраастай байх ба бүх нэмэлт төхөөрөмжийг салгана.

Аккумулятор цэнэглэсэн, эсвэл дахин холбосны дараа

Хөдөлгүүр асахгүй байж болно. Дараах үйлдлээр системийг анхны тохиргоонд буцаана.

1 **Араар Р-д шилжүүлнэ.**
2 **Аль нэг хаалга нээгээд хаана.**
3 **Хөдөлгүүр асаана.**

МЭДЭЭЛЭЛ

- Аккумулятор дахин холбосон даруйд Smart entry & start системээр хаалганы түгжээ тайлагдахгүй байж болно. Энэ нөхцөлд түлхүүрийн алсын удирдлага, эсвэл механик түлхүүрээр хаалга түгжинэ/тайлна.
- Асаах товчны ACC горимоос хөдөлгүүр асаана. Асаах товч Off горимд унтраастай үед хөдөлгүүр асахгүй байж болно. Нөгөөтэйгүүр 2 дахь оролдлогоос хөдөлгүүр хэвийн асна.
- Асаах товчны горимыг автомашин санадаг. Аккумулятор салгаад дахин холбосон үед асаах товчны горим аккумулятор салгахаас өмнөх асаах товчны горимд буцна. Аккумулятор салгахаас өмнө асаах товч унтраана уу. Аккумулятор салгахаас өмнөх асаах товчны горим мэдэгдэхгүй үед аккумулятор буцаан холбохдоо өндөр анхаарал болгоомжтой холбоно.

  Хэрэв дээрх үйлдлээр асаах оролдлого олон удаа хийсэн ч асахгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Аккумуляторын шингэн шалгах

Шингэн [**UPPER LEVEL**] болон [**LOWER LEVEL**] хэмжээний хооронд байгаа эсэхийг шалгана.

▶ NX250



A [**UPPER LEVEL**] хэмжээ

B [**LOWER LEVEL**] хэмжээ

Хэрэв аккумуляторын шингэний түвшин [**LOWER LEVEL**] хэмжээний түвшинд байгаа, эсвэл түүнээс буурсан үед нэрмэл ус нэмнэ.

▶ NX350



A [**UPPER LEVEL**] хэмжээ

B [**LOWER LEVEL**] хэмжээ

Хэрэв аккумуляторын шингэний түвшин [**LOWER LEVEL**] хэмжээний түвшинд байгаа, эсвэл түүнээс буурсан үед нэрмэл ус нэмнэ.

▶ NX200



A Цэнхэр: Сайн

B Улаан: Цэнэглэх шаардлагатай.

Та автомашинаа өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

C Тунгалаг: Хэвийн ажиллахгүй байгаа.

Хэвийн ажиллахгүй байгаа. Нэрмэл ус нэмнэ.

Нэрмэл ус нэмэх

⚠ АНХААР

Нэрмэл ус нэмэх үед аккумулятороос халиж асгарахаас сэргийлнэ. Асгарсан аккумуляторын шингэн зэврэлт үүсгэнэ.

1 Агааржуулалтын тагийг авна.

2 Нэрмэл ус нэмнэ.

Аккумуляторын шингэний [**UPPER LEVEL**] зураас харагдахгүй үед аккумуляторын торыг нүдээр шууд харж шингэний түвшинг шалгана.



A Бага

B Хэвийн

3 Агааржуулалтын тагийг буцааж сайтар таглана.

Шил арчигчийн шингэн нэмэх

Шил арчигчийн шингэн цацагдахгүй, эсвэл мэдээллийн дэлгэц дээр **"Windshield Washer Fluid Low"** гарсан үед шил арчигчийн шингэн дууссан байж болзошгүй. Шил арчигчийн шингэн нэмнэ.

▶ NX200/NX250



▶ NX350



⚠ АЮУЛТАЙ

Хөдөлгүүр халуун, эсвэл асаалттай үед шил арчигчийн шингэн нэмж болохгүй.

Шил арчигчийн шингэн нь спирт агуулдаг тул хөдөлгүүр зэрэг дээр асгасан үед галын аюултай.

⚠ АНХААР

■ Шил арчигчийн шингэнээс өөр шингэн ашиглаж болохгүй

Шил арчигчийн шингэний оронд савантай ус, хөдөлгүүрийн антифриз ашиглаж болохгүй. Автомашины будагтай гадаргууг гэмтээхээс гадна насос эвдрэх, улмаар шил арчигчийн шингэн цацагдахгүй болгоно.

■ Шил арчигчийн шингэн шингэрүүлэх

Шаардлагатай үед усаар шил арчигчийн шингэн шингэрүүлнэ. Шил арчигчийн шингэний саван дахь хөлдөх температурын жагсаалтыг шалгана уу.

Салоны агаар шүүгчийн засвар үйлчилгээ

Агааржуулалтын системийн үр дүнтэй ажиллагааг хангах үүднээс салоны агаар шүүгчийг тогмтол солих шаардлагатай.

Шалгах давтамж

Салоны агаар шүүгчийг засвар үйлчилгээний хуваарийн дагуу шалгаж солино. Тоостой орчин, эсвэл замын хөдөлгөөний ачаалал ихтэй нөхцөлд илүү богино давтамжаар солих шаардлагатай.

- Агааржуулалтын хоолойноос үлээх агаарын хэмжээ огцом буурсан үед салоны агаар шүүгч бөглөрсөн байж болно. Агаар шүүгчийг шалгаад шаардлагатай үед солино.
- Автомашин дотор агаар цэвэршүүлэгч зэрэг ашигласан үед салоны агаар шүүгчийн үнэр дарах чадвар болон хугацаа огцом буурч болно. Агааржуулалтын системээс үнэр гарч байгаа нөхцөлд салоны агаар шүүгчийг солино уу.

Салоны агаар шүүгч солих

⚠ АНХААР

Агааржуулалтын систем ашиглах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

Салоны агаар шүүгч цаг ямагт угсарч ашиглана. Агаар шүүгчгүйгээр агааржуулалтын систем ашиглах нь системийг гэмтээх аюултай.

1 **Асаах товчийг унтраана.**

2 **Урд хайрцаг нээж тулгуурыг салгана.**



3 **Урд хайрцагны 2 талыг дотогш дараад дээд талаас 2 хумсыг салгана. Дараа нь хайрцгийг нааш татаж доод хумсыг салгаад хайрцгийг салгаж авна.**



4 Агаар шүүгчийн (A) тагны түгжээг тайлаад (B) хумснаас мултлаад тагийг салгана.

▶ Зүүн жолооны хүрдтэй автомашин



▶ Баруун жолооны хүрдтэй автомашин



5 Агаар шүүгчийн хайрцгийг салгана.



6 Хайрцгаас салоны агаар шүүгч гаргаад шинээр солино.

[⇧ **UP**] тэмдгийг дээш харуулан агаар шүүгч хийнэ.



Дугуйн засвар үйлчилгээ

Дугуйг засвар үйлчилгээний төлөвлөгөө болон хээний элэгдэлд тохируулан солих, эсвэл байрлалыг нь өөрчлөнө.

⚠ АНХААР

Сул хөрстэй болон донсолгоотой замаар өндөр анхаарал болгоомжтой жолоодно.

Замын эдгээр нөхцөл дугуйны хийн даралт суларч донсолгоо шингээх чадвар нь буурдаг. Үүнээс гадна бартаа, донсолгоотой замаар явах нь дугуй, обуд болон автомашины их биеийг гэмтээх аюултай.

Дугуйнд үзлэг хийхэд шаардагдах зүйлс

⚠ АЮУЛТАЙ

■ Дугуйнд үзлэг хийх, солих үед

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд хүч дамжуулах ангийг гэмтээх, эсвэл автомашины тогтвортой жолоодлого алдагдахад хүрнэ.

- Өөр үйлдвэрлэгч, загвар, хээтэй дугуйнуудыг ашиглаж болохгүй. Мөн хээний элэгдлийн хэмжээ нь хэт өөр дугуй холиж угсрахгүй.
- Үйлдвэрлэгчийн зааснаас өөр хэмжээтэй дугуй ашиглахгүй.
- Өөр бүтэц, хийцтэй (radial, bias-belted, bias-ply) дугуй ашиглахгүй.
- Зуны, бүх улирлын, өвлийн дугуй холиж ашиглахгүй.
- Өөр автомашинд ашиглагдаж байсан дугуй ашиглахгүй.

  Өмнөх ашиглалтын байдал нь тодорхойгүй дугуй ашиглахгүй.

⚠ АНХААР

Жолоодлогын үед хийн даралт суларсан нөхцөлд үргэлжлүүлэн жолоодож болохгүй. Дугуй болон обуд гэмтэх аюултай.

Дугуйн дээр элэгдлийн индикатор харагдаж байгааг нягтлана. Мөн дугуй нэг талаараа хэт элэгдэх зэрэг хэвийн бус элэгдлийг шалгана.

Дугуйн байрлал солих үед нөөц дугуйг оролцуулан солиогүй үед нөөц дугуй болон хийн даралтыг шалгана.



A Шинэ хээ

B Элэгдсэн хээ

C Элэгдлийн индикатор

Элэгдлийн индикатыг дугуйн бөөрөнд байрлах [**TWI**], эсвэл △ тэмдгээр заасан байдаг.

Элэгдлийн индикатор гарч ирсэн үед дугуйг солино.

МЭДЭЭЛЭЛ

■ **Дугуй солих шаардлагатай нөхцлүүд**

Дараах нөхцөлд дугуй солих шаардлагатай:

- Дугуйн элэгдлийн индикатор гарч ирсэн.
- Язралт, зүсэгдэлт, цууралт зэрэг дугуйны олс ил харагдах гэмтэл, эсвэл дугуйн дотоод гэмтлийг илэрхийлэх хаван үүссэн.
- Дугуйн даралт тогтмол сулрах, эсвэл дугуйн гэмтлийн хэмжээ, байршлаас хамаарч засах боломжгүй болон бусад хэлбэрээр дугуй гэмтсэн.

  Шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ **Дугуйн ашиглалтын хугацаа**

Үйлдвэрлэснээс хойш 6-с дээш жил болсон дугуйг бага ашигласан, огт ашиглаагүй, эсвэл ил гэмтэлгүй байсан ч мэргэжлийн засварчнаар шалгуулна.

■ **Өвлийн дугуйны хээний гүн 4 мм (0.16 in.)-с бага болсон үед**

Өвлийн дугуйгаар ашиглах үеийн дугуйны гүйцэтгэл алдагдана.

Ослын гүйлттэй дугуй

Ослын гүйлттэй дугуй угсарч ашиглаж байгаа нөхцөлд аль нэг дугуй хагарснаас хойш 80 км/ц (50 миль/ц) хүртэлх хурдаар 80 км (50 миль) хүртэлх зайд явах боломжтой. (Нөгөөтэйгүүр цаг агаар, жолоодлогын нөхцлөөс хамаарч 80 км/ц [50 миль/ц] хурдад хүрч чадахгүй байж болно.)

Ослын гүйлттэй дугуйг 80 км (50 миль) хүртэлх зайд шинээр солино. Мөн зассан дугуйг буцааж ашиглаж болохгүй.

Ослын гүйлттэй дугуй нь хажуу талдаа тэмдэгтэй байдаг.



МЭДЭЭЛЭЛ

■ Ослын гүйлттэй дугуйны анхааруулга

- Ослын гүйлттэй дугуй нь зөвхөн тус автомашин зориулагдсан болно. Өөр автомашин дээр тус дугуйг ашиглаж болохгүй.
- Ослын гүйлттэй болон энгийн дугуйг холиж ашиглаж болохгүй.
- Lexus-н оригинал бус обуд ашигласан нөхцөлд ослын гүйлттэй дугуйг техникийн бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломжгүй байж болно.

Дугуйн даралт анхааруулах системийн ажиллагаа

Анхааруулах хавхлаг болон дамжуулагч ашиглан ноцтой нөхцөл байдал үүсэхээс өмнө дугуйн даралт буурсныг мэдэрдэг дугуйн даралт анхааруулах систем таны автомашинд суурилагдсан болно.

Дугуйн даралт анхааруулах систем дараах 2 анхааруулгатай

▶ Мэдээллийн дэлгэц (HUD дэлгэцгүй автомашин)



▶ Мэдээллийн дэлгэц (HUD дэлгэцтэй автомашин)



▶ Голын дэлгэц



● Дэлгэц дээр **"Adjust Pressure"** гарах (Хэвийн анхааруулга)

Хий сулрах, агаарын хэм буурах зэрэг энгийн шалтгаанаар даралт багасах үед дугуйн даралт анхааруулах гэрэл асч дохио дуугарна.

● Дэлгэц дээр **"Immediately Check tyre when Safe"** гарах (Онцгой үеийн анхааруулга)

Дугуй хагарах зэрэг шалтгаанаар даралт багасах үед дугуйн даралт анхааруулах гэрэл асч дохио дуугарна.

Нөгөөтэйгүүр хийн даралт огцом буурах (дугуй задрах зэрэг) үед анхааруулга гарахгүй.

● Дугуйн даралт анхааруулах системийн хэмжсэн дугуйн даралтын хэмжээг голын дэлгэц дээр гаргах боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

■ Дугуйн даралт тогтмол шалгах

Дугуйн даралт анхааруулах систем нь дугуйн даралтыг тогтмол шалгах үүргийг гүйцэтгэдэггүй.

Та автомашины өдөр тутмын үзлэг, шалгалтын хүрээнд дугуйн даралтыг тогтмол шалгах шаардлагатай.

■ Дугуйн хийн даралт

● Асаах товчийг ON горимд дарснаас хойш тодорхой минутын дотор даралт дэлгэцээр гарахгүй байж болно.

Мөн хийн даралт тохируулснаас хойш тодорхой хугацаанд дэлгэц дэх даралтын хэмжээ өөрчлөгдөхгүй байж болно.

● Дугуйн даралт нь температур өөрчлөгдөх үед өөрчлөгдөнө. Мөн дэлгэцийн заалт дугуйн хийн даралт хэмжигчээр хэмжсэн хэмжээнээс өөр байж болно.

■ Дугуйн даралт анхааруулах систем хэвийн ажиллахгүй нөхцлүүд

● Дараах тохиолдлуудад системийн хэвийн ажиллагаа алдагдаж болно.

- Lexus-н оригинал обуд ашиглаагүй үед.
- OE (Original Equipment) биш дугуй солиж тависан үед.
- Хэмжээ нь тохирохгүй дугуй солиж тависан үед.
- Дугуйн гинж г.м. зүйлс дугуйнд угсарсан үед.
- Радио долгионд нөлөөлдөг цонхны хуулга наасан үед.
- Автомашин, ялангуяа автомашины дугуй болон шаврын хаалтны ойр орчимд их хэмжээний цас, мөс тогтсон үед.
- Дугуйн даралт тохирох хэмжээнээс хэт өндөр үед.
- Дугуйн хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчгүй дугуй ашиглаж байгаа үед.
- Дугуйн даралт анхааруулах компьютерт дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийн ID код бүртгэгдээгүй үед.

● Дараах нөхцлүүд системийн ажиллагаанд нөлөөлөх магадлалтай.

- Телевизийн цамхаг, цахилгаан станц, ШТС, радио станц, том оврын дэлгэц, нисэх буудал болон бусад хүчтэй радио долгион, соронзон орон үүсгэдэг газрын ойр орчимд.
- Зөөврийн радио, гар утас, утасгүй суурин холбооны утас болон бусад утасгүй харилцаа холбооны төхөөрөмж биедээ авч явах үед.

Радио долгионы нөхцөл байдлаас хамаарч дугуйны байрлалын мэдээлэл дэлгэцээр зөв гарахгүй үед жолоодлого болон радио долгионы нөхцөл өөрчлөгдөх үед дэлгэц дээр засагдаж болно.

- Автомашиныг зогсоолд байрлуулсан үед анхааруулга асах, эсвэл унтрах хүртэлх хугацаа уртасч болно.
- Дугуй задарсан зэргээр дугуйн даралт огцом унасан үед анхааруулах функц ажиллахгүй байх тохиолдол гардаг.

Холбоотой холбоосууд

Дугуйн даралт(Х. 341)

Дугуйн даралт анхааруулах гэрэл (дохио)(Х. 569)

Дугуйн даралт анхааруулах хавхлаг, дамжуулагч угсрах

⚠ АНХААР

■ Дугуй, обуд, дугуйн даралт анхааруулах хавхлаг, дамжуулагч болон хийлэх хошууны таг засах болон солих

- Обуд, дугуй, эсвэл дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч салгах, угсрах үед буруу ажиллагааны улмаас дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийг гэмтээх эрсдэлтэй тул та өөрийн Lexus дилерт хандана уу.
- Дугуйны хошуунд таг заавал хийнэ. Хошуунд таг хийгээгүй үед ус дугуйны даралт анхааруулах хавхлагт орж гэмтээх, улмаар хавхлаг гацах, хий алдах аюултай.
- Дугуйны хошуунд таг хийх үед гацдаг тул тохирохгүй таг хийж болохгүй.

Дугуй, эсвэл обуд солих үед дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийг зайлшгүй угсрана.

Шинэ дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч угсарсан үед шинэ ID кодыг дугуйн даралт анхааруулах компьютерт бүртгэх шаардлагатай.

МЭДЭЭЛЭЛ

■ **Дугуй болон обуд солих үед**

Дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийн ID код бүртгэгдээгүй үед дугуйн даралт анхааруулах систем хэвийн ажиллахгүй.

- Чили улсаас бусад:

  Энэ нөхцөлд 10 орчим минут жолоодсоны дараа дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчаад үргэлжлэн асч систем доголдсоныг илтгэнэ.

- Чили улсад:

  Энэ нөхцөлд 20 орчим минут жолоодсоны дараа дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчаад үргэлжлэн асч систем доголдсоныг илтгэнэ.

Дугуйн байрлал сольсны дараа дугуйн байрлалыг бүртгэх

Дугуйн байрлал сольсны дараа дугуй тус бүрийн байрлалыг бүртгэх шаардлагатай.

Дугуйн байрлал бүртгэх үйлдлийг ганцаараа хийх боломжтой. Дугуйн байрлалыг баруун зүүн эргэнгээ урагш яван бүртгэх боломжтой. Нөгөөтэйгүүр жолоодлогын байдал, орчноос хамаарч хугацаа шаардагдаж болно.

1. **Автомашиныг аюулгүй газар зогсоогоод асаах товчийг унтрааж 15-с дээш минут хүлээнэ.**
2. **Хөдөлгүүр асаана.**

   Автомашин явж байх үед дугуйн байрлал бүртгэх үйлдлийг хийх боломжгүй.
3. **Голын дэлгэц дээр ⚙ -г сонгоно.**
4. **[Vehicle customise]-г сонгоно.**
5. **[Tyre pressure]-г сонгоно.**
6. **[Tyre rotation]-г сонгоно.**
7. **[Continue]-г сонгоно.**

   Дугуйн байрлал солих үйлдэл хийгдэж буйг илэрхийлэх мэдээлэл мэдээллийн дэлгэц дээр гарна. **"---"** заалт бүх дугуйн хийн даралт дээр гарах ба дугуйн байрлал бүртгэх үйлдэл эхэлнэ.
8. **Шулуун чиглэлд (баруун зүүн эргэнгээ) 40 км/ц (25 миль/ц)-с дээш хурдаар 10-с 30 минут жолоодно.**

   Дугуйн байрлал бүртгэх үйлдэл дууссан үед мэдээллийн дэлгэц дээр үйлдэл дууссаныг илтгэх мэдээлэл гарна.

   40 км/ц (25 миль/ц)-с дээш хурдтай явах боломжгүй байсан ч удаан хугацаанд автомашин жолоодсоноор бүртгэх үйлдлийг амжилттай

хийх боломжтой. Нөгөөтэйгүүр хэрэв 1 цагаас илүү хугацаанд жолоодсон ч бүртгэл дуусахгүй үед автомашиныг аюулгүй газар зогсоон асаах товчны ON горимд 15-с дээш минут хүлээсний дараа үйлдлийг дахин хийнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Дугуйн байрлал бүртгэх үед

- Хэвийн үед дугуйн байрлал бүртгэх үйлдэл 30 минутын дотор дуусдаг.
- 40 км/ц (25 миль/ц)-с дээш хурдтай жолоодох үед дугуйн байрлал бүртгэгддэг.

■ Дугуйн байрлал бүртгэх үйлдэл

- Дугуйн байрлал бүртгэх үйлдэл дунд асаах товч унтраасан нөхцөлд дараагийн удаа асаах товч ON горимд асаахад бүртгэх үйлдэл үргэлжлэх ба дахин эхлүүлэх шаардлагагүй.
- Систем дугуй тус бүрийн байрлалыг тодорхойлох явцад дугуйн хийн даралтын заалт гарахгүй ба нөгөөтэйгүүр энэ хугацаанд дугуйны даралт суларсан нөхцөлд дугуйн даралт анхааруулах гэрэл асна.

■ Дугуйн байрлал хялбараар бүртгэгдэхгүй үед

- Дарааx нөхцлүүдэд дугуйн байрлал бүртгэхэд хугацаа шаардагдах, эсвэл бүртгэх боломжгүй байж болно.
  - Автомашины хурд 40 км/ц (25 миль/ц) хүрээгүй
  - Хатуу хучилттай замаар яваагүй
  - Хэрэв 1 цагаас илүү хугацаанд жолоодсон ч бүртгэл дуусахгүй үед автомашиныг аюулгүй газар зогсоон 15-с дээш минут хүлээсний дараа үйлдлийг дахин хийнэ.
- Дугуйн байрлал бүртгэх явцад ухрах үйлдэл хийсэн нөхцөлд тухайн мөч хүртэлх цуглуулсан мэдээллүүд устана. Үйлдлийг дахин эхлэнэ.

Хийн даралт тохируулах

Дарааx нөхцлүүдэд дугуйн даралт анхааруулах системийн хийн даралтын тохиргоо хийх шаардлагатай.

- Ачсан ачаа тээш зэргээс хамаарч дугуйн хийн даралт өөрчлөгдсөн үед.
- Дугуйн хэмжээ өөрчлөгдсөн зэргээр хийн даралт өөрчлөгдсөн үед.

Дугуйны хийн даралтыг тохирох түвшинд тохируулсны дараа голын дэлгэц дээр хийн даралтын тохиргоог сонгож хийнэ.

Автомашинд тохирох хэмжээтэйгээс өөр дугуй ашигласан зэргээр дугуйн хийн даралтын түвшин тохирох хэмжээнээс өөр болох үед одоогийн хийн даралтын хэмжээгээр даралтыг тохируулна. Систем дээр хийн даралтын тохиргоо хийхээс өмнө дугуй тус бүрийн даралтыг тохирох түвшинд тохируулна. Дугуйн даралт анхааруулах систем тухайн тохиргоо хийх үеийн даралтын хэмжээнд үндэслэн ажиллана.

Холбоотой холбоосууд

Дугуйн тохиромжтой хийн даралтыг системд сануулах(X. 535)

Одоогийн дугуйн хийн даралт ашиглан сануулах(X. 536)

Дугуйн тохиромжтой хийн даралтыг системд сануулах

1 **Хөдөлгүүр асаана.**

Автомашин явж байх үед дугуйн хийн даралтыг сануулах боломжгүй.

2 **Голын дэлгэц дээр ⚙ -г сонгоно.**

3 **[Vehicle customise]-г сонгоно.**

4 **[Tyre pressure]-г сонгоно.**

5 **[Set indicated air pressure]-г сонгоод тухайн сонгох урд болон хойд дугуйн хийн даралтыг сонгоно.**

6 **[OK]-г сонгоно.**

Дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа удаанаар анивчина.

Үйлдэл дууссаны дараа мэдээллийн дэлгэц дээр үйлдэл дууссаныг илтгэх мэдээлэл гарна.



МЭДЭЭЛЭЛ

■ Дугуйн хийн даралтыг сануулахад хүндрэлтэй үед

- Дугуйн хийн даралт сануулах үйлдэл хийж эхлэх үед дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа анивчихгүй бол үйлдэл эхлэхгүй. Үйлдлийг дахин эхнээс нь хийнэ.
- Дээрх үйлдлийг хийсэн ч дугуйн хийн даралт сануулах үйлдэл амжилтгүй болсон нөхцөлд та өөрийн Lexus дилерт хандана уу.

Одоогийн дугуйн хийн даралт ашиглан сануулах

⚠ АЮУЛТАЙ

Дугуйн даралт сануулахаас өмнө бүх дугуйны хийг зохих түвшинд тохируулна. Эсрэг тохиолдолд хийн даралт буурсан анхааруулах гэрэл асахгүй байх, эсвэл хийн даралт хэвийн үед гэрэл асч болно.

МЭДЭЭЛЭЛ

■ Дугуйн даралт анхааруулах системийн анхааруулах үйлдэл

- Одоогийн хийн даралт ашиглан дугуйн хийн даралт сануулах үед тухайн сануулах үйлдэл хийсэн нөхцлөөс хамаарч анхааруулга өгөх хугацаа өөр байж болно. Тиймээс хийн даралт бага зэрэг буурсан үед анхааруулга өгөх, эсвэл сануулах үеийн хэмжээнээс хийн даралт нэмэгдэж болно.
- Дугуйн хийн даралтыг тохируулсны дараа сануулах үйлдлийг хийнэ. Мөн дугуйн хийн даралт тохируулах, сануулах үед дугуй хүйтэн байх шаардлагатай.

1. **Дугуй тус бүрийн хийн даралтыг зохих түвшинд тохируулна.**

   Дугуй хүйтэн үед хийн даралтыг тохируулна.

2. **Хөдөлгүүр асаана.**

   Автомашин явж байх үед хийн даралтыг сануулах боломжгүй.

3. **Голын дэлгэц дээр ⚙ -г сонгоно.**
4. **[Vehicle customise]-г сонгоно.**
5. **[Tyre pressure]-г сонгоно.**
6. **[Set current air pressure]-г сонгоно.**
7. **[Continue]-г сонгоно.**

   Дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа удаан анивчих ба мэдээллийн дэлгэц дээр дугуйн хийн даралт сануулж буйг илтгэх мэдээлэл гарна.

   Дугуйн хийн даралт сануулах үйлдэл дууссаны дараа мэдээллийн дэлгэц дээр үйлдэл дууссаныг илтгэх мэдээлэл гарна.



МЭДЭЭЛЭЛ

■ **Дугуйн хийн даралт сануулах дараалал**

- Дугуйн хийн даралт сануулах үйлдлийн дунд хөдөлгүүр унтраасан нөхцөлд дараагийн удаа асаах товчийг ON горимд шилжүүлэх үед үйлдэл дахин эхлэх тул дахин эхлүүлэх шаардлагагүй.
- Шаардлагагүй үед дугуйн хийн даралт сануулах үйлдлийг эхлүүлсэн нөхцөлд дугуй хүйтэн үед хийн даралтыг зохих түвшинд тохируулаад хийн даралтыг сануулах, эсвэл одоогийн дугуйн хийн даралтаар хийн даралт сануулах үйлдлийг хийнэ.

■ **Дугуйн хийн даралт сануулах нь хүндрэлтэй үед**

- Хэвийн үед дугуйн хийн даралт сануулах үйлдэл 2-3 минутанд дуусдаг.
- Дугуйн хийн даралт сануулах үйлдэл эхлэх үед дугуйн хийн даралт анхааруулах гэрэл 3 удаа анивчихгүй байх нь үйлдэл эхлээгүйг илтгэнэ. Үйлдлийг эхнээс нь дахин хийнэ үү.
- Дээрх үйлдлийг хийсэн ч дугуйн хийн даралтыг сануулах боломжгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

ID код бүртгэх

Дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч нь дахин давтагдахгүй ID кодтой байдаг. Шинэ хавхлаг болон дамжуулагч ашиглах үед автомашины компьютерт ID код бүртгэх шаардлагатай.

МЭДЭЭЛЭЛ

- ID кодыг та өөрөө бүртгэх боломжтой ба жолоодлогын орчин нөхцлөөс хамаарч үйлдэл дуусах хүртэл хугацаа шаардагдаж болно.
- Бүх ID кодыг өмнө нь бүртгэсэн дугуйны иж бүрдэл угсрах үед дугуйны иж бүрдлийг солих үйлдэл хурдан хийгдэнэ.

ID код бүртгэхийн өмнө автомашины ойр орчимд дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчтай өөр бусад байхгүй байгааг нягтлана.

1 **Автомашиныг аюулгүй газар зогсоогоод асаах товчийг унтрааж 15-с дээш минут хүлээнэ.**

2 **Хөдөлгүүр асаана.**

Автомашин явж байгаа үед ID код бүртгэл хийх боломжгүй.

3 **Голын дэлгэц дээр ⚙ -г сонгоно.**

4 **[Vehicle customise]-г сонгоно.**

5 **[Tyre pressure]-г сонгоно.**

6 Тухайн сонгосон дугуйны иж бүрдэл ([Set 1], эсвэл [Set 2]) дэлгэц дээр гарсныг нягтлана.



ID код нь тухайн дэлгэцээр гарч буй дугуйны иж бүрдэлд бүртгэгдэнэ.

Тухайн бүртгэх дугуйны иж бүрдэл солих үед дэлгэцээр гарах дугуйн иж бүрдлийг дэлгэцээр гаргаад тухайн бүртгэх иж бүрдлийг сонгоно.

Хэрэв тухайн дугуйн иж бүрдэлд ID код өмнө нь бүртгэгдсэн үед дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа удаан анивчих ба өөрчлөлт хийх гэж байгааг анхааруулсан мэдээлэл мэдээллийн дэлгэц дээр гарна.

7 [New tyre registration]-г сонгоно.

8 [Continue]-г сонгоно.



Дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа удаан анивчих ба мэдээллийн дэлгэц дээр ID код бүртгэх үйлдэл хийгдэж байгааг илтгэх мэдээлэл гарна. Дугуйны иж бүрдэл солих үйлдэл цуцлагдаж код бүртгэх үйлдэл эхэлнэ.

Бүртгэх үйлдэл хийгдэх үед дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчсаны дараа асах ба мэдээллийн дэлгэцний дугуй тус бүрийн даралт **"---"** тэмдгээр заагдана.

МЭДЭЭЛЭЛ

ID код бүртгэх үйлдэл эхлэх дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа анивчаагүй үед үйлдэл эхлэхгүй. Үйлдлийг дахин эхнээс эхлэнэ үү.

9 Шулуун чиглэлд (тогтмол баруун зүүн эргэнгээ) 10-с 30 минутын хугацаанд 40 км/ц (25 mph) ба түүнээс дээш хурдаар жолоодно.

Бүртгэл дууссан үед дугуйн даралт анхааруулах гэрэл унтарч бүртгэл дууссаныг илтгэх мэдээлэл мэдээллийн дэлгэц дээр гарна.

40 км/ц (25 mph)-с дээш хурдыг бариж чадаагүй үед бүртгэл хэвийн үеэс удаж болно. 1 цаг өнгөрсөн ч бүртгэл дуусахгүй үед та үйлдлийг дахин эхнээс нь эхлэнэ үү.

МЭДЭЭЛЭЛ

■ **ID код бүртгэх үед**

- Хэвийн үед дугуйн байрлалын бүртгэл 30 минутын дотор дуусдаг.
- ID код бүртгэл нь 40 км/ц (25 mph)-с дээш хурдтай явах үед хийгддэг.

■ **ID код бүртгэхэд хүндрэлтэй үед**

- Дараах нөхцөлд ID кодны бүртгэл хэвийн үеэс удах, эсвэл бүртгэл хийх боломжгүй байж болно.
  - Хөдөлгөөн эхлэхээс өмнө автомашиныг 15-с дээш минутын хугацаанд зогсоосон
  - Автомашиныг 40 км/ц (25 mph)-с дээш хурдаар жолоодоогүй
  - Автомашиныг хатуу хучилтгүй, шороон замаар жолоодсон
  - Автомашин бусад автомашинтай ойролцоо явж байгаа таны болон бусад автомашины дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийг систем ялгаж чадахгүй байгаа
  - Дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч суурилагдсан дугуй автомашины дотор, эсвэл ойр орчимд байгаа
- Бүртгэх үйлдлийн явцад ухрах үйлдэл хийсэн нөхцөлд тухайн мөч хүртэл цуглуулагдсан дата устана. Автомашины дахин жолоодно.
- 1 цагаас удаан жолоодсон ч ID код бүртгэл дуусахгүй үед үйлдлийг дахин эхлэнэ.
- Дээрх үйлдлийг хийсэн ч ID бүртгэгдэхгүй үед та өөрийн Lexus диллерт хандана уу.

10 Тухайн дугуйн иж бүрдлийн дугуйн даралт өмнөх дугуйн иж бүрдлээс өөр үед дугуйн даралт анхааруулах системийн тохиргоог дахин хийх шаардлагатай.

Дугуйн иж бүрдлүүдийн хийн даралтын тохиргоо адил үед дээрх үйлдлийг хийх шаардлагагүй.

Холбоотой холбоосууд

Хийн даралт тохируулах(X. 534)

ID бүртгэлийг цуцлах

Үйлдэл эхлэсний дараа ID код бүртгэл цуцлах үед [**New tyre registration**]-г голын дэлгэц дээр дахин сонгоно.

ID код бүртгэл цуцлагдсан үед дугуйн даралт анхааруулах гэрэл унтарна.

Дугуйн даралт анхааруулах гэрэл унтрахгүй үед ID код бүртгэл зөв цуцлагдаагүй байж болно. Бүртгэлийг цуцлах үед [**New tyre registration**]-г голын дэлгэц дээр дахин сонгоно.

Дугуйны иж бүрдэл сонгох

Таны автомашины дугуйн хийн даралт анхааруулах систем нь өвлийн ба зуны дугуйн иж бүрдэл зэрэг 2 өөр иж бүрдэл дугуйн ID код бүртгэх боломжтой.

- Тус функц нь зөвхөн 2 дахь дугуйн иж бүрдлийг бүртгүүлсэн үед ажиллана. 2 дахь дугуйн иж бүрдэл бүртгүүлээгүй үед **"Set 2(Unregistered)"** дэлгэц дээр 2 дахь иж бүрдлийн сонголт идэвхжихгүй.

  ID кодыг та өөрөө бүртгэх боломжтой.
- Зөвхөн иж бүрдэл хооронд солих боломжтой ба иж бүрдлүүдийн дугуйг холисон үед функц ажиллахгүй.
- ID код бүртгэх явцад дугуйны иж бүрдэл хооронд солих боломжгүй. Дугуйны иж бүрдэл солихын өмнө бүртгэх үйлдлийг цуцлана.

1 Тухайн ашиглах дугуйн иж бүрдлийг угсарна.

2 Голын дэлгэц дээр ⚙ сонгоно.

3 [Vehicle customise]-г сонгоно.

4 [Tyre pressure]-г сонгоно.

5 Тохиргоо сонгох дэлгэцнээс ([Set 1], эсвэл [Set 2])-г сонгоно.

6 Тухайн бүртгэх дугуйны иж бүрдлийг сонгоод [OK]-г дарна.

Дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа удаан анивчих ба иж бүрдэл солиж буйг илтгэх мэдээлэл гарч иж бүрдэл солих үйлдэл эхлэнэ.

Дугуйны иж бүрдэл солих үйлдэл эхлэх үед дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчаад асна. Мөн солих үйлдэл хийгдэх үед мэдээллийн дэлгэц дэх дугуй тус бүрийн даралтын хэмжээ **"---"** болно.



2 орчим минутын дараа дугуйны иж бүрдэл солих үйлдэл дуусах ба дугуйн даралт анхааруулах гэрэл унтарч мэдээллийн дэлгэц дээр үйлдэл дууссаныг илтгэх мэдээлэл гарна.

4 орчим минутын дараа үйлдэл дуусахгүй үед солих үйлдэл амжилтгүй болсныг илтгэх мэдээлэл гарна.

Угсарсан дугуйны иж бүрдлийг нягтлаад үйлдлийг дахин эхнээс эхлэнэ.

7 Тухайн угсарсан дугуйн иж бүрдлийн дугуйны тохиромжтой даралтын түвшин өмнөх иж бүрдлээс өөр үед дугуйн даралт анхааруулах системийн дугуйны даралтын тохиргоог мөн хийх шаардлагатай.

Хэрэв дугуйн иж бүрдлүүдийн тохиромжтой даралтын түвшин адил үед тохиргоо хийх шаардлагагүй.

8 Дугуй тус бүрийн байрлалыг бүртгэнэ.

Холбоотой холбоосууд

Дугуйн байрлал сольсны дараа дугуйн байрлалыг бүртгэх(Х. 533)

Дугуйны хийн даралт шалгах

Дугуйн зохих хийн даралтыг барина. Дугуйны хийн даралтыг сард нэг удаа шалгана. Нөгөөтэйгүүр Lexus нь дугуйны хийн даралтыг 2 долоо хоног тутам шалгахыг зөвлөж байна.

⚠ АЮУЛТАЙ

Дугуйны гүйцэтгэлийг хангах үүднээс дугуйны зохих хийн даралтыг барина.

Дугуйг зохих хэмжээнд хийлээгүй үед дараах нөхцөл байдал үүснэ:

- Хэт элэгдэл
- Тэгш бус элэгдэл
- Автомашины жолоодлого муудах
- Дугуй хэт халснаас дугуй задрах
- Дугуй болон обудны завсраар хий алдагдах
- Обуд хэлбэр алдах, дугуй гэмтэх
- Хөдөлгөөний үед дугуй гэмтэх өндөр эрсдэл (зам дээрх аюул эрсдэл, зам гүүрний тэлэлтийн залгаас, замын огцом ирмэг зэрэг)

⚠ АНХААР

Дугуйн хийн даралт шалгасан, тохируулсны дараа хийлэх хошууг таглана.

Хийлэх хошууг таглаагүй үед шороо тоос, бохирдол хошууны хавхлагт орж хий алдагдахад хүргэх ба дугуйн хийн даралт буурна.

Дугуйн хэвийн бус даралттай жолоодох нь дараах үр дүнд хүргэнэ:

- Шатахууны хэмнэлт буурна
- Жолоодлогын тав тух, жолоодлого буурах
- Элэгдлээс үүдэн дугуйн эдэлгээ богиносно
- Аюулгүй байдал буурна
- Хүч дамжуулах ангид гэмтэл үүснэ

Дугуйнд хий байнга сулраад байгаа үед та өөрийн Lexus дилер дээрээ оношлуулна уу.

■ Дугуйн хийн даралт шалгах үеийн зааварчилгаа

Дугуйн хийн даралт шалгах үед дараах анхааруулгыг мөрдөнө:

- Дугуйг зөвхөн хүйтэн үед шалгана.

  Автомашин 3-с дээш цаг зогссон, 1.5 км эсвэл 1 миль-с илүү зайнд яваагүй үед дугуйны хийн даралтыг зөв хэмжих боломжтой.

- Зөвхөн дугуйн хийн даралт хэмжигчээр хэмжинэ.

  Зөвхөн дугуйн харагдах байдлаар дугуйн хий тохирох хэмжээнд байгааг мэдэх боломжгүй.
- Дугуйн халуун нэмэгддэг тул автомашин явсны дараа хийн даралт нэмэгдэх нь хэвийн үзэгдэл юм. Жолоодлогын дараа дугуйн хийн даралтыг буулгаж болохгүй.
- Зорчигч болон ачаа тээшний жинг автомашины тэнцвэрийг хадгалан хуваарилна.

Дугуйн хийн даралт зохих хэмжээнд байгааг шалгах

Дугуй хүйтэн үеийн тохиромжтой хийн даралт болон дугуйны хэмжээ дугуй ба даацын мэдээллийн хавтан дээр байдаг.

▶ Зүүн жолооны хүрдтэй автомашин



▶ Баруун жолооны хүрдтэй автомашин



Автомашиныг домкратаар өргөх

Дугуйт домкрат ашиглах үед домкратны гарын авлагын зааварчилгааг даган үйлдлийг аюулгүй хийж гүйцэтгэнэ. Дугуйт домкратаар автомашин өргөх үед домкратыг зөв байрлуулна. Домкрат буруу байрлуулснаар автомашиныг гэмтээх, эсвэл бэртэл гэмтэлд хүргэнэ.

Урд талын домкратаар өргөх цэг



Хойд домкратаар өргөх цэг



Дугуйны байрлал солих

Дугуйны жигд элэгдэл, эдэлгээг уртасгах үүднээс Lexus нь дараах давтамжаар дугуйны байрлал солихыг зөвлөж байна:

2WD загвар: 10000 км (6000 миль) тутам дугуйны байрлал солих

AWD загвар: 5000 км (3000 миль) тутам дугуйны байрлал солих

Дараах дарааллаар дугуйны байрлал солино.

Дугуйн байрлал сольсны дараа дугуйн байрлал бүртгэх үйлдлийг хийнэ.



A Урд

Холбоотой холбоосууд

Дугуйн байрлал сольсны дараа дугуйн байрлалыг бүртгэх(Х. 533)

Обуд

Обуд хэлбэр алдсан, цуурсан эсвэл их хэмжээгээр зэвэрсэн үед шинээр солих шаардлагатай. Эсрэг тохиолдолд обуднаас дугуй салах, эсвэл жолоодлого алдах аюултай.

Обуд сонгох

Обуд солих үед хуучин обудтай даац, диаметр, өргөн болон обудыг автомашинд угсрах үед дугуй хэр наана болон цаана суух хэмжээ[*1] зэрэг нь адил обудаар солино.

Шинэ обуд нь Lexus дилер дээр байгаа болно.

Дараах обуд ашиглахыг Lexus дэмждэггүй:

- Өөр хэмжээ болон хэлбэртэй обуднууд ашиглах
- Хуучин обуд
- Хэлбэр алдсан обудыг засч ашиглах

МЭДЭЭЛЭЛ

■ Обуд солих үед

Таны Lexus автомашины обуданд дугуйн даралт багасах үед урьдчилан анхааруулга өгөх зориулалттай дугуйны хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч суурилагдсан болно.

Тиймээс обуд солих үед дугуйны хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийг суурилуулах шаардлагатай.

⚠ АЮУЛТАЙ

■ Обуд солих үед

- Автомашины жолоодлого алдахад хүргэж болзошгүй тул энэхүү гарын авлага дээр зөвлөмж болгосноос өөр хэмжээтэй обуд ашиглахыг хориглоно.
- Олгой хаймаргүй дугуйнд зориулагдсан обуднаас хий алдагдаж байгаа үед олгой хаймар ашиглахыг хатуу хориглоно. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осол аваарт хүргэх аюултай.
- Тухайн угсрах обуданд тохирсон боолт ашиглана.

  Дэлгэрэнгүйг мэдээллийн та өөрийн Lexus дилерээс авна уу.

■ Дугуйн боолт

Амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах эрсдлийг бууруулах үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө:

- Хэт чангалж болохгүй.

*1 : Нийтлэг нэршил нь “offset”.

⚠ АЮУЛТАЙ

- Дугуйн боолтонд тос, товуд огт ашиглаж болохгүй. Тос, товуд нь боолтыг хэт чангалагдах хүргэх, улмаар боолт, обудны диск гэмтээх аюултай. Үүнээс гадна тос, товуд ашигласнаар дугуйн боолт суларч дугуй салан ноцтой осолд хүргэнэ. Дугуйн боолтноос аливаа тос, товудыг арчиж цэвэрлэнэ.
- Дугуйн боолт цуурсан, хэлбэр алдсан, резьба элэгдсэн үед Lexus дилер дээрээ солиулна уу. Эсрэг тохиолдолд дугуйн боолт суларч дугуй салах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

■ **Дефект, гологдолтой обуд ашиглаж болохгүй**

Цуурсан, хэлбэр алдсан обуд ашиглаж болохгүй.

Хөдөлгөөний явцад дугуйнаас хий алдагдах, улмаар осолд хүргэх аюултай.

⚠ АНХААР

■ **Дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч солих**

- Дугуй засах, солих нь дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийн ажиллагаанд нөлөөлж болзошгүй тул та дугуйтай холбоотой засвар үйлчилгээг та өөрийн Lexus дилер эсвэл бусад мэргэжлийн газраар хийлгэнэ үү. Мөн дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийг та өөрийн Lexus дилерээсээ худалдан авна уу.
- Зөвхөн Lexus-н оригинал обуд ашиглана.

  Оригинал биш обуд ашиглах үед хавхлаг болон дамжуулагч хэвийн ажиллахгүй байж болно.

Хөнгөн цагаан обудны анхааруулга

Хөнгөн цагаан обудтай харьцах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Зөвхөн таны автомашины хөнгөн цагаан обуданд зориулагдсан Lexus-н дугуйн боолт болон дорцов ашиглана.
- Дугуйн байрлал солих, дугуй засах болон солих үед 1000 км (621 миль)-н дараа боолтны чангалгааг шалгана.
- Дугуйн гинж ашиглах үед хөнгөн цагаан обуд гэмтээхээс зайлсхийнэ.
- Обуд тэнцвэржүүлэх үед зөвхөн Lexus-н оригинал, эсвэл дүйцэх чанарын тэнцвэржүүлэх жин болон резин алх ашиглана.

Дугуй солих

Домкратаар автомашин өргөх үед домкратыг зөв байрлуулна.

Буруу байрлуулсан үед автомашиныг гэмтээх, бэртэл гэмтэл учруулах аюултай.

Дугуй солих нь хүндрэлтэй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Автомашин домкратаар өргөх бэлтгэл

МЭДЭЭЛЭЛ

■ Домкрат ба багаж хэрэгсэл

Тус автомашин нь хагарсан үед үргэлжлүүлэн явах боломжтой дугуйтай тул дугуй солиход шаардагдах дараах зүйлс таны автомашинд байхгүй. Та эдгээрийг өөрийн Lexus дилерээс худалдан авах боломжтой.

- Домкрат
- Домкратны иш
- Дугуйн дорцовны хошуу
- Чиглүүлэх шор
- Дугуйн дорцов

Автомашиныг домкратаар өргөхөөс өмнө дараах үйлдлийг хийнэ.

- **Хатуу, тэгш гадаргуутай аюулгүй газарт зогсооно.**
- **Зогсоолын тоормос татна.**
- **Арааны хөшүүргийг P-д шилжүүлнэ.**
- **Хөдөлгүүрийг унтраана.**

Багаж, домкратны хадгалах байрлал



A Домкрат*

⚠ АЮУЛТАЙ

Домкрат буруу суурилуулж ашиглах нь автомашин унахад хүргэх тул дараах анхааруулгыг мөрдөнө.

- Дугуй солих, гинж угсрах болон салгахаас өөр зорилгоор домкрат ашиглаж болохгүй.
- Хагарсан дугуй солих үед зөвхөн автомашинтай хамт нийлүүлэгдсэн домкрат ашиглана. Тус автомашины дугуй солих үед өөр автомашины, эсвэл өөр дугуйн домкрат ашиглаж болохгүй.

B Домкратны иш*
C Дугуйн дорцовны толгой*
D Чирэх дэгээ
E Чиглүүлэх шор*
F Обудны дорцов*
G Халив

Домкрат гаргах

1 Тээшний хэсгийн шалыг авна.



2 Домкрат гаргана.



A Чангалах бүсийг тайлна.

Дугуй салгах

⚠ АЮУЛТАЙ

■ **Дугуй солих үеийн анхааруулга**

- Калпакийг гараар тайлж болохгүй.

*: Тоноглогдсон автомашинд

⚠ АЮУЛТАЙ

Бэртэл гэмтлээс сэргийлж калпактай ажиллах үед анхаарал болгоомжтой харьцана.

- Явж байсан автомашины обудны диск, тоормосны ойр орчимд автомашин зогссон даруйд хүрч болохгүй.

  Явж байсан автомашины обудны диск, тоормосны ойр орчим хэт халсан байдаг. Дугуй солих зэргээр автомашины эдгээр хэсгүүдэд гар, хөл, биеийн бусад хэсгээр хүрсэн тохиолдолд түлэгдэх аюултай.

Дугуй солих үеийн тээшний автомат хаалганы тохиргоо*

Дугуй солих үед тээшний автомат хаалганы ажиллагааг цуцлана. Тээшний автомат хаалга санамсаргүй ажиллаж гар хуруугаа хавчуулж гэмтэх аюултай.

1 Дугуйнд ивээс хийнэ.

Дугуй ивэх байрлал



- Хагарсан дугуй: Зүүн урд

  Баруун хойд дугуйны ард талд ивээс тавина.
- Хагарсан дугуй: Баруун урд

  Зүүн хойд дугуйны ард талд ивээс тавина.
- Хагарсан дугуй: Зүүн хойд

  Баруун урд дугуйны урд ивээс тавина.
- Хагарсан дугуй: Баруун хойд

  Зүүн урд дугуйны урд ивээс тавина.

2 Дугуйн дорцов ашиглан дугуйн боолтыг бага зэрэг суллана (нэг эргэлт орчим).



*: Тоноглогдсон автомашинд

3 **Домкратны A хэсгийг домкрат домкратаар өргөх цэгт хүрэх хүртэл гараар эргүүлнэ.**



⚠ АЮУЛТАЙ

Домкратаар өргөх цэгт домкрат зөв байрласан байгааг нягтлана.

4 **Дугуйн дорцовыг домкратны ишэнд угсарна.**



5 **Дугуй газраас бага зэрэг хөндийрөх хүртэл автомашиныг өргөнө.**



⚠ АЮУЛТАЙ

Домкрат ашиглах үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Автомашин домкратаар өргөгдсөн үед автомашины доор биеээ оруулж болохгүй.
- Автомашин домкратаар өргөгдсөн үед хөдөлгүүр асаах, автомашин хөдөлгөж болохгүй.
- Автомашин дотор хүн байгаа үед домкратаар өргөж болохгүй.
- Автомашин өргөх үед домкратны доор, эсвэл дээр аливаа зүйл хийж болохгүй.

⚠ АЮУЛТАЙ

- Дугуй солиход шаардлагатай өндрөөс илүү өндөр өргөж болохгүй.
- Автомашин доогуур орох шаардлагатай үед тулгуур хөл ашиглана.

6 **Дээд талын боолтыг тайлаад чиглүүлэх шор A гараар эргүүлж хийнэ.**

Чиглүүлэх шорыг тулах хүртэл цагийн зүүний дагуу эргүүлж чангална.



⚠ АЮУЛТАЙ

Дугуй салгах, эсвэл угсрах үед чиглүүлэх шор ашиглана.

Чиглүүлэх шор нь резин материалаар хийгдсэн болно. Хэрэв обудаар шорны A -с өөр хэсэгт дарсан, эсвэл шоронд хэт хүчээр нөлөөлсөн үед шор гэмтэнэ.



7 **Үлдсэн боолтыг тайлаад дугуй салгана.**

Дугуйг газар байрлуулах үед обудны нүүр гэмтэхээс сэргийлж дээш харуулж тавина.



Дугуй угсрах

1 **Обуд болон боолтны гадаргуугаас аливаа гадны биет, бохирдлыг арчиж цэвэрлэнэ.**

Гадны биетийг цэвэрлээгүй үед дугуйн боолт автомашины хөдөлгөөний үед суларч дугуй салж болно.



2 **Нөөц дугуйны боолтны нүхийг чиглүүлэх шортой тааруулаад шорыг боолтны нүхэнд хийнэ.**

Обудны голын нүхийг булны голтой тааруулаад нөөц дугуйг обуд болон булыг сайтар нийлүүлэн угсарна.



⚠ АЮУЛТАЙ

Дугуй салгах, угсрах үед чиглүүлэх ор ашиглана.

Чиглүүлэх шор нь резин материалаар хийгдсэн болно. Шор нь дугуйг A хэсгээс өөр газар байрлуулсан, эсвэл шор дээр их хүчээр нөлөөлсөн үед гэмтэж болно.



3 **Дугуйн боолт бүрийг гараар, эсвэл боолтны торцов ашиглан сул чангална A .**

Боолтны дорцовыг дугуйн боолтыг гараар сул чангалахаас бусад зорилгоор ашиглаж болохгүй.



⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд дугуй боолт суларч дугуй салах аюултай.

- Дугуйн боолт, эсвэл боолтны обудтай харьцах гадаргууд тос, товуд түрхэхийг хориглоно [A].

  Энэ нь дугуйн боолт хэт чангалагдахад хүргэх, улмаар [B], хэсэгт угсрах дугуйн боолтны резьба, эсвэл обуд гэмтээх аюултай.

  Мөн дугуйн боолт сулрах, улмаар дугуй салж ноцтой осол үүсэхэд хүргэж болно. Эдгээр эд ангиудад тос, товуд хүрсэн үед цэвэрлэнэ.



- Обуд угсрах үед обуднаас салгасан боолт ашиглана. Мөн Lexus-н оригинал обудны боолтоос өөр боолт ашиглаж болохгүй.
- Обудны нүх, обудны боолтны резьба, шпилканы резьба, эсвэл дугуйн бул хэлбэр алдсан, цуурсан, зэвэрсэн болон бусад гэмтэл авсан үед та өөрийн Lexus дилер дээр автомашинаа оношлуулна уу.
- Хөдөлгөөний үед шидэгдэх аюултай тул гэмтсэн колпак ашиглаж болохгүй.

4 Чиглүүлэх шорыг аваад обудыг 3-т заасны дагуу сул чангална.



5 Автомашиныг доош буулгана.



⚠ АЮУЛТАЙ

Автомашин буулгах үед ойр орчимд бусад хүн байхгүй байгааг нягтлана. Бусад хүн байгаа үед автомашин буулгах гэж буйг анхааруулна.

6 Зураг үзүүлсэн дарааллын дагуу боолт нэг бүрийг 2-3 удаа сайтар чангална.

Чангалах хүч: 140 N•m (14.3 kgf•m, 103 ft•lbf)



⚠ АЮУЛТАЙ

Дугуйн боолт чангалах үед хэт чангалж болохгүй. Хэт чангалах нь дугуйн обуд, шпилканы резьба, эсвэл обудыг гэмтээх аюултай.

7 Домкрат болон бусад бүх багажийг хураана.

⚠ АЮУЛТАЙ

- Багаж болон домкрат ашигласны дараа хөдөлгөөн эхлэхийн өмнө бүх багаж, домкрат өөрийн байрлалд хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байгааг нягтлана. Эсрэг тохиолдолд мөргөлт, огцом тоормосны үед бэртэл гэмтэлд хүргэнэ.
- Дугуй сольсны дараа даруй чангалах хүчийг шалгана.

  Мөн 1000 км (621 миль) явсны дараа дугуйн боолт зохих хүчээр чангалагдсан байгааг нягтлана.

⚠ АНХААР

Дугуй, обуд мөн дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч салгах, буцааж угсрах үед буруу ажиллагааны улмаас дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийг гэмтээх эрсдэлтэй тул та өөрийн Lexus дилерт хандана уу.

Холбоотой холбоосууд

Дугуйны хийн даралт шалгах(X. 542)

Хийн даралт тохируулах(X. 534)

Дугуйн байрлал сольсны дараа дугуйн байрлалыг бүртгэх(X. 533)

9 Асуудал үүссэн үед

9-1. Жолоодлогын үед асуудал үүссэн нөхцөлд авах арга хэмжээ

Жолоодлогын үед асуудал үүссэн нөхцөлд авах арга хэмжээ 559

9-2. Анхааруулах гэрэл ассан/анивчсан, эсвэл хянах самбар дээр анхааруулга гарсан үед

Анхааруулах гэрэл ассан/анивчсан үед 563

Анхааруулга гарах үед 575

9-3. Хөдөлгүүр асахгүй үед

Стартер мотор ажиллаж байгаа ч хөдөлгүүр асахгүй үед 587

Стартер удаан эргэж хөдөлгүүр асахгүй үед 588

Стартер мотор ажиллахгүй ба хөдөлгүүр асахгүй үед 589

Салоны гэрэл, их гэрэл бүдэг ба хөдөлгүүр асахгүй үед 591

Салоны гэрэл, их гэрэл болон хөдөлгүүр асахгүй үед 597

Дуут дохио сул дуугарах, хөдөлгүүр асахгүй үед 598

Дуут дохио дуугарахгүй ба хөдөлгүүр асахгүй үед 599

9-4. Дугуй хагарсан үед

Дугуй хагарсан үеийн анхааруулга 600

9-5. Хаалга нээгдэхгүй, эсвэл түгжигдэхгүй үед

Автомашины түлхүүр гээсэн үед 601

Электрон түлхүүрээр хаалга/цонх/дээврийн нээлхий удирдагдахгүй үед 602

Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед 612

Хойд хаалга дотор талаас онгойхгүй үед 615

Тээшний хаалга нээгдэхгүй үед 616

9-6. Дээврийн нээлхий, эсвэл электрон нарны хаалт хэвийн ажиллахгүй үед

Дээврийн нээлхий зөв ажиллахгүй үед 618

Панорамик дээврийн нээлхий/электрон нарны хаалт зөв ажиллахгүй үед 619

9-7. Арын суудал зөв ажиллахгүй үед

Арын суудлыг анхны байрлалд буцаах (Тээшний автомат хаалгатай автомашин) ... 620

9-8. Шатахуун цэнэглэх боломжгүй үед

Шатахууны савны таг нээгдэхгүй үед 621

9-9. Салон доторх функц, системийн индикатор асч, анивчиж байгаа үед

Утасгүй цэнэглэгчийн ажиллагааны индикатор (цэнэглэх тавиурны) анивчсан үед 622

9-10. Автомашин хөдлөхгүй үед

Хөдөлгүүр асч байгаа ч автомашин хөдлөхгүй үед 624

Хурдны хайрцаг хэвийн бус дуу чимээ гаргаж байгаа үед..... 625

Чирэгч машинаар чирүүлэх..... 626

Тэвштэй бүтэн ачигч машинаар ачиж тээвэрлэх..... 630

Бусад автомашинаар чирүүлэх үед..... 631

Шавар, элс, цасанд суусан автомашин гаргах..... 635

9-11. Автомашинд асуудал гарсан гэж үзвэл

Автомашинд хэвийн бус зүйл илэрсэн үед 636

Автомашинаас хэвийн бус дуу чимээ гарч байгаа үед..... 637

Автомашины ажиллагаа хэвийн бус үед 638

9-12. Дилертэй холбогдохоос өмнө шалгах зүйлс

Хөдөлгүүр унтраасны дараа жолооны хүрд эргэхгүй байх 639

Автомат цонхны товчоор цонх нээгдэхгүй, эсвэл хаагдахгүй үед 640

Асаах товч автоматаар унтрах..... 642

Автомашин халсан үед 643

Товч дарсан ч цахилгаан эд анги, төхөөрөмж ажиллахгүй үед..... 647

Гэрэл асахгүй үед..... 648

Жолоодлогын үед асуудал үүссэн нөхцөлд авах арга хэмжээ

Ослын дохионы гэрэл ашиглан бусад жолооч нарт анхааруулга өгөх

Автомашинд эвдрэл гэмтэл гарсан зэргээр зам дээр зогссон үед ослын дохионы гэрэл ашиглан бусад жолооч нарт зам дээр автомашин байгааг анхааруулах боломжтой.

Товч дарна.

Эргэх дохионы бүх гэрэл анивчиж асна.
Унтраах үед товчийг дахин дарна.



МЭДЭЭЛЭЛ

■ Ослын дохионы гэрэл

- Хөдөлгүүр унтраастай үед ослын дохионы гэрэл удаан ашигласан нөхцөлд аккумуляторын цэнэг сууна.
- Дараах аль нэг SRS аюулгүйн дэр хүчтэй арын мөргөлтийн үед дэлгэгдсэн нөхцөлд ослын дохионы гэрэл автоматаар анивчиж асна.

  Ослын дохионы гэрэл 20 минут асаад автоматаар унтарна. Гэрлийг гар аргаар унтраах үед товч дээр 2 удаа дарна. (Мөргөлтийн хүч болон мөргөлтийн байдлаас хамаарч ослын дохионы гэрэл асахгүй байж болно.)

Автомашиныг онцгой нөхцөлд зогсоох

Автомашиныг хэвийн байдлаар зогсоох боломжгүй болсон зэрэг зөвхөн онцгой, аваарын нөхцөл үүссэн үед дараах дарааллаар зогсооно:

⚠ АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үед хөдөлгүүр унтраах шаардлагатай нөхцөлд

Жолоо, тоормосны хүчлүүр ажиллагаагүй болох тул тоормосны дөрөө гишгэхэд хатуу, жолооны хүрд эргүүлэхэд хүнд болно. Хөдөлгүүр унтраахаас өмнө хангалттай хэмжээнд хурд хасна.

1 Тоормосны дөрөөг 2 хөлөөрөө чанга үргэлжлүүлэн гишгэнэ.

Автомашиныг зогсооход шаардагдах тоормосны үйлчилгээ буурдаг тул тоормосны дөрөөг олон дахин гишгэж болохгүй.

2 **Арааг N байрлалд шилжүүлнэ.**



- Араа N байрлалд шилжсэн үед:

  Хурд буурсны дараа замын хажуу талд аюулгүй газарт зогсооно.

  Хөдөлгүүрийг унтраана.

- Арааг N байрлалд шилжүүлж болохгүй үед:

  Автомашины хурдыг боломжит хэмжээнд хамгийн ихээр бууруулахын тулд тоормосны дөрөөг 2 хөлөөрөө үргэлжлүүлэн гишгэнэ.

  Асаах товчийг 2 ба түүнээс дээш секунд үргэлжлүүлэн дарах, эсвэл 3 ба түүнээс олон удаа богино хугацаанд товчийг дарж хөдөлгүүр унтраана.

3 **Замын хажуу талд аюулгүй газарт зогсооно.**

⚠ АЮУЛТАЙ

Онцгой нөхцөлд хөдөлгүүр унтраасны дараа дахин асаах үед арааг N байрлалд шилжүүлээд асаах товч дарна.

Автомашин усанд живсэн, эсвэл усны түвшин нэмэгдэж байгаа үед

Тус автомашин нь гүнзгий устай, үерлэсэн замаар явахад зориулагдаагүй болно. Түвшин нэмэгдэж байгаа, эсвэл үерлэсэн замаар явж болохгүй. Автомашин усанд живэх, урсаж эхлэх магадлалтай үед автомашинд үлдэх нь аюултай.

Сандралгүй тайван байж, дараах арга хэмжээг авна.

- Хаалга онгойлгох боломжтой тохиолдолд хаалга онгойлгож автомашинаас гарна.
- Хаалга онгойхгүй үед цонх нээх товчоор цонх нээж автомашинаас гарах боломжийг нягтлана.
- Цонх нээх боломжтой үед цонхоор гарна.
- Түвшин нэмэгдэж буй уснаас шалтгаалж хаалга болон нээгдэхгүй үед сандралгүй тайван байж автомашины гадна болон дотор

талын усны даралт адил болох хүртэл бүхээгний усны түвшин нэмэгдэхийг хүлээгээд хаалга нээж гарна.

Автомашины гадна талын усны түвшин хаалганы дунд хүртэл байгаа үед усны даралтаас шалтгаалж хаалгыг дотор талаас онгойлгох боломжгүй.

МЭДЭЭЛЭЛ

Усны түвшин шал давсан үед

Усны түвшин шал давсан үед тодорхой хугацааны дараа электрон төхөөрөмжүүд гэмтэж автомат цонх ажиллагаагүй болох ба хөдөлгүүр унтарч автомашиныг хөдөлгөх боломжгүй болно.

Аваарын алх ашиглах*1

Тус автомашины салхины болон цонхны шилэнд давхар хальсаар бүрсэн шил * ашиглагддаг. Давхар хальсаар бүрсэн шилийг аваарын алхаар*1 хагалах боломжгүй.

Давхар хальсаар бүрсэн шилийг таних арга

Шилийг хажуунаас харах үед давхар хальсаар бүрсэн шил нь 2 хуудас нийлүүлсэн харагдана.



A Давхар хальсаар бүрсэн шил
B Хатаасан шил

⚠ АЮУЛТАЙ

Жолоодлогын үеийн анхааруулга

Усны түвшин нэмэгдэж байгаа, эсвэл үерлэсэн замаар явж болохгүй. Автомашин эвдэрч явахгүй болох, мөн үерт автах, урссанаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюулд хүргэнэ.

Бензин насос таслах системийн ажиллагаа

Мөргөлтийн улмаас аюулгүйн дэр дэлгэгдэж хөдөлгүүр унтран мөргөлтийн мэдрэгчид тодорхой түвшнээс өндөр мөргөлт мэдрэгдсэн үед шатахуун асгарах эрсдлийг бууруулах үүднээс бензин насос таслах систем ажиллана.

* : Тоноглогдсон автомашинд

*1 : Аваарын алхны тухай дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилер, эсвэл авто тоноглолын дэлгүүрээс авна уу.

Хөдөлгүүр дахин асаах

⚠ АНХААР

Хөдөлгүүр асаахаас өмнө автомашины доод талыг сайтар шалгана. Хэрэв газар дээр шингэн дуссан байвал шатахууны систем гэмтсэн ба засвар хийх шаардлагатай байж болно. Энэ нөхцөлд хөдөлгүүр асааж болохгүй.

Шатахууны насос таслах систем ажилласны дараа хөдөлгүүр дахин асаах үед дараах үйлдлийг хийнэ.

1 **Асаах товчийг ACC, эсвэл OFF горимд шилжүүлнэ.**

2 **Хөдөлгүүр дахин асаана.**

Анхааруулах гэрэл ассан/анивчсан үед

Анхааруулах гэрэл ассан, эсвэл анивчсан үед дараах үйлдлийг сандралгүйгээр хийнэ. Хэрэв гэрэл асаад, эсвэл анивчаад унтарсан үед энэ нь системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй. Нөгөөтэйгүүр энэ нь олон дахин үүсч буй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

МЭДЭЭЛЭЛ

■ Анхааруулах дуут дохио

Зарим тохиолдолд дуу чимээ ихтэй газар байгаагаас, эсвэл аудио хөгжимний дуунаас хамаарч анхааруулах дуут дохио сонсогдохгүй байж болно.

Тоормосны системийн анхааруулах гэрэл (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(улаан)	Дараах утгыг илтгэнэ: ● Тоормосны шингэний түвшин буурсан; эсвэл ● Тоормосны системд доголдол үүссэн Нэн даруй автомашинаа зогсоож өөрийн Lexus дилерт хандана уу. Үргэлжлүүлэн жолоодох нь аюултай.

⚠ АЮУЛТАЙ

ABS болон тоормосны системийн анхааруулах гэрэл зэрэг үргэлжлэн ассан нөхцөлд даруй автомашинаа зогсоож өөрийн Lexus дилерт хандана уу.

Тоормос хийх үед автомашин туйлын тогтворгүй болох ба ABS системийн ажиллагаа алдагдах, улмаар амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

Тоормосны системийн анхааруулах гэрэл (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(шар)	Цахлгаан зогсоолын тоормосонд доголдол үүссэнийг илтгэнэ Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

⚠ АЮУЛТАЙ

ABS болон тоормосны системийн анхааруулах гэрэл зэрэг ассан үед даруй аюулгүй газар зогсож та өөрийн Lexus дилерт хандана уу.

Тоормослох үед автомашин хэт тогтворгүй болох ба ABS систем ажиллахгүй байх, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

Хөргөлтийн шингэний өндөр хэм анхааруулах гэрэл (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
Тус гэрэл мэдээллийн дэлгэц дээр асна.	Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм өндөр байгааг илтгэнэ Автомашиныг даруй аюулгүй газар зогсоогоод хөдөлгүүр халсан үед авах арга хэмжээг авна.

Холбоотой холбоосууд

Автомашин халсан үед(X. 643)

Цэнэглэх системийн анхааруулах гэрэл (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
Гэрэл мэдээллийн дэлгэц дээр асна.	Автомашины цэнэглэх системд доголдол үүссэнийг илтгэнэ Даруй аюулгүй газар зогсоод та өөрийн Lexus дилерт хандана уу.

Хөдөлгүүрийн тосны даралт багассаныг анхааруулах гэрэл (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
Тус гэрэл мэдээллийн дэлгэц дээр асна.	Хөдөлгүүрийн тосны даралт хэт багассаныг анхааруулж асна. Даруй автомашиныг аюулгүй газар зогсоож Lexus дилертээ хандана уу.

Доголдол анхааруулах гэрэл

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	Дараах доголдол үүссэнийг илэрхийлнэ: ● Хөдөлгүүрийн электрон удирдлагын систем; ● Электрон хаазны удирдлагын систем; эсвэл ● Электрон хурдны хайрцгын удирдлагын систем Даруй автомашиныг аюулгүй газар зогсоож Lexus дилертээ хандана уу.

МЭДЭЭЛЭЛ

Хөдөлгөөний үед доголдол анхааруулах гэрэл ассан нөхцөлд

Зарим загвар дээр шатахуун сав бүрэн хоосон болсон үед доголдол анхааруулах гэрэл асна. Шатахууны сав хоосон үед даруй шатахуун цэнэглэнэ. Доголдол анхааруулах гэрэл автомашин бага зэрэг явсны дараа унтарна.

Доголдол анхааруулах гэрэл гэрэл унтрахгүй үед боломжит богино хугацаанд өөрийн Lexus дилерт хандана уу.

SRS анхааруулах гэрэл

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй / Арга хэмжээ
	● SRS аюулгүйн дэрний системд доголдол үүссэн ● Аюулгүйн бүс бүцаан чангалагч системд доголдол үүссэн **Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.**

ABS анхааруулах гэрэл (анхааруулах дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	Дараах системд үүссэн доголдлыг илтгэнэ: ● ABS тоормос; эсвэл ● Тоормосонд туслах систем Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

⚠ АЮУЛТАЙ

Хэрэв ABS тоормос болон тоормосонд туслах системийн анхааруулах гэрлүүд зэрэг ассан хэвээр байгаа үед даруй аюулгүй газар зогсож та өөрийн Lexus дилерт хандана уу.

Тоормослох үед автомашин туйлын тогтворгүй болох ба ABS систем ажиллахгүй байх, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

Дөрөөний буруу ажиллагааг анхааруулах гэрэл (дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
 Тус гэрэл нь мэдээллийн дэлгэц дээр гарна.	Дохио дуугарсан үед: Дараах системүүдийн доголдлыг илтгэнэ: ● Brake Override систем ● Хөдөлгөөн эхлэх удирдлага Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.
	Дохио дуугарсан үед: Хаазны дөрөө гишгэсэн үед арааны байрлал солигдож DSC хөдөлгөөн эхлэх удирдлага ажилласныг илтгэнэ. **Хаазны дөрөөг даруй суллана.**
	Дохио дуугарсан үед: PKSB систем ажилласан Мэдээллийн дэлгэцээр гарсан зааварчилгааг баримтлана.
	Дохио дуугарахгүй үед: Хаазны болон тоормосны дөрөөг зэрэг гишгэсэн ба Brake Override систем ажилласныг илтгэнэ. **Хаазны дөрөөг суллаж тоормосны дөрөө гишгэнэ.**

Цахилгаан жолооны хүчлүүрийн системийн анхааруулах гэрэл (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(улаан/шар)	EPS цахилгаан жолооны хүчлүүрийн системд доголдол үүссэнийг илтгэнэ Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

МЭДЭЭЛЭЛ

Цахилгаан жолооны хүчлүүрийн системийн анхааруулах гэрэл (дуут дохио)

Аккумуляторын цэнэг хангалтгүй болсон, эсвэл хүчдэл хэсэг хугацаанд унасан үед цахилгаан жолооны хүчлүүрийн системийн анхааруулах гэрэл асч дохио дуугарна.

АЮУЛТАЙ

Цахилгаан жолооны хүчлүүрийн системийн анхааруулах гэрэл шараар ассан үед жолооны хүчлүүрийн дэмжлэг хязгаарлагдана. Гэрэл улаанаар ассан үед жолооны хүчлүүрийн дэмжлэг алдагдаж жолооны хүчлүүр ажиллуулахад хэт хүнд болно.

Жолооны хүрд хэвийн үеэс хүнд болсон үед хүрдийг гараар чанга бариж илүү хүчээр ажиллуулна.

Шатахуун багассаныг анхааруулах гэрэл

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	Үлдэгдэл шатахууны хэмжээ 8.5 L (2.3 gal., 1.9 Imp. gal.)-с багассаныг илтгэнэ Шатахуун цэнэглэнэ.

Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүс анхааруулах гэрэл (дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	Жолооч, урд зорчигчид аюулгүйн бүсээ зүүхийг анхааруулна Аюулгүйн бүс зүүнэ. Урд зорчигчийн суудалд зорчигч суусан үед анхааруулах гэрэл, дохиог унтраахын тулд аюулгүйн бүс зүүнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүс анхааруулах дохио

● Булангийн Орнуудын Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнууд[*1], Йемэн, Ливан, Иракаас бусад:

Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүс анхааруулах дохио:

Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүс анхааруулах дохио нь жолооч, урд зорчигч аюулгүйн бүсээ зүүгээгүй байгааг анхааруулж дуугарна. Аюулгүйн бүс зүүгээгүй үед автомашины хурд тодорхой хэмжээнд хүрсний дараа тодорхой хугацааны турш дуугарна.

● Булангийн Орнуудын Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнууд[*1], Йемэн, Ливан, Ирак:

- Жолоочийн аюулгүйн бүс анхааруулах дохио:

  Жолоочийн аюулгүйн бүс анхааруулах дохио нь жолооч аюулгүйн бүсээ зүүгээгүй байгааг анхааруулж дуугарна. Асаах товчийг ON горимд шилжүүлэх үед дохио нэг удаа дуугарна. Аюулгүйн бүс зүүгээгүй үед автомашины хурд тодорхой хэмжээнд хүрсний дараа тодорхой хугацааны турш дуугарна.

- Урд зорчигчийн аюулгүйн бүс анхааруулах дохио:

  Урд зорчигчийн аюулгүйн бүс анхааруулах дохио нь урд зорчигч аюулгүйн бүсээ зүүгээгүй байгааг анхааруулж дуугарна. Аюулгүйн бүс зүүгээгүй үед автомашины хурд тодорхой хэмжээнд хүрсний дараа тодорхой хугацааны турш дуугарна.

■ Урд зорчигч мэдрэх мэдрэгч, аюулгүйн бүс анхааруулах гэрэл, дохио

● Урд зорчигчийн суудалд эд зүйл тависан үед суудлын мэдрэгч ажиллаж анхааруулах гэрэл анивчиж дохио дуугарч болно.

● Суудал дээр зөөлөвч тависан үед мэдрэгч зорчигч суусныг мэдрэхгүй байх, улмаар анхааруулах гэрэл ажиллахгүй байж болно.

*1 : Саудын Араб, Оман, Бахрейн, АНЭУ, Катар, Кувейт

Арын зорчигчийн аюулгүйн бүс сануулах гэрэл (анхааруулах дохио)*

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(HUD дэлгэцгүй автомашин) (HUD дэлгэцтэй автомашин)	Арын зорчигчийг аюулгүйн бүсээ зүүхийг сануулна Аюулгүйн бүс бүслэнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Арын зорчигчийн аюулгүйн бүс анхааруулах дохио

● Тайвань, Вьетнам, Чилээс бусад:

Арын зорчигчийн аюулгүйн бүсний анхааруулах дохио нь арын зорчигч аюулгүйн бүс бүслээгүй үед анхааруулна. Бүс бүслээгүй үед автомашины хурд тодорхой хурдад хүрсний дараа, эсвэл бүсэлсэн бүсээ тайлсны дараа тодорхой хугацаанд тасалдаж дуугарна.

● Тайвань, Вьетнам, Чили:

Арын зорчигчийн аюулгүйн бүсний анхааруулах дохио нь арын зорчигч аюулгүйн бүс бүслээгүй үед анхааруулна. Бүс бүслээгүй үед автомашины хурд тодорхой хурдад хүрсний дараа тодорхой хугацаанд тасалдаж дуугарна.

Дугуйн даралт анхааруулах гэрэл (дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	Гэрэл 1 минут анивчсаны дараа ассан үед (дохио дуугарахгүй): Дугуйн даралт анхааруулах системд доголдол үүссэн Та өөрийн Lexus дилер дээр системийг шалгуулна уу.
	Гэрэл ассан үед (дохио дуугарах): Дугуйны хийн даралт багассан Дугуйны хэм хангалттай хөрсний дараа дугуй бүрийн хийн даралтыг шалгаж зохих түвшинд тохируулна.

* : Тоноглогдсон автомашинд

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	Гэрэл ассан үед (дохио дуугарах): Дугуй хагаран хийн даралт буурсан Аюулгүй газар даруй зогсоож шаардлагатай арга хэмжээг авна

МЭДЭЭЛЭЛ

■ Дугуйн хийн даралт анхааруулах гэрэл ассан үед

Дугуй хагарсан эсэхийг шалгана.

- Хагарсан үед: → X.600
- Дугуй хагараагүй үед: Асаах товчийг ON горимд шилжүүлнэ. Дугуйн даралт анхааруулах гэрэл асах, анивчих эсэхийг нягтлана.
  - Дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчаад ассан үед

    Дугуйн даралт анхааруулах системд доголдол үүссэн байж болзошгүй. Та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.
  - Дугуйн даралт анхааруулах гэрэл ассан үед

    Дугуйны хэм хангалттай хөрсний дараа дугуй бүрийн хийн даралтыг шалгаж зохих түвшинд тохируулна.

    Дугуйн даралт анхааруулах гэрэл хэдэн минут өнгөрсөн ч унтрахгүй үед дугуй бүрийн хийн даралтыг шалгаж зохих түвшинд тохируулаад дугуйн хийн даралтыг сануулах үйлдэл хийнэ.

    Дугуйн хийн даралтыг сануулах үйлдэл хийсэн ч дугуйн даралт анхааруулах гэрэл хэдэн минутын дараа унтрахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

■ Байгаль цаг уурын шалтгаанаар дугуйн даралт анхааруулах гэрэл асах

Хий алдагдалт, агаарын хэмийн өөрчлөлтөөс хийн даралт өөрчлөгдөх зэрэг шалтгаанаар дугуйн даралт анхааруулах гэрэл асч болно. Энэ нөхцөлд хийн даралт тохируулахад гэрэл унтарна (хэдэн минутын дараа).

⚠ АЮУЛТАЙ

■ Дугуйн даралт анхааруулах гэрэл ассан үед

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд автомашины жолоодлого алдагдаж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.

- Даруй тохиромжтой хамгийн бага хурд хүртэл хурдаа хасна. 80 км/ц (50 mph)-с илүү хурдаар явж болохгүй.
- Аюулгүй газар даруй зогсооно. Даруй хийн даралтыг тохируулна.

⚠ АЮУЛТАЙ

- Дугуйн хийн даралт тохируулсан ч дугуйн даралт анхааруулах гэрэл ассан үед дугуй хагарсан байх магадлалтай. Та ойр байрлах Lexus дилер дээр дугуйгаа засуулна уу.
- Огцом маневр, тоормос хийхээс зайлсхийнэ. Дугуй муудсан үед жолоо болон тоормосны удирдлага алдах аюултай.

■ **Дугуй задарсан, эсвэл хий огцом суларсан үед**

Дугуйн хийн даралт анхааруулах систем даруй идэвхжихгүй байж болно.

⚠ АНХААР

■ **Дугуйн даралт анхааруулах системийн хэвийн ажиллагааг хангах**

Дугуйн даралт анхааруулах системийн хэвийн ажиллагаа алдагдах тул өөр техник үзүүлэлт, үйлдвэрлэгчийн дугуй холиж ашиглаж болохгүй.

Stop & Start cancel индикатор (анхааруулах дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(анивчих)	Stop & Start системд доголдол үүссэн байж болзошгүй. Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

Stop & Start системийн индикатор (дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(анивчих)	Арааны D байрлалд Stop & Start системээр хөдөлгүүр унтарсан үед жолоочийн хаалга нээхэд дохио дуугарч Stop & Start системийн индикатор анивчина. Дохиог зогсоох үед жолоочийн хаалга хаана.

Lexus parking assist-sensor OFF индикатор (анхааруулах дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	Lexus parking assist-мэдрэгчийн функцад доголдол үүссэнийг илтгэнэ Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	Мэдрэгч бохирдсон, мөсөөр хучигдсан зэргээр системийн ажиллагаа түр цуцлагдсаныг илтгэнэ. Мэдээллийн дэлгэцний зааварчилгааг мөрдөнө.

PCS анхааруулах гэрэл (анхааруулах дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	PCS мөргөлтийн өмнөх системд доголдол үүссэнийг илтгэнэ. Мэдээллийн дэлгэцийн зааварчилгааг дагана уу. ● **PCS мөргөлтийн өмнөх систем, эсвэл VSC автомашины тэнцвэрийн удирдлагын систем цуцлагдсан үед асна.**

LTA индикатор (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(Шаргал)	LTA системийн доголдлыг илтгэнэ. ● **Мэдээллийн дэлгэц дэх зааварчилгааг дагна.**

LDA индикатор (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(Шаргал)	LDA функцад доголдол үүссэнийг илтгэнэ. ● **Мэдээллийн дэлгэцийн зааварчилгааг дагана.**

Динамик радарын хурд баригчийн индикатор (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(Шаргал)	Динамик радарын хурд баригчийн системийн доголдлыг илтгэнэ. ● **Мэдээллийн дэлгэц дээр гарсан зааварчилгааг дагана.**

Хурд баригчийн индикатор (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(Шаргал)	Хурд баригчийн системд доголдол үүссэнийг илэрхийлнэ. ● **Мэдээллийн дэлгэц дээр гарсан зааварчилгааг баримтлана.**

Жолоодлогод туслах мэдээллийн индикатор

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
	Дараах аль нэг систем доголдсон, эсвэл цуцлагдсаныг илтгэнэ. ● PCS систем ● LDA систем ● PKSB систем* ● RCD арын камераар мэдрэгч* ● BSM систем* ● RCTA(Арын хөндлөн чиглэлийн хөдөлгөөн анхааруулах функц)* ● Аюулгүйгээр буухад туслах систем (хаалга нээх удирдлагатай)* ● Автомат арын ослын дохионы гэрэл ● **Мэдээллийн дэлгэц дээр гарсан зааварчилгааг дагана.**

* : Тоноглогдсон автомашинд

Шарвалтын индикатор

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(асах)	Дараах системийн доголдлыг илтгэнэ: ● VSC систем; ● Чиргүүлийн шарвалтын удирдлагын систем*; ● TRC систем; ● Trail Mode функц*; эсвэл ● Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын систем Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

Зогсоолын тоормосны индикатор

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(анивчих)	Зогсоолын тоормос бүрэн залгагдаагүй, эсвэл салгагдаагүй байж болно Зогсоолын тоормосны товч дахин дарна. Зогсоолын тоормос салгагдаагүй үед тус гэрэл асна. Зогсоолын тоормос бүрэн салгагдсаны дараа гэрэл унтарсан үед систем хэвийн ажиллана.
	Зогсоолын тоормосны систем доголдсоныг илтгэнэ Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

Тоормос баригчийн ажиллагааны индикатор (дуут дохио)

Нөхцөл	Шалтгаан / Авах арга хэмжээ
(анивчих)	Тоормос баригчийн системд доголдол үүссэнийг илтгэнэ Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

* : Тоноглогдсон автомашинд

Анхааруулга гарах үед

Системд үүссэн доголдол, буруу ажиллагаа, мөн шаардагдаж буй засвар үйлчилгээний анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гардаг. Анхааруулга гарсан үед тухайн анхааруулгын дагуу зохих арга хэмжээг авна.

Тохирох арга хэмжээг авсан ч анхааруулга дахин гарсан нөхцөлд та өөрийн Lexus дилерт хандана уу.

Мөн анхааруулга дэлгэцээр гарах үед зэрэг анхааруулах гэрэл ассан, эсвэл анивчсан нөхцөлд анхааруулах гэрэлд тохирох арга хэмжээг авна.

МЭДЭЭЛЭЛ

■ Анхааруулга

Дараах анхааруулга нь системийн ажиллагааны нөхцөл болон автомашины тоноглолоос хамаарч бодит анхааруулгаас өөр байж болно.

■ Анхааруулах дуут дохио

Зарим тохиолдолд орчны дуу чимээ, аудио системээс анхааруулах дуут дохио сонсогдохгүй байж болно.

"Engine Oil Level Low Add or Replace"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Хөдөлгүүрийн тосны түвшин багассан байж болзошгүй.	Хөдөлгүүрийн тосны түвшинг шалгаж шаардлагатай үед нэмнэ. Автомашин налуу газар зогссон тус мэдээлэл гарч болно. Автомашиныг тэгш газарт шилжүүлэн мэдээлэл унтрах эсэхийг шалгана.

Холбоотой холбоосууд

Хөдөлгүүрийн тос шалгах, нэмэх(X. 511)

"Engine Stopped Steering Power Low"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Тус мэдээлэл нь хөдөлгөөний үед хөдөлгүүр унтарсан нөхцөлд асна.	Жолооны хүрдний ажиллагаа хэвийн үеэс хүндэрсэн үед жолооны хүрдийг гараар сайтар барин илүү хүчээр эргүүлнэ.

"Auto Power OFF to Conserve Battery"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Автоматаар унтраах функц ажиллан цахилгаан хэлхээг унтраасан.	Дараагийн удаа хөдөлгүүр асаах үед хөдөлгүүрийн хурдыг бага зэрэг нэмэн 5 орчим минут ажиллуулж аккумулятор цэнэглэнэ.

Холбоотой холбоосууд

Асаах товчны горим солих(X. 145)

"12-Volt Battery Charging System Malfunction Stop in a Safe Place See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болзошгүй.	Автомашинаа даруй зогсоож өөрийн Lexus дилерт хандана уу. Үргэлжлүүлэн жолоодох нь аюултай байж болно.

"Speed Limit Exceeded"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Автомашины хурд 120 км/ц (75 mph) ба түүнээс давсан. Дуут дохио давхар дуугарна.	Дуут дохио 6 секундын дараа, эсвэл 120 км/ц (75 mph)-с хурд буурсан үед зогсоно. Хурдаа хасна уу.

"Tyre Set Switching Incomplete Retry Tyre Set Registration See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дугуйны иж бүрдэл солих үйлдэл амжилтгүй болсон.	Дугуйны аль иж бүрдэл угсрагдсан байгааг нягтлаад солих үйлдлийг эхнээс нь эхлэнэ.

Холбоотой холбоосууд

Дугуйны иж бүрдэл сонгох(X. 539)

* : Тоноглогдсон автомашинд

"Headlight System Malfunction Visit Your Dealer"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Системд доголдол үүссэн байж болзошгүй.	Та автомашинаа өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"AWD System Overheated 2WD Mode Engaged"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Хэт өндөр ачаалалтай нөхцөлд жолоодсон үед тус анхааруулга гарч болно.	● **Анхааруулга унтрах хүртэл бага хурдаар жолоодох, эсвэл аюулгүй газар хөдөлгүүр асаалттай зогсооно.** Анхааруулга унтрахгүй үед Lexus дилер дээрээ оношлуулна уу.

"Engine Coolant Temp High Stop in a Safe Place See Owner's Manual"

Авах арга хэмжээ
Хөдөлгүүр халсан үед авах арга хэмжээг авна.

Холбоотой холбоосууд

Автомашин халсан үед(X. 643)

"Smart Entry & Start System Malfunction See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болзошгүй.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Braking Power Low Stop in a Safe Place See Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болзошгүй.	Автомашинаа даруй зогсоож өөрийн Lexus дилерт хандана уу. Үргэлжлүүлэн жолоодох нь аюултай байж болзошгүй.

* : Тоноглогдсон автомашинд

"Braking power low Stop in a safe place See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болзошгүй.	Даруй автомашинаа зогсоож өөрийн Lexus дилертээ хандана уу. Үргэлжлүүлэн жолоодох нь аюултай байж болзошгүй.

"Oil Pressure Low Stop in a Safe Place See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болно.	Автомашинаа даруй зогсоож Lexus дилертээ хандана уу. Үргэлжлүүлэн жолоодох нь аюултай.

"High Power Consumption Power to Climate Temporarily Limited"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Тус мэдээлэл дэлгэцээр олон дахин гарч байгаа үед цэнэглэх системтэй холбоотой доголдол үүссэн, эсвэл аккумулятор муудсан байх магадлалтай.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

Lexus дилерт очих шаардлагатайг анхааруулах мэдээлэл

Шалтгаан	Авах арга хэмжээ
Мэдээллийн дэлгэцийн системд доголдол үүссэн.	Та даруй өөрийн Lexus дилерт хандана уу.

"New Key Registered Contact Your Dealer if You Did Not Register a New Key"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Шинэ электрон түлхүүр бүртгэсэн үед хаалганы түгжээг гадна талаас тайлж жолоочийн хаалга нээх бүрт 10 хоногийн турш тус мэдээлэл дэлгэц дээр гарна.	Хэрэв та шинэ электрон түлхүүр автомашинд бүртгээгүй бол тус мэдээлэл гарсан үед та өөрийн Lexus дилерт хандаж таны мэдэхгүй электрон түлхүүр (таньд байгаагаас бусад) бүртгэгдсэн эсэхийг шалгуулна уу.

"Parking Brake Temporarily Unavailable"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Богино хугацаанд зогсоолын тоормос давтан ашигласан үед хэт халалтаас сэргийлж системийн ажиллагаа хязгаарлагдаж болно.	Энэ нөхцөлд зогсоолын тоормос ажиллуулахаас зайлсхийнэ. Системийн хэвийн ажиллагаа 1 минутын дараа сэргэнэ.

"EPB Activation Stopped Incompletely"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Зогсоолын тоормосны товч ажиллуулна. Зогсоолын тоормосны товч хэд хэдэн удаа ажиллуулсан ч мэдээлэл унтрахгүй үед системд доголдол үүссэн байж болно.	Та автомашинаа өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Parking Brake Unavailable"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Зогсоолын тоормосны товч ашиглана. Товчийг олон удаа ажиллуулсан ч анхааруулга унтрахгүй үед системд доголдол үүссэн байж болно.	Та автомашинаа өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Brake Hold Malfunction Press Brake to Deactivate Visit Your Dealer"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Системд доголдол үүссэн байж болзошгүй.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Transmission Oil Temp High Stop in a Safe Place and See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Хурдны хайрцаг автоматаар хөнгөн араанд шилжинэ.	Та автомашинаа өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Shift System Malfunction Shifting Unavailable Drive to a Safe Place and Stop"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Араа солих удирдлагын системд доголдол үүссэн.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Shift System Malfunction Driving Unavailable"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Арааны удирдлагын системд доголдол үүссэн байж болзошгүй.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

Арааны хөшүүрэг шилжүүлэх шаардлагатайг анхааруулсан мэдээлэл гарсан үед*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Арааны хөшүүрэг буруу сэлгэх, эсвэл автомашин санамсаргүй гэнэт хөдлөхөөс сэргийлж мэдээллийн дэлгэц дээр араа сэлгэх шаардлагатайг анхааруулсан анхааруулга гарч болно.	Анхааруулгын зааварчилгааны дагуу арааны хөшүүргийг сэлгэнэ.

"Shift System Malfunction Apply Parking Brake Securely When Parking See Owner's Manual"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болно.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"P Switch Malfunction Apply Parking Brake Securely When Parking See Owner's Manual"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болзошгүй.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

* : Тоноглогдсон автомашинд

"Shift System Unavailable Apply Parking Brake Securely When Parking See Owner's Manual"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болзошгүй.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Shift System Malfunction See Owner's Manual"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болзошгүй.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Shift System Malfunction Stop in a Safe Place See Owner's Manual"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болзошгүй.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Battery Low Shifting Unavailable See Owner's Manual"*

Шалтгаан	Авах арга хэмжээ
Доголдол үүссэн байж болзошгүй.	Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

"Key Battery Low Replace Key Battery"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Электрон түлхүүрийн зайны цэнэг багассан.	Электрон түлхүүрийн зайг солино.

* : Тоноглогдсон автомашинд

"System Malfunction Visit Your Dealer"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ. ● PCS систем ● LDA систем ● LTA систем ● AHB автомат холын гэрэл ● AHS холын гэрэл ● Динамик радарын хурд баригч ● RSA замын тэмдэг танихад туслах систем* ● BSM систем* ● RCTA (Rear Cross Traffic Alert) систем* ● Автомат арын ослын дохионы гэрэл ● Аюулгүйгээр буухад туслах систем (хаалга нээх удирдлагатай)* ● Lexus parking assist-мэдрэгч* ● PKSB систем* ● RCD систем*	● **Даруй өөрийн Lexus дилер дээрээ оношлуулна уу.**

*: Тоноглогдсон автомашинд

"System Stopped See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах аль нэг системийн ажиллагаа цуцлагдсаныг илтгэнэ. ● PCS мөргөлтийн өмнөх систем ● LDA систем ● LTA систем ● AHB холын гэрэл ● AHS холын гэрэл ● Динамик радарын хурд баригч ● RSA систем* ● BSM систем* ● RCTA систем* ● Автомат арын ослын дохионы гэрэл ● Аюулгүйгээр буухад туслах дэмжлэг (хаалга нээх удирдлагатай)* ● Lexus parking assist-мэдрэгч* ● PKSB систем* ● RCD систем*	● **Дараах арга хэмжээг авна.** ● Аккумуляторын хүчдэлийг шалгана ● Урд, хойд хажуугийн радарын мэдрэгчээс шавар, бохирдлыг цэвэрлэнэ

* : Тоноглогдсон автомашинд

"System Stopped Front Camera Low Visibility See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах аль нэг системийн ажиллагаа цуцлагдсаныг илтгэнэ. ● PCS систем ● LDA систем ● LTA систем ● AHB холын гэрэл ● AHS холын гэрэл ● Динамик радарын хурд баригч ● RSA систем*	● **Дараах арга хэмжээг авна.** ● Шил арчигч ашиглан салхины шилнээс гадны биетийг цэвэрлэнэ. ● Агааржуулалтын систем ашиглан салхины шилний цан арилгана. ● Капот хааж урд камерыг халхлах аливаа наалтыг авна.

"System Stopped Front Camera Out of Temp. Range Wait until Normal Temperature"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ. ● PCS систем ● LDA систем ● LTA систем ● AHB холын гэрэл ● AHS холын гэрэл ● Динамик радарын хурд баригч ● RSA систем*	● **Дараах арга хэмжээг авна.** ● Халуун наранд удаан зогссон зэргээр урд камер халсан үед агааржуулалтын систем ашиглан урд камерын ойр орчмын хэмийг буулгана ● Автомашиныг зогсоолд байрлуулах үед нарны хаалт ашигласан нөхцөлд нарны хаалтны төрлөөс хамаарч халуун хуримтлагдаж урд камерын ойр орчмыг хэт халаах магадлалтай ● Хэт хүйтэн цаг агаарт автомашиныг зогсоолд байрлуулсан зэргээр урд камер хэт хөрсөн үед агааржуулалтын систем ашиглан камерын ойр орчмын хэмийг нэмнэ

*:Тоноглогдсон автомашинд

"System Stopped Front Radar Sensor Blocked Clean Radar Sensor"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах аль нэг системийн ажиллагаа цуцлагдсаныг илтгэнэ. ● PCS систем ● LDA систем ● LTA систем ● AHB автомат их гэрэл ● AHS их гэрэл ● Динамик радарын хурд баригч	● **Дараах арга хэмжээг авна.** ● Радарын мэдрэгч болон таганд гадны биет тогтсон эсэхийг шалгаж шаардлагатай тохиолдолд цэвэрлэнэ.→ X.351 ● Элсэн цөл, өвстэй тал, орон сууцны хороолол зэрэг бусад автомашин, эд зүйлтэй ойр зайтай явах үед тус мэдээлэл гарна. Тус мэдээлэл нь бусад автомашин, эд зүйл автомашины ойр орчимд байхгүй үед дэлгэцнээс унтарна.

"System Stopped Front Radar Sensor Out of Temp. Range Wait until Normal Temperature"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах системүүдийн ажиллагаа цуцлагдсаныг илтгэнэ. ● PCS систем ● LDA систем ● LTA систем ● AHB автомат холын гэрэл ● AHS холын гэрэл ● Динамик радарын хурд баригч	● **Радарын мэдрэгчийн температур ажиллах боломжтой хэмжээнээс давсан. Температур хэвийн түвшинд буцтал хүлээнэ.**

"System Stopped Front Radar In Self Calibration See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах аль нэг системийн ажиллагаа цуцлагдсаныг илтгэнэ. ● PCS систем ● LDA систем ● LTA систем ● AHB холын гэрэл ● AHS холын гэрэл ● Динамик радарын хурд баригч	● **Дараах арга хэмжээг авна.** ● Радарын мэдрэгч, радарын мэдрэгчийн таган дээр гадны биет тогтсон эсэхийг шалгаж шаардлагатай үед цэвэрлэнэ.→ X.351 ● Радарын мэдрэгчийн тусгал алдагдсан ба жолоодлогын үед автоматаар тохируулагдана. Үргэлжлүүлэн жолоодно.

"Parking Assist Unavailable Low Visibility See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ. ● RCD арын камерын мэдрэгчийн функц* ● PKSB зогсоолд байрлуулахад туслах тоормос*	● **Урд/хойд камераас аливаа бохирдол, гадны биетийг цэвэрлэнэ.**

"Cruise Control Unavailable See Owner's Manual"

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ. ● Динамик радарын хурд баригч ● Хурд баригч Жолоодлогод туслах товч олон давтан дарсан үед анхааруулга гарна.	● **Жолоодлогод туслах товч хурдан чанга дарна.**

*:Тоноглогдсон автомашинд

Стартер мотор ажиллаж байгаа ч хөдөлгүүр асахгүй үед

Шалтгаан	Авах арга хэмжээ
Шатахууны саванд хангалттай шатахуун байхгүй байж болно.	Шатахуун цэнэглэнэ.
Хөдөлгүүр баяжсан байж болно.	Хөдөлгүүр асаах зөв үйлдлийн дагуу хөдөлгүүр дахин асаахаар оролдоно.
Хөдөлгүүрийн иммобилайзер системд доголдол үүссэн байж болно.	● **Түлхүүр металл эд зүйлсэд хүрсэн, халхлагдсан үед эдгээрийг түлхүүрээс салгана.** ● **Бусад автомашины түлхүүр (транспондер чиптэй) автомашины хамгаалалтын системд хүрсэн, эсвэл ойр байгаа үед холдуулна.**

Холбоотой холбоосууд

Шатахуун цэнэглэх(Х. 200)

Хөдөлгүүр асаах(Х. 144)

Анхааруулга гарах үед(Х. 575)

Арааны удирдлагын системд доголдол үүссэн байж болзошгүй гэж бодсон үед

Дараах аль нэг нөхцөлд арааны удирдлагын системд доголдол үүсч болзошгүй.

Автомашиныг даруй аюулгүй, тэгш газар зогсоож зогсоолын тоормос залгаад өөрийн Lexus дилерт хандана уу.

1. Мэдээллийн дэлгэц дээр арааны удирдлагын системийг илтгэх анхааруулга гарсан үед.
2. Тодорхой секундээс удаан хугацаанд арааны байрлал сонгогдоогүйг дэлгэцээр харуулна.

Стартер удаан эргэж хөдөлгүүр асахгүй үед

Шалтгаан	Авах арга хэмжээ
Аккумуляторын цэнэг суусан байж болно.	Холбогч кабель ашиглан хөдөлгүүр асаах.
Аккумуляторын шонгийн боолт суларсан, эсвэл шон зэвэрсэн.	Аккумуляторын шонгийн боолт суларсан, эсвэл шон зэвэрсэн эсэхийг шалгана.

Холбоотой холбоосууд

Аккумуляторын цэнэг суусан үед(Х. 591)

Аккумулятор суусан үед автомашин асаах(Х. 607)

Аккумуляторын цэнэг суусан үед(Х. 591)

Стартер мотор ажиллахгүй ба хөдөлгүүр асахгүй үед

Шалтгаан	Авах арга хэмжээ
Электрон түлхүүрийн зайны цэнэг суусан, гал хамгаалагч шатсан зэрэг цахилгааны асуудлаас шалтгаалан хөдөлгүүр асаах систем доголдсон байж болно.	Хөдөлгүүрийг түр зуурын аргаар асаах боломжтой.
Аккумуляторын аль нэг, эсвэл 2 шон салсан.	Аккумуляторын шон салсан эсэхийг нягтлана.
Аккумуляторын цэнэг суусан байж болно.	Холбогч кабель ашиглан хөдөлгүүр асаана.
Жолоо түгжих системд доголдол үүссэн байж болно.	Та өөрийн Lexus дилерт хандана уу. Засах боломжгүй, эсвэл засах арга нь тодорхойгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Холбоотой холбоосууд

Онцгой нөхцөлд хөдөлгүүр асаах(X. 589)

Электрон түлхүүр хэвийн ажиллахгүй үед хөдөлгүүр асаах(X. 590)

Аккумуляторын цэнэг суусан үед(X. 591)

Аккумулятор суусан үед автомашин асаах(X. 607)

Аккумуляторын цэнэг суусан үед(X. 591)

Онцгой нөхцөлд хөдөлгүүр асаах

Хөдөлгүүр асахгүй үед хэрэв асаах товч хэвийн ажиллаж байгаа нөхцөлд дараах үйлдлээр хөдөлгүүрийг асаах боломжтой.

Хөдөлгүүр асаах энэ аргыг зөвхөн онцгой нөхцөлд ашиглана.

1 **Зогсоолын тоормосны товч татаж зогсоолын тоормос залгагдсан байгааг нягтлана.**

Зогсоолын тоормосны индикатор асна.

2 **Араа P-д байгааг нягтлана.**

3 **Асаах товчийг ACC горимд шилжүүлнэ.**

4 **Тоормосны дөрөө гишгэнгээ асаах товчийг 15 секунд орчим дарна.**

Дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч хөдөлгүүр асахгүй үед системд доголдол үүссэн байж болно.

Та автомашинаа даруй өөрийн Lexus дилер дээрээ шалгуулна уу.

Электрон түлхүүр хэвийн ажиллахгүй үед хөдөлгүүр асаах

1 **Араа P байрлалд байгааг нягтлаад тоормос гишгэнэ.**

2 **Асаах товчинд электрон түлхүүрийн Lexus эмблемтэй талыг хүргэнэ.**

Электрон түлхүүр танигдах үед дохио дуугарах ба асаах товч ON горимд шилжинэ.

Хэрэв Smart entry & start системийг өөрчлөх боломжтой тохиргоогоор цуцласан үед асаах товч ACC горимд шилжинэ.



3 **Хаазны дөрөөг сайтар гишгээд мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарсныг нягтлана.**

4 **Асаах товч дарна.**

Дээрх үйлдлийг хийсэн ч хөдөлгүүр асахгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

МЭДЭЭЛЭЛ

■ Хөдөлгүүр унтраах

Арааг P байрлалд шилжүүлээд зогсоолын тоормос залгаж хөдөлгүүр хэвийн унтраах аргаар унтраана.

■ Электрон түлхүүрийн зай

Дээрх нь түр зуурын арга хэмжээ тул электрон түлхүүрийн зайны цэнэг суусан үед даруй шинээр солих нь зүйтэй.

■ Асаах товчны горим солих

Тоормосны дөрөөг суллаж асаах товчийг дээр дурдсан **4**-р үйлдлийн дагуу дарна. Хөдөлгүүр асахгүй ба товч дарах бүрт асаах товчны горим өөрчлөгдөнө.

Холбоотой холбоосууд

Электрон түлхүүрийн зай солих(X. 602)

Салоны гэрэл, их гэрэл бүдэг ба хөдөлгүүр асахгүй үед

Шалтгаан	Авах арга хэмжээ
Аккумуляторын цэнэг суусан байж болно.	Холбогч кабель ашиглан хөдөлгүүр асаана.
Аккумуляторын шонгийн холболт суларсан, зэвэрсэн байж болно.	Аккумуляторын шонгийн холболт суларсан, зэвэрсэн эсэхийг нягтлана.

Холбоотой холбоосууд

Аккумулятор суусан үед автомашин асаах(X. 607)
Аккумуляторын цэнэг суусан үед(X. 591)
Аккумуляторын цэнэг суусан үед(X. 591)
Түлхүүрийн төрлүүд(X. 70)
Хаалга нээх/хаах(X. 79)
Механик түлхүүр ашиглах(X. 605)
Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед(X. 612)
Аккумуляторын шон салгах үед(X. 594)
Дахин тохируулах зүйлс(X. 696)

Аккумуляторын цэнэг суусан үед

⚠ АЮУЛТАЙ

■ Аккумулятор солих үед

- Аккумуляторын бэхэлгээнд агааржуулалтын таг, индикатор ойр байгаа үед аккумуляторын шингэн асгарч болзошгүй.
- Аккумулятор солих тухай дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерт хандаж авна уу.

Аккумуляторын цэнэг суусан үед арааг өөр байрлалд шилжүүлэх боломжгүй болно.

Энэ нөхцөлд урд дугуй түгжигдэх тул урд 2 дугуйг өргөлгүйгээр чирүүлэх боломжгүй.

МЭДЭЭЛЭЛ

■ Аккумулятор салгасан, эсвэл аккумуляторын цэнэг суусан үед

- Аккумулятор сольсны дараа зарим нөхцөлд Smart entry & start системээр хаалганы түгжээ тайлагдахгүй байж болно.

Түлхүүрийн алсын удирдлага, эсвэл механик түлхүүрээр хаалга түгжих буюу тайлна.

- Аккумулятор салгаад дахин холбосны дараа асаах товч даран анхны оролдлогоор хөдөлгүүр асахгүй үед электрон түлхүүрийн Lexus эмблемтэй талыг асаах түлхүүрт хүргээд хөдөлгүүр асаана.
- Асаах товчны горим автомашины санах ойд хадгалагддаг.

  Аккумулятор цэнэглэсэн, сольсны дараа аккумулярын цэнэг суух, эсвэл салгахаас өмнөх горимд асаах товч буцдаг.

  Аккумулятор салгахаас өмнө асаах товчийг унтраана.

  Аккумуляторын цэнэг суухаас өмнөх асаах товчны горим тодорхойгүй үед ялангуяа аккумулятор буцаан холбох үед анхаарал болгоомжтой байна.
- Зарим системийн тохиргоог анхны тохиргоонд тохируулах шаардлагатай.
- Stop & Start системтэй автомашин:

  Stop & Start систем 1 цагийн хугацаанд хөдөлгүүр автоматаар унтраахгүй байж болно.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

- Хөдөлгүүр унтраастай үед их гэрэл, аудио системийг унтраана.
- Хөдөлгөөний ачаалал ихтэй замаар явах зэргээр бага хурдаар удаан явах үед шаардлагагүй электрон төхөөрөмжүүдийг унтраана.

■ Аккумуляторын цэнэг суусан үед

- Smart entry & start систем, түлхүүрийн алсын удирдлагаар хаалга түгжих, тайлах боломжгүй ба хаалга нээх товч ажиллахгүй. Механик түлхүүрээр гар аргаар хаалга нээх бариулын ажиллагааг идэвхжүүлна/цуцлана. Гар аргаар хаалга нээх бариул идэвхжүүлснээр хаалга нээх боломжтой.
- Компьютерт бүртгэгдсэн мэдээллүүд устана.

  Аккумуляторын цэнэг суусан үед та өөрийн Lexus дилер дээрээ оношилгоо хийлгэнэ үү.
- Зарим системийн тохиргоог анхны тохиргоонд тохируулах шаардлагатай.

■ Аккумулятор цэнэглэх

Аккумуляторт хуримтлагдсан цэнэг нь автомашин ашиглагдаагүй үед зарим электрон төхөөрөмжүүдийн суурь ажиллагаа болон бусад шалтгаанаар бага багаар алдагддаг.

Автомашиныг удаан хугацаанд ашиглаагүй үед аккумуляторын цэнэг сууж хөдөлгүүр асаах боломжгүй болж болно.

(Автомашин явах үед аккумулятор автоматаар цэнэглэгдэнэ.)

■ **Аккумулятор солих**

- Stop & Start системтэй автомашин: Stop & Start системд зориулагдсан оригинал, эсвэл дүйцэх техник үзүүлэлттэй аккумулятор ашиглана. Үл тохирох аккумулятор ашигласан нөхцөлд аккумуляторыг хамгаалах үүднээс Stop & Start системийн функцууд хязгаарлагдаж болно. Мөн аккумуляторын ажиллагаа муудаж хөдөлгүүр асахгүй болж болно. Дэлгэрэнгүйг өөрийн Lexus дилерээс тодруулна уу.
- Stop & Start системтэй автомашин: Өмнөхтэй адил овор хэмжээтэй (LN3), (65Ah) ба түүнээс илүү хүчин чадалтай дүйцэх 20HR) буюу 20 ба түүнээс цагийн багтаамжтай, мөн (603A)-с дээш хүчин чадалтай дүйцэх үзүүлэлттэй (CCA) аккумулятор ашиглана.

  Stop & Start системгүй автомашин: Өмнөхтэй адил овор хэмжээтэй (LN3), (70Ah) ба түүнээс илүү хүчин чадалтай дүйцэх 20HR) буюу 20 ба түүнээс цагийн багтаамжтай, мөн (592A)-с дээш хүчин чадалтай дүйцэх үзүүлэлттэй (CCA) аккумулятор ашиглана.

  - Овор хэмжээ өөр үед аккумулятор бүрэн бэхлэгдэхгүй байж болно.
  - 20 цагийн багтаамж бага нөхцөлд богино хугацаанд ашиглаагүй үед ч аккумуляторын цэнэг суух, улмаар хөдөлгүүр асахгүй байж болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу.

Аккумуляторын цэнэг суусны дараа автомашиныг гадна талаас түгжих боломжгүй үед

Smart entry & start систем, эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар түгжих боломжтой.

Жолоочийн хаалганы ажиллагааг цуцлах

1 **Хуванцар карт зэргийг хаалганы бариулын завсар хийгээд тагийг салгаж авна.**

Гэмтээхээс сэргийлж таганд хэт хүчээр нөлөөлж болохгүй.



2 **Механик түлхүүр ашиглан хаалганы түгжээг түгжих байрлалд эргүүлж хаалганы ажиллагааг цуцлана.**



3 Хаалга нээгдэх боломжгүй болсныг нягтлана.

Жолоочийн хаалганаас бусад хаалганы ажиллагааг идэвхгүй болгох

1 Хаалга нээнэ. Механик түлхүүр ашиглан тагийг зурагт үзүүлсний дагуу хажуу тийш гүйлгэнэ.

Гэмтээхээс сэргийлж таганд хэт хүчээр нөлөөлж болохгүй.



2 Механик түлхүүрийг хийнэ.



3 Механик түлхүүрийг гаргаад онцгой нөхцөлд түгжих түгжээний тагийг анхны байрлалд буцаана.



4 Бүх хаалга нээх боломжгүйг нягтлана.

Аккумуляторын шон салгах үед

Аккумулятор салгах үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Аккумулятор салгах үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Электрон түлхүүр (механик түлхүүр) автомашин дотор цоожлогдохоос сэргийлж аккумуляторын шон салгахаас өмнө автомашинаас гаргана.



Электрон түлхүүр (механик түлхүүр) автомашин дотор үлдээсэн нөхцөлд хаалганы дотор бариулаар хаалга нээх үүднээс цонх нээлттэй орхино.



⚠ АЮУЛТАЙ

■ Аккумуляторын шон салгах үед

Хасах (-) шонг эхлээд салгана. Нэмэх (+) шон салгах үед (+) терминал ойр орчмын металл гадаргууд хүрсэн үед тогонд цохиулах, оч үсрэх, улмаар галын аюул үүсгэж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

■ Аккумулятор шатах, дэлбэрэхээс зайлсхийх

Аккумуляторос гарч байж болзошгүй шатамхай хийнд санамсар болгоомжгүй гал авалцахаас сэргийлж дараах анхааруулгыг мөрдөнө:

Аккумуляторын ойр орчимд тамхи татах, шүдэнз, асаагуур ашиглах, ил гал гаргахыг хориглоно.

■ Аккумуляторын анхааруулга

Аккумулятор нь хортой, идэмхий хүчиллэг электролит болон хар тугалгын орц, агууламжтай эд ангиудаас бүрддэг. Аккумулятортой харьцах үед дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:

- Аккумулятортой харьцах үед цаг ямагт хамгаалалтын шил зүүж хэрэглэх ба арьс, хувцас болон автомашины их биед аккумуляторын шингэн (хүчил) хүргэхгүй.
- Аккумулятор дээрээс тонгойж харахыг хориглоно.
- Хэрэв аккумуляторын шингэн нүд, арьсанд хүрсэн үед даруй усаар угаах ба эмнэлгийн тусламж даруй авна.

  Эмнэлгийн тусламж авах хүртэл нойтон пролон, даавуу тухайн хэсэг дээр тавина.

⚠ АЮУЛТАЙ

- Аккумуляторын бэхэлгээ, шон, бусад эд ангиудтай харьцсаны дараа гараа заавал угаана.
- Аккумуляторт бага насны хүүхэд ойртуулахыг хориглоно.

МЭДЭЭЛЭЛ

Аккумуляторын шон салгасан үед

- Аккумуляторын шон салгасан үед Smart entry & start систем, түлхүүрийн алсын удирдлагаар хаалга түгжих, түгжээ тайлах боломжгүй болох ба мөн хаалга нээх товч ажиллахгүй.

  Аккумуляторын шон салгахаас өмнө автомашинаас электрон түлхүүр (механик түлхүүр) гаргана.

  Электрон түлхүүр (механик түлхүүр) автомашин дотор үлдээсэн нөхцөлд хаалганы дотор бариулаар хаалга нээх үүднээс цонх нээлттэй орхино.
- Аккумуляторын шон салгаад дахин залгасан даруйд Smart entry & start системээр хаалганы түгжээ тайлах боломжгүй байж болно.

  Хаалганы түгжээ тайлагдахгүй үед түлхүүрийн алсын удирдлага, эсвэл механик түлхүүрээр хаалга түгжээд дахин тайлна.
- Аккумуляторын шон салгасан үед компьютерт бүртгэгдсэн мэдээллүүд устгагдана.
- Зарим системийг анхны тохиргоонд буцаах шаардлагатай.

Салоны гэрэл, их гэрэл болон хөдөлгүүр асахгүй үед

Шалтгаан	Авах арга хэмжээ
Аккумуляторын цэнэг суусан байж болно.	Холбогч кабель ашиглан хөдөлгүүр асаана. Тухайн асуудлыг шийдэх боломжгүй, эсвэл хүндрэлтэй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.
Аккумуляторын аль нэг, эсвэл хоёр шон салсан байж болно.	Аккумуляторын шон салсан эсэхийг нягтлана. Тухайн асуудлыг шийдэх боломжгүй, эсвэл хүндрэлтэй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.
Жолооны хүрд түгжих системд доголдол үүссэн байж болно.	Та өөрийн Lexus дилерт хандана уу.

Холбоотой холбоосууд

Аккумуляторын цэнэг суусан үед(X. 591)
Аккумулятор суусан үед автомашин асаах(X. 607)
Аккумуляторын цэнэг суусан үед(X. 591)
Түлхүүрийн төрлүүд(X. 70)
Хаалга түгжих/тайлах(X. 82)
Хаалга нээх/хаах(X. 79)
Механик түлхүүр ашиглах(X. 605)
Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед(X. 612)
Аккумуляторын шон салгах үед(X. 594)
Дахин тохируулах зүйлс(X. 696)

Дуут дохио сул дуугарах, хөдөлгүүр асахгүй үед

Шалтгаан	Авах арга хэмжээ
Аккумуляторын цэнэг суусан байж болно.	Холбогч кабель ашиглан хөдөлгүүр асаана.
Аккумуляторын шонгийн бэхэлгээ суларсан, шон зэвэрсэн.	Аккумуляторын шон суларсан, шон зэвэрсэн.

Холбоотой холбоосууд

Аккумуляторын цэнэг суусан үед(Х. 591)

Аккумулятор суусан үед автомашин асаах(Х. 607)

Аккумуляторын цэнэг суусан үед(Х. 591)

Дуут дохио дуугарахгүй ба хөдөлгүүр асахгүй үед

Шалтгаан	Авах арга хэмжээ
Аккумуляторын цэнэг сууж болно	Холбогч кабель ашиглан хөдөлгүүр асаах. Тухайн эвдрэл засагдахгүй, эсвэл засах арга тодорхойгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.
Аккумуляторын нэг, эсвэл хоёр шон салгагдсан.	Аккумуляторын шонгийн бэхэлгээ сул байгаа эсэхийг шалгана. Тухайн эвдрэл засагдахгүй, эсвэл засах арга тодорхойгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.
Жолооны хүрд түгжих систем доголдсон байж болзошгүй.	Та өөрийн Lexus дилерт хандана уу.

Холбоотой холбоосууд

Аккумуляторын цэнэг суусан үед(X. 591)
Аккумулятор суусан үед автомашин асаах(X. 607)
Аккумуляторын цэнэг суусан үед(X. 591)

Дугуй хагарсан үеийн анхааруулга

Тус автомашин нь нөөц дугуйгүй бөгөөд дугуй хагарсан ч, хий гарсан ч явах боломжтой дугуйгаар үргэлжлүүлэн явах боломжтой. Энэ нөхцөлд хурдаа хасах ба анхаарал болгоомжтой жолоодно.

Аль нэг дугуй хагарсан үед ойр байрлах Lexus дилер, эсвэл албан ёсны дугуйны дилерт хандана уу.

Дугуйны даралт анхааруулах гэрэл ассанаас хойш 80 км/ц (50 mph) хүртэлх хурдаар 80 км (50 miles) зайд явах боломжтой.

Хий гарсан ч явах боломжтой дугуй нь хажуу талдаа тэмдэгтэй байдаг.



МЭДЭЭЛЭЛ

Зарим нөхцөлд (хэм өндөр зэрэг)

Та 80 км (50 miles) хүртэлх зайд явах боломжгүй байж болно.

АНХААР

Дугуй солих үед

Обуд, дугуй, дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч салгах, буцааж угсрах үед буруу үйлдлээс шалтгаалж дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч гэмтэх тул та өөрийн Lexus дилерт хандана уу.

Энхэл донхолтой замаар явах үед

Дугуй хагарсан үед автомашин өндөр хэвийн үеэс намсана. Автомашины доод талыг цохихоос сэргийлнэ.

Дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийг гэмтлээс сэргийлэх

Шингэн нөхөөс ашиглан дугуй нөхсөн тохиолдолд дугуйны даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийн хэвийн ажиллагаа алдагдаж болно. Шингэн нөхөөс ашигласан тохиолдолд даруй өөрийн Lexus дилер, эсвэл бусад мэргэжлийн засвар үйлчилгээний төвд хандана уу. Дугуй засах, эсвэл солих үед дугуйны даралт анхааруулах хавхлаг, дамжуулагчийг мөн солино.

Автомашины түлхүүр гээсэн үед

Хэрэв та механик түлхүүрээ гээсэн тохиолдолд Lexus дилер дээр өөр механик түлхүүр, эсвэл түлхүүрийн пайзны дугаараар оригинал механик түлхүүр шинээр хийх боломжтой.

Түлхүүрийн пайзыг түрийвч зэрэг аюулгүй газар хадгалах ба автомашинд хадгалж болохгүй.

⚠ АНХААР

Электрон түлхүүрээ гээсэн үед автомашин хулгайд өртөх магадлал туйлын өндөр болно. Даруй өөрийн Lexus дилертээ автомашины үлдсэн бусад электрон түлхүүр, түлхүүр картын* хамтаар хандана уу.

* : Тоноглогдсон автомашинд

Электрон түлхүүрээр хаалга/цонх/дээврийн нээлхий удирдагдахгүй үед

Электрон түлхүүр ба автомашин хоорондын долгион дамжуулалтад саад учирсан, эсвэл зай сууснаас электрон түлхүүр ашиглах боломжгүй үед Smart entry & start систем болон түлхүүрийн алсын удирдлага ашиглах боломжгүй.

Өөрчлөх боломжтой тохиргоогоор Smart entry & start системийг цуцлах боломжтой.

Энэ нөхцөлд өөрчлөх боломжтой тохиргоогоор Smart entry & start системийг идэвхжүүлнэ.

⚠ АНХААР

Smart entry & start системийн доголдлоос шалтгаалан автомашинаа Lexus дилертээ үзүүлэх үед бүртгэгдсэн бүх электрон түлхүүрийн (түлхүүр карт мөн хамаарна) хамт аваачна.

Электрон түлхүүрийг түлхүүрийн зайны цэнэг хэмнэх горимд тохируулсан байж болно.

Зайны цэнэг хэмнэх горимд тохируулсан үед тохиргоог цуцлана.

Электрон түлхүүрийн зайны цэнэг суусан байж болно.

- **Зайг шинээр солино.**
- **Механик түлхүүр ашиглах.**

Аккумуляторын цэнэг суусан байж болно.

Холбогч кабель ашиглан хөдөлгүүр асаана.

Электрон түлхүүрийн зай солих

Түлхүүрийн зайны цэнэг суусан үед шинээр солино.

Түлхүүр картын зай зөвхөн Lexus дилер дээр байдаг. Та өөрийн Lexus дилер дээрээ зайг солиулж болно.

Бэлдэх зүйлс:

- Хасах толгойтой халив
- Хасах толгойтой жижиг халив
- Литийн зай CR2032

МЭДЭЭЛЭЛ

■ CR2032 литийн зай ашиглах

Түлхүүрийн зайг та өөрийн Lexus дилер, цахилгаан барааны болон зургийн аппаратны дэлгүүрээс худалдан авах боломжтой.

- Үйлдвэрлэгчийн ашиглахыг зөвлөж буй, эсвэл түүнтэй адил болон дүйцэх төрлийн зай ашиглана.
- Хуучин зайг тухайн улс орны хуулийн дагуу хаяж устгана.

■ **Электрон түлхүүрийн зай суусан үед**

Дараах шинж тэмдэг илэрч болно:

- Smart entry & start систем болон түлхүүрийн алсын удирдлага хэвийн ажиллахгүй.
- Системийн мэдрэх хүрээ багасна.

1 Механик түлхүүрийг гаргана.



2 Тагийг салгана.

Түлхүүрийг гэмтээхээс сэргийлж хасах толгойтой халивны үзүүрийг даавуугаар жийрэглэнэ.



3 Цэнэг суусан зайг гаргана.

Шинэ зайг “+” талыг дээш харуулан хийнэ.



⚠ АЮУЛТАЙ

■ Зайтай холбоотой анхааруулга

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

- Зайг залгиж болохгүй. Химийн түлэгдэлд хүргэнэ.
- Электрон түлхүүрт товчин, эсвэл зоосон зай ашиглагддаг. Зайг залгисан үед 2 цагийн дотор химийн түлэгдэл үүсгэх ба амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.
- Шинэ ба хуучин зайг хүүхдийн гар хүрэхгүй газар байлгана.
- Таг бүрэн хаагдахгүй үед түлхүүрийг ашиглаж болохгүй бөгөөд хүүхдийн гар хүрэхгүй газар байлгаж Lexus дилерт хандана.
- Санамсаргүйгээр зай залгисан, биеийн аль нэг хэсэгтээ оруулсан үед нэн даруй эмнэлгийн яаралтай тусламж авна уу.

■ Зай дэлбэрэх, шатамхай шингэн, эсвэл хий гарахаас сэргийлэх

- Зөвхөн хуучин зайтай адил төрлийн зай ашиглана. Буруу төрлийн зай ашигласан үед зай дэлбэрэх аюултай.
- Өндөрлөг газар зэрэг хэт бага даралттай газар, эсвэл хэт өндөр хэмтэй газар зайг байлгаж болохгүй.
- Зайг түлэх, эвдлэх, хуваж зүсэхийг хориглоно.

⚠ АНХААР

■ Түлхүүрийн зай солих солих үед

Тохирох хэмжээтэй хасах халив ашиглана. Хэт хүчтэй дарах нь зайг хэлбэр алдах, гэмтэхэд хүргэнэ.

■ Түлхүүрийн зай солисоны дараа

Ослоос сэргийлж дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:

- Зөвхөн гар хуурай үед зайтай харьцана.

  Чийг нь зайнд зэврэлт үүсгэх аюултай.
- Түлхүүр доторх бусад хэсгүүдэд хүрэх, хөдөлгөхийг хориглоно.
- Зайны терминалуудыг далийлгах, хэлбэрийг нь өөрчлөхийг хориглоно.

Механик түлхүүр ашиглах



Түгжээ тайлах товчийг даран механик түлхүүрийг сугалан гаргана.

Механик түлхүүрийг зөвхөн нэг тийш харуулан хийх боломжтой ховил электрон түлхүүрт байдаг. Түлхүүрийн нүхэнд механик түлхүүр орохгүй үед механик түлхүүрийг нөгөө тийш нь харуулан хийнэ. Механик түлхүүрийг хэрэглэсний дараа электрон түлхүүрт буцаан хийж хадгалах ба электрон түлхүүрээс салгаж болохгүй. Электрон түлхүүрний зай суусан, эсвэл entry функцийн хэвийн ажиллагаа алдагдсан, эсвэл аккумулятор суусан үед таньд механик түлхүүр шаардлагатай болно.

⚠ АНХААР

Түлхүүр картанд механик түлхүүр хийх үед хэт хүчтэй дарж болохгүй. Түлхүүр картыг гэмтээнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Буруу түлхүүр ашигласан үед

Цоожны механизм дотор түлхүүрийн цилиндрт чөлөөтэй эргэж түгжээ тайлагдахгүй.

■ Түлхүүр карт

- Механик түлхүүр гаргахад хүндрэлтэй үед түгжээ тайлах товчийг балны үзүүр зэргээр дарна. Мөн авах боломжгүй үед зоос зэргийг ашиглаж болно.
- Түгжээ тайлах товчийг дарангаа механик түлхүүрийг түлхүүр картанд хийнэ.



Дохиолол

Малайз, ӨАБНУ: Механик түлхүүрээр хаалга түгжих нь дохиоллын системийг идэвхжүүлэхгүй. Дохиолол идэвхтэй үед механик түлхүүрээр хаалганы түгжээ тайлсан нөхцөлд дохиолол ажиллаж болно.

Малайз, ӨАБНУ-с бусад: Дохиолол идэвхтэй үед механик түлхүүрээр хаалганы түгжээ тайлсан нөхцөлд дохиолол 10 секунд ажиллана.

Хаалга түгжих/тайлах

1 Хаалганы бариулын завсар хуванцар карт зэргийг хийж тагийг авна.

Гэмтээхээс сэргийлж таганд хэт хүчээр харьцаж болохгүй.



2 Механик түлхүүрээр дараах үйлдлийг хийнэ:



1 Бүх хаалганы түгжээ тайлах
2 Бүх хаалга түгжих

МЭДЭЭЛЭЛ

Түлхүүртэй холбоотой функц



1 Цонх, дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий нээх* (эргүүлээд барина)*1
2 Цонх, дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий хаах* (эргүүлээд барина)*1

* : Тоноглогдсон автомашинд

*1 : Тус тохиргоог Lexus дилер дээр хийнэ.

⚠ АЮУЛТАЙ

Цонх, дээврийн нээлхий, эсвэл панорамик дээврийн нээлхийд зорчигч биеээ хавчуулах эрсдэл байхгүйг нягтлаад ажиллуулна. Мөн механик түлхүүр ашиглан хүүхдээр удирдуулж болохгүй. Хүүхэд болон бусад зорчигчид цонх, дээврийн нээлхий, эсвэл панорамик дээврийн нээлхийд хавчуулагдах аюултай.

Аккумулятор суусан үед автомашин асаах

Хэрэв таньд холбогч кабель байгаа ба аккумулятортой холбож асаах өөр автомашин байгаа үед дараах дарааллаар холбож асаах боломжтой.

МЭДЭЭЛЭЛ

Хөдөлгүүрийг түлхэж асаах боломжгүй.

⚠ АЮУЛТАЙ

■ Аккумуляторын гал, дэлбэрэлтээс сэргийлэх

Аккумулятороос ялгарч байж болзошгүй шатамхай хийнд гал авалцахаас сэргийлж дараах анхааруулгыг мөрдөнө:

- Холбогч кабелийг зөв холбосон эсэх, мөн кабель тухайн шонгоос өөр эд ангитай нийлээгүй эсэхийг нягтлана.
- Холбогч кабелийг “+” болон “-” шонтой хооронд нь холбохыг хориглоно.
- Холбогч кабелийн “+” утасны нөгөө үзүүрийг автомашины аливаа эд анги, будаггүй гадаргууд хүрэхээс сэргийлнэ.
- Аккумуляторын ойр орчимд ил гал, шүдэнз, тамхины асаагуур, тамхи татахыг хориглоно.

■ Аккумуляторын анхааруулга

Аккумулятор нь хортой, идэмхий хүчиллэг электролит болон хар тугалгын орц, агууламжтай эд ангиудаас бүрддэг. Аккумулятортой харьцах үед дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:

- Аккумулятортой харьцах үед цаг ямагт хамгаалалтын шил зүүж хэрэглэх ба арьс, хувцас болон автомашины их биед аккумуляторын шингэн (хүчил) хүргэхгүй.
- Аккумулятор дээрээс тонгойж харахыг хориглоно.
- Хэрэв аккумуляторын шингэн нүд, арьсанд хүрсэн үед даруй усаар угаах ба эмнэлгийн тусламж даруй авна. Эмнэлгийн тусламж авах хүртэл нойтон пролон, даавуу тухайн хэсэг дээр тавина.
- Аккумуляторын бэхэлгээ, шон, бусад эд ангиудтай харьцсаны дараа гараа заавал угаана.

⚠ АЮУЛТАЙ

- Аккумуляторт бага насны хүүхэд ойртуулахыг хориглоно.

1 Электрон түлхүүрийг биедээ авна.

Холбогч кабель холбох үед нөхцөл байдлаас хамаарч дохиолол ажиллах, хаалга түгжигдэх магадлалтай.



2 Капот нээнэ.

3 Аккумуляторын (+) шонгийн тагийг авна.

▶ NX250



▶ NX350



▶ NX200



4 Холбогчийн нэмэх утасны хавчаарыг өөрийн автомашины A -д холбох ба холбогчийн нэмэх утасны нөгөө үзүүрийг холбох автомашины B -д холбоно. Дараа нь холбогчийн

хасах утасны хавчаарыг холбох автомашины C -д холбоод хасах утасны нөгөө үзүүрийг холбоно D

▶ NX200



A Холбож асаах шон (таны автомашин)

B Аккумуляторын нэмэх (+) шон (холбох автомашин)

C Аккумуляторын хасах (-) шон (холбох автомашин)

D Таны автомашины зурагт заасан холбож асаах шон болон аливаа хөдлөх эд ангиас хол, будаггүй, металл, хөдөлгөөнгүй эд анги

⚠ АНХААР

■ Холбогч кабельтай харьцах үед

Холбогч кабель холбох, салгах үед хөргөлтийн сэнс болон ременьтэй ороцолдохоос сэргийлнэ.

▶ NX250



A Холбож асаах шон (таны автомашин)

B Аккумуляторын нэмэх (+) шон (холбох автомашин)

C Аккумуляторын хасах (-) шон (холбох автомашин)

D Таны автомашины зурагт заасан холбож асаах шон болон аливаа хөдлөх эд ангиас хол, будаггүй, металл, хөдөлгөөнгүй эд анги

⚠ АНХААР

■ Холбогч кабельтай харьцах үед

Холбогч кабель холбох, салгах үед хөргөлтийн сэнс болон ременьтэй ороолдохоос сэргийлнэ.

▶ NX350



A Холбож асаах шон (таны автомашин)

B Аккумуляторын нэмэх (+) шон (холбох автомашин)

C Аккумуляторын хасах (-) шон (холбох автомашин)

D Таны автомашины зурагт заасан холбож асаах шон болон аливаа хөдлөх эд ангиас хол, будаггүй, металл, хөдөлгөөнгүй эд анги

⚠ АНХААР

■ Холбогч кабельтай харьцах үед

Холбогч кабель холбох, салгах үед хөргөлтийн сэнс болон ременьтэй ороолдохоос сэргийлнэ.

5 Холбох автомашины хөдөлгүүр асаах ба хөдөлгүүрийн эргэлтийг бага зэрэг нэмж цэнэг суусан аккумуляторыг 5 минут цэнэглэнэ.

6 Асаах товчны off горимд аль нэг хаалга нээгээд хаана.

7 Холбох автомашины хөдөлгүүрийн эргэлтийг өндөр хэвээр барингаа өөрийн автомашины асаах товчийг ON горимд шилжүүлнэ.

8 Хөдөлгүүр ассаны дараа холбогч кабелийг холбох үеийн эсрэг дарааллаар салгана.

Хөдөлгүүр ассаны дараа та өөрийн Lexus дилерт нэн даруй хандаж оношлуулна уу.

Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед

Хаалга нээх товчоор хаалга нээгдэхгүй үед гар аргаар тайлах бариулаар нээх боломжтой.

Гар аргаар хаалга нээх бариул ашиглах

⚠ АНХААР

Хэвийн нөхцөлд гар аргаар хаалга нээх бариулаар хаалга нээх боломжгүй. Гар аргаар хаалга нээх бариулын ажиллагааг дараах дарааллаар идэвхжүүлнэ. Дараах үйлдлийг хийгээгүй, мөн хүчээр татсан үед бариулыг гэмтээх, хэлбэр алдагдахад хүргэнэ.

▶ Автомашины гадна тал



Гар аргаар хаалга нээх A бариулыг татаж хаалга нээнэ.

Хэвийн нөхцөлд гар аргаар хаалга нээх бариулаар хаалга нээх боломжгүй.

Гар аргаар хаалга нээх бариулын ажиллагааг идэвхжүүлж хаалга нээнэ.→ Х.614

▶ Автомашины дотор тал



Гар аргаар хаалга нээх A бариулыг 2 удаа татаж хаалга нээнэ.

Бариулыг нэг удаа татахад ажиллагаа идэвхжинэ. Дахин татах үед хаалга нээгдэнэ.

МЭДЭЭЛЭЛ

Гар аргаар хаалга нээх бариул ажиллах нөхцөл

- Автомашин урд, эсвэл ард талаасаа хүчтэй мөргөлтөнд өртсөн үед гар аргаар хаалга нээх бариулын ажиллагаа бүх хаалганд идэвхжинэ.

  Нөгөөтэйгүүр мөргөлтийн хүч, нөхцлөөс хамаарч гар аргаар хаалга нээх бариулын ажиллагаа идэвхжихгүй байж болно.
- Хаалганы түгжээ тайлагдсан үед аккумуляторын хүчдэл бага багаар буурсан

  Хүчдэл хэрхэн буурснаас хамаарч идэвхжихгүй байж болно.
- Автомашины дотор талаас гар аргаар хаалга нээх бариулын ажиллагаа идэвхжүүлсэн үед



- Автомашины гадна талаас гар аргаар хаалга нээх бариулын ажиллагааг механик түлхүүрээр идэвхжүүлсэн үед



Гар аргаар хаалга нээх бариулын ажиллагаа идэвхгүй болох нөхцлүүд

- Хаалга нээхэд ашиглаж болохгүй тул хэвийн үед гадна талын гар аргаар хаалга нээх бариулын ажиллагаа идэвхгүй байдаг.

  Гар аргаар хаалга нээх бариулаар, эсвэл механик түлхүүрээр ажиллагааг идэвхжүүлсэн ч хаалга нээх товчоор хаалга нээсэн, эсвэл түгжсэн үед тус ажиллагаа автоматаар цуцлагдана.
- Гар аргаар хаалга нээх бариулын ажиллагаа асаах товчийг ON горимд шилжүүлсэн үед цуцлагдах ба бариулаар хаалга нээх боломжгүй болно.

  Гар аргаар хаалга нээх бариулаар, эсвэл механик түлхүүрээр ажиллагааг идэвхжүүлсэн ч хаалга нээх товчоор хаалга нээсэн, эсвэл түгжсэн үед тус ажиллагаа автоматаар цуцлагдана.

● Асаах товчны ON горимд хаалга санамсаргүйгээр нээхээс сэргийлж дотор талын гар аргаар хаалга нээх бариул 1 удаа ажиллуулсны дараа 1 секундын дотор ажиллагаа автоматаар цуцлагдана.

Холбоотой холбоосууд

Механик түлхүүр ашиглах(X. 605)

Механик түлхүүр ашиглан хаалганы гадна бариул идэвхжүүлэх

Механик түлхүүрээр хаалганы түгжээ тайлан гадна бариулын ажиллагааг идэвхжүүлэх боломжтой.

1 **Хуванцар карт зэргийг хаалганы бариулны завсар хийгээд тагийг авна.**

Гэмтээхээс сэргийлж тагийг хүчтэй дарж болохгүй.



2 **Механик түлхүүр ашиглан цоожны цилиндрийг түгжээ тайлах байрлалд эргүүлж бариулын ажиллагааг идэвхжүүлнэ.**



Механик түлхүүр нь нэг талдаа ховилтой ба зөвхөн нэг талаараа орох боломжтой.

Цоожны цилиндрт түлхүүр орохгүй үед нөгөө тийш харуулан дахин оролдоно.

Хаалганы бариулны ажиллагаа идэвхжинэ.

Хойд хаалга дотор талаас онгойхгүй үед

Хүүхэд хамгаалах түгжээ түгжигдсэн байж болно.

Хаалгыг гадна талаас нээж хүүхэд хамгаалах түгжээг тайлна.

Холбоотой холбоосууд

Автомашины дотор талаас хойд хаалга нээхээс сэргийлэх (хүүхэд хамгаалах түгжээ)(Х. 35)

Тээшний хаалга нээгдэхгүй үед

Тээшний хаалганы түгжээг дотор талаас тайлах боломжтой.

1 **Хасах халив ашиглан тагийг салгана.**

Тагийг хамгаалах үүднээс зурагт үзүүлсний дагуу хасах халивны үзүүрт даавуу жийрэглэнэ.



Тээшний автомат хаалгагүй автомашин:

2 **Тагийг эргүүлнэ.**



3 **Халив ашиглан хөшүүргийг түлхэнэ.**



Тээшний автомат хаалгатай автомашин:

4 **Шургийг халиваар суллаад тагийг буцаана.**



5 Халив ашиглан хөшүүргийг түлхэнэ.



Дээврийн нээлхий зөв ажиллахгүй үед

Дээврийн нээлхий хаагдсан ч буцаж бага зэрэг нээгдээд байгаа үед

1 **Автомашиныг зогсооно.**

2 **товчийг удаан дарна.*1**

Дээврийн нээлхий хаагдаад дахин нээгдэх ба 10 секунд зогсоно.*2

Дараа нь дахин хаагдах ба дээш өргөгдөөд 1 секунд зогсоно. Доош буугаад нээгдээд хаагдана.

3 **Дээврийн нээлхий бүрэн зогссоныг нягтлаад товчийг суллана.**

Дээрх үйлдлийг зөв хийсэн ч дээврийн нээлхий бүрэн хаагдахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

Дээврийн нээлхий доош буусан ч буцаж өргөгдөөд байгаа үед

1 **Автомашиныг зогсооно.**

2 **Дээврийн нээлхий дээш өргөгдөөд зогсох хүртэл товчийг дарна.*3**

3 **Товчийг нэг суллаад дахин удаан дарна.*3**

Дээврийн нээлхий дээш өргөгдсөн байрлалд 10 секунд хөдөлгөөнгүй зогсоно.*4

4 **Дээврийн нээлхий бүрэн хаагдсаныг нягтлаад товч суллана.**

Дээрх үйлдлийг хийсэн ч дээврийн нээлхий бүрэн хаагдахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

*1 : Товчийг буруу үед сулласан нөхцөлд үйлдлийг дахин эхнээс нь эхлэнэ.

*2 : Товчийг дээр дурдсан 10 секунд зогссоны дараа сулласан үед автомат ажиллагаа цуцлагдана. Энэ нөхцөлд , эсвэл товчийг удаан дарах ба дээврийн нээлхий дээш өргөгдөөд 1 секунд зогсоно. Үргэлжлээд дээврийн нээлхий доош буух ба нээгдээд хаагдана. Дээврийн нээлхий бүрэн зогссоныг нягтлаад товчийг суллана.

*3 : Товчийг буруу мөчид сулласан үед үйлдлийг дахин эхнээс нь хийнэ.

*4 : Товчийг дээр дурдсан 10 секундын дараа сулласан үед автомат ажиллагаа цуцлагдана. Энэ нөхцөлд , эсвэл товчийг удаан дарах ба дээврийн нээлхий өргөгдөөд 1 секунд хөдөлгөөнгүй зогсоно. Үүний дараа доош буугаад нээгдээд хаагдана. Дээврийн нээлхий бүрэн хаагдсаныг нягтлаад товч суллана.

Панорамик дээврийн нээлхий/электрон нарны хаалт зөв ажиллахгүй үед

Панорамик дээврийн нээлхий / электрон нарны хаалтыг анхны тохиргоонд тохируулах

1 **Автомашиныг зогсооно.**

2 **Асаах товч ON горимд шилжүүлнэ.**

3 **товч, эсвэл товчийг урагш үргэлжлүүлэн дарна. Панорамик дээврийн нээлхий, эсвэл нарны хаалт хаагдаад нээгдэх ба товчийг үргэлжлүүлэн 10 секунд дарна. Панорамик дээврийн нээлхий, эсвэл нарны хаалт хаагдаж эхэлнэ.*1**

4 **Панорамик дээврийн нээлхий, эсвэл нарны хаалт бүрэн хаагдсаныг нягтлаад товчийг суллана.**

Дээрх үйлдлийг зөв хийж гүйцэтгэсэн ч дээврийн нээлхий зөв хаагдахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

*1 : Товчийг буруу мөчид сулласан үед үйлдлийг дахин эхнээс нь эхлэх шаардлагатай болно.

Арын суудлыг анхны байрлалд буцаах (Тээшний автомат хаалгатай автомашин)

1. **Суудалд аливаа зүйл саад болохгүйг нягтлана.**
2. **Анхны байрлалд тохируулах суудлыг доош эвхэнэ.**
3. **Тээшний хэсэг дэх суудлын товчийг удаан дарна.**
4. **10 секундын дотор суудлын 2 дахь товчийг 5 удаа дарна.**
5. **10 секундын дараа дохио 3 удаа дуугарах үед тээшний хэсгийн товчийг суллана.**
6. **Тээшний хэсгийн товч, эсвэл товч, эсвэл 2 дахь товчийг дарж суудлыг буцаана.**

   Суудал буцаах үйлдлийн явцад түшлэг автоматаар хөдлөх ба дохио дуугарна.

   Үйлдэл дуусах үед дохио 2 удаа дуугарна.

   Өмнөх үйлдэл дууссан дохио дуугарах нь зогсохгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношилгоо хийлгэнэ үү.

Шатахууны савны таг нээгдэхгүй үед

Шатахууны савны таг нээх товч ажиллахгүй үед та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу. Шатахуун даруй цэнэглэх шаардлагатай үед дараах дарааллаар нээх боломжтой.

1 **Тээшний хэсгийн дотор талаас халив оруулан таг салгах.**

Таг салгах үед гэмтээхээс сэргийлж халивны үзүүрийг даавуугаар жийрэглэнэ.



2 **Хөшүүргийг татна.**



Утасгүй цэнэглэгчийн ажиллагааны индикатор (цэнэглэх тавиурны) анивчсан үед*

Утасгүй цэнэглэгчийн индикатор секунд бүр анивчиж (шаргал / ногоон) анивчиж байгаа үед

Шалтгаан	Авах арга хэмжээ
Автомашин болон утасгүй цэнэглэгчийн хоорондын холбоо муу.	Хөдөлгүүр асаалттай үед унтраагаад дахин асаана. Утасгүй цэнэглэгчийн ажиллагааны индикатор (цэнэглэх тавагны) үргэлжлэн анивчих үед Мөн зөөврийн төхөөрөмжинд гэр, хуулга угсарсан үед салгана.

Утасгүй цэнэглэгчийн индикатор нэг удаад 3 удаа үргэлжлэн анивчих (шаргал)

Шалтгаан	Авах арга хэмжээ
Дараах шалтгаантай байж болно. ● Гадны биет мэдрэгдсэн: Цэнэглэх хэсэгт металл эд зүйл мэдрэгдсэн үед цэнэглэх ороомогны халалтаас сэргийлэх функц ажиллана ● Зөөврийн төхөөрөмжийг зөв байрлуулаагүй: Цэнэглэх хэсэгт зөөврийн төхөөрөмжийг зөв байрлуулаагүй үед цэнэглэх ороомогны халалтаас сэргийлэх функц ажиллана	● Гадны биетийг цэнэглэх хэсгээс авна. ● Зөөврийн төхөөрөмжийг цэнэглэх тавиураас аваад индикатор буцаж ногоон ассаныг нягтлаад тавиурны гол хэсэгт буцаан тавина. Мөн цэнэглэх төхөөрөмж нь хамгаалалтын гэртэй үед гэрийг авна.

* : Тоноглогдсон автомашинд

Утасгүй цэнэглэгчийн индикатор 4 удаа дараалж хурдан анивчсан үед (шаргал)

Шалтгаан	Авах арга хэмжээ
Утасгүй цэнэглэгч доторх хэм хэт өндөр болсон.	Цэнэглэхээ зогсоож цэнэглэх тавиурнаас зөөврийн төхөөрөмжийг ава ба дахин цэнэглэх үйлдэл хийхээс өмнө цэнэглэгч хөртөл хүлээнэ.

Хөдөлгүүр асч байгаа ч автомашин хөдлөхгүй үед

Явах эд ангид доголдол үүссэн байж болно.

Автомашин чирүүлэхийн өмнө та өөрийн Lexus дилер, эсвэл мэргэжлийн байгууллагад хандана уу.

Хурдны хайрцаг хэвийн бус дуу чимээ гаргаж байгаа үед

Хүч дамжуулах эд ангиудад асуудал үүссэн байж болзошгүй.

Чирүүлэхээс өмнө та өөрийн Lexus дилер, эсвэл мэргэжлийн чирэх үйлчилгээ үзүүлдэг байгууллагад хандана уу.

Чирэгч машинаар чирүүлэх

⚠ АНХААР

■ **Дугуй өргөгчтэй чирэгч машинаар чирүүлэх үед автомашины эвдрэл гэмтлээс сэргийлэх**

- Асаах товч унтраастай үед автомашиныг хойд талаас чирэж болохгүй. Жолооны хүрд түгжих механизм нь урд дугуйг шулуун барих техникийн хүчин чадал байхгүй.
- Автомашин өргөх үед өргөсөн талын эсрэг талд газар хүртэл хангалттай зай үлдээнэ. Эсрэг тохиолдолд чирэх үед газарт шүргэж автомашин гэмтэнэ.

Урд хөтлөгчтэй автомашиныг чирэгч машинаар чирэх

Чирүүлэх шаардлагатай үед та өөрийн Lexus дилер, эсвэл мэргэжлийн байгууллагад хандан дугуй өргөгчтэй чирэгчээр чирүүлэх, эсвэл тэвштэй бүтэн ачигч машинаар ачиж тээвэрлүүлнэ. Чирэх үед аюулгүйн гинж ашиглах ба орон нутгийн хууль дүрмийг мөрдөнө.

⚠ АЮУЛТАЙ

Автомашин тээвэрлэх үед урд дугуйг, эсвэл бүх дөрвөн дугуйг өргөн газраас хөндий тээвэрлэнэ. Урд дугуй газартай харьцсан байдалтай чирэх үед явах эд анги болон түүнтэй холбоотой эд ангиуд гэмтэх аюултай.



⚠ АНХААР

■ **Крантай машинаар чирэх**

Автомашины их биед гэмтэл учруулахаас сэргийлж крантай машинаар чирэхийг хориглоно.



▶ Урд талаас чирэх



Зогсоолын тоормос салгана.

Автомат горимыг унтраана.

▶ Ард талаас чирэх



Урд дугуйнд чирэх дугуйг хийнэ.

AWD автомашиныг чирэгч машинаар чирэх

Чирүүлэх шаардлагатай үед өөрийн Lexus дилер, эсвэл мэргэжлийн байгууллагад хандан дугуй өргөгчтэй чирэгчээр чирүүлэх, эсвэл тэвштэй бүтэн ачигч машинаар ачиж тээвэрлүүлнэ. Чирэх үед аюулгүйн гинж ашиглах ба орон нутгийн хууль дүрмийг мөрдөнө.

⚠ АЮУЛТАЙ

Автомашин тээвэрлэх үед бүх 4 дугуйг газраас хөндий тээвэрлэнэ. Дугуй газартай харьцсан байдалтай чирэх үед явах эд анги болон түүнтэй холбоотой бусад эд ангиуд гэмтэх, автомашин ачааны машинаас даялж шидэгдэх аюултай.



⚠ АНХААР

■ Крантай машинаар чирэх

Автомашины их биед гэмтэл учруулахаас сэргийлж крантай машинаар чирэхийг хориглоно.



▶ Урдаас чирэх



Хойд дугуйнд чирэх дугуйг хийнэ.

▶ Ардаас чирэх



Урд дугуйнд чирэх дугуйг хийнэ.

Тэвштэй бүтэн ачигч машинаар ачиж тээвэрлэх

⚠ АНХААР

Автомашинд гэмтэл учруулах аюултай тул бэхэлгээг хэт чангалж болохгүй.

■ Тэвштэй бүтэн ачигч машинаар ачиж тээвэрлэх үед

Тэвштэй бүтэн ачигч машинаар тээвэрлэх үед зурагт цэгүүдийг ашиглан тэвштэй бэхлэнэ.



■ Бэхэлгээнд олс, гинж ашигласан үед

Бэхэлгээнд олс, гинж ашигласан үед хараар тодруулсан хэсгийн өнцөг 45° байх ёстойг анхаарна.

Дээрх аргаар автомашиныг бэхлэх боломжгүй үед дугуйгаар бэхлэх олс ашиглана.



Бусад автомашинаар чирүүлэх үед

Чирүүлэх шаардлагатай үед өөрийн Lexus дилер, эсвэл мэргэжлийн байгууллагад хандан дугуй өргөгчтэй чирэгчээр чирүүлэх, эсвэл тэвштэй бүтэн ачигч машинаар ачиж тээвэрлүүлнэ. Чирэх үед аюулгүйн гинж ашиглах ба орон нутгийн хууль дүрмийг мөрдөнө.

⚠ АНХААР

■ **Stop & Start системтэй автомашин чирүүлэх үеийн анхааруулга**

Бүх 4 дугуй газартай харьцсан байдлаар автомашин чирүүлэх үед системийг хамгаалах үүднээс дараах арга хэмжээг авна. Асаах товч унтраагаад буцааж хөдөлгүүр асаах, эсвэл асаах товчийг ON горимд шилжүүлнэ.

Ослын үеийн чирэлт

Автомат хурдны хайрцаг: Чирэгч автомашин олдохгүй үед зайлшгүй шаардлагатай үед чирэх дэгээнд олс, гинж холбон богино зайнд чирүүлэх боломжтой. Чирэх үйлдлийг зөвхөн хатуу гадаргуутай зам дээр 30км/ц (18 миль/ц) хүртэлх хурдаар богино зайнд хийж болно.

CVT хурдны хайрцаг: Чирэгч автомашин олдохгүй үед зайлшгүй шаардлагатай үед чирэх дэгээнд олс, гинж холбон богино зайнд чирүүлэх боломжтой. Чирэх үйлдлийг зөвхөн хатуу гадаргуутай зам дээр 30км/ц (18 миль/ц) хүртэлх хурдаар 80 км (50 миль) зайнд хийж болно.

Чирүүлэх үед жолооч жолооны хүрд, тоормостой харьцах бөгөөд автомашины дугуй, явах эд анги, тэнхлэг, жолооны механизм болон тоормосны ажиллагаа хэвийн байх шаардлагатай.

Бусад автомашинаар чирүүлж болохгүй нөхцлүүд (Автомат хурдны хайрцаг)

Дараах нөхцлүүдэд зогсоолын дугуй түгжих функцаар урд дугуй түгжигдэх тул гинж, татлага зэргийг ашиглан бусад автомашинаар чирүүлж болохгүй.

Та өөрийн Lexus дилер, бусад мэргэжлийн автомашин ачих үйлчилгээнд хандана уу.

- Арааны удирдлагын системд доголдол үүссэн.
- Хөдөлгүүрийн иммобилайзер системд доголдол үүссэн.
- Smart entry & start системд доголдол үүссэн.(→X. 590)
- Аккумуляторын цэнэг суусан.

Холбоотой холбоосууд

Асаах товчны горим солих(X. 145)

Анхааруулга гарах үед(X. 575)

Хөдөлгүүрийн иммобилайзер систем идэвхжүүлэх(X. 88)

Аккумуляторын цэнэг суусан үед(X. 591)

Ослын үеийн чирэлт

Автомашинаар чирүүлэх үед чирэх дэгээг та өөрийн автомашиндаа угсрах шаардлагатай. Чирэх дэгээг дараах дарааллаар угсарна.

⚠ АЮУЛТАЙ

Автомат хурдны хайрцагтай автомашин:

Зогсоолын тоормос түгжих механизм залгагдаж урд дугуй түгжих, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай тул дараах үйлдлийг хийхийг хориглоно:

- Жолоочийн аюулгүйн бүс тайлж жолоочийн хаалга нээх.
- Асаах товч унтраах.

1 Хасах халив болон чирэх дэгээг гаргана.

2 Хасах халиваар тагийг салгана.

Автомашины их биеийг хамгаалах үүднээс халивны үзүүрт зурагт үзүүлсний дагуу даавуу жийрэглэнэ.



3 Чирэх дэгээг хийж гараар чангална.



4 Дугуйн дорцов, эсвэл төмөр саваагаар чирэх дэгээг чангална.



МЭДЭЭЛЭЛ

■ Дугуйн дорцов

Дугуйн дорцовгүй автомашин: Дугуйн дорцовыг та өөрийн Lexus дилер дээрээс худалдан авах боломжтой.

Дугуйн дорцовтой автомашин: Дугуйн дорцов нь тээшний хэсэгт суурилагдсан байдаг.

⚠ АЮУЛТАЙ

Чирэх дэгээг угсрах үед зохих байрлалд хөдөлгөөнгүй угсрана.

Хөдөлгөөнгүй угсраагүй үед чирэх явцад чирэх дэгээ суларна.

5 Олс, гинжийг чирэх дэгээнд сайтар уяж холбоно.

Автомашины их биеийг гэмтээхээс сэргийлнэ.

⚠ АНХААР

Чирэх явцад автомашиныг гэмтээхээс сэргийлж олс, гинжийг явах эд ангиас уяж болохгүй.

6 Чирүүлэх автомашинд сууж хөдөлгүүр асаана.

Хөдөлгүүр асахгүй үед асаах товчийг ON горимд шилжүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ

■ Чирэх үед

Хөдөлгүүр асаагүй үед тоормос болон жолооны хүчлүүр ажиллахгүй тул тоормос болон жолоодлого илүү хүнд болно.

⚠ АЮУЛТАЙ

Автомат хурдны хайрцагтай автомашин: Асаах товчийг унтрааж болохгүй. Урд дугуй зогсоолын түгжээгээр түгжигдэж осолд хүргэх аюултай.

CVT хурдны хайрцагтай автомашин: Асаах товчийг унтрааж болохгүй. Жолооны хүрд түгжигдэж жолоодох боломжгүй болно.

7 Арааг N-д шилжүүлж зогсоолын тоормос салгана.

Зогсоолын тоормосны автомат горимыг унтраана.

CVT хурдны хайрцаг: Арааны хөшүүрэг шилжихгүй үед: → X.173

⚠ АЮУЛТАЙ

Чирэх үед чирэх дэгээ, олс, гинжинд хэт ачаалал өгөх байдлаар огцом хөдөлгөөн эхлэхээс зайлсхийнэ. Чирэх дэгээ, олс, гинж гэмтэж улмаар тасарсан хэсэг, хэлтэрхий нь хүн цохиж ноцтой гэмтэл учруулах аюултай.

Шавар, элс, цасанд суусан автомашин гаргах

1 **Хөдөлгүүр унтраана. Зогсоолын тоормос залгаад араар Р-д шилжүүлнэ.**

2 **Урд дугуйн ойр орчмоос шавар, цас, элсийг цэвэрлэнэ.**

3 **Барьцалдах чадварыг нэмэгдүүлэх үүднээс урд дугуйн доор мод, чулуу, бусад эд зүйл хийнэ.**

4 **Хөдөлгүүр асаана.**

5 **Араар D, эсвэл R-д шилжүүлээд зогсоолын тоормос салгана. Анхаарал болгоомжтойгоор хааз гишгэнэ.**

⚠ АЮУЛТАЙ

- Арааны хөшүүргийг шилжүүлэх үед хааз гишгэнгээ шилжүүлж болохгүй.

  Автомашин огцом ухасхийх, улмаар осол аваар үүсгэхэд хүргэх аюултай.
- Суусан автомашиныг гаргахаар урагш хойш хөдөлгөх үед бусад автомашин, объект болон хүн мөргөхөөс сэргийлж орчны аюулгүй байдлыг нягтлана.

  Автомашин суларсан даруйд урагш, эсвэл хойш огцом ухасхийх аюултай. Анхаарал болгоомжтой жолоодно.

⚠ АНХААР

Шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн урд дугуйг хий эргүүлэх, хаазны дөрөө гишгэхээс зайлсхийнэ.

Хурдны хайрцаг болон бусад эд ангийг гэмтээх аюултай.

6 **Суусан автомашиныг гаргах нь хүндрэлтэй үед товч дарж TRC-г унтраана.**

Дээрх үйлдлийг хийсэн ч автомашиныг гаргах боломжгүй үед чирүүлэх шаардлагатай.

Автомашинд хэвийн бус зүйл илэрсэн үед

Дараах нь хэвийн бус байдлын шинж тэмдэг болно.

- Автомашины доороос шингэн гоожиж байгаа

  Эйр кондишноос ус дусах нь хэвийн зүйл болно.

- Дугуйн хий сулрах, эсвэл хэвийн бус элэгдэл
- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм заагч байнга өндөр зааж байгаа.

  Та даруй өөрийн Lexus дилертээ хандана уу. Таны автомашинд тохиргоо, эсвэл засвар үйлчилгээ хийх шаардлагатай байж болно.

Автомашинаас хэвийн бус дуу чимээ гарч байгаа үед

Нөхцөл	Авах арга хэмжээ
Хэвийн бус дуу чимээг дор дурдав. ● Яндангийн дуу өөрчлөгдөх ● Эргэлт хийх үед чахрах дуу ● Амортизартой холбоотой хэвийн бус дуу ● Хөдөлгүүртэй холбоотой, цохио болон бусад хэвийн бус дуу	Даруй өөрийн Lexus дилерт хандана уу. Таны автомашинд тохиргоо, засвар хийх шаардлагатай байж болзошгүй.

Автомашины ажиллагаа хэвийн бус үед

Дараах шинж тэмдгүүд нь хэвийн бус байдлыг илтгэнэ.

- Хөдөлгүүрийн галын тохиргоо алдагдсан, доголдож байгаа
- Хөдөлгүүр хүчгүй болох
- Тоормослох үед автомашин нэг тал руугаа хүндээр чирэгдэх
- Тэгш зам дээр шулуун явах үед автомашин нэг тал руугаа даялах
- Тоормосны хүч алдагдах, тоормосны дөрөө зөөлөн болох, дөрөө шаланд тултал гишгэгдэх

  Та өөрийн Lexus дилерт даруй хандана уу. Таны автомашинд тохиргоо, засвар хийх шаардлагатай байж болзошгүй.

Хөдөлгүүр унтраасны дараа жолооны хүрд эргэхгүй байх

Автомашины хулгайгаас сэргийлж жолооны хүрд автоматаар түгжигддэг.



- Жолооны хүрдний түгжээ тайлагдахгүй үед мэдээллийн дэлгэц дээр **"Push ENGINE Switch while Turning The Steering Wheel in Either Direction"** гарна. Араа Р байрлалд байгааг нягтлаад жолооны хүрдийг 2 тийш эргүүлэнгээ асаах товч дарна.
- Жолооны хүрд түгжих моторны хэт халалтаас сэргийлж хөдөлгүүрийг богино хугацаанд олон удаа асааж унтраах үед моторны ажиллагаа түр хугацаанд салгагдана. Энэ үед хэсэг хугацаанд хөдөлгүүр асаалгүй хүлээнэ. Моторын ажиллагаа 10 секундын дараа дахин сэргэнэ.

Холбоотой холбоосууд

Асаах товчны горим солих(X. 145)

Автомат цонхны товчоор цонх нээгдэхгүй, эсвэл хаагдахгүй үед

Цонх түгжих товч дарагдсан эсэх.

Цонх түгжих товч дарагдсан үед жолоочийн суудлаас бусад автомат цонх ажиллахгүй.

Цонх түгжих товч дарж унтраана.

- **Хавчихаас хамгаалах функц, эсвэл хавчуулагдахаас сэргийлэх функц хэвийн бусаар ажиллаж хажуу цонх нээх болон хааж болохгүй үед тухайн хаалганы автомат цонхны товчоор дараах үйлдлийг хийнэ.**
  - Автомашиныг зогсооно. Асаах товчны ON горимд хавчихаас хамгаалах функц, эсвэл хавчуулагдахаас сэргийлэх функц идэвхжсэнээс 4 секундын дотор цонх нээх, хаах үүднээс автомат цонхны товчийг гүйцэд нээх, эсвэл гүйцэд хаах байрлалд барина.
  - Дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч хаалганы цонх нээгдэхгүй, хаагдахгүй үед функцийн тохиргоог тэглэнэ.

Холбоотой холбоосууд

Цонх аюулгүйгээр нээж хаахад туслах функцууд(X. 117)

Автомат цонхны товчоор ажиллуулах(X. 118)

Цонх санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх(X. 120)

Хавчихаас хамгаалах функц/хавчуулагдахаас сэргийлэх функцийг анхны тохиргоонд буцаах

1. **Асаах товчийг ON горимд шилжүүлнэ.**
2. **Автомат цонхны товчийг бүрэн хаах байрлалд удаан татаж цонх хаана.**
3. **Товчийг түр суллаад дахин бүрэн хаах байрлалд 6-с дээш секундын турш удаан татна.**
4. **Автомат цонхны товчийг бүрэн нээх байрлалд үргэлжлүүлэн дарна. Цонх бүрэн нээгдсэний дараа товчийг үргэлжлүүлэн 1-с дээш секунд дарна.**
5. **Товчийг түр суллаад дахин бүрэн нээх байрлалд 4-с дээш секундын турш удаан дарна.**
6. **Автомат цонхны товчийг бүрэн хаах байрлалд дахин удаан татна. Цонх бүрэн хаагдсаны дараа товчийг үргэлжлүүлэн 1-с дээш секунд татна.**

   Цонх хөдөлж байх үед товч сулласан нөхцөлд үйлдлийг дахин эхлэнэ.

Хэрэв цонх буцаж хөдлөн гүйцэд хаагдахгүй, нээгдэхгүй үед та өөрийн Lexus дилер дээрээ оношлуулна уу.

Холбоотой холбоосууд

Цонх аюулгүйгээр нээж хаахад туслах функцууд(Х. 117)

Автомат цонхны товчоор ажиллуулах(Х. 118)

Асаах товч автоматаар унтрах

Дараах нөхцлүүдэд автоматаар унтраах функцаар унтарна.

- Автомашиныг 20 минутаас удаан хугацаанд P араатай, ACC, эсвэл ON горимд орхисон (хөдөлгүүр асаагүй).
- P араатай, ACC, эсвэл ON горимд (хөдөлгүүр асаагүй) аккумуляторын цэнэг буурсан.

Хөдөлгүүр дараагийн удаа асаах үед хөдөлгүүрийн хурдыг бага зэрэг нэмэн 5 орчим минут аккумулятор цэнэглэнэ.

Хөдөлгүүр унтраастай үед асаах товчийг ACC, эсвэл ON горимд удаан орхиж болохгүй.

Автомашин халсан үед

Хөдөлгүүр халсныг дараах зүйлс илэрхийлнэ.

- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэмийн заалт улаан бүсэд орох.
- Хөдөлгүүр хүчгүй болох. (Автомашины хурд нэмэгдэхгүй зэргээр.)
- **"Engine Coolant Temp High Stop in a Safe Place See Owner's Manual"** анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гарсан.
- Капотноос уур гарах.

Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэмийн заалт улаан бүсэд орсон, эсвэл мэдээллийн дэлгэц дээр "Engine Coolant Temp High Stop in a Safe Place See Owner's Manual" гарсан үед

1 **Автомашиныг аюулгүй газарт зогсоох ба агааржуулагчийн систем унтраасны дараа хөдөлгүүр унтраана.**

⚠ АЮУЛТАЙ

Хөргөлтийн сэнс ажиллаж байгаа үед хөдөлгүүрийн хэсэг дэх эд ангиудад хүрэх, эсвэл ойртож болохгүй.

Гар хуруу, хувцасаа (ялангуяа зангиа, ороолт) хавчуулж ноцтой гэмтэл авах аюултай тул сэнс зэрэг эргэлдэх эд ангиудад хүрэх, эсвэл ойртож болохгүй.

Агааржуулалтын систем асаалттай байгаа, эсвэл хөргөлтийн шингэний хэм өндөр үед хөргөлтийн сэнс автоматаар ажиллана.

Мөн асаах товч унтрааснаас хойш хэдэн минутын дараа сэнс мөн ажиллаж болно.

2 **Уур гарахгүй үед капот болгоомжтой сөхнө.**

Уур гарч байгаа үед уур зогссоны дараа капот болгоомжтой сөхнө.

⚠ АЮУЛТАЙ

Капот онгойлгох үед дараах анхааруулгыг мөрдөнө.

- Капотны дооройос уур гарч байгаа үед уур зогстол капот нээж болохгүй. Хөдөлгүүрийн хэсэг хэт халуун байж болно.
- Хөдөлгүүр, радиатор халуун үед хөргөлтийн шингэний нөөцийн сав, радиаторын таг суллахыг хориглоно. Өндөр хэмтэй уур, хөргөлтийн шингэн цацагдана.

3 **Хөдөлгүүр хангалттай хөрсний дараа радиаторын хоолойноос шингэн алдагдаж байгаа эсэхийг шалгана.**

Хэрэв их хэмжээний хөргөлтийн шингэн асгарсан үед даруй өөрийн Lexus дилерт хандана уу.



A Радиатор
B Хөргөлтийн сэнс

4 Хөргөлтийн шингэний түвшин нөөцийн савны [FULL] болон [LOW] зураасны хооронд байгааг нягтлана.

▶ Хөдөлгүүр



A Нөөцийн сав
B [**FULL**] зураас
C [**LOW**] зураас
D Радиаторын таг

▶ Intercooler (зөвхөн NX350)



A Нөөцийн сав
B [**FULL**] зураас
C [**LOW**] зураас

5 Шаардлагатай үед хөргөлтийн шингэн нэмнэ.

Хөргөлтийн шингэн байхгүй үед онцгой нөхцөлд ус ашиглаж болно.

▶ Хөдөлгүүр



▶ Intercooler (зөвхөн NX350)



⚠ АНХААР

■ **Хөргөлтийн шингэн нэмэх үед**

Хөдөлгүүр хангалттай хөрсний дараа хөргөлтийн шингэн бага багаар нэмнэ.

Халуун хөдөлгүүр дээр хөргөлтийн шингэн их хэмжээгээр нэг дор нэмэх нь хөдөлгүүр гэмтээнэ.

■ **Хөргөлтийн системийг эвдрэл гэмтлээс сэргийлэх**

Дараах анхааруулгыг мөрдөнө:

- Хөргөлтийн шингэнийг гадны биетээр (элс, тоос шороо зэрэг) бохирдуулахаас зайлсхийнэ.
- Хөргөлтийн шингэний нэмэлт бодис ашиглаж болохгүй.

6 Хөдөлгүүр асаан агааржуулалтын систем ажиллуулж радиаторын хөргөлтийн сэнс ажиллаж байгааг, мөн радиатор болон хоолойноос хөргөлтийн шингэн гоожиж байгаа эсэхийг шалгана.

Хөрсөн хөдөлгүүр асаасан даруйд агааржуулалтын систем ажиллуулсан үед сэнс ажиллана.

Сэнсний дуу болон агаар үлээж байгаа байдлаар сэнс ажиллаж байгааг шалгана. Ингэж шалгах нь хүндрэлтэй үед агааржуулалтын системийг олон удаа асааж унтрааж үзнэ. (Хасах хэмд сэнс ажиллахгүй байж болно.)

7 **Сэнс ажиллахгүй үед: Хөдөлгүүр даруй унтрааж өөрийн Lexus дилерт хандана.**

Сэнс ажиллаж байгаа үед: Автомашиныг ойрын Lexus дилер дээр оношлуулна уу.

8 **Мэдээллийн дэлгэц дээр "Engine Coolant Temp High Stop in a Safe Place See Owner's Manual" мэдээлэл гарсан эсэхийг нягтлана.**

Мэдээлэл унтрахгүй үед: Хөдөлгүүр даруй унтрааж өөрийн Lexus дилерт хандана.

Мэдээлэл гараагүй үед: Ойр байрлах Lexus дилерт хандаж оношлуулна уу.

Товч дарсан ч цахилгаан эд анги, төхөөрөмж ажиллахгүй үед

Цахилгаан эд анги, төхөөрөмж ажиллахгүй үед гал хамгаалагч шатсан байж болно.

Энэ нөхцөлд гал хамгаалагчийг шинээр солино.

Холбоотой холбоосууд

Гал хамгаалагч шалгах, солих(Х. 648)

Гэрэл асахгүй үед

Дараах шалтгаантай байж болно:

- Аккумуляторын цэнэг суусан.
- Аккумуляторын аль нэг, эсвэл 2 шон салсан.
- Жолооны хүрд түгжих системд доголдол үүссэн байж болно.
- Гал хамгаалагч шатсан. Гал хамгаалагч шалгана.

Тухайн асуудал засагдахгүй, эсвэл засах арга нь тодорхойгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

МЭДЭЭЛЭЛ

■ Линзний дотор талд хөлрөлт үүссэн

Их гэрэл дотор түр хугацаанд хөлрөлт үүсэх нь доголдлыг илэрхийлэхгүй. Дараах нөхцлүүдэд та өөрийн Lexus дилерт хандана уу:

- Линзэн дотор усны том дуслууд үүссэн.
- Их гэрэл дотор ус тогтсон.

Гал хамгаалагч шалгах, солих

⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд автомашинд гэмтэл учруулах, улмаар гал түймэр, бэртэл гэмтэлд хүргэнэ.

- Зааснаас өндөр ампертай гал хамгаалагч, эсвэл гал хамгаалагчийн оронд өөр зүйл хийж ашиглахыг хатуу хориглоно.
- Зөвхөн Lexus-н оригинал, эсвэл дүйцэх чанартайг ашиглана. Түр зуурын засвар байсан ч цахилгааны утас түр ашиглахгүй.
- Гал хамгаалагч болон хайрцгийг өөрчлөхийг хориглоно.

⚠ АНХААР

Хэлхээний хэт ачааллын шалтгааныг даруй та өөрийн Lexus дилер дээр засуулна уу.

1 **Хөдөлгүүр унтраана.**

2 **Гал хамгаалагчийн хайрцагны таг нээнэ.**

▶ Хөдөлгүүрийн төрөл (A төрөл)

Хайрцагны хумсан дээр дарж таг нээнэ.



▶ Хөдөлгүүрийн төрөл (B төрөл)

Хайрцагны хумсан дээр дарж таг нээнэ.



▶ Зүүн талын хянах самбар (зүүн жолооны хүрдтэй автомашин)

Тагийг нээнэ.



▶ Зүүн талын хянах самбар (баруун жолооны хүрдтэй автомашин)

Шалавчийг авааД гал хамгаалагчийн хайрцагны таг авна.



3 Гал хамгаалагч салгаж авна.

Зарим гал хамгаалагчийг багажаар салгаж болно.



4 Гал хамгаалагч шатсан эсэхийг шалгана.

Зохих ампертай шинэ гал хамгаалагчаар шатсан гал хамгаалагчийг солино. Амперын мэдээллийг гал хамгаалагчийн тагнаас харж болно.



A Шатаагүй гал хамгаалагч

B Шатсан гал хамгаалагч

МЭДЭЭЛЭЛ

■ Гал хамгаалагч сольсны дараа

- Таг угсрах үед хайрцагны хумсыг зөв угсарна.
- Гал хамгаалагч солисон ч гэрэл асахгүй үед гэрлийн ламп солих шаардлагатай байж болно.
- Солисон гал хамгаалагч дахин шатсан үед та өөрийн Lexus дээр оношлуулна уу.

■ Хэлхээнд хэт ачаалал үүссэн үед

Гал хамгаалагч нь хэлхээнд гэмтэл үүсэхээс сэргийлж шатах зориулалттай байдаг.

■ Гэрлийн ламп солих үед

Lexus нь тус автомашинд зориулагдсан Lexus-н оригинал гал хамгаалагч ашиглахыг зөвлөж байна.

Хэлхээнд холбогдсон зарим ламп нь хэт ачааллаас сэргийлэх зориулалттай тул оригинал бус, эсвэл тус автомашинд зориулагдаагүй гал хамгаалагчийг ашиглах боломжгүй.

Гэрлийн ламп

Тухайн гэрлийн лампаас хамаарч ламп солих нь хүндрэлтэй байж болно. Ламп солих нь хүндрэлтэй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ Дараах гэрлүүдийг солих

Дараах аль нэг гэрэл шатсан үед та өөрийн Lexus дилер дээрээ солиулна уу.

- Их гэрэл
- Урд оврын гэрэл, өдрийн хөдөлгөөний гэрэл
- Урд эргэх дохионы гэрэл (LED)
- Хажуугийн эргэх дохионы гэрэл
- Урд манангийн гэрэл*
- Эргэх дохионы нэмэлт гэрэл*
- Хойд манангийн гэрэл
- Тоормос/арын гэрэл
- Ухрах арааны гэрэл
- Арын эргэх дохионы гэрэл
- Тоормосны нэмэлт гэрэл

*: Тоноглогдсон автомашинд

● Дугаарын гэрэл

МЭДЭЭЛЭЛ

■ LED гэрлүүд

Урд эргэх дохионы гэрэл (лампан төрөл)-с бусад гэрлүүд нь олон тооны LED гэрлээс бүрддэг. Аль нэг LED гэрэл шатсан үед та өөрийн Lexus дилер дээрээ солиулна уу.

⚠ АЮУЛТАЙ

Гэрэл солихтой холбоотой дараах анхааруулгыг мөрдөнө.

- Гэрлийг унтраана. Гэрэл унтраасан даруйд солих оролдлого хийж болохгүй. Гэрлийн ламп халуун байх, улмаар түлэгдэх аюултай.
- Лампны шилэн хэсгээс гараар бариж болохгүй. Шилнээс зайлшгүй шаардлагаар барих үед аливаа чийг, тос шилэнд хүрэхээс сэргийлж хуурай даавуугаар барина. Мөн ламп зурагдсан, газарт унагасан үед хагарах аюултай.
- Гэрлийн ламп болон бусад эд ангиудыг бүрэн угсарна. Эсрэг тохиолдолд ламп халж галын аюул үүсгэх, эсвэл их гэрэл дотор ус орох, улмаар их гэрэл гэмтээх, эсвэл их гэрэл дотор хөлрөлт үүсгэнэ.
- Гэрлийн ламп, холбогч, цахилгааны хэлхээ болон эд ангиудыг засах, задлахыг хатуу хориглоно.

  Эсрэг тохиолдолд тог цохих, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.
- Гэмтэл болон гал түймэр үүсэхээс сэргийлэн ламп сууриндаа бүрэн суусан, гүйцэд бэхлэгдсэн байна.
- Халалтаас шалтгаалсан гэмтлээс сэргийлж хийхийн өмнө лампны хүчдлийг шалгаж мэдсэн байна.

Гэрлийн лампны байрлал



A Урд эргэх дохионы гэрэл (лампан гэрэл)

Урд эргэх дохионы гэрлийн ламп солих (лампан гэрэл)

Ламп солихоос өмнө тухайн гэрлийн хүчдлийг шалгана.

1 Гэрлийн суурийг цагийн зүүний эсрэг эргүүлнэ.



2 Гэрлийн ламп авна.



3 Шинэ гэрлийн ламп хийгээд гэрлийн суурийг цагийн зүүний дагуу эргүүлж угсарна.

Гэрлийн ламп угсарсны дараа урд эргэх дохионы гэрлийг асааж гэрлийн суурьны завсраар гэрэл алдагдаж байгаа эсэхийг нүдээр шалгана.



10 Автомашины техник үзүүлэлт

10-1. Техник үзүүлэлт

Засвар үйлчилгээний мэдээлэл (шатахуун, тос г.м.) 656

Шатахууны мэдээлэл 671

10-2. Өөрчлөх боломжтой тохиргоо

Хэрэглэгчийн өөрчлөх боломжтой тохиргооны ерөнхий мэдээлэл 673

Тохиргоог өөрчлөх арга ... 674

Өөрчлөх боломжтой функцууд 675

10-3. Анхны тохиргоонд тохируулах

Дахин тохируулах зүйлс ... 696

Засвар үйлчилгээний мэдээлэл (шатахуун, тос г.м.)

Овор хэмжээ

Нийт урт		4660мм (183.5 in.)
Нийт өргөн		1865мм (73.4 in.)
Нийт өндөр(1)		1640мм (65.6 in.)(2) 1660мм (65.4 in.)(3) 1650мм (65.0 in.)(4) 1670мм (65.7 in.)(5)
Тэнхлэг хоорондын зай		2690мм (105.9 in.)
Мөр хоорондын зай	Урд	1605мм (63.2 in.)
	Хойд	1625мм (64.0 in.)

(1) Автомашин хоосон үед
(2) 235/60R18 дугуйтай ба дээврийн антеннгүй автомашин
(3) 235/60R18 дугуй, дээврийн антеннтай автомашин
(4) 235/50R20 дугуйтай ба дээврийн антеннгүй автомашин
(5) 235/50R20 дугуй, дээврийн антеннтай автомашин

Автомашины дугаар

■ Автомашины арлын дугаар

Vehicle identification number (VIN) буюу автомашины арлын дугаар нь таны Lexus автомашинд олгогдсон, үл давтагдах бүртгэлийн дугаар ба эзэмшигчийн бүртгэл хийхэд ашиглагддаг.

● Энэ дугаарыг хянах самбарын зүүн дээд буланд тэмдэглэсэн байдаг.



● Тус дугаар нь мөн бүртгэлийн дугаарын хавтан*1, эсвэл үйлдвэрлэгчийн шошго дээр байдаг*2.



● Тус дугаар нь баруун урд суудлын доор байдаг.



■ **Үйлдвэрлэгдсэн он болон улс (Булангийн орнуудын Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнууд*4, Ирак, Ливан, Йемен)**

Үйлдвэрлэгдсэн он болон улсын мэдээлэл бүртгэлийн дугаарын хавтан дээр байдаг.

*1 : Булангийн орнуудын Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнууд*3, Ирак, Ливан, Йемен

*2 : Булангийн орнуудын Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнууд*3, Ирак, Ливан, Йеменээс бусад

*3 : Саудын Араб, Оман, Бахрейн, АНЭУ, Катар, Кувейт

*4 : Саудын Араб, Оман, Бахрейн, АНЭУ, Катар, Кувейт

■ Хөдөлгүүрийн дугаар

▶ NX350



▶ NX250



▶ NX200



Хөдөлгүүр

▶ NX350

Загвар	T24A-FTS
Төрөл	Цуваа 4 цилиндр, 4 тактын бензин хөдөлгүүр (турботой)
Поршенгийн явалт, цилиндрийн диаметр	87.5 × 99.5 мм (3.44 × 3.91 in.)
Хөдөлгүүрийн эзлэхүүн	2393 см^3 (146.0 cu. in.)
Клапангийн зай (хүйтэн хөдөлгүүр)	Автомат тохируулгатай
Ремень чангалагч	Автомат тохируулгатай
Автомашины дээд хурд(1)	200 км/ц (124 mph)

Дээд мушгих хүч (NET)(1)	430 N•m@1700 - 3600 эрг/мин
Дээд хүчин чадал (NET)(1)	205 kW@6000 эрг/мин

(1) Булангийн Орнуудын Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнууд (2), Ирак, Ливан, Йемен

(2) Саудын Араб, Оман Бахрейн, АНЭУ, Катар, Кувейт

▶ NX250

Загвар	A25A-FKS
Төрөл	Цуваа 4 цилиндр, 4 тактын бензин хөдөлгүүр
Поршенгийн явалт, цилиндрийн диаметр	87.5 × 103.4 мм (3.44 × 4.07 in.)
Хөдөлгүүрийн эзлэхүүн	2487 см^3 (151.8 cu. in.)
Клапангийн зай (хүйтэн хөдөлгүүр)	Автомат тохируулгатай
Ремень чангалагч	Автомат тохируулгатай

▶ NX200

Загвар	M20A-FKS
Төрөл	Цуваа 4 цилиндр, 4 тактын бензин хөдөлгүүр
Поршенгийн явалт, цилиндрийн диаметр	80.5 × 97.6 мм (3.17 × 3.84 in)
Хөдөлгүүрийн эзлэхүүн	1987 см^3 (121.3 cu. in.)
Клапангийн зай (хүйтэн хөдөлгүүр)	Автомат тохируулгатай
Ремень чангалагч	Автомат тохируулгатай

Шатахуун

Шатахууны төрөл	ШТС дээр дараах төрлийн шатахууны тэмдэг байгаа үед дараах аль нэг тэмдэгтэй шатахуун хэрэглэнэ. Аргентин: Зөвхөн металлийн нэмэлт орцгүй (Манган суурьтай зэрэг), хар тугалгагүй бензин ашиглана. Бензиний тухай дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу. Аргентинаас бусад: Зөвхөн хар тугалгагүй бензин
Шинжилгээний октаны тоо	NX350: 95 буюу түүнээс дээш NX250/NX200: 91 буюу түүнээс дээш
Шатахууны савны багтаамж (жишээ)	55.0 л (14.5 gal., 12.1 Imp. gal.)

Тосолгооны систем (NX350)

■ Тосны багтаамж (Бүрэн асгаад дахин дүүргэх) (жишээ)*5

Шүүртэй	5.3 л (5.6 qt., 4.7 Imp.qt.)
Шүүргүй	5.0 л (5.3 qt., 4.4 Imp.qt.)

■ Хөдөлгүүрийн тос сонгох

Бензин хөдөлгүүр –

*5 : Хөдөлгүүрийн тосны багтаамжийн мэдээлэл нь тос солих үед ашиглагдах жишээ юм. Хөдөлгүүр халаасны дараа унтраах ба 5-с дээш минутын дараа тосны түвшинг шүүб татаж шалгана.

"Toyota Genuine Motor Oil" тус Lexus автомашинд ашиглагддаг. Тос солих үед "Toyota Genuine Motor Oil", эсвэл дараах тосны зэрэг, зууралдангитай тос ашиглана.

● Тосны зэрэг:

0W-20, 5W-20, 5W-30 болон 10W-30: API ангиллын SL "Energy-Conserving", SM "Energy-Conserving", SN "Resource-Conserving", SN PLUS "Resource -Conserving", эсвэл SP "Resource-Conserving"; эсвэл ILSAC GF-6A бүх улирлын тос

● Тохиромжтой зууралданги (SAE):



A Хөдөлгүүрийн тосны ашиглах боломжтой температур

B Тохиромжтой температур

Lexus автомашинд үйлдвэрээс хийгдэн ирдэг SAE 0W-20 нь шатахуун хэмнэлт, хүйтэн агаартай үеийн хөдөлгүүр асалтад хамгийн тохиромжтой. Хүйтний улиралд SAE 10W-30 ба түүнээс дээш зууралдангитай хөдөлгүүрийн тос ашигласан тохиолдолд хөдөлгүүрийн асалт муудах тул SAE 0W-20, 5W-20, эсвэл 5W-30 хөдөлгүүрийн тос ашиглана.

■ Тосны шошго дахь мэдээлэл

API бүртгэлийн тэмдэгтийн аль нэг, эсвэл хоюул зарим тосны саванд байдаг.



A API сервисийн тэмдэгт:

Дээд тал: "API SERVICE SP" тэмдэглэгээ нь Америкийн Нефть Судлалын Хүрээлэн (API)-н боловсруулан гаргасан тосны чанарыг хангасан утгыг илэрхийлнэ.
Төв хэсэг: "SAE 0W-20" тэмдэглэгээ нь зууралдангийн SAE ангилалд хамаарах утгыг илэрхийлнэ.
Доод тал: "Resource-Conserving" тэмдэглэгээ нь тухайн тос шатахуун зарцуулалт болон байгаль орчинд ээлтэй утгыг илэрхийлнэ.

B ILSAC сертификаторын тэмдэгт

Олон Улсын Тосны Стандартжуулалт Баталгаажуулалтын холбоо (ILSAC)-н сертификатын тэмдэгт тосны савны урд талд тэмдэглэгдсэн байдаг.

Тосны зууралданги чанар (0W-20 тосыг жишээ болгон тайлбарлав):

- Тосны 0W-20 зууралдангийн үзүүлэлт дээрх 0W нь нь тухайн тосны хүйтэнд асаах чадварыг илэрхийлнэ.

  W тэмдэгтийн өмнөх тоо бага байх тусам автомашины хөдөлгүүр хүйтэн нөхцөлд илүү сайн асна.

- 0W-20 дээрх 20 нь тосны хэм хэт өндөр үеийн зууралданги чанарыг илэрхийлнэ.

  Зууралданги чанар өндөр (үзүүлэлтийн тоо их) тос нь өндөр ачаалалтай хөдөлгүүрт тохирно.

Тосолгооны систем (NX250)

■ Тосны багтаамж (Тосыг бүрэн асгаад дүүргэх) (жишээ)*6

Шүүртэй	4.5 л (4.8 qt., 4.0 Imp.qt.)
Шүүргүй	4.2 л (4.4 qt., 3.7 Imp.qt.)

■ Хөдөлгүүрийн тос сонгох

Бензин хөдөлгүүр –

"Toyota Genuine Motor Oil" тус Lexus автомашинд ашиглагддаг. Тос солих үед "Toyota Genuine Motor Oil", эсвэл дараах тосны зэрэг, зууралдангитай тос ашиглана.

- Тосны зэрэг:

  0W-16: API ангиллын SN "Resource-Conserving", SN PLUS "Resource-Conserving", эсвэл SP "Resource-Conserving"; эсвэл ILSAC GF-6B бүх улирлын хөдөлгүүрийн тос
  0W-20, 5W-20, 5W-30 ба 10W-30: API ангиллын SL "Energy-Conserving", SM "Energy-Conserving", SN "Resource-Conserving", SN PLUS "Resource-Conserving", эсвэл SP "Resource-Conserving"; эсвэл ILSAC GF-6A бүх улирлын хөдөлгүүрийн тос

- Тохиромжтой зууралданги (SAE):

*6 : Хөдөлгүүрийн тосны багтаамжийн мэдээлэл нь тос солих үед ашиглагдах жишээ юм. Хөдөлгүүр халаасны дараа унтраах ба 5-с дээш минутын дараа тосны түвшинг шүүб татаж шалгана.



A Хөдөлгүүрийн тосны ашиглах боломжтой температур

B Тохиромжтой температур

Lexus автомашиныг үйлдвэрлэх үед хийдэг SAE 0W-16 тос нь шатахуун хэмнэлт, хүйтэн агаартай үеийн хөдөлгүүр асалтад хамгийн тохиромжтой. Хүйтний улиралд SAE 10W-30 ба түүнээс дээш зууралдангитай хөдөлгүүрийн тос ашигласан тохиолдолд хөдөлгүүрийн асалт муудах тул SAE 0W-16, 0W-20, 5W-20 эсвэл 5W-30 хөдөлгүүрийн тос ашиглана.

■ Тосны шошго дахь мэдээлэл

API бүртгэлийн тэмдэгтийн аль нэг, эсвэл хоюул зарим тосны саванд байдаг.



A API сервисийн тэмдэгт:

Дээд тал: "API SERVICE SP" тэмдэглэгээ нь Америкийн Нефть Судлалын Хүрээлэн (API)-н боловсруулан гаргасан тосны чанарыг хангасан утгыг илэрхийлнэ.
Төв хэсэг: "SAE 0W-16" тэмдэглэгээ нь зууралдангийн SAE ангилалд хамаарах утгыг илэрхийлнэ.
Доод тал: "Resource-Conserving" тэмдэглэгээ нь тухайн тос шатахуун зарцуулалт болон байгаль орчинд ээлтэй утгыг илэрхийлнэ.

B ILSAC сертификаторын тэмдэгт

Олон Улсын Тосны Стандартжуулалт Баталгаажуулалтын холбоо (ILSAC)-н сертификатын тэмдэгт тосны савны урд талд тэмдэглэгдсэн байдаг.

Тосны зууралданги (0W-16 тосыг жишээ болгон тайлбарлав):

- Тосны 0W-16 зууралдангийн үзүүлэлт дээрх 0W нь тухайн тосны хүйтэнд асаах чадварыг илэрхийлнэ.

  W тэмдэгтийн өмнөх тоо бага байх тусам автомашины хөдөлгүүр хүйтэн нөхцөлд илүү сайн асна.

- 0W-16 дээрх 16 нь тосны хэм хэт өндөр үеийн зууралданги чанарыг илэрхийлнэ.

  Зууралданги чанар өндөр (үзүүлэлтийн тоо их) тос нь өндөр хурдаар явдаг автомашин, өндөр ачаалалтай хөдөлгүүрт тохирно.

Тосолгооны систем (NX200)

■ Тосны багтаамж (суллаад дүүргэх) (жишээ)*7

Шүүртэй	4.3 л (4.5 qt., 3.8 Imp.qt.)
Шүүргүй	3.9 л (4.1 qt., 3.4 Imp.qt.)

■ Хөдөлгүүрийн тос сонгох

Бензин хөдөлгүүр –

"Toyota Genuine Motor Oil" тус Lexus автомашинд ашиглагддаг. Тос солих үед "Toyota Genuine Motor Oil", эсвэл дараах тосны зэрэг, зууралдангитай тос ашиглана.

- Тосны зэрэг:

  0W-16: API ангиллын SN "Resource-Conserving", SN PLUS "Resource-Conserving", эсвэл SP "Resource-Conserving"; эсвэл ILSAC GF-6B бүх улирлын хөдөлгүүрийн тос
  0W-20, 5W-20, 5W-30 болон 10W-30: API ангиллын SL "Energy-Conserving", SM "Energy-Conserving", SN "Resource-Conserving", SN PLUS "Resource-Conserving", эсвэл SP "Resource-Conserving"; эсвэл ILSAC GF-6A бүх улирлын хөдөлгүүрийн тос

- Тохиромжтой зууралданги (SAE):

*7 : Хөдөлгүүрийн тосны багтаамжийн мэдээлэл нь тос солих үед ашиглагдах жишээ юм. Хөдөлгүүр халаасны дараа унтраах ба 5-с дээш минутын дараа тосны түвшинг шүүб татаж шалгана.



A Хөдөлгүүрийн тосны ашиглах боломжтой температур

B Тохиромжтой температур

Lexus автомашинд үйлдвэрээс хийдэг SAE 0W-16 нь шатахуун хэмнэлт, хүйтэн агаартай үеийн хөдөлгүүр асалтад хамгийн тохиромжтой. Хүйтний улиралд SAE 10W-30 ба түүнээс дээш зууралдангитай хөдөлгүүрийн тос ашигласан тохиолдолд хөдөлгүүрийн асалт муудах тул SAE 0W-16, 0W-20, 5W-20, эсвэл 5W-30 хөдөлгүүрийн тос ашиглана.

■ Тосны шошго дахь мэдээлэл

API бүртгэлийн тэмдэгтийн аль нэг, эсвэл хоюул зарим тосны саванд байдаг.



A API сервисийн тэмдэгт:

Дээд тал: "API SERVICE SP" тэмдэглэгээ нь Америкийн Нефть Судлалын Хүрээлэн (API)-н боловсруулан гаргасан тосны чанарыг хангасан утгыг илэрхийлнэ.
Төв хэсэг: "SAE 0W-16" тэмдэглэгээ нь зууралдангийн SAE ангилалд хамаарах утгыг илэрхийлнэ.
Доод тал: "Resource-Conserving" тэмдэглэгээ нь тухайн тос шатахуун зарцуулалт болон байгаль орчинд ээлтэй утгыг илэрхийлнэ.

B ILSAC сертификаторын тэмдэгт

Олон Улсын Тосны Стандартжуулалт Баталгаажуулалтын холбоо (ILSAC)-н сертификатын тэмдэгт тосны савны урд талд тэмдэглэгдсэн байдаг.

Тосны зууралданги (0W-16 тосыг жишээ болгон тайлбарлав):

- Тосны 0W-16 зууралдангийн үзүүлэлт дээрх 0W нь тухайн тосны хүйтэнд асаах чадварыг илэрхийлнэ.

  W тэмдэгтийн өмнөх тоо бага байх тусам автомашины хөдөлгүүр хүйтэн нөхцөлд илүү сайн асна.

- 0W-16 дээрх 16 нь тосны хэм хэт өндөр үеийн зууралданги чанарыг илэрхийлнэ.

  Зууралданги чанар өндөр (үзүүлэлтийн тоо их) тос нь өндөр ачаалалтай хөдөлгүүрт тохирно.

Хөргөлтийн систем

Багтаамж(1)	NX350	Бензин хөдөлгүүр: 8.7 л (9.2 qt., 7.7 Imp.qt.) Intercooler: 2.7л (2.9 qt., 2.4 Imp.qt.)
	NX250	7.0 л (7.4 qt., 6.2 Imp.qt.)
	NX200	6.9 л (7.3 qt., 6.1 Imp.qt.)
Хөргөлтийн шингэний төрөл		Дараах төрлүүдийг ашиглана: ● "Toyota Super Long Life Coolant" ● Этилен гликол суурьтай, силикат, амины хүчил, нитрит, борын хүчил агуулаагүй хосолмол органик хөргөлтийн шингэн Ус дангаар ашиглаж болохгүй.

(1) Хөргөлтийн шингэний багтаамжийг мэдээллийн журмаар ашиглана. Солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Асаах систем (очлуур)

Үйлдвэрлэгч	NX350: NGK DILZKAR8E7H NX250: DENSO FC16HR-Q8 NX200: DENSO FC20HR-Q8
Очлуурын электродны зай	NX350: 0.7 мм (0.03 инч) NX250: 0.8 мм (0.03 инч) NX200: 0.8 мм (0.03 инч)

⚠ АНХААР

■ Иридиум очлуур

Зөвхөн иридиум очлуур хэрэглэнэ. Очлуурын электродны зайнд өөрчлөлт хийхийг хориглоно.

Цахилгаан систем

■ Аккумулятор

20°C (68°F) хэм дэх хүчдэл:	12.3 V ба түүнээс дээш (Хөдөлгүүр асаах товч унтраагаад холын гэрлийг 30 секунд асаана.)
20°C (68°F) хэм дэх нягтрал:	1.25 ба түүнээс дээш Нягтрал заасан хэмжээнээс бага үед аккумуляторыг цэнэглэнэ.

■ Цэнэглэх хурд

Хурдан цэнэглэх	Хамгийн ихдээ 15A.
Удаан цэнэглэх	Хамгийн ихдээ 5A.

Автомат хурдны хайрцаг (NX350/NX250)

Шингэний багтаамж(1)	NX350: 7.1 л (7.5 qt., 6.2 Imp.qt.) NX250: 7.3 л (7.7 qt., 6.4 Imp.qt.)
Шингэний төрөл	"Toyota Genuine ATF WS"

(1) Шингэний багтаамжийн хэмжээг мэдээллийн журмаар ашиглана. Солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

⚠ АНХААР

■ Хурдны хайрцагны шингэний төрөл

Дээр дурдсанаас өөр төрлийн хурдны хайрцагны шингэн ашиглах нь хэвийн бус дуу чимээ, чичиргээ үүсгэх, эсвэл хурдны хайрцагны гэмтэлд хүргэнэ.

CVT хурдны хайрцаг (NX200)

Шингэний багтаамж(1)	8.7 л (9.2 qt., 7.7 Imp.qt.)
Шингэний төрөл	"Toyota Genuine CVT Fluid FE"

(1) Шингэний багтаамжийн мэдээллийн зөвхөн мэдээллийн журмаар ашиглана. Солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

⚠ АНХААР

■ CVT хурдны хайрцгын шингэний төрөл

Дээр дурдсанаас бусад CVT (Continuously Variable Transaxle) шингэн ашиглах нь хэвийн бус дуу чимээ, чичиргээ үүсгэх, эсвэл CVT хурдны хайрцгийг гэмтээх аюултай.

Туслах хурдны хайрцаг (AWD)

Тосны багтаамж(1)	0.45 л (0.48 qt., 0.40 Imp. qt.)
Тосны төрөл болон зуурамтгай чанар	"Toyota Genuine Differential gear oil LT 75W-85, эсвэл дүйцэх чанартай тос"

(1) Шингэний хэмжээг мэдээллийн журмаар ашиглана. Солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Таны Lexus автомашин үйлдвэрээс "Toyota Genuine Differential Gear Oil" тостой нийлүүлэгддэг.

Lexus-с хүлээн зөвшөөрсөн "Toyota Genuine Differential Gear Oil", эсвэл дээрх техник үзүүлэлтийг хангасан ижил чанарын тос ашиглана. Дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс авна уу.

Хойд дифференциал (AWD)

Тосны багтаамж(1)	0.50 л (0.53 qt., 0.44 Imp. qt.)
Тосны төрөл ба зууралданги чанар	"Toyota Genuine Differential gear oil LT 75W-85, эсвэл дүйцэх чанартай тос"

(1) Тосны багтаамжийн хэмжээг мэдээллийн журмаар ашиглана. Солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

Таны Lexus автомашинд үйлдвэрээс "Toyota Genuine Differential Gear Oil" тос хийгдсэн байдаг.

Lexus-н хүлээн зөвшөөрсөн "Toyota Genuine Differential Gear Oil", эсвэл түүнтэй дүйцэх дээр дурдсан техник үзүүлэлт, чанартай тос ашиглана. Дэлгэрэнгүйг та өөрийн Lexus дилерээсээ авна уу.

Тоормос

Дөрөөний зай (1)	Зүүн жолооны хүрдтэй: 127 мм (5.0 инч) Баруун жолооны хүрдтэй: 96 мм (3.8 инч)
Тоормосны накладны зөвшөөрөгдөх элэгдлийн хэмжээ	1.0 мм (0.04 инч)
Дөрөөний сул явалт	1 - 6 мм (0.04 - 0.25 инч)
Шингэний төрөл	● SAE J1703, эсвэл FMVSS No. 116 DOT 3 ● SAE J1704, эсвэл FMVSS No. 116 DOT 4

(1) Хөдөлгүүр ажиллаж байх үед 300 N (30.6 kgf, 67.5 lbf) хүчээр гишгэх үеийн хамгийн бага дөрөөний зай

Жолооны хүрд

Сул явалт	30 мм (1.2 in.)-с бага

Дугуй ба обуд

▶ 18 инчийн дугуй

Дугуйн хэмжээ	235/60R18 103H
Дугуйны хийн даралт (Хөрсөн үеийн тохиромжтой дугуйны хийн даралт)	Урд: 230 kPa (2.3 kgf/cm^2, эсвэл bar, 33 psi) Хойд: 230 kPa (2.3 kgf/cm^2, эсвэл bar, 33 psi)
Обудны хэмжээ	18 × 7 1/2 J
Дугуйн боолт чангалах хүч	140 N•m (14.3 kgf•m, 103 ft•lbf)

▶ 20 инчийн дугуй

Дугуйн хэмжээ		235/50R20 100V	
Дугуйны хийн даралт (Хөрсөн үеийн тохиромжтой дугуйны хийн даралт)	Автомашины хурд	Урд обуд kPa (kgf/cm^2, эсвэл bar, psi)	Хойд обуд kPa (kgf/cm^2, эсвэл bar, psi)
	160 км/ц (100 mph)-с дээш	250 (2.5, 36)	250 (2.5, 36)
	160 km/h (100 mph) хүртэлх хурд	230 (2.3, 33)	230 (2.3, 33)
Обудны хэмжээ		20 × 7 1/2 J	
Дугуйн боолт чангалах хүч		140 N•m (14.3 kgf•m, 103 ft•lbf)	

Гэрлийн ламп

	Гэрлийн ламп	**W**	**Төрөл**
Гадна	Урд эргэх дохионы гэрлийн ламп (лампан төрөл)	21	A

A: Ганц төгсгөлтэй ламп (шаргал)

Шатахууны мэдээлэл



ШТС дээр дараах төрлийн шатахуун байгаа үед зөвхөн дараах тэмдэгтэй шатахуун ашиглана.

Зөвхөн хар тугалгагүй бензин ашиглана.

NX350: Хөдөлгүүрийн хүчин чадлыг дээд хэмжээнд хүргэх үүднээс шинжилгээний октаны тоо 95-с дээш бензин ашиглана. Дээрх өндөр чанарын бензин байхгүй нөхцөлд шинжилгээний октаны тоо 91-тэй хар тугалгагүй бензин түр ашиглаж болно.

NX250/NX200: Хөдөлгүүрийн хүчин чадлыг дээд хэмжээнд хүргэх үүднээс шинжилгээний октаны тоо 91-с дээш хар тугалгагүй бензин ашиглана.

МЭДЭЭЛЭЛ

■ Бензин хөдөлгүүрт этанолын хольцтой бензин ашиглах

10 хүртэлх хувийн этанолийн хольцтой бензин ашиглахыг Lexus зөвшөөрдөг. Этанолийн хольцтой бензин ашиглах үедээ тухайн бензиний шинжилгээний октаны тоо нь дээрх шаардлагад нийцсэн эсэхийг нягтлах шаардлагатай.

■ Таны хөдөлгүүрт детонац буюу цохилт үүссэн үед

- Өөрийн Lexus дилерт хандана уу.
- Мөн хурд авах, өгсүүр замаар явах үед үе үе богино хугацааны бага хэмжээний цохилт хөдөлгүүрт үүсэх тохиолдол байдаг ба энэ нь хэвийн зүйл бөгөөд анхаарал шаардлагагүй юм.

АНХААР

■ Бензиний чанартай холбоотой анхааруулга

- Чанарын шаардлага хангаагүй шатахуун ашиглахыг хориглоно. Эсрэг тохиолдолд хөдөлгүүрт гэмтэл учруулах аюултай.
- Манган, төмөр, хар тугалга зэрэг металл агуулсан бензин нь хөдөлгүүр, хаягдал утааны хяналтын систем гэмтээх тул ашиглаж болохгүй.
- Металлийн орцтой шатахууны нэмэлт бодис ашиглаж болохгүй.
- [**E50**], эсвэл [**E85**] нэрээр борлуулагддаг биоэтанол шатахуун, мөн этанолийн өндөр агууламжтай шатахуун ашиглаж болохгүй. Таны автомашинд 10% хүртэлх этанолын агуулгатай шатахуун ашиглах боломжтой. 10%-с дээш этанолын агуулгатай шатахуун ашиглах нь шатахууны систем гэмтээх аюултай. Та шатахууны үзүүлэлт болон

⚠ АНХААР

чанарын баталгаатай, найдвартай эх үүсвэрээс шатахуун цэнэглэнэ үү. Таньд эргэлзээ төрсөн нөхцөлд өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

- M15, M85, M100 зэрэг метанолийн хольцтой бензин ашиглаж болохгүй.

  Хөдөлгүүрт гэмтэл, доголдол учруулж болзошгүй.

Хэрэглэгчийн өөрчлөх боломжтой тохиргооны ерөнхий мэдээлэл

Тус автомашинд өөрийн сонголтод нийцүүлэн өөрчлөх боломжтой олон электрон функц байдаг. Эдгээр функцийн тохиргоог голын дэлгэц дээр, эсвэл та өөрийн Lexus дилер дээр хийх боломжтой.

⚠ АЮУЛТАЙ

Тохиргоо хийх үед хөдөлгүүр асаалттай байх шаардлагатай тул агааржуулалт сайтай газар зогсоно. Гараж зэрэг битүү орчинд нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) зэрэг хорт агуулагддаг утаа хуримтлагдаж бүхээгт орох, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай.

⚠ АНХААР

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж хөдөлгүүр асаалттай үед тохиргоо хийнэ.

Тохиргоог өөрчлөх арга

Голын дэлгэц ашиглан солих

Үйлдлийг аюулгүй хийх газар автомашинаа зогсоож зогсоолын тоормос залгаад арааг P-д шилжүүлнэ.

1 **Голын дэлгэц дээр ⚙ -г сонгоно.**

2 **[Vehicle customise], эсвэл [Driving assist]-г сонгоно.**

3 **Жагсаалтаас тохиргоо хийх зүйлийг сонгоно.**

Олон төрлийн тохиргоог өөрчлөх боломжтой. Дэлгэрэнгүйг өөрчлөх боломжтой тохиргооны жагсаалтаас харна уу.

On/off тохиргоо сонгох боломжтой функцад (ON)/ (OFF)-г сонгоно.

Өөрчлөх боломжтой функцууд

Бусад функцийн тохиргоог өөрчлөх үед зарим функцийн тохиргоо хамт өөрчлөгддөг. Дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

A Голын дэлгэцээр өөрчлөх боломжтой тохиргоо

B Lexus дилер дээр өөрчлөх боломжтой тохиргоо

Тэмдгийн утга: O = Боломжтой, — = Боломжгүй

Хянах самбар, хэмжүүр болон мэдээллийн дэлгэц

Хянах самбар, мэдээллийн дэлгэц дээр гарах хэл, хэмжих нэгж зэрэг зарим тохиргоо нь голын дэлгэц дээр тохируулсан тохиргооны дагуу өөрчлөгдөнө. Дэлгэрэнгүйг "Мултимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Хянах самбарын дэлгэцийн төрөл(1)	Төрөл 1	Төрөл 2	O	—
		Төрөл 3		
Эко жолоодлогын индикатор(1)	On	Off	O	—
Өндөр эргэлтийн индикатор(2)	5000 эрг/мин	2000 - 6800 эрг/мин(3) 2000 - 6200 эрг/мин(4)	O	—
		Off		
Хөдөлгүүрийн эргэлтийн оргил(2)	On	Off	O	—
Зөвлөмж функц(1)	On	On (автомашин зогссон үед)	O	O
		Off		
Арын суудал сануулах функц(1)	On	Off	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.
(2) F SPORT загвар
(3) NX200/NX250
(4) NX350

HUD дэлгэц*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Дэлгэц(1)	On	Off	O	—
Дэлгэцийн горим(1)	Хамгийн дээд	Хэвийн	O	—
		Хамгийн бага		

(1) Тус тохиргоо миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

Жолооны хүрдний товч (HUD дэлгэцтэй автомашин)

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Жолооны хүрдний баруун товчны тогтмол ашиглагддаг функцууд(1)	Дэлгэцийн удирдлага	Хэрэглэгчийн тохиргоо	O	—
Жолооны хүрдний зүүн товчны тогтмол ашиглагддаг функцууд(1)	Аудио	Цаг агаарын удирдлага	O	—
		Хэрэглэгчийн тохиргоо		
Товчны мэдрэгчийн өндөр мэдрэмжтэй горим (өвлийн бээлийний горим)(1)	Off	On	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

*: Тоноглогдсон автомашинд

Хаалганы түгжээ

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Хаалга түгжих товчны индикаторын асах хугацаа	30 секунд	60 секунд	—	O
		600 секунд		
		1200 секунд		
Дотор талын хаалга нээх товчны ажиллагааны тохиргоо (хаалга нээх функцийн тохиргоо)	Богино	Дунд	—	O
		Урт		
Дотор талын хаалга нээх товч ажиллуулах үеийн мэдээллийн дэлгэц/дуут дохионы ажиллагаа	On	Off	—	O
Дотор/гадна талын хаалга нээх товч ажиллуулах арга	Товч дарах үеийн хаалга нээх ажиллагаа	0.6 секунд	—	O
		Бүхээгнээс ажиллуулах: 0.6 секунд Гадна талаас ажиллуулах: Товч дарах үеийн хаалга нээх ажиллагаа		

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Дотор/гадна талын хаалга нээх товч ажиллуулах арга	Товч дарах үеийн хаалга нээх ажиллагаа	Бүхээгнээс ажиллуулах: Товч дарах үеийн хаалга нээх ажиллагаа Гадна талаас ажиллуулах: 0.6 секунд	—	O
Механик түлхүүрээр түгжээ тайлах(1)	Бүх хаалга нэг үйлдлээр түгжээ тайлах	Жолоочийн хаалга 1 үйлдэл, бүх хаалга 2 дахь үйлдлээр түгжээ тайлах	—	O
Арааны байрлалтай уялдаатай хаалга түгжих функц(2)	Off	On	O	O
Арааны байрлалтай уялдаатай хаалга түгжээ тайлах функц(1)(2)	Off	On	O	O
Жолоочийн хаалгатай уялдаатай хаалга түгжээ тайлах функц(1)(2)	Off	On	O	O

(1) Тухайн нийлүүлэгдсэн улсаас хамаарч үндсэн тохиргоо өөр байна.
(2) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

Тээшний автомат хаалга*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Тээшний хаалганы нээгдэх байрлал	5	Тээшний хаалгыг тохируулах байрлалд (өндөр) зогсооно(1)	O	—
		1-с 5		
Тээшний автомат хаалганы ажиллагаа	On	Off	O	—
Ажиллагааны дууны түвшин	3	1	O	—
		2		
Kick сенсор *	On	Off	O	—
Kick ажиллагааны дуут дохио *	On	Off	—	O
Тээшний хаалга түгжих үед түлхүүрийн алсын удирдлаганы товч идэвхжүүлэх функц	Off	On	—	O
Хаагаад түгжих (холдох) функц	On	Off	—	O

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Гарны оролцоогүй хаагаад түгжих (холдох) функц *	Off	On	—	O

(1) Тээшний хаалганы доод талын товчоор тохируулна.

Smart entry & start систем болон түлхүүрийн алсын удирдлага

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Ажиллагааны дууны түвшин(1)(2)	5	Off	O	O
		1-с 7		
Ажиллагааны дохио (Ослын дохионы гэрэл)(1)	On	Off	O	O
Түгжээ тайлагдсаны дараа хаалга нээгээгүй нөхцөлд автоматаар хаалга түгжих функцийн ажиллах хугацаа(1)	30 секунд	60 секунд	—	O
		120 секунд		
Нээлттэй хаалга анхааруулах дохио	On	Off	—	O

(1) Тус тохиргоо нь миний тохиргоо функцийн дагуу өөрчлөгдөнө.

* : Тоноглогдсон автомашинд

(2) ӨАБНУ, Малайзаас бусад

Smart entry & start систем

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Smart entry & start систем	On	Off	O	O
Смарт системээр хаалганы түгжээ тайлах(1)(2)	Бүх хаалга	Жолоочийн хаалга	O	O
Хаалга дараалан түгжих ажиллагааны зөвшөөрөгдөх тоо	2 удаа	Хүссэн тоогоор	—	O
Жолоочийн хаалганы бариул атгах үед хаалга тайлагдах хүртэлх хугацаа	2 секунд	Off	—	O
		1.5 секунд		
		2.5 секунд		

(1) Үндсэн тохиргоо нь нийлүүлэгдсэн улсаас хамаарч өөр байна.

(2) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

Түлхүүрийн алсын удирдлага

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Түгжээ тайлах(1)(2) .	Нэг үйлдлээр бүх хаалга тайлах	1-р үйлдлээр жолоочийн, 2-р үйлдлээр бүх хаалга тайлах	O	O
Паник функц(3)	On	Off	—	O

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Тээшний автомат хаалганы түгжээ тайлах	Удаан дарах (богино)	Нэг богино дарах	—	O
		Хоёр дарах		
		Удаан дарах (удаан)		
		Off		

(1) Тус тохиргоо миний тохиргоо функцийн дагуу өөрчлөгдөнө
(2) Нийлүүлэгдсэн улсаас хамаарч үндсэн тохиргоо өөр байна.
(3) ӨАБНУ болон Малайзаас бусад

Дохиолол

Функц	Үндсэн тохиргоо	Үндсэн тохиргоо	A	B
Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч, хазайлт мэдрэгч	ON	OFF	O	—

Жолоодлогын байрлал санах ой*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Автомашина ас буух үеийн жолоочийн суудлын хөдөлгөөн(1)	Хэвийн	Off	O	O
		Хагас		
Жолооны хүрдний хөдөлгөөн(1)	Зөвхөн дээш өргөгдөх	Зөвхөн урагш хураагдах	O	—
		Дээш өргөгдөх болон урагш хураагдах		

*:Тоноглогдсон автомашинд

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Жолооны хүрдний хөдөлгөөн(1)	Зөвхөн дээш өргөгдөх	Off	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

Хажуугийн толь

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Толь автоматаар эвхэх, дэлгэх ажиллагаа	Хаалга түгжих/ тайлахтай холбоотой толины ажиллагаа	Off	—	O
		Асаах товчтой холбоотой ажиллагаа		

Автомат цонх, дээврийн нээлхий*, эсвэл панорамик дээврийн нээлхий*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Механик түлхүүртэй холбоотой ажиллагаа	Off	On	—	O
Түлхүүрийн алсын удирдлагатай холбоотой ажиллагаа	Off	On	—	O

Дээврийн нээлхий*

*: Тоноглогдсон автомашинд

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Механик түлхүүр ашиглах үеийн ажиллагаа (зөвхөн нээх)	Зөвхөн урагш хойш	Зөвхөн дээш доош	—	O
Түлхүүрийн алсын удирдлага ашиглах үеийн ажиллагаа (зөвхөн нээх)	Зөвхөн урагш хойш	Зөвхөн дээш доош	—	O

Автомат гэрлийн удирдлагын систем

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Гэрлийн мэдрэгчийн мэдрэх түвшин(1)	Стандарт	-2-с 2	O	O
Их гэрэл үргэлжлэн асах (Их гэрэл автоматаар унтрах хүртэлх хугацаа)(2)	30 секунд	60 секунд	—	O
		90 секунд		
		120 секунд		
Их гэрэл автоматаар унтрах хүртэлх хугацаа(3)	Стандарт	Урт	—	O
Гэрэл сануулах функцийн ажиллагаа(3)	Асаах товчийг off горимд унтраах	Асаах товчийг off горимд унтраагаад жолоочийн хаалга нээсэн	—	O

(1) Тус тохиргоо миний тохиргоо функцаас хамаарч өөрчлөгдөнө..
(2) Зарим загварт
(3) Зарим загварт

Гэрлүүд

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Өдрийн хөдөлгөөний гэрэл(1)(3)	On	Off	O	O
Угтах гэрэл	On	Off	—	O

(1) Булангийн орнуудын Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн орнууд(2), Йемен, Ливан, Ирак
(2) Саудын Араб, Оман, Бахрейн, АНЭУ, Катар, Кувейт
(3) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

AHS (Adaptive High-beam System) холын гэрэл

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
AHS систем	ON/OFF	—	O
Автомашины хурдад тохируулан холын гэрлийн тусах хүрээ, гэрлийн хүчийг тохируулна	15 км/ц (9 mph) / 30 км/ц (19 mph) / 80 км/ц (50 mph)	—	O
Замын эргэлт дээр (эргэж буй талын гэрэл илүү тод тусна) их гэрлийн тусгалын идэвхийг тохируулна	ON/OFF	—	O

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
Урд талын автомашин хүртэлх зайнаас хамаарч ойрын гэрлийн тусах зайг тохируулна	ON/OFF	—	O
Хөдөлгөөн эхлэх үед эргэлтийн гэрэл асах	ON/OFF	—	O
Борооны үеийн холын гэрлийн тусгал хуваарилах удирдлага	ON/OFF	—	O
Хотын замын нөхцөл дэх гэрлийн тусгалын хуваарилалт	ON/OFF	—	O

PCS мөргөлтийн өмнөх систем

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
PCS мөргөлтийн өмнөх систем	ON/OFF	O	—
Анхааруулга өгөх хугацаа(1)	Орой / Хэвийн / Эрт	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргоо функцийн дагуу өөрчлөгдөнө.

Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах систем

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах систем(1)	ON/OFF	O	—

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
Анхааруулга өгөх хугацаа(1)	Хэвийн/Эрт	O	—
Анхааруулга өгөх хэлбэр	Чичиргээ/Дохио	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

Шинэ жолоочийн зөвлөгөө

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
Шинэ жолоочийн зөвлөгөө	ON/OFF	O	—

Эргэлтийн үед хурд хасах функц

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
Эргэлтийн үед хурд хасах функц(1)	OFF / Өндөр / Дунд / Бага	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

Динамик радарын хурд баригч

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
Хурд авалтын тохиргоо(1)	Өндөр / Дунд / Бага	O	—
Хурдны тохиргоо (богино дарах)(1)	1 км/ц / 5 км/ц / 10 км/ц, эсвэл 1 миль/ц / 5 миль/ц / 10 миль/ц	O	—
Хурдны тохиргоо (удаан дарах)(1)	1 км/ц / 5 км/ц / 10 км/ц, эсвэл 1 миль/ц / 5 миль/ц / 10 миль/ц	O	—

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
DRCC (RSA)	ON/OFF	O	—
Хурдны зөвшөөрөгдөх хэлбэлзэл	-5-с +5	O	—
Зааварчилгаа(1)	ON/OFF	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө

Замын тэмдэг танихад туслах систем*

Функц	Өөрчилсөн тохиргоо	A	B
Замын тэмдэг танихад туслах систем (RSA) (1)	ON/OFF	O	—
Өндөр хурд анхааруулах хэлбэр(1)	Үгүй / Дэлгэцээр / Дэлгэц болон дуугаар	O	—
Бусад анхааруулах хэлбэр(1)	Үгүй / Дэлгэцээр / Дэлгэц болон дуугаар	O	—
Өндөр хурд анхааруулах түвшин(1)	10 км/ц (5 mph) / 5 км/ц (3 mph) / 2 км/ц (1 mph)	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө

Lexus parking assist-мэдрэгч*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Lexus parking assist-мэдрэгч(1)	On	Off	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

*: Тоноглогдсон автомашинд

Зогсоолд байрлуулахад туслах системийн дууны түвшин*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Зогсоолд байрлуулахад туслах системийн дууны түвшин (1)	Дунд	Сул	O	—
		Чанга		

(1) Тус тохиргоо нь миний тохиргоо функцийн тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

BSM (Blind Spot Monitor) систем*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
BSM систем	On	Off	O	—
Ойртож буй автомашиныг анхааруулах хугацаа (мэдрэх түвшин) (1)	Дунд зэрэг	Эрт	O	—
		Орой		
Хажуугийн толины индикаторын гэрлийн түвшин (1)	Тод	Бүдэг	O	—

(1) Тус тохиргоо миний тохиргоо функцтай уялдан өөрчлөгдөнө..

Аюулгүйгээр буухад туслах функц*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Аюулгүйгээр буухад туслах функц	On	Off	O	—

*:Тоноглогдсон автомашинд

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Хажуугийн толины дэлгэц(1)	On	Off	O	—
Мэдрэх түвшин(1)	Дунд	Өндөр Бага	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

RCTA (Rear Cross Traffic Alert) функц*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
RCTA (Rear Cross Traffic Alert) функц(1)	On	Off	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргоо функцийн тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

RCD арын камераар мэдрэх функц*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
RCD арын камераар мэдрэх функц(1)	On	Off	O	—

(1) Тус тохиргоо нь миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

PKSB зогсоолд байрлуулахад туслах тоормос*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
PKSB зогсоолд байрлуулахад туслах тоормос(1)	On	Off	O	—

*: Тоноглогдсон автомашинд

(1) Тус тохиргоо миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө.

Stop & Start систем*

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
A/C асаалттай үеийн Stop & Start системийн хугацааг өөрчлөх	Стандарт	Удаан	O	—

Жолоодлогын горим сонгох товч

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Хүч дамжуулах ангийн удирдлага Custom горимд байгаа*	Normal	Power	O	—
		Eco		
Явах эд анги Custom горимд байгаа*	Normal	Sport	O	—
Жолооны механизм Custom горимд байгаа*	Normal	Sport	O	—
Агааржуулалтын систем Custom горимд байгаа*	Normal	Eco	O	—

* : Тоноглогдсон автомашинд

Автомат агааржуулалтын систем

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
“AUTO” товч асаалттай үед автоматаар гадна болон дотор агаарын горимд солино (AUTO товчтой холбоотойгоор агааржуулалтын горим өөрчлөгдөх) (1)	On	Off	O	O
AUTO товч асаалттай үед A/C товч автоматаар асаах (AUTO товчтой холбоотой A/C товч) (1)	On	Off	O	O
AUTO горим сонгогдсон үеийн жолооны хүрд халаагчийн температур(1)	Хэвийн	-2 (хүйтэн)-с 2 (халуун)	O	O
AUTO горим сонгогдсон үеийн жолоочийн суудал халаагчийн температур тохиргоо (1)	Хэвийн	-2 (хүйтэн)-с 2 (халуун)	O	O

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
AUTO горим сонгогдсон үеийн урд зорчигчийн суудал халаагчийн температур тохиргоо(1)	Стандарт	-2 (хүйтэн)-с 2 (халуун)	O	O

(1) Тус тохиргоо миний тохиргоо функцийн дагуу өөрчлөгдөнө.

Гэрэлтүүлэг

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Гэрлүүд унтрах хүртэлх хугацаа(1)	15 секунд	Off	O	O
		7.5 секунд		
		30 секунд		
Асаах товч унтраасны дараах ажиллагаа	On	Off	—	O
Автомашинд электрон түлхүүртэй хүн ойртох үеийн ажиллагаа	On	Off	—	O
Хаалганы түгжээ тайлагдсаны дараах ажиллагаа	On	Off	—	O
Хөлийн гэрэл	On	Off	—	O

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Хаалганы хавтасны гэрэл*, дотор бариулын гэрэл болон голын хайрцагны гэрэл*	On	Off	—	O
Гадна талын хөлийн гэрэл унтрах хүртэлх хугацаа(1)	15 секунд	Off	O	O
		7.5 секунд		
		30 секунд		
Электрон түлхүүртэй хүн ойртох үеийн гадна талын хөлний гэрлийн ажиллагаа	On	Off	—	O
Хаалга тайлах үеийн гадна талын хөлний гэрлийн ажиллагаа	On	Off	—	O
Хаалга нээгдэх үеийн гадна талын хөлний гэрлийн ажиллагаа	On	Off	—	O
Гадна талын хөлийн гэрэл унтраах үед гэрэл бүдгэрч унтрах	Удаан	Богино	—	O

*:Тоноглогдсон автомашинд

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
